СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч:



Андеррайтер:

NOVEL
INVESTMENT

СЭХ
2023 он 01 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

АНДЕРРАЙТЕР

"НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК

- investment@novel.mn
- +976- 7012 1616, 9111 0963
- NOVEL Investment
- Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Шангри-Ла оффис 2301 тоот

ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

"ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК" ХХК

- cr@tavanbogdcapital.com
- (+976)7272-7282
- tavanbogdcapital
- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, "Галлериа-Улаанбаатар" төвийн зүүн жигүүр, 1 давхарт

АУДИТЫН КОМПАНИ

"ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ" ХХК

- info@pkf.mn
- +976-75057979
- Home.pkf/mn
- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян гүний гудамж 18, Даун Таун оффис, 602, 701 тоот

ХУУЛИЙН ФИРМ

"СНОУ ХИЛЛ КОНСАЛТАНСИ" ХХН

- info@snowhill.mn
- +976- 7711 8193
- snowhill.mn
- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Гэндэнгийн гудамж, Сэнтрал оффис, 6 давхарт

ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

BDO МОНГОЛИА

- info@bdo.mn
- +976- 7740 4040
- www.bdo.mn
- Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 62, Юнескогийн гудамж, Юнион Бюлдинг, Б блок, 15 давхар, 1502 тоот

СЗХ
2023 он 01 сар 09 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 1

САНАЛ БОЛГОЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА 2

ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 3

1.1 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл 3

1.2 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө: 4

1.3 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн 4

1.4 Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл 5

1.5 Үнэт цаас гаргагчийн танилцуулга 7

1.5.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго, алсын хараа 8

1.5.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа 8

1.5.3. Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажлууд 27

1.6 Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт, засаглал 29

1.6.1. Үнэт цаас гаргагчийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт 29

1.6.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал 32

1.6.3. Гүйцэтгэх удирдлагын баг болон эрх бүхий албан тушаалтан 33

1.7 Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ, хэлцлийн мэдээлэл 36

1.8 Үнэт цаас гаргагчийн өмнөх 3 жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд болон аудитын дүгнэлтийн мэдээлэл 38

1.8.1 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтүүд 39

1.8.2 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд 41

1.8.3 Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд 43

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ШИНЖИЛГЭЭ, САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ:

2.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал 47

2.1.1 Эдийн засгийн нөхцөл байдал 47

2.1.2 Монгол Улсын хүнсний салбарын нөхцөл байдал, даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдал, 64

2.1.3 Төрөөс хүнсний салбарт баримталж буй бодлого, экспортыг дэмжиж, импортыг орлох салбарыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр 66

2.1.4 Салбарын хууль эрх зүйн орчин, зохицуулалт, стандарт 68

2.1.5 Салбар дахь Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө 68

2.2 Үнэт цаас гаргагчийн нөхцөл байдлын шинжилгээ 69

2.2.1 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь хэмжээ болон өрсөлдөөний орчны шинжилгээ 69

2.2.2 Эрсдэл, эрсдэлийн удирдлага 80

2.2.3 Хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа, шинжилгээ 85

2.2.4 Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм 93

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

2023.01.25
БҮРТГЭВ

3. ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ХУВЬЦАА, ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ:

3.1 Хувьцаа гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр 96
3.2 Нийтэд санал болгох хувьцааны тоо, ширхэг, нэрлэсэн үнэ
3.3 Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны санал болгох үнийг тогтоосон үндэслэл 97
3.4 Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагаа 97
3.5 Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүтцийн өөрчлөлт 98
3.6 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, үр ашгийн тооцоолол 98
3.7 Нийтэд санал болгож буй үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг 111
3.7.1. Хувьцаа эзэмшигчийн эрх 111
3.7.2. Хувьцаа эзэмшигчийн үүрэг 111
3.8 Ногдол ашгийн бодлого 111

4. ШИНЭЭР ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ АЖИЛЛАГАА

4.1 Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох, худалдах хэлбэр, арга 113
4.2 Хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилах хуваарь 114
4.2.1. Анхдагч зах зээлд арилжих зөвшөөрөл авах: 115
4.2.2. Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах 115
4.2.3. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга өгөх заавар 116
4.2.4. Захиалга өгөх: 117
4.2.5. Захиалга биелүүлэх 117
4.3 Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 117

5. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛАГА, ТЭДГЭЭРИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

5.1 Үнэлгээний компанийн танилцуулга, хараат бус үнэлгээний тайлангийн хураангуй 118
5.2 Хуулийн нөхөрлөлийн танилцуулга, хууль зүйн дүгнэлтийн хураангуй. 122
5.3 Аудитын компанийн танилцуулга, санхүүгийн тайланд хийсэн аудитын товч дүгнэлт 126
5.4 Үндсэн болон туслах Андеррайтерийн компанийн танилцуулга, дүгнэлт 128

6. ХАВСРАЛТ

6.1 Компанийн гэрчилгээ 138
6.2 Андеррайтерийн компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл 140
6.3 Үнэлгээний компани, үнэлгээчдийн тусгай зөвшөөрөл 144
6.4 Хуулийн компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл 147
6.5 Аудитын компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл 150
6.6 Үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэр 153
6.7 Компанийн дүрэм 156
6.8 Хувьцаат компанийн дүрмийн төсөл 163
6.9 Ногдол ашгийн бодлогын бичиг баримт 183
6.10 Зоорины барилга баригдах талбайн газар эзэмшигчийн гэрчилгээ 186
6.11 Зоорины барилгын ажлын үнийн санал 188
6.12 Зоорины тоног төхөөрөмжийн үнийн санал 189
6.13 Шинэ бүтээгдэхүүний тоног төхөөрөмжний үнийн санал 194
6.14 Андеррайтерийн тодорхойлох захидал 199
6.15 Аудитын тодорхойлох захидал 205
6.16 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 208
6.17 Үнэлгээний тайлан 248
6.18 Хуулийн дүгнэлт 326

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Ltd
ХТАБЗДА УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИРЭЭР ХЭЛТЭС

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

2023.01.25
БҮРТГЭВ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч "Газар шим үйлдвэр" ХХК нь "Монгол Улсын Компанийн тухай" хууль, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хууль болон "Санхүүгийн зохицуулах хороо", "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн холбогдох журмуудын дагуу шинээр хувьцаа гарган олон нийтэд санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөгөөг авахыг зөвлөж байна.

Үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ХК бүртгэсэн нь уг үнэт цаасны эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Тус үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны хувьцаа худалдан авах шийдвэр гаргалтад туслах, шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг оруулахыг зорилоо. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс бусад дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай буюу лавлах тодруулах зүйлсийг үнэт цаас гаргагч "Газар шим үйлдвэр" ХХК, андеррайтер "Новел инвестмент ҮЦК" ХХК компанид хандана уу.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч	“Газар шим үйлдвэр” ХХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт гаргасан хувьцааны тоо	1,000,000,000 ш
Шинээр нэмж гаргаж буй хувьцааны тоо	198,113,207
Нэмж гаргасны дараах хувьцааны тоо ширхэг	1,198,113,207
Олон нийтэд санал болгож буй хувьцааны хувь	16.54%
Нэгж хувьцааны үнэ	53 төгрөг
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	10,499,999,971 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Хүнсний ногооны зоорь барих; Бүтээгдэхүүн хөгжүүлэлт; Бэлтгэх дамжлагын автоматжуулалт; Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт.
Компани нийт хувьцааны зах зээлийн үнэлгээ	63,499,999,971 төгрөг
Олон нийтэд санал болгох нөхцөл	
Хувьцааг олон нийтэд санал болгох хэлбэр	Арилжаа эрхлэх байгууллага
Хувьцааг олон нийтэд санал болгох арга	Тогтоосон үнийн арга

СЗХ БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1 Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэл

"Газар шим үйлдвэр" ХХК нь "ГБТ трейдинг" ХХК нэртэйгээр 1999 оны 7 дугаар сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, 1999 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд 2577127 тоот регистрийн дугаартайгаар бүртгүүлж, Монгол улсад даршилсан ногооны анхны үйлдвэрийг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Компанийн нэрийг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр олон нийтэд танигдаж, хэвшсэн нэршлийн дагуу "Газар шим үйлдвэр" ХХК болгон өөрчилсөн.

Үнэт цаас гаргагчийн мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт-1

Оноосон нэр	"Газар шим үйлдвэр" ХХК
Компанийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Байгуулагдсан огноо	1999 оны 7 дугаар сарын 23-ны өдөр
Улсын бүртгэлд бүртгэсэн огноо	1999 оны 7 дугаар сарын 26-ны өдөр
Улсын бүртгэлийн дугаар	9011110110
Регистрийн дугаар	2577127
Үйл ажиллагааны чиглэл	• Хүнсний ногоо савлаж худалдаалах • Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх • Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх • Гадаад худалдаа эрхлэх • Хүнсний ногоо тариалах, худалдах • Жимс жимсгэнэ тариалах, худалдах • Ундаа, жүүс үйлдвэрлэх • Цайны газар эрхлэх • Хүнсний дэлгүүр эрхлэх • Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл • Үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, худалдаа, зуучлал түрээсийн үйлчилгээ эрхлэх • Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэх • Газар тариалан эрхлэх • Цайны үйлдвэрлэл худалдаа • Фермерийн аж ахуй эрхлэх • Хүлэмжийн аж ахуй эрхлэх
Хувьцаа эзэмшигчийн тоо	6
Дүрмийн сангийн хэмжээ	110.000.000
Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа	Хугацаагүй
Гүйцэтгэх захирал	Цээпэл овогтой Ганбат
Хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, /16102/, 66/01, 66/02.
Цахим хуудас	www.gazarshim.mn
Утас	7505-9933, 7505-9999

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.2 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хурлаар шинэчлэн батлсан компанийн дүрэмд үнэт цаас гаргагчийн нийт хувьцаа нь нэг бүр нь 0.11 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000,000,000 ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоож, дээрх хувьцаа нь зургаан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд бүртгэлтэй байна. Үнэт цаас гаргагчийн компанийн дүрэм, 2020, 2021 оны санхүүгийн тайлан тэнцлээс үзэхэд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 110,000,000 төгрөг бол өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмчийн хэмжээ 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 17,926,247,956 төгрөг 2021 оны тайлангаар 21,578,333,627 төгрөг болж нэмэгдсэн байна. Өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эзэмшигчдийн өмчийн хэмжээ нэмэгдэхэд үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдсэн нь нөлөөлжээ.

1.3 Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүн

Компанийн тухай хуулийн дагуу үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааг Монгол Улсын 5 иргэн, Герман улсын 1 иргэн тус тус эзэмшдэг бөгөөд үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч Ц.Ганбат, З.Байгалмаа, Ц.Төгсөө, Д.Сэргэлэн, Г.Түвшинзаяа нар холбоотой этгээдүүд юм.

Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааг өргөтгөх, компанийн засаглал, мэдээлэл тайлагналын ил тод байдлыг сайжруулж, аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэн сайн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх зорилгоор нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгон, компанийн хэлбэрийг өөрчлөхөөр хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн. Үнэт цаас гаргагч нь компанийн хэлбэрээ өөрчилж, олон нийтийн компани болсноор даршилсан ногоо үйлдвэрлэгч бусад аж ахуйн нэгжүүдээс анхдагч олон нийтийн компани болох юм.

Өнөөдрийн байдлаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээ дараах байдалтай байна.

Хүснэгт-2

№	Хувьцаа эзэмшигчид	Гаргасан хувьцаа	
		Тоо ширхэг	Хувь хэмжээ
1	Ц. Ганбат	510,000,000	51%
2	Ц. Төгсөө	130,000,000	13%
3	З. Байгалмаа	110,000,000	11%
4	Штеффэн Мэлцэр	150,000,000	15%
5	Д. Сэргэлэн	50,000,000	5%
6	Г. Түвшинзаяа	50,000,000	5%
	Нийт	1,000,000,000	100%

- Хувьцаа эзэмшигч Цээпэл овогтой Ганбат нь 1964 оны 10 дугаар сарын 28-нд Увс аймгийн Улаангом сумд төрж, Увс аймгийн Улаангом сумын 1-р 10 жилийг 1982 онд төгссөн. Улмаар 1988 онд Герман улсын Берлин хотын Эдийн засгийн дээд сургуулийг Эдийн засагч мэргэжилээр бакалаврын зэрэг хамгаалсан. 1992-1995 онд "АЗ" ББХК-д захирал, "НИК" ХК-ийн Зах борлуулалтын газрын дарга, 1996-2000 онд "Глобал Инвест" ХХК-д дэд захирал, 1999-оноос одоог хүртэл "Газар шим үйлдвэр" ХХК-д ерөнхий захирлаар ажиллаж байна.
- Цээпэл овогтой Төгсөө нь 1988 онд Увс Улаангомын 10 жилийн 2-р дунд сургуулийг, 1989-1992 онд Украйны Донецк хотын "Худалдааны дээд сургуулийг хүнсний бараа судлал мэргэжлээр, 1992-1996 онд Казакстаны Алма-Ата хотын "Удирдлагын академи"-д шилжин суралцаж эдийн засагч, бараа судлалын мэргэжлээр төгссөн. 2011 онд Монгол-Японы төвөөс зохион байгуулдаг "Япон маягийн менежмент"-ийн курсийг төгсөж, 2012 онд Жайка байгууллагын тусламжтайгаар Японы 21 хоногийн Японы үйлдвэрүүдтэй танилцах сургалтанд хамрагдсан.

СЭХ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ 03

- 2008 оноос "Артишок Монголд" төслийн ерөнхий зохицуулагчаар ажиллаж, Экологи хөгжил ТББ, ХААИС-ийн сургалт үйлдвэрлэлийн нарт төв, Монос АУДэС, ШУТИС-ийн докторууд, Клиникийн 3-р эмнэлгийн дотоод шүүрлийн тасаг зэрэг байгууллагуудтай хамтран Монголд нутагшуулсан артишокоор ШУ-ыг үйлдвэрлэлтэй холбосон туршилт, судалгаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг хийж 2010 онд Артишок эрүүл мэндийн зохицуулах үйлчилгээтэй ундааг зохион бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. 2017 оноос Ургамлын гаралтай хүнсний стандартчиллын дэд хорооны гишүүнээр 2019 оноос Монголын Хүнсчдийн Холбоо-ны Удирдах зөвлөлд Жимс ногоо боловсруулагчид болон бусад салбар зөвлөлийн даргаар ажиллаж байгаа. 1999 оноос Газар шим үйлдвэр ХХК-д Технологич, Ерөнхий технологич, Дэд захирал, Үйлдвэр эрхэлсэн захирлаар ажиллаж байна.
- Занашир овогтой Байгалмаа нь 1982 онд Увс аймгийн Улаангом 1-р 10 жилийг төгссөн, 1992 онд Эрхүү хотын Политехникийн их сургуулийг Инженер геологич мэргэжлээр суралцаж төгссөн. Улмаар 1999 онд Отгонтэнгэр их сургуулийг Эрхзүйч мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан. 1988-1992 онд Эрэл геофизикийн цогцолбор экспедизид геологийн инженер, 1992-1999 онд Патентын газар Шинжээч, 1999-2008 "Газар шим үйлдвэр" ХХК-д Хөрөнгө оруулалтын менежер, 2009-2015 онд оюуны өмчийн газар Улсын хяналтын байцаагч, 2016 оноос хойш "Газар шим үйлдвэр" ХХК -д Захиргаа, удирдлага хариуцсан захирлаар ажиллаж байна.
- Дүгэржав овогтой Сэргэлэн нь 1988 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1-р арван жилийн сургуулийг төгссөн. 1988-1989 онд ОХУ-н Эрхүү хотын их сургуулийн хэлний бэлтгэл, 1995 онд Казахстан улсын Алмата хотын АЗВИ-ийг, 2012-2014 онд Удирдлагын академи "Бизнес удирдлагын Бакалавр", 2015-201 онд Бизнес удирдлагын Магистрын зэрэг эзэмшсэн.
- 1999 онд "Газар шим үйлдвэр" ХХК-д борлуулагчаар ажиллаж эхэлсэн бөгөөд, 2002-2008 онд борлуулалтын ахлах менежер, 2009-2019 онд Маркетинг борлуулалтын албаны дарга, 2020 оноос Маркетинг, борлуулалт хариуцсан захирлаар ажиллаж байна.
- Ганбат овогтой Түвшинзаяа нь 2000 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн. Нийслэлийн ерөнхий боловсролын Үй Цай сургуулийг 2017 онд төгссөн. Одоо Тайваны Венхуа их сургуульд Олон улсын бизнес мэргэжлээр суралцаж байна.
- Gerd Steffen Melzer нь 1960 оны 12 сарын 25-нд Герман улсын "Zschopau" хотод төрсөн. 1967-1975 онд бага сургууль, 1975-1979 онд "Erweiterte Oberschule Clara Zetkin Zschopau" дунд сургууль, 1979-1982 онуудад цэргийн алба хааж, 1982-1986 онд Берлин хотын Гумбольдт их сургуулийг хуульч мэргэжилээр төгссөн. 1986-1990 онд Бүгд Найрамдах Ардчилсан Герман улсын ГХЯ-ны Хууль зүйн хэлтэст, 1991-1998 онд Герман улсын Халле дахь "Холбооны ачаа тээврийн агентлаг"-ын хуулийн хэлтсийн дарга, 1999.01.01-ээс одоог хүртэл "GERMON Steffen Melzer Trade & Service" хувийн компанийг үүсгэн байгуулж захиралаар нь ажиллаж байна.

1.4 Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар бүлгээр үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж үнэт цаас гаргагчийн танилцуулгад тусгагдах агуулгын бүрэлдэхүүнийг хуульчилж өгсөн бөгөөд тус хуулийн дагуу үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч Ц.Ганбат, Ц. Төгсөө, Штеффэн нар нь өөр компанийн хяналтын багц болон нийт гаргасан хувьцааг эзэмшдэг тул хамааралтай компаниудыг мэдээлж байна.. Харин бусад хувьцаа эзэмшигчид болох З.Байгалмаа Д.Сэргэлэн, Г.Түвшинзаяа нар аливаа хуулийн этгээдийн хувьцаа эзэмшиж, гүйцэтгэх удирдлагад ажилладаггүй байна.

Хувьцаа эзэмшигч Ц.Ганбатын эзэмшлийн "Батхүдэр" ХХК, "Шинэ хүдэр" ХХК-ийн мэдээллийг доорх хүснэгтээр үзүүлбэл.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Хүснэгт-3

Овог нэр	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдийн оноосон нэр	Үндсэн үйл ажиллагааны чиглэл	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдэд эзэмшдэг хувьцааны хэмжээ
Цээпэл ГАНБАТ	"Батхүдэр" ХХК	Гадаад худалдаа	100%
	"Шинэ Хүдэр" ХХК	Гадаад худалдаа /Бизнесийн зөвлөгөө өгөх, Худалдаа зуучлал/	100%

- "Бат хүдэр" ХХК нь 2014 оны 7 дугаар сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Улсын бүртгэлд 2014 оны 7 дугаар сарын 28-ны өдөр бүртгүүлсэн бөгөөд тус компани нь гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 төгрөг ба нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 ширхэг энгийн хувьцаатай.
- "Шинэ Хүдэр" ХХК нь 2018 оны 3 дугаар сарын 13-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Улсын бүртгэлд 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдөр бүртгэгдсэн бөгөөд тус компани нь гадаад худалдаа, бизнесийн зөвлөгөө өгөх, худалдааны зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 төгрөг бөгөөд нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 ширхэг энгийн хувьцаатай.

Хувьцаа эзэмшигч Ц.Төгсөөгийн эзэмшлийн "Эйч Эс Зэт" ХХК-ийн мэдээллийг доорх хүснэгтээр үзүүлбэл.

Хүснэгт-4

Овог нэр	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдийн оноосон нэр	Үндсэн үйл ажиллагааны чиглэл	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдэд эзэмшдэг хувьцааны хэмжээ
Цээпэл ТӨГСӨӨ	"Эйч Эс Зэт" ХХК	Худалдааны зуучлал, Барилгын материалын худалдаа, Барилгын засал чимэглэл, гадаад худалдаа	100%

- Хувьцаа эзэмшигч Ц.Төгсөө нь 2008 оны 5 дугаар сарын 02-ны өдөр "Эйч Эс Зэт" ХХК-ийг үүсгэн байгуулсан бөгөөд уг компани нь үүсгэн байгуулах үед Худалдааны зуучлал, Барилгын материалын худалдаа, Барилгын засал чимэглэл, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр улсын бүртгүүлсэн. Улмаар 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдөр үйл ажиллагааны чиглэлийг өргөтгөж хүнсний бүтээгдэхүүний агуулахын аж ахуй эрхлэх, хүнсний ногоо, жимс, ургамлын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр нэмж улсын бүртгэлд бүртгүүлсэн. Тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 төгрөг ба нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 ширхэг энгийн хувьцаатай байхаар компанийн дүрэмд тусгагдсан.

Хувьцаа эзэмшигч Штеффэн Мэлцэрийн эзэмшлийн "GERMON Steffen Melzer Trade & Service" -ийн мэдээллийг доорх хүснэгтээр үзүүлбэл.

Хүснэгт-5

Овог нэр	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдийн оноосон нэр	Үндсэн үйл ажиллагааны чиглэл	Холбоо хамаарал бүхий хуулийн этгээдэд эзэмшдэг хувьцааны хэмжээ
Штеффэн Мэлцэр	"GERMON Steffen Melzer Trade & Service"	Худалдааны зуучлал	100%

- "GERMON Steffen Melzer Trade & Service" нь 1999 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр үүсгэн байгуулагдсан бөгөөд тус компани нь гадаад худалдаа, худалдааны зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг.

СЭХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.5 Үнэт цаас гаргагчийн танилцуулга

Үнэт цаас гаргагч "Газар шим үйлдвэр" ХХК буюу бидний мэдэхээр Газар шим компани нь 1999 онд Монголын улсад даршилсан хүнсний ногооны анхны үйлдвэрийг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд үйлдвэрлэл эхэлсэн эхний жил 2 төрлийн 20.0 мянган шил бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол өнөөгийн байдлаар өргөст хэмх, салат, компот, гүн хөлдөөсөн ногоо, ногооны нухаш, Артишок эрүүл мэндийн ундаа зэрэг нийт 60 гаруй нэр төрлийн 8 сая шил бүтээгдэхүүн үйлдвэрлэж салбартаа тэргүүлэгч үндэсний үйлдвэрлэгч компани болсон.

Үйлдвэрлэл эхлүүлсэн эхний жилүүдэд улирлын чанартай үйлдвэрлэл явуулж байсан бол 2007 оноос байнгын үйлдвэрлэл явуулах болсноор үйл ажиллагаа жигдэрч, ажилчид ажилдаа мэргэшин бүтээгдэхүүний болон чанарын доголдлыг арилгаж, компанийн үйлдвэрлэл, борлуулалт, үр ашиг сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй нэмэгдэж ирсэн. 2008 оноос үйлдвэр хүнсээр дамжуулан "Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр" боловсруулан туршилт судалгаанууд хийсний үр дүнд 2011 онд "Артишок" эрүүл мэндийн ундааг үйлдвэрлэн гаргасан бөгөөд ундааны түүхий эдийг Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь өөрийн хүлэмжийн аж ахуйдаа эко стандартыг баримтлан тарьж ургуулж байна.

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээ өөрсдийн боловсруулсан монгол технологи, жороор үйлдвэрлэж, ямар нэгэн тогтворжуулагч бодис, консервант хийдэггүй, зөвхөн дулааны боловсруулалт хийх замаар даршилдаг. Ийм учир бүтээгдэхүүнийг задалснаас хойш бусад бүтээгдэхүүн шиг удаан хадгалж болдоггүй. Жилээс жилд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж энэ төрлийн бүтээгдэхүүний дотоодын зах зээл дээрх тэргүүлэх байр суурыа улам бататган ажиллаж байна.

2007-2009 онуудад үйлдвэрийн тоног төхөөрөмжийн 80 хувийг шинэчилж өндөр даралт, өндөр температурт ариутгах иж бүрэн автомат автоклав, механик автоклав болон бусад тоног төхөөрөмжийг суурилуулсан. Энэхүү шинэчлэлийн үр дүнд бүтээгдэхүүний нэр төрөл, амт чанар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн, ажлын нөхцлийг сайжруулсан бол 2013 онд иж бүрэн автомат ундааны үйлдвэрийг ашиглалтанд оруулсан.

2018 онд нийт 10000 м2 үйлдвэрийн байр, оффисын байр, бэлэн бүтээгдэхүүний агуулах, түүхий эдийн агуулах, нян судлалын болон хими-хор судлалын, чанарын ба аюулгүйн үзүүлэлтийн бүрэн шинжилгээг өндөр түвшинд хийх хүчин чадалтай лабораторитой иж бүрэн үйлдвэрийн цогцолборыг шинээр барьж ашиглалтанд оруулсан. 2019 онд Голланд улсын EFM Machinery машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрийн цагт 3000-6000 бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, бүрэн автомат шугамыг үйлдвэртээ суурилуулан ашиглалтанд оруулсан бөгөөд салбартаа анхдагч Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000:2005-ийг нэвтрүүлсэнээс гадна Монгол улсад Хүнсний салбарт анх удаа GMP олон улсын стандартуудыг амжилттай хэрэгжүүлсэн үндэсний үйлдвэрлэгч компани юм. Дээрх ISO стандартуудыг 3 жилийн хугацаатайгаар давтан баталгаажуулж 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000:2005-ийг ISO 22000:2018 болгон шинэчлэн баталгаажуулав.

"Газар шим үйлдвэр" ХХК нь Улаанбаатар хотод нэрийн барааны дэлгүүр, супермаркет, сүлжээ дэлгүүрүүд, хүнсний захуудад, хүнсний дэлгүүрүүд болон хөдөө орон нутагт гэрээт борлуулагч, гэрээт харилцагч нараараа дамжуулан Монгол орон даяар өөрийн бүтээгдэхүүнээ борлуулж, 190 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагчийн ололт, амжилтийг үзүүлбэл

- 2003, 2004, 2005 онуудад Нийслэлийн шилдэг бүтээгдэхүүн.
- 2005 он ХХААЯ-аас "Монгол улсын жимс, хүнсний ногоо боловсруулах шилдэг үйлдвэрлэгч" өргөмжлөлтэй.
- 2007 он ХХААЯ-аас "Монгол улсын жимс, хүнсний ногоо боловсруулах шилдэг үйлдвэрлэгч" өргөмжлөлтэй.
- 2010 он ХХААЯ-аас "Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн" өргөмжлөлтэй.
- 2011 он ХХААХҮЯам, НЗДТГазар, МҮХАҮТанхимын хамтарсан шагнал – Эрүүл мэндийг тэтгэгч шилдэг бүтээгдэхүүн.
- 2012 он Best Green New Product Award.
- 2013 он Best Green New Product Award.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

- 2013 он Инноваци лицензийн хэрэгжүүлэгч брэнд.
- 2015 он Татварын ерөнхий газрын тэргүүн шагнал "Хөх дэвтэр"
- 2018 он Салбартаа анх удаа Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000 олон улсын стандартуудыг амжилттай нэвтрүүлж батламжаа гардан авсан бөгөөд Хүнсний салбарт анх удаа GMP олон улсын стандартуудыг амжилттай хэрэгжүүлсэн байгууллага боллоо.
- 2019 он ХХАА-аас зохион байгуулдаг Намрын ногоон өдрүүд үзэсгэлэнгээс "Байцаатай салат" "Ард түмний хүнс" шагнал авсан.
- 2019 он "Монгол Брэнд холбоо" ТББ, АНУ-ын Вашингтон дахь "Ази Америкийн Худалдааны Танхим"-тай хамтран "Америкт экспортолъё" арга хэмжээнээс АНУ-ын зах зээлд өрсөлдөх Монголын 10 компанийн нэгээр шалгарсан.
- 2020 он Артишок эрүүл мэндийн ундаа, Артишокийн өтгөрүүлсэн ханд бүтээгдэхүүнүүдийн түүхий эдийн тариалалт, үйлдвэрлэлийн болон түгээлтийн үйл явцад албан ёсоор баталгаажуулалт хийгдэж органик бүтээгдэхүүн болсон.

1.5.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго, алсын хараа

Үнэт цаас гаргагч нь 1999 онд үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш хүнсний салбарт тэргүүлэгч байр суурыа хадгалан, бүтээгдэхүүний нэр төрлөөс хамааран зах зээлийн 23-40 хувийг эзлэн хэрэглэгчид чанартай, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх чиглэлээр байнга техник технологио сайжруулан, чанар стандартыг нэвтрүүлэн, GMP үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэрэгжүүлэн ажилладаг. Тус компани нь эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ дараах байдлаар тодорхойлжээ.

Хүснэгт-6

Эрхэм зорилго	Хүнээ дээдлэн эрүүл, чанартай хүнс үйлдвэрлэгч, шинийг санаачлагч, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэгч компани байна.
Алсын хараа	Дэлхийн жишигт хүрнэ.
Засаглалын зарчим	• Хариуцлагатай байдал • Ил тод, шударга байдал • Ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх • Хэрэглэгч, хөрөнгө оруулагч, олон нийтийн эрх ашгийг дээдлэх
Үнэт зүйлс	Хүн Чанар Хөгжил

1.5.2 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь 1999 оноос үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших хугацаанд 7 үндсэн төрлийн нийт 63 төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд түгээж байна. Бүтээгдэхүүний нэр төрлөөс дурьдвал алаг салат, даршилсан өргөст хэмх, олон нэр төрлийн компот, нухаш, хөлдөөсөн ногоо, хиймэл зөгийн бал, артишок ундаа зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа ба үйлдвэрийн өргөжилт хөрөнгө оруулалттай холбоотойгоор цаашид нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн, зах зээлд таниулан, зах зээлийн 20 хувийг хангах зорилтыг тавин ажиллаж байна.

Хүснэгт-7

Үйл ажиллагааны чиглэл	• Хүнсний ногоо савлаж худалдаалах • Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх • Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх • Гадаад худалдаа эрхлэх • Хүнсний ногоо тариалах, худалдах • Жимс жимсгэнэ тариалах, худалдах • Ундаа, жүүс үйлдвэрлэх • Цайны газар эрхлэх • Хүнсний дэлгүүр эрхлэх

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

	• Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл • Үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр зөвлөгөө өгөх, худалдаа, зуучлал түрээсийн үйлчилгээ эрхлэх • Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхлэх • Газар тариалан эрхлэх • Цайны үйлдвэрлэл худалдаа • Фермерийн аж ахуй эрхлэх • Хүлэмжийн аж ахуй эрхлэх
Нэрийн дэлгүүрийн хаяг	• Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, 10-р хорооллын автобусны буудлын урд.1 давхар ногоон барилга. • Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Нохойтой хөшөөний тойргоос баруун тийш 700м, Жанжин зах дотор. • Нарантуул зах, өргөтгөлийн 60 болон 167-р павильон
Бүтээгдэхүүн үйлчилгээ	• Салат ◇ Чинжүүтэй 570 мл ◇ Хаштай салат 570 мл ◇ Мөөгтэй лечо 570 мл ◇ Лечо 570 мл ◇ Өег салат 570 мл ◇ Өег салат /халуун чинжүүтэй/ 570 мл ◇ Винегрет салат 550 мл ◇ Хүрэн манжингийн салат 725 мл ◇ Хүрэн манжингийн салат 550 мл ◇ Хүрэн манжингийн салат 305 мл ◇ Байцаатай салат 550 мл ◇ Байцаатай салат 280 мл ◇ Алаг салат 280 мл ◇ Алаг салат 550 мл ◇ Өег салат 280 мл ◇ Өег салат 550 мл • Өргөст хэмх ◇ Шинэ монгол өргөст хэмх /саримстай/ 725 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /саримстай/ 925 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /саримстай/ 1680 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /cucumber/ 720 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /cucumber/ 920 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /cucumber/ 1680 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /for sandwich/ 725 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /stick/ 725 мл ◇ Шинэ монгол өргөст хэмх /for salad/ 725 мл ◇ Өргөст хэмх 720 мл ◇ Өргөст хэмх 920 мл ◇ Өргөст хэмх 1680 мл ◇ Өргөст хэмх 3000 мл ◇ Огурцы чигчийхэн 720 мл ◇ Огурцы 3000 мл ◇ Огурцы 725 мл ◇ Огурцы 920 мл ◇ Огурцы 1680 мл

СЭХ
2023 он 01 сар 25
БҮРТГЭВ
№ .1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Бүтээгдэхүүн үйлчилгээ	• Компот ◇ Интоорын компот 920 мл ◇ Олон жимстийн компот 920 мл ◇ Үхрийн нүдний компот 920 мл ◇ Хар чавганы компот 920 мл ◇ Абрикосны компот 920 мл ◇ Тоорын компот 920 мл ◇ Алимны компот 920 мл • Нухаш ◇ Шимт нухаш– Амтат чинжүү ◇ Шимт нухаш– Хаш ◇ Шимт нухаш– Хулуу ◇ Шимт нухаш– Хүрэн манжин ◇ Шимт нухаш– Лууван • Хөлдөөсөн ногоо ◇ Гүн хөлдөөсөн амтат чинжүү 400г ◇ Гүн хөлдөөсөн холимог ногоо 400г ◇ Гүн хөлдөөсөн цэцэгт байцаа 400г ◇ Гүн хөлдөөсөн брокколи 400г ◇ Гүн хөлдөөсөн хулуу 400г ◇ Гүн хөлдөөсөн үхрийн нүд 400г ◇ Гүн хөлдөөсөн интоор 400г • Ундаа ◇ Артишок ундаа 250 мл /зөгийн балтай/ ◇ Артишок ундаа 250 мл /сахаргүй/ ◇ Артишок өтгөрүүлсэн ханд 480 мл /зөгийн балтай/ ◇ Артишок өтгөрүүлсэн ханд 480 мл /сахаргүй/ ◇ Артишок өтгөрүүлсэн ханд 2л /зөгийн балтай/ ◇ Артишок өтгөрүүлсэн ханд 2л /сахаргүй/ • Зөгийн бал ◇ Зөгийн бал 220 мл ◇ Зөгийн бал 280 мл ◇ Зөгийн бал 725 мл
Үйл ажиллагааны чанар, стандарт	• Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001 • Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 22000:2005 • GMP олон улсын стандартууд
Цаашид зах зээлд үйлдвэрлэн нийлүүлэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн	Үнэт цаас гаргагч нь цаашдаа майонез, амтлагч, кетчуп, жимсний чанамал, нухашны төрлийн бүтээгдэхүүнүүдийг шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж байна.
Зорилтот зах зээл	• Борлуулалтыг нэмэгдүүлж даршилсан ногоо, салат, компотны зах зээлд эзлэх хувийг 50 хувьд хүргэх; • Нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн, зах зээлд таниулж, зах зээлийн 20 хувийг эзлэх.

Үнэт цаас гаргагч нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр үйлдвэрлэлд ашиглаж буй техник, тоног төхөөрөмжийг Герман, Голланд, АНУ, БНХАУ, Тайван зэрэг улсуудаас үйлдвэрлэлийн онцлог, бүтээгдэхүүн нэр төрлөөс хамруулан худалдан авч, үйлдвэрлэлд ашигладаг. Техник, технологийн сайжруулалтыг тасралтгүй хийснээр бүтээгдэхүүн нэр төрөл нэмэгдэж, чанар стандарт олон улсын жишигт хүрч, голлогч бүтээгдэхүүнүүдийг гадаад зах зээл, хөрш орнуудад нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03





Хүнсний ногоо хадгалах хөргүүр, Гүн хөргөлтийн агуулах, Хагас боловсруулсан түүхий эд хадгалах агуулах, бэлэн бүтээгдэхүүний агуулах нийт 10000 м2 талбай бүхий үйлдвэрийн иж бүрэн цогцолбортой.





Нян судлалын болон хими-хор судлалын, чанарын ба аюулгүйн үзүүлэлтийн бүрэн шинжилгээг өндөр түвшинд хийх хүчин чадалтай лабораторий.

2023 .01. 25
он сар едер
№ :11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03







Газар шим үйлдвэр ХХК нь артишокийг Монголд 2007 онд АНУ-ын Калифорниос "Навчит" гэсэн эмчилгээний сортын үрийг тарьж нутагшуулсан. 2011 оноос Артишок эрүүл мэндийн ундааг үйлдвэрлэж эхэлсэн. Ундааны түүхий эдийг Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь өөрийн хүлэмжийн аж ахуйдаа тарьж ургуулж байна. Артишок нь "Органик" Монгол бүтээгдэхүүн юм.

Схем-1

Үйлдвэрлэлийн функц



Үнэт цаас гаргагч нь хүнсний аюулгүй байдлын сулжээний бүх шатанд хүнсний аюулгүй байдлыг хангасан чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд чиглэн ажилладаг бөгөөд энэ хүрээнд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага MNS ISO 22000:2019, стандартын шаардлагад нийцүүлэн удирдлагын зөв тогтолцоог бий болгож, тогтвортой үр дүнтэй хэрэгжүүлэх замаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажилладаг.

Чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн бий болгоход үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж, түүхий эд, сав баглаа боодол, үйлдвэрлэлийн орчин, ажилтнуудын ур чадварыг уялдуулан шинэчлэх шаардлага байнга тулгардаг. Тиймээс гарал үүслийн гэрчилгээтэй, хууль, дүрэм, журам, шаардлагад нийцэж байгааг нотлох нэмэлт сорилт шинжилгээний материалууд, дагалдсан түүхий эд, жор орцын бүрдэл хэсгүүд, сав баглаа боодол ашиглаж, үйлдвэрлэлд эрүүл ахуйн болон үйлдвэрийн зохистой дадал GMP нэвтрүүлж Хүнс үйлдвэрлэлээс хэрэглэгч хүртэлх бүхий л үе шатанд ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдлыг бүрэн хангаж, эрсдэлгүй, чанар стандартын шаардлагыг бүрэн хангасан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа тул голлогч бүтээгдэхүүнүүдийг гадаад зах зээл дээр нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

Хүнсний үйлдвэрлэлийн салбарт мөрдөгддөг үйлдвэрлэлийн GMP зохистой дадлыг үйлдвэрлэлийн бүх шатанд мөрдүүлэн ажилладаг.

Хүснэгт-8

Үзүүлэлт	Зохистой дадлыг хэрэгжүүлсэн байдал
Үйлдвэрлэлийн байранд тавигдах шаардлага	• Үйлдвэрлэлийн байршлыг орчны эрүүл, ахуйн аюулгүй, байдал зөрчигдсөн, үер усны хамгаалалтгүй голын хөндий уулын бэл, хог хаягдлыг зайлуулах боломжгүй газар байгуулахгүй байх; • Барилга байгууламж нь засвар үйлчилгээ, цэвэрлэгээ ариутгал халдваргүйтгэл хийхэд хялбар бат бөх, гадны биет эвгүй үнэр амтыг хүнсний бүтээгдэхүүнд дамжуулахгүй материалаар хийгдсэн байх; • Барилгын дотоод бүтэц зохион байгуулалт нь технологийн дамжлагын нэг чиглэлийн урсгалтай, технологи, үйл ажиллагааны явцад хүнсний бүтээгдэхүүн бохирдлоос бүрэн хамгаалагдсан, чийдэнгийн шил хагарч хоол хүнсэнд орохоос хамгаалагдсан, үйл ажиллагаанд тохирсон гэрэлтүүлэгтэй, агаарын урсгал цэвэр хэсгээс бохирдолтой хэсэг рүү чиглэсэн тоноглолтой байх;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Үзүүлэлт	Зохистой дадлыг хэрэгжүүлсэн байдал
Тоног төхөөрөмжид тавигдах шаардлага	Үйлдвэрлэлийн технологийн шаардлага хангасан тусгай захиалгаар ХБНГУ-д үйлдвэрлэсэн зориулалтын бүрэн болон хагас автомат шугамтай, тэгш гөлгөр, хүчил шүлтэд тэсвэртэй зэвэрдэггүй материалаар хийсэн гадаргуутай тоног төхөөрөмж ашигладаг бөгөөд тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хуваарийн дагуу зориулалтын бодис, материал ашиглан тогтмол хийгддэг.
Хэрэглээний усанд тавигдах шаардлага болон ариутгал цэвэрлэгээ	Хүнсний үйлдвэрлэлд төвийн шугамын усыг 4 давхар шүүлтүүрээр шүүж хэрэглэдэг бөгөөд пастеризаторын хөргөлтөнд ашиглагдсан усыг үйлдвэр, гадны орчинд цэвэрлэгээнд хэрэглэж, галын ослын үед ашиглах нэмэлт нөөцлүүрийн савыг байршуулсан. Ариутгал цэвэрлэгээний цэгийг шаардлагатай газарт байршуулж, дэвшилтэд тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.
Түүхий эд бүтээгдэхүүнд тавигдах шаардлага	• Гарал үүсэл нь тодорхой, ургамал хорио цээр, чанар аюулгүйн баталгаажилттай үндсэн болон туслах түүхий эдийг хүлээж авна. • Түүхий эд, үйлдвэрлэлийн явц, бэлэн болсон бүтээгдэхүүнд өөрийн лабраторид хими, физик, микробиологийн шинжилгээнүүдийг хийдэг. • Түүхий эдийг хөргөлттэй зоорь болон гүн хөлдөөгч агуулахад хадгалах горимын дагуу хадгалж, хадгалалтын горимд хяналт тавьж бүртгэл хөтөлнө.
Технологийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага	• Бүтээгдэхүүний нэр төрөл бүрээр гаргасан технологийн зааврыг мөрдөж ажилладаг. Эрсдэл үүсэхээс сэргийлж хяналтын бүртгэл хөтөлдөг. • Үйлдвэрлэлийн дамжлага дунд хадгалах, угааж цэвэрлэх, хэрчих, савлах, ариутгах болон эцсийн бүтээгдэхүүнд технохимийн хяналт тавьж бүртгэдэг. • Үйлдвэрлэлийн бүх дамжлага дээр технологийн процессын хяналттай. • Шил ариутгах автомат шугамтай.
Бүтээгдэхүүний хаяг шошго, хадгалалт, тээвэрлэлт	• Бүтээгдэхүүний шошгыг мэдээлэл стандартын шаардлага хангасан • Бүтээгдэхүүний дээжийг 37 градусын температурт 72 цаг хадгалаад дахин шинжилж борлуулах зөвшөөрөл олгодог. • Бэлэн бүтээгдэхүүний стандартын шаардлага хангасан агуулахтай. Температур чиглэлийг байнга хянаж бүртгэдэг. • Өөрийн борлуулалтын албатай. • Бүтээгдэхүүн борлуулалтын буюу бүтээгдэхүүний ул мөрийн бүртгэл хөтөлдөг.

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн үйлдвэрлэлийн үйл явцыг түүхий эд, үйлдвэрлэл, борлуулалт, борлуулалтын суваг гэсэн процессын төрлөөр тус бүрээр нарийвчлан авч үзвэл дараах байдалтай байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ 03

Үйлдвэрлэлийн процесс:

Схем-2







МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ТҮҮХИЙ ЭД

Ногоочид

Импортын түүхий эд

ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

КОМПОТ



Бэлтгэх → Жинлэх → Савлах → Уусмал савлах → Дулааны боловсруулалт

Шошго наах, огноо дарах → Багцлах → Бэлэн бүтээгдэхүүн → Борлуулалт, түгээлт

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

- Нэрийн барааны дэлгүүр
- Сүлжээ дэлгүүрүүд
- Зах, бөөний төвүүд
- 6 болон 8 нэрийн дэлгүүрүүд
- Хөдөө орон нутгийн гэрээт борлуулагчид

ТҮҮХИЙ ЭД

Газаршим

Өөрийн эзэмшлийн органик тариалалт

ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

АРТИШОК



Хандлах → Ханд бариулах → Шүүх → Ундаа найруулах → Савлах

Шошго наах, огноо дарах → Багцлах → Бэлэн бүтээгдэхүүн → Борлуулалт, түгээлт

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

- Нэрийн барааны дэлгүүр
- Сүлжээ дэлгүүрүүд
- Зах, бөөний төвүүд
- 6 болон 8 нэрийн дэлгүүрүүд
- Хөдөө орон нутгийн гэрээт борлуулагчид

ТҮҮХИЙ ЭД

Ногоочид

Импортын түүхий эд

ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

ХӨЛДӨӨСӨН НОГОО



Бэлтгэх → Хэрчих → Хатаах → Хөлдөөх → Жинлэх → Савлах

Шошго наах, огноо дарах → Вакум жуулах → Бэлэн бүтээгдэхүүн → Борлуулалт, түгээлт

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

- Нэрийн барааны дэлгүүр
- Сүлжээ дэлгүүрүүд
- Зах, бөөний төвүүд
- 6 болон 8 нэрийн дэлгүүрүүд
- Хөдөө орон нутгийн гэрээт борлуулагчид

"НОБЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOBEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн танилцуулга

Үнэт цаас гаргагч нь даршилсан ногоо үйлдвэрлэлийн бүх шатанд ашиглагдах тоног төхөөрөмжийг ХБНГУ, Голланд, Хятад, Тайван, АНУ-д үйлдвэрлэлийн онцлог, түүхий эд, үйлдвэрлэлийн онцлогт тохируулан захиалгаар хийлгэсэн. Үйлдвэрийн шугамыг захиалгаар Өег салат, Байцаатай салат гэсэн өвөрмөц бүтээгдэхүүнүүдэд зориулж Европ стандарт, уламжлалт туршлагад үндэслэн гэртээ хийсэн мэт амт, чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтой чанах, савлах иж бүрэн шугамыг Голланд улсад захиалж хийлгэсэн.

Бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч 1 цагт 3000-6000 шил бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай 1 шугам, цагт 2500 шил савлах хүчин чадалтай ундааны 1 шугам, цагт 500кг ногоо огцом гүн хөлдөөх 1 шугам тус тус ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь 2021 онд үйлдвэрийнхээ хүчин чадлын 60 орчим хувийг ашиглан ажилласан бөгөөд ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2022 оны 1-р улиралд дөнгөж хүчин чадлынхаа 20 хувийг ашигласан.

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүд нь ямар нэгэн химийн тогтворжуулагч бодис ашиглахгүйгээр дулааны аргаар боловсруулагддаг бөгөөд энэ нь 100-с доош 70-с дээш температурт бүтээгдэхүүнд орсон түүхий эдийн витаминлаг чанарыг алдуулахгүйгээр боловсруулж байгаагаараа бусад компаниас ялгаатай, хүнсний аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүн гэдгээрээ давуу талтай.







СЭХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03













2023.01.25 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-19
БҮРТГЭВ-63

Үнэт цаас гаргагч нь 1999 оноос өнөөг хүртэлх хугацаанд даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарт тэргүүлэгч байр сууриа хадгалан ажиллаж, зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдийн хэрэгцээг ханган ажиллаж байна. Бүтээгдэхүүний хувьд Та бидний хэрэглэж заншсан алаг салат, өргөст хэмх, артишок, жимсний компот, хөлдөөсөн ногоо, ногооны нухаш, хиймэ зөгийн балыг үйлдвэрлэн гаргадаг бөгөөд бүтээгдэхүүний төрлийг хүснэгтээр үзүүлбэл.

Хүснэгт-9

Бүтээгдэхүүний төрөл	Зураг	Нэр төрөл-63
САЛАТ		7 нэр төрлийн нийт 16 салат
ӨРГӨСТ ХЭМХ		3 нэр төрлийн нийт 20 өргөст хэмх
КОМПОТ		7 нэр төрлийн компот 1 интоорын компот импортоор
АРТИШОК ЭРҮҮЛ МЭНДИЙН УНДАА		4 төрлийн артишок
ЗӨГИЙН БАЛ		1 төрлийн 3 өөр савлагаатай зөгийн бал
ХӨЛДӨӨСӨН НОГОО		5 төрлийн хөлдөөсөн ногоо
ХӨЛДӨӨСӨН ЖИМС		2 төрлийн хөлдөөсөн жимс
НУХАШ		5 төрлийн Шимт нухаш

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ 5436117
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

2023 он 01 сар 25 өдөр БҮРТГЭВ №

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний нэр төрөл бүрийн орц, найрлагатай холбоотой мэдээллийг үзүүлбэл.

АЛАГ САЛАТ



Савлагаа: 550мл, 280мл

Бүх төрлийн хоолыг амтлах, хачир болгон хэрэглэхэд тохиромжтой, Монгол хүний хэрэглэж заншсан уламжлалт амт чанарыг агуулсан бөгөөд бага зэрэг исгэлэн амттай.

Орц: Лууван, амтат чинжүү, сонгино, өргөст хэмх, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, давс, ургамлын тос, цууны хүчил /E260/, перец

ӨЕГ САЛАТ



Савлагаа: 550мл, 280мл

Бүх төрлийн хоолыг амтлах, хачир болгон хэрэглэхэд тохиромжтой, будаа болон талх нь дээр тавьж идэхэд зориулагдсан. Олон төрлийн ногоонуудыг агуулсан амин дэмээр баялаг бүтээгдэхүүн юм.

Орц: Лууван, цэвэршүүлсэн ус, сонгино, амтат чинжүү, улаан лоолийн нухаш, өргөст хэмх, ургамлын тос, элсэн чихэр, давс, сармис

ӨЕГ САЛАТ /Халуун чинжүүтэй/

Савлагаа: 570мл, 280мл



Бүх төрлийн хоолыг амтлах, хачир болгон хэрэглэхэд тохиромжтой, Монгол хүний хэрэглэж заншсан уламжлалт амт чанарыг агуулсан бөгөөд бага зэрэг исгэлэн амттай.

Орц: Лууван, амтат чинжүү, сонгино, өргөст хэмх, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, давс, ургамлын тос, цууны хүчил /E260/, перец

БАЙЦААНЫ САЛАТ



Савлагаа: 550мл, 280мл

Зохицуулах үйлчилгээтэй бүх төрлийн хоолонд амт оруулах, хачир болгох мөн шууд дангаар нь идэхэд тохиромжтой олон төрлийн ногооны хольцтой жингээ барьж буй хэрэглэгчид болон бүх насныханд зориулсан бүтээгдэхүүн юм.

Орц: Байцаа, өргөст хэмх, амтат чинжүү, сонгино, лууван, сармис, цэвэршүүлсэн ус, ургамлын тос, элсэн чихэр, давс, лаврын навч, цууны хүчил E260, перец

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЗХ
2023 ОН САР
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ХҮРЭН МАНЖИНГИЙН САЛАТ



Савлагаа:

725мл 550мл 280мл

Хүрэн манжингийн салатыг дангаар нь болон хоолны шөлөнд амт оруулах, хоолны хачир болгон хэрэглэнэ. Зүрх судасны үйл ажиллагааг дэмжих үйлчилгээтэй зөөлөн амттай.

Орц: Хүрэн манжин, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, давс, сармис, лаврын навч, цууны хүчил Е-260

ЛЕЧО



Савлагаа:

550мл

Пицца болон хоолны шөлөнд амт оруулах, будаатай хольж идэхэд тохиромжтой, бага зэрэг хүчиллэг амтыг агуулдаг.

Орц: Амтат чинжүү, улаан лоолийн нухаш, цэвэршүүлсэн ус, сонгино, ургамлын тос, элсэн чихэр, давс, перец

ЛЕЧО /мөөгтэй/



Савлагаа:

550мл

Пицца болон хоолны шөлөнд амт оруулах, будаатай хольж идэхэд тохиромжтой, бага зэрэг хүчиллэг амттай.

Орц: Мөөг, улаан лоолийн нухаш, амтат чинжүү, цэвэршүүлсэн ус, сонгино, ургамлын тос, элсэн чихэр, давс, перец

ВИНЕГРЕТ



Савлагаа:

550мл

Төмс хүрэн манжингийн төгс хослол В, С амин дэмээр баялаг зүрх судасны үйл ажиллагаа дэмжих үйлчилгээтэй идэхэд өег жингээ барьж байгаа болон хүрэн манжинг дангаар нь идэж чаддаггүй хэрэглэгчдэд зориулсан.

Орц: Хүрэн манжин, цэвэршүүлсэн ус, төмс, сонгино, ургамлын тос, элсэн чихэр, давс, сармис, цууны хүчил Е-260

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВӨР ХХК

СЗХ
2023 -01- 25 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19

ГАЗАРШИМ ӨРГӨСТ ХЭМХ



Савлагаа:

3000мл 725мл

Монголын хөрсөнд тарьж ургуулсан өргөст хэмх, хүчиллэг амттай Монгол хүний хэрэглэж заншсан уламжлалт амт чанарыг агуулсан.

Орц: Монголд ургуулсан өргөст хэмх, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, давс, цууны хүчил /E260/, саримс, лаврын навч, гоньд, хар перец, шар будаа

ГАЗАРШИМ ШИНЭ МОНГОЛ ӨРГӨСТ ХЭМХ



Савлагаа:

1680мл 725мл

Чихэрлэг, өргөст хэмхний амтыг илүү тодотгож, үйлдвэрлэсэн.

Орц: Өргөст хэмх, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, давс, цууны хүчил /E260/, гоньд, хар перец, бусад амтлагчууд

ГАЗАРШИМ ОГУРЦЫ



Савлагаа:

3000мл 725мл

Энэтхэг сортын өргөст хэмхээр хийсэн чихэрлэг амттай, цууны хүчил бага агуулсан.

Орц: Энэтхэг сортын өргөст хэмх, элсэн чихэр, давс, цууны хүчил E260, гоньд, хар перец, шар будаа

ГАЗАРШИМ ШИНЭ МОНГОЛ ӨРГӨСТ ХЭМХ



Савлагаа:

1680мл 725мл

Чихэрлэг, саримсны амт илүү тодотгосон

Орц: Өргөст хэмх, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, давс, цууны хүчил /E260/, гоньд, хар перец, сармисны хандыг агуулсан.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 6436117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
9022080716 2577127 H20583

он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

АЛИМНЫ КОМПОТ



Савлагаа:

920мл

Идэхэд тааламжтай зөөлөн амттай, хальстай алимны компот

Орц: Алим, цэвэршүүлсэн ус, элсэн чихэр, нимбэгний хүчил E330

ХАР ЧАВГАНЫ КОМПОТ



Савлагаа:

920мл

Идэхэд тааламжтай исгэлэн амттай, дотроо ястай

Орц: Хар чавга, цэвэршүүлсэн ус, сахарыг ашиглаж, үйлдвэрлэдэг.

ҮХРИЙН НҮДНИЙ КОМПОТ



Савлагаа:

920мл

Исгэлэн жимс идэх дуртай хэрэглэгчдэд зориулсан, дотроо ясгүй бүх насныхан хэрэглэх боломжтой. Десерт болон бялууны чимэглэл болгон хэрэглэнэ.

Орц: Үхрийн нүд жимс, элсэн чихэр, цэвэршүүлсэн ус

АБРИКОСНЫ КОМПОТ



Савлагаа:

920мл

Исгэлэн жимс идэх дуртай хэрэглэгчдэд зориулсан, дотроо ясгүй бүх насныханд зориулагдсан.

Орц: Абрикос жимс , элсэн чихэр, цэвэршүүлсэн ус

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT CO.
УЛААНБААТАР ХОТ

ИНТООРЫН КОМПОТ



Савлагаа:

920мл

Идэхэд тааламжтай зөөлөн амттай, дотроо ястай

Орц: Интоор жимс, элсэн чихэр, цэвэршүүлсэн ус, нимбэгний хүчил E330

ОЛОН ЖИМСНИЙ КОМПОТ



Савлагаа:

920мл

5 төрлийн жимсээс бүрдсэн исгэлэн амттай десерт болон бялууны чимэглэл болгон хэрэглэнэ.

Орц: Бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, үхрийн нүд, интоор улаалзгана, элсэн чихэр, цэвэршүүлсэн ус

ТООРЫН КОМПОТ



Савлагаа:

920мл

Идэхэд тааламжтай зөөлөн амттай дотроо ясгүй бүх насныханд зориулагдсан

Орц: Тоор жимс, элсэн чихэр, цэвэршүүлсэн ус, нимбэгний хүчил E330

ИНТООРЫН КОМПОТ



Савлагаа:

920мл

Дотроо ясгүй интоорын компот Унгар улсад үйлдвэрлэгдсэн

Орц: Интоор жимс, элсэн чихэр, цэвэршүүлсэн ус, нимбэгний хүчил

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ГАЗАРШИМ ЗӨГИЙН БАЛ



Савлагаа:

Үйлдвэрийн аргаар боловсруулсан Нарийн боов, бариа засалд ихэвчлэн хэрэглэгддэг.

Орц: Элсэн чихэр, зөгийн балны амт, үнэр орлуулагч, карамел E-150d, цэвэршүүлсэн ус, нимбэгний хүчил E-330

ГАЗАРШИМ АРТИШОК



Савлагаа:

Эрүүл хүн өдөрт 50мл өтгөрүүлсэн хандыг 200 мл халуун болон хүйтэн усаар шингэрүүлж хэрэглэх зориулалттай.

Орц: Хэрэглэх заавар: Эрүүл хүн өдөрт 50мл өтгөрүүлсэн хандыг 200 мл халуун болон хүйтэн усаар шингэрүүлж хэрэглэх зориулалттай.

ГАЗАРШИМ АРТИШОК /Зөгийн балтай/



Савлагаа:

Артишок нь элэгний өвчин, цөс хөөх, өтгөн хаталт, судасны ханын хатуурал эсрэг, бөөрний үйл ажиллагааг сайжруулах, сахарын өвчин, мэдрэлийн эд эсийн үйл ажиллагааг дэмжих, үрэвслийн эсрэг, даралт бууруулах, гэдэс дүүрэх, дотор муухайрах мөн организмын витамин ба эрдэс бодисын тэнцвэржилтийг сайжруулж бүх төрлийн хордлогыг саармагжуулах зорилгоор хэрэглэдэг.

Орц: Цэвэршүүлсэн ус, артишокны ханд, нэрс жимсний ханд, зөгийн бал, гаа, бусад амтлагчууд

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ГАЗАРШИМ хөлдөөсөн ногоо

Ногоонд алгуулагдаж буй амин дэм, эрдэс бодисыг алдагдуулахгүйгээр хурдан хугацаанд гүн хөлдөөсөн. Хэрэглээг хялбарчилсан удаан хугацаанд хадгалж хэрэглэх нөхцлийг бүрдүүлсэн -18°C ба түүнээс сэрүүн хэмийн температурт хадгалах зориулалттай. Идэхэд тааламжтай зөөлөн амттай.



ГАЗАРШИМ хөлдөөсөн жимс



ГАЗАРШИМ ШИМТ НУХАШ

Өдөр тутамдаа хэрэглэж чаддаггүй нарийн ногооноос авах боломжтой амин дэмийг алдагдуулахгүйгээр нухшилж хэрэглэгчдийн гарт хүрсэн ногоо идэх дургүй хэрэглэгчид болон бага насны хүүхэд, өндөр настан идэхэд тохиромжтой мөн жингээ барьж буй хэрэглэгчдэд зориулан гаргасан бүтээгдэхүүн юм.



"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ХӨЛДӨЭР ХХК

СЭХ
2020 -01- 25 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХОРЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -01- 19
БҮРТГЭВ-03

1.5.3 Үнэт цаас гаргагчийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүслэн ажлууд



"Мод тарих" өдөрлөг

Үнэт цаас гаргагчаас 2019 онд 20 жилийнхээ ойгоор Баянзүрх ууланд дуслын усалгаатай 30 мод тарьсан бөгөөд 2019 оноос хойш мод тарих өдрийг уламжлал болгон үргэлжлүүлж жил бүр 30-50 модыг Улаанбаатар хотын Баянзүрх ууланд суулгаж, өмнөх жилийнхээ тарисан модыг эргэж, усалж арчилдаг уламжлалтай.



"Шилээ дахин амьдруулья" аян

Тус компаниас эргэлтийн шил цуглуулж, угааж цэвэрлэдэг байгууллагатай хамтран ажиллаж эргэлтийн шилийг тодорхой хэмжээгээр авч үйлдвэрлэлд хэрэглэдэг. Энэ нь нийт үйлдвэрлэлд ашиглаж байгаа шилний 5 орчим хувийг эзэлдэг бөгөөд 2021-2022 онд байгальд ээлтэй зохистой хэрэглээг түгээх зорилгоор шилээ дахин амьдруулж, хог хаягдлыг багасгах санаачлага гарган "Шилээ дахин амьдруулья" аяныг өрнүүлж хэрэглэсэн бүтээгдэхүүний шилийг буцаан худалдан авч эхэлсэн. Энэхүү аяны хүрээнд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран шил цуглуулснаар үйлдвэрлэлд ашиглах эргэлтийн шилний тоо 8-10% болж өссөн. Мөн өөрийн нэрийн барааны дэлгүүрүүдээр хэрэглэсэн бүтээгдэхүүний шилийг тогтмол худалдан авч байна. Хэрэглэсэн бүтээгдэхүүний шилийг дахин ашигласнаар хог хаягдал багасаж байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, ажлын байр нэмэгдэх, иргэд байгууллага орлоготой болох, гадагшаа урсах валютын ургсгалыг бууруулах зэрэг олон эерэг үр дүн гарах болно.



Өргөст хэмх эрт тарьж, эрт хурааж эхлэх төсөл

Төслийн зорилго: Даршилсан өргөст хэмхийн гол түүхий эд болох өргөст хэмхийн хураах хугацааг 15-30 хоногоор уртасгаснаар нэгж талбайгаас хураах ургацыг 2 дахин хүртэл нэмэгдүүлснээр, ногоочдын орлогыг өсгөх, үйлдвэрийн ачааллыг тохируулах зорилготой. 2021 оноос эхлэн манай компани 20 тариаланчдыг сонгон төсөлд хамтран ажиллах санал тавин гэрээ байгуулан ажиллаж байна. 2021 онд 87 сая ₮, 2022 онд 60 гаруй сая ₮ зарцуулаад байна. Туршилтын тариалалтын хэлбэр: Хүлэмжинд үрслүүлэн ил талбайд шилжүүлэн тарих, Хучлага /плёнк/-нд дуслын системээр тарих, Туннел үүсгэн тарих / Монгол улсын хэмжээнд консервлосон өргөст хэмхийн зах зээлийн 82%-ийг импортоор хангаж байгаа бөгөөд үнэт цаас гаргагчийн зүгээс уг төслийг амжилттай хэрэгжүүлснээр дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг нэмэх боломжтой гэж үзэж байна.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5496117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЭХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсээс санаачлан ажилд хамтран оролцож дүүргийн 10, 22 дугаар хороонд үнс, нурам, ил задгай асгаснаас үүдэлтэй гал түймрийн шалтгаан нөхцөлийг бууруулах зорилгоор битүүмжлэл сайтай, тагтай, төмөр торх өгч хамтран ажиллав. Мөн харилцагч, оюутнууд, сургуулийн сурагчдад үйлдвэрийн үйл ажиллагааг тогтмол танилцуулж ирсэн.













СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.6 Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт

1.6.1. Үнэт цаас гаргагчийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бүтэц, зохион байгуулалтын хувьд 6 нэгж, албатайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг дараах схемээр үзүүлбэл.

Схем 3



Үйлдвэрлэлийн албаны үндсэн чиг үүрэг

Тус алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Схем 4

- Үйлдвэрлэл төлөвлөх, зохион байгуулах;
- Үйлдвэрлэлийн үйл явцыг тасралтгүй явуулахад шаардагдах түүхий эд материалын нөөц бүрдүүлэх;
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэх явцад технологийн горим, заавар мөрдүүлэх;
- Ажиллах хүчний асуудал ээлжийн хуваарь зохион байгуулах, хуваарилалт, дамжлага дундын хяналтыг сайн тавьж амт чанар сайтай чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа өгөх, түүнийг чанд мөрдүүлэх;
- Компанийн үндсэн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн төлөвлөгөө нормыг биелүүлэх.

СЭХ
2023 01 25
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Захиргаа, хүний нөөцийн албаны үндсэн чиг үүрэг

Захиргааны чиглэлд

- Удирдлагын багийг мэдээллээр хангах, шийдвэрийг баталгаажуулах
- Компанийн албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагааг хариуцах
- Компанийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах
- Ажилтнуудад хоол, унаа, угаалгын үйлчилгээ үзүүлэх, -компанийн байр, ажилчдын аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх, оффисын цэвэрлэгээ, үйлчилгээ, гадна талбайн тохижилт үйлчилгээг хариуцах чиглэлээр ажилладаг

Хүний нөөцийн чиглэлд

- Албадыг үндсэн болон нэмэлт ажиллах хүчээр хангаж, ажилтан бүрдүүлэх, сонгон шалгаруулах
- Ажилчдын нийгмийн халамж, шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах
- Ажилтны сургалт хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ, ур чадварын үнэлгээ, карьер хөгжлийн асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх
- Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангуулах ажлыг хариуцдаг.

Дотоод сүлжээний чиглэлд

- Компанийн аюулгүй байдал, камержуулалт
- Нийт ажилтнуудад программ хангамж, техник хангамжийн үйлчилгээ үзүүлэх
- Түүхий эдийн татан авалт, гаалийн бүрдүүлэлт хариуцаж ажилладаг

Инженер техникийн албаны үндсэн чиг үүрэг

- Тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай шинэ техник, технологи нэвтрүүлэх;
- Тоног төхөөрөмжийн төлөв байдлыг үнэлэх, эдэлгээ чанарыг тооцоолох, шаардлагыг хангах;
- Засвар механикийн ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,LTD
УЛААНБААТАР ХОТ 6405117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ УЙЛДВЭР ХХК

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Маркетинг, борлуулалтын албаны үндсэн чиг үүрэг

- Компанийн маркетингийн бодлого, хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлд хяналт тавих;
- Маркетинг, идэвхжүүлэлттэй холбоотой судалгаа, шинжилгээний ажлыг төлөвлөлтийн дагуу тогтмол гүйцэтгэх, судалгааны харьцуулалт, үр дүнд үндэслэн цаашид баримтлах бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийг хийж, хэрэгжүүлэх;
- Маркетинг, борлуулалтын орлого, зардлыг төлөвлөх, үр ашгийг тооцох, тайлагнах;
- Борлуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих.

Санхүү бүртгэлийн албаны үндсэн чиг үүрэг

- Компанийн НББ -ийн бодлого, санхүүгийн заавар, журмуудын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- Компанийн санхүүгийн тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргах, санхүүгийн тайлан балансыг нэгтгэх, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, тооцооны нягтлан бодогч нарын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллах;
- Татвар, гааль, НД-ын газрууд, Бэлтгэн нийлүүлэгчид, Харилцагчтай цаг тухайд нь төлбөр тооцоо хийх.
- Албан тушаалтай холбоотой бусад ажил үүргийг гүйцэтгэх

ХАБУТ-н хүрээнд

- Ажил үйлчилгээ нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгааг хариуцна
- Хэлтсийн чанарын бодлогыг тодорхойлно
- ЧУТ-нд шаардагдах нөөцөөр хангах
- Хэлтсийн хуулиар хүлээсэн үүргийг хангуулан биелүүлэхийг хариуцна
- Чанарын менежментийн тогтолцоог бусад байгууллагад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж санаачилгатай ажиллах
- Чанарын асуудлаар гадаад орчноос мэдээлэл авч нийт ажиллагсдын чанарын талаарх мэдлэг дээшлүүлэх

ХАБУТ-н хүрээнд

- "Газар шим үйлдвэр" ХХК-д Чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO22000-2018 хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, цаашид сайжруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлох, тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- Жимс жимсгэнэ, хүнсний ногооны нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагааны бүх шатанд хяналт тавьж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдлыг цаг тухайд нь илрүүлэн арилгах зорилго бүхий байгууллагын дотоод хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, зохион байгуулах, удирдан чиглүүлэх, тасралтгүй сайжруулах;
- Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтныг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг МУ-ын ХАБЭА-н тухай хуулийн хүрээнд удирдан зохион байгуулах;
- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хаягдлыг хадгалах, зайлуулах, орчны бохирдлыг багасгах, гал түймэр гарах эрсдэлийг бууруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах компанийн бодлого зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг удирдлагаар хангах, хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг тус тус гүйцэтгэдэг.

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.6.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал

Монгол Улсын Компанийн тухай хууль, хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн тогтоолоор баталсан компанийн дүрмээр компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байхаар зааж, хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байхаар заажээ. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр зарлан хуралдуулахаар заасан.

2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр хувьцаа эзэмшигч Ц.Төгсөө холбогдох хууль тогтоомжид заасан эрхийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, үнэт цаас нэмж гаргах, компанийн хэлбэр өөрчлөх асуудлыг хэлэлцүүлэхээр санал гаргаж, хуралдуулсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дээрх асуудлыг дэмжиж шийдвэрлэсэн.

- Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлаар компанийн нэр хүндийг өсгөж байр сууриа улам бэхжүүлэх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх замаар компанийн дараагийн шатанд гаргах "ГБТ Трейдинг" ХХК-ийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчлөх байгуулах, шийдвэр гаргасантай холбоотой арилжаа эрхлэх, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу мэдэгдэж зөвшөөрөл авах болон хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг авахын тулд андеррайтер, үнэлгээ, хуулийн мэргэжлийн байгууллагуудыг сонгох, хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.
- Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит бус хурлын 01, 02 дугаар тогтоолоор тус тус хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, мөн өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 3 дугаар тогтоолоор компанийн оноосон нэр болох "ГБТ трейдинг" ХХК гэсэн нэрийг олон нийтэд танигдсан "Газар шим үйлдвэр" ХХК болгон өөрчилсөн.
- Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн ээлжит бус хурлын 5 дугаар тогтоолоор "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нэг бүр нь 550 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 200,000 ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 5,000 хуваж, нэг бүр нь 0.11 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 1,000,000,000 ширхэг энгийн хувьцаа болгон хуваж, компанийн дүрэмд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, компанийн дүрмийн 6 дугаар зүйлд заасан дараах эрхийг эдлэхээр заажээ.

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- Давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг хуваалцахаас олсон орлогоос хувь хүртэх;
- Дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн эзэлжид худалдан авах;
- Хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг энэ зүйлд заасан бусад журмын дагуу тэргүүн эзэлжид худалдан авах;
- Хувьцаа эзэмшигч хуралдаа цахим хэлбэрээр оролцож, санал өгөх;
- Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эрхийг эдэлнэ.

СЭХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.6.3 Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан

Компанийн тухай хууль, үнэт цаас гаргагчийн дүрэмд компанийн гүйцэтгэх удирдлага нь гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаар заасан. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзэхэд 2007 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн бүртгэлээр компанийн гүйцэтгэх захирлаар Ц.Ганбатыг томилж бүртгэжээ.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал, түүний багаас ажилтнуудынхаа ур чадварт суурилан хамтаараа хөгжих, ажилтан бүрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, бодитоор шагнаж урамшуулах, эрүүл аюулгүй таатай орчинд ажиллах боломжийг олгож нээлттэй бодлого баримтлан ажиллаж, ажилтан сонгон шалгаруулахдаа ямагт шинийг эрэлхийлэгч, багаар ажиллах чадвартай, байгууллагын соёлд дасан зохицох чадварыг бэхжүүлэхэд хүний нөөцийн бодлого чиглэгддэг.

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцохоор заасан. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг хүснэгтээр үзүүлбэл:



Ц.ГАНБАТ
Ерөнхий захирал

Цээпэл овогтой Ганбат нь 1982 онд Увс аймгийн Улаангом сумын 1-р ерөнхий боловсролын сургуульд суралцан төгссөн. 1984-1988 онд ХБНГУ-н Берлин хотод Эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн байна. Мөн 2005 онд Монгол Япон төвөөс зохион байгуулсан "Жижиг дунд үйлдвэрийн газрын менежмент, үнэлгээ" сэдэвт бизнесийн практик сургалт, 2005 онд Япон улсад JICA-ийн "Япон маягийн менежменетын сургалтад , 2007 онд Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Бизнес төлөвлөгөө боловсруулах" сэдэвт бизнесийн практик сургалтад, "Мэргэн Түшээ" сургалтын төвөөс зохион байгуулсан Төрийн албанд мэргэших 14 хоногийн сургалтуудад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Ц.Ганбат нь 1992-1995 оны хооронд АЗ ББХК-ийн захирал, 1995-1996 онд НИК ХК-ийн зах зээлийн борлуулалтын газрын дарга, 1996-2000 оны хооронд Глобал Инвест ХХК-ийн дэд захирлаар тус тус ажиллаж байсан бөгөөд Компанийг 1999 онд үүсгэн байгуулсан хугацаанаас хойш одоог хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Ц.ТӨГСӨӨ
Үйлдвэр хариуцсан захирал

Цээпэл овогтой Төгсөө нь 1988 онд Увс Улаангомын 10 жилийн 2-р дунд сургуулийг, 1989-1992 онд Украйны Донецк хотын "Худалдааны дээд сургуулийг хүнсний бараа судлал мэргэжлээр, 1992-1996 онд Казакстаны Алма-Ата хотын "Удирдлагын академи"-д шилжин суралцаж эдийн засагч, бараа судлалын мэргэжлээр төгссөн.

1999 оноос Газар шим үйлдвэр ХХК-д Технологич, Ерөнхий технологич, Үйлдвэр эрхэлсэн захирлаар ажиллаж байна.

2008 оноос "Артишок Монголд" төслийн ерөнхий зохицуулагчаар ажиллаж, Экологи хөгжил ТББ, ХААИС-ийн сургалт үйлдвэрлэлийн нарт төв, Монос АУДэС, ШУТИС-ийн докторууд, Клиникийн 3-р эмнэлгийн дотоод шүүрлийн тасаг зэрэг байгууллагуудтай хамтран Монголд нутагшуулсан артишокоор ШУ-ыг үйлдвэрлэлтэй холбосон туршилт, судалгаа, бүтээгдхүүн хөгжүүлэлтийг хийж 2010 онд Артишок эрүүл мэндийн зохицуулах үйлчилгээтэй үндаг зохион бүтээж, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. 2017 оноос Ургамлын гаралтай хүнсний стандартчиллын дэд хорооны гишүүнээр 2019 оноос Монголын Хүнсчдийн Холбоо-ны Удирдах зөвлөлд Жимс ногоо боловсруулагчид болон бусад салбар зөвлөлийн даргаар ажиллаж байгаа.

ӨН САР ӨДӨР БҮРТГЭВ № 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03



З.БАЙГАЛМАА
Захиргаа, удирдлага хариуцсан захирал

Занашир овогтой Байгалмаа нь 1982 онд Увс аймгийн Улаангом сумын 1-р ерөнхий боловсролын сургуульд суралцан төгссөн. 1982-1992 онд Эрхүү хотын Политехникийн их сургуулийг инженер, геологич мэргэжлээр бакалавр, магистр зэрэг, Улаанбаатар хотын Отгонтэнгэр их сургуулийг 1996-1999 оны хооронд эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэг тус тус эзэмшжээ. Мөн

- 2013 онд МҮХАҮТанхим БНСУ-ын Хандонг Олон Улсын хууль зүйн сургуулийн хамтарсан "Оюун өмчийн арбитр" семинар
- 2014 онд МУ-ын ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын харъяа Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтэд "Байгууллагын мэдээлэл солилцооны арга технологи" сургалт
- 2014 онд МУ-ын ЗГ-ын хэрэг эрхлэх газрын харъяа Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтэд "Төрийн байгууллагын бүтээмжийн удирдлага" сургалт
- 2016 онд Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Ялон маягийн менежмент" сэдэвт суурь мэдлэгийн сургалт
- 2016 онд ХХААХҮЯамны "Оролцооны баталгаажуулалтын сургалт"
- 2022 онд Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Жижиг дунд аж ахуй нэгжийн менежментийг сайжруулах бизнесийн үндсэн сургалт" сэдэвт удирдлагын менежментийн сургалт

З.Байгалмаа нь 1988-1992 оны хооронд Эрэл геофизикийн цогцолбор экспедиз-д геологийн инженер, 1992-1999 оны хооронд Патентын газарт Шинжээч, 1999-2008 оны хооронд Газар шим үйлдвэр ХХК-д Хөрөнгө оруулалтын менежер, 2009-2015 оны хооронд Оюуны өмчийн газарт Улсын хяналтын байцаагч, 2016 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Захиргаа удирдлага хариуцсан захирлаар ажиллаж байна.



Д.СЭРГЭЛЭН
Маркетинг, борлуулалт хариуцсан захирал

Дүгэржав овогтой Сэргэлэн нь 1978-1988 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1989-1995 онд Казахстан улсын Алма-Ата хотын АЗВИ-д, 2012-2014 онд Улаанбаатар хотын Удирдлагын Академид Бизнесийн удирдлага мэргэжлээр бакалавр, тус сургуульд 2015-2016 онд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистрын зэрэг эзэмшсэн байна.

Д.Сэргэлэн нь 2017 онд Аюулгүй байдал нэн тэргүүн ТББ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдан 17-12 дугаар сертификат

2018 онд Анрэйд ХХК-с зохион байгуулсан Сошил медиа, маркетинг, брендингийн сургалтад хамрагдан сертификат

2018 онд Би Зи Пи ХХК-ийн Сошил медиа маркетинг бизнест үр дүнтэй ашиглах нь сэдэвт сургалтуудад хамрагдан батламж тус тус авсан байна.

2000-2011 онд Газар шим үйлдвэр ХХК-д Борлуулалтын менежер, 2011-2020 онд Маркетинг борлуулалтын албаны дарга, 2020 оноос одоог хүртэл Маркетинг борлуулалт хариуцсан захирлын албан тушаалд ажиллаж байна.

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03



Ч.ОЮУНБИЛЭГ
Чанар, эрүүл ахуй, хяналтын албаны дарга

Чүлтэм овогтой Оюунбилэг нь 1973-1983 онд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 10 жилийн 1 дүгээр дунд сургуульд суралцан бүрэн дунд боловсрол эзэмшин 1983-1984 онд Улаанбаатар хотын Хүнсний үйлдвэрийн ТМС-д Тоног төхөөрөмжийн засварчин мэргэжил, 1988-1996 онд Москва хотын Биотехнологийн академид Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн механик инженер мэргэжлээр магистр зэрэг эзэмшсэн байна. ХАБЭА-н мэргэшсэн инженер, Олон улсын Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 стандартын аудитор, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага MNS ISO 22000:2019 стандартын дотоод аудитор. 1984-1987 он Архи пиво ундааны үйлдвэрт тоног төхөөрөмжийн засварчин, 1996-2012 онд "НОББА" ХХК-ийн захирал, 2012-2018 онд "Зун Шин" Барилга угсралтын компанид ХАБЭА-н албаны дарга, 2018 оноос одоог хүртэл "Газар шим үйлдвэр" ХХК-д Чанарын хяналтын албаны даргаар ажиллаж байна.



Д.ЖАРГАЛ
Үйлдвэрийн орлогч дарга

Дорждагва овогтой Жаргал нь 1982-1990 онд Өвөрхангай аймгийн Бүрд сумын ерөнхий боловсролын сургуульд суралцан бүрэн дунд боловсрол, 1990-1993 онд Сэлэнгэ аймгийн Хөдөө Аж Ахуйн Техникумд Мал зүйч мэргэжлээр, 1996-2000 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Түүхий эд судлаач, бүтээгдэхүүний технологич мэргэжлээр бакалаврын зэрэг тус тус эзэмшсэн байна.

1993-2001 оны хооронд Зоонез өвчин судлалын төвд Лаборант, технологич, 2001-2006 онд Монхангай группт Худалдагч, менежер, дэлгүүрийн дарга, 2006-2011 онд БатСарай ХХК-д Дэлгүүрийн зохион байгуулагч, нарийн бичиг, 2011 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Үйлдвэр эрхэлсэн орлогч даргаар ажиллаж байна.



Л.БҮРЭНЧИМЭГ
Ерөнхий нягтлан бодогч

Лхагвасүрэн овогтой Бүрэнчимэг нь 1981 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Монгол улсын Завхан аймгийн Цагаанчулуут суманд төрж, Завхан аймгийн Улиастай сумын ЭОН 1-р арван жилийг 1998 онд төгссөн. Улмаар 2002 онд Улаанбаатар хот ХААИС-н ЭЗБСургуулийг нягтлан бодогч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн. 2004-2014 он хүртэл Завхан аймгийн Цагаанчулуут суманд Төсөвт байгууллагууд хариуцсан нягтлан бодогчоор ажиллаж байгаад 2015-2018 онд Санхүүгийн албаны дарга буюу Ерөнхий нягтлан бодогчоор дэвшин ажилласан. 2018 оноос Улаанбаатар хотод шилжин суурших "Алтанжолоо трейд" ХХК-д зардлын нягтлан бодогчоор ажиллаж байсан. 2020 оны 9 дүгээр сараас "Газар шим үйлдвэр" ХХК-д цалингийн нягтлан бодогч, ахлах нягтлан бодогчоор ажиллаж байгаад 2022 оны 10 дугаар сараас Ерөнхий нягтлан бодогчоор томилогдон ажиллаж байна.



М.НЯМСАНЖ
Ерөнхий инженер

Мөнхнасан овогтой Нямсанж нь 1991-2001 онд Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуульд суралцан бүрэн дунд боловсрол эзэмшин 2003-2007 онд Дархан хотын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Цахилгааны инженер мэргэжил эзэмшсэн.

М.Нямсанж нь 2020 онд Жи То Жи сургалтын Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо – Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавих шаардлага ISO 22000:2018 (MNS ISO 22000:2019) стандартын дотоод аудитын (Модуль-3) сургалтад хамрагдан ISO22000/M3/2020/005 дугаар гэрчилгээ, 2014 онд АНУ дахь Өу Эс Эч Академийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний багц сургалтад амжилттай хамрагдсан.

СЭХ
ГАЗАРШИМ Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.7 Үнэт цаас гаргагчийн хийсэн гэрээ, хэлцлийн мэдээлэл

Их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл: Үнэт цаас гаргагч нь сүүлийн гурван жилийн санхүүгийн тайлангийн балансын активын нийт дүнгийн 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

Хүснэгт-10

№	Хугацаа	Балансын нийт актив (төгрөгөөр)	Балансын активын 25% (төгрөгөөр)
1.	2019 оны хагас жил	18,918,812,500	4,729,703,125
2.	2019 оны жилийн эцэс	20,338,253,100	5,084,563,275
3.	2020 оны хагас жил	22,736,771,600	5,684,192,900
4.	2020 оны жилийн эцэс	22,645,275,407	5,661,318,851
5.	2021 оны хагас жил	26,800,145,900	6,700,036,475
6.	2021 оны жилийн эцэс	27,203,338,856	6,800,834,714
7.	2022 оны хагас жил	29,511,019,277	7,377,754,819

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд бусадтай байгуулсан гэрээ, хэлцлүүдийн үнийн дүнг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тодорхойлсны дагуу хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нөхөрлөлийн зүгээс нягтлан үзэхэд хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувьтай харьцуулж үзэхэд их хэмжээний хэлцэл хийгдээгүй байгаа талаар дүгнэсэн.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд зааснаар "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогддог.

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч эсхүл зуучлагчаар оролцож байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа;

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-т сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргахаар заасан байна. Үнэт цаас гаргагчийн үнэт цаас гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн нөхөрлөлийн холбогдох бичиг баримт, гэрээг нягтлан үзэхэд сүүлийн гурван жилийн хугацаанд дараах сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулагдсан байна.

СЭХ
ЬҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭСЭН-03

Хүснэгт-11

№	Гэрээний талууд	Гэрээний хугацаа, гэрээний нэр	Хоорондоо ямар хамааралтай талаар \зэрэгцээ, охин\	Уг гэрээ хэлцлийг баталсан Хувьцаа эзэмшигчийн шийдвэр
1	"Эйч Эс Зэт" ХХК	"Эйч Эс Зэт" ХХК нь өөрийн эзэмшдэг Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороонд байрлах 11773 м2 газрын газар эзэмших эрхийг Компанид шилжүүлэх, Компани нь тохирсон төлбөрийг гэрээний төлбөрт төлөхөөр тохирч 2021.10.15-ны өдөр гэрээ байгуулсан.	"Эйч Эс Зэт" ХХК нь Компанийн хувьцаа эзэмшигч Ц.Төгсөөгийн 100 хувийн эзэмшлийн компани юм.	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №02 шийдвэр.
2	Ц.Төгсөө	Лицензийн гэрээ "Артишок (Cynara scolymus) агуулсан эрүүл мэндийн ундаа, түүнийг бэлтгэх арга" патентыг Компанид ашиглуулах тухай	Компанийн 13%-ийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №01 шийдвэр.
3	З.Байгалмаа	Барааны тэмдэг эзэмших эрх шилжүүлэх гэрээ "40-0003579 улсын бүртгэлийн дугаар бүхий "ГАЗАР ШИМ" барааны тэмдгийн эзэмших эрхийг Компанид шилжүүлэх"	Компанийн 11%-ийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №04 шийдвэр.

Монгол Улсын иргэн Ц.Төгсөө нь Компанийн нийт хувьцааны 13 хувийг эзэмшигч бөгөөд Компанийн Үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, Иргэн З.Байгалмаа нь Компанийн нийт хувьцааны 11 хувийг эзэмшигч Захиргаа удирдлага хариуцсан захирал тул Компанийн Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.12-т зааснаар Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдох юм.

Харин Компанийн эрх бүхий албан тушаалтны хувьцааг нь 100 хувь эзэмшдэг компани болох "Эйч Эс Зэт" ХХК нь дээрх Гэрээний нөгөө тал болон оролцсон нь Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1-д заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдоно гэж дүгнэсэн.

"Эйч Эс Зэт" ХХК-тай газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ, "Артишок (Cynara scolymus) агуулсан эрүүл мэндийн ундаа, түүнийг бэлтгэх арга" патентыг Компанид ашиглуулах тухай Лицензийн гэрээ, "40-0003579 улсын бүртгэлийн дугаар бүхий "ГАЗАР ШИМ" барааны тэмдгийн эзэмших эрхийг Компанид шилжүүлэх" тухай Барааны тэмдэг эзэмших эрх шилжүүлэх гэрээ байгуулах зөвшөөрлийг Компанийн нийт хувьцааны 15 хувийн хувьцааг эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-г төлөөлж Штэффэн Мэлцэрийн зүгээс 2022 оны 8-р сарын 15-ны өдөр шийдвэр гаргах замаар олгосон. Компанийн бусад хувьцаа эзэмшигчид болох Ц.Ганбат болон З.Байгалмаа нар нь хувьцаа эзэмшигч Ц.Төгсөөтэй ах дүү, бэр эгчийн харилцаатай тул 2022 оны 8-р сарын 15-ны өдөр гаргасан шийдвэрийг түүнтэй сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигч Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-г төлөөлж Штэффэн Мэлцэрийн зүгээс гаргасан нь хуульд нийцсэн байна.

СЭХ
2023 -01- 20
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 41

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ 03

2022 оны 8-р сарын 15-ны өдөр гаргасан шийдвэрт *"Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээг Компанитай байгуулах хүсэлтэй байгааг хэлцэл хийхээс өмнө тус хэлцэлд Сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигч надад утсаар мэдэгдсэн..."* гэж дурдсан байгаа нь Иргэний хуулийн 50 дугаар 50.1-д *"Хэлцэл хүчин төгөлдөр байх зайлшгүй нөхцөл болсон зөвшөөрөл олгох эрх, үүрэг бүхий гуравдагч этгээд уг зөвшөөрлийг олгосон буюу олгохоос татгалзсан тухайгаа хэлцлийн талуудад нэгэн адил мэдээлнэ.", мөн хуулийн 50.2-т "Зөвшөөрлийг тухайн хэлцэлд баримтлах хэлбэрээр хийхийг шаардахгүй." гэж тус тус заасантай нийцэж байна гэж үзэж байна.* Тиймээс утсаар өгсөн зөвшөөрлөө хожим нь баталгаажуулан 2022 оны 8-р сарын 15-ны өдөр *"Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай"* шийдвэр гаргасан нь хуульд харшлаагүй гэж үзэж байна.

Үнэт цаас гаргагчийн Компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн Их хэмжээний хэлцэл хийгдээгүй бол Сонирхлын зөрчилтэй хэлцэл нь Компанийн тухай хуулийн хүрээнд хийгдсэн байна.

1.8 Үнэт цаас гаргагчийн өмнөх 3 жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд болон аудитын дүгнэлтийн мэдээлэл

1.8.1 Үнэт цаас гаргагчийн 3 жилийн тайланд хийгдсэн аудитын компаниудын дүгнэлт

Үнэт цаас гаргагчийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Сүлд-Аудит" ХХК аудитын дүгнэлт гаргаж дараах байдлаар дүгнэлт өгсөн байна.

- Хараат бус аудиторын тайланд "Газар шим үйлдвэр" ХХК нь 2019 оны 12 дугаар сарын 31 – өдрийн байдлаар санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийсэн талаар дурдаж.
- Аудиторын дүгнэлтээр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын, тайлан жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн.

Үнэт цаас гаргагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Сүлд-Аудит" ХХК аудитын дүгнэлт гаргаж 3 зөвлөмжийг үнэт цаас гаргагчид өгч, дүгнэлтийг хамтран хэрэгжүүлж ажилласан.

- **Өгсөн зөвлөмж-1:** Цаашид байгууллагын нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох үүднээс мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2–т зааснаар "...Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм журам, зааварт нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана..." гэсэн үүргийг аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад хариуцуулсан билээ. Иймд байгууллага нь өөрийн салбарын онцлогийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын болон Монгол улсын нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж байгаа санхүү, Нягтлан бодох бүртгэлтэй холбогдолтой хууль, дүрэм журамд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогоо шинээр боловсруулан, мөрдөн ажиллах нь зүйтэй.
- **Зөвлөмж-2:** Тайлант хугацаа бүрийн эцэст тооцоо нийлж үлдэгдлийг бүрэн гүйцэт баталгаажуулж байх. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5–д заасан "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5406117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
9122080716 2577127 НД0593

СЗХ 2023 -01- 29 БҮРТГЭВ № 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19

- **Зөвлөмж-3:** НББ– ын тухай хуулийн 20– р зүйлийн Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүргийн 20.2.6– д заасан "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтын дагуу байгууллагын эд хөрөнгө болон, төлбөрийн тооцооны тооллогыг жилд 2–оос доошгүй удаа, мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж хэвших. Цаашид үндсэн хөрөнгийн тооллогыг жилд нэг удаа, хангамж, бараа материал, түүхий эд материалын тооллогыг жилд 2-оос доошгүй удаа, мөнгөн хөрөнгийн тооллогыг сар бүр хийж хэвших.

Үнэт цаас гаргагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК аудитын дүгнэлт гаргаж дараах байдлаар дүгнэлт өгсөн байна.

- Хараат бус Аудиторын тайлан дүгнэлт: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31 – ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон тайлангийн тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ. Дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Газар шим үйлдвэр" ХХК – ийн 2021 оны 12 дугаар сарын 31 – ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын (СТОУС), Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу материаллаг алдаа, зөрчилгүй үнэн зөв толилуулсан талаар дүгнэсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаас гаргагч нь үнэт цаас танилцуулгыг боловсруулахдаа сүүлийн 6 сарын доторх хугацааны аудитын компаниар баталгаажуулсан санхүүгийн тайлан гаргаж, аудитын үйлчилгээ үзүүлэгч компаниас тодорхойлох захидлыг ирүүлэхээр заасан. Дээрх зохицуулалтын хүрээнд үнэт цаас гаргагч нь "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК-тай аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулж, үнэт цаас гаргагчийн тайланд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон аудит хийсэн.

Аудитын дүгнэлтээр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийхэд санхүүгийн тайлангууд нь тасалбар болгосон өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлэгдсэн талаар дүгнэсэн.

1.8.1 Үнэт цаас гаргагчийн 3 жилийн тайланд хийгдсэн аудитын компаниудын дүгнэлт

Үнэт цаас гаргагчийн дээр дурдсан аудитлагдсан баланс, орлого, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг 2020-2022 оны хоорондох 3 жилийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

"НОБЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT Co.,Ltd УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЗХ
2023 -01- 25
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Санхүүгийн байдлын тайлан

2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрөөр тасалбар болгосон тайлант жил

Хүснэгт-12

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2020.12.31	2021.12.31	2022.06.30
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2	2,646,355,000	2,390,592,895	1,506,968,691
Дансны авлага	3	2,244,050,936	2,935,328,537	3,776,051,558
Татвар, НДШийн авлага	4	29,107,279	120,912,689	115,376,036
Бусад авлага	5	3,825,144,236	5,923,245,157	3,595,173,047
Бараа материал	6	4,520,500,148	5,432,423,326	9,281,750,771
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	7	1,949,090,537	2,728,717,470	3,626,140,903
Эргэлтийн хөрөнгийн дүн		15,214,248,137	19,531,220,073	21,901,461,007
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэнхөрөнгө	8	7,403,888,575	7,660,714,445	7,601,882,044
Биет бус хөрөнгө	9	27,138,695	11,404,338	7,676,225
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		7,431,027,270	7,672,118,783	7,609,558,270
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		22,645,275,407	27,203,338,856	29,511,019,277
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	10	342,372,899	287,019,436	627,891,853
Цалингийн өглөг	11	173,543,078	65,398,229	205,866,672
Татвар хураамжийн өр төлбөр	12	115,708,982	792,854,582	441,295,135
НДШ-ийн өр төлбөр	13	-	-	2,946,671
Богино хугацаат зээл	14	-	-	1,977,488,000
Бусад богино хугацаат өр төлбөр	15	24,069,160	1,050,000,000	140,000,000
Богино хугацаат өр төлбөрийн дүн		655,694,118	2,195,272,247	3,395,488,331
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	16	4,063,333,333	3,428,267,333	2,551,768,209
Хойшлогдсон татварын өр	19	-	1,465,649	5,118,502
Урт хугацаат өр төлбөрийн дүн		4,063,333,333	3,429,732,983	2,556,886,711
ӨРТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		4,719,027,452	5,625,005,230	5,952,375,042
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч: - Төрийн		-	-	-
- Хувийн	20	110,000,000	110,000,000	110,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	21	380,000,000	380,000,000	380,000,000
Хуримтлагдсан ашиг	22	17,436,247,956	21,088,333,627	23,068,644,234
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		17,926,247,956	21,578,333,627	23,558,644,234
ӨРТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		22,645,275,407	27,203,338,856	29,511,019,276

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ 5408117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
9420080716 2577127 НД0983

СЗХ
2023 оны 01 сарын 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

1.8.2 Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагчийн дээр дурдсан аудитлагдсан баланс, орлого, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг 2019-2022 оны хоорондох 3 жилийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт-13

ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 01/01-06/30	2021 оны 07/01-12/31	2022 оны 01/01-06/30
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Тайлант хугацааны ашиг (алдагдал)	3,190,979,190.03	2,466,136,249.91	1,980,310,608.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	290,918,229.10	469,704,515.87	387,456,856.48
Валютын ханшийн бодит бус цэвэр гарз/(олз)	(4,777,837.95)	(6,672,546.12)	(37,566,972.14)
Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз (олз)	0.00	6,294,923.97	7,145,875.00
Бусад мөнгөн бус орлого	(41,877,423.36)	(319,340,514.63)	(32,867,650.00)
Авлагын өсөлт, бууралт	(2,036,419,069.14)	(844,764,861.34)	1,492,885,741.00
Урьдчилж төлсөн зардал/тооцооны өсөлт, бууралт	(562,327,451.82)	(217,299,481.03)	(897,423,433.00)
Төлсөн хүүгийн төлбөр	(154,425,570.78)	(136,848,949.78)	(117,726,392.70)
Бараа материалын өсөлт, бууралт	583,142,501.94	(1,495,065,679.17)	(3,849,327,445.00)
Богино хугацаат өр төлбөрийн өсөлт, бууралт	21,738,449.74	1,090,416,176.62	933,538,504.90
Орлогын албан татварын зардал	389,339,799.74	550,718,025.37	295,907,324.00
Төлсөн орлогын албан татвар	(34,666,950.28)	(407,655,999.80)	(811,656,431.86)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,641,623,867.22	1,155,621,859.87	(649,323,415.32)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын борлуулалт	0.00	4,500,000.00	19,500,000.00
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын худалдан авалт	(88,007,864.00)	(1,578,367,907.00)	(537,848,174.40)
Хүлээн авсан хүүний орлого	50,794,529.55	0.00	438,356.16
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(37,213,334.45)	(1,573,867,906.55)	(517,909,818.24)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хүлээн авсан зээл болон өр төлбөр	284,920,000.00	0.00	2,567,354,117.00
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт	(459,999,999.96)	(460,000,000.04)	(1,330,994,270.96)
Төлсөн ногдол ашиг	(24,069,160.00)	(765,000,000.00)	(910,000,000.00)
Валютын ханшийн зөрүү	(11,783,729.65)	(5,993,700.92)	(42,750,816.22)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(210,932,889.61)	(1,230,993,700.96)	283,609,029.82
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,393,477,643.16	(1,649,239,747.64)	(883,624,203.74)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,646,355,000.07	4,039,832,643.33	2,390,592,895.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,039,832,643.33	2,390,592,895.19	1,506,968,691.45

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Орлого, үр дүнгийн тайлангийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Хүснэгт-14

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2020 он	2021 он	2021 оны 01/01-06/30	2022 оны 01/01-06/30
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	23	21,514,458,446	29,186,082,214	14,890,008,866	15,506,287,710
Борлуулалтын өртөг	23	14,526,003,854	18,461,370,779	9,763,538,490	10,776,233,431
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)		6,988,454,593	10,724,711,435	5,126,470,376	4,730,054,279
Хүүний орлого	24	41,155,627	62,135,814	56,360,521	5,676,660
Бусад орлого	24	193,099,230	361,217,934	182,801,265	32,867,650
		234,254,857	423,353,748	239,161,786	38,544,310
Борлуулалт маркетингийн зардал	26	1,184,696,635	2,153,369,434	972,174,542	1,073,796,312
Ерөнхий ба удирдлагын зардал	25	1,667,477,210	1,382,250,534	624,086,327	634,401,824
Санхүүгийн зардал	27	-	325,464,571	171,522,591	149,194,644
Бусад зардал	27	17,210,115	677,185,408	10,523,821	622,658,159
		2,869,383,959	4,538,269,947	1,778,307,281	2,480,050,939
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз)	28	61,132,419	(17,777,431)	(11,783,730)	(42,750,816)
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз)	28	-	11,450,384	4,777,838	37,566,972
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	29	(53,778,048)	(6,294,924)	-	(7,145,875)
		7,354,371	(12,621,970)	(7,005,892)	(12,329,719)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)		4,360,679,861	6,597,173,265	3,580,318,990	2,276,217,931
Орлогын татварын зардал	30	433,191,634	940,057,825	389,339,800	295,907,324
ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)		3,927,488,227	5,657,115,440	3,190,979,190	1,980,310,608
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)					
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)		3,927,488,227	5,657,115,440	3,190,979,190	1,980,310,608
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		-	-	-	-
ОРЛОГЫН НИЙТ ДҮН		3,927,488,227	5,657,115,440	3,190,979,190	1,980,310,608

Эздийн өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт-15

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	110,000,000	380,000,000	17,436,247,956	17,926,247,956
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	110,000,000	380,000,000	17,436,247,956	17,926,247,956
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,190,979,190	3,190,979,190
2021 оны 06 дугаар сарын 30 -ны үлдэгдэл	110,000,000	380,000,000	20,627,227,146	21,117,227,146
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(5,029,769)	(5,029,769)
Залруулсан үлдэгдэл	110,000,000	380,000,000	20,622,197,377	21,112,197,377
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,466,136,250	2,466,136,250
Зарласан ногдол ашиг	-	-	(2,000,000,000)	(2,000,000,000)
2021 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	110,000,000	380,000,000	21,088,333,627	21,578,333,627
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	110,000,000	380,000,000	21,088,333,627	21,578,333,627
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	1,980,310,608	1,980,310,608
2022 оны 06 дугаар сарын 30 -ны үлдэгдэл	110,000,000	380,000,000	23,068,644,234	23,558,644,234

1.8.3 Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагчийн 2019-2021 он болон 2022 оны эхний хагас жилийн Санхүү байдлын тайланд санхүүгийн босоо шинжилгээг хийхэд нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ 2019 онд 60 хувь байснаас 2021 онд 72 хувь болж 12 хувиар өссөн бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 74 хувьд хүрчээ. Эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь хэмжээ нь 40 хувиас 28 хувь болж буурсан бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар 26 хувьтай байна. Энэ нь тухайн үнэт цаас гаргагч компанийн хөрөнгийн хөрвөх чадвар сайжирч, санхүүгийн эрсдэл бага байгааг илтгэж байна.

Эх үүсвэрийн хувьд гадаад эх үүсвэр буюу өр төлбөрийн хэмжээ 2021 оны байдлаар 2019 оноос 27 хувиас 21 хувь болон буурч өөрийн хөрөнгийн хэмжээ 73 хувиас 79 хувь болон өссөн нь гадны эх үүсвэр буюу өр төлбөрийн хэмжээ буурсан нь үнэт цаас гаргагч санхүүгийн бие даан үйл ажиллагаа явуулах чадвар сайжирч, богино хугацаат зээлийн санхүүжилтээс санхүүжих хамаарал буурсан байгааг илтгэж байна. Харин 2022 оны хагас жилийн байдлаар гадаад эх үүсвэрийн дүн буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт-16

Санхүү байдлын тайлан	2019.IV	2020.IV	2021.IV	2022.II
Хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө	60%	67%	72%	74%
Эргэлтийн бус хөрөнгө	40%	33%	28%	26%
Нийт хөрөнгө	100%	100%	100%	100%
Өр төлбөр				
Богино хугацаат өр төлбөр	4%	3%	8%	12%
Урт хугацаат өр төлбөр	23%	18%	13%	9%
Нийт өр төлбөр	27%	21%	21%	20%
Эздийн өмч	73%	79%	79%	80%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	100%	100%	100%	100%

График-1



Үнэт цаас гаргагч компанийн хөрөнгийн ерөнхий бүтэц, эх үүсвэрийн ерөнхий бутцийн хувьд зохистой харьцаанд байна.

СЗХ БҮРТГЭВ №-1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-19 БҮРТГЭВ-03

ДьюПонт шинжилгээ

Сүүлийн үед мэргэжлийн хөрөнгө оруулагчид ДьюПонт шинжилгээг түлхүү хардаг болсон бөгөөд энэхүү шинжилгээний аргачлалаар Компанийн өмчийн өгөөж 2017 онд 8.3% байсан нь 2021 онд 28.7% болж тогтмол сайжирч иржээ.Үүнийг ДьюПонтын шинжилгээгээр дэлгэрүүлж харвал: Хөрөнгийн эргэц 0.7-оос 1.2 болж үр ашиг сайжирсан, цэвэр ашгийн марж 10.6%-иас 19.4% болж сайжирсан бол, хөшүүргийн харьцаа (нийт хөрөнгө / өмч) 1.1-ээс 1.3 болж багахан өссөн нь Компани хөшүүргийн түвшинг нэмэгдүүлэлгүйгээр ашигт ажиллагаагаа нэмэгдүүлж чадсаныг харуулж байна. Санхүүгийн төсөөллийн хугацаанд ч энэхүү байдлаа хадгалан ажиллах төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт-17

Өсөлт	2017	2018	2019	2020	2021	2022.II
Борлуулалт	53.8%	44.2%	25.0%	44.8%	35.7%	15.1%
EBITDA	68.2%	102.6%	50.6%	55.9%	34.8%	-2.7%
EBIT	68.4%	98.4%	43.4%	46.1%	44.5%	-3.4%
Цэвэр ашиг	49.1%	115.6%	29.0%	61.1%	43.6%	-5.8%
Маржин						
EBITDA	13.6%	19.1%	23.3%	25.1%	25.0%	21.1%
EBIT	12.9%	17.8%	20.7%	20.9%	22.2%	18.7%
Цэвэр ашиг	10.6%	15.9%	16.4%	18.3%	19.3%	15.8%
Ашигт ажиллагаа - ДьюПонтын шинжилгээ						
Хөрөнгийн эргэц	0.7x	0.8x	0.8x	1.0x	1.2x	1.1x
-Ашигт ажиллагаа	10.6%	15.9%	16.4%	18.3%	19.3%	15.8%
Хөрөнгийн өгөөж	7.8%	12.5%	12.6%	18.3%	22.6%	17.6%
-Нийт хөрөнгө/Өмч харьцаа	1.1x	1.3x	1.4x	1.3x	1.3x	1.3
Өмчийн өгөөж	8.3%	16.4%	17.8%	23.9%	28.6%	22.9%
Ашигт ажиллагаа - ROCE буюу оруулсан капиталын өгөөж						
Үндсэн хөрөнгө	2,359	4,780	8,175	7,431	7,672	7,688
Ажлын капитал	7,132	10,115	9,709	11,912	14,945	9,896
Мөнгө	1,072	2,157	1,607	2,646	2,410	7,444
Нийт капитал	10,563	17,053	19,490	21,990	25,027	25,027
ХТӨА	1,064	2,111	3,076	4,495	6,493	6,273
- Татвар	-109	-217	-274	-433	-940	-590
Татварын дараах үйл ажиллагааны ашиг	955	1,894	2,802	4,061	5,553	5,683
Капиталын өгөөж		13.7%	15.3%	19.6%	23.6%	22.7%

NOVEL INVESTMENT
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР XXX

СЗХ
2023 -01- 25 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ 03

Эргэлтийн харьцаа нь эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөр нь хэрхэн баталгаажсаныг харуулж байгаа бөгөөд үнэт цаас гаргагч компанийн хувьд 2021 онд 2019 болон 2020 оны үзүүлэлтээс буурсан үзүүлэлттэй байгаа нь богино хугацаат өр төлбөр нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд хэдийн харьцаа үзүүлэлт буурсан байгаа ч эргэлтийн харьцаа нь зохистой хэмжээ болох 2-оос давсан сайн үзүүлэлттэй хэвээр байна.

Үнэт цаас гаргагч компанийн хувьд гадны эх үүсвэрээс хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулах чадварын хэмжээ нь 2021 онд 2019 оны байдлаас өссөн сайн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ нь санхүүгийн байдал мөн адил сайжирсныг илтгэж байна.

Хөрөнгийн өгөөж болон Капиталын өгөөжийн дүн

График-2



График-3



График-4



ROA нь хөрөнгийн ашиг олох чадварыг харуулдаг бол ROE буюу хувьцаат капиталын өгөөж нь хувьцаа эзэмшигчийн 1 төгрөг тутамд ногдож байгаа ашгийн хэмжээг илэрхийлдэг бөгөөд үнэт цаас гаргагч компанийн хувьд энэхүү өгөөжийн үзүүлэлт нь сүүлийн 3 жил тогтмол өсөлттэй байна. Энэ нь борлуулалтын орлого тогтмол өсөлттэй байгаатай холбоотой бөгөөд хөрөнгийн өгөөж болон давхар компанийн үйл ажиллагаа сайжирсныг илэрхийлж байна.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЗХ
2021 01 26 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

График-5



EPS нь Эргэлтэд байгаа нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээг авч үздэг. Үнэт цаас гаргагчийн хувьд сүүлийн 3 жил тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 2021 оны байдлаар нэгж хувьцаанд ногдох ашиг нь 4 төгрөг байна.

График-6



Үнэт цаас гаргагч компанийн сүүлийн 3 жилийн байдлаар Ашигт ажиллагааны түвшнийг харахад нийт ахиуц ашиг, цэвэр ахиуц ашиг, үйл ажиллагааны ахиуц ашиг зэрэг нь тогтмол өсөлттэй байна.

"Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй хүнсний салбарт үйл ажиллагаа эрхлэгч "Монос хүнс" ХК, "Түмэн шувуут" ХК, "Талх чихэр" ХК, "АПУ" ХК-ийн ROE, ROA болон нийт ахиуц ашиг, цэвэр үзүүлэлтүүдтэй "Газар шим үйлдвэр" ХХК-ийн санхүүгийн үзүүлэлтийг харьцуулан авч үзэхэд дундаж төвшнөөс дээгүүр байгаа нь цаашид бүртгэлтэй хувьцаат компани болсноор нийт ахиуц ашиг, цэвэр ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх боломжтой нь харагдаж байна.

Жишиг компаниудын санхүүгийн харьцаа үзүүлэлт

График-7



СЗХ
2023 -01- 25
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ХОЁРДУГААР БҮЛЭГ:
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ШИНЖИЛГЭЭ, САЛБАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1 Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

2.1.1 Эдийн засгийн нөхцөл байдал

Монгол Улсын эдийн засгийн хувьд хамгийн таатай үе нь олон улсад түүхий эдийн супер цикл тохиосон 2010-2013 онуудад байсан бөгөөд бизнесийн мөчлөгийн хувьд эдийн засаг нь төрөлжсөн бусад улс орнуудтай харьцуулахад богино, түүхий эдийн үнийн мөчлөгийг дагадаг шинж ажиглагддаг. 2017 оноос хойш улсын төсвийн гүйцэтгэлд эерэг өөрчлөлтүүд гарч, макро эдийн засгийн бодлогын уялдаа сайжирч, түүхий эдийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдсаны зэрэгцээ хувийн хөрөнгө оруулалт огцом нэмэгдсэн нь 2020 оныг хүртэл эдийн засгийн хувьд таатай байх нөхцөлийг бүрдүүлсэн.

Гэвч 2020 оноос дэлхий нийтийн өмнө хүнд сорилт болсон Ковид-19 цар тахлын нөлөөгөөр дэлхий дахинд түүхий эдийн эрэлт эрс буурч үнэ нь огцом унаж, улс орны хэмжээнд тогтоосон ээлжит хөл хорио, ялангуяа БНХАУ-аас хилээ хаасан нь эдийн засгийн өсөлт 1990 оноос хойш ёроолдоо хүрч 4.6%-аар унахад нөлөөлөв.

Харин 2021 оны эхэнд эдийн засаг эрчимтэй сэргэж байсан боловч гадаад худалдааны салбарт учирсан хүндрэл бэрхшээлээс шалтгаалан эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж ердөө 1.4 хувиар л өсжээ. Гадаад худалдааны саатал эхлэхээс өмнө 2021 оны эхний улиралд нүүрс олборлолт эрчимжиж, зэсийн хүдрийн агууламж сайжирч, үйлчилгээний салбар сэргэсэн нь эдийн засгийн өсөлтийг голлон дэмжсэн.

Үйлчилгээний салбар (эрүүл мэнд, мэдээлэл харилцааны технологи, худалдаа, зочид буудал болон ресторан, түүнчлэн санхүүгийн үйлчилгээ) 2021 оны ДНБ-ий 1.8 нэгж хувийг бүрдүүлсэн нь 2021 оны 2 дугаар хагасаас Ковид-19-тэй холбоотой дотоод хязгаарлалтуудыг сулруулж эхэлсний илрэл юм. Харин эсрэгээрээ аж үйлдвэрийн салбар зогсонги байдалд орсон бол хилийн боомтуудын доголдлоос шалтгаалан барилгын материалын нийлүүлэлт тасалдаж барилгын салбар уналтад орсон.

Азийн хөгжлийн банкнаас гаргасан тайлангаас үзвэл 2022 онд инфляц өсөж өндөр түвшинд хүрсэн, гадаад худалдааны тасалдал үргэлжилсээр байгаа, гадаад санхүүжилтийн нөхцөлүүд урьд өмнөхөөс илүү чангарах хүлээлттэй болсон, мөн геополитикийн нарийн төвөгтэй асуудал шинээр бий болж эрсдэл нэмэгдсэн зэрэг нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг үлэмж хязгаарлагдахаар байна. Харин 2023 онд коронавируст цар тахал (КОВИД-19)-ын сөрөг нөлөөлөл буурах, гадаад худалдааны тасалдал арилах боломжтой зэрэг эерэг хүлээлтэд тулгуурлан эдийн засгийн өсөлт нэмэгдэх төсөөлөлтэй байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн задаргаа салбаруудаар /өссөн дүнгээр/ нөхцөл байдал

График-8



СЗХ
БҮРТГЭВ
БҮРТГЭВ-03

Эдийн засгийн өсөлт 2022 оны 2 дугаар улиралд төсөөллөөс 3.1 нэгж хувиар өндөр гарсан бөгөөд үүнд нүүрс, зэсийн баяжмалын олборлолт хүлээлтээс бага гарч, уул уурхайн салбарын үйлдвэрлэл төсөөллөөс бага зэрэг муудсан ч эрчим хүчнээс бусад уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл хүлээлтээс давж, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Эдийн засгийн өсөлт ийнхүү хүлээлтээс өндөр гарсантай уялдуулан энэ оны өсөлтийн төсөөллийг 3 хувьд хүргэж нэмэгдүүлэв. Уул уурхайн бус салбарт эрчим хүч, боловсруулах, үйлчилгээний салбаруудаас бусад салбаруудын үйлдвэрлэл өмнөх төсөөллөөс нэмэгдэхээр байна.

Тодруулбал, цаг агаарын таатай нөхцөл байдал нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжиж, хөл хорионы дэглэм суларч, дотоод эрэлт сэргэж байгаатай холбоотойгоор худалдаа, үйлчилгээний зарим салбаруудын идэвхжил үргэлжилж, үүнээс улбаалан татварын орлого бүрдүүлэлт нэмэгдэнэ гэж үзлээ. Хилийн боомтууд дээрх хязгаарлалтууд суларч, экспорт сэргэж байгаатай холбоотойгоор уул уурхайн салбарын өсөлтийг өмнөх төсөөллөөс сайжруулаа.

Харин зээл олголт хумигдсантай холбоотойгоор санхүү, даатгалын үйлчилгээ буурч, үйлчилгээний салбар оны сүүлийн хагаст удаашрахаар байна. Дунд хугацаанд Оюу толгойн үйлдвэрлэл нэмэгдэх, нүүрсний экспорт хэвийн түвшинд хүрэх, газрын тосны олборлолт сайжрахаар байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг тэтгэх бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөл муудах, төсвийн төлөв чангарах нь уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулахаар байна.

Мөн олон улсын байгууллага, шинжээчдийн сүүлийн үеийн таамаглалаар Монгол Улсын эдийн засаг 2022 онд дунджаар 5.9%-иар өсөх хүлээлттэй байна.

- Олон улсын валютын сангийн зүгээс нүүрсний экспорт эргэж сэргэх, Оюу толгой зэсийн уурхайн хоёр дахь шатны бүтээн байгуулалт ашиглалтад орсноор зэсийн экспорт нэмэгдэх, Оюу толгой төслийн бүтээн байгуулалт бүрэн дууссанаар импортын орчин сайжрах зэрэгт үндэслэн 2022-2023 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хурд нэмэгдэх таамаглалыг гаргасан.
- Азийн хөгжлийн банкны зүгээс вакцинжуулалтын хөтөлбөрийн үр нөлөөгөөр цар тахлын нөхцөл байдал сайжрах, экспортод хүндрэл учруулж буй тээвэр логистикийн асуудал шийдэгдэх, дотоод эрэлтийн хэмжээ өсөн нэмэгдэх таамаглалд үндэслэн Монгол Улсын 2022 оны эдийн засгийн өсөлт өмнөх оны үзүүлэлтээс нэмэгдэхээр тооцсон.
- Дэлхийн банкны зүгээс дотоодын эдийн засгийг дэмжих бодлогын арга хэмжээнүүд, дэлхийн эдийн засгийн эерэг төлөв, үр дүнтэй вакцинжуулалт зэрэг хүчин зүйлд үндэслэн Монгол Улсын эдийн засаг 2022 онд 5.1%-иар өсөх таамаглал дэвшүүлсэн байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төлөв

Хүснэгт-18.

Байгууллага	Шинэчилсэн огноо	2021	2022*	2023*
World Bank	2022.01	3.50%	5.10%	6.20%
IMF	2021.11	4.50%	7.00%	6.10%
ADB	2021.09	4.60%	6.00%	
BOM	2021.09	4%	5.50%	5.60%

Валютын ханш: Монголбанкнаас зарласан төгрөгийн америк доллартой харьцах сарын дундаж ханш 2022 оны 9 дүгээр сард 3257.10 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 408.16 төгрөгөөр, өмнөх сараас 71.38 төгрөгөөр суларсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн юаньтай харьцах сарын дундаж ханш 2022 оны 9 дүгээр сард 463.90 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 22.70 төгрөгөөр суларч, өмнөх сараас 4.47 төгрөгөөр чангарсан байна. Монголбанкнаас зарласан төгрөгийн рубльтэй харьцах сарын дундаж ханш 2022 оны 9 дүгээр сард 54.48 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.40 төгрөгөөр, өмнөх сараас 1.87 төгрөгөөр суларсан нь гадаад валютын цэвэр урсгал буурч, хасах болсон нь төгрөгийн ханш сулрах дарамтыг улам нэмэгдүүлж байна.

СЗХ
БҮРТГЭВ
No 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19

Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 2021 оны эцэст чангарах төлөвтэй байсан ч 2022 оны эхнээс эргэн суларч 2022 оны 9 дүгээр сарын байдлаар 7 орчим хувиар суларлаа. Ингэхдээ төгрөгийн ханш рублийн эсрэг 2022 оны 2 дугаар сард огцом 27.5 хувиар чангарсан ч 10 дугаар сард буцаад 35 орчим хувиар суларсан бол төгрөгийн ханш еврогийн эсрэг сүүлийн 2 улирал дараалан чангарсан байна. Харин төгрөгийн ханш ам.доллар болон юанийн эсрэг сулрах хурд 2022 оны эхнээс нэмэгдсэн бөгөөд 2022 оны 10 дугаар сард тус бүр 18.7, 3.7 хувиар суларсан байна.

Цаашид дэлхийн зах зээл дээр экспортын гол түүхий эдийн үнэ тогтвортой байж, вакцинжуулалттай холбоотойгоор халдварын тохиолдлын тоо буурч, хилийн хорио цээр хэвийн нөхцөлд шилжиж, экспортын хэмжээгээ нэмэгдүүлж чадвал валютын ханшийг тогтвортой барих боломжтой. Нөгөөтэзгүүр, Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй төсөв, мөнгөний зөөлөн бодлого үргэлжилж, 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд эдийн засаг идэвхжихийн хэрээр ам.долларын худалдан авах эрэлт нэмэгдэж байгаа нь валютын ханш чангарах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр унах, Ковид-19-ийн халдварын шинэ төрлүүд гарч, хилийн хорио үргэлжилж, экспортын хэмжээ буурвал төгрөгийн ханш огцом сулрах эрсдэл байсан хэвээр байна.

Ам.доллар төгрөгийн ханшийн хөдөлгөөн болон өдрийн хэлбэлзэл

График-9



Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш болон нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт)

График-10



Бодит ханш 2021 оны сүүлийн хагасаас эхлэн дотоод инфляцаас шалтгаалан чангарч байгаа бөгөөд 2022 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оноос 7 хувиар чанга тогтсон. Үүнд дотоод үнэ нэмэгдэж, гадаад үнэтэй харьцуулахад 9 хувиар чангарсан нь голлон нөлөөллөө.

Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт

График-11



Төгрөгийн харьцангуй өгөөж

График-12



Эх сурвалж: Монголбанк

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
ХУДАЛДАА, УЛААНБААТАР ХОТ

ГАЗАР ШИМ УНЭЦЭР ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19

Дотоодын зах зээлийн хувьд ам.долларын нийлүүлэлтийг уул уурхайн олборлолт, экспортын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг цөөхөн тооны томоохон ААН-үүд бүрдүүлдэг бол эрэлтийг импортын үйл ажиллагаа эрхэлдэг бүхий л ААН-үүд, иргэд, зах зээлийн бусад оролцогчид бүрдүүлдэг байна. Бодлого боловсруулагчдын зүгээс долларжилтыг бууруулах зорилгоор ам.долларын эх үүсвэрт хамаарах заавал байлгах нөөцийн хувийг нэмэгдүүлэх, төлбөр тооцоог зөвхөн төгрөгөөр гүйцэтгэх, гадаад валютын хадгаламжийг даатгахгүй байх, гадаад валютын зээлийн эрсдэлээр жигнэх активын хувийг өндөр тогтоох гэх мэт тодорхой бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа нь дотоодын зах зээл дээрх долларжилтыг бууруулахад нөлөөлж байна.

Инфляц: Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 9 дүгээр сард 10.2 хувь гарсан бол 2022 оны 9 дүгээр сард 13.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.6 нэгж хувиар өссөн байна. Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд 13.8 хувь гарсны 4.4 (32.0%) нэгж хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Гэсэн хэдий ч ирэх онд хүнсний үнийн төсөөлөл нэмэгдэх, гадаад үнүүд өсөх, төгрөгийн ханш сулрах, үүнтэй холбоотойгоор импортын бараа, улмаар дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх нөлөөгөөр инфляцын төсөөлөл дунд хугацаанд бага зэрэг нэмэгдэж, Төв банкны зорилтот интервалд тогтворжих хугацаа хойшлох хандлагатай болов.

Инфляц

График-13



Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт

График-14



Энэ оны 3 дугаар улиралд инфляц улсын хэмжээнд 13.8 хувь, Улаанбаатар хотод 14 хувь болж өмнөх улирлаас тус бүр 0.9 болон 0.6 нэгж хувиар нэмэгдэв. Инфляц сүүлийн улирлуудад өндөр байгаа нь гадаад орчинд бий болсон өөрчлөлт, түүнтэй холбоотой тээвэр логистикийн хүндрэлээс үүдсэн зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө өндөр байлаа.

Махнаас бусад дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнэ 8-р сард жилийн 30.7 хувиар өсөж инфляцад үзүүлэх нөлөө 3.1 нэгж хувь болж II улирлаас 0.2 нэгж хувь нэмэгдлээ. Үүнд өндөгний үнэ жилийн 41.0 хувь өссөн нь голлон нөлөөлөв.Үйлчилгээний үнэ тайлант сард жилийн 10.8 хувь өсөж инфляцад үзүүлэх нөлөө 2.3 нэгж хувь буюу II улирлын орчимд байна.

Импортын нийт бараа, бүтээгдэхүүний инфляцад үзүүлэх шууд нөлөө нь тайлант сард 7.2 нэгж хувь буюу инфляцын тал орчим хувийг бүрдүүлэв. Үүнд тээврийн саатлаас үүдэн зардал нэмэгдэж, төгрөгийн ханш суларсан нь гол нөлөөтэй байна (Зураг I.2, I.3). Тухайлбал, 8 дугаар сард шатахуунаас бусад импортын бараа жилийн 11.7 хувь өсөж инфляцын 4.0 нэгж хувийг, импортын хүнс жилийн 29.7 хувиар нэмэгдэж 1.7 нэгж хувийг бүрдүүлжээ. Шатахууны бүлгийн хувьд инфляцад үзүүлэх нөлөө 1.5 нэгж хувь болж II улирлаас 1.1 нэгж хувиар буурсан нь суурь үеийн нөлөө арилсан болон тайлант сард дизель түлшний үнэ литр тутамдаа 300 төгрөгөөр буурсантай холбоотой байв.

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт

График-15



Инфляц

График-16



Ирэх онд хүнсний үнийн төсөөлөл нэмэгдэх, гадаад үнэ өсөх, төгрөгийн ханш сулрах холбоотойгоор импортын бараа, үүний дам нөлөөгөөр дотоодын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж, инфляцыг өмнөх төсөөллөөс нэмэгдүүлэхээр байна.

Инфляцын цаашдын төлөв:

Ирэх улирлуудад махны үнэ улирлын хандлагаа даган буурах бол тээвэр, үйлдвэрлэлийн зардлын өсөлттэй холбоотойгоор хүнсний үнэ нэмэгдэх хандлага үргэлжлэхээр авч үзлээ. Түүнчлэн, тээвэр, логистикт үүссэн хүндрэл энэ онд сайжирч, хэвийн түвшинд очихооргүй байгаагаас зардлын болон нийлүүлэлтийн шалтгаантай инфляц эрчимжих хандлага ирэх улирлуудад хадгалагдах төлөвтэй байна. Нийт эрэлт: Оны I улиралд 3.8 хувиар агшаад байсан нийт эрэлт II улиралд 6.9 хувиар тэлжээ. Эрэлт ийнхүү тэлэхэд эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал эергээр нөлөөлсөн бол цэвэр экспорт бууруулах нөлөө үзүүлсэн хэвээр байна.

Дунд хугацаанд уул уурхайн бус салбарын өсөлт удааширч, эрэлтийн шалтгаантай инфляцын дарамт багасах хэдий ч ханш сулрах, гадаад үнэ өсөх зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляцын төсөөлөл нэмэгдэж, улмаар Төв банкны зорилтот интервалд тогтворжих хугацаа хойшлох хандлагатай боллоо. Инфляцыг дунд хугацаанд тогтворжуулах, банкны системийн эх үүсвэрийн долларжилт нэмэгдэж, гадаад суурь хүү өсөж байгаа нөхцөлд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2022 оны 9 дүгээр сарын ээлжит хурлаар бодлогын хүүг нэмэгдүүлж, хүүгийн коридорыг өргөтгөн мөнгөний бодлогын төлөвийг хатууруулж байгаа нь инфляцын дараа үеийн нөлөө болон хүлээлтийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлж байна.

Нийт нийлүүлэлт:

Нийт нийлүүлэлт энэ оны эхний хагас жилд 2021 оны мөн үеэс 1.9 хувиар тэлсэн ч цар тахлын өмнөх үетэй харьцуулахад 1.4 хувиар бага байна. Энэ нь голчлон уул уурхайн салбарын үйлдвэрлэл хэвийн түвшиндээ хүрч хараахан сэргээгүй байгаатай холбоотой байна. Харин уул уурхайн бус салбаруудын хувьд үйлдвэрлэл цар тахлын өмнөх үеийн түвшнээс 5.2 хувиар давжээ. Энэ оны II улирлын хувьд нийт нийлүүлэлтийн жилийн өсөлт эрчимжиж, 6.3 хувьд хүрсэн бөгөөд эдийн засгийн үйл ажиллагааны ихэнх салбаруудад өссөн байна.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Нийт нийлүүлэлт цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргэх хараахан болоогүй байна.

График-17



Нүүрсний экспорт өнгөрсөн улирлаас нэмэгдэв.

График-18



Хөдөө аж ахуйн салбарын өсөлт эрчимжиж 11.3 хувьд хүрсэн нь энэ оны мал төллөлт, төл бойжилтын явц олон жилийн дунджаас өндөр гүйцэтгэлтэй байгаагийн зэрэгцээ том малын зүй бус хорогдол бага байгаагаар голлон тайлбарлагдаж байна. Газар тариалангийн салбарын хувьд дотоодын улаанбуудай, төмсний хэрэгцээг бүрэн, хүнсний ногооны хэрэгцээг 70 хувьтай хангах хэмжээний ургац авахаар урьдчилсан тооцоо ХХААХҮЯ-наас гарчээ.

Худалдааны салбар 16.1 хувиар, үүнтэй уялдаатайгаар бараа, бүтээгдэхүүнд ногдуулсан татварын орлого 13.6 хувиар тус тус тэллээ. Энэ нь тайлант улиралд чингэлэг татан авалт сайжирч, импортын барааны эргэлт хурдассантай шууд холбогдож байна. Тодруулбал, удаан эдэлгээт хэрэглээний бараа болон барилгын материалын импорт, борлуулалт сайжирчээ.

Үйлчилгээний салбаруудын өсөлт тайлант улиралд 5.4 хувьтай байлаа. Үүнд өмнөх оны мөн үед хатуу хөл хорионы улмаас идэвхжил нь огцом хумигдаад байсан байр сууц, хоол хүнсээр үйлчлэх, урлаг үзвэрийн холбогдолтой дэд салбарууд сэргэснээр голлох нөлөөг үзүүлжээ. Харин сүүлийн саруудад зээл, хадгаламжийн өсөлт удааширч байгаа нь санхүү даатгалын холбогдолтой үйл ажиллагааг сааруулж байна. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа он гарсаар төдийлөн сэргээгүй байна.

Сүүлийн 3 улирал дараалан уналттай байсан боловсруулах салбар тайлант улиралд 5.0 хувиар өслөө. Энэ нь өмнөх улирлуудтай харьцуулбал хилийн боомтууд дээрх асуудал алгуур сайжирч, дотоодын боловсруулах үйлдвэрлэлд шаардагдах түүхий эд, бараа материалын татан авалт дээрдэж байгаатай холбоотой байж болох юм. Голлох бүтээгдэхүүнээр авч үзвэл ундаа, нэхмэл бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэл өсөлттэй байгаа бол мах, сүү, гурил, шахмал түлш болон химийн гаралтай эм, эмэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл саарчээ.

Харин сүүлийн 8 улирлын турш тогтмол уналттай байсан барилгын салбар тайлант улиралд 1.7 хувиар өсжээ. Үүнд орон сууцны болон сургууль соёл, дотуур байрны зэрэг орон сууцны бус зориулалттай барилгын ажлууд эерэг нөлөө үзүүллээ. Мөн авто зам болон төмөр зам зэрэг инженерийн барилга байгууламжийн ажил идэвхжих хандлагатай болж байна.

Уул уурхайн салбар тайлант улиралд 18.2 хувиар, үүнтэй холбогдуулан тээврийн салбар 8.7 хувиар тус тус агшлаа. Өнгөрсөн оны сүүлийн хагасаас хойш хилийн боомтууд дээр үүссэн асуудлаас шалтгаалан эдгээр салбарууд уналттай гарч байгаа билээ. Уул уурхайн голлох нэр төрлийн бүтээгдэхүүнээс нүүрсний тээвэрлэлт 5 дугаар сараас эхлэн сэргэх хандлагатай болсон бол оны эхнээс хойш зогсонги байсан газрын тосны тээвэрлэлт 6-р сараас сэргэж эхэллээ. Оюу толгойн уурхайгаас олборлож буй зэсийн агууламж болон түүнд агуулагдах алт энэ онд төлөвлөгөөний дагуу буурч байна.

Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв: Эдийн засгийн өсөлт 2022 оны 2 дугаар улиралд хүлээлтээс өндөр гарсантай уялдуулан энэ оны өсөлтийн төсөөллийг 3 хувьд хүргэж нэмэгдүүллээ. Уул уурхайн бус салбарт эрчим хүч, боловсруулах, үйлчилгээний зарим салбаруудыг эс тооцвол дийлэнх салбаруудын үйлдвэрлэл өмнөх төсөөллөөс нэмэгдэх хандлагатай байна. Тодруулбал, хөдөө аж ахуй,

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 13
БҮРТГЭВ-03

худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг салбаруудын өсөлт нэмэгдэх хандлага үргэлжлэх бол хилийн хязгаарлалтууд алгуур суларснаар тээвэр, барилгын салбарыг дэмжинэ гэж үзлээ. Харин зээл олголт хумигдсантай холбоотойгоор санхүү, даатгалын үйлчилгээ буурч, үйлчилгээний салбарын өсөлтийн төлөвийг өмнөхөөс бууруулав. Уул уурхайн салбарын хувьд хилийн боомтууд дээрх хязгаарлалтууд суларч, экспорт сэргэж байгаатай холбоотойгоор өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс бага зэрэг сайжрахаар байна.

Дунд хугацаанд уул уурхайн салбарын өсөлт өмнөх төсөөллийн орчимд хадгалагдах бол гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөл бага зэрэг муудах, төсвийн төлөв чангарах зэрэг нь уул уурхайн бус салбарын өсөлтийг удаашруулж, эдийн засгийн өсөлт өмнөх төсөөллөөс буурах хүлээлттэй байна.

Экспортын гүйцэтгэл (сая ам доллар)

График-19



Эх сурвалж: УСХ

Гадаад худалдааны тэнцэл 2021 оны эхний улиралд 476.6 сая америк долларын ашигтай байсан бол 2022 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 225.3 сая америк доллароор буурч, 251.4 сая америк долларын ашигтай гарчээ. Харин 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 50.5 сая америк доллароор буурчээ. Хятад Улстай 2022 оны эхний улиралд 2.1 тэрбум америк долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.6 хувийг эзэлж байна.

Импорт: 2022 оны II улиралд 29.9 хувиар өсөхөд импортын бүх бүлгүүд, тэр дундаа нефть, хэрэглээний бүтээгдэхүүний импорт хамгийн өндөр нөлөөлөв. Нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт нь газрын тосны үнээс голлон шалтгаалж байгаа бол хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт нь биет хэмжээний өсөлтөөр түлхүү тайлбарлагдаж байна. Тодруулбал, тайлант улиралд өрхийн хэрэглээний өсөлт өндөр байж, өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар өссөн нь ийнхүү хэрэглээний импорт тэлэх шалтгаан боллоо. Мөн өмнөх улиралд бууралд байсан хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт эргэн сэргэж, тайлант улиралд 13.2 хувиар өссөн байна. Тяньжин боомтод гацаад байсан манай улсын чингэлгүүдийг II улирлын дундаас эрчимтэй татан авсан нь импорт нэмэгдэх нэг шалтгаан байв.

Цаашид дэлхий дахинд өсөж буй инфляцын түвшинд хариу үйлдэл үзүүлэх зорилгоор томоохон Төв банкнууд мөнгөний бодлогоо хумих төлөвт орсон тохиолдолд таваарын үнийн тэлж буй мөчлөгийн хурд удааширч, улмаар уналтын мөчлөг рүү шилжих эрсдэл өндөр хэвээр байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Монгол Улсын голлох таваарын экспортын үнийн дүн

График-20



Блүүмбергийн түүхий эдийн үнийн индекс

График-21



Зах зээлийн хүү болон инфляц

Монгол Улсын дотоодын зах зээлийн төгрөгийн зээлийн хүүгийн хувьд хөгжиж буй бусад орнуудын дотоодын зээлийн хүүтэй харьцуулахад харьцангуй өндөрт эрэмбэлэгдсээр ирсэн. Үүнд, дотоодын зах зээлд эх үүсвэрийн хүү өндөр, санхүүгийн зах зээлийн үр ашигт байдал нь бага, зах зээл дээрх эрсдэл өндөр болон Төв банкны мөнгөний бодлогын хүүгийн шилжих нөлөө муу байгаа зэрэг шалтгаанууд нөлөөлж байна.

Банкнуудын эх үүсвэрийн бүтцийг харвал бодлогын хүүтэй уялдсан хөвөгч хүүтэй эх үүсвэр нь бодлогын хүүтэй уялдсан активтай харьцуулахад маш бага хувийг эзэлж байна. Энэ нь арилжааны банкнуудын зээлийн хүү бодлогын хүүг дагаж буурахгүй байх үндсэн шалтгаан болж байна. 2018 онд УИХ нь "Зээлийн хүүг бууруулах үндэсний стратеги 2018-2023"-ийг баталж, тодорхой зорилтуудыг тавьсан бөгөөд үүнд: 1) Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх, 2) Мөнгөний бодлогын хүүгийн шилжих нөлөөг сайжруулах, 3) Банкны эрсдэл удирдах чадвар, үр ашиг, засаглалыг сайжруулах гэсэн үндсэн 3 зорилтыг тавин ажиллаж байна.

Дэлхий дахинд тулгарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бүхий л орнуудын Төв банкнууд ААН-ийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, хөрөнгийн зах зээлийг дэмжих, иргэдийн хэрэглээ, хөрөнгө оруулалтыг тэлэх зорилгоор бодлогын хүүгээ түүхэн доод түвшинд тогтоосон. Үүний адилаар Монголбанкны хувьд ч бодлогын хүүгээ 6%-д хүргэж, банкнуудад шинээр уламжлалт бус эх үүсвэрийн сувгийг нээж, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 10.5-6 хувь болгож бууруулсан. Мөн үүнтэй зэрэгцээд УИХ-ын зүгээс Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль баталсан бөгөөд үүнд банкны эх үүсвэрийн зардлыг бууруулах замаар зээлийн хүүг буулгах зохицуулалтыг хийсэн.

Тухайлбал, банкнууд уг хууль хүчинтэй хэрэгжих хугацаанд хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй, тусгай нөхцөлтэй хадгаламжид энгийн хадгаламжийн хүү тооцох тухай зохицуулалтууд орсон. Уг арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2021 оны 12 дугаар сарын байдлаар банкны системийн хэмжээнд хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 3.49%-иар буурч 7.1%-д, зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү 1.15%-иар буурч 15.6%-д хүрсэн бол тухайн сард татсан хадгаламжийн хүү 3.49%-иар буурч 5.4%-д, тухайн сард шинээр олгосон зээлийн хүү 1.29%-иар буурч 14.5%-д тус тус хүрээд байна.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2023-01-25 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-19 БҮРТГЭВ-03

Банкны секторын зээл болон хадгаламжийн хүү

График-22



Монголбанкны бодлогын хүү

График-23



Дэлхий даяар эдийн засгийн идэвхжил, үүнийг дагасан таваарын үнийн өсөлт, мөн тээврийн зардал өссөнтэй холбоотойгоор инфляцын түвшин нэмэгдэж байгаа нь улс орнуудын Төв банкнууд хүүгээ өсгөж, мөнгөний бодлогын хумих мөчлөгт зайлшгүй шилжих нөхцөлийг бий болгоод байна. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 03 дугаар сарын 23, 24-ний өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөвийг хэлэлцэн бодлогын хүүг 2.5 нэгж хувиар нэмэгдүүлж, 9.0 хувьд хүргэх шийдвэр гаргав. Ийнхүү бодлогын хүүг нэмэгдүүлсэн нь олон улсын харилцаанд хурцадмал байдал шинээр үүсэж, гадаад, дотоод эдийн засгийн тодорхой бус байдлын нэмэгдэж, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, хүнсний үнэ огцом өсөж, нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжлэхээр хүлээлттэй байгаатай холбоотой байна.

Мөн Монголбанкнаас 2022 оны 9 дүгээр сарын 16, 20-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

- Бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх;
- Бодлогын хүүгийн коридорыг бодлогын хүүгээс +2, -2 нэгж хувийн өргөнтэй болгох;
- Банкнуудын 360 хоног ба түүнээс дээш хугацаагаар гадаад зах зээлээс бонд болон зээл хэлбэрээр шинээр татсан эх үүсвэрийг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрээс хасаж тооцох шийдвэр гаргасан.

Цар тахлын хуульд төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулахаар дахин шийдвэрлэсэн. 2020 оны эхэн үеэс хойш 3 удаа эргэн төлөлтийг хойшлуулах шийдвэр гаргаад байна. 2021 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар давхардсан тоогоор 152,078 мянган өрхийн 3.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулсан. Мөн орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанк болон арилжааны банкнуудын эх үүсвэрээр 935.9 тэрбум төгрөгийн зээлийг 12.4 мянган өрхөд олгосон байна.

Санхүүгийн салбарын нөхцөл байдал

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эхний хагаст 23.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өслөө. Эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөрийн эерэг нөлөөгөөр банкнуудын зээл олголт нэмэгдэж, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт агшсанаар банкны системийн зээлийн багцын нийт активт эзлэх хувь хэмжээ өсөж байна.

Энэхүү өөрчлөлтөөс шалтгаалан өмнөх оны мөн үетэй харьцуулахад банкнуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа бага зэрэг муудаж, банкны салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ буурсан үр дүн гарав. Ковид-19 цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах чиглэлд Монголбанкнаас банк, санхүүгийн салбарт авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 4.8 их наяд төгрөгийн дүнтэй 134,752 зээл Ковид-19-д өртсөн байгаагаас 71 хувь буюу 3.46 их наяд төгрөгийн 105,693 зээлд бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөх нөхцөлд өөрчлөлт оруулаад байна.

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

Банкнуудад байршуулсан хугацаагүй хадгаламж, харилцахад хүү төлөхгүй байх хуулийн зохицуулалт үргэлж байгаатай холбоотойгоор банкны хүүгийн зардал өмнөх оноос буурсан бол хүүгийн бус орлогын хэмжээ нэмэгдэж, улмаар банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сайжирлаа. Гадаад орчны таагүй байдал, төлбөрийн тэнцлийн өндөр алдагдлын улмаас ханшийн сулрах дарамт нэмэгдэж байгаа нь банкны салбарын эх үүсвэрийн долларжилтыг өдөөж, банкнуудын гадаад валютын позицод сөргөөр нөлөөлж байна.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2022 оны 2 дугаар улиралд 41.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар буюу 2.2 их наяд төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт активын өсөлт 11.5 нэгж хувиар буурсан байна. Активыг бүтцээр нь авч үзвэл 2022 оны эхний хагас жилийн байдлаар зээл (цэврээр) 4.3 их наяд төгрөгөөр, мөнгөн хөрөнгө 2.0 их наяд төгрөгөөр, бусад актив 0.5 их наяд төгрөгөөр тус тус өссөн бол банкнуудын эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалт, тухайлбал, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 4.5 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 0.1 их наяд төгрөгөөр тус тус буурсан байна.

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2022 оны эхний хагаст 23.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 22.4 хувиар өслөө. Энэхүү өөрчлөлтийг зээлдэгчийн төрлөөр салгаж үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдааны болон хэрэглээ, өрхийн аж ахуйн зээл хамгийн өндөр буюу 33.8 хувь болон 33.6 хувиар тус тус өссөн байна.

Даатгалын зах зээлд нийт хөрөнгөөрөө эхний 5-д жагсаж байгаа даатгалын компанийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үед нийт зах зээлийн 55.0 хувийг эзэлж байсан бол тайлант улиралд 52.1 хувь болж буурчээ. Даатгалын компаниудын нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 431.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.5 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна. Харин нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 1.8 хувиар буурч 185.9 тэрбум төгрөгт хүрлээ . Даатгалын тохиолдлын улмаас урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 48.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс 66.1 хувиар өссөн дүн юм. Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 124.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлсний 98.7 хувь буюу 122.6 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.3 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани тус тус төвлөрүүлсэн бөгөөд даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 11.9 хувиар өссөн байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 527 банк бус санхүүгийн байгууллага /ББСБ/ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 83.1 хувь нь Улаанбаатар хотод байршдаг бөгөөд Нийт ББСБ-уудын 92.7 хувь буюу 489 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (Зураг 3.25). ББСБ-уудын нийт хөрөнгө болон зээл олголт эрчимтэй тэлж байна. Тухайлбал нийт хөрөнгө 2022 оны 2 дугаар улиралд 3.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар, нийт зээлийн хэмжээ 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 58.9 хувиар тус тус өссөн байна. Салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.7 сая хүрч өмнөх оны мөн үеэс 44.2 хувиар өсөж, зээлдэгчдийн тоо 1.5 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 102.1 хувиар өслөө. Цар тахалтай холбоотойгоор сүүлийн 2 жилийн хугацаанд ББСБ-уудын ашигт ажиллагаанд тодийлөн өсөлт байхгүй байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-уудын үндсэн үйл ажиллагаа болох зээл олголт нэмэгдэж, үүнийгээ дагаад хүүгийн орлого болон үйлчилгээний хураамж шимтгэлийн орлого харгалзан 72.8 болон 91.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

2022 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй Хадгаламж зээлийн хоршоо /ХЗХ/-дын тоо өмнөх онтой харьцуулахад 34-өөр буюу 14.5 хувиар буурч 200 ХЗХ болсон байна. Харин ХЗХ-дын гишүүдийн тоо 73,719 байсан бол тайлант үед 1.56 хувиар буурч 72,566 гишүүн болжээ. Тайлант улиралд нийт 200 ХЗХ-ноос 110 ХЗХ нь Улаанбаатар хотод, 90 ХЗХ нь орон нутагт бүртгэлтэй байна. Улсын хэмжээнд ХЗХноос зээл авсан нэг зээлдэгч гишүүн дунджаар 6.4 сая төгрөгийн зээлтэй байна. Улаанбаатар хотын хэмжээнд энэ дүн 9.6 сая төгрөг байгаа бол орон нутагт 2.8 сая төгрөг байна.

Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 0.42 хувиар өсөж 271.6 тэрбум төгрөгт хүрлээ. Харин нийт зээлийн хэмжээ 217.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өслөө. Цэвэр зээлийн

СЗХ он сар өдөр БҮРТГЭВ № 11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03

хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өсөж 212.2 тэрбум төгрөгт, зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 11.8 хувиар өсөж 5.6 тэрбум төгрөгт хүрлээ. Тайлант үед хэвийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өсөж 204.9 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 10.0 хувиар өсөж 5.6 тэрбум төгрөг, чанаргүй зээлийн хэмжээ 4.7 хувиар нэмэгдэж 7.2 тэрбум төгрөгт тус тус хүрлээ.

Монгол Улсын санхүүгийн салбарт оролцогчдын тоо 2021 оны IV улирлын байдлаар арилжааны 11 банк, банк бус санхүүгийн байгууллага 534, хадгаламж зээлийн хоршоо 209, даатгалын зах зээлд 15 ердийн даатгалын компани, даатгалын зуучлагч 58 компани, хөрөнгийн зах зээлд 314 хувьцаат компани, 53 үнэт цаасны компани (ҮЦК), арилжаа эрхлэх 2 биржтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Санхүүгийн салбарын нийт актив 2021 оны эцсээр 50.3 их наяд төгрөгт хүрч 2016 оноос ЖНӨХ 12.5 хувь байна. Салбарын бүтцийг нийт активын хэмжээгээр банкны салбар 81.3 хувийг, хөрөнгийн зах зээл 11.9 хувийг, ББСБ-ууд 5.4 хувийг, даатгалын зах зээл 0.8 хувийг, хадгаламж зээлийн хоршоод 0.6 хувийг тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсын санхүүгийн салбарт оролцогчдын тоо 2021 оны IV улирлын байдлаар арилжааны 11 банк, банк бус санхүүгийн байгууллага 534, хадгаламж зээлийн хоршоо 209, даатгалын зах зээлд 15 ердийн даатгалын компани, даатгалын зуучлагч 58 компани, хөрөнгийн зах зээлд 314 хувьцаат компани, 53 үнэт цаасны компани (ҮЦК), арилжаа эрхлэх 2 биржтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Санхүүгийн салбарын нийт актив 2021 оны эцсээр 50.3 их наяд төгрөгт хүрч 2016 оноос ЖНӨХ 12.5 хувь байна. Салбарын бүтцийг нийт активын хэмжээгээр банкны салбар 81.3 хувийг, хөрөнгийн зах зээл 11.9 хувийг, ББСБ-ууд 5.4 хувийг, даатгалын зах зээл 0.8 хувийг, хадгаламж зээлийн хоршоод 0.6 хувийг тус тус бүрдүүлж байна.

Санхүүгийн салбарын бүтэц (тэрбум.төг), нийт зах зээлд эзлэх хувь

Хүснэгт-19

Салбарын	2021		2020		2019		2018		2017		2016		
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	2016-2021 III
Банкны систем	41,012	81.3	36,685	86.6	35,859	87.7	33,053	88.4	28,773	88.3	25,338	90.7	10.1
Хөрөнгийн зах зээл	5,983	11.9	3,030	7.2	2,693	6.6	2,512	6.7	2,440	7.5	1,474	5.3	32.3
ББСБ	2,710	5.4	2,007	4.7	1,739	4.2	1,285	3.4	969	3.0	787	2.8	28.1
Даатгал	425	0.8	382	0.9	366	0.9	332	0.9	245	0.8	209	0.7	15.3
ХЗХ	291	0.6	256	0.6	223	0.5	200	0.5	153	0.5	113	0.4	20.8
Нийт	50,421	100.0	42,360	100.0	40,880	100.0	37,382	100.0%	32,580	100.0%	27,921	100.0	12.5

Эх сурвалж: ҮСХ, СЗХ, Монголбанк

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

Манай улсын хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн эхний үе шатанд үнэт цаасны зах зээлийг өмч хувьчлалыг хэрэгжүүлэх хэрэгсэл хэлбэрээр үүсгэн байгуулсан бөгөөд Улсын Бага Хурлаас 1991 оны 5 дугаар сард батлагдсан Өмч хувьчлах тухай хуулиар өмч хувьчлалын зарчим, хувьчлалд хамрагдах өмчлөлийн зүйлс, хувьчлал явуулах арга хэлбэр, хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлон зохицуулсан.

Их хувьчлалыг хэрэгжүүлэхээр үйлдвэрийн газруудыг хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулж, тэдгээрийн хувьцааг ХОЭБ-ээр худалдаалах ажлыг зохион байгуулахаар 1991 онд хөрөнгийн биржийг байгуулсан бөгөөд 1992 оны 2 дугаар сарын 07-ний өдөр анхдагч зах зээлийн анхны арилжаа явагдаж, 1995 оны 5 дугаар сард хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19

1992 онд "Монголын хөрөнгийн биржс" ХК-д бүртгэлтэй 208 хувьцаат компани бүртгэлтэй байснаас 7 нь тухайн ондоо хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан бол 1993 онд 114 хувьцаат компани хурлаа хуралдуулж, 72 ХК ногдол ашиг хуваарилж, 208 ХК санхүүгийн тайлангаа биржид хүргүүлж байсан байна. 1992-2021 оны хоорондох үнэт цаасны зах зээлийн нөхцөл, байдлыг товчлон авч үзвэл:

Үнэт цаас гаргагч нээлттэй хувьцаат компаниудын хувьд

- 1992-1995 оны хооронд төрийн өмчийн хувьцаат компаниудын хувьцааг хөрөнгийн биржийн анхдагч зах зээлээр дамжуулан үнэ төлбөргүйгээр цэнхэр, ягаан тасалбараар үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх, данс нээх ажиллагааг хэрэгжүүлсэн.
- 1995-2006 онд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа албан ёсоор эхэлж, зах зээлийн зуучлагчид болох брокерын компани, иргэдийн санхүүгийн мэдлэг дутмаг байдлаас үүдэн бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны дийлэнх хувийг нэгдмэл сонирхолтой болон холбоотой этгээдүүдийн гарт төвлөрч, хувьцааны төвлөрөл бий болох нөхцөл бүрдсэн.
- 2007-2009 онд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах компанийн тоо нэмэгдэж, иргэд, аж ахуйн нэгжүүд үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхол өссөн. Гэвч 2009 оны дэлхийн санхүүгийн зах зээлийн хямрал болон
- 1992-1995 оны хооронд төрийн өмчийн хувьцаат компаниудын хувьцааг хөрөнгийн биржийн анхдагч зах зээлээр дамжуулан үнэ төлбөргүйгээр цэнхэр, ягаан тасалбараар үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх, данс нээх ажиллагааг хэрэгжүүлсэн.
- 1995-2006 онд үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа албан ёсоор эхэлж, зах зээлийн зуучлагчид болох брокерын компани, иргэдийн санхүүгийн мэдлэг дутмаг байдлаас үүдэн бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьцааны дийлэнх хувийг нэгдмэл сонирхолтой болон холбоотой этгээдүүдийн гарт төвлөрч, хувьцааны төвлөрөл бий болох нөхцөл бүрдсэн.
- 2007-2009 онд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа идэвхжиж, шинээр болон нэмж үнэт цаас гаргах компанийн тоо нэмэгдэж, иргэд, аж ахуйн нэгжүүд үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхол өссөн. Гэвч 2009 оны дэлхийн санхүүгийн зах зээлийн хямрал болон дотоод хүчин зүйлсээс хамааран үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаагаа гаргасан "Анод банк" ХК, "Зоос банк" ХК-иудын дампууралтай холбоотойгоор иргэдийн зах зээлд итгэх итгэл суларсан.
- 2010-2012 онд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш огцом нэмэгдэж, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэнээс эдийн засгийн өсөлт огцом нэмэгдсэнээс, хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн хувьцаат компаниудын хувьцааны үнэ, ханш огцом өсч, төрөөс "Эрдэнэс таван толгой" ХК-ийн 1072 ширхэг хувьцааг иргэдэд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхтэй холбоотойгоор үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид иргэд, аж ахуйн нэгжүүд шинээр данс нээх ажиллагаа идэвхжиж, хуучин хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа эзэмшсэн иргэд дансны мэдээллээ шалгах явцад дансанд ХОЭБ-ээр эзэмшсэн хувьцаатайгаа мэдсэн нь арилжих сэдлийг бий болгосноор хувьцаат компанийн төвлөрөл огцом нэмэгдсэн.
- 2013-2015 онд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш унасантай холбоотойгоор хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн хувьцаат компанийн үнэ, ханш огцом унасан нь зах зээлийн үнэлгээ, арилжааны хэмжээ буурахад нөлөөлсөн.

- 2016-2022 оны хагас жилийн байдлаар хөрөнгийн зах зээл дээрх идэвх сэргэж, банк бус санхүүгийн байгууллага, даатгал, арилжааны банк, үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд хувьцаагаа олон нийтэд санал гаргах ажиллагаа сэргэж, шаардлагатай санхүүжилтээ арилжааны банкны өндөр хүүтэй зээлийн санхүүжилтээр бус хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татах сонирхол нэмэгдсэн. Мөн аж ахуйн нэгжүүд биржийн бус зах зээлээр дамжуулан өрийн хэрэгслийг мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох замаар татан төвлөрүүлэх хандлага нэмэгдсэн. Мөн хөрөнгийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан арилжааны шинжтэй баталгаат үнэт цаас, хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг олон нийтэд санал болгож, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийн үзүүлэлтүүд: Хөгжиж буй болон хөгжингүй зах зээлтэй орнуудын зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, индекс, бүртгэлтэй хувьцаат компанийн тоо зэрэг үзүүлэлтээр тооцдог бөгөөд өнөөгийн байдлаар хөрөнгийн зах зээлд "Монголын хөрөнгийн биржи" ХК, "Улаанбаатар үнэт цаасны биржи" ХК зэрэг 2 арилжаа эрхлэх байгууллага үйл ажиллагаа явуулж буй хэдий ч хувийн өмчит "Улаанбаатар үнэт цаасны биржи" ХК-д 1 хувьцаат компанийн хувьцаа арилжаалагдаж, арилжааны идэвх сул байгаа тул "Монголын хөрөнгийн биржи" ХК-ийн үзүүлэлтээр зах зээлийн хөгжлийн үзүүлэлтийг төлөөлүүлэн авч үзэж байна. Зах зээлийн үнэлгээний үзүүлэлтүүдийг графикаар үзүүлбэл:

ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

График-24



Эх сурвалж: ҮСХ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 4.7 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.16 хувиар буурсан бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 11.13 хувийг эзэлж байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 90 гаруй хувийг ТОП-20 индексийн сагсанд бүртгэлтэй хувьцаат компанийн үзүүлэлт бүрдүүлдэг бөгөөд зах зээлийн үнэлгээний өсөлтөд зах зээлд арилжаалагдаж буй хувьцаат компаниуд болох "АПУ" ХК, "Таван толгой" ХК, "МИК Холдинг" ХК, Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Эрдэнэ ресурс" ХК-ийн давхар бүртгэлтэй хувьцааг дотоодын биржид бүртгэсэнтэй холбоотойгоор зах зээлийн үнэлгээний хэмжээ нэмэгдсэн байна.

Хөрвөх чадварын хувьд Дэлхийн банкнаас гаргасан үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын багтдаг ангилал буюу дунджаас бага орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 53.6 хувь байгаа бол өндөр орлоготой орнуудын хөрвөх чадварын үзүүлэлт 2020 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувь байна. Монгол Улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар энэ оны 3 дугаар

улирлын байдлаар 2.69 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.06 пунктээр буурсан байна. Хөрвөх чадварыг тооцохдоо тайлант хугацаанд хийгдсэн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны дүнг нийт зах зээлийн үнэлгээнд харьцуулж тооцдог бөгөөд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа 57.18 тэрбум төгрөгөөр буурснаас гадна зах зээлийн үнэлгээний өсөлт өндөр байсан тул буурсан үзүүлэлттэй байна.

Түүнчлэн, хөрвөх чадварын үзүүлэлт олон улсын дундаж үзүүлэлттэй харьцуулахад маш бага түвшинд байгаа нь голчлон хувьцааны төвлөрөлтэй хамааралтай байна.

Хөрвөх чадвар /хувиар/

График-25



Зах зээлийн үнэлгээний 2006 оноос хойших 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх үзүүлэлтээс үзэхэд эдийн засгийн өсөлттэй шууд хамааралтай буюу мөчлөг дагасан шинжтэй, эдийн засгийн өсөлттэй жилүүдэд биржид арилжаалагддаг хувьцаат компаниудын хувьцааны ханш өсөж, шинээр болон нэмж үнэт цаас гаргагч компаниудын тоо нэмэгдэж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгддэг.

"Монголын хөрөнгийн бирж" ХК-д ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 36,033.30 нэгж, доод үзүүлэлт 32,836.01 нэгж, дундаж үзүүлэлт 34,568.58 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,913.00 нэгжээр буюу 20.76 хувиар буурч, 34,024.26 нэгж болсон байна. Үүнд хөрөнгийн захад бүртгэлтэй "АПУ", "Ард санхүүгийн нэгдэл", "Говь" зэрэг ТОП-20 индексийг бүрдүүлэгч дийлэнх компаниудын хувьцааны үнэ оны эхнээс буурч байгаатай холбоотой юм.

"Монголын хөрөнгийн бирж" ХК-аас 2018 онд үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хамаарах MSE-A болон MSE-B индексийг тооцон гаргадаг болсон. MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 13,654.82 нэгж, доод үзүүлэлт 12,098.54 нэгж, дундаж үзүүлэлт 12,800.31 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,800.31 нэгжээр буюу 13.41 хувиар өсөж 12,098.54 нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,315.82 нэгж, доод үзүүлэлт 11,397.98 нэгж, дундаж үзүүлэлт 11,918.03 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 298.35 нэгжээр буюу 2.43 хувиар буурч 11,972.15 нэгж болсон байна.

Хүснэгт-20

Индекс	2021.09.30	2022.09.30	Өөрчлөлт
ТОП 20	42,937.26	34,024.26	-20.76%

ТОП-20 индексийн сагсыг 54.9 хувийг аж үйлдвэрлэлийн үнэт цаас гаргагч, 20.1 хувийг банк санхүүгийн салбар, 18.3 хувийг уул уурхай, 3.5 хувийг худалдаа, 3.2 хувийг харилцаа холбооны компани бүрдүүлж байгаа бөгөөд 2018 оноос хойших хугацаанд санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч компаниуд болох Мандал даатгал, Ард даатгал, Бодь даатгал, Монгол даатгал ХК, Лэндмн ББСБ, Ард кредит ББСБ, Инвескор ББСБ ХК зэрэг компаниуд үнэт цаасаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компанийн хэлбэрт шилжиж, хувьцаа нь зах зээлд идэвхтэй арилжаалагдаж байгаа нь ТОП индексийг бүрдүүлэхэд томоохон нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант улиралд нийт 150.4 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.17 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд хувьцааны хоёрдогч зах зээлд нийт 128.95 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.72 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График-26



2022 оны 3 дугаар улиралд нийт 61 удаагийн үнэт цаасны арилжаа явагдаж, хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 111 ХК-ийн 152.8 сая ширхэг хувьцааг 36.72 тэрбум төгрөгөөр, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 117.25 мянган ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 11.72 тэрбум төгрөгөөр, Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.6 сая ширхэг нэгж эрхийг 0.8 тэрбум төгрөгөөр, Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 23.4 мянган ширхэг бондыг 3.21 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 52.47 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 2.5 сая ширхэг үнэт цаасыг 0.86 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт арилжааны үнийн дүнгийн 69.98 хувь буюу 36.72 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа, 22.34 хувь буюу 11.72 тэрбум төгрөгийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа, 1.54 хувь буюу 0.8 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа, 6.13 хувь буюу 3.2 тэрбум төгрөгийг компанийн бондын арилжаа тус тус эзэлж байна.

Мөн үнэт цаасны арилжааны график мэдээнээс ЗГҮЦ арилжаа эрхлэх байгууллагаар дамжин арилжаалагдах нөхцөлд нийт арилжаанд дийлэнх хувийг дангаараа бүрдүүлдэг бол ЗГҮЦ-ын арилжаа явагдаагүй нөхцөлд хувьцааны арилжаа идэвхжих хандлага ажиглагддаг. Харин 2020 оноос төрийн зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсний үр дүнд биржийн болон биржийн бус зах зээл өрийн хэрэгсэл гаргагч компаниудын тоо эрс нэмэгдэж, компанийн бондын зах зээл үсрэнгүй хөгжих нөхцөл бүрдсэн.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Мөн цаашид хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний чиг хандлагаас үзэхэд дан хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, ЗГҮЦ зэрэг уламжлалт бүтээгдэхүүнээс гадна арилжааны шинжтэй хөрөнгөөр баталгаажсан баталгаат, барьцаат үнэт цаас, хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, биржээр арилжаалагдсан сангууд зах зээлд бүрэлдэн бий болох нөхцөл бүрдээд байна.

Хэдийгээр УИХ-аас 2002 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг баталж, олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргах эрх зүйн зохицуулалтын орчин бүрдсэн боловч 2005 онд "Монгол шилтгээн" ХК хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргаснаар дотоодын хөрөнгийн зах зээлд аж ахуй нэгжүүд банкны зээлээс гадна хөрөнгийн зах зээлд үнэт цаас санал болгон гаргах замаар хөрөнгө оруулалт татах боломж бүрдсэн.

Олон нийтэд шинээр болон нэмж хувьцаа гаргах ажиллагаа 2007-2008 онуудад эрс идэвхэжсэн боловч 2008 онд тохиолдсон дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралт байдал, арилжааны нэр бүхий 2 банк дампуурсантай холбоотойгоор 2017 оныг хүртэлх хугацаанд хангалттай байсан боловч 2017 оноос аж ахуйн нэгжүүд хувьцаа болон өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон гаргах замаар санхүүжилт татах төвлөрүүлэх, олон нийтийн хяналттай хувьцаат компани болох сонирхол эрс нэмэгдсэн. 2005-2022 оны 3 дугаар улирлын байдлаар 29 компани шинээр хувьцааг олон нийтэд санал болгох замаар 139.8 тэрбум, 16 компани нэмж хувьцаа гаргах замаар 39.0 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн байна.

Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан компанийн тоо

График-27



Эх сурвалж: СЗХ

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын талаар: Хөрөнгийн зах зээлд тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн этгээдийн үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар дараах байдалтай байна.

СЗХ
БҮРТГЭВ

Хүснэгт-21

№	Зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч	Оролцогчдын тоо
1	Үнэт цаасны арилжаа эрхлэх	2
2	Үнэт цаасны тооцооны	2
3	Үнэт цаасны төлбөр төвлөрсөн хадгаламжийн	1
4	Хөрөнгө оруулалтын менежментийн	36
5	Үнэт цаасны компани	51
6	Кастодиан банк	3
7	Хамтын хөрөнгө оруулалтын сан	4
8	Хөрөнгө итгэмжлэн удирдах	7
9	Хөдөө аж ахуйн түүхий эдийн арилжаа эрхлэх	1
10	Хөдөө аж ахуйн түүхий эдийн брокер	10
11	Аудитын компани	45
12	Үнэлгээний компани	24
13	Хуулийн компани	35
14	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч	40
15	Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэгч	1

Эх сурвалж: СЗХ

Үнэт цаасны зах зээлд оролцогчдыг төвлөрсөн хадгаламжид бүртгэлтэй дансны нийт тоогоор авч үзэж байгаа бөгөөд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 3,898 данс нээгдэж өссөн дүнгээр нийт 2,439,127 данс нээгдсэн байна. Мөн хугацаанд 15,727 холболтын данс нээгдэж нийт 499,223 холболтын данс нээгджээ.

Тайлант хугацаанд нийт арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 52.88 хувь, дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 43.73 хувьд, гадаадын иргэний хийсэн арилжаа 2.18 хувь, гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 1.20 хувийг тус тус эзэлж байна.

Хөрөнгө оруулагчдын бүтэц /арилжаанд эзлэх хувиар/

График-28



СЗХ
ГАЗАРЧИМ
БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн мэдээлэл: 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Монголын хөрөнгийн бирж- д бүртгэлтэй хувьцаат компани 180, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хувьцаат компани 314, Улаанбаатар бирж-д бүртгэлтэй хувьцаат компани 1, "Монголын хөрөнгийн бирж" ХК-д 1809 хувьцаат компани бүртгэлтэй байна. Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн зөрүү үүсгэсэн гол хүчин зүйлс өмч хувьчлалын эрхийн бичгээр хувьчлагдсан хувьцаат компанийн үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагаа бүртгэлээс хассан хэдий ч Санхүүгийн зохицуулах хорооноос жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хүрээнд ногдол хувийн хөрөнгийг тэдгээрийн дансанд байршуулах хүртэлх хугацаанд нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн хэвээр байна.

2021-2022 оны хооронд Монголбанкнаас мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж, бодлогын хүү доогуур байсан нь хөрөнгө оруулагчдын банкны хадгаламжаас бусад хөрөнгө оруулалтын боломжуудыг хайх сонирхлыг нэмэгдүүлж байгаа бөгөөд компанийн бонд болон хувьцаа нь хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж, аж ахуйн нэгжүүд хувьцаа, өрийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээлээр дамжуулан санал болгон гаргаж, санхүүжилт татах боломж бүрдсэн.

УИХ-аас 2021 онд батлсан Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт болон 2022 онд батлсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-үүдэд системийн ач холбогдолтой арилжааны банкнууд олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж, нээлттэй хувьцаат компани болох төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хувьцааны тодорхой хувийг олон нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн нь хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх боломж бүрдэхээр харагдаж байна.

2.1.2 Монгол Улсын хүнсний салбарын болон даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдал

Монгол улсын хүнсний салбарын өнөөгийн нөхцөл байдал: Монгол улсын хэмжээнд 2017 онд жилд 661.0 тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүн, 599 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 924 тэрбум төгрөгийн хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг импортоор хангаж байсан бол 2021 оны жилийн дүнгээр 1,293 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 780 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 1,730 тэрбум төгрөгийн хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг импортоор хангажээ. 2022 оны эхний 6 сарын байдлаар 621 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 463 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 366 сая ам долларын хүнсний бэлэн бүтээгдэхүүн импортолсон байна.

Өнгөрсөн таван жилийн дунджаас харахад, Монгол улсын хүнсний бэлэн бүтээгдэхүүний хангамжийн 40 гаруй хувийг дотооддоо үйлдвэрлэж, үлдсэн хэсгийг импортоор ханган нийлүүлдэг бөгөөд Монголын улсын сүүлийн таван жилийн хугацааны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн жилийн нийлмэл өсөлт 18.3%, үндааны үйлдвэрлэлийн жилийн нийлмэл өсөлт 7% байсан бол импортоор авсан хүнсний бэлэн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн ЖНӨ нь 17% байсан. Импортын бүтээгдэхүүний ЖНӨ-ийн 6.4% нь төгрөгийн ханшийн уналтаас үлдсэн 10 орчим хувь нь эрэлтээс хамааралтай өсөлт гэж үзэж болохоор байна.

Хүснэгт-22

Тэр бум төгрөг	2017	2018	2019	2020	2021
Дотоодын үйлдвэрлэл	661	856	941	1,018	1,293
Жилийн өөрчлөлт(%)		29.4%	9.9%	8.3%	27.0%
Импорт	924	1,077	1,183	1,222	1,730
Жилийн өөрчлөлт(%)		16.6%	9.8%	3.3%	41.6%
Нийт хүнсний хангамж	1,585	1,933	2,124	2,240	3,024
Жилийн өөрчлөлт(%)		22.0%	9.9%	5.5%	35.0%
Дотоодын үйлдвэрлэлийн хувийн жин	41.7%	44.3%	44.3%	45.5%	42.8%
Импортын хувийн жин	58.3%	55.7%	55.7%	54.5%	57.2%

Эх сурвалж: ҮСХ-ны өгөгдөл

Монгол улсын хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн 30 орчим хувийг мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл, 25 орчим хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, 20 орчим хувийг үр тариа, гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байгаа бол жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэл дөнгөж 2-3 хувийг эзэлдэг байна.

Хүснэгт-23

ЖИЛ БҮРИЙН ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИНГЭЭР	2017	2018	2019	2020	2021	2022 I-VI
Мах боловсруулах, консервлох	25.7%	32.3%	30.0%	26.5%	27.6%	20.1%
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	1.2%	1.8%	2.4%	3.1%	2.1%	3.5%
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16.3%	20.2%	22.5%	21.7%	24.7%	26.8%
Үр тарианы гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	30.7%	25.3%	22.0%	24.2%	20.7%	18.0%
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	26.1%	20.4%	23.2%	24.5%	24.9%	31.5%
Дотоодын үйлдвэрлэлийн дүн	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Эх сурвалж: ҮСХ-ны өгөгдөл

Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэл нийт дотоодын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 3 орчим хувийг эзэлж буй ч 2017 онд 8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2020 оны цар тахлын хорионы жилд 31 тэрбум төгрөгт хүртэл өсөж, 2021 онд 27 тэрбум төгрөгт хүржээ. Харин 2022 оны эхний 6 сарын байдлаар 22 тэрбум төгрөгт хүрснээс харахад 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр өндөр өсөлтийг үзүүлэх магадлалтай байна. Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэлийн дэд секторын сүүлийн 5 жилийн хугацааны жилийн нийлмэл өсөлт нь 37 хувь байгаа нь энэ сектор хамгийн өндөр өсөлттэй болохыг илтгэж байна.

Даршилсан ногооны салбарын нөхцөл байдал: Даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарын голлох бүтээгдэхүүн нь өргөст хэмх, салат, компот бөгөөд 2021 оны байдлаар тус салбарын 56 хувийг импортын бараа бүтээгдэхүүн дангаар бүрдүүлж байна. Тус салбарын 2017 оноос хойших импорт болон дотоодын зах зээлийн хэмжээг графикаар үзүүлбэл:

График-29



2021 оны байдлаар импортоор 28 тэрбум төгрөгийн өргөст хэмх, 10.7 тэрбум төгрөгийн салат, 24.6 тэрбум төгрөгийн компот импортоор орж ирсэн нь нийт салбарын 56 хувийг импортын бараа, бүтээгдэхүүн эзэлж байна. Даршилсан ногооны хамгийн өндөр борлуулалттай үечлэл нь баяр ёслол болох Цагаан сар болдог бөгөөд өмнөх оны 3,4-р улиралд импортоор орж ирсэн бүтээгдэхүүнүүд энэ оны нэгдүгээр улиралд борлуулагдах хандлага ажиглагддаг. Даршилсан ногооны салбарын импортын бүтээгдэхүүн, үйлчилгээнээс үзэхэд өргөст хэмхийн хувьд Польш улсад үйлдвэрлэсэн Урбанек брэндийн өргөст хэмх дангаараа нийт импортын 33 хувийг бүрдүүлдэг бол импортын компотны 47 хувийг Ковар брэндийн компот дангаараа эзэлж байна.

2.1.3 Төрөөс хүнсний салбарт баримталж буй бодлого, экспортыг дэмжих, импортыг орлох салбарыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөр

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг баталсан. Уг тогтоолоор "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг өрнүүлэх хүрээнд авах арга хэмжээний хүрээнд 5 багц чиглэл, арга хэмжээг батлалсан. Үүнд:

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:

a. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 онд улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох;

b. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулах;

c. Тарифын зохицуулалт хийх замаар хүнсний эд, бүтээгдэхүүний импортын хамаарлыг бууруулах, экспортын чиг хамаарлыг бууруулах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

d. Хүүхдийн хоол хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох;

e. Хүнсний аюулгүй байдлын статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах, хүнсний чиглэлийн бүх стандартад дүн шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай стандарт, техникийн зохицуулалт, хүнсний сүлжээний үе шат бүрд зохистой дадлын зөвлөмж, зааврыг шинээр батлах;

f. Мал, амьтны гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ур мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам боловсруулж, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх;

g. Хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон журмыг боловсруулах;

h. Хүнсний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох, пестицид, малын эм, хоруу чанар өндөртэй нян, хүнд металлын үлдэгдлийг хянах, хяналтын төлөвлөгөөг батлах;

i. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, нөөцийн нэгдсэн тогтолцоо, түүний удирдлагын системийг бий болгож, логистик нийлүүлэлтийн төвүүдийг үе шаттайгаар байгуулах;

j. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын татаас, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгож, шаардлагатай урамшууллын хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусгах.

2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр: "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх, бусад хөтөлбөрүүдтэй уялдуулах, хүнсний эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн байгуулах, холбогдох итгэмжлэгдсэн байгууллагын тоог нэмэгдүүлэх, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх;

a. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтэц, эрчим хүч, уур, дулааны эх үүсвэр, шатахуунаар тогтвортой хангах;

b. Монгол орны байгаль, газар зүй, цаг уурын онцлогтой уялдсан уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, хэрэглээнд нэвтрүүлэх, хүнс бэлтгэх уламжлалт мэдлэгт суурилсан, инновац шингэсэн бүтээгдэхүүн бий болгох тогтолцоог бүрдүүлэх;

c. Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах хүрээнд мал аж ахуй, газар тариалангийн салбарт аж ахуйн эрхлэхээр нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэн, ААН-д татварын болон бусад дэмжлэг үзүүлэх;

d. Монгол Улсад үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах боломжийг бүрдүүлж, экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

e. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт ШУ-ны ололтыг нэвтрүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний хүрээлэнгээр захиалгат судалгаа, туршилтын ажил хийлгэх хөрөнгийг нэмэгдүүлэх.

3. Газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр: тариалангийн зориулалттай газар ашиглалтыг сайжруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ургамлын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалт, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх, үр тариа, төмс хүсний ногоо, жимс, жимсгэнэ болон ашигт таримлын үр үйлдвэрлэлийн тогтолцоог бүрдүүлэх;

a. Монгол Улсад газар тариалан эрхлэх систем, тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйг хөгжүүлж, санхүүгийн дэмжлэг олгох;

b. Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг 270 гектор хүртэл нэмэгдүүлэх хөгжүүлж, хүн амыг жилийн туршид шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, дулааны хангамж, дэд бүтэц бүхий бүс нутгууд 50 гектор өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулах;

c. Дотооддоо бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүх төрлийн будаа, чихрийн манжин, бусад ашигт тариамлын тариалалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санхүүжилтийг бүрдүүлэх, үр тарианы элеваторын багтаамжийг нэмэгдүүлэх, усалгааны дэвшилтэт технологи нэвтрүүлэх, услалтын системийг шинээр барих, сэргээх засварлах, үйлдвэр, фермер, нөхөрлөл, хоршоо, аж ахуйн үйл ажиллагааг дэмжсэн кластерыг бий болгоход чиглэсэн хөдөө аж ахуйн агро парк байгуулах;

d. Жил бүрийн намрын ургацаас стратегийн нөөц бүрдүүлэх зорилгоор 100.0 мянгаас доошгүй тонн хүнсний улаан буудайг худалдан авах нөөц бүрдүүлэх.

4. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр: Бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, мал, малын галалтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлэх, хот суурин газрын ойролцоо, газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, зэрэг.

5. Хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн газар

- Мал аж ахуй, газар тариалангаас нийлүүлсэн хүнсний түүхий эдийг дотооддоо боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, дотоодын зах зээлд борлуулсан чанар, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийн шаардлага хангасан бүтээгдэхүүнд олгож байгаа урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;
- Хүүхдийн хоол, сүү, ногоо, жимс, жимсгэнийн тэжээлийн үйлдвэрийг шинээр байгуулах, өргөтгөх, үндсэн түүхий эдийг дотоодоос бэлтгэн нийлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах;
- Хуурай сүү, хүнсний давс, хүнсний тос, төмс, төрөл бүрийн будаа, элсэн чихрийн боловсруулах үйлдвэрийг шинээр байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хүнсний зориулалтын тусгай тээврийн хэрэгслээр тоноглогдсон тээврийн паркийг шинээр бий болгох, дотоодын болон экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

СЗХ БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 13 БҮРТГЭВ-03

- Хүнсний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар бүтээгдэхүүний амт чанар, сав, баглаа боодлыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэн экспортын зориулалтын брэндийг хөгжүүлэх, үйлдвэрийн үйл ажиллагааг нь тогтвортой явуулахад эргэлтийн хөрөнгөөр дэмжих;
- Хүнсний нэмэлт, биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүн, зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг дэмжих, улсын хэмжээнд лабораторийн шинжилгээний аргачлалыг шинэчлэх замаар хүнсний аюулгүйн үзүүлэлтийг бүрэн тодорхойлох, экспорт, импортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд ачилтын өмнөх лабораторийн шинжилгээ, хяналт шалгалтыг хийх тогтолцоог бүрдүүлэх, хилийн болон улсын итгэмжлэгдсэн лабораторийг чадавхжуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах
- Үнэт цаас гаргагчийн зүгээс дотоодын жимс жимсгэнэ, хүнсний ногоогоор даршилсан бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдлын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу үйлдвэрлэж, экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох, зах зээлд хэмжээг нэмэгдүүлэх стратегийг баримтлан ажилладаг.

Тиймээс дээрх бодлогын баримт бичгийн хүрээнд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь дэмжлэг үзүүлэх, төрийн бодлогод чиглэлд нийцэж, дэмжлэг олгох салбарын шаардлага нөхцлийг бүрэн хангаж байгаа харагдаж байна. Тиймээс хүнсний даршилсан ногооны салбарт анхны нээлттэй хувьцаат компани болсноор төрөөс хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цаашид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг нэвтрүүлэх, газрын шимийг үйл ажиллагааны ашгаар хувьцаа эзэмшигч нарт хүртээх боломжтой юм.

2.1.4 Салбарын хууль эрх зүйн орчин, зохицуулалт, стандарт

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, хүнсний чиглэлийн үйл ажиллагаа, салбарын хууль, тогтоомжоор зохицуулагддаг. Холбогдох хууль тогтоомжийн мөрдөн ажиллаж байна.

2.1.5 Салбар дахь Ковид-19 цар тахлын сөрөг нөлөө

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимаас БНХАУ-д гарсан шинэ корона вирусээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний бизнест үзүүлж байгаа үр нөлөө, бизнес эрхлэгчдэд шаардлагатай дэмжлэгийг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг 2020 оны 3 сарын 3-4 өдрүүдэд 1100 аж ахуйн нэгжийг хамруулан явуулсан. Судалгаанд оролцогсдын 67 хувь нь Улаанбаатар хот, 33 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ба үйл ажиллагааны авч үзвэл 25 хувь нь худалдаа, 22 хувь нь үйлчилгээ, 11 хувь нь хүнсний үйлдвэрлэлийн салбар байна.

Нийт судалгаанд оролцсон ААН-үүдийн 89 хувь нь жилийн 5 тэрбумаас жилийн орлоготой , 92 хувь нь 199 хүртэлх ажиллагсадтай, 48 хувь нь 10- аас дээш жил, 24 хувь нь 5-10 жил үйл ажиллагаагаа явуулж байна. Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ 89.5 хувь нь маш их ба дунд түвшинд нөлөөлсөн байгаа бол дөнгөж 2.2 хувь нь нөлөөлөөгүй байна. Бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодруулан асуухад 57.7 хувь нь бараа үйлчилгээний эрэлт буурсан, 40.1 хувь нь тээвэр ложистик доголдсоноос бараа үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон нь гэж хариулжээ. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан бизнест үүсээд буй хүндрэлийг нээлттэй асуулгаар асуухад зээлийн эргэн төлөлт, НДШ-ын төлбөр, түрээсийн төлбөр гэсэн асуудлуудыг хамгийн их хүндрэл учруулж байна гэж нэрлэсэн байна.

COVID-19 вирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээ бизнест нөлөөлсөн тухай тодруулан асуухад судалгаанд оролцогсдын 57.4 хувь нь маш их нөлөөлсөн, 32 хувь нь дунд зэрэг нөлөөлсөн гэж хариулжээ. Харин 8.3 хувь нь одоо хэлэхэд эрт байна гэж үзсэн бол дөнгөж 2 хувь нь ямар нэг нөлөөгүй байна гэж хариулжээ.

Энэ үзүүлэлтийг салбараар ангилан харвал боловсрол, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, эрүүл мэнд, үйлчилгээ, барилгын салбарын бизнес эрхлэгчдэд хамгийн их нөлөөтэй ба дунджаар 96 хувь нь үйл ажиллагаанд дунд ба маш их хэмжээгээр нөлөөлсөн гэж хариулсан байна. Харин тээвэр, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдийн бизнест дунджаар 69 хувь нь нөлөөлсөн гэж хариулжээ. Гэвч нийт дүнгээр нь харвал бүх салбарын бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд 65 хувиас дээш дүнгээр нөлөө үзүүлжээ.

Ямар нөлөө үзүүлсэн талаар тодруулан асуухад судалгаанд оролцсон бизнес эрхлэгчдийн 57.7 хувь нь бараа үйлчилгээний эрэлт буурсан, 40 хувь нь тээвэр ложистик доголдсоноос бараа үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон нөлөөлөл хамгийн их байна гэж хариулжээ. Мөн 14.8 хувь нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тодорхойгүй байдал үүссэн, 14.5 хувь хувь нь бэлэн мөнгөний хомсдолд орсон зэрэг санхүүжилттэй холбогдох нөлөөтэй байгааг дурджээ. Бизнесийн салбараар ангилан харвал салбарын ялгаагүйгээр бараа үйлчилгээний эрэлт буурсан, тээвэр, логистик доголдсоноос бараа, үйлчилгээг хугацаанд нь нийлүүлж чадахгүй болсон зэрэг нь хамгийн их нөлөөтэй байна гэж үзсэн байна. Мөн уул уурхайн салбарын хувьд тээвэр, логистик хамгийн их нөлөөг үзүүлж байгаа бол боловсролын салбарт ажилтнуудыг түр болон бүр мөсөн чөлөөлсөн нь үйл ажиллагаанд ихээр нөлөөлжээ. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа нь хүнсний салбарт үйл ажиллагаа явуулагч компанийн хувьд даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарт нэн шаардлагатай бараа түүхий эд, сав баглаа боодлыг татан авахад ковидаас тээвэр, логистикийн доголдсоноос түүхий эдийн татан авахад бэрхшээлтэй байдал ихээхэн нөлөөлж байна. Тиймээс бараа материалын татан авалтыг нэмэгдүүлж 3-6 нөөц бүрдүүлж үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

2.2. Үнэт цаас гаргагчийн нөхцөл байдлын шинжилгээ:

2.2.1 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь хэмжээ болон өрсөлдөөний орчны шинжилгээ

Даршилсан ногоон салбарын хувьд улсын хэмжээнд 2021 оны байдлаар 56 хувийг импортын бараа бүтээгдэхүүн, 25 хувийг "Газар шим үйлдвэр" ХХК бусад аж ахуйн нэгжүүд 19 хувийг тус тус эзэлж байна. Үнэт цаас гаргагчаас өнгөрсөн хугацаанд компанийн өрсөлдөх чадварыг бүх талаар бэхжүүлж, салбарын зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг тухай авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Чанарын удирдлагын тогтолцоог илүү сайжруулж, үр ашиг бүтээмжийг нэмэгдүүлэх /компанийн чанарын удирдлагын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг хангахад шаардлагатай баримтжуулсан мэдээллийн жагсаалтыг нэгдсэн байдлаар тодорхойлж, баримт бичгийн тохиромжтой байдалд дүн шинжилгээ хийж шинэчилж, хянах, хянах тогтолцоог бүрэн бий болгох, сайжруулах, хяналтын үйл ажиллагааг төлөвшүүлэх, тасралтгүй сайжруулах/;
- Жилийн борлуулалтыг тогтмол өсгөх /Нөөшилсөн бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэх, худалдан борлуулах үйл ажиллагааны ХАБ-ын сүлжээний бүх шатанд хамаарах УНБХ, АХТ-ийг хэрэгжүүлж, төлөвшүүлж хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, артишок ундааны нэр төрлийг нэмэгдүүлэхэд нөлөөлөх туршилт, судалгаа хийх/;
- Санхүүгийн ашигт ажиллагааг сайжруулж, үргүй зардлыг бууруулах /Үйлдвэрлэлийн дамжлага дундын түүхий эд материалыг бүртгэлд хяналт тавьж дахин хувиргалтыг багасгах, ДҮ-ийн хорогдлыг бууруулах, ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж гүйцэтгэлийг сайжруулах, ажлын байрны эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх/
- Ажилтныг мэргэшүүлж, сургаж хөгжүүлэх /компанийн ажилтнуудад шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгож, чадавхжуулах, хүнсний аюулгүй байдлын багт шаардлагатай чадавхыг бүрдүүлэх, сургах, ажилтнуудын мэргэжлийн болон ерөнхий ур чадварыг сайжруулах, дотоодын сургагч багшаар чадавхжуулах/

Үнэт цаас гаргагчийн зүгээс өөрийн бизнесийн давуу сул тал, боломжийн талаар SWOT болон TOWS матрицын шинжилгээний жил болгон тогтмол хийдэг бөгөөд 2021 онд хийгдсэн үр дүнг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

SWOT шинжилгээ

Хүснэгт-24

		ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС			ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛС
		STRENGTHS (+)			WEAKNESSES (–)
1	BP	Бүтээгдэхүүний шинэ шугам нэвтрүүлсэн, Үйлдвэрийн шинэ байр, Оффисын шинэ байртай	1	BP	Зарим түүхий эдийг гадаадаас авдаг /шил, таг/ Гаднаас импортын түүхий эд авах үйл явц саатах
2		ISO стандартууд болон GMP стандарт үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн	2		Технологийн алдаа гарах, Хэрэглэгчийн гомдол ихсэх
3		Үндэсний үйлдвэрлэгч компаниудаас салбартаа анхдагч олон жилийн туршлагатай.	3		Үйлдвэрийн шугам эвдрэх
4	MS	Маркетингийн судалгаануудыг жил бүр тогтмол хийдэг	4	MS	Бүтээгдэхүүн тасалдах, нөөц дуусах
5		Өргөн цар хүрээг хамарсан хуваарилалтын сувагтай.	5		Нэрийн барааны дэлгүүр цөөн
6		Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг. Жилдээ 2-3 шинэ бүтээгдэхүүн гаргадаг.	6		Үнийн өсөлт
7	FE	Бүтээгдэхүүн тасрах магадлал импортын брэндүүдтэй харьцуулахад харьцангуй бага	7	FE	Түүхий эд их хэмжээгээр муудах
8		Удирдлагын шийдвэр гаргалт хурдан	8		Зээлтэй
9		Найдвартүй авлагын хэмжээ бага	9		Бүтээгдэхүүний өртөг өсөх
10	HR	Олон жил ажилласан туршлагатай ажиллагсад	10	HR	Ажилтнуудын ажлаас гаралт ихсэх /Үйлдвэр/
11		Цалин хөлс цагтаа буудаг	11		Ажилчдын ур чадварын зэргийг тогтоогоогүй
12		Салбартаа цалин өндөр	12		Байгууллагын соёл төлөвшиж байгаа

		ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС			ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛС
		OPPORTUNITIES (+)			THREATS (–)
1	BP	Хэрэглэгчид эх орны газар шороонд ургасан түүхий эдээр үйлдвэрлэсэн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүний хэрэглэх хандлагатай болохоос гадна дотоодын үйлдвэрлэгчдийг дэмждэг болсон.	1	BP	Цаг агаарын тааварлашгүй байдлаас болж өргөст хэмх болон бусад Монгол ногоонууд ургахгүй байх
2		Өрсөлдөгч импортын компаниудын бүтээгдэхүүн тасрах	2		Олон нийтийг хамарсан өвчин, Хөл хорио тогтоох, Тэг зогсолт хийх
3		Манай компаниас үр авч өргөст хэмх тариалах сонирхолтой хүмүүс нэмэгдэж байгаа	3		Зах зээлд шинэ үйлдвэрлэгч нэмэгдэх
4	MS	Баяр ёслолын үеэр бүтээгдэхүүнээ их хэмжээгээр борлуулах	4	MS	Нөөшилсөн бүтээгдэхүүний нэр хүнд унах
5		Даршилсан ногоо өдөр тутмын хэрэглээ болох хандлагатай болж байгаа	5		Орлуулах бүтээгдэхүүнүүд нэмэгдэх
6		Салбарын хувьд реклам сурталчилгаа явуулахад хуулийн хязгаарлалт байхгүй	6		Бүтээгдэхүүний чанараас хамаарч компанийн нэр хүнд унах
7	FE	Зээлийн хүү буурах	7	FE	Цар тахлын улмаас эдийн засаг хямрах
8		Эдийн засгийн нөхцөл байдал сайжрах	8		Инфляц өсөх
9		Хэрэглэгчдийн цалин хөлсний орлого өсөх	9		ДНБ-ний өсөлт
10	HR	Хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний тоо өсөх	10	HR	Хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчин хомсдох
11		Боловсролын түвшин нэмэгдэх	11		Зах зээл дээр мэргэшсэн ажилтны тоо бага
12		Үндэсний үйлдвэрт болон хүнсний салбарт ажиллах сонирхолтой хүмүүсийн тоо өсөх	12		Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлтүүд

TOWS МАТРЕЦ

Хүснэгт-25

SO- Боломжийг ашиглаж давуу талаа бэхжүүлэх стратеги	ST-Давуу талаараа аюулаас зайлсхийх стратеги
S1-O2 Баярын үеэр борлуулалт ихтэй үед шинэ бүтээгдэхүүний борлуулалтаа хийх, зах зээлд таниулах	S1-T3 Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг учир салбарт шинэ өрсөлдөгч орж ирсэн ч зах зээлээ алдахаас сэргийлж чадна.
S2-O1 Монголд ургуулсан түүхий эдээр үйлдвэрлэдэг салбартаа анхдагч компани гэдгээ улам таниулах	S3-T5Эх орны хөрсөнд ургасан түүхий эдээр бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг гэдгээ сайн таниулж чадвал орлуулах бүтээгдэхүүний аюулаа с сэргийлж чадна.
S1-O3 Өдөр тутам хэрэглэхэд тохиромжтой шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх	S6-T1 Маркетингийн судалгаануудыг тогтмол хийдэг учир бүтээгдэхүүний болон компанийн нэр хүнд унахаас сэргийлэх
S5-O5 Стандартууд нэвтрүүлсэн гэдгээ хэрэглэгчдэд реклам сурталчилгаагаараа таниулах	S8-T8 Онцгой байдлын үед оновчтой шийдвэрийг хурдан хугацаанд гаргах
S9-O4 Өрсөлдөгч компаниудын бүтээгдэхүүн тасарсан үед зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх	S-T
WO -Боломжоо ашиглан сул талаа багасгах стратеги	WT-Аюул болон сул талаа аль алиныг нь багасгах стратеги
W3-O1 Эх орны хөрс өнд ургасан түүхий эдээр шилэнд бүтээгдэхүүнээ савладаг, хэрэглэгчдэд эрүүл гэж таниулах	W1-T1 Олон түүхий эд нийлүүлдэг сувагтай болох
W5-O2 Баяр ёслолын өмнө түүхий эдээ сайн татаж бүтээгдэхүүнээ хангалттай үйлдвэрлэх	W2-T4 нөөшилсөн бүтээгдэхүүний давуу тал болон компанийн бүтээгдэхүүний давуу талуудыг хэрэглэгчдэд таниулах
W1-O6 Гадаадаас авдаг зарим түүхий эд ногоонуудаа Монголд тарьж ургуулах	W4-T2 Монголд ургадаг хүнсний ногоонуудаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх
W2-O7 Салбартаа нэр хүндтэй учир хэрэглэгчээс хуурамч гомдол ирэх нь бага	W6-T7 Ажилтнуудыг сург аж хөгжүүлэх, Гүйцэтгэлийг үнэлгээг сайжруулах
W-O	W8-T9 Түүхий эдийн хадгалалтад тавих хяналтыг сайжруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн өмнө шинжилгээг сайн хийх

Дээрх шинжилгээнүүдээс үзэхэд үнэт цаас гаргагч нь зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж, урт хугацаанд тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэхэд дараах стратегийн арга хэмжээг богино болон дунд хугацаанд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн. Үүнд:

- Өрсөлдөгч компаниудын бүтээгдэхүүн тасарсан үед зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх;
- Гадаадаас авдаг зарим түүхий эд ногоонуудаа Монголд тарьж ургуулах;
- Түүхий эд нөөцлөх зоорины багтаамжийг нэмэгдүүлэх
- Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг учир салбарт шинэ өрсөлдөгч орж ирсэн ч зах зээлээ алдахаас сэргийлэх;
- Монголд ургадаг хүнсний ногоонуудаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

Үнэт цаас гаргагчийн зүгээс гадаад орчноос үзүүлэх нөлөөллийг улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, технологийн орчны нөлөөлөлд тулгуурлан шинжилгээг хийсэн бөгөөд шинжилгээний үр дүнг графикаар үзүүлбэл.

График-30

Улс төрийн орчин



Эдийн засгийн орчин



Хүрээлэн буй орчин



Хууль эрх зүйн орчин



Нийгэн соёлын орчин



Технологийн орчин



Хүснэгт-26

Улс төрийн орчин			Эдийн засгийн орчин			Нийгэм соёлын орчин		
1	Татварын бодлого	0.24	1	Цалин хөлс, орлого	0.21	1	Хэрэглэгчийн хандлага	0.21
2	Төрийн бодлого	0.14	2	ДНБ-ний өсөлт	0.19	2	Хүн амын өсөлт	0.14
3	Төрийн зохицуулалт	0.14	3	Инфляци	0.14	3	Соёлын өөрчлөлт	0.10
4	Гадаад худалдаа	0.08	4	Хүүгийн түвшин	0.13	4	Шилжилт хөдөлгөөн	0.06
5	Хүний эрх	0.05	5	Мөнгөний бодлого	0.12	5	Боловсролын түвшин	0.50
Технологийн орчин			**Хууль эрхзүйн орчин**			**Хүрээлэн буй орчин**		
1	Инноваци	0.20	1	Хөдөлмөрийн тухай хууль	0.14	1	Байгалийн гамшиг	0.23
2	Дэд бүтэц	0.13	2	ХАБ болон эрүүл мэндийн хуулиуд	0.14	2	Цаг уурын өөрчлөлт	0.14
3	Автоматжуулалт	0.13	3	Бизнесийн хуулиуд	0.13	3	Хөдөө аж ахуй	0.14
4	Биотехнологи	0.12	4	Хэрэглэгчийг хамгаалах хуулиуд	0.12	4	Байгалийн баялаг	0.06
5	Хиймэл оюун ухаан	0.04	5	Авилгал хээл хахуул	0.04	5	Байгаль орчны тухай хууль	0.06

Улс төрийн орчноос татварын бодлого, хууль эрх зүйн орчин, эдийн засгийн орчноос цалин хөлс, орлого, нийгэм соёлын орчноос боловсролын түвшин, технологийн орчноос инновацын хүчин зүйлс хамгийн нөлөө үзүүлж байна.

Хүснэгт-27

	PESTEL шинжилгээ	Салбарын өөрчлөлт	Компани өөрчлөлт	Авах үйл ажиллагаа
УЛС ТӨРИЙН ОРЧИН				
1	Татварын бодлого	Үнийнөөрчлөлт	Үйлажиллагааны өөрчлөлт	Үйлажиллагаагаа тогтвортой явуулах
2	Гадаад худалдаа	Импортын барааны үнийн өөрчлөлтөөсболж үнэ өөрчлөгдөхДотоодын түүхий эд бэлтгэгчдийн эрэлт нэмэгдэх	Дотоодын түүхий эд бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтран ажиллах, тогтвортой харилцаа тогтоох	Экспортын зах зээлийг судлах. Экспортлолдог үл орнуудыг судлах, шинэ гарц хайх
3	Төрийн бодлого	Төрөөс манай салбарыг дэмжвэл салбар хөгжинө	Компанийн үйл ажиллагаа томрох эрэлт ихсэх	Үйлдвэрлэлээнэмэгдүүлэх зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэхийн төлөө ажиллах
ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН				
1	ДНБ-ний өсөлт	Салбарын зах зээл тэлэх	Борлуулалт өсөх	Үйлдвэрийн хэмжээг нэмэгдүүлэх, зэх зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх
2	Цалин хөлс, орлого	Хэрэглэгчдийн орлого нэмэгдэж зах зээл тэлэх	Борлуулалт өсөх	Үйлдвэрийн хэмжээг нэмэгдүүлэх, зэх зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх
3	Инфляци	Зах зээлдих их хэмжээний мөнгө эргэлдэнэ	Үйлдвэрлэхбараа бүтээгдэхүүний үнэ өсөлт	Үйлажиллагаагаа тогтвортой явуулж, үнийг хэт хөөрөгдүүлэхээс зайлсхийх.
НИЙГЭМ СОЁЛЫН ОРЧИН				
1	Хэрэглэгчийн хандлага	Ямар нэгэн генийн өөрчлөлтгүйөрүүл, аюулгүй хүнсний хэрэглээ өсөжбайна.	Хэрэглэгдийн хэв маягт тохирсон бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Хэрэглэгчдийн амьдралын хэв маяг, зуршил, чиг хандлагыг сайн судлалж түүнд тохирсон бүтээгдэхүүн үйлчилгээгээнэмэгдүүлэх.
2	Хүн амын өсөлтийн	Зах зээлийн багтаамж нэмэгдэнэ	Хэрэглэгчийн тоо өснө	Үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх
3	Соёлын өөрчлөлт	Бүтээгдэхүүний хэрэглээ өөрчлөгдөх	Борлуулалт өсөх, эсвэл буурах	Хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа хийх, хэрэглэгчийн соёлын өөрчлөлтөнд тохирсон бүтээгдэхүүн санал болгох

Хүснэгт-28

	PESTEL шинжилгээ	Салбарын өөрчлөлт	Компанийн өөрчлөлт	Авах үйл ажиллагаа
		ТЕХНОЛОГИЙН ОРЧИН		
1	Инноваци	Шинээр өрсөлдөгчид бий болох. Техник технологийн өрсөлдөөн.	Зах зээлээ тэлэх, шинэ зах зээлд нэвтрэх, өрсөлдөгчдөөс ялгарах илүү давуу тал олж авах	Шинэ техник технологийн тусламжтай чанартай бүтээгдэхүүнийг олон тоогоор үйлдвэрлэх, бүтээгдэхүү ний нэр төрлөө нэмэгдүүлэх
2	Дэд бүтэц	Салбарын өсөлт	Компанийн үйл ажиллагаа саадгүй тогтвортой явах	Үйл ажилллагаа хэвийн саадгүй явуулах
3	Автоматжуулалт	Шинэ технологи, чадварлаг ажилчидтай компаниуд тэргүүлэгч болох, ялгарах.	Ажилчид албан хаагчдийн хаагчдын орон тоо багасах.	Бүтээмж өндөр, найдвартай тоног төхөөрөмжөөр хүчээ нэмэх. Зардалаа бууруулах.
		ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН		
1	Хэрэглэгчийг хамгаалах хуулиуд	Бүтээгдэхүүн үйлчилгээнд тавигдах шаардлага ихсэх	Бүтээгдэхүүний чанар сайжирна	Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх
2	Хөдөлмөрийн тухай хууль	Ажиллах хүч	Ажиллагсадад ажиллах таатай орчин бүрдэх	Хуульд нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах
3	Бизнесийн хуулиуд	Бизнес явуулах орчин таатай болох		Хуульд нийцүүлсэн үйл ажиллагаа явуулах
		ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН		
1	Хөдөө аж ахуй	Түүхий эдийн нийлүүлэлт сайжрах	Борлуулалт өсөх	Үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлэх, зах зээлээ тэлэх
2	Цаг уурын өөрчлөлт	Түүхий эдийн хомсдол	Дотоодын гадаадаас авдаг түүхий эдийн олдоц багасах, үнэ өсөх	Олон нийлүүлэгчтэ й болох
3	Байгалийн гамшиг	Дотоодын үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа доголдох	Түүхий эдийн хомсдолд орох	Илүү олон нийлүүлэгчтэй болох, гадаадаас түүхий эд авах

Үнэт цаас гаргагчийн зүгээс хэрэглэгч болон өрсөлдөгчийн судалгааг портерын 5 хүчин зүйлийн шинжилгээг ашигласан хийсэн бөгөөд шинжилгээний үр дүнг хүснэгтээр үзүүлбэл.

Өрсөлдөгч компанийн орлох бүтээгдэхүүний аюул заналыг үнэлэх

Хүснэгт-29

Үнэлгээний параметр	Параметрийн тооцоо		
	3	2	1
Орлох бүтээгдэхүүн "үнэ ба чанар"	Оршин тогтнодог бөгөөд зах зээлд эзлэх хувь өндөртэй	Оршин тогтнодог боловч зах зээлд эзлэх хувь бага	Оршин тогтнодоггүй
Тайлбар: (Ижил чанарыг хямд үнээр хангах чадвартай)	Оршин тогтнодог бөгөөд зах зээлд эзлэх хувь өндөртэй		
Нийт оноо	3 оноо		
1 оноо	Орлуулагч бүтээгдэхүүний аюулын бага түвшин		
2 оноо	Орлуулагч бүтээгдэхүүний аюулын дундаж түвшин		
3 оноо	Орлуулагч бүтээгдэхүүний аюулын өндөр түвшин		

II хүчний үзүүлэлт: Салбар доторх өрсөлдөөний түвшин

Хүснэгт-30

Үнэлгээний параметр	Тайлбар	Параметрийн тооцоо		
		3	2	1
Тоглогчдын тоо	Зах зээл дээр тоглогч олон байх тусам өрсөлдөөний түвшин өндөр болж, зах зээл дээр эзлэх хувиа алдах эрсдэлтэй байдаг	Зах зээл ханалтын өндөр түвшин	Зах зээлийн дундаж ханалт (3-10)	олон тоглогч байхгүй (1-3)
		3		
Зах зээлийн өсөлтийн хурд	Зах зээлийн өсөлтийн түвшин бага байх тусам зах зээлийг дахин хуваарилах эрсдэл байнга өндөр байдаг	Зах зээлийн зогсонги байдал эсвэл уналт	Удааширсан ч өсөж байгаа	**Өндөр**
			2	
Зах зээл дээрх бүтээгдэхүүний ялгавартай байдлын түвшин	Бүтээгдэхүүний ялгаа бага стандарт өндөр байх тусам хэрэглэгчид өөр компаниудын хооронд шилжих эрсдэл өндөр байдаг	Компаниуд нь стандартчилагдсан бараа борлуулдаг.	Зах зээл дээрх бүтээгдэхүүн нь гол шинж чанараараа стандартчилагдсан боловч нэмэлт ашиг тусаараа ялгаатай	Компаниудын бүтээгдэхүүн нь хоорондоо ихээхэн ялгаатай байдаг
			2	
Эцсийн оноо		9 оноо		
4 оноо		Салбар доторх өрсөлдөөний түвшин бага		
5-8 оноо		Салбар доторх өрсөлдөөний түвшин дунд		
9-12 оноо		Салбар доторх өрсөлдөөний түвшин өндөр		

Хүснэгт-31

Үнэлгээний параметр	3-р хүчний үзүүлэлт. Зах зээлд шинээр нэвтрэгсдэд учрах аюулыг үнэлэх. Параметрийн тооцоо			
	Тайлбар	3	2	1
Бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд эдийн засгийн хэмнэлт	Үйлдвэрлэлийн хэмжээ их байх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх т/э материал худалдан авах өртөг зардал бага байх нь үйлдвэрлэлийн тогтмол зардал багасаж нэгж бүтээгдэхүүний өртөгт нөлөөлдөг	Ач холбогдол байхгүй	Зах зээлийн цөөн хэдэн тоглогчдын хувьд л байдаг	Чухал ач холбогдолтой
				1
Өндөр түвшний мэдлэг, үнэнч байдал бүхий хүчтэй брэндүүд	Одоо байгаа брэндүүд салбартаа илүү хүчтэй мэдрэгдэх тусам шинэ тоглогчид ороход илүү төвөгтэй байдаг.	гол тоглогч байхгүй	2-3 том тоглогч зах зээлийн 50 орчим хувийг эзэмшдэг	2-3 том тоглогч зах зээлийн 80 гаруй хувийг эзэмшдэг
				1
Бүтээгдэхүүний ялгаа	Салбарын бараа, үйлчилгээний нэр төрөл хэдий чинээ их байх тусам шинэ тоглогчид зах зээлд гарч, сул орон зайг эзлэх нь илүү хэцүү байдаг.	бүтээгдэхүүний төрөлжилт бага	сиймхий байдаг	бүх боломжит сиймхийг тоглогчид эзэлсэн
				1
Энэ салбарт нэвтрэх хөрөнгө оруулалт, зардлын түвшин	Салбар руу орох анхны хөрөнгө оруулалтын түвшин өндөр байх тусам энэ салбарт шинэ тоглогчид орж ирэх нь илүү хэцүү байдаг.	бага (1-3 сарын хугацаанд ашгаа өгдөг)	дунд (6-12 сарын хугацаанд ашгаа өгдөг)	өндөр (жилээс дээш хугацаанд ажилласанд нь ашгаа өгдөг)
				1
Түгээх сувгуудад нэвтрэх	Зах зээл дээр зорилтот хэрэглэгчдэд хүрэхэд илүү хэцүү байх тусам тухайн салбарын сонирхол татахуйц байдал буурдаг.	түгээх сувгуудад нэвтрэхэд бүрэн нээлттэй байна	түгээлтийн сувгуудад нэвтрэхэд дунд зэргийн хөрөнгө оруулалт шаардагдана	борлуулалтын сувагт түгээх хандалт хязгаарлагдмал
		3		
Засгийн газрын бодлого	Засгийн газар үнийн түвшнийг зохицуулах замаар түүхий эд, бүтээгдэхүүн нэвтрэх эрхийг хязгаарлах, лиценз зөвшөөрөл олгох замаар үйлдвэрлэлд нэвтрэх боломжийг хязгаарлаж хаадаг.	төрөөс хязгаарлалт тогтоодоггүй	төр энэ салбарт хөндлөнгөөс оролцдог боловч бага түвшинд байдаг	төр энэ салбарыг бүрэн зохицуулж, хязгаар тогтоодог
		3		
Одоо байгаа тоглогчдын үнийг бууруулах хүсэл эрмэлзэл	Хэрэв тоглогчид зах зээлд эзлэх байр сууриа хадгалахын тулд үнээ бууруулж чадвал энэ нь шинэ тоглогчдод нэвтрэхэд ихээхэн саад болж байна.	тоглогчид үнийг бууруулахыг зорьдоггүй	том тоглогчид үнийг бууруулахыг зөвшөөрөхгүй	хямд үнийн саналыг нэвтрүүлэх анхны оролдлогоор одоо байгаа тоглогчид үнийг бууруулдаг
		3		
Аж үйлдвэрийн өсөлтийн хурд	Салбарын өсөлтийн хурд өндөр байх тусам шинэ тоглогчид зах зээлд орох хүсэл эрмэлзэлтэй байдаг	өндөр	удаашралттай	Зогсонги эсвэл бууралттай
			2	
Эцсийн оноо		14 оноо		
8 оноо		шинэ тоглогчдын орох аюулын түвшин бага		
9-16 оноо		шинэ тоглогчдын орох аюулын түвшин дунд зэрэг		
17-24 оноо		шинэ тоглогчдын нэвтрэх аюулын түвшин өндөр		

IV хүчний үзүүлэлт: Худалдан авагчдын зах зээл дээрх хэлэлцээр хийх чадварыг үнэлэх

Хүснэгт-32

Үнэлгээний параметр	Тайлбар	Параметрийн тооцоо		
		1	2	3
Худалдан авалтанд өндөр хувь эзэлдэг харилцагч худалдан авагчид	Хэрэв хэдхэн харилцагч худалдан авагчдад төвлөрч, томоохон хэмжээний худалдан авалт хийдэг бол компани тэдэнд байнга буулт хийхээс өөр аргагүй болно.	борлуулалтын 80 гаруй хувийг хэдхэн том харилцагч эзэлдэг	борлуулалтын 50 орчим хувийг дундаж харилцагчид эзэлдэг	борлуулалтын хэмжээ нь бүх харилцагч үйлчлүүлэгчдэд жигд тархсан байдаг
				3
Орлох бүтээгдэхүүн рүү шилжих хандлага	Компанийн бүтээгдэхүүний онцлог шинж чанар бага байх тусам худалдан авагч өөр сонголт олох магадлал өндөр байдаг.	компанийн бүтээгдэхүүн өвөрмөц биш, ижил төстэй шинж агуулдаг	компанийн бүтээгдэхүүн нь зарим талаараа ялгаатай бөгөөд хэрэглэгчдэд чухал үнэ цэнэ агуулсан онцлог шинж чанаруудтай байдаг	компанийн бүтээгдэхүүн нь бүрэн ялгардаг бөгөөд хэрэглэгчдэд чухал онцлог шинж чанаруудтай байдаг
			2	
Үнийн мэдрэмжтэй байдал	Үнийн мэдрэмж өндөр байх тусам худалдан авагч барааг өрсөлдөгчдөөс хямд үнээр худалдаж авах магадлал өндөр байдаг	худалдан авагч нь үргэлж хямд үнэтэй бүтээгдэхүүн рүү шилждэг	үнийн мэдэгдэхүйц зөрүүтэй тохиолдолд л худалдан авагч шилжинэ	Үнийн огт мэдрэмжгүй худалдан авагчид
			2	
Зах зээл дээрх бүтээгдэхүүний чанарт хэрэглэгчид сэтгэл хангалуун бус	Чанарт сэтгэл ханамжгүй байх нь зах зээлийн шинэ тоглогч эсвэл өрсөлдөгчөөр хангагдах далд эрэлтийг бий болгодог	Бүтээгдэхүүний чанарт сэтгэл ханамжгүй	Бүтээгдэхүүний чанарт сэтгэл ханамж дунд зэрэг	Чанарт бүрэн сэтгэл ханамжтай
				3
Үр дүнгийн оноо		10 оноо		
4 оноо		үйлчлүүлэгч гарах аюулын доод түвшин		
5-8 оноо		Үйлчлүүлэгч гарах аюул дунд зэрэг		
9-12 оноо		Үйлчлүүлэгч гарах аюул их		

СЗХ БҮРТГЭВ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БИРЖ 2023-01-19 БҮРТГЭВ-03

V хүчний үзүүлэлт: Нийлүүлэгчдээс ирэх бизнест учирч буй аюул заналыг үнэлэх Хүснэгт-33

Параметрийн үнэлгээ	Тайлбар	Үнэлгээний параметр	
		2	1
1. Нийлүүлэгчдийн тоо	Нийлүүлэгч цөөн байх тусам үнэ үндэслэлгүй өсөх магадлал өндөр байдаг	Цөөн тооны ханган нийлүүлэгчид эсвэл монополь	Өргөн хүрээний нийлүүлэгчид
		2	
2. Хязгаарлагдмал ханган нийлүүлэгчдийн нөөц	Нийлүүлэгчдийн нөөцийн хэмжээ хязгаарлагдмал байх тусам үнэ өсөх магадлал өндөр байдаг	Хязгаарлагдмал хэмжээ	Хязгааргүй хэмжээ
		2	
3. Шилжих зардал /нийлүүлэгчээ солих/	Шилжих өртөг өндөр байх тусам үнийн өсөлтөд нөлөөлдөг	Бусад ханган нийлүүлэгчид рүү шилжих өртөг зардал өндөр	Бусад ханган нийлүүлэгчид рүү шилжих өртөг бага
		2	
4. Нийлүүлэгчийн тэргүүлэх чиглэл	Ханган ийлүүлэгчийн хувьд салбарын тэргүүлэх чиглэлийн бодлого сул, хэрэгжих явц удаан байснаар хөрөнгө оруулалтаа багасгаж, чанаргүй т/э болон бүтээгдэхүүн гарах эрсдэл өндөр болно	нийлүүлэгчийн хувьд салбарын тэргүүлэх чиглэл ач холбогдол багатай	нийлүүлэгчийн хувьд салбарын тэргүүлэх чиглэл ач холбогдол өндөртэй
		2	
Нийт оноо		8 оноо	
4 оноо		Нийлүүлэгчдийн нөлөөллийн түвшин бага	
5-6 оноо		Нийлүүлэгчдийн нөлөөллийн түвшин дунд	
7 оноо		Нийлүүлэгчийн нөлөөллийн түвшин өндөр	

Шинжилгээний үр дүнг нэгтгэх, цаашид хийх ажлын чиглэл стратеги боловсруулах

Хүснэгт-34

№	Параметр	Ач холбогдол	Тайлбар	Ажлын чиглэл /Стратеги/
1	Орлох бүтээгдэхүүний аюул	ӨНДӨР -3 оноо	Өрсөлдөгч компаниуд зах зээлд том байр суурь эзэлдэг. Орлох бүтээгдэхүүнийн сонголт ихтэй.	Бусдаас ялгарсан онцлогтой бүтээгдэхүүн үйлдвэрлэж ялгарал бий болгох, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэх.
2	Салбарын дотоод өрсөлдөөний түвшин	ӨНДӨР -9 оноо	Салбарын зах зээлийн өрсөлдөөн өндөр. Цаашдаа зах зээлээ тэлэхэд хэцүү.	Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, өрсөлдөгчдийн үйл хөдлөлийг судалж түрүүлж шийдвэр гаргах. Ялгарах бүтээгдэхүүн гаргах.
3	Шинэ тоглогчдын аюул	ДУНД -14 оноо	Шинэ тоглогч орж ирэх аюулын түвшин дунд зэрэг	Одоо байгаа бүтээгдэхүүнээ хоногшуулах,
4	Одооги йн үйлчлүүлэгчдээ алдах аюул	ДУНД -8 оноо	Хэрэглэгчид шилжих магадлал дунд зэрэг	Бүтээгдэхүүний чанартаа анхаарах, онцлог бүтээгдэхүүнээ сайн идэвхжүүлэх, чанарын мэдрэмжтэй хэрэглэгчдэд зориулсан шинэ бүтээгдэхүүн гаргах.
5	Нийлүүлэгчдийн тогтворгүй байдал	Өндөр -8 оноо	Нийлүүлэгчийн нөлөөллийн түвшин өндөр	Импортын түүхий эдийг нөөцийг хангалттай хэмжээнд байлгах, Дотоодын нийлүүлэгчдэд шаардлагуудаа сайн тавих, нийлүүлэгчдийн тоог нэмэх

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -04- 13
БҮРТГЭВ-03

	Газар шим	Багро	Видан	Урбанек	Ковар
Ерөнхий мэдээдэл	1999 онд байгуулагдсан.	2008 онд байгуулагдсан.	2008 онд байгуулагдсан.	1994 онд Монголд анх оруулж ирсэн.	2006 онд Монголд анх оруулж ирсэн.
Харьяалал	Монгол улс	Монгол улс, Польш	Монгол улс	Польш	Польш
Хүчин чадал	Цагт 3000-6000 бүтээгдэхүүн	Цагт 3000 бүтээгдэхүүн	Хоногт 12000 бүтээгдэхүүн		
Онцлог	Анхны үндэсний үйлдвэр	Өнгө үзэмж, нэр хүнд сайтай	Үнэ хямд	Анхдагч	Өнгө үзэмж сайтай
Зорилтот зах зээл	Масс зах зээл	Масс зах зээл	Масс зах зээл	Масс зах зээл	Өндөр орлоготой
Зах зээлд эзлэх хувь	25%	10%	8%	41%	15%
Савлагаа	Шил	Шил, Лааз	Шил	Шил	Шил, Лааз
Идэвхжүүлэлт	Телевизийн сурталчилгаа, Facebook /127931/ Instagram /1066/	Телевизийн сурталчилгаа, Facebook/31268/	Facebook/41625/ Instagram/94/	Телевизийн сурталчилгаа, Facebook /28921/	Телевизийн сурталчилгаа, Facebook /90342/ Instagram/1255/
Нэр төрөл	60	38	26	60	22
Өргөст хэмх	16	7	4	10	5
Салат	17	14	5	17	2
Компот	7	7	4	8	12
Үнэ ханш	Дундаж	Дундаж	Дунджаас доогуур	Дунджаас дээгүүр	Үнэтэй
Өргөст хэмх	5510-15800₮	5500-19000₮	5000-8420₮	5650-15580₮	7450-19400₮
Салат	2710-5600₮	2270-4000₮	3030-4800₮	3100-6600₮	
Компот	6200-8650₮	7400-8500₮	6900-7720₮	7300-11200₮	8790-11080₮
Борлуулалтын суваг	Улаанбаатар хот, Хөдөө орон нутаг /Нарантуул зах, Зарим аймгуудад гэрээт борлуулагч, Өөрсдөө түгээх	Улаанбаатар хот, Багро /Нарантуул зах/	Улаанбаатар хот, Хөдөө орон нутаг /Нарантуул зах/	Улаанбаатар хот, Хөдөө орон нутаг /Нарантуул зах, Тотал дистрибюшин ХХК/	Улаанбаатар хот, Хөдөө орон нутаг /Нарантуул зах/
Давуу тал	Салбартаа анхдагч, өөрийн гэсэн брэнд бүтээгдэхүүнүүдтэй	Хэрэглэгчдэд сайн хоногшсон, үндэсний үйлдвэрлэгч	Үндэсний үйлдвэрлэгч үнийн хувьд боломжийн	Анхдагч импортын бүтээгдэхүүн, зах зээлд эзлэх хувь өндөр	Өнгө үзэмж сайтай, компотны зах зээлийн ихэнх хувийг эзэлдэг
Сул тал	Түүхий эдийн нөөц тасалддаг	Хөдөө орон нутагт түгээлт хийдэггүй	Бүтээгдэхүүний өртөг өсөх	Дотоодын бүтээгдэхүүнүүдтэй харьцуулахад үнэ өндөр	Үнэ өндөр
Боломж	Хэрэглэгчид эх орны хөрсөнд ургасан түүхий эдээр үйлдвэрлэсэн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүний хэрэглэх хандлагатай болохоос гадна дотоодын үйлдвэрлэгчдийг дэмждэг болсон.			Дотоодын үйлдвэрлэгчдийн түүхий эдийн нөөц тасалдаж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл багасах	
Аюул	Импортын барааны нэр төрөл тоо ширхэг өсөх, түүхий эдийн тасалдал	Импортын барааны өсөлт, түүхий эдийн тасалдал	Хэрэглэгчийн гомдлын тоо өсөх	Хил гааль хаах, валютын ханш өсөх	Импортын татвар нэмэгдэх

2.2.2 Эрсдэл, эрсдэлийн удирдлага

Даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч үндэсний үйлдвэрлэгчийн хувьд үнэт цаас гаргагчид тулгарч болох эрсдэл, учруулж болох тодорхойгүй эрсдэлтэй байдлыг боломжит бага түвшинд байлгах үүднээс эрсдэлийн удирдлагын дараах хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг.

Үнэт цаас гаргагчийн зүгээс алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд 2018 онд байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой хөгжлийн суурь бий болгоход тустай чухал стратеги шийдвэр гаргасан нь "Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага ISO 22000:2018 стандартын шаардлагад нийцүүлэн удирдлагын зөв тогтолцоог бий болгож, тогтвортой үр дүнтэй хэрэгжүүлэх замаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэнэ" гэж тодорхойлсон.

Стратеги зорилгоо амжилттай хэрэгжүүлэхээр 2018 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, "Үйлдвэрлэлийн зохистой дадал" олон улсын GMP стандарт, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага ISO 22000:2018 стандартуудыг амжилттай хэрэгжүүлж гэрчилгээгээ авсан.

Схем-5

Байгууллагын түвшинд	Компанийн зорилго, төлөв байдалд тохирсон, стратегийн чиглэлийг дэмжсэн, чанарын зорилтуудыг тогтоох үндэслэл, боломжийг хангасан, холбогдох шаардлагыг биелүүлэх үүргийг тусгасан, чанарын удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулах үүргийг тусгасан чанарын бодлогыг бий болгож, хэрэгжүүлж, мөрдүүлэх; Удирдлагын тогтолцооны нэгдмэл байдлыг хангаж, холбогдох чиг үүрэгт хамаарах хариуцлага, эрх мэдлийг хуваарилах, үйл явцын арга барил, эрсдэлд суурилсан сэтгэлгээг дэмжих, удирдлагын тогтолцооны шаардлагатай нөөцийн бэлэн байдлыг хангах; Хэрэглэгчийн, холбогдох хууль болон зохицуулалтын шаардлагыг тодорхойлж, тогтвортой мөрдөж ажиллах, бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын байдал, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх чадварт нөлөөлөхүйц эрсдэл болон боломжуудыг тодорхойлж, хэрэгжүүлэх
Бүтээгдэхүүн үйлчилгээний түвшинд	Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага MNS ISO 22000:2019 стандартыг тогтвортой хэрэгжүүлэх замаар Хүнсний аюулгүй байдлын сулжээний бүх шатанд хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангасан чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх; Үйлдвэрлэлийн бүх үе шатанд түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад шаардагдах нөхцөл, хяналт, үйл ажиллагаанд тавигдах шаардлага буюу "Үйлдвэрлэлийн зохистой дадал" олон улсын GMP стандартыг хэрэгжүүлэх замаар эрүүл, аюулгүй чанартай хүнсний ногооны нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.
Хувь хүний түвшинд	Ажилтны ур чадвар, мэдлэгт тавигдах шаардлагыг ажлын байрны тодорхойлолтод тодорхойлсон бөгөөд "Ажилтны мэргэжил, ур чадварын түвшин тогтоох журам"-ын дагуу гэрчилгээжүүлэлтийн үр дүнгээр баталгаажуулах; Бүх шатны ажилчдыг ажлын байранд өндөр чанартай ажиллахад чиглэсэн ажлын гүйцэтгэлд суурилсан "Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох, шагнах журам", шаардлагатай техник, арга барилд сургахад чиглэсэн "Сургалт хөгжлийн журам"

Эрсдэлд суурилсан сэтгэлгээ буюу эрсдэлийн удирдлага

Үр дүнтэй чанарын удирдлагын тогтолцоог бий болгож, чанарын удирдлагын тогтолцооны үр бүтээлтэй байдлыг дээшлүүлэх, бий болсон боломжийг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, сайжирсан үр дүнд хүрэх, сөрөг үр дагавраас сэргийлэхэд эрсдэлд суурилсан сэтгэлгээ, чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын 4 ба 6-р бүлэгт эрсдэлд суурилсан төлөвлөлт хийхийг шаарддаг.

Эрсдэлийн менежментийг хэрэгжүүлснээр хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, хууль, эрх зүйн орчин, иргэдийн хүлээлт, хүрээлэн буй орчны хамгаалал, бүтээгдэхүүний чанар, төслийн менежмент, үйл ажиллагааны үр ашиг, засаглал ба нэр хүнд зэргийг тодорхой болгож байгууллага тавьсан зорилтдоо хүрэх, гүйцэтгэлээ сайжруулахад чухал хувь нэмэр болдог. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ Эрсдэлийн менежмент – Зарчим ба заавар MNS ISO 31000:2011 стандартын ерөнхий арга зүйн зааврыг удирдлага болгодог.

Өөрөөр хэлбэл Эрсдэлийн менежментийг байгууллагын бүх үйл ажиллагаа болон үйл явцад үр нөлөөтэй, үр ашигтай, уялдаа холбоотой байдлаар бодлого боловсруулалт, үйл ажиллагааны ба стратегийн төлөвлөлт, хяналт болон өөрчлөлтийн менежментийн үйл явцад тусгаж стратеги төлөвлөгөө болон зохион байгуулалтын төлөвлөгөөнүүдтэй уялдуулдаг.

Схем-6



СЭХ БҮРТГЭВ
ХӨРӨНГИЙН БИРЖ 2023-01-19 БҮРТГЭВ-03

Эрсдэлийн менежментийн үйл явц

Схем-7

Мэдээлэл солилцох ба зөвлөлдөх Байгууллагын бүх үйл ажиллагаа болон үйл явцад оролцогч (Гадаад болон дотоод) талуудтай эрсдэл, түүний шалтгаан, үр дагавар (хэрэв мэдэж байгаа бол) болон тухайн эрсдэлийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотой асуудал талаар мэдээлэл солилцох болон зөвлөлдөнө

НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛНО.

ГАДААД ТӨЛӨВ БАЙДАЛД ХАМААРАХ

Олон улсын, үндэсний, бүс нутаг ба орон нутгийн аль ч түвшний соёл, нийгэм, улс төр, эрх зүйн орчин, санхүү, технологи, эдийн засаг, байгаль орчны болон өрсөлдөөний байдал байгууллагын зорилгод нөлөөлөх үндсэн хүчин зүйл, хандлага; ба харилцан ажиллагаатай гадны оролцогч талуудын ойлголт, үнэлэмж гэх мэт асуудлууд

ДОТООД ТӨЛӨВ БАЙДАЛД ХАМААРАХ

- Засаглал, бүтэц, зохион байгуулалт, үүрэг, хариуцлага;
- Бодлого, зорилт ба тэдгээрт хүрэх стратеги;
- Нөөц болон мэдлэг (жишээ нь хөрөнгө, хугацаа, хүмүүс, үйл явц, тогтолцоо ба технологи)-ээр илэрхийлэгдэх чадвар

ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛГЭЭ БУЮУ ЭРСДЭЛИЙГ ИЛРҮҮЛЭХ, ЭРСДЭЛИЙГ ШИНЖЛЭХ, ЭРСДЭЛИЙГ ДҮГНЭХ ҮЙЛ ЯВЦ

АЛХАМ 1. ЭРСДЭЛИЙГ ИЛРҮҮЛНЭ.
Эрсдэлийн эх үүсвэр, нөлөөлөх хэсэг, тохиолдол (нөхцөл байдлын өөрчлөлт багтана), түүний шалтгаан болон түүнээс учирч болох үр дагаврыг олж тогтооно.

АЛХАМ 2. ЭРСДЭЛИЙГ ШИНЖИЛНЭ.
Эрсдэлийг шинжлэхэд эрсдэлийн шалтгаан ба эх үүсвэр, түүний эерэг ба сөрөг үр дагавар, эдгээр үр дагавар гарч болох магадлалыг судалж үздэг. Үр дагавар болон магадлалд нөлөө үзүүлэх хүчин зүйлийг тодорхойлно. Эрсдэлийг үр дагавар ба түүний магадлалаар нь болон эрсдэлийн бусад шинж чанарыг тодорхойлж шинжилнэ.

АЛХАМ 3. ЭРСДЭЛИЙГ ДҮГНЭХ.
Эрсдэлийн шинжилгээний үр дүнд үндэслэж ямар эрсдэлд арга хэмжээ авах шаардлагатайг тогтоох болон хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэхэд шийдвэр гаргагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор эрсдэлийг дүгнэнэ.

ЭРСДЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭ

Эрсдэлийн арга хэмжээнд эрсдэлийг өөрчлөх нэг буюу хэд хэдэн хувилбарыг сонгоод хэрэгжүүлнэ. Хамгийн тохиромжтой эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг сонгохдоо хууль, эрх зүйн зохицуулалт болон байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага зэрэг бусад шаардлагын талаар, гарах үр ашгийг хэрэгжүүлэх зардал, хичээл зүтгэлтэй дүйцүүлэхийг хамаарна.

Эрсдэлийн арга хэмжээний хувилбарт:

- Эрсдэлийг нэмэгдүүлж байгаа үйл ажиллагааг үргэлжлүүлэхгүй, эхлүүлэхгүй байх шийдвэр гаргаж эрсдэлээс зайлсхийх
- Боломжийг ашиглах үүднээс эрсдэлийг нэмэгдүүлэх эсвэл үүрэх
- Эрсдэлийн эх үүсвэрийг арилгах
- Магадлалыг өөрчлөх
- Үр дагаврыг өөрчлөх
- Бусад тал буюу талуудтай (гэрээ болон эрсдэлийн санхүүжилт) эрсдэлийг хуваалцах
- Мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргаж эрсдэлийг хадгалах зэрэг хувилбар байдаг.

Хяналт ба мониторинг Дараах зорилгын үүднээс эрсдэлийн менежментийн үйл явцын бүх асуудалд Хяналт ба мониторинг хийдэг. Үүнд: Хяналтыг загвар ба ажиллагааны аль алинд нь үр нөлөөтэй, үр дүнтэй байлгах Эрсдэлийн үнэлгээг сайжруулахад шаардлагатай мэдээлэл олж авах; Тохиолдол, өөрчлөлт, чиг хандлага, амжилт болон алдаагаа шинжлэх, сургамж авах Эрсдэлийн шалгуурыг өөрчлөгдөхөд хүргэх дотоод, гадаад нөхцөл байдлын өөрчлөлт болон эрсдэлийн арга хэмжээг нэмж засварлах шаардлага, нэн тэргүүний асуудлыг илрүүлэх Шинээр үүсч сэж буй эрсдэлийг олж тогтоох.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

ХӨРӨНГИЙН ХӨРӨЛТИЙН БИРЖ
ЦЕННЫХ БУМАГ БИРЖ
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн функцүүд болох үйлдвэрлэл, борлуулалт маркетинг, санхүүгийн үйл ажиллагаанд тулгарч болох эрсдэлүүдээс удирдахад төвөгшил өндөртэй дотоод эрсдэл, компанийн үйл ажиллагаанаас үл хамаарах гадаад эрсдэл тэдгээрийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар доор тодорхойлж үзвэл.

Үйлдвэрлэлийн эрсдэл: Компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд түүхий эд, сав баглаа боодлын татан авалт, нийлүүлэлтээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн бэлэн болох бүх процесс хамаардаг.

Схем 8



Хүснэгт-36

МАТЕРИАЛ /Түүхий эд, сав баглаа боодол/		
Эрсдэлийн төрөл	Юу тохиолдож болох вэ?	Ямар арга хэмжээ авах вэ?
Гадаад хүчин зүйлээс хамаарах	Байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсоноор дотоодоос худалдан авдаг үндсэн түүхий эдийн нийлүүлэлт тасалдах	Гадаад зах зээлээс хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан ТЭ -ийг худалдан авна.
	Монгол Улсын у ур амьсгалын нөхцөл байдал, газар зүйн хүчин зүйлээс шалтгаалан хүнсний ногоо тариалах хугацаа богино байдаг учир хурааж хадгалсан ногоог дараа жилийн шинэ ургац гарах хүртэл хугацаанд худалдан авах шаардлага гардаг ба хорогдол их хэмжээгээр гардаг нь бүтээмж болон өртөгт нөлөөлөх	Аль болох монгол хөрсөнд ургасан ногоог хэрэглэх компанийн үзэл баримтлалын хүрээнд нийлүүлэгч талтай худалдан авалтын гэрээ байгуулахдаа хорогдлын эрсдэлийг хуваах бодлого барих,
	Түүхий эдийн хэрэгцээгээ дотоодоосоо бүрэн хан гах зорилгын хүрээнд ногоог хямд үед нь худалдан авч харилцагчийн агуулахад хадгалуулах үед зориулалтын сайн чанарын зоорь, агуулах, тээвэрлэлтийн систем дутмаг байгаагийн улмаас нийлүүлэлтийн эрэлттэй харьцуулахад түүхий эдийн хорогдол ихэсдэг.	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан зориулалтын агуулах, зооринд хадгалах, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох, хатаах, хөлдөөх, нөөшлөх бага, дунд оврын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийг дэмжих, хүнсний сав, баглаа боодлын дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолыг УИХ -ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлсан нь өөрсдийн хэрэгцээнд нийцсэн агуулах барих боломжтой болгож байна.
	Цар тахлын улм аас хил хаагдах, шаардлагатай түүхий эд материалын худалдан авалт зогсох саатсанаас бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдах	Шаардлагатай нөөцийг урьдчилан төлөвлөж, зохистой бүрдүүлэлт, хангалтыг хийнэ.
	Олон улсын эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэлтэй валюты н эрсдэл	Зарим нэг түүхий эд, сав баглаа боодлыг гадаадын зах зээлээс худалдан авагч худалдан авалтыг төлөвлөхдөө олон улсын зах зээлийн судалгаанд үндэслэн нийлүүлэгчийг зөв сонгон худалдан авалт хийх зарчмыг баримталдаг.

НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ЗҮЙН ЗӨВЛӨХ ХХК

СЭХ
2023 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Хүснэгт-37

БҮХ ШАТНЫ АЖИЛТНУУД		
Гадаад хүчин зүйл	Улирлын чанартай /өргөст хэмх, хүрэн манжин г.м/ нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үед ажиллах хүчний хомсдолд орох	Хүний нөөцийн бүрдүүлэлтийн гадаад сувгуудыг өргөн хүрээнд ашиглах, мэргэжлийн чиглэлийн сургалтын төвүүдтэй хамтын ажиллагаа зохион байгуулах, орон нутгийн хөдөлмөрийн биржүүдтэй хамтарч ажиллах
Дотоод хүчин зүйл	Ажилтнуудын ур чадвар, гүйцэтгэлээс үүдэлтэй чанарын доголдол гарах	Гүйцэтгэлийн удирдлагад суурилсан ажилтнуудыг чадавхжуулах, сургаж хөгжүүлэх, ажилтны тогтвортой байдлыг хангах бодлогыг тасралтгүй сайжруулах
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ		
Гадаад хүчин зүйл	Тоног төхөөрөмжийн гадаадаас нийлүүлдэг эд ангийн эвдрэл гэмтлээс үүдэлтэй техникийн засвар үйлчилгээ сунжрах	Шаардлагатай сэлбэг хэрэгслийг нөөцлөхөөс Гадна, тухайн дамжлагын ажлыг гар болон хагас автомат хэлбэр лүү шилжүүлэх төлөвлөгөөт ажлыг өөрчилж өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Схем-9



Хүснэгт-38

МЭДЭЭЛЭЛ /Маркетингийн мэдээлэл /		
Эрсдэлийн төрөл	Юу тохиолдож болох вэ?	Ямар арга хэмжээ авах вэ?
Дотоод хүчин зүйлээс хамаарах	Борлуулалтын суваг, зорилтот хэрэглэгчид болон эрэлтийг буруу тодорхойлсонтой холбоотой бүтээгдэхүүний борлуулалт хангалтгүй байх.	Зах зээлийн нөхцөл байдал болон борлуулалтын суваг, зорилтот хэрэглэгчийн судалгаа гэх мэт маркетингийн судалгаа, шинжилгээг сайтар хийн, бүтээгдэхүүний борлуулалтын сувгийг тодорхойлох, борлуулалтыг нэмэгдүүлэх арга замыг судлан бүтээгдэхүүний зах зээлд эзлэх хувийг тасралтгүй нэмэгдүүлэх
	Бэлэн бүтээгдэхүүний хадгалалт бо лон түгээлтийн журам алдагдаж, бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгчдэд хүргэх хугацаа хойшлох	Борлуулалтын багаас жижиглэн худалдаалагчдаас захиалгыг авах, агуулах руу урьдчилсан захиалгыг өгөх зэргээр жижиглэн худалдааны газар, агуулах, түгээлтийн хоорондын уялдаа холбоог тасралтгүй сайжруулж ажиллах
Гадаад хүчин зүйл	Жижиглэн худалдаа эрхэлдэг байгууллага, хувь хүн/харилцагч гэх/ -ий Хүнсний аюулгүй байдлын талаарх мэдлэг мэдээлэл дутуу, хүнсний бүтээгдэхүүн худалдаалах хууль эрх зүйн шаардлага зөрчигдсөнөөс бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдаж хэрэглэгчийн гар дээр чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн очсоноос хэрэглэгчийн сэтгэл ханамжид нөлөөлөх	Харилцагчтай хамтран ажиллах гэрээнд бүтээгдэхүүний чанарт тавих шаардлагын талаар тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөмж хүргүүлэх зэргээр харилцагч нартай нягт хамтран ажиллах, хэрэглэгчийн гомдлыг цаг алдалгүй хүлээн авч барагдуулах, хэрэглэгчдэд нөөшилсөн бүтээгдэхүүний талаар өргөн мэдлэг олгох ажлыг тасралтгүй явуулах

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436117

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЭХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛ ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

2.2.3 Хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа, шинжилгээ

Үнэт цаас гаргагчаас 2021 онд даршилсан ногооны салбарын бүтээгдэхүүний талаар хэрэглэгчдийн зан төлөвийг тодорхойлох зорилгоор нийслэлийн 8 дүүрэг, 20 аймгийн хэрэглэгчээс буюу Улаанбаатар хотын нийт 19 байршилд томоохон худалдааны төвүүд, төвлөрсөн зах, супермаркетаар үйлчлүүлж байгаа 275 хэрэглэгч, цахимаар 586 хэрэглэгчээс судалгаа авсан бөгөөд судалгаанд оролцсон 861 хэрэглэгчийн 757 Улаанбаатар хотынх, үлдсэн нь 104 хөдөө орон нутгийн хэрэглэгчид байсан. Судалгааны ерөнхий асуулгад амьдран суух хаяг, ажил эрхлэлтийн байдал, өрхийн орлого, ам бүл зэрэг үзүүлэлтийг сонгосон.

Зураглал-1

Хүйсийн харьцаа



Эмэгтэй **82.9%**



Эрэгтэй **17.1%**

Судалгаа авсан хэлбэр



Цаасаар **31.9%**



Цахимаар **68.1%**

Судалгаанд оролцогчдын нас



16 нас хүртэл	17-22 нас	23-30 нас	31-40 нас	41-50 нас	51-60 нас	61-дээш нас
1%	11%	23%	33%	19%	9%	4%

Амьдардаг дүүрэг График-31



Өрхийн орлого График-32



Ам бүлийн байдал График-33



Судалгаанд оролцсон нийт 861 хэрэглэгчийн 29.8% нь үйлдвэрийн даршилсан ногоо, 16.5% нь Урбанек брэнд, 13.3% нь ковар брэнд, 13.2% нь Багро брэнд, 6.1% нь Видан брэндийн даршилсан ногоог ихэвчлэн хүнсэндээ хэрэглэдэг талаар хариулсан бөгөөд энэхүү үр дүнгээс харахад 50.3% нь дотоодын үйлдвэрийн даршилсан ногоог хэрэглэдэг бол 39.6% нь импортын даршилсан ногоо хэрэглэдэг.

Аль брэндийн даршилсан ногоог ихэвчлэн худалдан авдаг вэ? График-34



Та аль брэндийн даршилсан ногоог ихэвчилэн худалдан авдаг вэ? /судалгаа авсан хэлбэрээр/ График-35



Брэнд сонголтыг судалгаанаас үзэхэд судалгаа өгсөн 275 хэрэглэгчдийн 27% /74/ нь Газар шим, онлайнаар судалгаа өгсөн 586 хэрэглэгчдийн 31% /182/ нь үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдан авдаг гэж хариулт өгсөн.

СЭХ 2021 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-19 БҮРТГЭВ-03

График-36

Брэнд сонголт 2013-2023 он



Судалгааны үр дүнгээс үзэхэд өнгөрсөн онуудад хэрэглэгчдийн 91% нь Газар шим, Багро, Видан, Урбанек, Коварын бүтээгдэхүүнийг сонгож худалдан байсан бол 2021 онд 79% нь дээрх брэндүүдийн бүтээгдэхүүнүүдийг ихэвчлэн худалдан авч байна. Үлдсэн 20 орчим хувьд нь бусад брэндүүдийн бүтээгдэхүүнийг сонгож хэрэглэдэг талаар судалгаа өгсөн.

Та ямар нэр төрлийн даршилсан ногоо ихэвчлэн худалдан авдаг вэ? Хүснэгт-37



Даршилсан ногооны хэрэглээ График-38



График-39



2014 оноос хойших 7 жилийн хугацаанд хэрэглэгчдийн даршилсан ногоо, салат сонголтын өөрчлөлтийг харвал Өргөст хэмх, Алаг салат /Дунайн салат сонголт буурах хандлага ажиглагдаж байгаа бөгөөд үүний шалтгаан нь зах зээл дээр илүү олон төрлийн салат худалдаалагдах болсонтой холбоотой гэж үзсэн.

NOVEL INVESTMENT Co.,Ltd
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЗХ БҮРТГЭВ №-1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-01-19 БҮРТГЭВ-03

График-40



График-41



Харин Өег салат сонгох хандлага тогтвортой байгаа бол, Лечо/Мөөгтэй лечо сонгох хандлага өссөн үзүүлэлттэй байна.

График-42



График-43



Хүрэн манжин, Байцаатай салат сонгох хэрэглэгчдийн хандлага сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаа бол Өег салат, Хүрэн манжин, Лечо/Мөөгтэй лечоны хувьд үнэт цаас гаргагчийн борлуулалтын тоо хэмжээний өсөлттэй энэхүү хандлага нь мөн уялдаж байна.

График-44



Хэрэглэгчид даршилсан ногоо, салат, компотыг 24.4% нь зочин ирсэн үед, 23.1% нь аялал зугаалгаар явахдаа, 21,7% нь өдөр тутам хүнсэндээ, 20.7% нь баяр ёслолоор хэрэглэдэг бол үлдсэн 10% нь бусад үе хэрэглэдэг. Сүүлийн 5 жилийн хандлагыг харвал зөвхөн Баяр ёслолоор хэрэглэх нь буурах хандлагатай байгаа бол бусад 3 үед хэрэглэх хандлага өсөж байгаа харагдаж байна.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮНДЭР ХХК

Хэрэглэгчийн хүнсний хэрэглээндээ зориулж сард дунджаар хэдэн удаа даршилсан ногоо худалдан авдаг талаарх түүвэр судалгаагаар сар бүр худалдан авааД байдаггүй гэсэн 15 хувь, 1 удаа 8.8 хувь, 2 удаа 20.3 хувь, 3 удаа 26.1 хувь, 4 ба түүнээс дээс удаа 29.7 хувь байгаа нь үнэт цаас гаргагчийн зүгээс дотоодын даршилсан ногооны салбарын хэмжээг нэмэгдүүлж, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэн гаргах боломжтой нь харагдаж байна.

Даршилсан ногоо хэрэглээний давтамж сараар

Хүснэгт-39

Давтамж /сараар/	Хувь	Өрхийн тоо /874,157*хувь/	Ширхэг /өрхийн тоо*хэрэглэх давтамж/
Сар бүр худалдан авааД байдаггүй	15%	131,998	-
1 удаа	9%	76,926	76,926
2 удаа	20%	177,454	354,908
3 удаа	26%	228,155	684,465
4 ба түүнээс дээш удаа	30%	259,625	1,038,499
Нийт	100%	874,157	2,154,797

Монгол улсын даршилсан ногооны сарын хэрэглээ 2,154,797 ширхэг, жилийн хэрэглээ 26.0 сая шил бүтээгдэхүүн буюу мөнгөн дүнгээр 181.3 тэрбум орчим төгрөг байхаар судалгааны дүн гарсан хэдий ч зах зээл дээрх бодит хэрэглээ 114.7 тэрбум төгрөгийг бүтээгдэхүүн хэрэглэсэн байна. Даршилсан ногоо үйлдвэрлэлийн импортын болон дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувь хэмжээг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна.

Зах зээлийн одоогийн байдал ба зах зээлд эзлэх хувь

Хүснэгт-40

	Бүтээгдэхүүний төрөл	2021 оны зах зээлд эзлэх хувь
1	Импорт	56%
2	Дотоод Газар шим	25%
3	Дотоод бусад	19%
	Нийт	100%

Эх сурвалж: 2021 оны зах зээлийн судалгаа

Даршилсан ногооны салбар 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтүүд тулгуурлан импортын болон дотоодын үйлдвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувь хэмжээг графикаар үзүүлбэл дараах байдалтай байгаа бөгөөд үнэт цаас гаргагчийн хувьд 2021 оны борлуулалт 29.2 тэрбум төгрөг байсан бөгөөд энэ нь зах зээлийн 25 хувийг эзэлж байна.

График-45



Даршилсан ногоог хаанаас худалдан авдаг вэ?

График-46



Хэрэглэгчдийн 48.8% нь гэрийн ойролцоох хүнсний дэлгүүрээс худалдаг авалт хийдэг бол, 27% нь Томоохон супермаркет сүлжээ дэлгүүрээс, 15.3% нь Хүнсний зах болон бөөний төвүүдээс, 7.6% нь нэрийн барааны дэлгүүрээс, 0,7% нь бусад, 0,3% нь хүргэлтээр /онлайн, утас/ гэж хариулсан байна.

Даршилсан ногоог хаанаас худалдан авдаг вэ? /2014-2020 он/

График-47



Гэрийн ойролцоох дэлгүүр, хүнсний зах бөөний төвөөс худалдан авах хандлага буурч байгаа бол томоохон супермаркет болон сүлжээ дэлгүүрээс худалдан авах хандлага өсөж байна.

Даршилсан ногоог хаанаас худалдан авдаг вэ? /2014-2020 он/

График-48



Хэрэглэгчдийн 32.9% нь Телевизийн зар сурталчилгааанаас мэдээлэл авдаг бол 27% нь сошиал медиагаас, 15.3% нь ойр дотны хүмүүсээсээ, 13.2% нь үзэсгэлэн яармагаас мэдээлэл авдаг.

СЭХ
2023 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Сошиал медиа /Facebook, Instagram г.м/

График-49



2013 оноос хойш нэг удаагийн худалдан авалтаар 1 ширхгийг худалдан авах хандлага нь буурч байгаа бол 3 болон түүнээс дээш худалдан авах хандлага нь нэмэгдэж байна.

График-50



График-51



Даршилсан ногоо худалдан авахад дараах хүчин зүйлс хэр чухал вэ?
/чухал биш-1, чухал-5/

График-52



Даршилсан сонгон худалдан авахад хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлс нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн он, сар /5-4.09/, Амт /5-4/, Орц найрлага/5-3,82/, Брэндийн нэр хүнд найдвартай байдал /5-3.67/, Түүхий эдийн гарал үүсэл /05-3,67/ голлон нөлөөлдөг байна. Хэрэглэгчийн бүтээгдэхүүн сонголтод хамгийн их нөлөөлдөг 3 хүчин зүйлийн 5 жилийн хандлагыг харвал өсөх хандлагатай байна.

"НОВЕЛ ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ 6436117
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
9022080716 2577127 ИД0593

СЗХ
БҮРТГЭВ
№ 1

2023 -01- 19

График-53



График-54



Нийт судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 45% нь үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тогтмол худалдан авдаг бол, 53 хувь нь худалдан авч байсан, 2% нь огт худалдан авч байгаагүй гэж хариулсан байна. 2020 он болон 2021 оны үр дүнг харьцуулахад огт худалдан авч байгаагүй хэрэглэгчдийн хувь 3% буурсан, байнга худалдан авдаг хэрэглэгчийн хувь 8% өссөн дүнтэй байна.

Даршилсан үйлдвэрийн бүтээгдэхүүнийг бусад ижил үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад нийт судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн 93.4% нь эерэг хариулт өгсөн. Үүнд Амт сайтай-35.2%, Монгол ногоогоор хийсэн учир эрүүл байдаг-33.7% нь,Чанартай-19.3%, Илүү шинэ-5.2% гэж хариулсан. Сөрөг хариултуудаас хамгийн өндөр хувьтай нь Өөрсдийгөө сайн таниулаагүй-2.2%, Амт муутай-1.4%, Хаяг шошгын өнгө үзэмж муу-1% тус тус хариулсан байна. Сөрөг хариулт өгсөн хэрэглэгчид нийт 6.4% эзэлж байна.

Зураглал-4

2013 он		2020 он		2021 он	
Амтанд дурлагсад	21%	Тодорхой шалгуургүй	21%	Гол шалгууруудаа л хардаг	21%
Төгс шалгууртнууд	41%	Брэнд нэр хүнд чухалчлагчид	41%	Эрүүл мэнддээ анхаарагчид	41%
Эрүүл мэнддээ анхаарагчид	38%	Эрүүл мэнддээ анхаарагчид	38%	Төгс шалгууртнууд	38%

Үнэт цаас гаргагчийн зүгээс 2013 оноос хойш хэрэглэгчийн судалгааг тасралтгүй хийж байгаа бөгөөд 2013 онд 22% нь Газар шимийн бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэдэг байсан бол 2021 онд 30% нь тус брэндийн даршилсан ногоог худалдан авч хэрэглэдэг хандлага ажиглагдсан. Судалгааны үр дүнгээс дүгнэж үзвэл.

- Даршилсан ногооны хэрэглээнээс хамгийн өндөр хэрэглээтэй нь Өргөст хэмх, Өег салат ,Алаг салат байгаа бөгөөд 2013 оны даршилсан ногооны хэрэглээний хандлагыг харвал Өргөст хэмх, Алаг салат, Өег салат 3 бүтээгдэхүүн хэрэглээний 80%-ийг эзэлж байсан бол 2020 онд эдгээр 3 бүтээгдэхүүн 49%, 2021 онд 40.7%-г эзэлж байна. Үүнээс харвал Өргөст хэмх, Алаг салат хэрэглээ буурсан ч Өег салат, Лечо, Хүрэн манжин, Байцаатай салат зэрэг бүтээгдэхүүний хэрэглээ өсжээ.
- Хэрэглэгчид даршилсан ногоо, салат, компотыг зөвхөн баяр ёслолоор хэрэглэх нь 2013 онд 46 хувь байсан бол энэ хандлага жилээс жилд буурч өдөр тутам хүнсэндээ хэрэглэх, зочин ирсэн үед хэрэглэх, аялал зугаалгаар явахдаа хэрэглэх хандлага өсөж байна. Даршилсан ногоог гэрийн ойролцоох дэлгүүрээс худалдан авах нь их байгаа ч ерөнхий хандлагыг харвал энэ хандлага буурч, томоохон супермаркет, сүлжээ дэлгүүрээс

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УПЛАНБААТАР ХОТ 5636117
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

худалдан авах хандлага өсөж байгаа. Сүлжээ супермаркетуудаас худалдан авах хандлага 2014 онд 15 хувь байсан бол 2020 онд 23 хувь, 2021 онд 27 хувь болж өссөн бол цаашид 2026 он гэхэд 32 хувь болж өсөх хандлага ажиглагдаж байна.

- Даршилсан хүнсийг сар бүр хэрэглээд байдаггүй болон 1 удаа хэрэглэдэг гэсэн хэрэглэгчийн тоо буурч, 2 удаа хэрэглэдэг хэрэглэгчийн тоо тогтвортой байгаа бол 3 болон 4 ба түүнээс дээш удаа хэрэглэх хэрэглээний давтамж өсжээ.
- Хэрэглэгчийн мэдээлэл авах эх үүсвэрт гарч байгаа томоохон өөрчлөлт нь Сошиал медиагаас мэдээлэл авах хэрэглэгчийн хувь 2013 онд 4% байсан бол 2020 онд 23%, 2021 онд 27 хувь болтлоо өсжээ. Харин телевизээс мэдээлэл авах ерөнхий хандлага буурч байгаа ч 32.9 хувийг эзэлсэн хэвээр байгаа боловч сошиал хэрэглээ ихсэж байна.
- Нэг удаагийн худалдан авалтаараа 2013 онд 1 ширхгийг худалдан авдаг хэрэглэгчийн хувь 46 хувь байсан бол 2020 онд 23 хувь болтлоо буурсан бол харин 2 ширхэг бүтээгдэхүүн авах хэрэглэгчийн хувь тогтвортой байгаа бол 3 болон түүнээс дээш ширхгийг худалдан авах хэрэглэгчийн хандлага өсөж байна.
- Даршилсан ногоо худалдан авахад нөлөөлдөг түлхүүр хүчин зүйлсийг тодруулж асуухад хамгийн их буюу Үйлдвэрлэсэн хугацаа 82%-тай нөлөөлдөг байна. Энэ нь хэрэглэгчид аль болох шинэхэн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хэрэглэх хүсэлтэй байдаг бөгөөд хэрэглэгч хаана хэзээ үйлдвэрлэсэн нь баттай биш импортын бүтээгдэхүүнээс илүү үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнээ хэрэглэх хандлагыг нэмэгдүүлж байна гэж үзэж байна.
- Дараагийн бүтээгдэхүүн сонголтод хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлс нь Амт 80%-тай нөлөөлдөг бол Орц найрлага 76% буюу хаана тарьж ургуулсан ямар ногоогоор үйлдвэрлэсэн, ямар нэгэн консервант орсон эсэх, давс сахрын агууламж зэрэг нь нөлөөлдөг хэмээн хариулсан байна. Хэрэглэгчийн даршилсан ногоо худалдан авахад нөлөөлдөг хүчин зүйлсийн дундаж оноо сүүлийн 5 жилийн байдлаар өсөх хандлагатай байгаа нь хэрэглэгчдийн шаардлага жил ирэх бүр өсөж байгааг харуулж байна.

2021 оны судалгаагаар брэндийн бүтээгдэхүүнийг худалдан авч байсан уу? Гэсэн асуултад 53% нь худалдан авч байсан, 45% нь байнга худалдан авдаг, 2% нь огт худалдан авдаггүй гэж хариулсан. Энэ нь 2013 оны судалгааны дүнтэй харьцуулахад Байнга хэрэглэдэг хэрэглэгчийн хувь /Үнэнч хэрэглэгч/34%-иар нэмэгдсэн, худалдан авч байсан хэрэглэгчдийн тоо 22% буурсан /байнга хэрэглэдэг хэрэглэгч рүү шилжсэн/, Огт худалдан авч байгаагүй хэрэглэгчдийн тоо 9% буурсан дүнтэй байна.

Хэрэглэгчид Газар шимийн бүтээгдэхүүнийг бусад брэндийн бүтээгдэхүүнтэй харьцуулахад хамгийн том давуу тал нь Амт сайтай 35.2%, Монгол ногоогоор хийсэн учир эрүүл 33.7%, Чанартай 19% гэж давуу талуудыг тодорхойлсон бол, Сул талууд нь Өөрсдийгөө сайн таниулаагүй 2.2%, Амт муутай 1.4%, Хаяг шошгын өнгө үзэмж муу 0.9%, өнгө үзэмж муу 0.9% хариулсан байна.

2.2.4 Үнэт цаас гаргагчийн богино болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм

Үнэт цаас гаргагч давхардсан тоогоор 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа бөгөөд үндсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүд бүтээгдэхүүний нэр төрлөөс хамааран нэг цагт 3,000-6,000 шилэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай 1 шугам нь цагт 2,500 шил савлах хүчин чадалтай ундааны 1 шугам, цагт 0.5 тонн ногоо хөлдөөх шугам 1 тус тус ажиллуулж байгаа нь нийт үйлдвэрийн хүчин чадлын 60 орчим хувийг ашиглаж байна. Өнгөрсөн 2021 онд 5 төрлийн шинэ төрлийн ногооны нухшийг үйлдвэрлэж, зах зээлд амжилттай нэвтрүүлээд байгаа бөгөөд дээрх бүтээгдэхүүнүүд нь хэрэглэгчдийн өдөр тутамдаа хэрэглэж чаддаггүй, нарийн ногооноос авах амин дэмийг алдагдуулахгүйгээр нухшилж, хэрэглэхэд хялбар байдлыг хангаснаараа импортын болон бусад өрсөлдөгчийн бүтээгдэхүүнээс давуу юм. Өмнөх хэсэгт дурдсан даршилсан ногооны салбарын зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн судалгаанаас үзэхэд Монгол Улсын нийт өрхийн тоо, хэрэглэх давтамжийг 2021 онд хийгдсэн судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд өрх бүр сард 2,760,495 ширхэг салат хэрэглэх боломжтой тооцоолол гарсан.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчаас 2022-2024 оны хооронд богино хугацаанд бага насны болон бүх насны хүүхдэд зориулсан жимс ногооны нухаш, жимсний чанамал үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байгаагаас гадна кетчуп, соус, сүмс, майонез шинээр үйлдвэрлэх төлөвлөлт, зах зээлийн судалгааг хийгээд байна. Бүх насны хүүхдэд зориулсан нухаш болон жимсний чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээр дотоодын зах зээлийн багтаамжийг 299.1 тэрбум болгон нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

"Газар шим үйлдвэр" ХХК нь 2023 оноос 2027 оны хооронд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөнд дараах зорилгуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн зах зээлд таниулж, зах зээлд эзлэх хувь хэмжээг 20 хувьд хүргэх;
- Үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтын автоматжуулалтын тоног төхөөрөмжийг шинэчилж, бүтээмжийг нэмэгдүүлж зах зээлд эзлэх хувь хэмжээг 50 хувьд хүргэх,
- Түүхий эдийн нөөцийг бүрдүүлж, бүтээгдэхүүний тогтвортой үнийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хүнсний ногооны иж бүрэн зоорь барьж ашиглалтад оруулах.

Эдгээр зорилгуудыг хэрэгжүүлснээр 2027 оны жилийн эцсийн байдлаар компанийн борлуулалтын хэмжээг 108.5 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн хэмжээг 25.3 тэрбум төгрөгт хүргэж ажиллахаар төлөвлөж байна.

Үнэт цаас гаргагчийн зүгээс шинээр нухаш, кетчуп, соус, сүмс, майонез, чанамал, эрүүл мэндийн ундаа зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зайлшгүй үйлдвэрлэлийн савлагааны болон хуталтын техник тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах замаар үйлдвэрлэх боломж бүрдэх юм.

Шинээр нэвтэрч орох гэж байгаа нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонезын зах зээлийн багтаамж нь 2021 оны байдлаар 203 тэрбум төгрөг байна. Дэлгэрэнгүйг доор хүснэгтээс харна уу.

Хүснэгт-41

	Бүтээгдэхүүний төрөл	2021 оны зах зээл сая/төг	2021 оны зах зээлд эзлэх хувь
1	Импорт нухаш	26,530	13%
2	Импорт чанамал	26,160	13%
3	Импорт кетчуп, соус, сүмс	42,438	21%
4	Импорт Майонез	72,734	36%
5	Импорт Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	12,636	6%
6	Дотоодын Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	3,889	2%
7	Дотоод нухаш	1,851	1%
8	Дотоод чанамал	10,110	5%
9	Дотоод Майонез	6,666	3%
	Нийт	203,014	100%

Эх сурвалж: 2021 оны зах зээлийн судалгаа

Үнэт цаас гаргагчийн зүгээс дээрх бүтээгдэхүүний хөгжүүлэлт, судалгааг хийж бүтээгдэхүүний эхний дээжийг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2021 оны намраас 5 төрлийн ногооны нухаш шинээр үйлдвэрлэж, худалдаанд гаргаж эхэлсэн боловч хил хорио, цар тахлаас болж сав баглаа тасарч цөөхөн тоогоор үйлдвэрлэж байна.

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэхээр төлөвлөж буй шинэ бүтээгдэхүүн, өмнө үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүний зах зээлийн багтаамжийг нэгтгэж хүснэгтэд харуулав.

"НОВЕЛ ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19

Хүснэгт-42

	Бүтээгдэхүүний төрөл	2021 оны зах зээл сая/төг	2021 оны зах зээлд эзлэх хувь
1	Импорт өргөст хэмх	28,019	9%
2	Импорт салат	10,707	4%
3	Импорт компот	24,596	8%
4	Импорт нухаш	26,530	9%
5	Импорт чанамал	26,160	9%
6	Импорт кетчуп, соус, сүмс	42,438	14%
7	Импорт Майонез	72,734	24%
8	Импорт Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	12,636	4%
9	Дотоот Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	3,889	1%
10	Дотоод Газар шим /салат, өргөст хэмх, компот/	29,186	10%
	Дотоод Бусад /салат, өргөст хэмх, компот	22,181	7%
11	Нийт	299,076	100%

2021 онд нийт манай одоогийн үйл ажиллагаа явуулж буй өргөст хэмх, салат, компотны зах зээл болон шинээр нэвтрэхээр ажиллаж буй зах зээл болох нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн нэр төрлийн бүтээгдэхүүний импортын хэмжээ нийлээд 247.7 тэрбум төгрөг байна. Харин эдгээр бүтээгдэхүүний дотоодын зах зээл 51.4 тэрбум төгрөг байсан бөгөөд нийт зах зээлийн хэмжээ 299.1 тэрбум төгрөг байна. Цаашдаа буюу 2022-2027 онд зах зээлийн хэмжээ хэрхэн өөрчлөгдөх хандлагыг тооцоолж үзэхэд 2022 онд 318 тэрбум буюу 6 хувиар , 2023 онд 12 хувиар, 2024 онд 11 хувиар өсч цаашлаад 2027 онд 539.1 тэрбум төгрөгт хүрэхээр харагдаж байна. Гэвч бид зах зээлийн багтаамжийг 2021 оны дүнгээр бизнес төлөвлөгөөний төсөөлөлөө тооцоолсон бөгөөд зах зээлийн өсөлт таамаглалын дагуу хэрэгжсэн тохиолдолд бидний борлуулалт болон цэвэр ашиг нэмэгдэж компанийн үнэлгээ болон хувьцааны ханшинд эерэгээр нөлөөлөх магадлалтай юм.

Зах зээлийн нийт багтаамжийн таамаглал

Хүснэгт-43

Бүтээгдэхүүний төрөл	Импортын хэмжээ			Таамагласан импортын хэмжээ					
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он
Импорт	215,602	227,103	247,709	262,245	280,828	296,713	314,397	330,881	348,165
Дотоод	26,147	37,865	51,368	55,755	74,173	97,284	126,380	157,471	190,923
Нийт	241,748	264,968	299,077	318,000	355,002	393,997	440,776	488,352	539,088

График-55



"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ

ГУРАВДУГААР БҮЛЭГ:
ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАЖ БУЙ ХУВЬЦАА, ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

3.1 Хувьцаа гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн талаар

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлаар Монгол Улсын Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 23 дугаар зүйл болон 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.4, 61.1.16, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгож Монголын Хөрөнгийн Биржээр арилжих талаарх Гүйцэтгэх захирлын болон холбогдох мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлтийг үндэслэн дараах шийдвэрийг гаргасан.

- "Газар шим үйлдвэр" ХХК-ийг хувьцаат компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, Компанийн эрх, үүрэг хариуцлагыг шинээр бий болж байгаа хувьцаат компанид шилжүүлэх;
- Компанийн одоо гаргасан байгаа нэг бүр нь 0.11 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1.000.000.000 ширхэг энгийн хувьцаан дээр нэмж, компанийн нийт хувьцааны 16.54 хувьтай тэнцэх 198,113,207 ширхэг хувьцааг шинээр нэмж гарган олон нийтэд санал болгох;
- Үнэлгээний үйлчилгээг үзүүлэгч "БДО Аудит" ХХК-аас гаргасан "Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан", андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Новел Инвестмент УЦК" ХХК-ийн мэргэжлийн зөвлөгөөг харгалзан, компанийн нэмж гаргасан хувьцааны олон нийтэд санал болгох 198,113,207 ширхэг хувьцааны нэг бүрийн үнийг 53 төгрөгөөр, үнэт цаасны танилцуулганд тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд санал болгох;
- Олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж буй хувьцааг "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувьцааны нэгдүгээр ангиллаар бүртгүүлж, арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу тогтоосон үнийн аргаар нийтэд санал болгох;
- Анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь 10,499,999,971 төгрөг байхаар тогтоож, уг мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад дурдсан зориулалтаар зарцуулахаар тус тус шийдвэрлэсэн.

3.2 Нийтэд санал болгох хувьцааны тоо, ширхэг, санал болгох үнэ

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит бус хурлаар нийтэд санал болгох хувьцааны тоо, ширхэг, санал болгох үнийг үнэлгээний тайлан, андеррайтерийн компанийн зөвлөмжийг үндэслэн компанийн нийт гаргасан хувьцааг 1,198,113,207 ширхэг байхаар тогтож, үүнээс 198,113,207 ширхэг буюу 16.54 хувийг 53 төгрөгөөр олон нийтэд болон стратегийн хөрөнгө оруулагчид санал болгон гаргаж, 10,499,999,971 төгрөгийг татан төвлөрүүлэхээр шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн бүтцийг дараах байдалтай байхаар тогтсон.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10

3.3 Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны санал болгох үнийг тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг 2022 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу БДО-Аудит ХХК хийж гүйцэтгэсэн.

Хараат бус үнэлгээний байгууллага нь үнэлгээг үнэлгээний олон улсын стандартын дагуу орлогын хандлагын чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргыг ашиглаж, хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнөх болон арилжаалсны дараах байдлаар хийсэн.

Компани хувьцаагаа олон нийтэд санал болгох 100 хувийн өмчийн үнэ цэнийн үнэлгээ нь хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалахаас өмнө 52,643 сая төгрөгөөс 55,324 сая төгрөгийн хооронд, олон нийтэд санал болгож нээлттэй зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлсний дараа 61,933 (Жаран нэгэн тэрбум есөн зуун гучин гурван) сая төгрөгөөс 65,087 (Жаран таван тэрбум наян долоон) сая төгрөгийн хооронд байна гэж үнэлгээний байгууллага дүгнэсэн байна.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2.3 дахь заалтыг үндэслэн Газар шим үйлдвэр ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас шинээр гаргаж буй нэгж хувьцааны анхдагч зах зээлд нийтэд санал болгох үнийг 53 төгрөг байхаар шийдвэрлэж, 2022 оны 11 дүгээр сарын 23-ний өдрийн 6 тоот тогтоолоор баталгаажуулсан байна.

Үнэлгээний дэлгэрэнгүй мэдээллийг "Газар шим үйлдвэр" ХХК-ийн өмчийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан"-гаас харна уу.

3.4 Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагаа

Андеррайтер нь компанийн гаргасан нийт энгийн хувьцааны хоёрдогч зах зээл дээрх ханшийн тогтвортой байдлыг хангах болон хөрвөх чадварыг нэмэгдүүлэх ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 8.3-т заасны дагуу бусад үнэт цаасны компаниудтай гэрээний хүрээнд хамтран зохион байгуулна.

Андеррайтер нь компанийн гаргасан нийт энгийн хувьцааны хоёрдогч зах зээл дээрх хэт нийлүүлэлтээс сэргийлэх, ханш тогтворжуулах арга хэмжээг 6 сарын хугацаанд дараах нөхцөлөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- Хоёрдогч зах зээл дэх нийлүүлэлт: Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаас гаргагчийн дийлэнх хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг 1 жилийн хугацаанд тусгаарлах (lock-up) арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тус арга хэмжээ нь хоёрдогч зах зээлийн арилжаанд хэт нийлүүлэлт үүсэх, ханшид сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх бололцоотой.
- Нийтэд санал болгож буй хувьцааны 50 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад 6 сарын хугацаанд тусгаарлах (lock-up) нөхцөлтэйгөөр санал болгоно.
- Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээс өмнөх үеийн компанийн нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байсан этгээдийн хувьцааг 1 жилийн хугацаанд тусгаарлана.

Хоёрдогч зах зээл дээр хувьцааг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх

Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагаанд андеррайтер нь туслах андеррайтер болон үнэт цаас гаргагчтай хамтран хувьцааны хоёрдогч зах зээлийн ханш нийтэд анх санал болгосон үнээс 20-аас дээш хувиар буурсан эсвэл 60 хувиас дээш өссөн тохиолдолд 400 сая хүртэлх үнийн дүн бүхий үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ. Үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр уг хөтөлбөрийг санхүүжүүлэхгүй.

СЗХ БҮРТГЭВ №31
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх

Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаас гаргагчийн хоёрдогч зах зээл дээр хэт өндөр эрэлт үүсэх, ханшийн хэт хөөргөдөл бий болох тохиолдолд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хоёрдогч зах зээлд нийлүүлж болно. Үүнийг хэрэгжүүлэхдээ нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлөөр хэсэгчлэн чөлөөлж зах зээлд нийлүүлэх хэлбэрээр хөрвөх чадвар нэмэгдүүлэх ажиллагааг зохион байгуулна.

Түүнчлэн андеррайтер нь Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.5.3-т заасны дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас 100 сая төгрөг хүртэлх үнийн дүн бүхий хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авах, өөрийн харилцагчдад санал болгон худалдахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь хоёрдогч зах зээл дээрх хэт нийлүүлэлтийг бууруулах боломжтой гэж харж байна.

3.5 Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүтцийн өөрчлөлт

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 6 -р тогтоолоор олон нийтэд 198,113,207 ширхэг хувьцааг буюу нийт гаргасан хувьцааны 16.54 хувийг олон нийтэд санал болгон гаргаж, 10.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн энэхүү тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн өнөөгийн бүтэц дараах байдлаар өөрчлөгдөхөөр байна.

Хүснэгт-44

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Ц.Ганбат	510,000,000	51%	510,000,000	42.57%
Штеффэн Мэлцэр	150,000,000	15%	150,000,000	12.52%
Ц.Төгсөө	130,000,000	13%	130,000,000	10.85%
З.Байгалмаа	110,000,000	11%	110,000,000	9.18%
Д.Сэргэлэн	50,000,000	5%	50,000,000	4.17%
Г.Түвшинзаяа	50,000,000	5%	50,000,000	4.17%
Олон нийт			198,113,207	16.54%
Хувьцаа гаргасны дараа нийт дүн	1,000,000,000	100%	1,198,113,207	100%

3.6 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, үр ашгийн тооцоолол

Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөнд дурдсан хөрөнгө оруулалтын бодлого, зорилтуудыг хэрэгжүүлснээр импортын бүтээгдэхүүнийг орлох, өрсөлдөгч компаниудаас өртөг, үнийн хувьд бага, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээг хангаж, борлуулалтыг нэмэгдүүлж даршилсан ногоо, салат, компотын зах зээлд эзлэх хувийг 50 хувьд хүргэх, нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн, зах зээлд таниулж, зах зээлийн 20 хувийг эзлэх зорилтуудыг хэрэгжүүлнэ. Энэхүү зорилтуудыг хэрэгжүүлэхэд үнэт цаас гаргагч нь компанийн энгийн хувьцааны 16.54 хувийг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд санал болгон гаргаж, хөрөнгийн зах зээлээс 10.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Үнэт цаасны тухай хуулийн 12.9-ийг үндэслэн үнэт цаас гаргагч нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зарцуулалтын төлөвлөгөө гаргасан бөгөөд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг компанийн хувьд хамгийн өндөр өгөөж өгөхүйц төслүүдэд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт-45

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө		Сая.төг	Эзлэх хувь	Сая.төг	Хөрөнгө оруулалтанд эзлэх хувь
Хүнсний ногооны зоорь	Зоорины барилга	2,133	20.3%	5,538	52.7%
	3500 тн багтаамжтай зоорины тоног төхөөрөмж	1,695	16.1%		
	Ногоо ялгах, хатаах, савлах шугам	639	6.1%		
	Ногоо хадгалах модон хайрцаг	1,071	10.2%		
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт	Нухаш, чанамал, кетчуп, ундаа савлах шугам	466	4.4%	2,891	27.5%
	Майонез, соус, сүмс савлах шугам	699	6.7%		
	Сав баглаа боодол	226	2.1%		
	Хутгач машин	800	7.6%		
	Маркетинг идэвхжүүлэлтийн зардал	700	6.7%		
Бэлтгэх дамжлагын автоматжуулалт	Ногоо хальслах төхөөрөмж	300	2.9%	1,000	9.6%
	Ногоо угааж, хальслах шугам	700	6.7%		
Эргэлтийн хөрөнгө	Эргэлтийн хөрөнгө	1,070	10.2%	1,070	10.2%
Нийт		10,499	100%	10,499	100%

- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 52.7 хувийг ногооны зоорь барих төсөлд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд зоорь барьснаар чанартай хүнсний ногоог намрын улиралд хямд үнээр худалдан авч нөөцлөн жилийн турш бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болох юм. Ингэснээр үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүний өртөг буурч үнийн тогтвортой бодлогыг барих боломж бүрдэх юм. Үнийн тогтвортой бодлогыг баримталснаар өрсөлдөгч компаниудаас хямд үнэтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх, улмаар импортын хэмжээг бууруулж, экспортыг хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдэх боломжтой гэж үзэж байна.
- Салат, өргөст хэмх, компот гэсэн гол нэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, улмаар нухаш, чанамал, кетчуп, ундаа савлах шугам, майонез, соус, сүмс савлах шугам гэсэн том жижиг савалгаатай бүтээгдэхүүн савлах 2 төрлийн савалгааны шугам суурилуулж, шинэ бүтээгдэхүүнүүд болон бусад бүтээгдэхүүний идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг явуулахад татан төвлөрүүлсэн хөрөнгийн 27.5 хувийг зарцуулна.
- Бэлтгэх дамжлага буюу анхан шатны боловсруулалтын үйл ажиллагааг автоматжуулахад татан төвлөрүүлэх хөрөнгийг 9.6 хувийг зарцуулахаар төлөвлөж байна. Анхан шатны боловсруулалтыг автоматжуулснаар гар ажиллагаа багасаж үйлдвэрлэлийн бүтээмж өсөх боломжтой.
- Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн үлдэх 10.2 хувийг үйл ажиллагаанд шаардлагатай эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэхэд зарцуулж, үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангахад тус тус чиглэнэ.

Хүнсний ногооны иж бүрэн зоорины барилга: Үнэт цаас гаргагч нь Хан-Уул дүүргийн 4 хороонд байрлах 10,000 мкв газарт төмөр карказан хийцтэй сендвичин барилгыг татан төвлөрүүлсэн хөрөнгөөр барихаар төлөвлөж байна. Уг барилгын хэмжээ нь 57.5м*8,5м*7.6м байх бөгөөд дээврийн зузаан 30 см, ханын зузаан 20 см байх бөгөөд 500 тн-ийн багтаамжтай 4 тасалгаа, 300 тн-ийн 5 тасалгаатай ба ногоо ялгах, ангилах, савлах, ачаа ачих буулгах, үүдний гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Уг зоорины барилгыг үнийн саналууд авч судалгаа хийсний үр дүнд салбартаа туршлагатай "Түмэн төмөрт" ХХК-иар гүйцэтгүүлэхээр төлөвлөөд байна.

СӨХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГӨӨР БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Барилгын ерөнхий план зураглалыг үзүүлбэл:

Зураглал-5





- 3500 тн багтаамжтай зоорины тоног төхөөрөмж: Зоорины тоног төхөөрөмжийг судалгаа хийсний үр дүнд Европын Нидерланд улсын Allround компаниас авахаар төлөвлөж байна.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ

Зураглал-6



- Ногоо хүлээн авах, ялгах, савлах шугам: Ногоо хүлээн авах, ялгах, хатаах, савлах шугамыг мөн ногооны зооринд байрлуулах бөгөөд энэхүү шугам нь ногоо хүлээж авах бункер, ногоог зөөх шугам, ногоог ялгах шугам, өргөх, савлах гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Энэхүү шугамыг Европын Нидерланд улсын хүнсний ногоо боловсруулах болон хадгалах тоног төхөөрөмж үйлдвэрлэг 1955 онд байгуулагдсан энэ салбарт 70 гаруй жилийн туршлагатай Allround компаниас зоорины болон ногоо хүлээн авах, ангилж ялгах, савлах тоног төхөөрөмжүүдээ авахаар төлөвлөж байна.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ

Зураглал-7

1.Ногоо хүлээн авах бункер



2.Ногоо зөөх шугам



3.Ногоог ялгах шугам



4.Ногоо савлах төхөөрөмж



5.Өргөх төхөөрөмж



- Ногоо хүлээн авах бункер-1
- Ногоо зөөх шугам-1
- Ногоо ялгах шугам-1
- Ногоог модон хайрцагт савла төхөөрөмж -1
- Өргөх төхөөрөмж-1

- **Ногоо хадгалах модон хайрцаг:** Хүнсний ногоонуудыг зооринд тусгай зориулалтын модон хайрцагт хийж хадгалах бөгөөд зоорины нэг тасалгаанд 510 хайрцаг ногоо хадгална. Нийт 4 тасалгаанд зориулж 2,040 хайрцаг, 300 тн багтаамжтай 5 тасалгаанд 1,530 хайрцаг нийт 3,570 модон хайрцаг авахаар төлөвлөсөн. Модон хайрцаг нь 1,200 mm x 1,600 mm x 1,230 mm хэмжээтэй багтаамж нь ногоноосоо хамааруулаад 1 тн орчим, нэг модон хайрцгийн үнэ 300,000 төгрөг байхаар тооцоолсон.

Зураглал-8



Зураглал-9



"Хүнсний ногооны зоорь барих" төсөлд нийт дараах хөрөнгө оруулалт шаардлагатай.

Хүснэгт-46

Нэр	Дүн, төг
ЗООРИНЫ ГАДНА БАРИЛГА	2,133
3,500ТН БАГТААМЖТАЙ ЗООРЬ	1,695
НОГОО ЯЛГАХ, ХАТААХ, САВЛАХ ШУГАМ	639
МОДОН ХАЙРЦАГ /160СМ*120СМ*123СМ/	1,071
Нийт дүн	5,538

СЗХ ГАЗАРШИМ БҮРТГЭВ № 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч нь шинээр нухаш, кетчуп, соус, сүмс, майонез, чанамал, эрүүл мэндийн ундаа зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зөвхөн савлагааны болон хутгалтын машин нэмж суурилуулах шаардлага үүсээд байна. Зах зээлд шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонезын улсын хэмжээнд зах зээлийн багтаамж нь 2021 оны байдлаар 203 тэрбум төгрөг, бүтээгдэхүүний дийлэнх хувийг импортоор хангаж байгаа цаашид үндэсний үйлдвэрлэгч компаниуд дээрх зах зээлд нэвтрэн зах зээлийн хэмжээг өсгөх бүрэн боломж харагдаж байна.

Хүснэгт-47

Шинээр нэвтрэх зах зээл	Нухаш	Чанамал	Кетчуп, соус, сүмс	Майонез	Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	Нийт
Импорт	26,530	26,160	41,438	72,734	12,636	179,498
Дотоод	1,851	10,110	1,000	6,666	3,889	23,516
Нийт	28,381	36,270	42,438	79,400	16,525	203,014

Эх сурвалж: 2021 оны зах зээлийн судалгаа

График-56



Үнэт цаас гаргагчийн зүгээс дээрх бүтээгдэхүүний хөгжүүлэлт, судалгааг хийж, эхний бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж эхлээд байна. Тухайлбал 2021 оны намраас 5 төрлийн ногооны нухаш шинээр үйлдвэрлэж, худалдаанд гаргаж эхэлсэн боловч хил хорио, цар тахлаас болж сав баглаа тасарч цөөхөн тоогоор үйлдвэрлэсэн. 2022 оны намраас тогтмол үйлдвэрлэж худалдаанд гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт-48

	Бүтээгдэхүүний төрөл	2021 оны зах зээл сая/төг	2021 оны зах зээлд эзлэх хувь
1	Импорт нухаш	26,530	15%
2	Импорт чанамал	26,160	14%
3	Импорт кетчуп, соус, сүмс	42,438	24%
4	Импорт Майонез	72,734	40%
5	Импорт Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	12,636	7%
	Нийт	180,498	100%

Эх сурвалж: 2021 оны зах зээлийн судалгаа

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ДЭЭР ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагчийн дараагийн ээлжинд хүүхдэд зориулсан жимс ногооны нухаш, жимсний чанамал үйлдвэрлэх, түүнээс гадна кетчуп, соус, сүмс, майонез шинээр үйлдвэрлэхээр төлөвлөж, зах зээлийн судалгаа хийгээд байна. Хүүхдийн нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ зах зээлд нэвтэрснээр зах зээлийн багтаамж 299.1 тэрбум болж нэмэгдэх боломжтой юм.

- **Нухаш, чанамал, кетчуп, ундаа савлах шугам:** Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх ажлын хүрээнд нухаш, чанамал, кетчуп, эрч хүч эрүүл мэндийн ундаа савлах машин, мөн соус, сүмс, майонез гэсэн бүтээгдэхүүнүүд савлах гэсэн нийт 2 төрлийн савлагааны шугам шинээр авч суурилуулахаар төлөвлөж байгаа бөгөөд эдгээр бүтээгдэхүүнүүдийг уламжлалт шилэн савлагаанд савлахаас гадна хэрэглэгчдийн хэрэглээний чиг хандлага, бүтээгдэхүүний өртгийг бууруулах зорилгоор шинэ уутан савлагаанд савлахаар төлөвлөж байна.

Зураглал-10



- Нухаш, чанамал, кетчуп, ундаа савлах шугамын хүчин чадал: 2400-3600 уут/ц, машины хэмжээ-урт 4280мм*өргөн 970мм*өндөр 1500мм хэмжээтэй, савлах хэмжээ-80мл-300мл
- Майонез, соус, сүмс савлах шугамын хүчин чадал: 2400-3600 уут/ц, машины хэмжээ-урт 4570мм*өргөн 1050мм*өндөр 1500мм хэмжээтэй, савлах хэмжээ- 250мл-1000мл

Хүснэгт-49

Нухаш, чанамал, кетчуп, ундаа савлах шугамын хүчин чадал	**Үнэ/сая.төгрөг/**
Автомат савлах машин	261
Дүүргэх төхөөрөмж	34
Нэмэлт тоног төхөөрөмж	63
Машины багцын нийт үнэ	**358**
Тээвэр, татварын зардал	108
Нийт	**466**



СЭХ ГАЗАРШИМ БУРТГЭВ



Бүтээгдэхүүний уутан савлагаа нь орчин үеийн хүүхдийн болон хүнсний бүтээгдэхүүний тренд савлагаа бөгөөд явж явахад хялбар, хэмжээ багатай байдаг онцлогтой. Энэхүү савлагаанд хүүхдэд зориулсан нухаш, эрүүл мэндийн ундаа, жимсний чанамал, кетчуп, соус, майонез зэрэг бүтээгдэхүүн савлана.

Хүснэгт-50

Майонез, соус, сүмс савлах шугамы н хүчин чадал	Үнэ/сая.төгрөг/
Автомат савлах машин	392
Дүүргэх төхөөрөмж	51
Нэмэлт тоног төхөөрөмж	95
Машины багцын нийт үнэ	**538**
Тээвэр, татварын зардал	161
Нийт	**699**

Хүснэгт-51

	Идэвхжүүлэлтийн сувгууд	Үнэ /сая ₮/	Идэвхжүүлэх бүтээгдэхүүн
1	Сошиал медиа	100	Шинэ бүтээгдэхүүн Салат, Өргөст хэмх, Хөлдөөсөн ногоо, Шимт нухаш
2	Телевиз	300	Шинэ бүтээгдэхүүн Салат, Өргөст хэмх, Хөлдөөсөн ногоо, Шимт нухаш
3	ФМ радио	20	Шинэ бүтээгдэхүүн Салат, Өргөст хэмх, Хөлдөөсөн ногоо
4	Борлуулалтын урамшуулал	270	Шинэ бүтээгдэ хүүн Салат, Өргөст хэмх, Компот
5	Хэвлэмэл материал, танилцуулга	10	Шинэ бүтээгдэхүүн
	Нийт	700	

Сонгино хальслах төхөөрөмж:



Энэ төхөөрөмжөөр сонгиныг хальснаас салгаж цэвэрлэх төхөөрөмж, хоёр талын ишийг нь авдаг төхөөрөмж гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

Хүчин чадал: 500-700 кг/цаг

Хэмжээ: 1800*830*1800мм

Энэхүү шугам нь ногоо угаах төхөөрөмж, ногоо ялгах хэсэг, ногоо хальслах төхөөрөмж гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Хүчин чадал: 1200 кг/цаг



Хүснэгт-52

Бэлтгэх дамжлагын автоматжуулалт	Үнэ/сая.төгрөг/
Сонгино хальслах тоног төхөөрөмж	300
Ногоо угааж, хальслах тоног төхөөрөмж	700
Нийт	1,000

Төслийн хүрээнд нэвтрүүлэх шинэ бүтээгдэхүүний талаар: Үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгөөр 2 төрлийн савлагааны төхөөрөмж нэг хутгагч машин 19 хувийг шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд зарцуулахаар төлөвлөсөн. Уг бүтээгдэхүүнүүд нь эх орны хөрсөнд ургасан түүхий эдээр үйлдвэрлэсэн нэмэлт удаан хадгалах бодис агуулаагүй импортыг орлох үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн гэдгээрээ онцлог юм.

Хүснэгт-53

Бүтээгдэхүүний онцлог, давуу тал: Энэхүү жимс ногооны нухаш нь Монгол Улсад ургасан хулууны суурьтай, амт нь жимсний амт давамгайлсан, уутан савлагаа болон шилэнд савлагдана. Уутан савлагааны хэмжээ 110 мл, шилэн савлагааны хэмжээ 210 мл байна.6 сараас дээш насны том хүн хүүхэд бүх насныхан хэрэглэнэ.

Хүний өдөрт хоол хүнсээс авах эрдэс амин дэм, витамины хэрэглээг нөхөх зорилготой

Бүтээгдэхүүний нэр төрөл: Нийт 5 төрлийн нухаш үйлдвэрлэх бөгөөд "Хулуу, Чацаргана, Алим", " Хулуу, Чацаргана, Банана", "Хулуу, Гүзээлзгэнэ, Алим, Банана", "Хулуу, Үхрийн нүд, Банана", "Хулуу, Аньс, Банана, Алим" гэсэн төрөлтэй.





МОНГОЛЫН ХӨРӨНГӨ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Хүснэгт-54

Бүтээгдэхүүний онцлог, давуу тал: Чацаргана, нэрс, аньс зэрэг жимсний чанамлыг Монголын хөрсөнд ургасан жимсээр үйлдвэрлэх бөгөөд энэхүү жимсний чанамлын онцлог нь уутан савлагаа болон шилэнд савлагдана. Уутан савлагааны хэмжээ 300 мл, шилэн савлагааны хэмжээ 550 мл байна. Бүх насны хүн хэрэглэж болохоор онцлог.
Бүтээгдэхүүний нэр төрөл: Нийт 7 төрлийн чанамал үйлдвэрлэнэ. Чацарганы чанамал, Нэрсний чанамал, Гүзээлзгэний чанамал, Аньсны чанамал, Интоорын чанамал, Чавганы чанамал, Абрикосны чанамал 

Хүснэгт-55

	**Бүтээгдэхүүний онцлог, давуу тал:** Бүх насны хүн хэрэглэж болно. Энэхүү майонез нь 4 төрлийн савлагаатай байх бөгөөд энэ нь хэрэглэгчид өөрсдийн хэрэглээний хэмжээнд тааруулж худалдан авалт хийхэд тохиромжтой байх юм.
Бүтээгдэхүүний нэр төрөл:	Уутан савалгааны хэмжээ нь 250 мл, 500 мл, 1000 байна. Шилэн савлагааны хэмжээ 350 мл байна.

Хүснэгт-56

	**Бүтээгдэхүүний онцлог, давуу тал:** Кетчупийг энгийн болон халуун ногоотой гэсэн 2 төрлөөр үйлдвэрлэнэ. Бүх насны хүн хэрэглэж болох бөгөөд импортыг орлох үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн гэдгээрээ онцлог юм.
Бүтээгдэхүүний нэр төрөл:	Кетчуп нь уутан савлагаатай байна. Хэмжээ нь 250 мл хэмжээтэй байна. Энгийн болон халуун ногоотой гэсэн 2 төрөл байна.

"НОВЕЛ-ІНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ 6406617
ГАЗАР ШИМ ҮЙЛДВӨР ХХК

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Хүснэгт-57

	**Бүтээгдэхүүний онцлог, давуу тал:** Артишок эрүүл мэндийн ундааг шилэнд савлахаас гадна уутан савлагаанд савлана. Ингэснээр илүү хэрэглэхэд болон авч явахад хялбар болох юм. Артишок эрүүл мэндийн ундааг эрүүл хүмүүс эрүүл мэндээ сахин хамгаалахын тулд, эрүүл ч гэсэн хордож байгаа хүмүүс, хүний биед ямар нэгэн эмгэг өөрчлөлт гарч эхэлж байгаа хүмүүс хэрэглэх бөгөөд бүх төрлийн хордлого тайлах үйлчилгээтэй. Бүх насны хүн хэрэглэж болно.
Бүтээгдэхүүний нэр төрөл:	Уутан савлагаатай байна. Хэмжээ нь 100 мл хэмжээтэй байна. Зөгийн балтай болон зөгийн балгүй гэсэн 2 төрөл байна.

Үнэт цаас гаргагчийн зүгээс дээрх төслүүдийг санхүүжүүлэн хэрэгжүүлснээр борлуулалтыг дараах байдлаар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

Борлуулалтын орлогын төсөөлөл

Хүснэгт-58

	Бүтээгдэхүүний төрөл	Гүйцэтгэл			Төлөвлөсөн					
		2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он
1	Өргөст хэмх	4,635	6,714	9,107	10,627	12,336	14,187	16,315	18,762	21,577
2	Салат	7,910	11,455	15,539	17,604	21,049	24,207	27,838	32,013	36,815
3	Компот	1,888	2,734	3,710	4,370	5,025	5,779	6,646	7,642	8,789
4	Хөлдөөсөн ногоо	-	-	113	346	398	457	526	605	696
5	Нухаш	-	-	-		567	1,419	2,838	4,257	5,676
6	Чанамал	-	-	-		725	1,813	3,627	5,440	7,254
7	Кетчуп, сүмс, соус	-	-	-		424	2,121	4,243	6,365	8,487
8	Майонез	-	-	-		794	3,970	7,940	11,910	15,880
9	Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	422	612	717	632	826	1,322	1,834	2,478	3,305
	Нийт	14,856	21,514	29,186	33,579	42,144	55,275	71,807	89,472	108,479

Салат, өргөст хэмх, компотын зах зээлд 25% орчмыг эзэлж байгаа бөгөөд ирэх 5 жилд энэхүү зах зээлд эзлэх хувийг 50%-д хүргэх, шинээр орж байгаа нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонезын зах зээлд эзлэх хувийг 20%-д хүргэхээр төлөвлөөд байна. 2023 онд буюу үйлдвэрлэж эхэлсэн эхний жилд зах зээлийн 2%-д хүрэх бөгөөд дараагийн жилээс зах зээлийн 5%, 2025 онд 10%, 2026 онд 15%, 2027 онд 20% хүргэхээр төлөвлөж байна. Ингэснээр 2027 он гэхэд жилийн нийт борлуулалт 108,5 тэрбум болох юм.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ДЭЭР ХХК

СЗХ ГАЗАРШИМ он сар өдөр БҮРТГЭВ №1

2023 -01- 19 БҮРТГЭВ-03

Мөнгөн урсгалын тооцоо /сая.төгрөг/

Хүснэгт-59

Үзүүлэлтүүд	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он
Нийт ажиллагсдын тоо	192	219	224	226	231
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,348	281	840	7,250	17,662
1. Мөнгөн орлого					
1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	42,144	55,275	71,807	89,472	108,479
1.2 Шаардлагатай хөрөнгө оруулалт	10,500				
2. Мөнгөн зарлага					
2.1 Хөрөнгө оруулалт /Хүнсний ногооны зоорь/	5,538				
2.2 Хөрөнгө оруулалт /Бүтээгдэхүүн хөгжүүлэлт/	2,891				
2.3 Хөрөнгө оруулалт /Бэлтгэх дамжлагын автоматжуулалт/	1,000				
2.4 Хөрөнгө оруулалт /Урсгал/	1,070	1,000	1,000	1,000	1,000
2.5 Бараа материал худалдан авахад төлсөн	29,501	36,813	44,951	55,473	66,172
2.6 Ашиглалтын зардалд төлсөн	950	1,093	1,256	1,445	1,662
2.7 Ажиллагчдад төлсөн	4,107	4,723	5,432	6,246	7,183
2.8 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,443	1,659	1,908	2,195	2,524
2.9 Татварын байгууллагад төлсөн	2,500	2,875	3,306	3,802	4,373
2.10 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	900	1,035	1,190	1,369	1,574
2.11 Хүүний төлбөрт төлсөн	1,200	1,200	500		
2.12 Зар сурталчилгаа, идэвхижүүлэлтэнд төлсөн	700	805	926	1,065	1,224
2.13 Бусад мөнгөн зарлага	1,000	1,150	1,323	1,521	1,749
2.14 Төлсөн ногдол ашиг	1,911	2,363	3,605	4,945	6,299
Нийт мөнгөн орлогын дүн	54,992	55,556	72,647	96,722	126,141
Нийт мөнгөн зарлагын дүн	54,711	54,716	65,397	79,060	93,760
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	281	840	7,250	17,662	32,381

"НОБЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЗХ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Орлогын тайлангийн төсөөлөл /сая.төгрөг/

Хүснэгт-60

№	Үзүүлэлт	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он	2026 он	2027 он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	29,186	33,579	42,144	55,275	71,807	89,472	108,479
1.1	Өргөст хэмх		10,627	12,336	14,187	16,315	18,762	21,577
1.2	Салат		17,604	21,049	24,207	27,838	32,013	36,815
1.3	Компот		4,370	5,025	5,779	6,646	7,642	8,789
1.4	Хөлдөөсөн ногоо		346	398	457	526	605	696
1.5	Нухаш			567	1,419	2,838	4,257	5,676
1.6	Чанамал			725	1,813	3,627	5,440	7,254
1.7	Кетчуп, сүмс, соус			424	2,121	4,243	6,365	8,487
1.8	Майонез			794	3,970	7,940	11,910	15,880
1.9	Эрч хүч/эрүүл мэндийн ундаа		632	826	1,322	1,834	2,478	3,305
2	Борлуулалтын өртөг	18,461	21,826	26,551	32,612	41,648	50,999	61,833
3	Нийт ашиг (алдагдал)	10,725	11,753	15,593	22,663	30,159	38,473	46,646
4	Борлуулалт, маркетингийн зардал	2,153	2,351	2,950	3,869	5,026	6,263	7,594
5	Ерөнхий ба удирдлагын зардал	1,749	2,069	3,302	3,926	4,308	5,368	6,442
6	Бусад зардал	663	40	40	45	45	45	45
7	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,570	7,294	9,301	14,822	20,779	26,797	32,565
8	Орлогын татварын зардал	927	923	1,425	2,806	4,295	5,799	7,241
9	Татварын дараахь ашиг (алдагдал)	5,643	6,370	7,876	12,017	16,484	20,997	25,324

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ 5436117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАРШИМ ҮЛДВЭР ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГӨӨР
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

3.7 Нийтэд санал болгож буй үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

3.7.1 Хувьцаа эзэмшигчийн эрх

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг хуваалцахаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл болон Компанийн дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдан авах;
- Хувьцаа эзэмшигч нь компаниас доорх мэдээллийг шаардан авах эрхтэй. Үүнд: Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;
- Компанийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн дүрэм журмаар тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
- Компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн эцэг/эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, түүний эзэмшлийн хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардах эрхтэй бөгөөд үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хариуцна
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх багтана.

3.7.2 Хувьцаа эзэмшигчийн үүрэг

- Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх
- Нийт гаргасан хувьцааны таваас дээш хувийг данган авах болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай Компанид бичгээр мэдэгдэх
- Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 заалтад зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг орно.

3.8 Ногдол ашгийн бодлого

Энэхүү ногдол ашгийн бодлогыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Компанийн засаглалын кодекс, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6-р сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журам болон холбогдох бусад хууль тогтоомж, үнэт цаас гаргагчийн дүрэмд үндэслэн батлав.

Ногдол ашгийн бодлого нь нэг талаас үнэт цаас гаргагчийн ашгийг зохистой хэмжээнд хувьцаа эзэмшигчдэд шууд хуваарилах, нөгөө талаас үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган, байгууллагын ирээдүйн өсөлтийг бий болгох гэсэн хоёр үндсэн зорилтын тэнцвэртэй байдлыг хангахад чиглэх бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн цэвэр ашгийн 30 -аас доошгүй хувийг ногдол ашиг хэлбэрээр тараах бодлогыг баримтална.

БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ЗАХ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Ногдол ашиг тооцох зарчим

Ногдол ашгийг тооцохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,
- Компанийн засаглалын стандартыг дагаж мөрдөх,
- Ногдол ашгийн тооцоо, төлбөрийн ил тод байдлыг хангах,
- Хувьцаа эзэмшигчдийн богино хугацааны болон урт хугацааны ашиг сонирхлын зохистой тэнцвэрийг хадгалах,
- Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын сонирхол, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд анхаарах,
- Ногдол ашиг үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулалт татах гол үзүүлэлтүүдийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрөх.

Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хуваарилахдаа дараах хүчин зүйлсийг тооцно. Үүнд:

- Хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагын шаардлага,
- Тухайн жилийн болон хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэл,
- Бизнесийн өсөлт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө,
- Тухайн үеийн болон хүлээгдэж буй өөрийн хөрөнгийн хүрэлцээ цаашид дагаж мөрдөх зохицуулалт ба өсгөх шаардлага,

Үнэт цаас гаргагч нь дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд ногдол ашиг хуваарилах боломжтой. Үүнд:

- Ногдол ашиг төлсний дараа үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадвартай байх,
- Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилсны дараа холбогдох санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангаж байх,
- Нэг төрлийн хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ нь ижил байх бөгөөд тухайн төрлийн нийт хувьцаанд хуваарилахаар тооцогдсон ногдол ашгийн дүнг тухайн төрлийн хувьцааны нийт тоонд хуваасантай тэнцүү байна.
- Халаасны хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй, төлөхгүй.

Ногдол ашиг хуваарилах, шийдвэр гаргах: Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор гаргаж, Хувьцаа эзэмшигчдэд танилцуулна. Уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг хуваарилах өдөр зэргийг заана. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчийг бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлно. Зарласан болон тараасан ногдол ашиг хуваарилах хугацаандаа тодорхой хувьцаа эзэмшигчдэд давуу эрх олгохгүй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд тайлагнана. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацааны татварын дараах ашгийн 30-аас доошгүй хувийг ногдол ашиг болгон тараах бодлогыг баримтална.

Ногдол ашгаас тооцогдох татвар: Ногдол ашгаас Монгол Улсын татварын хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасан журмын дагуу татвар ногдуулна. Хэрэв ногдол ашиг хуваарилах хугацаанд татварын хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол үнэт цаас гаргагч нь ногдол ашгаа олгохдоо тухайн төлбөр хийх үеийн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хууль тогтоомжийн дагуу зохих татварыг тооцоолж өөрчлөлт оруулна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ШИНЭЭР ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОН ХУДАЛДАХ АЖИЛЛАГАА

4.1. Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох, худалдах хэлбэр, арга

УИХ-аас 2013 онд баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-аар үнэт цаас гаргагч нь гаргасан хувьцаагаа олон нийтэд санал болгохдоо арилжаа эрхлэх байгууллага болон ... анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахаар зохицуулагдсан. Андеррайтерийн компани болон үнэт цаас гаргагчаас хамтран холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэн нийтэд 16.54 хувийг хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд санал болгон арилжихаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлээд байна.

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг тогтоосон үнийн арга ашиглан санал болгох үнийг үнэлгээний тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт тус тус үндэслэн 53 төгрөгөөр анхдагч зах зээлд санал болгохоор тогтсон. Тогтоосон үнийн арга гэдэг үнэт цаас гаргагч, андеррайтерийн компаниас хувьцааны санал болгох үнийг тогтоож, тухайн үнээр санал болгон худалдаж, захиалга давсан нөхцөлд хувь тэнцүүлэн хуваарилах арга юм. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-аар үнэт цаас гаргагч, андеррайтерийн компани анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнийн арга ашиглан зохион байгуулахаар тохиролцсон нөхцөлд андеррайтерийн компани эсхүл арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах зохицуулалттай.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар үнэт цаас гаргагч нь нийтэд анх удаа санал болгож буй үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтийг арилжаа эрхлэх байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороонд нэгэн зэрэг гарган, Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн талаарх шийдвэр гаргасан нөхцөлд олон нийтэд санал болгох эрх нээгдэнэ.

Үнэт цаас гаргагч "Газар шим үйлдвэр" ХХК болон андеррайтерийн "Новел Инвестмент ҮЦК" ХХК нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор батлсан Үнэт цаасны бүртгэлийн журам, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлсан Үнэт цаасны бүртгэлийн журам, болон Биржийн ТУЗ-ийн 2018 оны 15 дугаар тогтоолоор батлсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу явуулна.

Андеррайтер болон үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжааг дараах байдлаар зохион байгуулна.

Схем 10:



БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03

4.2. Хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилах хуваарь

Андеррайтер болон үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлд олон нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны 50 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдэх 50 хувийг олон нийтэд хуваарилна.

Стратегийн хөрөнгө оруулагч: Стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт дараах хоёр нөхцлийн аль нэгийг хангасан хөрөнгө оруулагчдыг оруулна. Үүнд:

- Үнэт цаас гаргагчтай бизнесийн болон хамтын ажиллагаатай түгээлтийн суваг, борлуулалтын цэг зэрэг харилцагч иргэд, аж ахуйн нэгж болон үнэт цаас гаргагчаас бизнесийн ирээдүйн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлэхүйц гэж тооцсон хөрөнгө оруулагчид;
- 50-500 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах захиалга өгсөн хөрөнгө оруулагчид;

Стратегийн хөрөнгө оруулагч нь үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш өөрийн эзэмшиж буй үнэт цаасаа 6-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах нөхцлийг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй.

Олон нийт: Олон нийт гэдэг нь стратегийн хөрөнгө оруулагчдаас бусад хөрөнгө оруулагчдыг тооцно.

- Бусад хөрөнгө оруулагч

Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт

Хүснэгт-61

Хөрөнгө оруулагчид	Нийтэд санал болгож буй хувьцаанаас санал болгох хувь	Санал болгох хувьцааны тоо	Санал болгох үнэ (төгрөг)	Татан төвлөрүүлэх дүн
Стратегийн	50%	99,056,604	53	5,250,000,012
Олон нийт	50%	99,056,603	53	5,249,999,959
Нийт	100%	198,113,207		10,499,999,971

Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг 100% биелүүлэх зарчмыг баримтлах ба бусад хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцааны анхдагч зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн захиалгыг биелүүлэх зарчмаар хуваарилалтыг гүйцэтгэнэ.

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОНЫ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГӨВ-03

4.2.1 Анхдагч зах зээлд арилжих зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг арилжаа эрхлэх болон Хороонд нэгэн зэрэг гаргах бөгөөд арилжаа эрхлэх байгууллага болон зохицуулагч байгууллагууд үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг олон нийтэд санал болгон арилжаалах боломжтой.

Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын гурваас доошгүй хоногийн өмнө энэ талаар мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороонд гаргах бөгөөд тус мэдэгдлийг хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авахад бэлэн болно.

Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, анхдагч зах зээлийн арилжааг эхлэх, дуусгах өдрийг товлон арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж, тус байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авч, арилжааг зохион байгуулан, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг биржийн дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулах хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын гурван өдөрт багтаан холбогдох талуудад хүргүүлнэ.

4.2.2 Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах хуваарь

Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаас бүртгэлийн журам"-аар үнэт цаасыг бүртгэж, бүртгэсэн тогтоолоор үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалахыг зөвшөөрсний дараа анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөнд заасан хугацаанд үнэт цаасыг нийтэд танилцуулах ажиллагааг дараах байдлаар зохион байгуулна.

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үнэт цаасны мэдээллийг хүргэх;
- Стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчтай тусгайлан уулзалт зохион байгуулах;
- Нийтэд зориулсан танилцуулга уулзалт зохион байгуулах;
- Үнэт цаасны танилцуулга, хураангуй танилцуулгыг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах;
- Олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулах;
- СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.4-т заасны дагуу олон нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнөх хугацаанд стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад танилцуулж болно;
- Үнэт цаасыг танилцуулах маркетингийн төлөвлөгөөний дагуу бусад арга хэлбэрээр танилцуулна.

4.2.3 Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга өгөх заавар

Үнэт цаасыг нийтэд санал болгох үнэт цаасны бүртгэлд бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр гарсны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь арилжаа зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган тогтоосон үнээр захиалгын бүртгэлийн эхлэх болон дуусах хугацааг тодорхойлж, өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

Үнэт цаас гаргагч болон андеррайтер нь тогтоосон хугацаанд анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах бэлтгэлийг хангана. Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөний дагуу анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэн, захиалгын санг бүрдүүлнэ.

Хөрөнгө оруулагч нь дараах зааврын дагуу үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжаанд оролцоно.

СЗХ
ГАЗАРШИМ
ЬҮРГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Зураг-59



Үнэт цаас гаргагч нь дараах хуваарийн дагуу үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулна.

Үнэт цаасны данс нээлгэх

Үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь үнэт цаасны данстай бол өөрийн харилцдаг үнэт цаасны компаниар дамжуулан үнэт цаас гаргагчийн хувьцаа худалдан авна.

Хэрэв үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь үнэт цаасны дансгүй бол арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаасны компаниар дамжуулан цахимаар болон биечлэн үнэт цаасны данс нээх боломжтой. Уг данс нь ажлын 1-2 хоногийн дотор нээгдэнэ.

Мөнгө байршуулах Андеррайтерийн компанийн харилцагчдын хувьд

Хэрэв хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчид андеррайтерийн үйлчилгээ үзүүлж буй үнэт цаасны компанийн харилцагч бол андеррайтерийн компанийн өгсөн зааврын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөө байршуулна.

Бусад үнэт цаасны компанийн харилцагчдын хувьд

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкаар дамжуулан "ҮЦТХТ" ХХК-д бүртгэлтэй өөрийн нэр дээрх дансанд дараах зааврын дагуу үнэт цаас гаргагчийн хувьцаа худалдан авах мөнгөө байршуулна.

Бусад үнэт цаасны компанийн харилцагчдын мөнгө байршуулах заавар

Хүснэгт-62

Гүйлгээний заавар	
Хүлээн авагч банк:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв /95 кодтой банк/
Хүлээн авах данс:	____(*ҮЦК-ийн код*)_____ *(Харилцагчийн үнэт цаасны дансны* дугаар)
Хүлээн авагч:	Харилцагчийн нэр
Шилжүүлэх дүн	Худалдан авах үнийн дүн + ҮЦК -ийн арилжааны шимтгэл
Утга:	Овог нэр, регистрийн дугаар

Үнэт цаасны анхдагч зах зээлд оролцох гэж буй этгээд нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний шимтгэлийг төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын шимтгэлийн дүн багтсан болно. Үнэт цаасны компаниудын шимтгэлийн хувь нь харилцан адилгүй бөгөөд уг хувиар хувьцаа худалдан авах үнийн дүнд нэмж байршуулахыг анхаарна уу.

4.2.4 Захиалга өгөх

Хөрөнгө оруулагч нь өөрийн үнэт цаасны бүртгэлтэй компаниар дамжуулан үнэт цаас гаргагчийн хувьцаа худалдан авах захиалгыг биеэр болон цахимаар өгөх боломжтой. Үнэт цаасны компаниуд нь хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан хувьцаа худалдан авах захиалгыг IPO системд шивснээр захиалга баталгаажна. Анхдагч зах зээлийн захиалгыг IPO системд бүртгэх хугацаа Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.3-т заасны дагуу ажлын 5 хоног байна.

4.2.5 Захиалга биелэгдэх

Үнэт цаас гаргагчийн анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөөнд тусгаснаар хөрөнгө оруулагчдын эрэлтийн дагуу андеррайтер нь хуваарилалтыг гүйцэтгэж, нийлүүлэлтийг гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагчийн стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг 100% биелүүлэх ба бусад хөрөнгө оруулагчдад санал болгох хувьцааны анхдагч зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд хувь тэнцүүлэн захиалгыг биелүүлэх зарчмыг баримтлан хуваарилалтыг гүйцэтгэнэ.

4.3 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг хөрөнгө оруулагчдад худалдаж, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийн хамт Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.

Санхүүгийн зохицуулах хороо нь үнэт цаас гаргагчийн арилжааны тайланг ажлын 3 өдөрт багтаан хянан үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагааг амжилттай явагдсан гэж үзвэл "ҮЦТХТ" ХХКд өмчлөх эрхийн бүртгэл хийх, арилжаа эрхлэх байгууллагад хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх талаарх зөвшөөрлийг олгодог.

"ҮЦТХТ" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрлийн дагуу ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийж, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэнэ.

"ҮЦТХТ" ХХК-ийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэл хийгдсэнээр арилжаа эрхлэх байгууллага нь ажлын 2 өдөрт багтаан үнэт цаас гаргагчийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх ажиллагааг зохион байгуулна. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа арилжаа эрхлэх байгууллагад төлөөтэй арилжаалах, нэмж худалдан авах боломж нээгдэнэ.

СЗХ БҮРТГЭВ 1
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭСЭН-03

ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГА, ТЭДГЭЭРИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээний үйлчилгээг "БДО Аудит" ХХК, хууль зүйн зөвлөх үйлчилгээг Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси ХХН нь тус тус үзүүлсэн бөгөөд хууль болон үнэлгээний компанийн талаар товч танилцуулгыг хүргэвэл.

5.1 Үнэлгээний компанийн танилцуулга

БДО нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. Тус компани нь дэлхийн 164 оронд өөрийн 1,713 салбар оффисоор дамжуулан 95,414 гаруй ажилчидтай үйл ажиллагаа явуулж байна. БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотноо БДО Монгол Нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай Итгэлт Аудит ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан.

БДО Монгол нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд зөвлөх үйлчилгээний БДО Консалтинг ХХК, аудит ба баталгаажуулах үйлчилгээний БДО Аудит ХХК болон татварын цогц үйлчилгээний БДО Такс ТМЗ ХХК нэрийн дор 5 партнер, 55 орчим ажилчидтай үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь уул уурхай, үйлдвэрлэл, банк санхүү, техник технологи гэх мэт Монгол улсын гол салбаруудад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.

БДО Аудит ХХК-ийн үнэлгээний үйлчилгээний хэлтэс нь өнгөрсөн хугацаанд Мандал даатгал ХК, Ард даатгал ХК, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Кредит ХК, Хөвсгөл Алтандуулга ХК, БогдБанк ХК, ХаанБанк ХХК, ХасБанк ХХК-иудын IPO-д зориулсан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээнд ажилласнаас гадна АПУ ХК-д Хэйнекэний Монгол дах бизнесийг нэгтгэх үеийн бизнесийн үнэлгээ болон янз бүрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хаалттай компаниудад бизнесийн үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлсэн арвин туршлагатай компани юм.

Үнэлгээний үйлчилгээний гэрээний танилцуулга

БДО Аудит ХХК нь 2021 оны 6 сарын 24-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан бизнесийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд Олон Улсын Үнэлгээний Стандарт, Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын дагуу үнэт цаасны зах зээл дээр шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд зориулан Үнэт цаас гаргагчийн 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргахаар тусгасан байна.

Гэрээний хүрээнд Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн болон бизнесийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд эрх бүхий байгууллагуудаас баталсан холбогдох журам, стандартын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх зах зээлийн үнэ цэнэ тодорхойлоход чиглэсэн хөрөнгийн үнэлгээ хийх, тэдгээрт тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах, үнэлгээ хийхтэй холбогдох ажиллагаа хийх бүрд тэмдэглэл хөтлөх, ажлын явцын үр дүн, гарч болох эрсдэл, нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл өгөх, гэрээт ажлыг гүйцэтгэх явцад аливаа байдлаар сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд даруй мэдэгдэх, үйлчлүүлэгчийн эрх, ашиг хууль ёсны сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэг хүлээсэн байна.

Гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь Үнэлгээний компанид гэрээт ажилтай холбоотой Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, удирдлагын дотоод мэдээлэл зэрэг бүхий л мэдээлэл, шаардлагатай нэмэлт баримт, материалыг шаардсан тухай бүрд нь бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг үзүүлэх; үнэлгээний байгууллагыг өөрийн байранд нэвтрэх, уулзалт хийх, дүгнэлт гаргахад шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах зэрэг ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлын зохион байгуулах үүргүүд тус тус багтсан байна.

Үнэлгээний компаний товч дүгнэлт

"Газар шим Үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох ажлыг "BDO аудит" ХХК хариуцан хөндлөнгийн хараат бус үнэлгээний дүгнэлтийг хийсэн.

"BDO аудит" ХХК нь үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо орлогын хандлагын Ирээдүйн мөнгөн урсгалыг хорогдуулах аргыг ашигласан бөгөөд гарсан үр дүнг бизнес төлөвлөгөөнд тусгасан ногдол ашгийг ашиглан Ногдол Ашгийн Хорогдуулах загвар болон Зах зээлийн хандлагын Жишиг Компанийн Арга Зүйг ашигласан бөгөөд үнэлгээний дүгнэлтийн дээд, доод хүрээг тооцохдоо дараах алхмуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагчиийн "Ионголын хөрөнгийн бирж" ТӨХК дээр шинээр анх удаа хувьцаа гаргах төлөвлөгөөнд үндэслэн үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-ийн суурь хувилбар болон 18.6%-ийн хорогдуулах хувь (Капиталын жинлэсэн дундаж өртөг)-ийг ашиглан үнэлгээний орлогын хандлагын Байгууллагад хамаарах чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулан тооцоход IPO гаргасны дараах байдлаарх (post-money) байгууллагад хамаарах үнэ цэнэ нь 76,356 сая төгрөг байна.
2. Энэхүү тогтоосон байгууллагын үнэ цэнийг компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан хянах хяналтын эрх мэдэлтэй хувьцаа эзэмшигчдэд хамаарах байгууллагын үнэ цэнэ(БҮЦ) гэж үзэж тухайн дүнгээс хяналтгүйн хөнгөлөлт буюу жижиг хувьцаа эзэмшигчдэд хамаарах хувьцааны хямдруулалтыг олон улсын судалгааны эх сурвалжид суурилан гутранги төсөөлөлд өмчийн үнэ цэнийн 15.5 хувиар, өөдрөг төсөөлөлд БҮЦ-ийн 10.8 хувиар тус тус сонгож хассанаар байгууллагын үнэ цэнийг 64,960 сая төгрөгөөс 68,114 сая төгрөгийн хооронд байх үндэслэлтэй гэж тогтоосон байна;
3. Дараа нь байгууллагын үнэ цэнийн дээд ба доод утгаас үнэлгээний өдрөөрх цэвэр өр(Нийт банкны зээлээс мөнгөний үлдэгдэл хассан дүн)-ийг хассанаар IPO гаргасны дараах байдлаар 100%-ийн өмчийн үнэ цэнэ нь 61,933 (Жаран нэгэн тэрбум есөн зуун гучин гурав) сая төгрөгөөс 65,087 (Жаран таван тэрбум наян долоо) сая төгрөгийн хооронд байхаар гарсан ба дундаж үнэлгээ 63,510 (Жаран гурван тэрбум таван зуун арав) сая төгрөг байна гэж дүгнэжээ. Дээрх үнэлгээнээс IPO-гоос босгох санхүүжилтийг хасвал IPOийн өмнөх (pre-money) байдлаар тус компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн үнэ цэнэ нь 51,693 сая төгрөгөөс 54,325 сая төгрөгийн хооронд гарсан байна.

Хүснэгт-63

Үзүүлэлт	Нэгж	Доод хязгаар	Дээд хязгаар
IPO-ийн өмнөх 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ	Сая.төг	51,693	54,325
IPO-ийн өмнөх хувьцаа эзэмшигчдийн өмчийн дансны үнэ цэнэ	Сая.төг	23,559	23,559
IPO гаргахын өмнөх хувьцааны тоо (200000*5000)	Сая.шир	1,000,000,000	
IPO-ийн өмнөх ;өмчийн ЗЗҮЦ / Дансны үнэ харьцаа	Харьцаа	2.2x	2.3x
IPO-ийн өмнөх нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ	Төг	52.64	55.32
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо	Сая.ширхэг	198,113,207	
IPO-оос босгох санхүүжилт	Сая.төг	10,240	10,762
Нэгж хувьцааг олон нийтэд санал болгох хувьцааны үнэ	Төг	51.69	54.32
IPO-ийн дараах хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ	Сая.төг	61,933	65,087
IPO-ийн дараах хувьцаа эзэмшигчдийн өмчийн дансны үнэ цэнэ	Сая.төг	33,799	34,320
IPO-ийн өмнөх өмчийн ЗЗҮЦ/Дансны үнэ харьцаа	Харьцаа	1.8x	1.9,x
IPO-ийн дараах нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ	Төг	51.7	55.3

Хүснэгт-64

IPO-д зориулсан үнэлгээ	Нэгж	Үнэ цэнийн хүрээ	
		Дээд	Доод
Эрсдэлийн өгөөжийн хувь хэмжээ	%	12.5%	
Өмчийн эрсдэлийн шагнал	%	9.9%	
Дахин хөшүүрэгдсэн бета	коэф	0.58	
Тухайн компанид хамаарах эрсдэлийн шагнал	%	2.0%	
Өмчийн өртөг	%	20.2%	
Өрийн татварын өмнөх өртөг	%	14.3%	
Татварын үр ашигт хувь	%	18.5%	
Өрийн татварын дараах өртөг	%	11.7%	
Капиталын бүтцэд өмчийн капиталын эзлэх хувь	%	80.8%	
Капиталын бүтцэд өрийн капиталын эзлэх хувь	%	19.2%	
Капиталын жинлэсэн дундаж өртөг	%	18.6%	
Урт хугацааны тогтмол өсөлт	%	5.0%	
Хувьцаа эзэмшигчдийн өмч (Үнэлгээний өдрөөр)	Сая.төг	23,559	
2022 оны хүлээгдэж буй цэвэр ашиг	Сая.төг	5,312	
2027 он хүртэлх ЧМУ -ын өнөөгийн үнэ цэнэ	Сая.төг	22,946	
Терминал үнэ цэнийн ӨҮЦ	Сая.төг	53,410	
Байгууллагын зах зээлийн үнэ цэнэ (IPO-н дараах байдлаар)	Сая.төг	76,356	
Жижиг хувьцаа эзэмшигчид хамаарах хяналтгүйн хөнгөлөлт	%	10.8%	15.5%
Хяналтгүйн хөнгөлөлтийн дараах Байгууллагын үнэ цэнэ (EV):IPO -н дараах байдлаар	Сая.төг	68,114	64,960
Үнэлгээний өдрөөрх цэвэр өр	Сая.төг	3,027	3,027
Хяналтгүй хувь оролцоонд хамаарах 100 % хувьцаа эзэмшигчдийн өмчийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ (Equity Value): IPO-н дараах байдлаар	Сая.төг	65,087	61,933
IPO-оор олон нийтэд санал болгох хувь	Хувь	16.54 %	16.54 %
Хяналтгүй хувь оролцоонд хамаарах 100 % хувьцаа эзэмшигчдийн өмчийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх байдлаар)	Сая.төг	55,324	52,643

IPO гаргасны дараах үнэлгээний хүрээг ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргын үр дүнг зах зээлийн хандлагын ЖКАЗ аргыг (хувьцааны арилжаа нь хяналтын эрхгүй жижиг хувьцаа эзэмшигчид байдаг учраас хяналтгүйн хөнгөлөлт тооцохгүй) болон орлогын хандлагын НАХ загвар болон Тохируулсан өнөөгийн үнэ цэнийн арга (Орлогын хандлагын үндсэн төсөөлөл нь хяналтын эрх мэдэлтэй одоогийн хувьцаа эзэмшигчдийн төсөөлөл учраас хяналтгүйн хөнгөлөлтийг өмчид хамаарах 15.5%-ийг ашигласан)-ыг ашиглан баталгаажуулсан.

- **Ногдол ашиг хорогдуулах загвар:** Газар шим Үйлдвэр ХХК-ийн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022- 2027)-д тусгаснаар 2022 оноос эхлэн жил бүр ногдол ашиг хуваарилахаар төлөвлөсөн байна. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн үнэ цэнийн хүрээг тооцоолохын тулд ногдол ашгийн төсөөллийг ашиглан НАХ загвараар үнэ цэнийн хүрээг тооцоолсон. НАХ загвараар тооцоолоход, IPO гаргасны дараах нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 51,058 сая төгрөгөөс 79,716 сая төгрөгийн хооронд байна гэж тооцоолсон нь дүгнэлт гаргасан үр дүнг дэмжиж байна.
- **Тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга:** "Газар шим Үйлдвэр" ХХК-ийн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-д тусгасан чөлөөт мөнгөн урсгал болон хөшүүрэггүй КЖДӨ-ийг ашиглан Тохируулсан өнөөгийн үнэ цэнийн аргаар үнэлгээний үр дүнг дахин баталгаажуулсан. Энэ загвараар тооцоолоход, IPO гаргасны дараах нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 63,000 сая төгрөгөөс 71,639 (суурь төсөөллөөр 66,985) сая төгрөгийн хооронд гарсан.
- **Жишиг компанийн арга зүй:** "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй, ТОП20 индексэд багтдаг хүнсний салбарын ижил төстэй 5 компанийг жишиг компани болгон сонгосон. IPO гаргасны дараах байдлаар: Жишиг компаниудын 2021 оны тайлант жилийн гүйцэтгэлд суурилсан Үнэ/Ашиг үржүүлэгчийг үнэлгээний өдрөөрх зах зээлийн үнэлгээнд гарсан өөрчлөлтөөр засварлан, компани тус бүрийн цэвэр ашгийн маржинаас Үнэ/Ашиг харьцааны хамаарах хамаарлын шинжилгээгээр тохируулснаар Газаршим Үйлдвэр ХХК-д дүйцэх Үнэ/Ашиг үржүүлэгчийг 12.4х байх нь үндэслэлтэй хэмээн тооцож, 2022 оны хүлээгдэж буй цэвэр ашигт суурилан шинжлэхэд тус компанийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ 64,996 сая төгрөг байхаар байна.
- Жишиг компаниудын 2021 оны тайлант жилийн гүйцэтгэлд суурилсан Үнэ/Борлуулалт үржүүлэгчийг үнэлгээний өдрөөрх зах зээлийн үнэлгээнд гарсан өөрчлөлтөөр засварлан, компани тус бүрийн өмчийн өгөөжөөс Үнэ/Борлуулалт харьцааны хамаарах хамаарлын шинжилгээгээр тохируулснаар "Газар шим Үйлдвэр" ХХК-д дүйцэх Үнэ/Борлуулалт үржүүлэгчийг 2х байх нь үндэслэлтэй хэмээн тооцож, 2022 оны хүлээгдэж буй борлуулалтад суурилан шинжлэхэд тус компанийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ 64,996 сая төгрөг байхаар байна.
- Жишиг компаниудын 2021 оны тайлант жилийн гүйцэтгэлд суурилсан БҮЦ/ХТӨА үржүүлэгчийг үнэлгээний өдрөөрх зах зээлийн үнэлгээнд гарсан өөрчлөлтөөр засварлан, компани тус бүрийн ХТӨА-ийн маржинаас БҮЦ/ХТӨА харьцааны хамаарах хамаарлын шинжилгээгээр тохируулснаар "Газар шим Үйлдвэр" ХХК-д дүйцэх БҮЦ/ХТӨА үржүүлэгчийг 11.5х байх нь үндэслэлтэй хэмээн тооцож, "Газар шим Үйлдвэр" ХХК-ийн 2022 оны хүлээгдэж буй ХТӨА-т суурилан шинжлэхэд тус компанийн цэвэр өрийг хассаны дараах 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ 68,049 сая төгрөг байхаар байна.
- Дээр дурдсанчлан, Зах зээлийн хандлагын 3 өөр үржүүлэгчид суурилсан шинжилгээгээр үнэлгээний өдрөөрх Газаршим Үйлдвэр ХХК-ийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 64,996 сая төгрөгөөс 68,922 сая төгрөгийн хооронд байхаар байна. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн ТОП-20 индексэд багтдаг хүнсний салбарын компаниудын зах зээлийн үржүүлэгчийн доод квартил утга нь Үнэ/Ашиг харьцааны хувьд 9.3х, Үнэ/Борлуулалт харьцааны хувьд 1.8х, БҮЦ/ХТӨА харьцааны хувьд 7.7х байсан бол дээд квартил утга нь Үнэ/Ашиг харьцааны хувьд 19.0х, Үнэ/Борлуулалт харьцааны хувьд 2.3х, БҮЦ/ХТӨА харьцааны хувьд 16.1х байсан. Эдгээр зах зээлийн үржүүлэгчид суурилан өмчийн үнэ цэнийн доод болон дээд хүрээг шинжлэхэд, Газаршим Үйлдвэр ХХК-ийн 2022 оны 6 дугаар сарын 30-наар 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 54,410 сая төгрөгөөс 99,076 сая төгрөгийн хооронд хэлбэлзэх магадлалтай байгаа талаар дүгнэсэн.

5.2 Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч компанийн товч танилцуулга

"Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси" ХХН нь 2020 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Улсын дээд шүүхэд бүртгэлтэй өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх 19 хуульч, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий 12 хуульч, Татварын итгэмжлэгдсэн болон Мэргэшсэн нягтлан бодогч, санхүү бүртгэлийн зөвлөх 3, хятад, англи, орос, герман, солонгос болон япон хэлээр мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай 30 гаруй хуульч, эрх зүйчдээс бүрдсэн томоохон хуулийн фирмүүдийн нэг юм.

Дан ганц бизнесийн зөвлөх үйлчилгээ төдийгүй хуулийн төсөл боловсруулах, гаднын санхүүжүүлэгч байгууллагуудаас хэрэгжүүлдэг, нийгмийн хөгжилд чиглэсэн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж, дотоодын болон олон улсын шүүхийн болон арбитрын хэргүүдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байна. Тус нөхөрлөл нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 1 сарын 27-ны өдөр 24 тоот тогтоолын дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөө үзүүлэн ажиллаж байна.

Сноу Хилл нь үнэт цаас гаргагчтай байгуулсан 2022 оны 6 сарын 30-ны өдрийн S-40/22 тоот Хууль зүйн үйлчилгээний гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр, олгосон эрх, зааварчилгааны дагуу анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт гаргахаар ажиллаж байгаа болно.

Үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эрх бүхий байгууллагуудаас баталсан холбогдох журмын дагуу хууль зүйн дүгнэлт гаргахдаа Нөхөрлөл нь үйлчлүүлэгчээс ирүүлсэн баримт бичгийг бүрэн судалж, холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн гаргах, төрийн байгууллагуудаас лавлагаа, тодорхойлолт авах, бусад мэргэжлийн байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах бөгөөд үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгыг хянаж тэдгээрт тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь нөхөрлөлд энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээллийг, бичиг баримт болон материалуудын баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх, холбогдох бичиг баримт нь алдаатай эсхүл бүрдэл дутуу, шаардлага хангахгүй нөхцөлд нөхөрлөлийн тавьсан шаардлагын дагуу баримт бичгийг бүрдүүлэх, бодитой мэдээллээр хангах, шаардлагатай бичиг баримтыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулах үүрэгтэй.

Хууль зүйн дүгнэлтийн хураангуй

Дор дурдсан мэдээлэл болон өөрсдийн шаардлагатай гэж үзсэн хяналт, шалгалтын материалд үндэслэн, энд тодорхойлсон хязгаарлалт болон нөхцөлийн хүрээнд Хуульч нь дараах дүгнэлтийг гаргаж байна:

- Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 1999 оны 07-р сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, 2007 оны 07-р сарын 20-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн газар ("ХЭУБ")-т бүртгүүлэн, 2577127 тоот регистрийн дугаартай үйл ажиллагаа явуулж байна.
- Компани нь үйл ажиллагаа эрхлэх салбар, төлөөлөгчийн газаргүй.
- Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компани нь Цээпэлийн Ганбат (51%), Цээпэлийн Төгсөө (13%), Штэффэн Мэлцэр (15%), Занаширын Байгалмаа (11%), Дүгэржавын Сэргэлэн (5%), Ганбатын Түвшинзаяа (5%) гэсэн 6 хувьцаа эзэмшигчтэй байна.
- Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т "...хязгаарлагдмал хариуцлагатай компани дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно" гэсэн зохицуулалтын хүрээнд байна.
- Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтүүдийг тухай бүр бүртгэлийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлсэн байх бөгөөд 2022 оны 11-р сарын 29-ний өдрийн байдлаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөг ба нэг бүр нь 0.11 (тэг зууны арван нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000,000,000(нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.
- Компанийн Гүйцэтгэх захирлаар Цээпэлийн Ганбатыг томилсныг 2007 оны 07-р сарын 20-ны өдөр ХЭУБ-т бүртгүүлэн, Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэсэн ба 2021 оны 12-р сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хуралтай байгуулсан Контрактын гэрээний дагуу өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.
- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11-р сарын 08-ны өдрийн ээлжит бус хурлаар Компанийн дүрмийг шинэчлэн найруулсан байна. Дүрэм нь Компанийн тухай хууль ("КтХ")-ийн 16 дугаар зүйлд заасан тусгагдвал зохих мэдээлэл бүрэн тусгагдсан байна.
- Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журам, Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй холбоотойгоор заавал мөрдөх заавар, стандартууд нь холбогдох хууль тогтоомж болон КтХ, СЗХ-ны 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн Засаглалын Кодекс ("КЗК")-т нийцсэн байна.
- Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд мөрдөгдөх хөдөлмөрийн дотоод журмын төсөл нь шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.
- ХК-ийн Компанийн дүрмийн төсөл нь КтХ-д заасан заавал тусгах зүйлсийг бүрэн тусгасан, жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашигт хамааралтай зохицуулалтыг агуулсан байгаа нь КтХ, КЗК-т нийцсэн байна.
- Бусадтай байгуулсан Худалдах-худалдан авах, Бэлтгэн нийлүүлэх, Зээлийн гэрээ, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэрээнүүд нь Иргэний хуулийн гэрээнд тавигдах ерөнхий шаардлагуудыг хангасан байна.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5% ба түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээнүүдийн хэрэгжилт хэвийн байна.
- Компанийн хөдөлмөрийн гэрээ нь шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдийг бүрэн тодорхойлсон байна.

- Компани нь сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл байгуулаагүй боловч энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй, 2019 оноос өмнө байгуулсан 1 (нэг) их хэмжээний хэлцэл байна. Компани нь сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй 5(тав) хэлцэл байгуулсан байна. Эдгээр хэлцлүүд нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан байна. Компани нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахаас өмнө Хувьцаа эзэмшигчдийн хурлаар КтХ-д заасан шаардлагын дагуу хэлэлцүүлж батлуулсан байгаа нь КтХ болон КЗК-ийн шаардлагад нийцсэн байна.
- Оюуны Өмчийн Газрын 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн 3/403 тоот албан бичиг болон Оюуны Өмчийн Газрын мэдээллийн сангийн мэдээллээс үзэхэд Компанийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг, патент, бүтээгдэхүүний загвар байхгүй байна. Гэхдээ компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа барааны тэмдэг, патентууд Компанийн Хувьцаа эзэмшигчдийн нэр дээр бүртгэлтэй бөгөөд Лицензийн гэрээ, Барааны тэмдгийн гэрээний хүрээнд ашиглахаар Оюуны Өмчийн Газарт холбогдох баримт бичгээ бүрдүүлэн хүргүүлсэн байна.
- Компанийн үнэт цаас, Дүгнэлтийн хэсэгт зааснаас бусад үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр ба аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн нөхцөл үүсээгүй байна. Компанийн нэр дээр бүртгэлтэй Газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 4 газар, Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ байгуулагдсан, бүртгэлийн шатанд явж байгаа 2 газар байна.
- Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн зээлийн мэдээллийн лавлагаагаар Компанийн зээлийн ангилал хэвийн түвшинд хамаарч байна.
- Компанийн эсрэг аливаа төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, хувь хүнээс үүсгэсэн, үүсгэж болзошгүй ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрын хэрэг эсвэл хүлээгдэж буй шүүхийн шийдвэр, албадлагын арга хэмжээний мэдэгдэл байхгүй.
- Татварын Ерөнхий Газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн татварын цахим системээс авсан Тодорхойлолт болон Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 2022 оны 07-р сарын 04-ний өдөр бидэнд ирүүлсэн 2086 тоот Тодорхойлолт зэргээс үзэхэд Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомж зөрчөөгүй, тус компанийн эсрэг ямар нэг татварын нэхэмжлэл, маргаан үүсээгүй.
- Гаалийн ерөнхий газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн Тодорхойлолтоор Компани нь Гаалийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн талаарх мэдээлэл гаалийн зөрчлийн санд бүртгэгдээгүй, 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн байдлаар гаалийн байгууллагад өргүй байна.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн Тодорхойлолтоор Компани нь 2022 оны 10-р сард 43,351,755 (дөчин гурван сая гурван зуун тавин нэгэн мянга долоон зуун тавин тав) төгрөгийн өглөгтэй байна.
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн дугаар, Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Компанийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ болон Компанийн холбоотой этгээдийн мэдээлэл нь Хуульчид Компанийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна.
- Компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь Компанийн 51 хувийн хувьцааг эзэмшигч Монгол Улсын иргэн Ц.Ганбат байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дах хэсэгт заасны дагуу Хуульч нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд илэрхий мэдээ баримт, төрийн болон эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтууд, Компанийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн болно.

Хуульч нь андеррайтер компанийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн дугаар, Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Компанийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ болон Компанийн холбоотой этгээдийн мэдээлэл нь Хуульчид Компанийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Эдгээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Компанийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Компанийн үйл ажиллагааны тухай болон Компанийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, Компанийн талаар олон нийтэд, ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, нийтэд санал болгож байгаа үнэт цаасыг арилжих нөхцөл, журам, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр зэрэг мэдээлэлд Хуульч нь дүн шинжилгээ хийгээгүй болно.

Иймд Компанийн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна.

5.3 Аудитын үйлчилгээ үзүүлэгч компанийн товч танилцуулга

Тус аудитын компани нь анх "Координат Аудит" ХХК нэртэйгээр 1998 онд үүсгэн байгуулагдсан анхны нэр хүндтэй аудитын компаниудын нэг бөгөөд санхүүгийн салбарт 24 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулахдаа мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, нийтийн ашиг сонирхлыг хангах үндсэн үүрэг, хариуцлагыг ухамсарлан, үйлчлүүлэгч, харилцагчдад мэргэжлийн өндөр түвшинд чанартай ажил, үйлчилгээг үзүүлэх, тэднийг үнэн зөв мэдээллээр хангах эрхэм зорилгыг үйл ажиллагаандаа баримталж ирсэн.

Мөн тус аудитын компани нь санхүүгийн салбарын хөгжил, дэвшилд багагүй хувь нэмрийг оруулж аудит ба баталгаажуулалт, татвар, бизнесийн зөвлөх үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч Олон улсын сүлжээ фирмүүдийн нэг "PKF International" сүлжээ фирмтэй 2016 оноос хойш хамтран ажиллаж байгаа ба тус сүлжээ фирмийн Монгол Улс дахь албан ёсны төлөөллийг хэрэгжүүлэх гишүүн фирмийн эрхийг 2017 онд хүлээн авч үйлчлүүлэгч, харилцагчдад олон улсын стандартад нийцсэн, чанартай, мэргэжлийн ажил, үйлчилгээг үзүүлж байна.

Аудит компани нь эдийн засгийн бүх салбарт хамрагдах хувийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллага, төсвийн байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллага, Олон улсын төсөл хөтөлбөрүүд зэрэг 200 гаруй байгууллага, аж ахуйн нэгжүүдэд аудитын болон зөвлөх үйлчилгээ үзүүлснээс гадна төрийн байгууллагуудын захиалгаар санхүүгийн шинжээчийн ажлуудыг гүйцэтгэсэн ажлын арвин туршлагатай.

"Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК нь нягтлан бодох бүртгэл, аудитын салбарт ажиллахын зэрэгцээгээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн Монгол Улсын санхүүгийн салбарын зохицуулалт, засаглалыг сайжруулахад чиглэсэн техник туслалцааны төсөлд дотоодын зөвлөхөөр ажилласан, мөн Дэлхийн банкны санхүүжилт, зээл тусламжаар хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, Олон улсын байгууллагуудад ажил, үйлчилгээг үзүүлж байсан туршлагатай. Олон төрлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын түнш, харилцагч, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах боломж нь бидэнд мэдлэг, туршлага, мэргэшлийн ур чадварыг баяжуулах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлж байдаг.

Аудитын товч дүгнэлт

Бид "Газар шим үйлдвэр" ХХК-аас хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид анх удаа гаргахаар төлөвлөж байгаатай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тойм болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго нь эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн гаргасан эсэхэд дүгнэлт өгөхөд оршино.

Бид аудиторын дүгнэлт, тайланг бие даасан, хараат бус байдлаар гаргасан бөгөөд тус компанийн санхүүгийн тайланг үнэт цаасны танилцуулгад хавсарган олон нийтэд танилцуулахад татгалзах зүйлгүй болно.

Компанийн үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэгтэй. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Аудитын товч дүгнэлт

Бид "Газар шим үйлдвэр" ХХК-аас хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид анх удаа гаргахаар төлөвлөж байгаатай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тойм болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго нь эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн гаргасан эсэхэд дүгнэлт өгөхөд оршино.

Бид аудиторын дүгнэлт, тайланг бие даасан, хараат бус байдлаар гаргасан бөгөөд тус компанийн санхүүгийн тайланг үнэт цаасны танилцуулгад хавсарган олон нийтэд танилцуулахад татгалзах зүйлгүй болно.

Компанийн үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэгтэй. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Бидний хараат бус байдал

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн Санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ бид Нягтлан бодогчдын Олон улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөл (НБОУЁЗСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн шаардлагыг дагаж мөрдсөн. Бид "Газар шим үйлдвэр" ХХК –ийн хараат бус аудитор тул санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд мөрдөгдөж буй НБОУЁЗСЗ –ийн хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн.

Манай компани Чанарын хяналтын олон улсын стандарт 1, Санхүүгийн тайланд аудит хийж, хянан шалгадаг компаниуд болон бусад баталгаажуулалт болон холбогдох үйлчилгээний ажлуудын чанарын хяналтын стандарт-ыг мөрддөг бөгөөд үүний дагуу ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөх талаар баримтжуулсан бодлого, журмыг багтаасан чанарын хяналтын цогц тогтолцоо, мэргэжлийн стандарт, холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагыг хангаж ажилладаг.

Аудитын тайлангийн хэрэглээ

Монгол Улсын "Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчид, андеррайтерийн компанийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид зориулан гаргасан бөгөөд үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн үзүүлэлт нь бидний гаргасан аудитын дүгнэлтэд тусгагдсан тоо мэдээлэлтэй нийцэж байна.

5.4 Андеррайтерийн компанийн танилцуулга

"Новел Инвестмент ҮЦК" ХХК нь 2010 онд үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 29 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх, 2021 онд үнэт цаасны зах зээлд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. 2015 оны 10 дугаар сард хувьцаа эзэмшигчид өөрчлөгдөж, менежментийн бүрэн шинэчлэл хийгдсэн.

Хүснэгт-65

"НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК	
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР	9011269003
РЕГИСТРИЙН ДУГААР	5436117
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх үйл ажиллагаа
ФЭЙСБҮҮК ХУУДАС	novel investment
УТАС	70121616

"Новел инвестмент ҮЦК" ХХК нь "Монголын хөрөнгийн бирж" ХК, "Улаанбаатар үнэт цаасны бирж" ХК, Биржийн бус зах зээл (OTC) -ийн тус тус гишүүн бөгөөд Засгийн газрын үнэт цаасны итгэмжлэгдсэн дилер, Засгийн газрын бондын хоёрдогч зах зээлийн арилжааны тэргүүлэгч компани юм.

2015 он

Монголын Хөрөнгийн Биржийн итгэмжлэгдсэн дилер

2016 он

66.0 тэрбум

Нийт арилжааны дүнгээр 66,0 тэрбэм төгрөгийн арилжаа хийсэн

2017 он

286.0 тэрбум

286 тэрбум төгрөгийн арилжааны идэвхээр Үнэт цаасны компаниудыг тэргүүлж байсан.

Андеррайтерийн гэрээ, эрх үүрэг:

"Новел инвестмент ҮЦК" ХХК нь "Газар шим үйлдвэр" ХХК-тай 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр "Андеррайтерийн болон хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулж, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн шинээр нийтэд нээлттэй санал болгож буй хувьцааг "Монголын хөрөнгийн бирж" ХК, Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж, олон нийтэд санал болгон арилжихтай холбоотой ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаа.

Андеррайтер нь гэрээгээр заагдсан үйл ажиллагааны гүйцэтгэлийн хүрээнд Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэт цаасны бүрдүүлбэрийг бэлтгэлээ.

Андеррайтер нь бэлтгэсэн мэдээлэлдээ Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн цаасан болон цахим хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, аудит, үнэлгээ, хуулийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн тайлан, дүгнэлт, түүнд агуулагдсан мэдээ, мэдээллийг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан.

Туслах андеррайтерын танилцуулга

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь 2011 онд "Зэт Жи Би ҮЦК" ХХК нэртэйгээр брокерийн үйл ажиллагаа явуулах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан бөгөөд 2021 оны 04 сард бүтцийн өөрчлөлт хийж, Таван Богд Трейд ХХК-ийн 85%-ийн хөрөнгө оруулалттайгаар өөрчлөн байгуулагдсан.

Ийнхүү 2021 оны 04 сараас үйл ажиллагаандаа томоохон өөрчлөлтийг хийж Санхүүгийн Зохицуулах Хорооноос нэмэлтээр Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Мөнгөн хөрөнгийн номинал данс эзэмших, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах худалдан авахад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг авч харилцагч, хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн өргөн хүрээнд үйлчилгээг үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

ТАВАН БОГД КАПИТАЛ" ҮЦК ХХК	
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР	9011286006
РЕГИСТРИЙН ДУГААР	5469112
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
ВЭБ САЙТ	www.tavanbogdcapital.com
УТАС	(+976) 7272 7282
ЦАХИМ ХАЯГ	cr@tavanbogdcapital.com
ХАЯГ	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа Улаанбаатар худалдааны төв 1 давхар

"Таван Богд Капитал" ҮЦК ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Говь ХК-ийн хоёрдогч зах зээлд хөрвөх чадвар бүхий бондыг амжилттай гаргаж, 10 тэрбум төгрөгийн, 2021 оны 11-р сараас 2022 оны 11 сар хүртэлх хугацаанд Таван Богд Финанс ББСБ ХХК-ийн 27.9 тэрбум төгрөгийн, 2022 оны 3 сараас-8 сар хүртэлх хугацаанд Эко Кар Центр ХХК-ийн нийт 1.5 тэрбум төгрөгийн, 2022 оны 12 сард "ТОСК" ТӨХХК-ийн 180.5 тэрбум төгрөгийн санхүүжилтүүдийг биржийн бус зах зээлээс тус тус амжилттай татаад байна.

Үндсэн болон туслах андеррайтерийн үйлчилгээний гэрээгээр хүрээсэн эрх, үүрэг

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээ мэдээлэл, тоо баримт, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бичиг баримтуудыг Үнэт цаас гаргуулагчаас гаргуулан авах;

- Эрх бүхий төрийн байгууллагаас тогтоосон үнэлгээг Андеррайтерийн зүгээс хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- Үнэт цаас гаргагчийг гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- Андеррайтерийн үйлчилгээтэй холбоотой гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг ҮЦЗЗТХ-ийн 41.3.4-т заасны дагуу дээд зэргийн хүчин чармайлт гарган арилжаалах;
- Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бичиг баримт, материалын бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалсан бүхий л арга хэмжээг авах;
- Андеррайтер нь гэрээний хугацаанд зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулсан судалгаа, тайлан, зураг, график, үнэт цаасны танилцуулга, баримт бичгийг эх хувиар нь Үнэт цаас гаргагчид хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг хамтран ажиллах гэрээнд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ДҮГНЭЛТ

Үнэт цаас гаргагчийн бизнес үйл ажиллагаа

"Газар шим үйлдвэр" ХХК нь 1999 оны 7 дугаар сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, 1999 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд 2577127 тоот регистрийн дугаартайгаар бүртгүүлж, Монгол улсад анхны даршилсан ногооны үйлдвэрийг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Тус компани нь үйлдвэрлэл эхэлсэн эхний жил 2 төрлийн 20 мянган шил бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол өнөөгийн байдлаар 60 нэр төрлийн 5 сая орчим шил бүтээгдэхүүн үйлдвэрлэж энэ салбартаа тэргүүлж байна.

- Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн: Үнэт цаас гаргагч нь 7 үндсэн төрлийн нийт 63 төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн хэрэглэгчид түгээж байгаа бөгөөд бүтээгдэхүүний нэр төрлөөс дурдвал алаг салат, даршилсан өргөст хэмх, олон нэр төрлийн компот, нухаш, хөлдөөсөн ногоо, хиймэл зөгийн бал, артишок ундаа зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа ба үйлдвэрийн өргөжилт хөрөнгө оруулалттай холбоотойгоор цаашид нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн, зах зээлд таниулан, зах зээлийн 20 хувийг хангах зорилтыг тавин ажиллаж байна.
- Үнэт цаас гаргагчийн техник технологи: "Газар шим үйлдвэр" ХХК нь даршилсан ногоо үйлдвэрлэлийн бүх шатанд ашиглагдах тоног төхөөрөмжийг ХБНГУ, Голланд, Хятад, Тайван, АНУ-д үйлдвэрлэлийн онцлог, түүхий эд, материалын онцлог Европ стандарт, уламжлалт туршлагад үндэслэн гэртээ хийсэн мэт амт, чанартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломжтойгоор тохируулан захиалгаар хийлгэсэн бусад өрсөлдөгч бүтээгдэхүүнүүдээс ялгарах давуу тал болж байна. Бүтээгдэхүүний нэр төрлөөс хамаарч 1 цагт 3,000-6,000 шил бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай 1 шугам, цагт 2,500 шил савлах хүчин чадалтай ундааны 1 шугам, цагт 500 кг ногоо огцом гүн хөлдөөх шугам 1 тус тус ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь үйлдвэрийнхээ хүчин чадлын 60 орчим хувийг ашиглан ажиллаж байгаа нь цаашид анхан шатны үйл ажиллагааг автоматжуулж түүхий эдийн тасралгүй байдлыг хангаж ажилласанаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх нөөц боломж их байгааг харуулж байна.
- Үнэт цаас гаргагчийн технологи: Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүд нь ямар нэгэн химийн тогтворжуулагч бодис ашиглалгүй дулааны аргаар буюу 100-с доош 70-с дээш температурт бүтээгдэхүүнийг боловсруулдаг.Энэхүү арга нь түүхий эдийн витаминлаг чанарыг алдуулахгүйгээр боловсруулж байгаагаараа бусад компаниудаас онцлог ба үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хүнсний аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж чаддагаараа давуу талтай. Үнэт цаас гаргагч нь хүнсний аюулгүй байдлын сүлжээний бүх шатанд хүнсний аюулгүй байдлыг хангасан чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд чиглэн ажилладаг бөгөөд энэ хүрээнд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2018, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага MNS ISO 22000:2019, стандартын шаардлагад нийцүүлэн удирдлагын зөв тогтолцоог бий болгож, тогтвортой үр дүнтэй хэрэгжүүлэх замаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж ажилладаг. Мөн хүнсний үйлдвэрлэлийн салбарт мөрдөгддөг GMP зохистой дадлыг бүх шатанд мөрдүүлэн ажилладаг цөөн үйлдвэрүүдийн нэг юм.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт

Үнэт цаас гаргагчийн дээр дурдсан аудитлагдсан баланс, орлого, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг 2019-2022 оны хоорондох 3 жилийн үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлбэл дараах байдалтай байна

Хүснэгт-66

Үзүүлэлтүүд	2019.IV	2020.IV	2021.IV	2021.II	2022.II
Борлуулалтын орлого	14,856,091,100	21,514,458,400	29,186,082,200	14,890,008,860	15,506,287,710
БО өсөлтийн хувь хэмжээ	44.82%	35.66%		2.11%	
Нийт ашиг (алдагдал)	4,909,139.90	6,988,454.50	10,724,711.40	5,126,470.37	4,730,054.27
Нийт ашиг өсөлтийн хувь хэмжээ	41.27%	53.46%			-7.73%
Цэвэр ашиг (алдагдал)	2,437,590.60	3,927,488.30	5,642,754	3,190,979	1,980,000
Цэвэр ашиг өсөлтийн хувь хэмжээ	61.12%	43.67%		-37.95%	

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагчийн 2019-2021 он болон 2022 оны эхний хагас жилийн Санхүү байдлын тайланд санхүүгийн босоо шинжилгээг хийхэд нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь хэмжээ 2019 онд 60 хувь байснаас 2021 онд 72 хувь болж 12 хувиар өссөн бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 74 хувьд хүрчээ. Эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь хэмжээ нь 40 хувиас 28 хувь болж буурсан бөгөөд 2022 оны хагас жилийн байдлаар 26 хувьтай байна. Энэ нь тухайн үнэт цаас гаргагч компанийн хөрөнгийн хөрвөх чадвар сайжирч, санхүүгийн эрсдэл бага байгааг илтгэж байна.

Эх үүсвэрийн хувьд гадаад эх үүсвэр буюу өр төлбөрийн хэмжээ 2021 оны байдлаар 2019 оноос 27 хувиас 21 хувь болон буурч өөрийн хөрөнгийн хэмжээ 73 хувиас 79 хувь болон өссөн нь гадны эх үүсвэр буюу өр төлбөрийн хэмжээ буурсан нь үнэт цаас гаргагч санхүүгийн бие даан үйл ажиллагаа явуулах чадвар сайжирч, богино хугацаат зээлийн санхүүжилтээс санхүүжих хамаарал буурсан байгааг илтгэж байна Мөн "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй хүнсний салбарт үйл ажиллагаа эрхлэгч "Монос хүнс" ХК, "Түмэн шувуут" ХК, "Талх чихэр" ХК, "АПУ" ХК-ийн ROE, ROA болон нийт ахиуц ашиг, цэвэр үзүүлэлтүүдтэй "Газар шим үйлдвэр" ХХК-ийн санхүүгийн үзүүлэлтийг харьцуулан авч үзэхэд дундаж түвшинээс дээгүүр байгаа ба цаашид бүртгэлтэй хувьцаат компани болсноор нийт ахиуц ашиг, цэвэр ахиуц ашгийн хэмжээ нэмэгдэх боломжтой нь харагдаж байна.

График-57



Монгол Улсын хүнсний салбарын болон даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарын нөхцөл байдал

Монгол улсын хэмжээнд 2017 онд жилд 661.0 тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүн, 599 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 924 тэрбум төгрөгийн хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг импортоор хангаж байсан бол 2021 оны жилийн дүнгээр 1,293 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 780 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 1,730 тэрбум төгрөгийн хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг импортоор хангажээ. 2022 оны эхний 6 сарын байдлаар 621 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 463 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 366 сая ам долларын хүнсний бэлэн бүтээгдэхүүн импортолсон байна.

Тиймээс Төрөөс хүнсний салбарт баримталж буй бодлого, экспортыг дэмжих, импортыг орлох салбарыг дэмжих чиглэлээр 3 үе шат бүхий хөтөлбөр боловсруулан Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлэхээр холбогдох ажлуудыг эхлүүлээд байгаа нь тус компанийн цаашдын үйл ажиллагаанд томоохон дэмжлэг болохоор байна.

Даршилсан ногооны салбарын нөхцөл байдал

Даршилсан ногоо үйлдвэрлэлийн салбарын голлох бүтээгдэхүүн нь өргөст хэмх, салат, компот бөгөөд тус салбарын 56 хувийг импортын бараа бүтээгдэхүүн дангаар бүрдүүлж байна. 2022 оны 2 дугаар улиралд импорт зах зээлд борлуулагдах үнээр 27,657,999,957 төгрөг ба нийт зах зээлийн 60 хувийг эзэлж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар зах зээлд борлуулагдах үнээр 37,253,613,352 төгрөгийн бүтээгдэхүүн импортоор орж ирсэн бөгөөд энэ нь эхний хагас жилийн хугацаанд зах зээлд борлуулагдсан бүтээгдэхүүний 54 хувийг тус тус эзэлж байна.

Үнэт цаас гаргагчийн богино болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм

Үнэт цаас гаргагчаас 2022-2024 оны хооронд бага насны болон бүх насны хүүхдэд зориулсан жимс ногооны нухаш, жимсний чанамал үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байгаагаас гадна кетчуп, соус, сүмс, майонез шинээр үйлдвэрлэх төлөвлөлт, зах зээлийн судалгааг хийгээд байна. Бага насны болон бүх насны хүүхдэд зориулсан нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ төрлийн дотоодын бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээр зах зээлийн багтаамжийг 299.1 тэрбум болгон нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

"Газар шим үйлдвэр" ХХК нь 2023 оноос 2027 оны хооронд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөнд дараах 3 зорилгуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн зах зээлд таниулж, 5 жилийн хугацаанд үе шаттайгаар зах зээлийн 20 хувийг эзлэх;
- Үйлдвэрийн тасралтгүй ажиллагааг хангаж анхан шатны боловсруулалтын автоматжуулалтын тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлд нэвтрүүлж анхан шатны гар ажиллагааг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлж зах зээлд эзлэх хувь хэмжээг 50 хувьд хүргэх, шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлж зах зээлд таниулж бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэх;;
- Түүхий эдийн нөөцийг бүрдүүлж, бүтээгдэхүүний тогтвортой үнийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хүнсний ногооны иж бүрэн зоорь барьж ашиглалтад оруулах. /Чанартай хүнсний ногоог шинэ ургацын ногооны борлуулалтын үед хямд үнээр худалдан авч нөөцлөн, жилийн турш бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болж ингэснээр бүтээгдэхүүний өртөг буурч үнийг тогтвортой барих замаар импортын бүтээгдэхүүн болон өрсөлдөгчдөөс хямд үнэтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх/

Үнэт цаас гаргагчийн зүгээс шинээр нухаш, кетчуп, соус, сүмс, майонез, чанамал, эрүүл мэндийн ундаа зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зайлшгүй үйлдвэрлэлийн савлагааны болон хутгалтын техник тоног төхөөрөмжийг шинэчлэн суурилуулах замаар үйлдвэрлэх боломж бүрдэх юм.

Үнэт цаас гаргагчийн үйлдвэрлэхээр төлөвлөж буй шинэ бүтээгдэхүүн, өмнө үйлдвэрлэж байсан бүтээгдэхүүний зах зээлийн багтаамжийг нэгтгэж хүснэгтэд харуулав.

Хүснэгт-67

	Бүтээгдэхүүний төрөл	2021 оны зах зээл сая/төг	2021 оны зах зээлд эзлэх хувь
1	Импорт өргөст хэмх	28,019	9%
2	Импорт салат	10,707	4%
3	Импорт компот	24,596	8%
4	Импорт нухаш	26,530	9%
5	Импорт чанамал	26,160	9%
6	Импорт кетчуп, соус, сүмс	42,438	14%
7	Импорт Майонез	72,734	24%
8	Импорт Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	12,636	4%
9	Дотоот Эрч хүч/эрүүл мэндийн ундаа	3,889	1%
10	Дотоод Газар шим /салат, өргөст хэмх, компот/	29,186	10%
11	Дотоод Бусад /салат, өргөст хэмх, компот	22,181	7%
	Нийт	299,076	100%

Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах болон компанийн засаглалыг сайжруулах зорилгоор компанийн энгийн хувьцааны 16.54 хувийг Монголийн хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох замаар 10.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж дараах үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байна. Үүнд: Хүнсний ногооны зоорь 5.5 тэрбум төгрөг, Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт 2.8 тэрбум төгрөг Бэлтгэх дамжлагын автоматжуулалт 1 тэрбум төгрөг зарцуулах бөгөөд үлдсэн 10.1 хувийг эргэлтийн хөрөнгөд зарцуулахаар төлөвлөжээ.

Төлөвлөгөөний хүрээнд Салат, өргөст хэмх, компотны зах зээлд ирэх 5 жилд энэхүү зах зээлд эзлэх хувийг 50%-д хүргэх, шинээр орж байгаа нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонезны зах зээлд эзлэх хувийг 2023 онд буюу үйлдвэрлэж эхэлсэн эхний жилд зах зээлийн 2%-д хүрэх бөгөөд дараагийн жилээс зах зээлийн 5%, 2025 онд 10%, 2026 онд 15%, 2027 онд 20% хүргэхээр төлөвлөж байна. Ингэснээр 2027 он гэхэд жилийн нийт борлуулалт 108.5 тэрбум төгрөгт хүрэх боломжтой гэж таамаглаж байна.

Энэхүү борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн гаргасан орлогын тайлангын төсөөлөлөөр 2023 онд 42.1 тэрбум төгрөг (25.5%), 2024 онд 55.2 тэрбум төгрөг (31.1%), 2025 онд 71.8 тэрбум төг (29.9%), 2026 онд 89.5 тэрбум төгрөг (24.6%) 2027 онд 108.5 тэрбум төгрөг (21.1%) тус тус байхаар төсөвлөжээ. Энэ нь компанийн сүүлийн 3 жилийн өсөлтийн түвшинтэй харьцуулахад бага, харьцангуй консерватив таамаглал байна.

"Монголын хөрөнгийн биржээ" ХК-ийн I ангиллын бүртгэлийн шалгуур хангаж буй тухай

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, санхүүгийн үзүүлэлт, үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтан, хяналтын багц эзэмшигч, санал болгож буй үнэт цаас зэрэг нь "Монголын хөрөнгийн биржээ" ХК-ийн "Бүртгэлийн журам"-ын I ангиллын дараах шалгуурыг бүрэн хангаж байна. Үүнд:

11.1.1 заалт: Өргөдөл гаргахаас өмнө 3-оос доошгүй жил тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байх.
Шалгуур хангаж буй тухай: "Газар шим үйлдвэр" ХХК нь "ГБТ трейдинг" ХХК нэртэйгээр 1999 оны 7 дугаар сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, 1999 оны 07 дугаар сарын 26-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлд 2577127 тоот регистрийн дугаартайгаар бүртгүүлж, Монгол улсад анхны даршилсан ногооны үйлдвэрийг байгуулж үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Компанийн нэрийг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр "Газар шим үйлдвэр" ХХК болгон олон нийтэд танигдаж, хэвшсэн нэршлийн дагуу өөрчилсөн.
11.1.2 заалт: Сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг СТОУС /IFRS/-ын дагуу бэлтгэж, аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байх.
Шалгуур хангаж буй тухай: Компанийн 2019, 2020, жилийн эцсийн санхүүгийн тайланд "Сүлд-Аудит" ХХК 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК үйлчилгээ үзүүлж санхүүгийн тайланг СТОУС /IFRS/-ын дагуу бэлтгэж, дүгнэлт гаргасан байна.
11.1.3 заалт: Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилд 5 000 000 000 /таван тэрбум/ төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 000 000 000 /нэг тэрбум/ төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай ажилласан байх ба орлого, зардал, цэвэр ашгийн тооцоололд үндсэн үйл ажиллагаанаас бусад орлого, зардал, онцгой шинжтэй олз, гарзыг тооцохгүй.
Шалгуур хангаж буй тухай: Компани 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланд тусгаснаар 29,186,082,214 төгрөгийн орлоготой 5,657,115,440 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
11.1.4 заалт: Сүүлийн 2 жилийн дотор компанийн гүйцэтгэх удирдлагын багийн бүрэлдэхүүний 2/3 хэмжээнд болон сүүлийн 1 жилд хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй байх.
Шалгуур хангаж буй тухай: Гүйцэтгэх захирал болон удирлагын баг нь сүүлийн 5 аас доошгүй жил тогтвортой ажиллаж байна.
11.2.1 заалт: Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ нь 10 000 000 000 /арван тэрбум/ төгрөгөөс дээш байх ба зах зээлийн үнэлгээг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоо ширхэг болон олон нийтэд санал болгож буй үнээр тооцно.
Шалгуур хангаж буй тухай: Үнэт цаас гаргагчийн ХЭХ-ийн 2022 оны 11 сарын 15-ны өдрийн 07 тоот тогтоолоор шинээр 16.54 хувь буюу 196,117,207 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Мөн тус тогтоолоор нэгж хувьцааны санал болгох үнийг 53 төгрөгөөр тогтоосон байна. Иймд үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээ үнэт цаасыг арилжаанд оруулах өдрөөр 63.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй байна.
11.2.2 заалт: Үнэт цаас гаргагчийн Бирж дээр бүртгүүлэх нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах, эсхүл тухайн компанийн хувьцааны хагас жилээрх арилжигдсан үнийн дүн нь Биржээр арилжаалагдсан хувьцааны нийт арилжааны үнийн дүнгийн 5-аас доошгүй хувь байх.
Шалгуур хангаж буй тухай: Компанийн хэдийгээр нийт хувьцааны 16.54 хувийг олон нийтэд санал болгож байгаа хэдий ч МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11.2.2-т "...20 000 000 000 /хорин тэрбум/ төгрөгөөс дээш зах зээлийн үнэлгээтэй үнэт цаас гаргагчийн олон нийтэд эзэмшүүлэх хувь хэмжээнд хөнгөлөлт үзүүлж болно" гэж заасны дагуу дээрх шаардлагыг хангах боломжтой.

11.2.3 заалт: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн тоо 100-аас доошгүй байх ба цаашид бүртгэлтэй байх хугацаанд хэвээр хадгалагдах;
Шалгуур хангаж буй тухай: Компани нь нийтэд хувьцаагаа санал болгож нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болсноор одоогийн хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэх боломжтой.
11.2.4 заалт: Бүртгүүлэх үнэт цаас нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байх.
Шалгуур хангаж буй тухай: Хуулийн компанийн гүйцэтгэсэн дүгнэлтэд Үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад барьцаалсан тухай ямар нэгэн мэдээлэл хөдлөх хөрөнгийн барьцааны цахим бүртгэл хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх мэдээллийн www.mpr.gov.mn цахим сангийн бүртгэлд бүртгэгдээгүй байна гэж тусгасан байна.

СЗХ ГАЗАРШИМ БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -01- 19 БҮРТГЭВ-03

ДҮГНЭЛТ

"Газар шим үйлдвэр" ХХК нь 1999 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд хүнсний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа даршилсан ногооны чиглэлийн анхны компани юм. Өнөөдрийн байдлаар 7 нэр төрлийн 60 гаруй бүтээгдэхүүн үйлдвэрлэж даршилсан ногооны зах зээлийн 25 хувийг дангаараа хангаж байна.

Үнэт цаас гаргагч нь олон улсын Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 болон, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, зохистой дадалын GMP тогтолцоог хүнсний үйлдвэрлэлийн салбарт анх удаа нэвтрүүлж бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйг дээд зэргээр ханган ажиллаж байгаа бөгөөд энэхүү давуу талууд нь "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бүтээгдэхүүнүүдийг дотоодын төдийгүй гадаад зах зээлд гаргах боломжийг бий болгож байгаа болно.

Үнэт цаасны танилцуулгад зааснаар олон нийтэд шинээр хувьцаа гаргаж, татан төвлөрүүлэх хөрөнгөөр нэн тэргүүнд зоорь барилгын санхүүжилтэд зарцуулснаар Монгол Улсын хүнсний салбарт тэр дундаа дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг дэмжих, компанийн бүтээгдэхүүний өртөгийг бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Компанийн Гүйцэтгэх удирлагын багийн гишүүд нь 5 доошгүй жил ажилласан туршлагатай, мөн бүтээгдэхүүний онцлогуудыг бүрэн таньсан туршлагатай, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлсэн байгаа нь шинээр хэрэгжүүлэх төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх чадамжтайг харуулж байна.

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангаас үзэхэд өөрийн хөрөнгийн дундаж өсөлт 14 хувь, борлуулалтын жилийн дундаж өсөлт 35.15 хувь, цэвэр ашиг сүүлийн 3 жилийн дунджаар 44.6 хувиар өссөн байна. Үнэт цаасны танилцуулгад тусгасаны төсөөллөөр цэвэр ашгийн хэмжээ жилд дунджаар 36.7 хувийн өсөлттэй тооцоолсон нь өмнөх жилүүдийн дунджаас харьцангуй багаар төлөвлөсөн бөгөөд хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтэрснээр энэхүү төсөөллийг давсан үр дүн гаргах хүлээлттэй байна.

Мөн үнэт цаас гаргагч нь ногдол ашгийн бодлогын хүрээнд жил бүр цэвэр ашгийн 30-аас доошгүй хувийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар төлөвлөсөн нь шинэ хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн өсөлт болон тогтмол өгөөжийг зэрэг хүртэх боломжийг олгож байгаараа давуу талыг бий болгож байна.

Андеррайтерийн компанийн зүгээс андеррайтерийн гэрээгээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгон, анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 зүйлд заасны дагуу шаардлагатай бүх хүчин чадлаа дайчлан ажиллахаар төлөвлөсөн.

Мөн үнэт цаас гаргагчийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулах чиглэлээр нийт шинээр гаргасан хувьцааны 50 хувийг өөрийн харилцагч стратегийн хөрөнгө оруулагчид санал болгон худалдах, үлдсэн 50 хувийг дангаараа болон бусад андеррайтерийн компаниудтай хамтран олон нийтэд санал болгон худалдах замаар амжилттай зохион байгуулах боломжтой гэж үзэж байна.

Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсны дараа хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэснээс хойших Санхүүгийн зохицуулах хорооны 2021 он 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу 6 сарын хугацаанд үнэ тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тиймээс "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийтэд шинээр санал болгож буй хувьцаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, тогтвортой өгөөжтэй, эрсдэл багатай, дунд, урт хугацааны хөрөнгө оруулалтад илүү тохиромжтой сайн бүтээгдэхүүн гэж дүгнэж байна.

СЗХ
БУРГТЭВ

ГАЗАР ШИМ®

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХАВСРАЛТ

СЗХ
2023 .01 .25 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРЭНГӨ ЗАХ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ХАВСРАЛТ МАТЕРИАЛЫН ТОВЪЁОГ

6.1 Компанийн гэрчилгээ

6.2 Андеррайтерийн компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл

6.3 Үнэлгээний компани, үнэлгээчдийн тусгай зөвшөөрөл

6.4 Хуулийн компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл

6.5 Аудитын компанийн гэрчилгээ тусгай зөвшөөрөл

6.6 Үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэр

6.7 Компанийн дүрэм

6.8 Хувьцаат компанийн дүрмийн төсөл

6.9 Ногдол ашгийн бодлогын бичиг баримт

6.10 Зоорины барилга баригдах талбайн газар эзэмшигчийн гэрчилгээ

6.11 Зоорины барилгын ажлын үнийн санал

6.12 Зоорины тоног төхөөрөмжийн үнийн санал

6.13 Шинэ бүтээгдэхүүний тоног төхөөрөмжний үнийн санал

6.14 Андеррайтерийн тодорхойлох захидал

6.15 Аудитын тодорхойлох захидал

6.16 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

6.17 Үнэлгээний тайлан

6.18 Хуулийн дүгнэлт

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
ХТА0301 УЛААНБААТАР ХОТ 5435117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ЗҮЙН ҮЙЛЧЛЭР ХХК
9022080718, 2577127 N30583

6 Хавсралт:

6.1 Компанийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000260036

2007.07.20	9011110110
/ Бүртгэсэн он,сар,өдөр /	/ Хувийн хэргийн дугаар /
	2577127
	/ Регистрийн дугаар /

Газар шим үйлдвэр

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол	01	1999.07.23
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /

0113	Хүнсний ногоо савлаж худалдаалах
0125	Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх
4630	Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа
0119	Хүнсний ногоо тариалах, худалдах
0124	Жимс, жимсгэнэ тариалах, худалдаа
1079	Ундаа, жүүс үйлдвэрлэл
5610	Цайны газар /-/
4690	Хүнсний дэлгүүр

/ Код/ / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй	6	110,000.00
/ хугацаа /	/ гишүүдийн тоо /	/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянгол, 20-р хороо, үйлдвэрийн бүс, 66/2 , Утас1: 94492021, Утас2: 99112827, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тэмдэг/ С.МӨНХСАНЧИР /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 08 сар 18 өдөр

СЭХ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХОРОНГОЛЫН ХЭЛ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 13
БҮРТГЭВ-03

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Цээпэл овогтой Ганбат-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.* *1010 Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл* *4774 Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ* *0150 Газар тариалан эрхлэх* *1073 Цайны үйлдвэрлэл, худалдаа* *0149 Фермерийн аж ахуй эрхлэх* *0130 Хүлэмжийн аж ахуй эрхлэх* *46100 Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа*	2007.07.20	Ч.Поотой
2	*Дахин гэрчилгээ олгов.*	2022.08.18	С.Мөнхсанчир
3	*Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 6 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.*	2022.10.25	Н.Энхцэцэг
4	*Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.*	2022.10.25	Н.Энхцэцэг
5	*Шинэчилсэн дүрэм бүртгэв.*	2022.11.13	Н.Золжаргал

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000260036

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ 5436117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

СЭХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭСЭН

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/58

2011 оны 01 сарын 31 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 01 сарын 31 өдрийн 29 дугаар тогтоолоор

"НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК"ХХК -д

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

СЭХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭСЭН

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 301/58 ТООТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл, хэлбэрийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Олгосон огноо	Олгосон шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар
1.	Брокер	2011.01.31	№29 тогтоол	
2.	Дилер	2011.01.31	№29 тогтоол	
3.	Хөрөнгө оруулалтын зөвлөх	2011.01.31	№29 тогтоол	
4.	Андеррайтер	2021.10.13	№432 тогтоол	

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

00024279

2010.12.27 / Бүртгэсэн он,сар,өдөр /

9011269003 / Хувийн хэргийн дугаар /

5436117 / Регистрийн дугаар /

Новел-Инвестмент ҮЦК / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол / шийдвэрийн нэр /

001 / дугаар /

2010.12.24 / он, сар, өдөр /

4610
66120 / Код/

Гадаад худалдаа
Тусгай зөвшөөрлийн хавсралтад заасан үйл ажиллагаа /2021.01.31-/ / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа /

2 / гишүүдийн тоо /

1,885,000.00 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 6-р хороо, "Өөг тулга" ХХК-ийн байр, 304 тоот, Утас1: 70121616, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /тэмдэг/ Г.БАТМӨНХ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 02 сар 22 өдөр

СЗХ
2020 -01- 19
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХОРОНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -01- 19
БҮРТГЭВ-03

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Дэлгэрсайхан овогтой Гансүх-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.*	*2016.07.07*	*Б.Амартүвшин*
2	*Дахин гэрчилгээ олгов.*	*2022.02.22*	*Г.Батмөнх*

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000242779

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436417

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

СЭХ
2020 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -01- 19
БҮРТГЭВ-03

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2013 оны 286 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2013 оны 12-р сарын 20-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.УЛААН /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2017 оны 7 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2017 оны 1-р сарын 11-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.ЧОЙЖИЛСҮРЭН /

0000001

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2019 оны 262 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2019 оны 12-р сарын 17-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 07120001

Иргэний ургийн овог: Мундгар

Иргэний овог нэр: Гомбо овогтой Баянмонх

Иргэний үнэмлэхний дугаар: УБ0620617

Иргэний бүртгэлийн дугаар: РП67042814

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: УБ 1068695, Нийслэл, БЗД, 12-р хороо, Кристал таун 801-809 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2010/12/20-ны өдрийн 280 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД / С.БАЯРЦОГТ /

УЛААНБААТАР ХОТ

NOVEL DEVELOPMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436117

СЗХ ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
БҮРТГЭВ-03

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2021.10.25

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар :	**чй******15**
Нэр :	**БАЯРСАЙХАН**
Авсан огноо :	**2021-09-28**
Дуусах огноо :	**2024-09-28**
Хүчинтэй эсэх :	**Хүчинтэй**
Тушаалын огноо :	**2021-09-28**
Тушаалын дугаар :	**№ 167**
Тусгай зөвшөөрлийн нэр :	**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

/ Тусгай зөвшөөрлийн цахим системээс олгогдов. /

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу

СЗХ
2020.01.25
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020-01-19
БҮРТГЭВ-03

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..21 оны ..41дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..21оны 03.-р сарын ..23ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.ЖАВХЛАН /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

0000300

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2016 оны 19 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 17120006

Иргэний ургийн овог: Хасгууд

Иргэний овог,нэр: Бимбажав овогтой Одгэрэл

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: ОЭ78033069

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 4-р хороолол 73-р байр 61 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 354 дугаар тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

УЛААНБААТАР ХОТ

NOVEL INVESTMENT COMPANY
УЛААНБААТАР ХОТ 5436117

ГАЗАР ЗӨЛДВӨР ХХК

СЭХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

00207410

2020.07.09 / Бүртгэсэн он,сар,өдөр /	9022003117 / Хувийн хэргийн дугаар /
	6593879 / Регистрийн дугаар /

Өмгөөллийн сноу хилл консалтанси / Хуулийн этгээдийн нэр, харияцлагын хэлбэр / — Нөхөрлөл /ХХН/

Гэрээ / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол / шийдвэрийн нэр /	01 / дугаар /	2020.07.02 / он, сар, өдөр /

1710 / Код / — Өмгөөллийн үйл ажиллагааа эрхлэх / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа /	3 / гишүүдийн тоо /	4,500.00 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Гэндэнгийн гудамж 16, Ардчиллын өргөө, 6-р давхар,
Утас1: 77118193, Утас2: 77118194, Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгуулагын нэр /

5296722
FC16115 1118268561

2020 -07- 19
БҮРТГЭВ-03

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Батаа овогтой Нямцэрэн-г Гүйцэтгэх захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.*	*2020.07.09*	*Ж.Нямдорж*

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000207410

СЗХ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХОРОНГИЙН ХУДАЛДАА
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 27 өдөр Дугаар 24 Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, 63 дугаар зүйлийн 63.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси" ХХН /Б.Нямцэрэн/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ХЭЛДЭЭР ХХК
9022000716 2577127 H020583

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 1
ЭНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

Хууль зүйн сайдын 2016 он
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000197059

2009.03.19 / Бүртгэсэн он,сар,өдөр /	9018001031 / Хувийн хэргийн дугаар /
	2565617 / Регистрийн дугаар /
Пи Кэй Эф Монголиа Аудит / Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /	
Тогтоол / шийдвэрийн нэр /	1 / дугаар /
1998.12.14 / он, сар, өдөр /	
69200 / Код/	Аудитын үйл ажиллагаа эрхлэх /2017.11.16-2020.11.16/ / Үйл ажиллагааны чиглэл /
Хугацаагүй / хугацаа /	2 / гишүүдийн тоо /
15,183.00 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /	

Улаанбаатар, Баянгол, 5-р хороо, 10-р хороолол, энхтайваны өргөн чөлөө, 92-201, Утас1: 686131, Утас2: 99193732, Факс: 686131
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2020 он 01 сар 16 өдөр

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРЭНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-01-19
БҮРТГЭВ-03

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	*Пэрэнлэйжамц овогтой Баярмаа-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.*	2009.03.19	Ч.Батцэцэг
2	*Дахин гэрчилгээ олгов.*	2020.01.16	Ж.Нямдорж
3	*Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.*	2021.02.05	С.Мөнхсанчир
4	*Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.*	2021.02.05	С.Мөнхсанчир
5	*Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, жамьян гүний, Даунтаун оффис, 602 тоот Утас1: 99193732, Утас2: , Факс: 686131 хаягийг шинээр бүртгэв.*	2021.02.05	С.Мөнхсанчир

Бичуу гэрчилгээ хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ эвдэртэй бол хүчингүй.

NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436117

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХОРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2020 -01- 19
БҮРТГЭВ-03

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 015-1998

Аж ахуйн нэгжийн нэр: " ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ" ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 2565617

Аж ахуйн нэгжийн хаяг: УБ хот, БГДүүрэг, 10-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө-92, 201 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 11 д үгээр сарын 16-ний өдөр, тушаал №335

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ..... / Ч.ХҮРЭЛБААТАР /

УЛААНБААТАР ХОТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20 20 оны 209 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20 20 оны 11-р сарын 16-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД /Ч.ХҮРЭЛБААТАР /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

0000170

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co.,Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

6.2 Үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн шийдвэр

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11-р сарын 23-ны өдөр №06. Улаанбаатар хот

Компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болох, нэмж хувьцаа гаргах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1[1], 23 дугаар зүйл болон 31 дүгээр зүйлийн 31.2.2[2], 38 дугаар зүйлийн 38.8[3], 62 дугаар зүйлийн 62.1.1[4], 62.1.3[5], 62.1.4[6], 61.1.16[7], Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1[8], 11 дүгээр зүйлийн 11.1[9] дэх заалт, "Газар Шим Үйлдвэр" ХХК (**Компани**)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон, хувьцаагаа анх удаа нийтэд санал болгож Монголын Хөрөнгийн Биржээр арилжих талаарх Гүйцэтгэх захирлын болон холбогдох мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлт, үнэт цаасны танилцуулгатай танилцсаны үндсэн дээр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас ТОГТООХ нь:

Нэг. "Газар Шим Үйлдвэр" ХХК-ийг хувьцаат компани болгох замаар Компанийн хэлбэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсүгэй.

Хоёр. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан шийдвэрийн хүрээнд Компанийн одоо гаргасан байгаа нэг бүр нь 0.11*(Тэг зууны арван нэг)* төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 000 000 000*(Нэг тэрбум)* ширхэг энгийн хувьцаа дээр нэмж, компанийн нийт хувьцааны 16.54 *(Арван зургаа зууны тавин дөрөв)* хувьтай тэнцэх 198,113,207 *(Нэг зуун ерэн найман сая нэг зуун арван гурван мянга хоёр зуун долоо)* ширхэг энгийн хувьцааг нэмж гаргасугай.

Гурав. Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн одоогийн хувьцаа эзэмшигч нар нэмж гаргах хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээ бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

---

[1] 18.1. Компанийг энэ хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

[2] 31.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:
31.2.2. хувьцаа нэмж гаргах замаар өсгөх

[3] 38.8.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.

[4] 62.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах

[5] 62.1.3. компанийн өрийг хувьцаагаар солих, **хувьцаа нэмж гаргах**, түүнийг тоог тогтоох

[6] 62.1.4. компанийн хэлбэрийг өөрчлөх

[7] 62.1.16. энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

[8] 6.1.Үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно.

[9] 11.1.Үнэт цаас гаргагч дангаар, эсхүл зохицуулалттай этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасаа үнэт цаасны анхдагч зах зээлд худалдахаар 50 ба түүнээс дээш тооны хөрөнгө оруулагчид танилцуулах, сурталчлах замаар санал болгоно.

Дөрөв. "БДО Аудит" ХХК-аас гаргасан Компанийн "Хараат бус бизнесийн үнэлгээний тайлан", "Новел Инвестмент ҮЦК" ХХК болох андеррайтерийн мэргэжлийн зөвлөгөөг харгалзан, Компанийн нэмж гаргасан хувьцааны олон нийтэд санал болгох хувьцааны нэг бүрийн үнийг 53*(Тавин гурав)* төгрөгөөр тогтоосугай.

Тав. Олон нийтэд санал болгохоор нэмж гаргаж буй хувьцааг Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу тогтоосон үнийн аргаар нийтэд санал болгосугай.

Зургаа. Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсны үр дүнд одоогийн хувьцаа эзэмшигчид болон олон нийтийн эзэмших хувь дараах байдалтай болохыг дурдсугай.

Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Эзэмшиж буй хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Ц.Ганбат	510,000,000	51	510,000,000	42.57
Штеффэн Мэлцэр	150,000,000	15	150,000,000	12.52
Ц.Төгсөө	130,000,000	13	130,000,000	10.85
З.Байгалмаа	110,000,000	11	110,000,000	9.18
Д.Сэргэлэн	50,000,000	5	50,000,000	4.17
Г.Түвшинзаяа	50,000,000	5	50,000,000	4.17
Олон нийт			198,113,207	16.54
Хувьцаа гаргасны дараа нийт дүн	1,000,000,000	100%	1,198,113,207	100%

Долоо. Анхдагч зах зээлийн арилжаагаар олон нийтээс төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь 10,499,999,971 (арван тэрбум дөрвөн зуун ерэн есөн сая есөн зуун ерэн есөн мянга есөн зуун далан нэг) төгрөг байхаар тогтоож, уг мөнгөн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад дурдсан зориулалтаар зарцуулахаар шийдвэрлэсүгэй.

Найм. Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар үүсэх Хувьцаат компанийн дүрмийн төслийг 1 дүгээр Хавсралтаар батлуулсугай.

Ес. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар "Үнэт цаасны танилцуулга"-ыг батлуулсугай.

Арав. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д

холбогдох журмын дагуу мэдэгдэж зөвшөөрөл авах болон хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бүх талын арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай зохион байгуулж, хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр хангах, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганбат/-д даалгасугай.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Ц.ГАНБАТ

Ц.ТӨГСӨӨ

З.БАЙГАЛМАА

Д.СЭРГЭЛЭН

ШТЕФФЭН МЭЛЦЭР - 2

Г.ТҮВШИНЗАЯА - 2

NOVEL INVESTMENT

6.3 Компанийн дүрэм

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 11-р сарын 08-ны өдрийн 05 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлав.

ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК-ийн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

9011110710
2022 11 13

1.1.Компанийн оноосон нэр (монголоор)
- а) Бүрэн нэр: "ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК /цаашид энэхүү дүрэмд "Компани" гэх/
- б) Англиар: "Gazar Shim Industry" LLC

1.2.Компанийн оршин байгаа газар:
- Улсын нэр: Монгол улс
- Аймаг, нийслэлийн нэр: Улаанбаатар хот 16102
- Сум, дүүргийн нэр: Баянгол дүүрэг
- Баг, хороо, хорооллын нэр: 20-р хороо
- Гудамж, өргөн чөлөө, тойрог, талбайн нэр: Үйлдвэрийн баруун бүс
- Хашаа, байшин, хаалганы дугаар: 66/1, 66/2 өөрийн байр
- Шуудангийн хаяг: Улаанбаатар-37
- Шуудангийн хайрцгийн дугаар: 162
- Харилцах утасны дугаар: 99112827, 75059933 Факсын дугаар: .....
- И-мэйл хаяг: ganbat@gazarshim.mn, info@gazarshim.mn

1.3. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг, хариуцлага хүлээх, хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцааны хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь Иргэний болон Компанийн тухай хууль, энэхүү дүрмээр хязгаарлагддаг, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр ажиллана.

1.4. Компани нь үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг энэ заалтад хамаарууллахгүй.

1.4.1. Хүнсний ногоо савлаж худалдаалах
1.4.2. Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх
1.4.3. Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа
1.4.4. Хүнсний ногоо тариалах, худалдах
1.4.5. Жимс, жимсгэнэ тариалах, худалдаа
1.4.6. Ундаа, жүүс үйлдвэрлэл
1.4.7. Цайны газар
1.4.8. Хүнсний дэлгүүр эрхлэх
1.4.9. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
1.4.10. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ
1.4.11. Газар тариалан эрхлэх
1.4.12. Цайны үйлдвэрлэл, худалдаа
1.4.13. Фермерийн аж ахуй эрхлэх
1.4.14. Хүлэмжийн аж ахуй эрхлэх
1.4.15. Төлбөр гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа

1.5.Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авч, энэхүү дүрэмдээ өөрчлөлт оруулан бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

1.6.Компанийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа: Хугацаагүй, Хугацаа ..... жил./**доогуур нь зурах буюу хугацааг бичих/**

1.7.Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу салбар, төлөөлөгчийн газраа байгуулан, бүртгэх байгууллагад бүртгүүлж, үйл ажиллагаагаа явуулна.

1.8.Компани нь үүсгэн байгуулах баримт бичигт болон улсын бүртгэлийн жагсаалтад агуулагдаж байгаа бусад мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Хоёр. Компанийн эрх

2.1.Компани нь өөрийн бэлгэдэл (эмблем), албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

2.2.Компани нь Компанийн тухай хуулийн 6.1-6.8 дахь хэсэгт заасны дагуу хараат болон охин компани байгуулж болох бөгөөд үүнийгээ бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

2.3.Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар, эсхүл бусад хуулийн этгээдтэй хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.

2.4.Компани нь үндсэн ба туслах үйл ажиллагаагаа хэвийн явуулах зорилгоор мэргэжил, ур чадвар, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдгээрийн ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

Гурав. Компанийн үүрэг

3.1.Компани нь энэхүү дүрмийн 1.5, 1.6-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхэлнэ.

3.2.Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргана.

3.3.Компани нь Монгол Улсын албан татварын хуулийн дагуу орлого, татвараа єрєє тодорхойлж, албан татвараа сайн дураар төлнө.

3.4.Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгнө.

3.5.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлнэ.

3.6.Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээж, давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

3.7.Компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

3.8.Компани хувьцаагаа нэгтгэх, хуваахдаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг хүлээнэ.

3.9.Компани нь хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулна.

3.10.Компани нь ногдол ашиг аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлєх єр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэнэ.

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ .1

2023 -01- 10
БТРТГЭВ-93

3.11.Хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигч нь уг саналаа компанид мэдэгдэх бөгөөд энэ тухай компани нь бусад хувьцаа эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

3.12.Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу дараах албан тушаалтнуудыг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Үүнд:

I. Гүйцэтгэх захирал;
II. Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий технологич;
III. Захиргаа, удирдлага хариуцсан захирал;
IV. Маркетинг борлуулалт хариуцсан захирал;
V. Ерөнхий нягтлан бодогч;
VI. Үйлдвэрийн дарга;
VII. Ерөнхий инженер;
VIII. Чанар хяналтын албаны дарга;
IX. Ахлах технологич;
X. Захиргаа хүний нөөцийн ахлах менежер;
XI. Лабораторийн эрхлэгч

3.13.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, хувьцаа эзэмшигчийн шаардлагаар танилцуулах, тэдгээрийг архивд шилжүүлнэ.

Дөрөв. Компанийн хариуцлага

4.1.Компани нь Компанийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээнэ.

4.2.Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын эрхийг зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.3.Компани нь улсын бүртгэлд бүртгүүлэхээсээ өмнө иргэний эрх зүйн харилцаанд бие даан оролцохыг хориглоно. Энэхүү заалтыг зөрчсөний улмаас бусдад гэм хор учруулсан бол буруутай этгээд гэм хорыг арилгана.

4.4.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.

4.5.Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.

Тав. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө

5.1.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.

5.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 110 000 000/Нэг зуун арван сая/ төгрөг ба нэг бүр нь 0.11/Тэг зууны арван нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1 000 000 000/Нэг тэрбум/ ширхэг энгийн хувьцаа байна.

5.2.1.компанийн хувь нийлүүлэгчид дараах байдлаар гаргасан хувьцааг эзэмшинэ:

№	Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр	Гаргасан хувьцаа			Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		
			Нэг бүрийн	Бүгд	
1.	Цээпэлийн Ганбат	510 000 000	0.11	56 100 000	51
2.	Цээпэлийн Төгсөө	130 000 000	0.11	14 300 000	13

3.	Занаширын Байгалмаа	110 000 000	0.11	12 100 000	11
4	Штэффэн Мэлцэр	150 000 000	0.11	16 500 000	15
5	Дүгэржавын Сэргэлэн	50 000 000	0.11	5 500 000	5
6	Ганбатын Түвшинзаяа	50 000 000	0.11	5 500 000	5

5.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.2 дахь хэсэгт зааснаар тодорхойлно.

5.4.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

5.5.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөхдөө Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасныг баримтална.

5.6.Компанийн хувьцаа, компанийн зарласан болон гаргасан хувьцаатай холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 32, 33 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэнэ.

Зургаа.Компанийн удирдлага

6.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн тухай хуулийн 59.1 дэх хэсэгт зааснаа хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

6.2.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит ба ээлжит бус хурал, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх, хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс, хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох, хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний шийдвэрийн талаар гомдол гаргах, саналын хуудас, саналын хуудсыг хүчинтэйд тооцох, эчнээ санал хураалтаар компанийн хувьцаа эзэмшигчид шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлтэй холбоотой асуудлыг Компанийн тухай хуулийн 59-74 дүгээр зүйлд зааснаар зохицуулна.

6.3 "Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор хурлыг хуралдуулна."

6.4. Хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах хэлбэрээр оролцож болно. Үүнд:

6.4.1. хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн биеэр оролцохгүй бол итгэмжлэлээр төлөөлөгч томилон оролцуулж болно эсвэл саналын хуудсаар саналаа ирүүлж болно;

6.4.2. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар буюу зайнаас, хосолсон/танхим болон зайнаас/ зохион байгуулах тохиолдолд зайнаас оролцогч Хувьцаа эзэмшигч саналаа цахим хэлбэрээр өгнө. Саналыг и-мэйлээр эсхүл шуудангаар саналын хуудсыг бөглөн илгээх байдлаар баталгаажуулна.

6.5.Компанийн гүйцэтгэх захирлыг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр сонгож, өөрчилнө. Гүйцэтгэх захиралтай хувьцаа эзэмшигчид гэрээ байгуулна.

6.6.Компанийн хувьцаа эзэмшигчид компаниа өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

6.7.Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигч Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.

Долоо.Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх

7.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.

Найм.Гүйцэтгэх удирдлага

8.1.Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

8.2.Компанийн гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчидтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

8.3.Компанийн хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх захирал байж болно. Энэ тохиолдолд үүсгэн байгуулагч буюу хувьцаа эзэмшигчийн шийдвэрт тусгах бөгөөд гэрээ байгуулахгүй.

8.4.Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуулийн 7.11 дэх хэсэгт заасны дагуу компанийн салбар, төлөөлөгчийн газрын удирдлагыг томилж, чөлөөлнө.

8.5.Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг шийдвэрлүүлэхдээ Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасныг баримтална.

8.6.Компанийн гүйцэтгэх захирал нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.

8.7.Компанийн гүйцэтгэх захирлын шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн эзэлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

8.8.Компанийн гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийн эзэлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61.1 дэх хэсэгт заасны дагуу зарлан хуралдуулна.

8.9.Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 61.5 дахь хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд санал, шаардлага гаргасан хувьцаа эзэмшигчид нэн даруй мэдэгдэнэ.

8.10.Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн эзэлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.

8.11.Компанийн гүйцэтгэх захирал Компанийн тухай хуулийн 66.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигч, 66.3 дахь хэсэгт заасны дагуу саналаа бичгээр гаргасан тохиолдолд 66.5 дахь хэсэгт заасан үүргийг хүлээнэ. Мөн хуулийн 66.6 дахь хэсэгт зааснаар компанийн гүйцэтгэх захирал үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

8.12.Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

8.13.Компанийн гүйцэтгэх захирал нь Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо аудиторын зөвлөмжийн дагуу эд

СЭХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

хөрөнгийн балансын үнийг мөнгөний ханшийн уналтын түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

8.14.Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

Ес. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

9.1.Компанийн хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 94.1 дэх хэсэгт зааснаар гэрээний үндсэн дээр аудитын байгууллагыг томилон ажиллуулж болно.

9.2.Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын байгууллагын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

9.3.Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд хийсэн аудитын байгууллагын шалгалт нь ээлжит байна.

9.4.Аудитын байгууллагын шалгалтын хөлсийг Компанийн тухай хуулийн 94.8 дахь хэсэгт заасны дагуу компани болон хувьцаа эзэмшигч хариуцан төлнө.

9.5.Компани нь санхүүгийн тайлангаа эрх бүхий этгээдэд танилцуулна.

9.6.Компанийн санхүүгийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

9.7.Компани нь компанийн санхүүгийн тайланд Компанийн тухай хуулийн 96.1 дэх хэсэгт заасан зүйлийг тусгана.

9.8.Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан баримт бичгийг хадгалах, байнга хадгалах, эрх бүхий этгээдийн шаардлагаар танилцуулах, хуульд заасан хугацаа дууссаны дараа архивд шилжүүлнэ.

Арав. Компанийг өөрчлөн байгуулах

10.1.Компанийн хувьцаа эзэмшигч нь компанийг өөрчлөн байгуулахдаа Компанийн тухай хуулийн 18-23 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Арван нэг. Компанийг татан буулгах

11.1.Компанийг Компанийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан үндэслэлээр татан буулгана.

11.2.Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд татан буулгах комиссыг томилно.

11.3.Компанийг татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24.1 дэх хэсэгт заасан хугацаанд бүртгэх байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

11.4.Татан буулгах комисс Иргэний хуулийн 32.2-32.10 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 26, 27, 28 дугаар зүйлд заасны дагуу компанийг татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

11.5.Компани татан буугдсаныг улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлж бүртгэх байгууллагад ирүүлнэ.

Арван хоёр. Бусад зүйл

ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
2022 он 11 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 11

БҮРТГЭВ-03

12.1.Энэхүү дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж, нэг хувийг бүртгэх байгууллагад, хоёр хувийг компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх эрх бүхий этгээдэд өгнө.

12.2.Компанийн дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болсонд тооцогдоно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Ц.ГАНБАТ

Ц.ТӨГСӨӨ

З.БАЙГАЛМАА

Д.СЭРГЭЛЭН

2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр

ооо О ооо

6.4 Хувьцаат компанийн дүрмийн төсөл

"Газар шим үйлдвэр " ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны __-р сарын ___-ны өдрийн ... тоот тогтоолын Хавсралт №...
/Төсөл/

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. "ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК нь /"**Компани**"/ Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан холбогдох дүрэм, журам болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм (**Дүрэм**)-ийн хүрээнд ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа явуулах нээлттэй хувьцаат компани (**ХК**)-ийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд мөн.

1.2. Энэхүү Дүрмийн зорилт нь Компанийг үүсгэн байгуулах, дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулах, Компанийн удирдлага, зохион байгуулалт тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөл (**ТУЗ**)-ийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох болон Компанийн татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.3. Компанийн Дүрэм нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн акттай харшлах, зөрчилдөх тохиолдолд Компани нь холбогдох хууль тогтоомжийн актад нийцүүлэн энэхүү Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдэгдлийг бүх хувьцаа эзэмшигчдэд хуанлийн 14 хоногийн дотор бичгээр хүргүүлнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ХАЯГ

1.1. Компанийн оноосон нэрийг "ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК, англиар GAZAR SHIM INDUSTRY Joint Stock Company гэх бөгөөд Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

2.3. Компанийн ерөнхий захиргаа, удирдлага оршин байрлаж байгаа хаяг нь Компанийн оршин байгаа хаяг байна.

2.4. **Компанийн эрхэм зорилго**: Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг газар тариалангийн салбарын ашигт ажиллагаатай хослуулан, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл эрхлэх, Монгол хүний эрүүл мэндэд тустай, тэжээллэг, амт чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нийлүүлэх замаар хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг нэмэгдүүлэх,мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хамт олон бүрдүүлэх.

2.5. **Компанийн алсын хараа**: Дэвшилтэт технологи, сайн чанарын ургац, мэргэшсэн хамт олны туршлагад тулгуурлан инновацлаг, шинэлэг бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхэмлэх. **Компанийн засаглалын зарчим**: Компани нь дотоод үйл ажиллагаандаа засаглалын дараах 9 зарчмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

2.5.1. ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч бүтэцтэй байх;

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ .1

2.5.2. ТУЗ нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээх;

2.5.3. ТУЗ нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах;

2.5.4. ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангаж ажиллах;

2.5.5. Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, тогтолцооны үр дүнтэй байдалд хяналт тавих;

2.5.6. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ нь Компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байх;

2.5.7. Компани нь үйл ажиллагаагаа явуулахдаа оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэх;

2.5.8. ТУЗ-ийн гишүүд Компанийн бизнесийн ёс зүй, хариуцлагыг өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтанд мөрдлөг болгон хэвшүүлэх;

2.5.9. Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, холбогдох мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор хангах.

ГУРАВ. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Компани нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу дараах үндсэн аж ахуйн үйл ажиллагаануудыг эрхлэн явуулна. Үүнд:

3.1.1. Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт"- жимс болон хүнсний бусад ногоогоор шүүс, баяжмал зэрэг бүтээгдэхүүн хийх, хатаах, хөлдөөх, боловсруулан савлан хадгалах үйл ажиллагаа Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх;
3.1.2. Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа;
3.1.3. Хүнсний ногоо тариалах, худалдах;
3.1.4. Жимс, жимсгэнэ тариалах, худалдаа;
3.1.5. Ундаа жүүс, үйлдвэрлэл;
3.1.6. Цайны газар;
3.1.7. Хүнсний дэлгүүр эрхлэх;
3.1.8. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
3.1.9. Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ;
3.1.10. Газар тариалан, мал аж ахуй, ан агнуур, түүнтэй холбогдох үйлчилгээ;
3.1.11. Цайны үйлдвэрлэл, худалдаа;
3.1.12. Фермерийн аж ахуйн эрхлэх;
3.1.13. Хүлэмжийн аж ахуйн эрхлэх;
3.1.14. Төлбөр гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.

3.2. Компани нь дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдөж ажиллана.

ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

БҮРТГЭВ-03

3.3. Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжоор хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагааг эрхлэх болон ажил гүйлгээг хийх бүрэн эрхтэй байна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

4.1. Компанийг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж тооцно.

4.2. Компани үүсгэн байгуулагдсан өдрөөс эхлэн Хувьцаа эзэмшигчээс тусгайлсан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, үйл ажиллагааныхаа хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээх ба түүнээс үүсэн гарах аливаа үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банканд өөрийн нэр бүхий данстай, бие даасан тайлан бланстай, Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадвартай байна.

4.3. Компани нь өөрийн тамга, цорын ганц тэмдэг (лого), бичгийн хэвлэмэл хуудастай байна. Гүйцэтгэх захирал нь Компанийн тамга ашиглах аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Албан албан бичгэн дээр дарагдах Компанийн тамга нь эрх бүхий этгээд, Гүйцэтгэх захирал эсхүл тэдгээрийн эрх олгсон этгээдийн гарын үсгээр баталгаажигдаж гэрчлэгдэнэ.

4.3. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба Хувьцаа эзэмшигчдийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.

4.4. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн хараат, охин компани, салбар төлөөлөгчийн газрыг Компанийн тухай хуулийн дагуу байгуулах эрхтэй байна. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээр нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна. Салбар болон төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд Компанийн баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

4.5. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан зөвшөөрлийг үндэслэн салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар, нэгжүүд нь тусдаа улсын гэрчилгээ, тамга, тэмдэг, үйл ажиллагааны журамтай байна.

ТАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

5.2. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь..... төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ..... (_____) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх ба Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь .....(_____) төгрөг байна.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК

СЭХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ :01
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

"Газар шим үйлдвэр " ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
хурлын 2022 оны __-р сарын ___-ны өдрийн ... тоот тогтоолын
Хавсралт №...
/Төсөл/

5.3. Компани нь Санхүүгийн Зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.

5.4. Компани нь давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшичдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.5. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч багаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.

5.6. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгөд шинээр хөрөнгө оруулалт оруулж болно.

5.7. Компани тодорхой нөхцөлөөр хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.

5.8. Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр хасах тэмдэгтэйгээр харуулна.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

6.1. Компанийн энгийн хувьцааг зохих журмын дагуу худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

6.2. Компаниас хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг хуваарилахаар ТУЗ-аас шийдвэр гарсны дагуу ногдол ашиг авах эрхтэй байна.

6.3. Компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон өөрийн эзэмшилдээ байгаа үнэт цаасны тоо, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар бүртгэл хөтлөх этгээдэд зохих журмын дагуу мэдэгдэх зэрэг үүрэг хүлээнэ.

6.4. Дүрмийн 5.7 дах хэсэгт заасан асуудал болон хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.5. Хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тодорхй нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байна. Энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хүлээнэ.

6.6. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

6.7. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.

"Газар шим үйлдвэр " ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны __-р сарын ___-ны өдрийн ... тоот тогтоолын Хавсралт №... /Төсөл/

6.8. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

6.9. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ.

6.9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" Компанийн хувьцааг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хуралд оролцож, хэлэлцэж буй асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

6.9.2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хууль журамд заасан хугацаандаа олгохгүй бол алданги төлөхийг шаардах;

6.9.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үндсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;

6.9.4. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах.

6.9.5. Дор дурдсан асуудлаар гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцааг эргүүлэн авахыг Компаниас шаардах эрхтэй. Үүнд:

6.9.5.1. Нийлэх, нэгдэх, хуваах, болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөх хэлбэрээр Компанийг өөрчлөн байгуулах болсон бол;

6.9.5.2. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн бол;

6.9.5.3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан бол;

6.9.5.4. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт Компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигчид Компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

СЗХ
ГАЗАРШИМ
БҮРТГЭВ
№ :1
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
МОНГОЛЫН ХӨРӨНГӨӨР БИРЖ
2023 -01- 10
БҮРТГЭВ-03

6.9.6. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшиг буй этгээд хувьцаа эзэмшигчдийн зөлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д санал хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;

6.9.7. Хувьцаа эзэмшигч нь улирал бүр Компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй.

6.9.8. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

ДОЛОО. КОМПАНИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

7.1. Компани нь энгийн хувьцаанаас гадна өрийн бичиг, хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргаж болно.

7.2. Компанийн үйл ажиллагааг өргөтгөх, шинэ бизнес эрхлэх, нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах, гүйлгээнд оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.

7.3. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

7.4. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт үнэт цаас гаргах болсон үндэслэл, шалтгаан, гаргах үнэт цаасны төрөл, тоо нэрлэсэн үнэ, үнийн дүн, гаргах хугацаа нөхцөл зэргийг заасан байна.

7.5. Компанийн хувьцаа эзэмшигч нь дүрмийн санд оруулсан хувь хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.

7.6. Хувьцаа эзэмшигчдийн хувьцааны бүртгэлийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлж, бүртгэлийг хөтлүүлнэ.

7.7. Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж, хорогдуулж болно:

7.7.1. Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;

7.7.2. Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох;

7.7.3. Өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх.

7.8. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ шийдвэрлэнэ.

7.9. Компанийн тухай хуулийн 43-р зүйлд зааснаас бусад тохиолдолд Хувьцаа бусад үнэт цаасны нийт үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
I-ҮҮРТГЭВ-03

7.10. Компаниас шинээр гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлбэрээр хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн саналаар тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын санал дүгнэлтийг үндэслэл болгоно.

7.11. ТУЗ-ийн шийдвэрээр Компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдаж авч болно. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны 25 хувиас хэтрэхгүй байна. Худалдан авсан өөрийн хувьцааг халаасны хувьцаа гэнэ.

7.12. Компани нь дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах шийдвэр гаргаж болно.

7.12.1. хуульд заасан үүргийнхээ дагуу эргүүлэн авах энгийн хувьцаа бол;

7.12.2. үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байвал;

7.12.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их бол.

7.13. Компанийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.

7.14. Компанийн хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдахаас бусад хэлбэрээр шилжүүлсэн бол хувьцаа эзэмшигчийн бүртгэл хөтлөх этгээд буюу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй.

НАЙМ. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

8.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (**ХЭХ**) байна.

8.2. ХЭХ нь ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.

8.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-өөс шийдвэрлэж хуралдуулна.

8.4. ХЭХ-аар энэ дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

8.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах этгээд нь тухайн хурлыг хуралдуулах санал гаргасан этгээд байх бөгөөд түүнийг тухайн хурал хуралдуулах шийдвэрт тусгана.

8.6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах дараах асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.6.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;

8.6.2. компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;

8.6.3. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх;

8.6.4. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор шийдвэрлэх;

8.6.5. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

8.6.6. компанийн өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;

8.6.7. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

8.6.8. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал

8.7. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

8.7.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

8.7.2. нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

8.7.3. компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;

8.7.4. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

8.7.5. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

8.8. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох гишүүдийг тодруулах, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль, Компаниас баталсан журмын дагуу явуулна.

8.9. Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 68 дугээр зүйлд заасан журмын дагуу ХЭХ-д өөрийн биеэр буюу Иргэний хуулийн 63-64 дүгээр зүйлд зааснаар бичгээр олгосон хуулийн хүчин төгөлдөр итгэмжлэлийг үндэслэн өөр этгээдээр төлөөлүүлэн оролцуулж болно.

8.10. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ. Уг санал нь Компанийн тухай хуулийн холбогдох шаардлагыг хангасан байна.

8.11. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаар тогтоосон өдрөөс ажлын 1 хоногийн өмнө Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах эрхтэй.

8.12. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болно. Хурлын ирцэд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг дахин хуралдуудах өдрийг товлож энэ тухай тэмдэглэл үйлдэж ТУЗ-ийн дарга, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаас хэлэлцэх асуудлыг өөрчлөхгүй болно.

8.13. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.6-д заасан журмын дагуу ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Өмнөх хуралд саналын хуудсаар ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.

8.14. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нар хуралд оролцоноор Дүрмийн 8.13 дэх хэсэгт заасан хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

8.15. Хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болох бөгөөд эчнээ санал хураалтыг саналын хуудсыг ашиглан явуулна.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

8.16. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.

8.17. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.

"Газар шим үйлдвэр " ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны __-р сарын ___-ны өдрийн ... тоот тогтоолын Хавсралт №...
/Төсөл/

8.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тогтоолыг Компанийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан журмын дагуу хөтөлж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга баталгаажуулан гарын үсэг зурна.

ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (**ТУЗ**) байна. ТУЗ нь эрх хэмжээнийхээ дагуу хамгийн цөөндөө улирал бүр хуралдана.

9.2. ТУЗ нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

9.2.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

9.2.2. хувьцаа эзэмшигчдийн эзлжит болон эзлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

9.2.3. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

9.2.4. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

9.2.5. компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

9.2.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

9.2.7. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

9.2.8. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

9.2.9. компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

9.2.10. аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

9.2.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;

9.2.12. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

9.2.13. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

9.2.14. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах

ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

9.2.15. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.2.16. их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.2.17. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

9.2.18. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал.

9.3. ТУЗ нь нийт 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.

9.4. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхоор ТУЗ-ийн дарга гишүүдийн дотроос сонгоно.

9.5. ТУЗ-ийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчийн хурлаар 3 (гурван) жилийн хугацаатай сонгоно. Гишүүдийг сонгохдоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.

9.6. ТУЗ-аас тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн дарга гагцхүү гарын үсэг зурж баталгаажуулна.

9.7. Гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон тохиолдолд ТУЗ-өөс түүний оронд өөр хүнийг түр томилно.

9.8. ТУЗ-ийн дарга нь:

9.8.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хяналт тавих зэрэг Компанийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

9.9. ТУЗ-ийн хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой асуудлыг Компанийн тухай хууль болон "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу зохицуулна.

9.10. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, Компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

9.11. ТУЗ нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүнийг ТУЗ-ийн дарга томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.12. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурал хүчин төгөлдөр болно. ТУЗ-ийн гишүүд асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

9.13. ТУЗ-ийн хэлэлцэж шийдвэрлэсэн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга нь дангаараа эсхүл аль нэг гишүүн болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар шийдвэр гаргах буюу ТУЗ-өөр сонгогдоогүй тохиолдолд ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.

9.14. ТУЗ нь хуралдаанаар хурлын тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд бичгээр саналаа өгсөн гишүүдийн саналыг ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хавсаргана.

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨӨР БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

9.15. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоолын хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

9.16. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлэхээс гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ.Үүнд:

9.16.1. Компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

9.16.2. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байна;

9.16.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэх;

9.16.4. өрсөлдөгч Компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх;

9.16.5. ТУЗ-ийн хуралд идэвхитэй оролцож, ажлын туршлага, өөрийн мэдлэг, ур чадвар, нөөц бололцоог дайчлах, хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнах үүрэгтэй.

9.17. ТУЗ нь байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хороо, Эрсдлийн үйл ажиллагааны хороодтой байна. Хороодын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

9.18. ТУЗ нь хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу томилно.

9.19. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хууль болон энэ Дүрэмд заасан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.

9.20. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ болон үйл ажиллагааны журмыг ТУЗ батална.

9.21. ТУЗ-ийн гишүүн нь тухайн жилд гурав болон түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд биеэр оролцоогүй, аливаа хэлбэрээр саналаа өгөөгүй мөн Компанийн холбогдох үйл ажиллагаа, хувьцаа эзэшигчдийн хуралд оролцоогүй, идэвхи хариуцлагагүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ТУЗ-ийн холбогдох хороо нь уг гишүүний бүрэн эрхийн асуудлыг авч хэлэлцэх үүрэгтэй бөгөөд ТУЗ уг гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөх эрхтэй.

СЭХ
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIA STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

"Газар шим үйлдвэр " ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны __-р сарын ___-ны өдрийн ... тоот тогтоолын Хавсралт №...
/Төсөл/

АРАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

10.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөсн сонгосон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу өөрийн эрх хэмжээний хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.2. ТУЗ-ийн зөвшөөрсөн тохиолдолд Гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.

10.3. Гүйцэтгэх удирдлагын ТУЗ-тэй байгуулсан гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

10.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.

10.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.

10.6. Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.

10.7. ТУЗ Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч хязгаарлаж болно.

10.8. Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТҮҮНИЙ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

11.1. Дараах албан тушаалд ажиллах ажилтнуудыг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Эрх бүхий албан тушаалтнаар томилогдох этгээд нь Санхүүгийн зохицуулах хорооноос батласан Тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

a. Ерөнхий захирал;
b. Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд, Ерөнхий технологич;
c. Захиргаа, удирдлага хариуцсан захирал;
d. Ерөнхий нягтлан бодогч;
e. Үйлдвэрийн дарга;
f. Ерөнхий инженер;
g. Чанар хяналтын албаны дарга;
h. Ахлах технологич
i. Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер;
j. Лабораторын эрхлэгч;
k. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
l. Маркетинг борлуулалт хариуцсан захирал

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРСНИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

11.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй. Үүнд:

11.2.1. Компанийн тухай хууль, энэхүү Дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, Компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

11.2.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд Компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

11.2.3. шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, үндэслэл бүхий шийдвэр гаргах;

11.2.4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

11.2.5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

11.2.6. эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш ажлын 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

11.3. Эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ Дүрмийн 11.2.2-т заасан үүргийг хүлээнэ.

11.4. Албан тушаалтан энэ Дүрмийн 11.2 болон 11.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас Компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид, бусад оролцогч талуудад хохирол учруулсан буюу торгуулсан бол учруулсан хохирол, төлбөр, торгуулийг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна. Үүнд:

11.4.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

11.4.2. хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;

11.4.3. эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

11.4.4. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан Компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

11.4.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгсөнөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар Компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

"НОБЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Ltd
УЛААНБААТАР ХОТ 5436111
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК

СЭХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ :01

11.5. Энэ Дүрмийн 11.2 болон 11.3-т заасан үүргээ зөрчин шийдвэр гаргасан албан тушаалтнууд хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ

12.1. Компанийн санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гаргаж баталгаажуулах бөгөөд тайланг хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

12.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээрсарын 01-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

12.3. Компанийн санхүүгийн тайлан, түүний үнэн зөвийг Гүйцэтгэх удирдлага хариуцна.

12.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 95 дүгээр зүйлийн 95.1-дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

12.5. Ногдол ашиг хуваарилалтын шийдвэрийг ТУЗ гаргана. ТУЗ-ийн тогтоолд хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах "бүртгэлийн өдөр" болон ногдол ашиг төлж эхлэх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

12.6. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ашиг хуваарилна. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

АРВАН ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ

13.1. Компани нь Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална. Үүнд:

13.1.1. Компанитай болон охин компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцэлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед Гүйцэтгэх захиралд болон Аудитийн хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ;

13.1.2. хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтооход хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй;

NOVEL INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨВ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БҮРТГЭЛ-03

13.1.3. хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас Компанид хохирол учруулсан бол эрх бүхий албан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

13.2. Хувьцаат компанийн хувьд дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:

13.2.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;

13.2.2. компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;

13.2.3. төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүн нь /хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус бүх гишүүн/ хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.

13.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналаар, хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

13.4. Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуулийн 92.3-т заасны дагуу батлуулах шаардлагагүй.

13.5. Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцогдохоос өмнө компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувьцаа эзэмшигчдийн дараагийн ээлжит хурал болох хүртэл Компанийн тухай хуулийн 92.3-т заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлагагүй.

13.6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хийх өдөр компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран компанийн буюу түүний хараат болон охин компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах

NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР
УЛААНБААТАР ХОТ

бөгөөд энэ нөхцөлд Компанийн тухай хуулийн 92.3-т заасан шаардлагыг хангасанд тооцно.

13.7. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай Компанийн тухай хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална.

АРВАН ДӨРӨВ. Үнэт цаас, өрийн бичиг, опцион гаргах

14.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргаж болно.

14.2. Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

14.3. Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өрийн бичиг гаргаж болно.

14.4. Өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

14.5. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

14.6. Дор дурдсанаас бусад тохиолдолд Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн Компанийн ТУЗ тогтооно.

14.6.1. хувьцаанд хөрвөх үнэт цаас болон опцион гаргах үед үнийг тогтоосон бол;
14.6.2. хувьцаа худалдаж авах эрхийн бичгээр хувьцааг худалдаж байгаа бол;
14.6.3. компани үүсгэн байгуулах үед үүсгэн байгуулах баримт бичигт хувьцааны үнийг тогтоосон бол;
14.6.4. хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заасан бол.

14.7. Шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

14.8. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу брокерт захиалга өгөх замаар худалдан авч болно.

СЗХ
2023 -01- 25
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХОРОНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 19
БҮРТГЭВ-03

"Газар шим үйлдвэр " ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны __-р сарын ___-ны өдрийн ... тоот тогтоолын Хавсралт №...
/Төсөл/

14.9. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас илүүгүй байна.

14.10. Гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн аль ч хэлбэрээр хийж болно.

14.11. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

АРВАН ТАВ. КОМПАНИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ

15.1. Компанийн дүрэм, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, Компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

15.2. Компани нь жил бүр санхүүгийн үйл ажиллагаандаа хөндлөнгийн шалгалт хийлгэж, тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар заавал аудит хийж гүйцэтгүүлэх бөгөөд тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.

15.3. Компанийн санхүүгийн тайлан үзүүлэлтүүд нь олон улсын жишгийг үндэслэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байна. Компани нь санхүүгийн тайлангаа улирал, жилээр гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ.

15.4. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар аудитын хороо нь 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр 2 жилийн хугацаатай сонгогдоно.

15.5. Аудитын хорооны бүрэн эрх, чиг үүрэг, гишүүдэд тавих шаардлага зэргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулах бөгөөд бусад зүйлсийг аудитын хорооноос баталсан дотоод журмаар зохицуулна.

15.6. Аудитын хороо нь хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлбар өгөх үүрэгтэй оролцох эрхтэй.

15.7. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.

15.8. Аудитын хороо нь аудитын тухай хуульд заасны дагуу Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг ТУЗ-өөр батлуулна.

15.9. Гэрээнд Компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT
УЛААНБААТАР ХОТ 5436117
УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК
2022060716 2577127 НД0503

ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

15.10. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудитын байгууллагын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.

15.11. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

15.12. Дараах этгээдийг Компанийн дотоод аудитор болон аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:

15.12.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн бүюу нэгдмэл сонирхолтой Компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

15.12.2. компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эзэмшдэг бол;

15.12.3. компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;

15.13. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан Компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.

АРВАН ТАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ ТУХАЙ

15.1. Компанийг ХЭХ-ын шийдвэрээр буюу Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр өөрчлөн байгуулах (нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөн зохион байгуулах замаар) өөрчлөн байгуулж болно.

15.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуулийн 18-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

15.3. ХЭХ-ын шийдвэрээр Компанийг татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Татан буулгах комисс, хэрэв шүүхийн шийдвэрээр татан буугдаж байгаа бол шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч гүйцэтгэнэ.

15.4. Дор дурьдсан үндэслэлээр шүүх Компанийг татан буулгана

15.4.1. Компани дампуурсан;

15.4.2. Нэг ч гишүүн үлдээгүй;

15.4.3. Хуульд заасан бусад үндэслэл;

15.5. Компанийг татан буулгах тохиолдолд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг хангасны дараа үлдсэн хөрөнгө (үүний дотор Компанийн эд хөрөнгийг борлуулсны орлого мөн орно)-ийг Компанийн хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 01
2023 -01- 10
БҮРТГЭВ-03

15.6. Компанийг бүртгэх эрх бүхий байгууллага Улсын бүртгэлээс хассанаар татан буулгасанд тооцно.

АРВАН ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛҮҮД

16.1. Энэхүү дүрэмд гагцхүү хувьцаа эзэмшигчдийн хурлын дийлэнх олонхийн шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

16.2. Энэхүү дүрэм болон холбогдох журамд шууд заагаагүй аливаа асуудлыг тухайн үед нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын хууль болон эрх зүйн бусад актаар зохицуулна.

16.3. Энэхүү дүрэм нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болж Компани татан буугдах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хугацаагүй үйлчилнэ.

16.4. Энэхүү дүрэм нь Монгол хэл дээр 3 хувь үйлдэж, УБЕГ-ын Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газарт, татварын албанд тус тус нэг нэг хувийг, Компанид нэг хувийг хадгална.

.....oooOOOooo.....

6.5 Ногдол ашгийн бодлогын бичиг баримт

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны
_сарын _-ны өдрийн _ тоот тогтоолын
Нэгдүгээр хавсралт

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХК-ИЙН

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

2022 он

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү Ногдол ашгийн бодлогын журам (цаашид "Журам" гэх)-ын зорилго нь "ГБТ Трейдинг" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-өөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлоход оршино.

1.2. Хувьцаа эзэмшигч нь Компанийн хувьцааг худалдан авч, хөрөнгө оруулалт хийхдээ тодорхой хэмжээний орлого олохоор төлөвлөдөг учраас өнөөгийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид Компанийн ашиг хуваарилалтын бодлого, ногдол ашгт хуваарилах ашгийн доод хязгаар, ашиг хуваарилах хэлбэр зэргийг тодорхой журамлах нь зүйтэй.

Хоёр. Ногдол ашиг хуваарилах нөхцөл

2.1. Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

2.2. Компани дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд ногдол ашиг хуваарилна. Үүнд:

2.2.1. Ногдол ашиг төлсний дараа Компани төлбөрийн чадвартай байх;

2.2.2. Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, Компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.2.3. Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;

2.3. Компани дараах тохиолдолд заавал ногдол ашиг хуваарилна.

2.3.1. Энэ Журмын 2.2-т заасан нөхцөл хангагдсан.

2.3.2. Компани ашигтай ажилласан бөгөөд Компанийн дүрэм болон хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт заасан хөрөнгө оруулалт, тусгай зориулалтын санд зориулсан хуваарилалтыг бүрэн хийсний дараа хуваарилагдаагүй цэвэр ашиг үлдэж байгаа.

Гурав. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

2.1. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана.

2.2. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчид мэдээлэл хүргүүлнэ.

2.3. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

2.4. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

2.5. Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ Журмын дагуу тайлбарласан байна.

2.6. Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа Хувьцаа эзэмшигчид тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тусгасан байна.

Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

4.1. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчид аль болох тохиромжтой байна.
4.2. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс Компанид учирсан хохирлыг Гүйцэтгэх захирал хариуцна.
4.3. Ногдол ашгийг олгох хэлбэр нь мөнгөн хөрөнгө, зах зээлд идэвхтэй арилжаалагддаг үнэт цаасны хэлбэртэй байх нь зохимжтой. Хувьцаа эзэмшигч дансны дугаараа албан ёсоор мэдэгдсэн нөхцөлд бэлэн бусаар шилжүүлж болно. Хувьцаа эзэмшигч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд эд хөрөнгийн хэлбэрээр олгож болно.
4.4. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн бол тухайн санхүүгийн жилийн ногдол ашгийн 30 хувиас доошгүйг ногдол ашгаар тараана
4.5. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчид төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусган бүртгэл хөтөлнө.

Тав.

5.1. Энэхүү Журам нь ТУЗ-ийн тогтоолоор баталсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
5.2. Журмыг шинэчлэн батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ

--oOo---

6.6 Зоорины барилга баригдах талбайн газар эзэмшигчийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС

ИРГЭНИЙ ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 000046602

Цээпэл (энэг /эх/-ийн нэр) Ганбат (нэр) / УУ64102814 (регистрийн дугаар) /-д

Нийслэлийн Засаг даргын захирамж (шийдвэр гаргагч) -ын 20 17 оны 04 сарын 14 өдрийн А/243 тоот

шийдвэрийг үндэслэн Улаанбаатар (аймаг, нийслэл) Хан-Уул (сум, дүүрэг) 4-р хороо (баг, хороо)

(гудамжны нэр) (хашааны дугаар/ тоот) хаягт

байрлах, нэгж талбарын 1780911080 дугаар бүхий 9992.0 /0.9992/ м.кв /га/ газрыг

Орон сууц зориулалтаар

5 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-2206000707

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛТАН

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

ТАМГА / ТЭМДЭГ (гарын үсэг) / А.Энхманлай (нэр) /

Газрын хэдэстрын мэдээллийн сан Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолын дагуу WGS-84 [illegible] ЦТК тусгэгт шилжсэнтэй [illegible] талбайн хэмжээ 9992 м.кв/га [illegible] нэгж талбарын дугаар 1780911080 болж өөрчлөгдсөн бүртгэс. Огноо: 2019.09.25 Гарын үсэг: Сөрийн дугаар: 111212

20 19 оны 9 сарын 25 өдөр

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тамга
1			

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

6.7 Зоорины барилгын ажлын үнийн санал

ST-M-002

Сайхан төмөрт ХХК *Огноо* *2022.09.10*

QUOTATION № ST2200504

Захиалагч	
Хүлээн авагч	
Утас	89091209
И-мэйл хаяг	nyamsanj@gazarshim.mn
Гүйцэтгэгч	: Сайхан төмөрт ХХК
Хаяг	: 20-р хороо, Эрчим хүчний гудам, Улаанбаатар хот, Монгол улс
Бэлтгэсэн	Инженер Э.Отгонсүрэн
И-мэйл хаяг	Otgonsuren@saikhantumurt.mn
Утас	

Тодорхойлолт **57.5x79x8.5 барилгын урьдчилсан тооцоо**

№	Тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Металл хийц Зурагаар	тн	230	6,320,000	1,453,600,000
2	Хана 150мм	м	2,525.00	65,000	164,125,000
3	Дээвэр 150мм	м	3,591.00	71,000	254,961,000
4	Дагалдах нугалаа	м2	2,211.00	30,000	66,330,000

Хүчинтэй хугацаа: 7 хоног

Нийт үнэ	1,939,016,000
НӨАТ ₮	193,901,600
Нийт үнэ	**2,132,917,600**

Нэмэлт мэдээлэл:

СЗХ
ГАЗАРШИМ
БУРТГЭВ
№ 11
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

6.8 Зоорины тоног төхөөрөмжийн үнийн санал

ALLROUND
VEGETABLE PROCESSING
+91 171 2830065
info@allroundindia.com
www.allroundvp.com

GBT Trading LLC
Attn. Mr. Ganbat Tseepel
Ulaanbaatar region,
kees@martinoz.nl
Mongolia

Ambala, 16/09/2022

Subject	: Offer for box storage
Customer	: GBT Trading LLC
Drawing Reference	: Lay_1 GBT 220915
Offer Number	: IE22-23/ 20090
Offer date	: 16/09/2022
Validity of the offer	: 30 Days
Offer Made By	: Gurbaj Singh
contact	Jaap van der Tas

Dear Sir,
Please see the offer for 7 room carrot, cabbage & onion box storage.
4 room with 500mt each. 5 room with 300mt each.

In case you require any further clarifications or details please do feel free to contact with us.

Best Regards,
Jaap van der Tas

Phone: +91 9354610204, +31 651284822
E-mail: jt@allroundindia.com

Disclaimers:
All capacities are indications and are based on experience from the past and depend on soil and product conditions, Allround VP does not guarantee any of them.

ALLROUND (INDIA) VEGETABLE PROCESSING MACHINES PVT LTD
Shahbad-Saha Highway, NH 444A, Village Kesri, PO Dinarpur
Ambala-133102, Haryana, INDIA
Tel: +91 171 2830065, +91 171 2830066
Email: info@allroundindia.com
Website: www.allroundvp.com

СЗХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 01

ALLROUND
VEGETABLE PROCESSING
+91 171 2830065
info@allroundindia.com
www.allroundvp.com

Pos	Item Code	Description	Units	Qty	Unit Price	Amount
01	FGCM00005	Turnkey cooler TKC50 Hatch 50kW cooling capacity	Nos	9	39.850,00	358.650,00
02	FGHA00002	Hatch Standard 2000 X 1200 100 mm PIR with heating	Pcs	9	630,00	5,670.00
03	FGHA00005	Set Automation for 2-5 Hatches	Pcs	9	930,00	8,370.00
04	FGVL00010	Recirculation fan CAF 45	Pcs	12	390,00	4,680.00
05	FGHU00003	Humidifier set for 1 room including triple filter	Pcs	9	1.550,00	13,950.00
06	FGSD00033	Refrigeration dryer ACD-12	Pcs	2	4.140,00	8,280.00
07	FGSC00001	Storage Computer System A-store 4 rooms	Pcs	1	8.900,00	8,900.00
08	FGSN00008	Sensor Set T/RH/CO2	Pcs	2	1.330,00	2,660.00
09	FGSN00005	Weather Station T/RH	Pcs	1	520,00	520.00
10	FGSP00019	Switch Panel 4 Room box with 10" HMI	Pcs	1	4.700,00	4,700.00
11	FGEP0002	Electric Cables and cable duct	Pcs	2	4.500,00	4,500.00

Total	€	**420,880.00**

Total price of this offer	€	420,880.00
Freight	€	Not included
Installation	€	Not included
Grand Total	€	**420.880,00**

TERMS AND CONDITIONS

1. Delivery Terms	EXW, Ambala India
2. Delivery Time	12 weeks after receipt of down-payment
3. Warranty	One-year full warranty except for electric motors & belts
4. Payment Condition	35% Advance at order, balance before loading
5. Delivery Conditions	Incoterms 2010 conditions
6. Transport & Insurance	Not included, price on request
7. Installation	Not included, price on request
8. Goods must be loaded within	4 weeks after first possible loading date
9. Penalty of late loading	Allround may charge 1% interest and stock cost per m²
10. Tax	Not applicable.

Remarks and points of attention

ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Electric control line: **400V / 50Hz & Included touch screen & internet control**
Standard all machines are controlled separately
Pictures, videos and additional information can be found on our website
www.allroundvp.com

All our quotations ,all orders placed with us and all contracts concluded with us are subject to the Jurisdiction of the District Court of Ambala , Haryana , India.

СЗХ
ГАЗАРШИМ
БУРТГЭВ
No 01
ЭЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

ALLROUND
VEGETABLE PROCESSING

+91 171 2830065
info@allroundindia.com
www.allroundvp.com

GBT Trading LLC
Attn. Mr. Ganbat Tseepel
Ulaanbaatar region,
kees@martinoz.nl
Mongolia

Ambala, 16/09/2022

Subject	: Offer for box filling line
Customer	: GBT Trading LLC
Drawing Reference	: Standard machines
Offer Number	: IE22-23/ 20091
Offer date	: 16/09/2022
Validity of the offer	: 30 Days
Offer Made By	: Gurbaj Singh
Contact	Jaap van der Tas

Dear Sir,

Please see the offer for the following machines as per attached layout. The line can be used as receiving and box filling line, as well for bag filling line after storage (with box tipper and weigher/bagger in blue)

In case you require any further clarifications or details please do feel free to contact with us.

Best Regards,
Jaap van der Tas

Phone: +91 9354610204, +31 651284822
E-mail: jt@allroundindia.com

Disclaimers :
All capacities are indications and are based on experience from the past and depend on soil and product conditions, Allround VP does not guarantee any of them.

СЭХ
ГАЗАРШИМ
БУРТГЭВ
№ 01
УНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 10
БУРТГЭВ-03

ALLROUND
VEGETABLE PROCESSING
+91 171 2830065
info@allroundindia.com
www.allroundvp.com

Pos	Item Code	Description	Units	Qty	Unit Price	Amount
01	FGHP00064	Hopper ARH 160-600	Pcs	1	23.412,00	
02	FGSR00001	Spiral Roller Set VS 160-6	Pcs	1	7.667,00	
03	FGTB00050	Pomme Parisienne Belt TB 250-60	Pcs	1	4.900,00	
3a	FGTB00045	Transport belt bag holder 600	Pcs	1	253,00	
04	FGBT00200	Transport belt TC 300-60	Pcs	1	3.399,00	
05	FGBT00200	Transport belt TC 300-60	Pcs	1	3.399,00	
06	FGBT00298	Transport belt TC 800-80	Pcs	1	7.674,00	
6a	FGRI00048	Inspection unit light strip	Pcs	1	598,00	
6b	FGTB00031	Transport belt wheels 4x	Pcs	1	220,00	
07	FGMT00001	Mobile transporter MT 600-60	Pcs	1	10.020,00	
08	FGVB00001	Box Filler VBF 275-200-70	Pcs	1	24.720,00	
09	FGBT00001	Box Tipper Z 160	Pcs	1	6.910,00	
10	FGBS00011	Weigher AW 50-01 S	Pcs	1	11.274,00	

Total	€	**104,446.00**

Total price of this offer	€	104,446.00
Freight	€	Not included
Installation	€	Not included
Grand Total	€	**104.446,00**

TERMS AND CONDITIONS

1. Delivery Terms	EXW, Ambala India
2. Delivery Time	12 weeks after receipt of down-payment
3. Warranty	One-year full warranty except for electric motors & belts
4. Payment Condition	35% Advance at order, balance before loading
5. Delivery Conditions	Incoterms 2010 conditions
6. Transport & Insurance	Not included, price on request
7. Installation	Not included, price on request
8. Goods must be loaded within	4 weeks after first possible loading date
9. Penalty of late loading	Allround may charge 1% interest and stock cost per m²
10. Tax	Not applicable.

Remarks and points of attention

ALLROUND (INDIA) VEGETABLE PROCESSING MACHINES PVT LTD
Shahbad-Saha Highway, NH 444A, Village Kesri, PO Dinarpur
Ambala-133102, Haryana, INDIA
Tel: +91 171 2830065, +91 171 2830066
Email: info@allroundindia.com
Website: www.allroundvp.com

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

ALLROUND
VEGETABLE PROCESSING
+91 171 2830065
info@allroundindia.com
www.allroundvp.com

Electric control line: **400V / 50Hz**
Standard all machines are controlled separately
Pictures, videos and additional information can be found on our website
www.allroundvp.com

All our quotations ,all orders placed with us and all contracts concluded with us are subject to the Jurisdiction of the District Court of Ambala , Haryana , India.

ALLROUND (INDIA) VEGETABLE PROCESSING
MACHINES PVT LTD
Shahbad-Saha Highway, NH 444A, Village Kesri, PO Dinarpur
Ambala-133102, Haryana, INDIA
Tel: +91 171 2830065, +91 171 2830066
Email: info@allroundindia.com
Website: www.allroundvp.com

NOVEL INVESTMENT Co.,Ltd
ГАЗАР ШИМ УНЭТ ЦЭР ХХК

СЗХ
2021-01-25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2021-01-19
БҮРТГЭВ-03

6.9 Шинэ бүтээгдэхүүний тоног төхөөрөмжний үнийн санал

YOUR SOLUTION

Acepack

The Leading Horizontal FFS Machine Global Supplier

Shanghai Acepack Intelligent Technology Co., Ltd.
ADDR: #330, Xinnuo Rd. Nanqiao Town, Fengxian District, Shanghai, China 201400
T: +8621 37596589 F: +8621 37596583-616 E: sales@acepackgroup.com
www.acepackgroup.com

Date: September 27, 2022
Compiled by: Ali
Mobile: +86 13817117592
Quotation #: APIQ010246-220927-MOG-A

Proposal for,

DS-280DSXC Horizontal Spouted Doypack FFS Machine

Liquids



"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК
NOVEL INVESTMENT Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ 8636117

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР ШИМ ҮЙЛДВӨР ХХК

СЗХ
ГАЗАРШИМ
БУРТГЭВ
№ 01
ТЭЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Section 5: Price(FOB Shanghai, China)

Equipment	Price
***Acepack* Model DS-280DSXC Packaging Machine** ● One Main Packing Machine 280DSXC ● NORD Germany Main Motor ● Schneider France PLC ● Schneider France Servo ● SMC Japan Pneumatic Devices ● 10-digit Cold Embossing Date Code System(default)	**USD$ 125,000.00**
Filling & Feeding Equipment	
Two sets of Piston pump Filler with Rotary valve	**USD$ 9,500.00**
One set of 50L Double Layer Material Tank	**USD$ 8,500.00**
Additional Equipment	
Two Sets of Round Corner Punch Knife Device	**USD$ 8,400.00**
One set of Industrial Chiller	**USD$ 800.00**
One Set No Pouch No filling Device	**Free**
One set of Cold Upper Sealing Device	**Free**
One set of Finish Product Conveyor	**Free**
Total Machine Set Price	**USD$ 152,200.00**
Equipment Packing & Relevant FOB Cost	**USD$ 1,700.00**
Freight	**By Purchaser**
Insurance	**By Purchaser**
Total FOB Shanghai Price	**USD$ 153,900.00**
Optional Equipment	
One set Markem Imaje Heat Transfer Printer	**USD$ 5,500.00**
One set of Automatic Cap Feeder	**USD$ 4,600.00**

- ✧ **Above price doesn't include the fee of after service, the fee of after service is bargained by contract.**
- ✧ **The pricing depends on the final price of the further evaluation we have received the technical requirements and products, as well as you need assistive devices**

ГАЗАРШИМ ...УНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Section 6: Service Term

6.1 Installation

The initial installation is **NOT** included with the professional ***ACEPACK*** team member. All installation with the ***ACEPACK*** team must be scheduled at least 4 weeks in advance before actual trip taken. All necessary connectivity must be ready prior the service being scheduled.

While ***ACEPACK*** team member arrives at the site for a complete and final installation, two days training course will be provide to the customer for operation and maintenance procedure. The initial installation is provided within **5 working days** excluding travel days. The actual installation days may vary, based on different machine mode and packing lines. Each day of working hour consist at 8 working hours. Any additional day will be charge according to our service fee listed below.

When initial installation is being called for the ***ACEPACK*** team required, the surcharge will be made in advance by the purchase at **US$150/person/day** plus all travel expenses. Travel expenses include documentation fees (visa charge); local and destination transportation charges (air, train, ferry, bus, taxi or any means of transportation required to arrive to/from destination); accommodation (minimum of 3 star hotel facility) and 3 daily hot meals.

6.2 After Service

ACEPACK provide free parts and parts delivery, when manufacture defects has been detected during normal operation (vulnerable parts not included) under warranty period.

ACEPACK provide low cost after service.
When service is being called for with the ***ACEPACK*** team required, the charge is same as initial installation stipulated above.

6.3 Training

We will provide free training to your technician free of charge at our factory site in Shanghai, China. The total training period would be 2 working days. All travel and related expensed would be at the purchaser's expense.

6.4 Translator

If translator is required and can't be provided by purchaser then we will provide a translator for same charge as initial installation stipulated above. All communicate with our engineer should be in Chinese. Any translation provide by us will be based between English and Chinese only. Purchaser is responsible for the translation between local language and English.

СӨХ
ГАЗАРШИМ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
БҮРТГЭВ
№ 01

Section 7: Commercial Terms

7.1 Warranty

All parts are under **One Year Warranty** with defects from manufacturer. Any other defect caused by human error, mishandling, wear-and-tear & any foreseeable conditions will not be covered by this warranty. All electronic parts and component can be guaranteed by original part's manufacturer or ***ACEPACK.***

7.2 Payment

50% of the total contract amount is to be T/T into assigned account at the period of 5 working days after the Purchase contract is signed.

50% of the balance must to be made via T/T of the remainder balance amount of the purchase contract before the ordered equipment(s) is to be delivered 10 working days prior of the shipment.

7.3 Delivery

Delivery term is **FOB - Shanghai, China**;

55 work days after receive initial deposit.

This quotation of price is effective for 30 calendar days and the starting date is marked on the cover sheet of this quotation.

Ali

International Department

Shanghai Acepack Intelligent Technology Co., Ltd.

Date:2022-09-27

СЗХ
он сар едер
БАРГГЭВ
№ 01

NOVEL
INVESTMENT

АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

ҮЗХ
2023 он 01 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Новел Инвестмент ҮЦК ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 дүгээр хороо, Шангри-Ла оффис, 2301
тоот
Утас: 7012 1616, 99115233

2023.01.06 № 2301-02
танай_____-ны №_____-т

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООН-Д

Г Г

Андеррайтерийн тодорхойлох захидал

Манай "Новел Инвестмент ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагч "Газар шим үйлдвэр" ХХК нь 2022 оны 6-р сард андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, олон нийтэд санал болгон гаргаж буй хувьцааны үнэт цаасны танилцуулгыг бэлтгэж, арилжаа эрхлэх, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, анхдагч зах зээлийн арилжааг арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан худалдах гэрээг байгуулан ажиллаж байна.

Бид Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.1.6-д заасан Андеррайтерийн тодорхойлох захидлыг дараах агуулгын хүрээнд гаргалаа. Үүнд;

1. Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга өнөөгийн нөхцөл байдал
2. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдахад ашиглах арга, хэлбэр;
3. Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн талаар;
4. Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх талаар гаргасан баталгаа;

Андеррайтер нь энэхүү тодорхойлох захидал болон үнэт цаас гаргагчийн танилцуулгыг хөндлөнгийн шинжээчдийн тайлан дүгнэлт болон үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд тулгуулан хийсэн бөгөөд холбогдох талуудаас ирүүлсэн мэдээллүүдэд орхигдуулсан буруу дутуу танилцуулсан нөхцөлд андеррайтер хариуцлага хүлээхгүй.

1. Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга өнөөгийн нөхцөл байдал

Үнэт цаас гаргагч "Газар шим үйлдвэр" ХХК нь 1999 оноос хойш 20 гаруй жилийн хугацаанд хүнсний салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа даршилсан ногооны чиглэлийн

"НОВЕЛ-ИНВЕСТМЕНТ" ХХК NOVEL INVESTMENT Co.,Ltd ХУДАЛДАА УЛААНБААТАР ХОТ 5408117

ГАЗАРШИМ ҮЙЛДВЭР ХХК УЛААНБААТАР ХОТ

00000199

анхны компани юм. Өнөөдрийн байдлаар 7 нэр төрлийн 60 гаруй бүтээгдэхүүн үйлдвэрлэж даршилсан ногооны зах зээлийн 25 хувийг дангаараа хангаж байна.

Үнэт цаас гаргагч нь олон улсын Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015, Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO 22000:2019 болон, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, зохистой дадлын GMP тогтолцоог хүнсний үйлдвэрлэлийн салбарт анх удаа нэвтрүүлж бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйг дээд зэргээр ханган ажиллаж байгаа бөгөөд энэхүү давуу талууд нь "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бүтээгдэхүүнүүдийг дотоодын төдийгүй гадаад зах зээлд гаргах боломжийг бий болгож байгаа болно.

Үнэт цаас гаргагчийн ойрын болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хувьд 2022-2024 оны хооронд бага насны болон бүх насны хүүхдэд зориулсан жимс ногооны нухаш, жимсний чанамал үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байгаагаас гадна кетчуп, соус, сүмс, майонез шинээр үйлдвэрлэх төлөвлөлт, зах зээлийн судалгааг хийгээд байна. Бага насны болон бүх насны хүүхдэд зориулсан нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ төрлийн дотоодын бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлснээр зах зээлийн багтаамжийг 299.1 тэрбум болгон нэмэгдэх боломжтой гэж үзэж байна.

"Газар шим үйлдвэр" ХХК нь 2023 оноос 2027 оны хооронд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөнд дараах 3 зорилгуудыг дэвшүүлсэн. Үүнд:

• Шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонез гэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэн зах зээлд таниулж, 5 жилийн хугацаанд үе шаттайгаар зах зээлийн 20 хувийг эзлэх;

• Үйлдвэрийн тасралтгүй ажиллагааг хангаж анхан шатны боловсруулалтын автоматжуулалтын тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлд нэвтрүүлж анхан шатны гар ажиллагааг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлж зах зээлд эзлэх хувь хэмжээг 50 хувьд хүргэх, шинэ бүтээгдэхүүнийг хөгжүүлж зах зээлд таниулж бүтээгдэхүүнийг хэрэглэгчид хүргэх;

• Түүхий эдийн нөөцийг бүрдүүлж, бүтээгдэхүүний тогтвортой үнийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хүнсний ногооны иж бүрэн зоорь барьж ашиглалтад оруулах. /Чанартай хүнсний ногоог шинэ ургацын ногооны борлуулалтын үед хямд үнээр худалдан авч нөөцлөн, жилийн турш бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болж ингэснээр бүтээгдэхүүний өртөг буурч үнийг тогтвортой барих замаар импортын бүтээгдэхүүн болон өрсөлдөгчдөөс хямд үнэтэй бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх/

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах болон компанийн засаглалыг сайжруулах зорилгоор компанийн энгийн хувьцааны 16.54 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох замаар 10.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж дараах үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байна. Үүнд: Хүнсний ногооны зоорь 5.5 тэрбум төгрөг, Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт 2.8 тэрбум төгрөг Бэлтгэх дамжлагын автоматжуулалт 1 тэрбум төгрөг зарцуулах бөгөөд үлдсэн 10.1 хувийг эргэлтийн хөрөнгөд зарцуулахаар төлөвлөжээ.

00000200

Төлөвлөгөөний хүрээнд Салат, өргөст хэмх, компотын зах зээлд ирэх 5 жилд энэхүү зах зээлд эзлэх хувийг 50%-д хүргэх, шинээр орж байгаа нухаш, чанамал, кетчуп, соус, сүмс, майонезын зах зээлд эзлэх хувийг 2023 онд буюу үйлдвэрлэж эхэлсэн эхний жилд зах зээлийн 2%-д хүрэх бөгөөд дараагийн жилээс зах зээлийн 5%, 2025 онд 10%, 2026 онд 15%, 2027 онд 20% хүргэхээр төлөвлөж байна. Ингэснээр 2027 он гэхэд жилийн нийт борлуулалт 108.5 тэрбум төгрөгт хүрэх боломжтой гэж таамаглаж байна.

Энэхүү борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн гаргасан орлогын тайлангийн төсөөллөөр 2023 онд 42.1 тэрбум төгрөг (25.5%), 2024 онд 55.2 тэрбум төгрөг (31.1%), 2025 онд 71.8 тэрбум төг (29.9%), 2026 онд 89.5 тэрбум төгрөг (24.6%) 2027 онд 108.5 тэрбум төгрөг (21.1%) тус тус байхаар төсөвлөжээ. Энэ нь компанийн сүүлийн 3 жилийн өсөлтийн түвшинтэй харьцуулахад бага, харьцангуй консерватив таамаглал байна.

Үнэт цаасны танилцуулгад зааснаар олон нийтэд шинээр хувьцаа гаргаж, татан төвлөрүүлэх хөрөнгөөр хүнсний ногооны зоорь барих, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бэлтгэх дамжлагын автоматжуулалт, эргэлтийн хөрөнгийн санхүүжилтэд зарцуулснаар Монгол Улсын хүнсний салбарт тэр дундаа дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх төрийн бодлогыг дэмжих, компанийн бүтээгдэхүүний өртгийг бууруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Компанийн Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд нь 5 доошгүй жил ажилласан туршлагатай, мөн бүтээгдэхүүний онцлогуудыг бүрэн таньсан туршлагатай, чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлсэн байгаа нь шинээр хэрэгжүүлэх төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх чадамжтайг харуулж байна.

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлангаас үзэхэд өөрийн хөрөнгийн дундаж өсөлт 14 хувь, борлуулалтын жилийн дундаж өсөлт 35.15 хувь, цэвэр ашиг сүүлийн 3 жилийн дунджаар 44.6 хувиар өссөн байна. Үнэт цаасны танилцуулгад тусгасны төсөөллөөр цэвэр ашгийн хэмжээ жилд дунджаар 36.7 хувийн өсөлттэй тооцоолсон нь өмнөх жилүүдийн дунджаас харьцангуй багаар төлөвлөсөн бөгөөд хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтэрснээр энэхүү төсөөллийг давсан үр дүн гаргах хүлээлттэй байна.

Мөн үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр ногдол ашгийн бодлогын хүрээнд жил бүр цэвэр ашгийн 30-аас доошгүй хувийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар төлөвлөсөн нь шинэ хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн өсөлт болон тогтмол өгөөжийг зэрэг хүртэх боломжийг олгож байгаараа давуу талыг бий болгож байна.

2. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдахад ашиглах арга, хэлбэр

Андеррайтерийн компани үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу нийт хувьцааны 16.54 хувьтай тэнцэх нэмж гаргаж буй 198,113,207 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд болон стратегийн хөрөнгө оруулагчдад 53 төгрөгөөр санал болгон худалдаж, 10.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос Үнэт цаас бүртгэх шийдвэр гарсны дараа ажлын 10 өдөрт багтаан явуулах ба андерайтерын компани нь үнэт цаас гаргагчийн хувьцааны захиалгын бүртгэлийг арилжаа эрхлэх байгууллага болох "Монголын хөрөнгийн бирж" ХК-аар дамжуулан холбогдох дүрэм журмын дагуу ажлын 5 өдөрт багтаан анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж, арилжаална.

Нэмж гаргаж буй нийт хувьцааны 50 хувийг стратегийн хөрөнгө оруулагчид, үлдсэн 50 хувийг олон нийтэд санал болгон худалдах бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг бүрэн биелүүлэх бөгөөд олон нийтээс ирүүлсэн захиалга нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд МХБ-ийн "Анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын Тогтоосон үнийн аргын үндсэн зарчмын дагуу хувь тэнцүүлэн хуваарилах ба суурь хуваарилалтад 10,000 ширхэг хүртэлх хувьцаа худалдан авах захиалгыг бүрэн биелүүлж илүү гарсан үнийн дүнг хувь тэнцүүлэн хуваарилна.

Стратегийн хөрөнгө оруулагчид нь компанийн ирээдүйн үйл ажиллагаа өсөлт хөгжилтөд эерэг нөлөө үзүүлэхүйц хөрөнгө оруулагч эсвэл 50-500 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах захиалга өгч үнэт цаасаа 6-аас доошгүй сараар хувьцаагаа тусгаарлуулах нөхцөлийг зөвшөөрсөн хөрөнгө оруулагч байна.

3. Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн талаар;

Андеррайтерийн компанийн зүгээс үнэт цаас гаргагчийн салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн үйлчилгээ, бизнесийн дунд хугацааны төлөвлөгөөг хянаж үзсэний үндсэн дээр хөндлөнгийн мэргэжлийн байгууллагууд болох хууль, аудит, үнэлгээний компаниудын тайланд тулгуурлан үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэлийн журам, арилжаа эрхлэх байгууллагын журамд нийцүүлэн бие даасан хараат бусаар боловсруулсан болно.

Үнэт цаас гаргагч нь "Өмгөөллийн Сноу Хилл Консалтанси" ХХН байгуулсан 2022 оны 6 сарын 30-ны өдрийн S-40/22 тоот Хууль зүйн үйлчилгээний гэрээний дагуу Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр, олгосон эрх, зааварчилгааны дагуу анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбоотой хууль зүйн дүгнэлт гаргаж ажилласан.

Санхүүгийн аудитын хувьд олон улсын "PKF International" сүлжээ фирмийн Монгол Улс дахь албан ёсны төлөөллийг хэрэгжүүлэгч "Пи Кэй Эф Монголиа Аудит" ХХК-тай хамтран ажилласан бөгөөд үнэт цаас гаргагчийн захиалгаар 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болон 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тойм болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэсэн.

Үнэт цаас гаргагч нь БДО Аудит ХХК-тай 2021 оны 6 сарын 24-ний өдөр бизнесийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан. Тус гэрээний хүрээнд Олон Улсын

Үнэлгээний Стандарт, Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын дагуу үнэт цаасны зах зээл дээр шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд зориулан Үнэт цаас гаргагчийн 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх бизнесийн үнэлгээ хийж, тайлан гаргахаар тусгасан байна.

Андеррайтер болон үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэхдээ "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжид нийцүүлэн, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээллүүдийг тусгахаар зорьсон бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3-р зүйл, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл бичиг баримтын бүрдлийг хангаж ажилласан.

4. Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх талаар гаргасан баталгаа;

Андеррайтерийн компаниудын зүгээс андеррайтерийн гэрээгээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгон, анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг ҮЦЗЗТХ-ын 41.4.3-т заасны дагуу бүх хүчин чадлаа дайчлан ажиллахаар төлөвлөсөн.

Бид хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагаа идэвхжүүлэх зорилгоор үнэт цаас гаргагчийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжаагаар нэмж гаргаж байгаа хувьцааны 1 хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг худалдан авах боломжтой .

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2021 он 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсаны дараа хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойших 6 сарын хугацаанд үнэ тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тиймээс "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийтэд шинээр санал болгож буй хувьцаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, тогтвортой өгөөжтэй, эрсдэл багатай, дунд, урт хугацааны хөрөнгө оруулалтад илүү тохиромжтой сайн бүтээгдэхүүн гэж дүгнэж, үнэт цаас гаргагч нь шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Үнэт цаас гаргагч нь даршилсан ногооны салбарын анхны үйлдвэрлэгч компани бөгөөд зах зээлд эзлэх байр суурия байнга нэмэгдүүлсээр ирсэн дотоодын зах зээлийн тэргүүлэгч компани юм. Үнэт цаасны танилцуулгад тусгасны төсөөллөөр цэвэр ашгийн хэмжээ жилд дунджаар 36.7 хувийн өсөлттэй тооцоолсон нь өмнөх жилүүдийн дунджаас харьцангуй багаар төлөвлөсөн бөгөөд хөгжүүлж буй шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтэрснээр энэхүү төсөөллийг давсан эерэг үр дүн гаргах хүлээлттэй байна.

Мөн үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр ногдол ашгийн бодлогын хүрээнд жил бүр цэвэр ашгийн 30-аас доошгүй хувийг ногдол ашиг

хэлбэрээр хуваарилахаар төлөвлөсөн нь шинэ хувьцаа эзэмшигчдэд хөрөнгийн өсөлт болон тогтмол өгөөжийг зэрэг хүртэх боломжийг олгож байна.

Түүнчлэн Андеррайтерын компаниуд болон үнэт цаас гаргагч хамтран хоёрдогч захзээлийн арилжаа эхэлснээс хойших 6 сарын хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасны дагуу үнэ тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тиймээс "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийтэд шинээр санал болгож буй хувьцаа нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, тогтвортой өгөөжтэй, эрсдэл багатай, дунд, урт хугацааны хөрөнгө оруулалтад илүү тохиромжтой сайн бүтээгдэхүүн гэж дүгнэж байна.

Хувийг Монголын хөрөнгийн бирж ТӨХК -д

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ГАНСҮХ

00000204

СЭХ
ЭМ сар адар
БУРТГЭВ
№ 01

АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

Accountants &
business advisers

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюлдинг, #602 тоот,
Жамъяан гүний гудамж -18/1,
1 -р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976-75057979
Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref: 24/GBT/22/07042022/OG

Огноо: 2022 оны 11 сарын 08-ны өдөр

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТУХАЙ АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хамрах хүрээ ба зорилго

Бид "Газар шим үйлдвэр" ХХК-аас хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид анх удаа гаргахаар төлөвлөж байгаатай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31–ний өдөр болон 2022 оны 6 сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын тойм болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго нь эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн гаргасан эсэхэд дүгнэлт өгөхөд оршино.

Тус компанийн Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон улсын Стандартын Зөвлөлөөс гаргадаг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС") –ын дагуу тайлагнагдсан бөгөөд бид 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр, 2022 оны 6 дугаар сарын 30 -ны өдрөөрх Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй, СТОУС –ын дагуу үнэн зөв толилуулагдсан гэж үзэн, аудиторын өөрчлөлтгүй дүгнэлт гаргасан болно.

Бид аудиторын дүгнэлт, тайланг бие даасан, хараат бус байдлаар гаргасан бөгөөд тус компанийн санхүүгийн тайланг үнэт цаасны танилцуулгад хавсарган олон нийтэд танилцуулахад татгалзах зүйлгүй болно.

Компанийн үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэгтэй.

00000205

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТУХАЙ АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ (үргэлжлэл)

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Компанийн үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Бидний үүрэг хариуцлага

Аудитор нь санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар харгалзах санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн гаргасан эсэхэд дүгнэлт өгдөг.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг бөгөөд бид дараах горимуудыг гүйцэтгэдэг:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.
- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид

00000206

дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТУХАЙ АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ (үргэлжлэл)

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Бидний үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бидний хараат бус байдал

Санхүүгийн тайлангийн аудитыг хийхдээ бид Нягтлан бодогчдын Олон улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөл (НБОУЁЗСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн шаардлагыг дагаж мөрдсөн. Бид "Газар шим үйлдвэр" ХХК –ийн хараат бус аудитор тул санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд мөрдөгдөж буй НБОУЁЗСЗ –ийн хараат бус байдлын шаардлагыг дагаж мөрдсөн.

Манай компани Чанарын хяналтын олон улсын стандарт 1, *Санхүүгийн тайланд аудит хийж, хянан шалгадаг компаниуд болон бусад баталгаажуулалт болон холбогдох үйлчилгээний ажлуудын чанарын хяналтын стандарт*-ыг мөрддөг бөгөөд үүний дагуу ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөх талаар баримтжуулсан бодлого, журмыг багтаасан чанарын хяналтын цогц тогтолцоо, мэргэжлийн стандарт, холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагыг хангаж ажилладаг.

Аудитын тайлангийн хэрэглээ

Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчид, Андеррайтерийн компанийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, аудитын дүгнэлт тайланг Компанийн хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид зориулан гаргасан бөгөөд "Үнэт цаасны танилцуулга" -д тусгагдсан санхүүгийн үзүүлэлтүүд нь бидний гаргасан Аудитын дүгнэлт тайланд тусгагдсан тоо мэдээлэлтэй нийцэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ П.БАЯРМАА

0000207

СӨХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Accountants &
business advisers

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК

(Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2021 оны 12 сарын 31 ба 2022 оны 06 сарын 30 -ны өдрөөр дуусгавар болсон тайлант жил

Улаанбаатар 2022

Accountants &
business advisers

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК

2021 ОНЫ 12 САРЫН 31 БА 2022 ОНЫ 06 САРЫН 30–НЫ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ТАЙЛАНТ ЖИЛ

АГУУЛГА	ХУУДАС
КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	1
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	3 – 4
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	5
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	6
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	7
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	8
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	9-38

00000208

СЭХ
2021-01-22
он сар өдөр
БҮРТГЭВ

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК

КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

АЛБАН ХАЯГ	Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг албан хаяг нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс /16102/, 66/01, 66/02 тоот
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ	Цээпэлийн Ганбат 51% Цээпэлийн Төгсөө 18% Заншар Байгалмаа 16% Герман Штэффэн Мэлцэр Трейд унд Сервис е.кфм 15%
АУДИТОРУУД	Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

00000209

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК -ийн Гүйцэтгэх захирал Ц.Ганбат, нягтлан бодогч Г.Үүрийнцолмон бид, энэхүү тайлангийн 5-34 дугаар хуудсанд тусгагдсан Компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Зөвлөл (СТОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

“ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР” ХХК –ийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг нийтэд толилуулахыг зөвшөөрч батлав.

Ц.Ганбат
Гүйцэтгэх захирал

Г.Үүрийнцолмон
Ерөнхий Нягтлан Бодогч

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2022 оны 09 дугаар сарын 28 өдөр

00000210

Accountants &
business advisers

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК

Даун Таун Бьюлдинг, #602 тоот,
Жамъяан гүний гудамж -18/1,
1 -р хороо, Сүхбаатар дүүрэг-14240,
Улаанбаатар хот, Монгол улс

Утас: +976-75057979
Факс: +976-70186131

Имэйл: info@pkf.mn

Ref: 23/GBT/22/07042022/OG

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид "Газар шим үйлдвэр" ХХК (цаашид "Компани" гэх) –ийн 2021 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөрх болон 2022 оны 06 дугаар сарын 30 –ны өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрүүдээр тасалбар болгосон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогод аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2021 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөрх болон 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилүүдийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн "Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага" хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Тасралтгүй байх зарчим

Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд Компани нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг хэмжээний эрсдэл, тодорхой бус байдал байхгүй байна.

Асуудлыг онцгойлсон зүйл

Санхүүгийн байдлын тайланд илэрхийлэгдсэн 2022 оны 6 сарын 30 -ны өдрөөрх Дансны авлагын 3,776,051,558 төгрөгийн үлдэгдлийн дүнд Материал Импекс ХК-аас авах урт хугацааны насжилт бүхий 1,008,096,000 төгрөгийн авлага багтаж байгаа болно.

Энэ тооцоо нь 2014 оны 10 сарын 01 -ний өдөр Газар Шим Үйлдвэр ХХК-ийн эзэмшлийн газар дээр Материал Импекс ХК нь үйлчилгээ, орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө барих тухай хамтран ажиллах гэрээ байгуулснаар үүссэн ба 2022 оны 08-р сарын 29-ний өдөр хийгдсэн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр Материал Импекс ХК нь барилгын ажлыг эхлүүлснээс хойш 4 жилийн дотор 560 мкв бүхий үл хөдлөх хөрөнгийг Газар Шим Үйлдвэр ХХК -д хүлээлгэн өгөхөөр харилцан тохиролцсон байна. Авлагын үлдэгдлийг аудитын тулган баталгаажуулалтаар баталгаажуулсан. Удирдлага тус тооцооны авлагыг үнэ цэнийн бууралтад ороогүй гэж үзэж байгаа болно.

00000211

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС - ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх.

00000212

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана) -ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

П.БАЯРМАА
Гүйцэтгэх захирал

ПИ КЭЙ ЭФ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2022 оны 10 дугаар сарын 06

00000213

СЗХ
БҮРТГЭВ

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2020 ОНЫ БОЛОН 2021 ОНЫ 12 САРЫН 31 -НИЙ; 2022 ОНЫ 06 САРЫН 30 -НЫ ӨДРИЙН БАЙДЛААРХ

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2020.12.31	2021.12.31	2022.06.30
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2	2,646,355,000	2,390,592,895	1,506,968,691
Дансны авлага	3	2,244,050,936	2,935,328,537	3,776,051,558
Татвар, НДШ -ийн авлага	4	29,107,279	120,912,689	115,376,036
Бусад авлага	5	3,825,144,236	5,923,245,157	3,595,173,047
Бараа материал	6	4,520,500,148	5,432,423,326	9,281,750,771
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	7	1,949,090,537	2,728,717,470	3,626,140,903
Эргэлтийн хөрөнгийн дүн		**15,214,248,137**	**19,531,220,073**	**21,901,461,007**
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	8	7,403,888,575	7,660,714,445	7,601,882,044
Биет бус хөрөнгө	9	27,138,695	11,404,338	7,676,225
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**7,431,027,270**	**7,672,118,783**	**7,609,558,270**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**22,645,275,407**	**27,203,338,856**	**29,511,019,277**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
ӨР ТӨЛБӨР				
Богино хугацаат өр төлбөр				
Дансны өглөг	10	342,372,899	287,019,436	627,891,853
Цалингийн өглөг	11	173,543,078	65,398,229	205,866,672
Татвар хураамжийн өр төлбөр	12	115,708,982	792,854,582	441,295,135
НДШ -ийн өр төлбөр	13	-	-	2,946,671
Богино хугацаат зээл	14	-	-	1,977,488,000
Бусад богино хугацаат өр төлбөр	15	24,069,160	1,050,000,000	140,000,000
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**655,694,118**	**2,195,272,247**	**3,395,488,331**
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	16	4,063,333,333	3,428,267,333	2,551,768,209
Хойшлогдсон татварын өр	19	-	1,465,649	5,118,502
Урт хугацаат өр төлбөрийн дүн		**4,063,333,333**	**3,429,732,983**	**2,556,886,711**
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		**4,719,027,452**	**5,625,005,230**	**5,952,375,042**
ЭЗДИЙН ӨМЧ				
Өмч : - Төрийн		-	-	-
- Хувийн	20	110,000,000	110,000,000	110,000,000
Эздийн өмчийн бусад хэсэг	21	380,000,000	380,000,000	380,000,000
Хуримтлагдсан ашиг	22	17,436,247,956	21,088,333,627	23,068,644,234
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		**17,926,247,956**	**21,578,333,627**	**23,558,644,234**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		**22,645,275,407**	**27,203,338,856**	**29,511,019,276**

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

00000214

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2021 ОНЫ 12 САРЫН 31 БОЛОН 2022 ОНЫ 06 САРЫН 30 -НЫ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2020 он	2021 он	2021 оны 01/01-06/30	2022 оны 01/01-06/30
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	23	**21,514,458,446**	**29,186,082,214**	**14,890,008,866**	**15,506,287,710**
Борлуулалтын өртөг	23	14,526,003,854	18,461,370,779	9,763,538,490	10,776,233,431
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)		**6,988,454,593**	**10,724,711,435**	**5,126,470,376**	**4,730,054,279**
Хүүний орлого	24	41,155,627	62,135,814	56,360,521	5,676,660
Бусад орлого	24	193,099,230	361,217,934	182,801,265	32,867,650
		234,254,857	**423,353,748**	**239,161,786**	**38,544,310**
Борлуулалт маркетингийн зардал	26	1,184,696,635	2,153,369,434	972,174,542	1,073,796,312
Ерөнхий ба удирдлагын зардал	25	1,667,477,210	1,382,250,534	624,086,327	634,401,824
Санхүүгийн зардал	27	-	325,464,571	171,522,591	149,194,644
Бусад зардал	27	17,210,115	677,185,408	10,523,821	622,658,159
		2,869,383,959	**4,538,269,947**	**1,778,307,281**	**2,480,050,939**
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит олз (гарз)	28	61,132,419	(17,777,431)	(11,783,730)	(42,750,816)
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз (гарз)	28	-	11,450,384	4,777,838	37,566,972
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	29	(53,778,048)	(6,294,924)	-	(7,145,875)
		7,354,371	**(12,621,970)**	**(7,005,892)**	**(12,329,719)**
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)		**4,360,679,861**	**6,597,173,265**	**3,580,318,990**	**2,276,217,931**
Орлогын татварын зардал	30	433,191,634	940,057,825	389,339,800	295,907,324
ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)		**3,927,488,227**	**5,657,115,440**	**3,190,979,190**	**1,980,310,608**
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)					
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)		**3,927,488,227**	**5,657,115,440**	**3,190,979,190**	**1,980,310,608**
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		-	-	-	-
ОРЛОГЫН НИЙТ ДҮН		**3,927,488,227**	**5,657,115,440**	**3,190,979,190**	**1,980,310,608**

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

00000215

ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2021 ОНЫ 12 САРЫН 31 БОЛОН 2022 ОНЫ 06 САРЫН 30 -НЫ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**17,436,247,956**	**17,926,247,956**
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**17,436,247,956**	**17,926,247,956**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	3,190,979,190	3,190,979,190
2021 оны 06 дугаар сарын 30 -ны үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**20,627,227,146**	**21,117,227,146**
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(5,029,769)	(5,029,769)
Залруулсан үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**20,622,197,377**	**21,112,197,377**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,466,136,250	2,466,136,250
Зарласан ногдол ашиг	-	-	(2,000,000,000)	(2,000,000,000)
2021 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**21,088,333,627**	**21,578,333,627**
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**21,088,333,627**	**21,578,333,627**
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	1,980,310,608	1,980,310,608
2022 оны 06 дугаар сарын 30 -ны үлдэгдэл	**110,000,000**	**380,000,000**	**23,068,644,234**	**23,558,644,234**

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

00000216

СЗХ
он сар өдөр
№ 01

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 ОНЫ 12 САРЫН 31 БОЛОН 2022 ОНЫ 06 САРЫН 30 -НЫ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он	2021 оны 01/01-06/30	2022 оны 01/01-06/30
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Тайлант хугацааны ашиг (алдагдал)	**5,657,115,439.94**	**3,190,979,190.03**	**1,980,310,608.00**
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	760,622,744.97	290,918,229.10	387,456,856.48
Валютын ханшийн бодит бус цэвэр гарз/(олз)	(11,450,384.07)	(4,777,837.95)	(37,566,972.14)
Үндсэн хөрөнгө борлуулсаны гарз (олз)	6,294,923.97	0.00	7,145,875.00
Бусад мөнгөн бус орлого	(361,217,937.99)	(41,877,423.36)	(32,867,650.00)
Авлагын өсөлт, бууралт	(2,881,183,930.48)	(2,036,419,069.14)	1,492,885,741.00
Урьдчилж төлсөн зардал/тооцооны өсөлт, бууралт	(779,626,932.85)	(562,327,451.82)	(897,423,433.00)
Төлсөн хүүгийн төлбөр	(291,274,520.56)	(154,425,570.78)	(117,726,392.70)
Бараа материалын өсөлт, бууралт	(911,923,177.23)	583,142,501.94	(3,849,327,445.00)
Богино хугацаат өр төлбөрийн өсөлт, бууралт	1,112,154,626.36	21,738,449.74	933,538,504.90
Орлогын албан татварын зардал	940,057,825.11	389,339,799.74	295,907,324.00
Төлсөн орлогын албан татвар	(442,322,950.08)	(34,666,950.28)	(811,656,431.86)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**2,797,245,727.09**	**1,641,623,867.22**	**(649,323,415.32)**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын борлуулалт	4,500,000.00	0.00	19,500,000.00
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын худалдан авалт	(1,666,375,771.00)	(88,007,864.00)	(537,848,174.40)
Хүлээн авсан хүүний орлого	50,794,529.55	50,794,529.55	438,356.16
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(1,611,081,241.00)**	**(37,213,334.45)**	**(517,909,818.24)**
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хүлээн авсан зээл болон өр төлбөр	284,920,000.00	284,920,000.00	2,567,354,117.00
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт	(920,000,000.00)	(459,999,999.96)	(1,330,994,270.96)
Төлсөн ногдол ашиг	(789,069,160.00)	(24,069,160.00)	(910,000,000.00)
Валютын ханшийн зөрүү	(17,777,430.57)	(11,783,729.65)	(42,750,816.22)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(1,441,926,590.57)**	**(210,932,889.61)**	**283,609,029.82**
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(255,762,104.48)**	**1,393,477,643.16**	**(883,624,203.74)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,646,355,000.07	2,646,355,000.07	2,390,592,895.19
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,390,592,895.59	4,039,832,643.33	1,506,968,691.45

[1] НББОУС 7 Мөнгөн гүйлгээний тайлан -д "Хэрэв зээлийн хүүний зардал болон хүүний орлогыг ашиг, алдагдлаар тайлагнасан бол Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны ангилалаар тусгаж болно гэж заасны дагуу тайлагнасан.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

0000217

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31 БОЛОН 2022 ОНЫ 06 САРЫН 30-НЫ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

КОМПАНИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК нь (цаашид "Компани" гэх) нь 2007 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 110,000,000 төгрөгийн дүрмийн сантайгаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан.

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК нь 2007 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлж 2577127 тоот регистрийн дугаар, 9011110110 дугаартай Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

2019 онд хувь нийлүүлэгчид 1 хүнээр нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 4 болж өөрчлөгдсөнийг 2019 оны 7 сарын 31-нд бүртгүүлсэн байна.

Хувьцаа эзэмшигчид:

Цээпэлийн Ганбат	51%
Цээпэлийн Төгсөө	18%
Заншар Байгалмаа	16%
Герман Штэффэн Мэлцэр Трейд унд Сервис е.кфм	15%

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК-ийн үндсэн үйл ажиллагаа нь хөдөө ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулдаг байна.

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Хүнсний ногоо савлаж худалдаалах
- Жимсний чанамал мармелад үйлдвэрлэх
- Хүнсний бөөний болон жижиглэн худалдаа
- Гадаад худалдаа
- Хүнсний ногоо тариалах, хадгалах, худалдах
- Ундаа, жүүс үйлдвэрлэх
- Цайны газар, Хүнсний дэлгүүр
- Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- ҮХХ-ийн чиглэлээр зөвлөгөө өгөх, худалдаа, зуучлал, түрээсийн үйлчилгээ
- Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ
- Газар тариалан, Хүлэмжийн аж ахуй
- Цайны үйлдвэрлэл, худалдаа
- Фермерийн аж ахуй

а. Ажиллагсдын тоо нийт 280

- Удирдах ажилтан 29
- Гүйцэтгэх ажилтан 251

Компанийн үндсэн үйл ажиллагаа явуулдаг албан хаяг нь Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 20 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс /16102/, 66/01, 66/02 тоот болно.

Компанийн Гүйцэтгэх захирал Цээпэл овогтой Ганбат ба Ерөнхий нягтлан бодогч Гансүх овогтой Үүрийнцолмон нар бөгөөд энэ компани Татварын Ерөнхий газар болон Баянгол дүүргийн Санхүү, татварын хэлтэстэй харилцдаг.

Компани нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэхдээ "DIAMOND" программ ашигладаг байна. Санхүүгийн тайлан нь Орлогын дэлгэрэнгүй тайлан, Санхүүгийн бэйдлын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн дөрвөн тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрддэг.

00000218

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2021 ОНЫ 12 САРЫН 31 БОЛОН 2022 ОНЫ 06 САРЫН 30-НЫ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

1.1 ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Нийцтэй байдлын мэдэгдэл

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн.

Хэмжилтийн суурь

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгслүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

Тайлагнагч валют

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн.

Тасралтгүй үйл ажиллагаа

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

Нягтлан бодох бүртгэлийн томоохон тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх үнэлгээ, таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд оруулсан өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварын дарааллаар толилуулсан.

Зөвхөн хуулиар эрх олгосон тохиолдолд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрч Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулснаас бусад тохиолдолд орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнахгүй.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

1) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кассад байгаа бэлэн мөнгө, банкинд байршуулсан хугацаагүй хадгаламж /3 сар хүртэлх сарын хугацаатай хадгаламж/-с бүрдэнэ. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, хөрвөх чадвар сайтай хөрөнгө болно.

2) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь найдваргүй авлагын нөөцийг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

3) Бараа материал

Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авалтын бүх өртөг зардал, хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдон гарсан бусад зардал орно.

Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана.

Цэвэр боломжит үнийг тооцоход бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасаж тооцно.

Бараа материалын өртгийг тооцохдоо эхэлж авсныг эхэлж зарлагадах эсвэл жинлэсэн дундаж өртгийн аргыг хэрэглэдэг.

Бараа материалыг борлуулах тохиолдолд түүний орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед тэрхүү бараа материалын дансны үнийг зардлаар хүлээн зөвшөөрнө.

4) Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг уг жил гүйлгээ гарсан өдрийн ханшид үндэслэн Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж нэгэн зэрэг бүртгэдэг.

Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст Монгол банкны зарласан хаалтын ханшийг үндэслэн хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түүхэн өртгөөр илэрхийлэгдсэн, анх гадаад валютаар гарсан мөнгөн бус зүйлсийг түүнийг олж бэлтгэх үеийн түүхэн ханшийг ашиглан хөрвүүлж бүртгэдэг.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

4) Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ (үргэлжлэл)

Нэгж гадаад валютын төгрөгтэй харьцах албан ханш:

(төгрөгөөр)

№	Валют	2021.12.31	2022.06.30
1	USD	2,848.80	3,134.10
2	CNY	447.15	468.09
3	RUB	38.34	59.33
4	EUR	3,222.99	3,273.57

5) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрддэг.

Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Үндсэн хөрөнгийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог ба олз, гарзыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Машин тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

6) Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглагдах хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдүүлж, элэгдлийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

- Барилга 25 жил
- Машин тоног төхөөрөмж 10 жил
- Тээврийн хэрэгсэл 10 жил
- Тавилга, эд хогшил 10 жил
- Компьютер түүний дагалдах хэрэгсэл 2 жил
- Бусад үндсэн хөрөнгө 10 жил

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

7) Түрээсэлсэн хөрөнгө

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгөөр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа тохиолдолд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Ийм тодорхойлолтыг хэлцлийн шинж байдлыг үнэлсний үндсэн дээр хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийн хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

Компанийн түрээсэлж буй хөрөнгийн ангилал

- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлэх нөхцөлтэй бол санхүүгийн түрээс гэж ангилна.
- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх нөхцөлгүй түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилдаг.

Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээсэлсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг. Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түрээсэлсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг. Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжиж ирэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

Үйл ажиллагааны түрээс

Компани нь үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмших хөрөнгийг ашиглаж буй тохиолдолд түрээсийн дагуу хийгдсэн төлбөрүүдийг түрээсийн хугацаанд хамрагдах тайлант үеүдэд тэнцүү хэмжээгээр дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

8) Сангууд

Компанид (а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа (б) энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

00000222

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

9) Санхүүгийн хэрэглүүр

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Компани тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрдөг. Үүнд “хэвийн нөхцөлтэй арилжаа” буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно

(ii) Зээл ба авлага

Компани санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон зөвхөн тийм тохиолдолд санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийг өөрийн санхүүгийн байдлын тайландаа хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр хэмжих ба харин ашиг алдагдлаар дамжуулан тусгах бодит үнэ цэнээс өөр дүнгээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө буюу өр төлбөр байх тохиолдолд тэдгээрийг олж эзэмших буюу гаргахад шууд хамаарах ажил гүйлгээний зардлыг уг дүн дээр нэмж эсвэл хасах байдлаар хэмжинэ.

Анх хүлээн зөвшөөрсний дараа санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ:
1. хорогдуулсан өртгөөр
2. бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр үнээр
3. ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тус тус хэмжинэ.

Хэмжилтийн сонголт нь санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулах тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар, гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанараас хамаарна.

Санхүүгийн хөрөнгө нь мөнгө, худалдааны ба бусад авлага, борлуулахад бэлэн байгаа үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

10) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Компани тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
- Компани хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

11) Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнийн тодорхойлолт

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд зохих журмын дагуу хөрөнгө борлуулснаас орж ирэх эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ байна.

Бодит үнэ цэнийн хэмжилтийг дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээнд үндэслэн хийдэг. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн ашигтай зах зээлд

Үндсэн зах зээл болон хамгийн ашигтай зах зээл нь Компанийн хувьд оролцож болохуйц зах зээл байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадах эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгөх нөхцөлд тооцно.

Компани нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай мэдээллүүд нь хангалттай олдоцтой үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн бага түвшинд байлгадаг.

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэж, санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг.

Түвшин 1 - Хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхитэй зах зээл дээрх үнэ,

Түвшин 2 - Бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бусад техникүүд,

Түвшин 3 - Бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашигладаггүй аргачлалууд.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)
Тайлант хугацааны эцэст Компани нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг (бодит үнэ цэнийн хэмжилтэд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн).

12) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтад орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн хувьд Компани эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь дангаараа чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ.

Хэрэв Компани нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдэлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтыг нэг бүрчлэн үнэлсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Хэрэв үнэ цэнэ буурсан талаарх бодит нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгийн дансны үнэ болон ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын (тохиолдоогүй байгаа ирээдүйн, хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын гарзыг оруулахгүй) өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ.

00000226

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

12) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд (үргэлжлэл)

Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл Компанид шилжүүлсэн үед, зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Өмнөх жилүүдэд данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл эргэн төлөгдсөн дүнг ашиг, алдагдлын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах нөхцөлтэй бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь дахин ангилсан өдрөөрх өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна.

Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтыг багцын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдэлийн шинж чанаруудыг харгалзан үзсэн Компанийн дотооддоо хэрэглэдэг зээллэгийн ангиллын систем дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг бүлэглэнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгадаг. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

13) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Зөвхөн хуулиар эрх олгосон, хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд толилуулдаг.

14) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Компанид эдийн засгийн өгөөж орох магадлалтай бөгөөд орлогыг хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

Барааг нийлүүлсэн буюу үйлчилгээг үзүүлсэн үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

(i) Бараа, үйлчилгээний борлуулалт

- Компани нь ажил үйлчилгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай,
- Компани нь бараа үйлчилгээний өмчлөлтэй холбогдсон мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн,
- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой,
- Бараа үйлчилгээтэй холбогдон гарсан болон гарах зардлыг найдвартай хэмжих боломжтой.

(ii) Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого

Тайлант хугацааны худалдан авагчтай байгуулсан гэрээний орлогыг дараах алхмаар тодорхойлж хүлээн зөвшөөрнө.

- Худалдан авагчтай байгуулсан гэрээг тодорхойлох,
- Гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох,
- Ажил гүйлгээний үнийг тодорхойлох,
- Ажил гүйлгээний үнийг хуваарилах,
- Орлого хүлээн зөвшөөрөх

Гэрээний орлого нь анх байгуулсан гэрээгээр тохиролцсон дүн байх ба гэрээгээр зохицуулснаас гадуурх ажлын өөрчлөлт урамшууллын орлого нь ихэнх тохиолдолд орлогоор бүртгэгдэх ба тэдгээр нь бодитоор хэмжигдэх боломжтой байна.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

14) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх (үргэлжлэл)

(iii) Өртөг зардлыг хүлээн зөвшөөрөх

Зардал гэдэг нь өмч эзэмшигчдэд олгосон хуваарилалтаас бусад өмчийг бууруулах үр дүн бүхий хөрөнгийн зарлага эсвэл өр төлбөр үүсгэх тухайн тайлант хугацааны эдийн засгийн өгөөжийн бууралт.

Өртөг зардлыг орлогын хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан аккруэл сууриар, бодит дүнгээр хүлээн зөвшөөрдөг. Гэрээний өртөг нь тухайн гэрээтэй шууд холбогдсон зардал байх ба гэрээнд хамаатуулж болох бусад зардлыг гэрээнд хуваарилж болно.

15) Татвар

(i) Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тайлант үеийн татвар ногдох орлогоос тооцож төлөх татварын өглөг болон өмнөх тайлант хугацааны тайлант үед төлөх татвариг түүний төлөгдөөгүй байгаа дүнгээр татварын өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

(ii) Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон тэдгээрийн татварын суурь хоорондын түр зөрүүнээс тооцоолж хүлээн зөвшөөрдөг.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн дансны үнийг санхүүгийн тайлангийн өдөр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг дансны үнийг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хэрэв хуулиар хэрэгжүүлэх эрх нь үүссэн бол нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

16) Эздийн өмч

(i) Хувьцаат хөрөнгө

Тухайн компанийн нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

(ii) Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь тухайн тайлант хугацаанд хуримтлуулсан нийт ашиг, алдагдлын дүнгээс зарлагдсан ногдол ашгийг хассан дүнгээр тодорхойлогдох ба өмнөх үеийн залруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөллийг тусгасан байж болно.

17) Холбоотой талуудын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуй нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(а) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

(i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
(ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
(iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:

(i) Аж ахуй нэгж нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
(ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох группийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
(iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд байх.
(iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани байх.
(v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
(vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ТОВЧОО (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

17) Холбоотой талуудын ажил гүйлгээ (үргэлжлэл)

(vii) (a) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(viii) Аж ахуй нэгж нь эсвэл групппийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтан байх.

Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийхийг шаарддаг ба болзошгүй өр төлбөр, хөрөнгүүдийг тодруулахыг шаарддаг. Ойролцоолсон тооцоолол, төсөөллийг хэрэглэсэн үнэлэмж, төсөөллийг өөрчлөхөд хүргэх үйл явдлууд ирээдүйд тохиолдож болно. Төсөөлөл, ойролцоолсон тооцооллыг байнга шалгаж үздэг ба эдгээр нь туршлага, ирээдүйн үйл явдлын талаарх хүлээлт гэх мэт хүчин зүйлээс хамаардаг.Гэхдээ бодит үр дүн эдгээр ойролцоолсон тооцооллоос ялгаатай байж болно.

Тасралтгүй үйл ажиллагаа

Компанийн удирдлага Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үздэг бөгөөд Компани нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэдэг. Цаашилбал удирдлага нь компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг хэмжээний, тодорхой бус байдлын талаар олж мэдсэн зүйлгүй байна. Тийм тохиолдолд компанийн санхүүгийн тайлангуудыг тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэдэг.

2. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

№	Мөнгөн хөрөнгийн зүйлс		2020.12.31		2021.12.31		2022.06.30	
			Валют	Төгрөг	Валют	Төгрөг	Валют	Төгрөг
Касс дахь бэлэн мөнгө								
1	Касс	MNT	-	1,577,542,566.16	-	1,142,728,674.30	-	760,085,714.68
2	Касс	EUR	472.7	1,652,455.21	2,340.00	7,541,796.60	-	-
3	Касс	CNY	24,499.93	10,685,154.47	-	-	-	-
4	Касс	RUB	480,000.00	18,480,000.00	-	-	-	-
	Дүн			1,608,360,175.84		1,150,270,470.90		760,085,714.68
Банкин дахь мөнгө								
1	Голомт Банк 1601003176	MNT	-	59,267,489.35	-	106,879,902.39	-	92,238,244.55
2	Голомт Банк 1601020741	USD	6,972.91	19,869,376.77	55,075.38	156,898,742.54	122.64	384,388.10
3	Голомт Банк 1605033671	CNY	2,673.58	1,166,028.45	2,646.12	1,183,346.70	2,633.40	1,231,588.51
4	Голомт Банк 1605144389	USD	147.71	420,901.12	48.75	138,879.00	822.66	2,578,446.78
5	Голомт Банк 1605102938	RUB	12,100.59	465,872.72	682.08	26,150.95	527.77	32,642.57
6	Голомт Банк 1605140271	EUR	10,904.37	38,119,278.56	532.87	1,717,434.68	64.69	213,158.08
7	ХААН Банк 5014313784	MNT	-	777,813,492.54	-	476,057,691.46	-	490,273,507.22
8	ХААН Банк 5014331055	USD	391.52	1,115,640.16	5,792.59	16,501,930.39	209.11	655,409.29
9	ХААН Банк 5014331066	CNY	318,373.40	138,852,190.94	641,081.89	286,659,767.11	338,049.29	158,098,891.95
10	ХААН Банк 5176010411	RUS	3,059.11	117,775.74	5,047,422.77	193,518,189.00	6,740.44	416,896.21
11	ХХБанк 406098226	MNT	-	518,792.07	-	506,092.07	-	499,292.07
12	ХХБанк 406098227	USD	37.73	107,512.01	33.57	95,634.22	31.57	98,949.22
13	ХХБанк 406098228	CNY	212.59	92,716.88	185.66	83,017.87	172.66	80,749.63
14	ХХБанк 406098229	RUB	1,759.92	67,756.92	1,451.38	55,645.91	1,306.59	80,812.59
	Дүн			1,037,994,824.23		1,240,322,424.29		746,882,976.77
	Нийт дүн			2,646,355,000.07		2,390,592,895.19		1,506,968,691.45

0000232

3. ДАНСНЫ АВЛАГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Дансны авлага	Дансны авлага (цэвэр дүнгээр)
	2020 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	2,244,050,936.17	2,244,050,936.17
	Нэмэгдсэн	32,736,689,480.18	32,736,689,480.18
	Хасагдсан :	32,045,411,879.61	32,045,411,879.61
	2021 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	2,935,328,536.74	2,935,328,536.74
	Нэмэгдсэн	17,211,150,461.73	17,211,150,461.73
	Хасагдсан :	16,370,427,439.98	16,370,427,439.98
	2022 оны 6 дугаар сарын 30 -ны үлдэгдэл	3,776,051,558.49	3,776,051,558.49

2022 оны 6 сарын 30 -ны өдрөөрх дансны авлагын үлдэгдлийн дэлгэрэнгүй:

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Дүн
1	Дансны авлага (Борлуулалт)	2,733,020,758.49
2	Материал Импекс ХХК (Газар)[1]	[1] 1,008,096,000.00
3	Бусад НӨАТ-тэй байгууллага	34,934,800.00
	Нийт дүн	3,776,051,558.49

[1] 2020.12.31 -нээс 2022.06.30 -ны өдрийн тайлант хугацааны эцсийн өдрүүдийн Дансны авлагын үлдэгдэлд Материал Импекс ХК -тай холбоотой үүссэн 1,008,096,000 төгрөгийн авлагын тооцооны үлдэгдэл тайлагнагдсан байна.

Энэ тооцоо нь 2014.10.01-ний өдөр Газар Шим Үйлдвэр ХХК-ийн эзэмшлийн газар дээр Материал Импекс ХК нь үйлчилгээ, орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө барих тухай хамтран ажиллах гэрээ байгуулсан ба 2022 оны 08-р сарын 29-ний өдөр хийгдсэн гэрээний нэмэлт өөрчлөлтөөр Материал Импекс ХК нь барилгын ажлыг эхлүүлснээс хойш 4 жилийн дотор 560 мкв бүхий үл хөдлөх хөрөнгийг Газар Шим Үйлдвэр ХХК -д хүлээлгэн өгөхөөр харилцан тохиролцсон байна. Авлагын үлдэгдлийг баталгаажуулсан. Удирдлага тус тооцооны авлагыг үнэ цэнийн бууралтад ороогүй гэж үзэж байгаа болно.

Борлуулалттай холбоотой дансны авлагын хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хэмжихдээ нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийг байгуулах СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр -т заасан хялбаршуулсан аргыг ашиглав. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг цуглуулагдах сууриар хэмжихдээ дансны авлагыг ижил зээлийн эрсдэл болон насжилтанд үндэслэн, санхүүгийн зохицуулагч Олон улсын байгууллагуудаас гаргасан зах зээлийн дундаж хүү, эрсдлийн мэдээлэлд үндэслэсэн болно. Хорогдуулсан өртгөөр ангилсан дансны авлагын дансны үнэ цэнэ нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байна.

4. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН АВЛАГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	2022.06.30
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	561,419.73	10,577,169.61	-
2	Хойшлогдсон нэмэгдсэн өртгийн албан татвар	14,585,578.04	95,949,141.37	97,261,253.36
3	Нийслэл хотын албан татвар	2,939.29	2,939.29	2,939.29
4	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,077,670.67	3,537,290.67	18,111,843.27
5	Хувь хүний орлогын албан татвар	-	-	-
6	Нийгмийн даатгалын шимтгэл	9,879,671.14	10,846,147.70	-
	Нийт дүн	29,107,278.87	120,912,688.64	115,376,035.92

00000233

5. БУСАД БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31	2022.06.30
1	Холбоотой талаас авах авлага	2,171,779,583.38	5,327,029,199.77	3,083,258,689.67
2	Агентын ажилтнуудаас авах авлага	205,804,295.12	607,183,141.97	544,132,214.16
3	Агентын авлагаас тооцсон – Хорогдуулсан өртөг	-	(14,424,735.77)	(34,260,356.77)
4	Бусад авлага	1,447,560,357.98	3,457,550.83	2,042,500.00
	Нийт дүн	3,825,144,236.48	5,923,245,156.80	3,595,173,047.06

2022.06.30 -ны өдрөөрх бусад богино хугацаат авлагын үлдэгдлийн дэлгэрэнгүй:

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2022.06.30	Эзлэх хувь	Тайлбар
1	Ц.Ганбат[1]	2,104,554,396.29	59%	Хувь нийлүүлэгч
2	Ц.Төгсөө[2]	186,926,581.00	5%	Хувь нийлүүлэгч
3	Эйч Эс Зэт ХХК (Холбоотой тал)	791,777,712.38	22%	Усны төлбөр
4	Агентын ажилтнуудаас авлага	76,235,782.48	1%	Насжилт тооцооллоор 90 хоног дотор
5	Найдваргүй авлагын нөөц *	(34,260,356.77)	-	Агентын авлагаас тооцсон хорогдуулсан өртөг
6	Ажилчид зээл (Байр)[3]	217,896,431.68	6%	Нэр бүхий 10 ажилтанд олгосон зээл.
7	Холбоотой тал, зээл (Гансүх)[4]	250,000,000.00	7%	Орон сууцны байрны барьцаа бүхий зээл
8	Бусад авлага	2,042,500.00	0%	Болорцогт (шил тээвэр).
	Нийт дүн	3,595,173,047.06	100%	

[1] Ц.Ганбат захирал 2021 оны тайлант жилийн эхэнд компанид 314,306,800 төгрөгийн өртэй байсан ба 2021 онд 2,817,211,276.39 төгрөгийн, 2022 онд 990,000,000 төгрөгийн хүүгүй зээлийг тус тус компаниас авч, 2022 оны тайлант жилд 2,016,963,680.10 төгрөгийн зээл төлснөөр 2022.06.30 -ны байдлаар 2,104,554,396 төгрөгийн тооцооны үлдэгдэлтэй байгааг баталгаажуулсан байна.

[2] Ц.Төгсөө захирал 2021 оны тайлант жилийн эхэнд компанид 216,926,580 төгрөгийн өртэй байсан ба 2021 онд 853,720,000 төгрөгийн хүүгүй зээл авч, 629,158,580.00 төгрөгийг нь төлсөн байна. 2022 онд 50,000,000 төгрөгийн зээл авч, 304,561,419 төгрөгийн зээлийг төлсөн ба тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.

[3] Компаниас ажилтнуудаа дэмжих зорилгоор дунджаар 6 жилийн хугацаатай, жилийн 8 хувийн хүүтэй зээл олгосон.

[4] 2021.06.18 -нд сарын 1.5 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай, орон сууцны байр барьцаалсан зээл олгосон.

** Агентын ажилтнууд дээрх тооцооны үлдэгдлийг насжилтаар ангилан, нийт хугацааны туршид хүлээгдэж буй зээлийн алдагдлын нөөцийг байгуулах СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр -т заасан хялбаршуулсан аргыг ашиглан, санхүүгийн зохицуулагч Олон улсын байгууллагуудаас гаргасан зах зээлийн дундаж хүү, эрсдлийн мэдээллийг ашиглан хорогдуулалтыг тооцсон болно.*

6. БАРАА МАТЕРИАЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2020.12.31	Нэмэгдсэн дүн	Хасагдсан дүн	2021.12.31	Нэмэгдсэн дүн	Хасагдсан дүн	2022.06.30
1	Түүхий эд материал	1,513,598,615.54	7,389,362,424.64	8,902,960,736.29	303.89	-	303.89	-
2	ТЭМ амтлагч	-	811,952,493.64	300,860,659.88	511,091,833.76	1,333,741,254.21	1,068,238,279.35	776,594,808.62
3	ТЭМ хүнсний ногоо	-	4,294,344,820.41	2,242,259,615.16	2,052,085,205.25	4,945,351,260.99	4,564,465,411.28	2,432,971,054.96
4	Түүхий эд материал/Хяналт/	-	50,561,590.65	4,709,508.13	45,852,082.52	9,764,830,086.01	9,649,823,878.77	160,858,289.76
5	ТЭМ шил, хайрцаг, хаяг, таг	-	3,491,196,976.47	2,400,114,236.40	1,091,082,740.07	6,349,208,907.81	4,513,025,848.37	2,927,265,799.51
6	Хүнсний ногоо (Орхон)	-	178,032,637.75	-	178,032,637.75	11,821,544.88	189,854,182.63	-
- Жишиг компаниудын 2021 оны тайлант жилийн гүйцэтгэлд суурилсан БҮЦ/ХТӨА үржүүлэгчийг үнэлгээний өдрөөрх зах зээлийн үнэлгээнд гарсан өөрчлөлтөөр засварлан, компани тус бүрийн ХТӨА-ийн маржинаас БҮЦ/ХТӨА харьцааны хамаарах хамаарлын шинжилгээгээр тохируулснаар "Газар шим үйлдвэр" ХХК-д дүйцэх БҮЦ/ХТӨА үржүүлэгчийг 11.5х байх нь үндэслэлтэй хэмээн тооцож, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2022 оны хүлээгдэж буй ХТӨА-т суурилан шинжлэхэд тус компанийн цэвэр өрийг хассаны дараах 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ 68,922 сая төгрөг байхаар байна.

- Дээр дурдсанчлан, Зах зээлийн хандлагын 3 өөр үржүүлэгчид суурилсан шинжилгээгээр үнэлгээний өдрөөрх "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 64,996 сая төгрөгөөс 68,922 сая төгрөгийн хооронд байх магадлалтай байна.

- МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг хүнсний салбарын компаниудын зах зээлийн үржүүлэгчийн доод квартил утга нь Үнэ/Ашиг харьцааны хувьд 9.3х, Үнэ/Борлуулалт харьцааны хувьд 1.8х, БҮЦ/ХТӨА харьцааны хувьд 7.7х байсан бол дээд квартил утга нь Үнэ/Ашиг харьцааны хувьд 19.0х, Үнэ/Борлуулалт харьцааны хувьд 2.3х, БҮЦ/ХТӨА харьцааны хувьд 16.1х байсан. Эдгээр зах зээлийн үржүүлэгчид суурилан өмчийн үнэ цэнийн доод болон дээд хүрээг шинжлэхэд, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2022 оны 6 дугаар сарын 30-наар 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 54,410 сая төгрөгөөс 99,076 сая төгрөгийн хооронд хэлбэлзэх магадлалтай байна.

Зах зээлийн хандлагын ЖКАЗ-н талаарх тооцооллын дэлгэрэнгүйг Хүснэгт 54, Хүснэгт 55 болон Хүснэгт 61-аас 66-д харуулсан.

- ***Дээрх баталгаажуулах аргууд нь ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргаар гарсан бидний дүгнэлтийг дэмжиж байна.***

Дүгнэлт гаргасан аргыг дэмжих аргуудын хураангуй

- Үнэлгээний өдрөөр, IPO гаргасны дараах байдлаар, үнэлгээний үндсэн аргыг баталгаажуулах аргуудын доод ба дээд квартил утгуудад суурилсан шинжилгээгээр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь **51,058 сая төгрөгөөс 97,152 сая төгрөгийн хооронд (дүгнэлтийн хувилбар: 61,933 сая төгрөгөөс 65,087 сая төгрөг)** байх үндэслэлтэй байна.

График 1. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн IPO гаргасны дараах өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт ба дүгнэлтийг баталгаажуулах аргуудын зэрэгцүүлэлт (сая.төг)



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

График 2. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн IPO гаргасны дараах өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт ба дүгнэлтийг баталгаажуулах аргуудын хураангуй дүрслэл (сая.төг)



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

2. Ажлын цар хүрээ

2.1 Үйлчлүүлэгчийн мэдээлэл

- "Газар шим үйлдвэр" ХХК нь энэхүү үнэлгээний ажлын үйлчлүүлэгч тал мөн болно.
- Үйлчлүүлэгч нь Монгол улс, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 20 дугаар хорооны нутаг дэвсгэр, Үйлдвэрийн бүс, 66/1, 66/2, 66/3 тоот байранд байрладаг.
- "Газар шим үйлдвэр" ХХК нь анх 1999 оны 7 дугаар сарын 23-ны өдөр улсын бүртгэлд "ГБТ Трэйдинг" ХХК нэртэйгээр бүртгүүлж, хүнсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.
- Түс компани нь 2007 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт 9011110110 улсын бүртгэлийн дугаар, 2577127 регистрийн дугаартайгаар шинэчлэн бүртгүүлсэн.
- Түс компани нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. Үүнд:
  i. Хүнсний ногоо савлаж худалдаалах
  ii. Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх
  iii. Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх
  iv. Хүнсний ногоо тариалах, худалдах
  v. Жимс, жимсгэнэ тариалах, худалдаалах
  vi. Ундаа, жүүс үйлдвэрлэх
  vii. Цайны газар ажиллуулах
  viii. Хүнсний нэрийн барааны дэлгүүр ажиллуулах.
- "Газар шим үйлдвэр" ХХК нь Монголын хүнсний салбарын тэргүүлэгч үйлдвэрлэлийн компаниудын нэг бөгөөд Алсын хараагаа "Дэлхийн жишигт хүрнэ", Эрхэм зорилгоо "Хүнээ дээдлэн эрүүл чанартай хүнс үйлдвэрлэгч, шинийг санаачлагч, тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэгч компани байна", Үнэт зүйлсээ "Хүн Чанар Хөгжил" хэмээн тодорхойлсон.
- "Газар шим үйлдвэр" ХХК нь 280 ажиллагсадтайгаас 29 нь удирдах ажилтан, албан хаагчид, 80 нь түр ажиллагсад, бусад нь хөдөлмөрийн гэрээтэй үндсэн ажиллагсад байна.
- Түс компанийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдаалах нэрийн барааны дэлгүүр нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 10-р хороолол, Баянзүрх дүүргийн Жанжин зах, Нарантуул захад байрладаг.
- 2008 оноос "Газар шим үйлдвэр" хүнсээр дамжуулан "Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр" боловсруулан туршилт судалгаануудыг хийсний үр дүнд 2011 онд "Артишок" эрүүл мэндийн ундааг үйлдвэрлэн гаргасан. Ундааны түүхий эдийг Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь өөрийн хүлэмжийн аж ахуйдаа тарьж ургуулдаг байна.
- Түс компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь 2003, 2004, 2005 онуудад "Нийслэлийн шилдэг бүтээгдэхүүн"-ээр шалгарч, 2007 онд ХХААЯ-наас "Монгол улсын жимс, хүнсний ногоо боловсруулах шилдэг үйлдвэрлэгч", 2010 онд "Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүн" өргөмжлөл, 2011 онд ХХААХҮ-ийн Яам, НЗДТГ, МҮХАҮТ-ын хамтарсан шагнал болох "Эрүүл мэндийг тэтгэгч шилдэг бүтээгдэхүүн" шагнал, 2012-2013 онуудад "Best Green New Product Award", 2013 онд "Инновац лицензийн хэрэгжүүлэгч брэнд" шагналыг түс түс хүртэж, 2018 онд "ISO-9001.2015 Чанарын менежментийн тогтолцоо", "ISO-22000.2018 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо", "Үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)" стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хэрэгжүүлсэн. Мөн 2019 онд "Органик монгол хүнсний "MNS CAC/GL 32:2017"стандартын шаардлагыг хангаж, Артишокын тариалалт, Артишокын ханд, Артишок ундаа зэрэг бүтээгдэхүүндээ "Органик монгол хүнс" баталгаажуулалт авсан.

Хувьцаа эзэмшигчид

- Үнэлгээний өдрийн дараа компанийн дүрэмд орсон өөрчлөлтөөр хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн нь дараах байдалтай болсон байна.

Хүснэгт 3. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчид	Иргэний харьяалал	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь
Ц.Ганбат	Монгол	510,000,000	51.0%
Ц.Төгсөө	Монгол	130,000,000	13.0%
З.Байгалмаа	Монгол	110,000,000	11.0%
Штэффэн Мэлцэр	Герман	150,000,000	15.0%
Д.Сэргэлэн	Монгол	50,000,000	5.0%
Г.Түвшинзаяа	Монгол	50,000,000	5.0%
Нийт		**1,000,000,000**	**100%**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК

Төлөөлөн удирдах зөвлөл

- Үнэлгээний өдрийн байдлаар "Газар шим үйлдвэр" ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй байсан.

2.2 Зориулагдсан хэрэглээ

- Энэхүү үнэлгээний тайланг Монголын хөрөнгийн бирж дээр компанийн энгийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгон гаргах (IPO гаргах) зориулалтаар хэрэглэнэ.

- Энэхүү үнэлгээний тайлангийн зорилтот хэрэглэгчид нь дараах талууд бөгөөд өөр өөрсдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд зориулан ашиглана. Үүнд:

  i. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, тус компанийн сонгосон андеррайтер нь IPO гаргах үйл явцад зориулан хэрэглэнэ;
  ii. СЗХ нь тус компанийн үнэт цаасыг хөрөнгийн зах зээл дээр гаргах зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргах зохицуулалтын зорилгоор хэрэглэнэ;
  iii. МХБ нь тус компанийн хувьцааг бүртгэж, биржээр дамжуулан арилжаалах эсэх шийдвэрийг гаргах зорилгоор хэрэглэнэ;
  iv. Ирээдүйн хөрөнгө оруулагчид тус компанийн хувьцаанд хөрөнгө оруулах шийдвэр гаргах зорилгоор тус тус энэхүү тайланг ашиглана.

- Энэхүү үнэлгээний тайланд тусгагдсан үнэлгээний тооцоолол нь санхүүгийн тайлагнал, аливаа зарга, маргаан болон дээр дурдаагүй бусад зорилгоор хэрэглэхэд зориулагдаагүй болно.

2.3 Үнэлгээний даалгавар

- Үйлчлүүлэгч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн үнэ цэнийг хараат бусаар тодорхойлох бизнесийн үнэлгээ хийхийг биднээс хүссэн. Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу бид үнэлгээний даалгаврыг дараах байдлаар тодорхойлсон:

  - Компанийн нийт капиталын буюу байгууллагын хэмжээний бизнесийн зах зээлийн үнэ цэнийг Үнэлгээний өдрийн байдлаар тодорхойлох;
  - Компанийн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг Үнэлгээний өдрийн байдлаар тодорхойлох;
  - "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бизнесийн зориулалтаар өмчилсөн газар, үл хөдлөх хөрөнгө, үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж болон тодорхойлох боломжтой бөгөөд эрх бүхий оюуны өмчийн байгууллагад бүртгүүлэн хамгаалагдсан оюуны өмчийн зах зээлийн үнэ цэнийг бизнесийн үнэлгээний тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн аргаар хийх үнэлгээнд ашиглах зориулалтаар тодорхойлох.

2.4 Хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаа

- Тус компани нь 2022 оны сүүлийн хагас жилд багтаан МХБ-д хувьцаагаа гаргахаар төлөвлөсөн. IPO гаргахад санал болгох энгийн хувьцааны хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд харууллаа.

- Компани IPO гаргалтаар 198,113,207 ширхэг хувьцаа шинээр гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд ингэснээр одоогийн энгийн хувьцааны тоог 200,000,000 ширхэг хувьцааг 5000 хуваан жижгэрүүлсэн 1,000,000,000 ширхэг хувьцааг 1,198,113,207 ширхэг болгон нэмэгдүүлнэ.

Хүснэгт 4. IPO гаргасны дараах хувьцааны тоо ширхэг

Хувьцааны тоо ширхэг		*хувиар*
IPO гаргахаас өмнөх хувьцааны тоо	1,000,000,000	83.5%
Шинээр нэмж гаргах хувьцааны тоо	198,113,207	16.5%
IPO гаргасны дараах хувьцааны тоо	**1, 198,113,207**	**100%**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр

2.5 Мэргэшсэн үнэлгээчид

- БДО Аудит ХХК (бусад улсууд дахь БДО-ийн пүүсүүдээс ялган таних зорилгоор цаашид "БДО Монгол" хэмээн нэрлэнэ) нь үйлчлүүлэгчийн хүсэлтээр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэгч хараат бус мэргэжлийн байгууллага болно. Бид өөрийн компанид ажилладаг СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчид болон үнэлгээний мэргэжилтнүүдэд суурилан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхээс гадна үнэлгээний бус үйлчлүүлэгчдэд аудитын болон бусад зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, БДО олон улсын сүлжээний Монгол улс дахь гишүүн компани юм.

- Үнэлгээний багийг БДО Монгол-ын үнэлгээ хариуцсан партнер (БДО-ийн дүрмээр партнер хэмээн нэрлэдэг) ноён Г.Баянмөнх удирдан чиглүүлсэн. Үнэлгээний багийн гишүүдийн талаарх мэдээллийг Хавсралт IV-ээс харна уу. Энэ үнэлгээний ажилд тооцооллын болон шинжилгээний аливаа нарийн төвөгтэй нөхцөл байдал үүсэх

магадлал бага гэж таамагласан үчраас үнэлгээний ажилд аливаа хөндлөнгийн туслалцаа аваагүй.

- Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу БДО Монгол нь энэ үнэлгээний тайланд хариуцлага хүлээх бөгөөд мэргэжлийн хариуцлагаа Номин даатгал ХХК-аар даатгуулсан. Мөн түүнчлэн манай мэргэшсэн үнэлгээчид нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа Номин даатгал ХХК-аар даатгуулсан болно.

- БДО Монгол болон үнэлгээнд оролцсон үнэлгээчид, мөн үнэлгээний туслах ажилтнууд нь "Газар шим үйлдвэр" ХХК-д энэхүү үнэлгээний үйлчилгээнээс өөр үйлчилгээ үзүүлдэггүй, хувьцаа эзэмшдэггүй, үнэлгээний үр дүнд нөлөөлөх аливаа ашиг сонирхлын зөрчилгүй болно. (Үнэлгээний багийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг Хавсралт III-аас үзнэ үү.)

2.6 Түсгай зохицуулалтууд

- Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтээс гаргасан Ёс зүйн дүрмийн дагуу бид өөрсдийн үнэлгээний тайланд түсгагдсан үнэ цэнийн талаарх дүгнэлтийг Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Ёс Зүйн Хороо болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хамгаалах эрхтэй.

2.7 Үнэ цэнийн суурь

- Бид энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний олон улсын стандартын консул (ҮОУСК)-ын бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС)-ыг даган мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд зах зээлийн үнэ цэнийн суурийг ашигласан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

- Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь ҮОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу "зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн"-г хэлнэ. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтыг дараах үзэл баримтлалын дагуу ашиглана:

  - "Тооцоолсон дүн" – харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс үл үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн үл үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин ерөнхий санхүүжилт, борлуулалт ба бүцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай төлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид хамаарах үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.

  - "Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино" – гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцөлийг илэрхийлнэ. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах үг ажил гүйлгээний үнэ байдаг.

  - "Үнэлгээний өдрөөр" – гэдэг нь тухайн үнэ цэнэ үг өдрийн байдлаар гэх мэт тусгай цаг хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас үг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад дурын өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал ба нөхцөлүүдийг тусган илэрхийлдэг.

  - "Бэлэн байгаа худалдан авагч" – гэдэг нь худалдан авах сэдэл санаачилгатай боловч тийм албан үүрэг хүлээгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийг буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал болон одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчдийн нэг болдог.

  - "Бэлэн байгаа борлуулагч" – нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг үл үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцөлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачилгатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.

- "Хамааралгүй талуудын ажил гүйлгээ" – нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тухайлсан буюу тусгай харилцан хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь түс бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.

- "Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа" – гэдэг нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган таниулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхааралд уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой.

- "Талууд түс бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй" – гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар ул үндэслэлтэйгээр мэдээлсэн байна гэсэн урьдчилсан нөхцөлийг илэрхийлнэ. Талууд түс бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр суурины хувьд хамгийн тааламжтай байх үнийг олохын тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгөөр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл, борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

- "Албан шахалт шаардлагагүй" – гэдэг нь тал түс бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачилгатай боловч түүнийг гүйцэтгүүлэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.

- Үнэлгээний тайланд ашигласан орц мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлгээний тайлангийн туршид тусгайлан зааснаас бусад үзүүлэлтийн хувьд монгол төгрөгөөр, сая төгрөгийн нарийвчлалтайгаар ашиглана. Үнэлгээний валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг болно.

2.8 Үндсэн төсөөллүүд

- Дараах ерөнхий болон тусгай төсөөллүүдэд үндэслэн, түс компанийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон. Доор дурдсан төсөөллүүд нь Үнэлгээний өдрийн байдлаар оршин байгаа бодит байдалтай нийцэж байна гэж үзсэн болно. Үүнд:

  - Үнэлэгдэж буй компани нь дүнд хугацаанд өөрийн эрхэлдэг бизнесийг тасралтгүйгээр үргэлжлүүлнэ;

  - Үнэлэгдэж буй компанийн тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэлд ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацаанд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй;

  - Үйлчлүүлэгчээс бидэнд ирүүлсэн мөнгөн урсгалын төсөөлөл нь түс компанийн болон Монгол улсын хүнсний салбарын түүхэн хандлагад суурилсан. Бизнес төлөвлөгөөнд багтсан мэдээллийн агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой байна гэж төсөөлсөн;

  - Дүнд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-д багтсан аливаа тооцоолол нь бизнесийн үйл ажиллагааны хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалтад үндэслэсэн [1]. Энэхүү санхүүгийн төлөвлөгөөнд байгууллагын нөөц ашиглалтыг боломжит хамгийн дээд түвшинд тодорхойлсон бөгөөд эдгээр тооцоолол нь удирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж төсөөлсөн. Дүнд Хугацааны Санхүүгийн Төсөөлөлд ашигласан төсөөллийг Үнэлгээний шинжилгээ хэсгээс дэлгэрүүлнэ үү;

  - Хөдөлмөрийн орц, ажиллах хүчний сургалт, ажил олгогчоос ажилтанд олгох нийгмийн халамжийн зардалд бизнес төлөвлөгөөнд тусгаснаас давсан огцом өсөлт гарахгүй. Мөн түүнчлэн ажиллах хүчний мэргэжлийн ур чадварын дутагдал, мэргэжлийн ёс зүйн доголдлоос үүсэх аливаа зарга, маргаан үүсэхгүй;

[1] *Энд үнэ цэнийн урьдчилсан нөхцөл нь "хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт" байна. Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт гэдэг нь Оролцогчийн хэтийн төлөвөөс авч үзсэн, тухайн хөрөнгүйн хувьд хамгийн өндөр үнэ цэнийг бий болгодог ашиглалт юм.*

- Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт тус компанийн бизнесийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлэхгүй;

- Тус компанийн бизнесийн үйл ажиллагаа нь Монголын татварын хуулиар зохицуулагдах бөгөөд 2020 оны 1 дүгээр сараас мөрдөгдсөн татварын шинэчлэгдсэн зохицуулалтаар үргэлжлэн зохицуулагдана;

- Тус компанийн санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө/өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг хариуцлага, Үнэлгээний өдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй шүүхийн зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй;

- Хүнсний салбарт мэдэгдэхүйц нөлөөлөх байгалийн гамшиг, цаг үурын таагүй нөхцөл ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацааны туршид үүсэхгүй. Үнэлгээний өдрийн байдлаар, ОХУ-Украйны дайн, Ковид-19 цар тахлаас үүдэлтэй нийлүүлэлтийн саатал цаашид БДО Монгол болон тус компанийн удирдлагын багийн зүгээс таамаглаж байгаагаас өөр байдлаар үргэлжлэхгүй гэж үзэн, Дүнд Хугацааны Санхүүгийн Төсөөлөлд тусгасан болно.

2.9 Түсгай төсөөллүүд

- Төсөөлсөн төлөв байдал нь Үнэлгээний өдрөөр оршин байгаа бодит байдлаас ялгаатай байх тохиолдолд үүнийг "түсгай төсөөлөл" гэж УОУС 104-ийн 200.4-д заасан. Энэхүү үнэлгээний тайлангийн хүрээнд дараах түсгай төсөөллүүдийг хүлээн зөвшөөрсөн. Үүнд:

  - Инфляцын өндөр түвшинтэй өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан, үнэлгээний тооцоололд Үнэлгээний өдрийн байдлаарх түүхэн инфляцын түвшинг ашиглахын оронд ОУВС-аас гаргасан Монгол улс болон АНУ-ын инфляцын 2027 оны төсөөллийг ашигласан;

  - Компанийн шинээр үйлдвэрлэн гаргахаар төлөвлөсөн бүтээгдэхүүнүүд бизнес төлөвлөгөөнд тусгагдсан тоо хэмжээнээс багагүй түвшинд үйлдвэрлэгдэн зах зээлд чөлөөтэй зарагдана гэсэн өөдрөг төсөөллийг дэвшүүлсэн.

  - Компанийн барааны тэмдэг нь энэхүү үнэлгээний тайланд тусгаснаас өөрөөр нэмэлт төлбөргүйгээр компанид бүрэн шилжинэ гэсэн баталгааг удирдлага гаргасан учраас оюуны өмчийн эрхийг компанийн өмчлөл, эзэмшилд шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйд ямар нэгэн нэмэлт төлбөр төлөхгүй гэсэн түсгай төсөөлөл ашигласан.

2.10 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал

- Үнэлгээний тайлан нь Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд өөр хэл рүү орчуулах эрх зөвхөн БДО Монгол-д хадгалагдана. Бид энэхүү үнэлгээний тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Гарын үсэг зурж, тамга дарсан Монгол хэл дээрх, хэвлэмэл болон цахим тайлангууд аль аль нь адил хүчин төгөлдөр болно.

- Үнэлгээний тайланг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь үнэлгээний зорилгоос өөр зорилгоор хувилж, эсвэл бүрэн/хэсэгчлэн иш татаж ашиглахыг хориглоно.

3. Эдийн засаг, салбарын тойм

3.1 Монгол улсын эдийн засаг

- УСХ-ны тайлагнаснаар, 2022 оны эхний хагас жилд Монгол улсын эдийн засаг ДНБ-ний оны үнээр 23.0 их наяд төгрөг, ДНБ-ний 2015 оны зэрэгцүүлэх үнээр 12.8 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1.9%-ийн өсөлт үзүүлсэн. Энэ нь 2020 оны мөн үе(2020 оны эхний хагас жилд -7.5%-иар агшсан)-тэй зэрэгцүүлэхэд эерэг өсөлт боловч 2021 оны мөн үе(6.2%)-тэй зэрэгцүүлэхэд буурсан үзүүлэлт юм.

График 3. Сүүлийн жилүүдийн эхний 6 сарын ДНБ-ний бодит өсөлт



- 2022 оны эхний хагас жилийн 1.9%-ийн эдийн засгийн өсөлтийг салбараар задалж үзүүлбэл, ХАА-н салбар 1.8%, үйлчилгээний салбар 2.2%, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.7%-ийн өсөлт үзүүлсэн бол үүл үүрхай, олборлолтын салбар -3.7%, аж үйлдвэр, барилгын салбар -0.1%-ийн бууралт үзүүлсэн.

- ОУВС-аас 2022 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 5.2% байхаар буюу 14.3 тэрбум ам.долларт хүрнэ гэж таамагласан байсан бол 2022 оны 5 сард таамаглалыг 1% болгон бууруулсан.

График 4. Дотоодын нийт бүтээгдэхүүний зэрэгцүүлэлт



Эх сурвалж:https://www.imf.org/en/Countries/MNG

- 2017 оноос ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр, Монгол Улсын эдийн засаг 2017-2019 оны хооронд жилд 5%-7.2%-аар өсөж, Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд дэлхийн бусад улс орнуудын адил 4.6%-аар агшсан бол 2021 оны гүйцэтгэлээр бодит ДНБ 15.1 тэрбум ам доллар хүрч эдийн засгийн өсөлт 1.4%-тай байсан.

- Дэлхийн банкнаас 2022 оны 4-р сард нийтэлсэн "Монгол улсын эдийн засгийн тойм"-д "Монгол улсын эдийн засаг 2021 оны эхэнд эрчимтэй сэргэж байсан ч гадаад хүдалдааны салбарт учирсан хүндрэл бэрхшээлээс шалтгаалан зогсонги байдалд оров... Хилийн боомтын саатал, Украйны дайны нөлөөтэй холбоотойгоор 2022 онд Монголын эдийн засаг 2.5%(муу хувилбараар 0.7% өсөж болзошгүй)-иар өсөх төлөвтэй" хэмээн дүгнэсэн. Харин дунд хугацаанд эдийн засгийн өсөлт хурдсах ба 2023 оны хоёрдугаар хагаст Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхлэхтэй холбоотойгоор 2023-2024 онуудад 6% давахаар байна гэж таамагласан.

- Хэрэглээний үнийн индексийн өсөлт 2020 онд 2.3%-д хүрч нам доогуур байсан бол 2021 онд 13.5% болж өссөн ба 2022 оны хувьд эхний хагас жилийн гүйцэтгэлээр 14.2%, эхний 7 сарын байдлаар 15.7% болж өсөөд байна. Инфляцын огцом өсөлт нь Ковид-19 цар тахал, Орос-Украйны дайн болон нийлүүлэлтийн сүлжээний тасалдлаас үүдсэн дэлхий даяарх үнийн өсөлттэй холбоотой.

- 2022 оны эхний 7 сарын хүнсний бараа, үндаа, усны хэрэглээний үнийн индекс 21.5%-д хүрсэн нь ерөнхий индекс өсөхөд хамгийн том нөлөө үзүүлсэн байна.

График 5. 2022 оны эхний 7 сарын байдлаарх ХҮИ-ийн задаргаа



Эх сурвалж: УСХ

- ОУВС, Монгол Улсын инфляцын түвшинг 2023-2026 онд 6.0%-10.5%-ийн хооронд байна гэж таамагласан бол Дэлхийн банк 2022 онд 10.5%, 2023 онд 7.5%, 2024 онд 6.8% хүрнэ гэж таамаглажээ.
- Харин Монголбанкны зүгээс инфляцын зорилтот түвшинг 2022-2024 оны хооронд 6%-аас +/-2%-ийн хэлбэлзэлтэйгээр тогтворжуулахыг зорьж байна. Мөнгөний нийлүүлэлт (М2) 2022 оны эхний 5 сарын байдлаар 27.5 их наяд, 2021 онд 27.9 их наяд төгрөгт хүрсэн нь 2021 онтой харьцуулахад 1.2%-аар өссөн, 2020 онтой харьцуулахад 15%-аар өссөн үзүүлэлт юм. Эдийн засгийг сэргээх, ажлын байрыг хадгалах зорилгоор Засгийн газар болон Монголбанкнаас янз бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд, жишээлбэл, банкны системээр дамжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгосон.

- Мөнгөний нийлүүлэлт (М2) 2022 оны эхний 6 сард 27 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5%-иар буурсан нь төгрөгийн хадгаламжийн 13.7%-ийн бууралт, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 11% буурсан нь нөлөөлсөн гэж УСХ тайлагнасан байна. Эдийн засгийг сэргээх, ажилгүйдлийг бууруулах зорилгоор Засгийн газар, Монголбанктай хамтран олон төрлийн арга хэмжээ авсан. Үүнд жижиг дунд үйлдвэрүүдэд банкны системээр дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох зэрэг томоохон хөтөлбөрүүд багтсан.

Хүснэгт 5. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

тэрбум төгрөгөөр	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022-6
Мөнгөний нийлүүлэлт М2	10,049	12,159	15,862	19,475	20,833	24,220	27,863	27,614
Жилийн өөрчлөлт %	-5.5%	21.0%	30.5%	22.8%	7.0%	16.3%	15.0%	1.2%
Нийт хадгаламж	6,335	8,044	9,616	12,189	13,391	17,244	18,927	18,127
Жилийн өөрчлөлт %	9.0%	27.0%	19.5%	28.8%	9.9%	28.8%	6.6%	-4.2%
Валютын хадгаламж	1,385	2,003	1,751	2,273	2,667	3,401	3,921	4,369
Жилийн өөрчлөлт %	17%	45%	-13%	-9.2%	17.3%	27.5%	-10.0%	11.4%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- 2011 оноос 2022 оны хооронд, ам.дол төгрөгийн эсрэг жилд дунджаар 6.7%-аар чангарсан. Гэхдээ 2021 оны хувьд, хил хаагдсанаас үүдэлтэй хэрэглээний хэмнэлт болон АНУ-ын хүүгийн түвшин хэт бага байсан зэрэг нь капиталын урсгалыг тогтворжуулж, валютын ханшийг тогтвортой байхад нөлөөлсөн ба 2022 оны 3 дугаар сараас эхлэн Орос-Украйны дайн болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр 10% чангарсан.

Хүснэгт 6. Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш (2010-2022)

Он	Хаалтын ханш	Өөрчлөлт	Дундаж ханш	Өөрчлөлт
2011	1,396.4	11.1%	1,265.5	2.5%
2012	1,392.1	-0.3%	1,359.2	7.4%
2013	1,659.3	19.2%	2,045.6	50.5%
2014	1,888.4	13.8%	1,817.9	-11.1%
2015	1,995.5	5.7%	1,970.3	8.4%
2016	2,489.5	24.8%	2,145.5	8.9%
2017	2,427.1	-2.5%	2,439.8	13.7%
2018	2,643.7	8.9%	2,467.1	1.1%
2019	2,734.3	3.4%	2,663.5	8.0%
2020	2,849.9	4.2%	2,813.3	5.6%
2021	2,849.2	0.0%	2,849.2	1.3%
2022	3,134.1	10.0%	3,124.25	9.65%
Дундаж нийлмэл өсөлт		**6.7%**		**7.5%**

Эх сурвалж: МонголБанк, БДО Монгол шинжилгээ

- 2016 оноос хойш гадаад худалдаа тогтвортой өсөж байна. 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хил хаагдсаны улмаас цэвэр экспорт 2019 онтой харьцуулахад жигд өсөлттэй байсан ч 2021 онд нүүрс, зэс, төмрийн хүдрийн үнийн өсөлтөөс шалтгаалж экспортын орлого мэдэгдэхүйц өссөн байна. Олон улсын тээврийн зардал нэмэгдэж, нефтийн үнийн өсөлтөөс шалтгаалж импорт мөн нэмэгдсэн.

График 6. Экспорт болон импорт (тэрбум доллар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Доорх хүснэгтэд Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг харуулав. ОУВС 2022 оноос Монгол улсын эдийн засаг 5%-7.5%-ийн өсөлттэй байна гэж таамаглаж байгаа нь АХБ, Дэлхийн банк, Монголбанкны таамаглалтай нийцэж байна. Гэсэн хэдий ч, эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв Ковид-19 цар тахал, 2022 оны эхээр Монгол улсын хөрш зэргэлдээ оронд өрнөсөн дайны байдал, түүнтэй холбоотой дэлхийн улс орнуудаас авсан хилийн болон эдийн засгийн хориг болон таваарын зах зээлийн цаашдын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 7. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Байгууллага	2022	2023	2024	2025	2026
Монголбанк	5.6%	6.0%	6.3%	7%	
ОУВС	2.0%	7.0%	6.5%	6.0%	5.5%
АХБ	2.3%	5.6%			
Дэлхийн Банк	2.5%	5.8%	6.8%		

Эх сурвалж: МонголБанк, ОУВС, АХБ, Дэлхийн банк

3.2 Монгол улсын хөрөнгийн зах зээл

- 2022 оны эхний 7 сарын байдлаар Монгол улсын хөрөнгийн зах зээл дээр 24.7 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдэж, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.0 их наяд төгрөгт хүрчээ.

- МХБ-ийн голлох индекс болох ТОП-20 индекс нь 2021 онд 44,412 нэгж болж 130%-аар өссөн бол 2022 оны эхний хагас жилд 32,795 нэгж болж өмнөх оний эцсээс 26.1%-аар буурсан ба өмнөх оны эхний хагас жилтэй харьцуулахад 713 нэгжээр буурсан байдалтай байна. Үүнд дараах хүчин зүйлс нөлөөлжээ: (i) хүүгийн түвшин буурсан нь хөрөнгө оруулагчдын уг зах зээлийг сонирхох сонирхлыг нэмэгдүүлсэн байсан; (ii) шинэ бүтээгдэхүүнүүд олноор бий болсон (хувьцаа, компанийн бонд, хамтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас); (iii) арилжааны идэвх бага байгаа нөхцөл байдал. 2022 оны 3 дугаар сараас эхэлсэн Орос-Украйны дайны үр нөлөөллөөс үүдэлтэй нийлүүлэлтийн сүлжээний доголдол үүнээс урган гарсан төлбөрийн тэнцлийн алдагдлаас үүдэлтэй инфляц өссөн нь нөлөөлсөн байх талтай.

Хүснэгт 8. Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс, нэгжээр

Он	Дээд	Доод	Хаалтын ханш	Өөрчлөлт
1997	373	345	356	
1998	252	229	235	-34.0%
1999	260	245	256	8.8%
2000	506	460	470	83.8%
2001	963	758	814	73.2%
2002	1,128	804	934	14.7%
2003	911	588	896	-4.1%
2004	682	507	586	-34.6%
2005	1,053	956	1,019	74.0%
2006	2,031	1,755	2,031	99.3%
2007	10,568	9,441	10,256	405.0%
2008	6,174	5,511	5,583	-45.6%
2009	6,190	5,905	6,190	10.9%
2010	14,760	14,006	14,760	138.4%
2011	21,688	18,515	21,688	46.9%
2012	17,715	15,450	17,715	-18.3%
2013	16,737	15,316	16,302	-8.0%
2014	15,265	14,475	14,854	-8.9%
2015	12,898	11,962	12,898	-13.2%
2016	12,456	10,938	12,456	-3.4%
2017	24,520	19,870	20,737	66.5%

Он	Дээд	Доод	Хаалтын ханш	Өөрчлөлт
2018	21,467	19,387	21,467	3.5%
2019	19,622	18,520	19,622	-8.6%
2020	19,286	17,516	19,286	-1.7%
2021	44,412	39,203	44,412	130.3%
2022-6	32,795	37,759	32,795	-26.1%
CAGR (1997-2022) – 24.5 жил				**20.28%**
CAGR (2012-2022) – 11 жил				**4.6%**
CAGR (2017-2022) – 5.5 жил				**19.25%**

Эх сурвалж: МонголБанк, БДО Монгол шинжилгээ

- Хөрөнгийн зах зээл идэвхжиж буй давуу талыг ашиглаж олон компани МХБ дээр хувьцаа, бонд гаргаж байна. 2021 онд МХБ-д хоёр компани IPO гаргаж, нэг компани нэмж хувьцаа гаргаж, нийт 75 тэрбум төгрөг (ойролцоогоор 26.3 сая ам.доллар) татан төвлөрүүлсэн байна. Мөн 10 компани бонд гаргаж, 720 тэрбум төгрөг (ойролцоогоор 253 сая ам.доллар) татан төвлөрүүлжээ. Түүнчлэн, нэг нээлттэй хамтын хөрөнгө оруулалтын сан МХБ-д бүртгүүлж, олон нийтээс 50 тэрбум төгрөг (17.5 сая ам.доллар) татан төвлөрүүлсэн.

- Хөрөнгийн зах зээл идэвхжиж байгаа ч, арилжааны хэмжээ бага хэвээр байна. 2021 онд хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааны нийт хэмжээ 2020 онтой харьцуулахад 327%-иар мэдэгдэхүйц өссөн ч бага хэвээр буюу нийт 230 тэрбум төгрөг[2] (ойролцоогоор 80 сая ам.доллар) байв. Ирэх улирлуудад, томоохон арилжааны банкнууд МХБ-д бүртгүүлснээр арилжааны хэмжээ өсөх төлөвтэй байна.

- Зэргэлдээ графикт Монголын хөрөнгийн биржийн хувьцааны зах зээлийн нийт үнэлгээг харуулав. 2021 онд зах зээлийн нийт үнэлгээ өмнөх оныг нугалсан хэмжээнд мэдэгдэхүйц өссөн нь хөрөнгийн зах зээлийн өсөлт болон шинээр гаргасан үнэт цааснууд нөлөөлсөн. Харин 2022 оны эхний 6 сард 1 их наяд төгрөгөөр буурч 5 их наяд төгрөгт хүрээд байна.

График 7. Монголын хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ (их наяд төгрөг)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

[2] *Үнэт цаасны арилжааны тайлан 2021, МХБ*

3.3 Дэлхийн хүнсний салбар

- Дэлхийн хүнсний зах зээл 2022 онд ойролцоогоор 9 их наяд ам.доллар байгаа бөгөөд Statista-н судалгаагаар 2022-2027 оны хооронд 4.80% хүртэл өсөх чиг хандлагатай байна. Хэдийгээр дэлхийн аж үйлдвэрийн орлого өсөж байгаа ч эдийн засгийн удаашрал нь сүүлийн жилүүдэд хөгжиж буй гол зах зээлүүдийн өсөлтийг хязгаарлаж байна.

- АНУ-ын BVR-ийн 2020 оны өгөгдөлд 2022 оны 5 сард 17324 компанийг хамруулан хийсэн судалгаагаар хүнсний салбарын компаниудын нийт ашгийн түвшин(борлуулсан бүтээгдэхүүний өртөг нь борлуулалтын 78.1%) 22.9% байгаа бол энэ үзүүлэлт хүнсний салбарын том компаниудад 22.7%, дунд хэмжээний компаниудад 24.8%, жижиг компаниудад 26.3% байдаг байна.

Хүснэгт 9. 2020 оны АНУ-ын Хүнсний салбарын орлогын тайлангийн бүтцийн статистик

	Бүх компани	Том компани	Дунд хэмжээтэй	жижиг компани
Цэвэр борлуулалт	100.0%	100.0%	100.0%	100.0%
Борлуулалтын өртөг	77.1%	77.3%	75.2%	73.7%
Нийт ашиг	22.9%	22.7%	24.8%	26.3%
Хөдөлмөрийн өртөг	0.9%	0.8%	1.5%	2.5%
Борлуулалт, маркетингийн зардал	1.5%	1.6%	1.1%	1.1%
Үйл ажиллагааны бусад зардал	18.8%	18.7%	20.0%	20.6%
Нийт үйл ажиллагааны зардал	21.3%	21.1%	22.6%	24.2%
Үйл ажиллагааны ашиг	1.6%	1.6%	2.2%	2.1%
Цэвэр ашиг	0.6%	0.6%	0.9%	0.9%

Эх сурвалж: BVR, First Research, Quarterly Update 9/19/2022

- Харин үйл ажиллагааны болон борлуулалт, маркетингийн зардал нь нийт борлуулалтын 21.2%-ийг эзэлж, үйл ажиллагааны ашигт ажиллагааны түвшин 1.6%, үүнээс том компаниудын үйл ажиллагааны ашигт ажиллагааны түвшин 1.6%, дунд хэмжээний компаниудынх 2.2%, жижиг компаниудынх 2.1% байсан байна.

- Тухайн судалгаанд хамрагдсан бүх компанийн дунджаар хүнсний салбарын компанийн балансын бүтэц дараах байдалтай гарчээ.

Хүснэгт 10. 2020 оны АНУ-ын Хүнсний салбарын балансын бүтцийн статистик

	Бүх компани	Том компани	Дунд хэмжээтэй	жижиг компани
Мөнгө	7.5%	7.5%	7.1%	7.2%
Авлага	21.5%	21.7%	19.9%	18.9%
Бараа материал	21.5%	21.6%	19.8%	18.8%
Эргэлтийн хөрөнгө	55.7%	56.1%	51.5%	49.6%
Үндсэн хөрөнгө	26.8%	26.3%	33.1%	34.7%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	17.5%	17.7%	15.4%	15.7%
Нийт хөрөнгө	100.0%	100.0%	100.0%	100.0%
Дансны өглөг	14.7%	14.7%	14.2%	13.7%
Эргэлтийн өр төлбөр	28.2%	28.1%	28.9%	28.4%
Эргэлтийн бус өр төлбөр	24.5%	24.2%	24.7%	29.6%
Өмч	47,4%	47.7%	43.7%	42.1%

Эх сурвалж: BVR, First Research, Quarterly Update 9/19/2022

Хүснэгт 11. АНУ-ын Хүнсний салбарын борлуулалтын ЖНӨХ-ийн төсөөлөл

	Жилийн нийлмэл өсөлт
2021 он	-5.5%
2022 он	10.2%
2023 он	5.0%
2024 он	3.2%
2025 он	3.0%
2026 он	3.0%

Эх сурвалж: BVR, First Research, Quarterly Update 9/19/2022

3.4 Монгол улсын хүнсний салбарын өнөөгийн нөхцөл байдал

- Монгол улс 2017 онд жилд 661 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 599 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 924 тэрбум төгрөгийн хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг импортоор хангаж байсан бол 2021 оны жилийн дүнгээр 1,293 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 780 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 1,730 тэрбум төгрөгийн хүнсний бэлэн бүтээгдэхүүнийг импортоор хангажээ.

- 2022 оны эхний 6 сарын байдлаар 621 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 463 тэрбум төгрөгийн ундааг дотооддоо үйлдвэрлэж, 366 сая ам долларын хүнсний бэлэн бүтээгдэхүүн импортолсон байна.

- Өнгөрсөн таван жилийн дунджаас харахад, Монгол улсын хүнсний бэлэн бүтээгдэхүүний хангамжийн 40 гаруй хувийг дотооддоо үйлдвэрлэж, үлдсэн хэсгийг импортоор ханган нийлүүлдэг байна.

- Монгол улсын сүүлийн таван жилийн хугацааны хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн жилийн нийлмэл өсөлт 18.3%, ундааны үйлдвэрлэлийн жилийн нийлмэл өсөлт 7% байсан бол импортоор авсан хүнсний бэлэн бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн ЖНӨХ нь 17% байсан. Импортын бүтээгдэхүүний ЖНӨ-ийн 6.4% нь төгрөгийн ханшийн уналтаас үлдсэн 10 орчим хувь нь эрэлтээс хамааралтай өсөлт гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 12. 2017-2021 оны Монгол улсын ундаанаас бусад хүнсний хангамжийн статистик

Тэр бум төгрөг	2017	2018	2019	2020	2021
Дотоодын үйлдвэрлэл	661	856	941	1,018	1,293
Жилийн өөрчлөлт(%)		*29.4%*	*9.9%*	*8.3%*	*27.0%*
Импорт	924	1,077	1,183	1,222	1,730
Жилийн өөрчлөлт(%)		*16.6%*	*9.8%*	*3.3%*	*41.6%*
Нийт хүнсний хангамж	1,585	1,933	2,124	2,240	3,024
Жилийн өөрчлөлт(%)		*22.0%*	*9.9%*	*5.5%*	*35.0%*
Дотоодын үйлдвэрлэлийн хувийн жин	41.7%	44.3%	44.3%	45.5%	42.8%
Импортын хувийн жин	*58.3%*	*55.7%*	*55.7%*	*54.5%*	*57.2%*

Эх сурвалж: УСХ-ны өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Монгол улсын хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн 30 орчим хувийг мах боловсруулах, консервлох үйлдвэрлэл, 25 орчим хувийг сүү, сүүн бүтээгдэхүүн, 20 орчим хувийг үр тариа, гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байгаа бол жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэл дөнгөж 2-3%-ийг эзэлдэг байна.

Хүснэгт 13. 2017-2022 онуудын Монгол улсын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүтэц

Жил бүрийн эзлэх хувийн жингээр	2017	2018	2019	2020	2021	2022 I-VI
Мах боловсруулах, консервлох	25.7%	32.3%	30.0%	26.5%	27.6%	20.1%
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	1.2%	1.8%	2.4%	3.1%	2.1%	3.5%
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	16.3%	20.2%	22.5%	21.7%	24.7%	26.8%
Үр тарианы гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	30.7%	25.3%	22.0%	24.2%	20.7%	18.0%
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	26.1%	20.4%	23.2%	24.5%	24.9%	31.5%
Дотоодын үйлдвэрлэлийн дүн	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**

Эх сурвалж: УСХ-ны өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэл

- Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэл нийт дотоодын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 3 орчим хувийг эзэлж буй ч 2017 онд 8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2020 оны цар тахлын хорионы жилд 31 тэрбум төгрөгт хүртэл өсөж, 2021 онд 27 тэрбум төгрөгт хүржээ. Харин 2022 оны эхний 6 сарын байдлаар 22 тэрбум төгрөгт хүрснээс харахад 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр өндөр өсөлтийг үзүүлэх магадлалтай байна.

- Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалтын үйлдвэрлэлийн дэд секторын сүүлийн 5 жилийн хугацааны жилийн нийлмэл өсөлт нь 37% байгаа нь энэ сектор хамгийн өндөр өсөлттэй болохыг илтгэж байна.

3.5 Монгол улсын хөрөнгийн биржийн ТОП-20-д хүнсний салбарын эзлэх байр суурь

Хүснэгт 14. МХБ-ийн ТОП20-д хүнсний салбарын эзлэх байр суурь

T.m	ЗЗУ	2021 оны Борл-лт	ЗЗУ/ Борл	5Y's Wkly Beta	2Y's Wkly Beta	Салбар
APU	*1,455,212*	*669,724*	*2.17x*	*0.85*	*0.69*	*Хүнс*
AARD	93,654	22,213	4.22x		1.95	Санхүү
GOV	219,602	144,344	1.52x	0.88	0.70	Аж үйлдвэр
ERDN	234,976	-	na		0.36	Уул уурхай
INV	303,886	41,122	7.39x		0.33	Санхүү
TTL	472,933	196,556	2.41x	0.81	0.50	Уул уурхай
TUM	*80,022*	*35,913*	*2.23x*		*0.65*	*Хүнс*
ADB	25,301	7,769	3.26x		1.53	Санхүү
MNDL	55,663	19,019	2.93x		0.66	Санхүү
UID	129,083	6,707	19.25x	0.81	1.05	УХХ
AIC	18,100	11,693	1.55x		1.07	Санхүү
SUU	*168,100*	*100,397*	*1.67x*	*0.66*	*0.59*	*Хүнс*
MFC	*45,239*	*18,841*	*2.40x*		*0.42*	*Хүнс*
MNP	69,810	19,839	3.52x	0.67	0.60	Мэдээлэл, харилцаа
LEND	22,956	12,492	1.84x		0.45	Санхүү
BODI	29,448	17,062	1.73x		0.39	Санхүү
MMX	*14,108*	*49,180*	*0.29x*	*0.55*	*0.53*	*Хүнс*
NEH	24,182	23,414	1.00x	0.73	0.77	Аж үйлдвэр
BDS	15,064	3,378	4.46x	0.40	0.38	Санхүү
TCK	*31,735*	*75,804*	*0.42x*	*0.50*	*0.45*	*Хүнс*
ТОП 20	**3,508,208**	**1,475,466**	**2.38x**	**0.69**	**0.70**	
Хүнс	**1,794,417**	**949,859**	**1.89x**	**0.64**	**0.56**	

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- МХБ-ийн ТОП20-ийн 6 компани нь хүнсний салбарын компани байгаа ба эдгээр нь ТОП20-ийн зах зээлийн үнэлгээний 51%, ТОП20-ийн 2021 оны жилийн борлуулалтын 64%-ийг тус тус бүрдүүлж байна.

- 2021 оны дээрх хүснэгтэн мэдээллээс харахад, МХБ-ийн ТОП-20 компани нь МХБ-д хувьцаа нь арилжаалагддаг компаниудын зах зээлийн үнэлгээний зонхилох хэсгийг эзэлж байгаагаас гадна хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн компаниудын ТОП20-д эзлэх байр суурь тэргүүлэх түвшинд байна.

- ТОП20 болон хүнсний салбарт АПУ ХК дангаар хамгийн том нөлөө үзүүлдэг ба тус компанийн зах зээлийн үнэлгээ нь ТОП20-ийн зах зээлийн үнэлгээний 41%-тай, 2021 оны жилийн борлуулалт нь ТОП20-ийн 2021 оны нийлбэр жилийн борлуулалтын 45%-тай тэнцдэг байна.

- АПУ ХК-ийг хассаны дараах байдлаар ТОП-20-ийн бусад 19 компанийн зах зээлийн үнэлгээ 2,052,995 сая төгрөг(хүнсний салбар 17% хувь), 2021 оны жилийн борлуулалт нь 805,742 сая төгрөг(хүнсний салбар 35% хувь) байна.

- МХБ-ийн ТОП20-д багтсан АПУ-гаас бусад 5 компани нь (1) өндөг үйлдвэрлэл, (2) сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, (3) мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, (4) талх нарийн боов үйлдвэрлэл, (5) хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн компаниуд байна. Өөрөөр хэлбэл, ТОП20-д багтдаг хүнсний 6 компани нь нэгэн ижил зах зээл дээр үйл ажиллагаагаараа өрсөлддөггүй байна.

Хүснэгт 15. МХБ-ийн хүнсний салбарын зах зээлийн өгөөжийн түвшин

Хүвиар	Зах зээлийн үнэлгээ+Ногдол ашиг		
	Хувьцааны үнийн өсөлт (5 жилийн CAGR)	Жилийн дундаж ногдол ашгийн өгөөж	Жилийн дундаж өгөөж
MFC	12.4%	1.9%	14.4%
TUM	22.9%	4.5%	27.4%
TCK	1.4%	1.4%	2.8%
SUU	17.8%	3.6%	21.3%
APU	15.2%	14.6%	29.8%
MMX	7.4%	3.6%	11.0%
Дундаж	**12.8%**	**4.9%**	**17.8%**
Медиан	**13.8%**	**3.6%**	**17.9%**
Доод квартил	**8.6%**	**2.4%**	**11.8%**
Дээд квартил	**17.1%**	**4.3%**	**25.9%**

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- МХБ-ийн хүнсний салбарын компаниудын нэгж хувьцааны хаалтын ханш 2017-2022 оны 6 сарын 30-ны хооронд жил бүр дунджаар 12.8%-ийн өсөлт үзүүлсэн ба энэ салбарт багтдаг 6 компани жил бүр тогтмол ногдол ашиг хуваарилж иржээ.

- Хүнсний салбарын нээлттэй компаниуд үйл ажиллагааныхаа 80 орчим хувийг өөрийн хөрөнгөөр, 20 орчим хувийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн дүр зураг дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 16. МХБ-ийн хүнсний салбарын Капиталын бүтцэд өмчийн санхүүжилтийн эзлэх хувийн жин

МХБ-ийн таних тэмдэг	Түүхэн статистик					
	2017	2018	2019	2020	2021	2022ХБГ
MFC	28.8%	62.3%	80.8%	76.0%	70.9%	67.3%
TUM	71.6%	72.4%	82.6%	82.5%	73.0%	67.8%
TCK	91.8%	96.0%	82.5%	87.8%	91.7%	91.5%
SUU	55.0%	49.0%	43.4%	45.9%	43.2%	
APU	87.7%	95.2%	94.5%	94.2%	90.8%	88.4%
MMX	99.7%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Газаршим	**100.0%**	**73.0%**	**76.4%**	**81.5%**	**86.3%**	**83.9%**
Дундаж	**76.4%**	**79.1%**	**80.6%**	**81.1%**	**78.3%**	**83.0%**
Медиан	79.7%	83.8%	82.6%	85.1%	81.9%	88.4%
Доод квартил	59.1%	64.8%	81.2%	77.6%	71.4%	67.8%
Дээд квартил	90.7%	95.8%	91.6%	92.6%	91.5%	91.5%

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Капиталын бүтцийн шинжилгээнээс харахад, Мах-Импекс болон Талх Чихэр ХК-иуд зээлийн хөшүүрэг багатай байгаа нь салбарын капиталын бүтцэд нөлөөлж байх магадлалтай байна. Иймд олонлогийн дундаж буй медиан утга нь зах зээлийн капиталын бүтцийг илүү оновчтой харуулж байх магадлалтай байна.

Хүснэгт 17. МХБ-ийн хүнсний салбарын жишиг компаниудын түүхэн борлуулалт ба ЖНӨХ-ийг "Газар шим үйлдвэр" ХХК-тай харьцуулсан судалгаа

МХБ-ийн таних тэмдэг	Түүхэн үзүүлэлт						CAGR
	2017	2018	2019	2020	2021	2022H1	ЖНӨХ
MFC	5,939	8,003	9,433	12,491	18,841	13,880	20.8%
TUM	13,230	17,321	20,106	25,393	35,913	21,125	11%
TCK	36,427	46,604	54,856	63,054	75,804	44,464	5%
SUU	48,184	71,108	73,945	79,194	100,397	-	20.1%
APU	234,606	432,498	472,634	491,204	669,724	391,076	12%
MMX	10,326	39,081	41,013	63,054	75,804	17,030	12%
Салбар	**348,712**	**614,614**	**671,987**	**734,391**	**976,483**	**487,575**	**7.7%**
Газаршим	8,241	11,886	14,856	21,514	29,186	15,506	15.1%

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Хүснэгт 17-д харуулсан судалгаанаас харахад, 2017 оноос 2022 оны эхний хагас жилийн хооронд судалгаанд хамрагдсан МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг 6 компаниудын нийлбэр борлуулалт нь 7.7%-ийн ЖНӨХ-иар өссөн ба үүнээс Монос Хүнс ХК болон Сүү ХК-иуд хамгийн өндөр буюу 20.1%-20.8%-ийн ЖНӨХ-иар өсөлт үзүүлсэн бол үнэлэгдэж буй "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьд 2017 оноос хойш 15.1%-ийн ЖНӨХ-иар тогтмол өсөлт үзүүлсэн нь салбарын дунджаас дээгүүр байна.

ТОП 20 индексэд багтдаг хүнсний салбарын компаниудын үнэлгээний үндсэн үржүүлэгч

Хүснэгт 18. МХБ-ийн хүнсний салбарын жишиг компаниудын Үнэ/Данс үржүүлэгчийн судалгаа

МХБ-ийн таних тэмдэг	Түүхэн статистик					
	2017	2018	2019	2020	2021	2022H1
MFC		3.0x	1.8x	2.1x	3.1x	2.8x
TUM		3.4x	1.4x	1.3x	4.5x	2.5x
TCK	0.7x	0.4x	0.3x	0.3x	0.5x	0.5x
SUU	3.5x	3.4x	2.8x	2.5x	6.2x	
APU	1.5x	1.5x	1.4x	1.4x	3.8x	2.6x
MMX	4.2x	3.5x	3.0x	2.8x	2.6x	2.8x
Дундаж	**2.5x**	**2.5x**	**1.8x**	**1.7x**	**3.4x**	**2.2x**
Медиан	**2.5x**	**3.2x**	**1.6x**	**1.7x**	**3.5x**	**2.6x**
Доод квартил	1.3x	1.8x	1.4x	1.3x	2.8x	2.5x
Дээд квартил	3.7x	3.4x	2.6x	2.4x	4.3x	2.8x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Хүснэгт 18-д харуулсан судалгаанаас харахад, 2017 оноос 2022 оны эхний хагас жилийн хооронд судалгаанд хамрагдсан МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг 6 компаниудын Үнэ/Данс харьцаа нь 1.7х-ээс 3.4х-ийн хооронд байна. Үнэ/Данс харьцаа нь хувьцаат компанийн нэгж хувьцаа нь өртгөөсөө хэр өндөр арилжаалагдаж байгааг харуулдаг. Энэ үзүүлэлтийн медиан утга нь зах зээлийн голч утга байдаг. 2022 оны 6 сарын 30-наарх Үнэ/Данс харьцааны медиан нь 2.6х байна.

- Харин Үнэ/Ашиг харьцаа өнгөрсөн жилүүдэд зах зээл дээр хэр түвшинд тогтоогдож байсан болон 2022 оны 6 сарын 30-наар хэд байгааг Хүснэгт 19-өөс үзнэ үү.

Хүснэгт 19. МХБ-ийн хүнсний салбарын жишиг компаниудын Үнэ/Ашиг үржүүлэгчийн судалгаа

МХБ-ийн таних тэмдэг	Түүхэн харьцаа					
	2017	*2018*	*2019*	*2020*	*2021*	*2022ХБГ*
MFC		39.7x	37.7x	27.1x	22.8x	14.3x
TUM		15.3x	10.0x	8.4x	19.5x	11.0x
TCK	27.2x	10.0x	6.3x	5.5x	5.5x	5.7x
SUU	35.2x	16.9x	12.7x	10.0x	21.6x	
APU	30.2x	13.7x	8.9x	7.2x	12.5x	8.6x
MMX	30.8x	13.4x	12.2x	3.6x	2.6x	20.5x
Дундаж	**30.8x**	**18.2x**	**14.6x**	**10.3x**	**14.1x**	**12.0x**
Медиан	**30.5x**	**14.5x**	**11.1x**	**7.8x**	**16.0x**	**11.0x**
Доод квартил	29.4x	13.5x	9.2x	6.0x	7.2x	8.6x
Дээд квартил	31.9x	16.5x	12.6x	9.6x	21.1x	14.3x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Хүснэгт 19-д харуулсан судалгаанаас харахад, 2018 оноос 2022 оны эхний хагас жилийн (2022 оны эхний хагас жилийн цэвэр ашгийг 2022 оны жилийн хүлээлтэд шилжүүлсэн) хооронд судалгаанд хамрагдсан МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг 6 компаниудын Үнэ/Ашиг харьцаа нь дунджаар 10.3х-ээс 18.2х-ийн хооронд байна. Үнэ/Ашиг харьцаа нь хувьцаат компанийн нэгж хувьцаа нь нэгж хувьцаанд ногдох ашгийг хэд дахин өсгөж арилжаалагдаж байгааг харуулдаг бөгөөд энэ нь тухайн өдөр худалдан авсан хувьцааны үнийг ашгараа хэдэн жилд нөхөхийг илэрхийлнэ. Энэ үзүүлэлтийн медиан утга нь зах зээлийн голч утга байдаг. 2022 оны 6 сарын 30-наарх нэгж хувьцааны зах зээлийн үнийг 2022 оны жилийн хүлээгдэж буй нэгж хувьцаанд ногдох цэвэр ашигт харьцуулж тооцоолсон Үнэ/Ашиг харьцааны медиан нь 11.0х, дундаж утга нь 12х байна.

- Хүснэгт 20-д Үнэ/Борлуулалт харьцааг харуулав. Энэ нь судалгаанд хамрагдсан хүнсний салбарын нээлттэй компаниудын хувьцааны зах зээлийн үнэлгээ ба жилийн цэвэр борлуулалтын хооронд ямар хамаарал, харьцаатай байгааг харуулах бөгөөд зах зээлд оролцогчдын хувьцаа худалдан авахдаа төлж буй мөнгө нь тухайн компанийн жилийн цэвэр борлуулалттай ямар харьцаагаар тогтоогдож буйг харуулна.

- Судалгаанаас харахад, 2017 оноос 2022 оны эхний хагас жилийн (2022 оны эхний хагас жилийн борлуулалтыг 2022 оны жилийн хүлээлтэд шилжүүлсэн) хооронд судалгаанд хамрагдсан МХБ-ийн ТОП-20 индексэд багтдаг 6 компаниудын Үнэ/Борлуулалт харьцаа нь дунджаар 1.0х-ээс 1.9х-ийн хооронд байна. Энэ үзүүлэлтийн медиан утга нь зах зээлийн голч утга байдаг. 2022 оны 6 сарын 30-наарх нэгж хувьцааны зах зээлийн үнийг 2022 оны жилийн хүлээгдэж буй нэгж хувьцаанд ногдох борлуулалтад харьцуулж тооцоолсон Үнэ/Борлуулалт харьцааны медиан нь 1.6х, дундаж утга нь 1.2х байна.

Хүснэгт 20. МХБ-ийн хүнсний салбарын жишиг компаниудын Үнэ/Борлуулалт үржүүлэгчийн судалгаа

МХБ-ийн таних тэмдэг	Түүхэн харьцаа					
	2017	*2018*	*2019*	*2020*	*2021*	*2022ХБГ*
MFC	0.3x	3.6x	3.0x	2.2x	2.5x	1.6x
TUM	0.7x	2.3x	1.6x	1.3x	3.8x	1.9x
TCK	0.8x	0.4x	0.3x	0.3x	0.4x	0.4x
SUU	1.8x	1.0x	1.0x	0.9x	2.0x	
APU	3.2x	1.5x	1.4x	1.3x	2.9x	1.8x
MMX	1.1x	0.3x	0.2x	0.2x	0.2x	0.4x
Дундаж	**1.3x**	**1.5x**	**1.3x**	**1.0x**	**1.9x**	**1.2x**
Медиан	**0.9x**	**1.3x**	**1.2x**	**1.1x**	**2.2x**	**1.6x**
Доод квартил	0.7x	0.6x	0.5x	0.4x	0.8x	0.4x
Дээд квартил	1.6x	2.1x	1.6x	1.3x	2.8x	1.8x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Хүснэгт 21-д судалгаанд хамрагдсан компаниудын зах зээлийн үнэлгээн дээр өрийн санхүүжилтийн дүнг нэмж гаргасан байгууллагын үнэ цэнийг компани түс бүрийн хүү, татварын өмнөх ашигт харьцуулсан БҮЦ/ХТӨА(англиар EV/EBIT) харьцааны статистикийг харуулав.

- Энэ харьцаа нь өр ба өмчийн санхүүжилт бүхий капиталын бүтэцтэй бизнесийн зах зээлийн үнэлгээг тогтооход сүүрь үзүүлэлт болж ашиглагддаг.

Хүснэгт 21. МХБ-ийн хүнсний салбарын жишиг компаниудын EV/EBIT үржүүлэгчийн судалгаа

МХБ-ийн таних тэмдэг	Түүхэн харьцаа					
	2017	*2018*	*2019*	*2020*	*2021*	*2022ХБГ*
MFC	7.3x	35.4x	36.0x	22.1x	18.0x	12.1x
TUM	10.5x	-74.6x	10.3x	9.1x	18.4x	9.0x
TCK	20.2x	7.9x	7.7x	6.1x		5.2x
SUU	21.9x	11.4x	10.2x	7.9x	17.8x	
APU	22.9x	10.1x	7.1x	5.9x	10.1x	7.0x
MMX	27.6x	12.1x	12.1x	2.8x		18.4x
Дундаж	**18.4x**	**0.4x**	**13.9x**	**9.0x**	**16.1x**	**10.4x**
Медиан	**21.1x**	**10.8x**	**10.3x**	**7.0x**	**17.9x**	**9.0x**
Доод квартил	12.9x	8.4x	8.4x	5.9x	15.9x	7.0x
Дээд квартил	22.6x	11.9x	11.7x	8.8x	18.1x	12.1x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

3.6 Эдийн засгийн болон салбарын ирээдүйн төлөв

Эрчимтэй хөгжиж буй зах зээл ба хөгжиж буй эдийн засаг (ЭХБЭЗ)-тай орнууд

- Ирэх жилүүдийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн төлөв байдал тодорхой бус байна. Эдийн засгийн байдал Ковид-19-ийн үеэс сэргэх төлөвтэй байгаа ч цар тахлын шинэ хувилбарууд бий болох эрсдэл, БНХАУ-ын Ковидыг тэглэх бодлого, ОХУ-ын зүгээс Украйнд явуулж буй цэргийн ажиллагаа, өндөр хөгжилтэй улс орнуудын мөнгөний хумих бодлого зэрэгтэй холбоотой олон зүйлс тодорхойгүй хэвээр байна.

- 2022 оны эхээр өрнөсөн Орос-Украйны асуудал нь дэлхийн болон Монгол улсын эдийн засагт тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байна.

- Дэлхийн банкнаас бэлтгэн гаргадаг "Дэлхийн эдийн засгийн төлөв байдал" тайланд[3] дурдсанаар, дэлхийн эдийн засгийн өсөлт 2021 онд 5.5%, харин 2022 онд 4.1% болж буурах төлөвтэй байна. Энэ нь Ковид-19-тэй холбоотой тодорхойгүй байдал үргэлжилж, төсвийн дэмжлэг буурч, нийлүүлэлтийн гинжин хэлхээний саатал үргэлжилж байгаатай холбоотой. 2022 онд дэлхий даяарх инфляцын өсөлт, мөнгөний хумих бодлого нь хувийн хэрэглээнд сөргөөр нөлөөлөх төлөвтэй байна.

График 8. Засгийн газрын дотоод болон гадаад өр, 2020 (ДНБ-д эзлэх хувиар)



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөв

[3] https://www.worldbank.org/en/publication/global-economic-prospects

- 2023 онд хөрөнгө оруулалтын идэвх ба хувийн хэрэглээний өсөлт суларч, таваарын үнэ буурах эсвэл тогтворжих хандлагатай байгаа тул ЭХБЭЗ-тай улс орнуудын нийт үйлдвэрлэлийн өсөлт 4.4% хүртэл буурна гэж таамаглаж байна. ЭХБЭЗ-тай улс орнуудын өргөн хүрээг хамарсан вакцинжуулалтын ачаар олон улсын аялал жуулчлал аажмаар сэргэж, 2023 онд зарим улс орнуудын хувьд үргэлжлэн сэргэх болно. Гэсэн хэдий ч, макро эдийн засгийн хатуу бодлого, хөрөнгө оруулалтын сэргэлт удаашралтай байгаагаас үүдэн 2023 онд ч гэсэн ЭХБЭЗ-тай олон улс орнууд бүрэн гүйцэд сэргэхгүй байх төлөвтэй байна.

- Вакцинжуулалтын үйл явц удаашралтай, бодлогын хариу арга хэмжээ илүү хязгаарлагдмал, цар тахлын үлдээсэн сөрөг нөлөөллийн үр дүнд хөгжиж буй эдийн засагтай улс орнуудыг өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад сэргэлт нь илүү сул, эмзэг байхыг тайланд анхааруулжээ. Монгол улсын хувьд, хэдийгээр вакцинжуулалтын түвшин харьцангуй өндөр байгаа ч ерөнхийдөө цар тахал ба Омикрон хувилбартай холбоотой тодорхойгүй байдал үргэлжилсээр байгаа нь хувийн хэвшил болон эдийн засагт тодорхой бус байдал үүсгэхээр байна.

График 9. Монгол улсын гадаад өр төлбөрийн эргэн төлөлт (сая доллар)



Эх сурвалж: ОУВС, Монгол улсын тайлан No. 21/251

- Уг тайланд Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн олон улс орнууд (ЗАНДБН-ийн улс орнууд) "нийлүүлэлтийн гаралтай үнийн инфляцын огцом өсөлттэй тулгараад байна"

хэмээн онцолжээ. Мөн эрэлтээс үүдэлтэй инфляц хурдсаж буй боловч Монгол, Филиппинээс бусад ЗАНДБН-ийн ихэнх улс орнуудад төв банкны зорилтот түвшинд хэвээр байна. Монгол улсын инфляцын түвшин 13.4% байгаа нь Монголбанкны зорилтот түвшин болох 6%-аас үлэмж өндөр байгааг харуулж байна.

- Мөн өндөр хөгжилтэй орнуудад хүүгийн түвшин өсөх төлөвтэй байгаа тул дараах эрсдэлүүд учирч болзошгүйг анхааруулжээ. Хөгжингүй эдийн засагтай орнуудын төсөөлж байснаас илүү өндөр инфляцаас үүдэлтэй зээлийн хүүгийн огцом өсөлт нь эмзэг эдийн засагтай улс орнуудыг хөрөнгийн гадагшлах урсгал, валютын ханшийн уналт, дотоодын мөнгөний бодлогын чангаралт, тэр ч байтугай санхүүгийн хямралд ч хүргэж болзошгүй юм. Тус тайланд гадаад өрийн түвшин өндөр буюу олон улсын санхүүгийн зах зээлээс ихээхэн хамааралтай байгаа тул эрсдэлд өртөх магадлалтай гэж үзсэн гурван улсыг (БНАЛАУ, Монгол, Папуа Шинэ Гвиней) нэрлэсний нэг нь Монгол улс байна. Гадаад өрийн ДНБ-д харьцуулсан харьцаа өндөр, таваарын зах зээлээс ихээхэн хамааралтай байгаагаас шалтгаалан өндөр хөгжилтэй орнуудын зээлийн хүүгийн өсөлттэй холбоотой хөрөнгийн гадагшлах урсгал нь Монголын эдийн засагт ихээхэн эрсдэл учруулж болзошгүй юм.

Монголын эдийн засаг

Эдийн засгийн хүчтэй сэргэлт үргэлжилж байгаа ч тодорхойгүй байдал хэвээр байна.

- ОУВС-аас 2021 оны 11 дүгээр сард гаргасан Монгол улсын талаарх хамгийн сүүлийн тайланд дурдсанаар Монгол улсын эдийн засагт дараах таатай нөхцөл байдал эергээр нөлөөлж байна[4]:
  - 2020 оны дүнд үеэс эхэлсэн экспортод тулгуурласан сэргэлт таваарын үнийн өсөлттэй уялдан эрчимжиж байна.
  - Дэлхийн эдийн засгийн сэргэлттэй уялдан үүл үүрхайн салбарын экспорт 2020 оны дүнд үеэс сэргэж эхэлснээр 2021 оны эхний хагаст ДНБ-ий өсөлт хүлээлтээс давсан. Уул үүрхайн салбарын ГШХО ба хувийн хөрөнгө оруулалт дахин сэргэсэн нь дэлхийн эдийн засгийн сэргэлт, суурь нөлөөллийн үр дүн зэргээс үүдэлтэй экспортын нөлөөнөөс уг өсөлт ихээхэн хамааралтай.

График 10. Олон улсын зах зээл дээрх зэсийн үнэ (ам.доллар тонн тутамд)



Эх сурвалж: ОУВС, Монгол улсын тайлан No. 21/251.

- 2022-2023 онд Оюу Толгойн зэсийн үүрхай бүрэн ашиглалтад орох үед экспортын хэмжээ нэмэгдэнэ гэж үзэж байна. 2022 оны 1 дүгээр сард, төслийн далд үүрхайн бүтээн байгуулалттай холбоотой Оюу Толгойн хувь нийлүүлэгчдийн хооронд үүссэн гол асуудал шийдэгдэж, 2023 оны эхний хагаст үүрхай бүрэн хэмжээгээр ажиллаж эхэлнэ гэж Рио Тинто групп болон Монгол улсын Засгийн газрын зүгээс мэдэгдсэн.
- Цар тахлын нөлөө намжих үед одоогоор сул байгаа дотоодын эрэлт сайжирна гэж үзэж байна. Дотоодын эдийн засагт өсөлтийн боломж байгаа тул инфляц Монголбанкны зорилтот түвшинд хадгалагдах боломжтой байх болох юм.
- 2021 онд ОУВС-аас олгосон 98.3 сая ам.долларын зээлжих тусгай эрх (SDR) болон их хэмжээний гадаад өрийн хэд хэдэн удаагийн дахин санхүүжилт нь гадаад валютын болон төсвийн нөөцийг зузаатгаад байна.

- Гэсэн хэдий ч, уг тайланд дурдсанаар дараах хэд хэдэн эрсдэл тулгарч болзошгүй байна. Үүнд:

[4] *IMF Country Report No. 21/251 (https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2021/11/29/Mongolia-2021-Article-IV-Consultation-Press-Release-Staff-Report-and-Statement-by-the-510086)*

- Ковид-19 болон вирусийн шинэ хувилбаруудын улмаас урт хугацаанд хил хаалттай байх нь эдийн засагт дарамт шахалт үзүүлсэээр байх магадлалтай;
- Таваарын үнийн хэлбэлзэл нь экспортоос хамааралтай сэргэлтэд саад учруулж болзошгүй;
- Улсын гадаад өрийн түвшин өндөр байгаа тул олон улсын санхүүжилтийн нөхцөл хатуу болох нь эрсдэл авч ирж болзошгүй;
- Мөчлөг дагасан бодлого нь бусад томоохон эрсдэлийг шийдвэрлэх бодлогын орон зайг багасгаж, эдийн засгийн сэргэлтийг сааруулж, макро санхүүгийн тогтвортой байдал, өрийн тогтвортой байдлыг алдагдуулж болзошгүй юм.

4. Санхүүгийн мэдээлэл

4.1 Санхүүгийн мэдээлэл

Санхүүгийн байдал

- Харьцуулалт хийхэд хялбар болгох үүднээс дараах график, хүснэгтэд 2017-2021 он хүртэлх бүх түүхэн тоон үзүүлэлтүүдийг IPO-ийн дараах төсөөлсөн үзүүлэлттэй зэрэгцүүлсэн байдлаар харуулав.

- Сүүлийн таван жилийн хугацаанд компанийн үйл ажиллагаа өргөжин тэлж, нийт активын хэмжээ өсөж ирсэн байна. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийт хөрөнгө 2017 оны 12 тэрбум төгрөгөөс 23.04%-ийн ЖНӨХ-иар өсөж 2021 оны эцэст 27 тэрбум төгрөгт хүрсэн бол 2027 он хүртэл 22.09%-ийн ЖНӨХ-иар 90 тэрбум төгрөгт хүрч өснө хэмээн төсөөлсөн байна.

- Харин жилийн борлуулалт нь 2017 оны 8 тэрбум төгрөгөөс 37.2%-ийн ЖНӨХ-иар өсөж 2021 оны тайлант жилд 29 тэрбум төгрөгт хүрсэн бол 2027 хүртэл 24.5%-ийн ЖНӨХ-иар 108 тэрбум төгрөгт хүрнэ гэж төсөөлжээ.

График 11. Нийт хөрөнгө болон борлуулалт (тэрбум төгрөг)



Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК

- Компанийн цэвэр ажлын капитал нь 2017 оны 7.1 тэрбум төгрөгөөс 20.32%-ийн ЖНӨХ-иар өсөж 2021 оны эцэст 14.9 тэрбум төгрөгт хүрсэн бол цаашид 2021 оныг суурь болгон харьцуулахад 2027 он хүртэл 11.4%-ийн ЖНӨХ-иар 28.5 тэрбум төгрөгт хүрнэ. Харин үндсэн хөрөнгө нь 2017 оны 2.4 тэрбум төгрөгөөс 34.29%-ийн ЖНӨХ-иар өсөж 2021 оны эцэст 7.7 тэрбум төгрөгт хүрсэн бол 2023 онд IPO-гоос татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 10 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хийснээр огцом өсөж, 2027 он хүртэл 2021 оныг суурь болгон харьцуулснаар 8.56%-ийн ЖНӨХ-иар 12.6 тэрбум төгрөгт хүрнэ гэж төсөөлжээ.

График 12. Цэвэр ажлын капитал ба үндсэн хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК

Хүснэгт 22. Санхүүгийн байдлын тайлан: 2017-2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, 2022-2027 оны прогноз/сая.төг/

Санхүүгийн байдлын тайлан	Өнгөрсөн хугацааны санхүүгийн байдал						Ирээдүйн санхүүгийн байдал					
Хөрөнгө	**2017**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022/6**	**2022**	**2023**	**2024**	**2025**	**2026**	**2027**
Эргэлтийн хөрөнгө												
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	1,072	2,157	1,607	2,646	2,391	1,507	7,444	12,946	15,333	21,094	29,568	40,313
Дансны авлага	310	1,416	1,598	2,244	2,935	3,776	5,763	5,418	8,331	11,426	14,519	17,738
Татвар, НДШ – ийн авлага	142	44	21	29	121	115	0	0	0	0	0	0
Бусад авлага	1,977	1,211	1,099	3,825	5,923	3,595	2,517	1,510	755	377	189	94
Бараа материал	5,469	5,827	7,195	4,521	5,432	9,282	4,395	5,361	6,832	8,756	10,767	13,044
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	539	2,841	644	1,949	2,729	3,626	2,137	2,583	3,261	4,165	5,100	6,183
Нийт эргэлтийн хөрөнгө	**9,510**	**13,496**	**12,164**	**15,214**	**19,531**	**21,901**	**22,256**	**27,817**	**34,513**	**45,819**	**60,142**	**77,373**
Эргэлтийн бус хөрөнгө												
Үндсэн хөрөнгө	2,359	4,780	8,134	7,404	7,661	7,602	7,688	16,817	16,282	15,408	14,182	12,562
Биет бус хөрөнгө	0	1	41	27	11	8	3,135	2,805	2,475	2,145	1,815	1,485
Нийт эргэлтийн бус хөрөнгө	**2,359**	**4,780**	**8,175**	**7,431**	**7,672**	**7,610**	**10,823**	**19,623**	**18,757**	**17,553**	**15,997**	**14,047**
Нийт хөрөнгө	**11,869**	**18,277**	**20,338**	**22,645**	**27,203**	**29,511**	**33,078**	**47,440**	**53,269**	**63,372**	**76,140**	**91,420**

Эх үүсвэр	Өнгөрсөн хугацааны санхүүгийн байдал						Ирээдүйн санхүүгийн байдал					
Өр төлбөр	**2017**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022/6**	**2022**	**2023**	**2024**	**2025**	**2026**	**2027**
Эргэлтийн өр төлбөр												
Дансны өглөг	1,159	1,008	268	342	287	628	4,662	4,767	3,779	4,697	5,626	6,754
Цалингийн өглөг	38	17	50	174	65	206	107	129	163	208	255	309
Бусад өглөг	109	199	530	140	1,843	584	148	284	544	837	1,171	1,482
Богино хугацаат зээл	-	-	-	-	-	1,977						
Нийт богино хугацаат өр төлбөр	**1,307**	**1,224**	**848**	**656**	**2,195**	**3,395**	**4,916**	**5,180**	**4,486**	**5,742**	**7,052**	**8,546**
Урт хугацаат өр												
Урт хугацаат зээл	-	4,600	4,600	4,063	3,428	2,552	3,262	3,504	3,648	3,816	3,974	4,048
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	1	5						
Нийт урт хугацаат өр төлбөр	**-**	**4,600**	**4,600**	**4,063**	**3,430**	**2,557**	**3,262**	**3,504**	**3,648**	**3,816**	**3,974**	**4,048**
НИЙТ ӨР ТӨЛБӨР	**1,307**	**5,824**	**5,448**	**4,719**	**5,625**	**5,952**	**8,178**	**8,684**	**8,134**	**9,559**	**11,026**	**12,594**

Эздийн өмч	Өнгөрсөн хугацааны санхүүгийн байдал						Ирээдүйн санхүүгийн байдал					
Өмч	**2017**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022/6**	**2022**	**2023**	**2024**	**2025**	**2026**	**2027**
Хувьцаат капитал	490	490	490	490	490	490	490	10,899	10,899	10,899	10,899	10,899
Хуримтлагдсан ашиг	10,073	11,963	14,400	17,436	21,088	23,069	24,410	28,739	35,119	43,797	55,097	68,810
Эздийн өмчийн дүн	**10,563**	**12,453**	**14,890**	**17,926**	**21,578**	**23,559**	**24,900**	**38,756**	**45,136**	**53,813**	**65,114**	**78,826**
Нийт өмч ба өр төлбөр	**11,869**	**18,277**	**20,338**	**22,645**	**27,203**	**29,511**	**33,079**	**47,440**	**53,270**	**63,372**	**76,140**	**91,420**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

Хүснэгт 23. Санхүүгийн байдлын тайлан: 2017-2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, 2022-2027 оны прогноз/%-иар/

Санхүүгийн байдлын тайлан	Өнгөрсөн хугацааны санхүүгийн байдлын бүтэц						Ирээдүйн санхүүгийн байдлын бүтэц					
Хөрөнгө	**2017**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022/6**	**2022**	**2023**	**2024**	**2025**	**2026**	**2027**
Эргэлтийн хөрөнгө												
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	9.0%	11.8%	7.9%	11.7%	8.8%	5.1%	22.5%	27.3%	28.8%	33.3%	38.8%	44.1%
Дансны авлага	2.6%	7.7%	7.9%	9.9%	10.8%	12.8%	17.4%	11.4%	15.6%	18.0%	19.1%	19.4%
Татвар, НДШ – ийн авлага	1.2%	0.2%	0.1%	0.1%	0.4%	0.4%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Бусад авлага	16.7%	6.6%	5.4%	16.9%	21.8%	12.2%	7.6%	3.2%	1.4%	0.6%	0.2%	0.1%
Бараа материал	46.1%	31.9%	35.4%	20.0%	20.0%	31.5%	13.3%	11.3%	12.8%	13.8%	14.1%	14.3%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4.5%	15.5%	3.2%	8.6%	10.0%	12.3%	6.5%	5.4%	6.1%	6.6%	6.7%	6.8%
Нийт эргэлтийн хөрөнгө	**80.1%**	**73.8%**	**59.8%**	**67.2%**	**71.8%**	**74.2%**	**67.3%**	**58.6%**	**64.8%**	**72.3%**	**79.0%**	**84.6%**
Эргэлтийн бус хөрөнгө												
Үндсэн хөрөнгө	19.9%	26.2%	40.0%	32.7%	28.2%	25.8%	23.2%	35.5%	30.6%	24.3%	18.6%	13.7%
Биет бус хөрөнгө	0.0%	0.0%	0.2%	0.1%	0.0%	0.0%	9.5%	5.9%	4.6%	3.4%	2.4%	1.6%
Нийт эргэлтийн бус хөрөнгө	**19.9%**	**26.2%**	**40.2%**	**32.8%**	**28.2%**	**25.8%**	**32.7%**	**41.4%**	**35.2%**	**27.7%**	**21.0%**	**15.4%**
Нийт хөрөнгө	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100%**	**100%**	**100%**	**100%**	**100%**	**100%**

Эх үүсвэр	Өнгөрсөн хугацааны санхүүгийн байдлын бүтэц						Ирээдүйн санхүүгийн байдлын бүтэц					
Өр төлбөр	**2017**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022/6**	**2022**	**2023**	**2024**	**2025**	**2026**	**2027**
Эргэлтийн өр төлбөр												
Дансны өглөг	9.8%	5.5%	1.3%	1.5%	1.1%	2.1%	14.1%	10.0%	7.1%	7.4%	7.4%	7.4%
Цалингийн өглөг	0.3%	0.1%	0.2%	0.8%	0.2%	0.7%	0.3%	0.3%	0.3%	0.3%	0.3%	0.3%
Бусад өглөг	0.9%	1.1%	2.6%	0.6%	6.8%	2.0%	0.4%	0.6%	1.0%	1.3%	1.5%	1.6%
Богино хугацаат зээл	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	6.7%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**11.0%**	**6.7%**	**4.2%**	**2.9%**	**8.1%**	**11.5%**	**14.9%**	**10.9%**	**8.4%**	**9.1%**	**9.3%**	**9.3%**
Урт хугацаат өр												
Урт хугацаат зээл	0.0%	25.2%	22.6%	17.9%	12.6%	8.6%	9.9%	7.3%	6.8%	6.0%	5.2%	4.5%
Бусад урт хугацаат өр төлбөр	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%						
Урт хугацаат өр төлбөрийн дүн	**0.0%**	**25.2%**	**22.6%**	**17.9%**	**12.6%**	**8.7%**	**9.9%**	**7.3%**	**6.8%**	**6.0%**	**5.2%**	**4.5%**
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	**11.0%**	**31.9%**	**26.8%**	**20.8%**	**20.7%**	**20.2%**	**24.7%**	**18.3%**	**15.3%**	**15.1%**	**14.5%**	**13.8%**

Эздийн өмч	Өнгөрсөн хугацааны санхүүгийн байдлын бүтэц						Ирээдүйн санхүүгийн байдлын бүтэц					
Өмч	**2017**	**2018**	**2019**	**2020**	**2021**	**2022/6**	**2022**	**2023**	**2024**	**2025**	**2026**	**2027**
Хувьцаат капитал	4.1%	2.7%	2.4%	2.2%	1.8%	1.7%	1.5%	21.1%	18.8%	15.8%	13.2%	11.0%
Хуримтлагдсан ашиг	84.9%	65.5%	70.8%	77.0%	77.5%	78.2%	73.8%	60.6%	65.9%	69.1%	72.4%	75.3%
Эздийн өмчийн дүн	**89.0%**	**68.1%**	**73.2%**	**79.2%**	**79.3%**	**79.8%**	**75.3%**	**81.7%**	**84.7%**	**84.9%**	**85.5%**	**86.2%**
Нийт өмч ба өр төлбөр	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**	**100.0%**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн Капиталын бүтэц

- "Газар шим үйлдвэр" ХХК нь 2017 онд 100% өөрийн хөрөнгөөр санхүүжсэн капиталын бүтэцтэй байсан бол 2018-2021 оны хооронд дунджаар нийт капиталын 83.5%-ийг өөрийн хөрөнгөөр, 16.5%-ийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж иржээ.
- 2022-2027 онуудад дунджаар нийт капиталын 93%-ийг өөрийн хөрөнгөөр 7%-ийг зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр хүлээгдэж байна.

График 13. Капиталын бүтэц (%-иар)



Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

- Түс компанийн эргэлтийн хөрөнгөөрөө эргэлтийн өр төлбөрөө төлөх чадвар өнгөрсөн хугацаанд хангалттай байсан нь Санхүүгийн харьцааны төлбөрийн чадварын харьцааны шинжилгээнээс харагдаж байна.
- Түс компани авлагаа 66-100 хоногт бүрэн цуглуулж ирсэн ба бараа материал болон урьдчилгааны мөнгөнд хөрвөх дундаж хоног өнгөрсөн 5 жилийн хугацаанд 300 орчим хоногоос буурсаар 145 хоног болж иржээ. Түс компани үйлдвэрийн сав, баглаа боодлыг гадаадын улс орнуудаас импортоор худалдан авдаг учраас бараа материалын урьдчилгаа данс тогтмол үлдэгдэлтэй байдаг нь бараа материалын хоногт нөлөөлдөг байна.
- Төлбөрийн чадвар, үйл ажиллагаа болон хөшүүргийн харьцааны үзүүлэлтүүдийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 24. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн Санхүүгийн харьцаа

	Түүхэн гүйцэтгэлээр					
	2017	2018	2019	2020	2021	2022H1
Төлбөрийн чадварын харьцаа						
Төлбөрийн чадвар	7.3x	11.0x	14.3x	23.2x	8.9x	6.5x
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	1.1x	2.9x	3.8x	7.5x	2.4x	1.6x
Үйл ажиллагааны харьцаа						
Авлагын эргэц	3.4x	4.7x	5.5x	4.9x	3.9x	1.9x
Авлагын цуглуулах хоног	107.6	78.3	66.2	74.8	94.3	193.8
Бараа материалын эргэц	1.0x	1.2x	1.2x	2.0x	2.5x	1.0x
Бараа материал, урьдчилгааны хоног	352	317	304	180	145	357
Цэвэр ажлын капиталын эргэц	1.2x	1.4x	1.5x	2.0x	2.2x	0.9x
Нийт хөрөнгийн эргэц	0.7x	0.8x	0.8x	1.0x	1.2x	0.5x
Үндсэн хөрөнгийн эргэц	3.5	3.3	2.3	2.8	3.9	2.0
Хөшүүргийн харьцаа						
Нийт өр ба нийт хөрөнгө	0%	25%	23%	18%	13%	15%
Нийт өмч ба нийт хөрөнгө	89%	68%	73%	79%	79%	80%

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

- Нийт өрийн нийт хөрөнгөд эзлэх хувь үнэлгээний өдрийн байдлаар 15% байсан бол прогнозын хугацаанд багассаар 11%-иас 5%-д хүрнэ. Ингэснээр урт хугацаандаа нийт хөрөнгийн 88%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх юм.
- Прогнозын хугацаанд авлагыг 60-90 хоногт цуглуулж, бараа материал болон урьдчилгааг 90-135 хоногт мөнгөнд хувиргаж, эргэлтийн өр төлбөрийг 40-45 хоногт барагдуулна хэмээн төсөөлж ажлын капиталын хэрэгцээг төлөвлөсөн.

Санхүүгийн гүйцэтгэл

График 14. Борлуулалт, ББӨ, нийт ашиг (%-иар)



Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

График 15. Цэвэр ашиг (тэрбум төгрөг) ба Өмчийн өгөөж(%)



Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

- 2017-2021 оны хооронд компанийн борлуулалт 37.2%-ийн ЖНӨХ-иар 2017 оны 8.1 тэрбум төгрөгөөс 29.2 тэрбум төгрөгт хүртэл өссөн бол цаашид 24.5%-ийн ЖНӨХ-иар өсөж 2027 он гэхэд 108 тэрбум төгрөгт хүрнэ.
- Өнгөрсөн хугацаанд Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн борлуулалтад эзлэх хувийн жин 2017 оны 76%-ийн түвшнээс жил бүр буурсаар 2021 оны тайлант жилд 63%-д хүрсэн.
- Цаашид үнэлгээний суурь жилийн 63%-ийн түвшнээс прогнозын хугацааны туршид жил бүр аажим буурсаар 2027 онд борлуулалтын 57%-д хүрч тогтворжино гэж төсөөлсөн.
- Харин цэвэр ашгийн борлуулалтад эзлэх хувийн жин буюу ашигт ажиллагааны түвшинд 2017 онд 11% байсан бол 2021 онд 19%-д хүртэл жил бүр нэмэгдэж ирсэн бол цаашид энэ түвшинд хадгалагдана гэж төсөөлсөн.
- Оны эхэн дэх өмчид хамаарах өмчийн өгөөж нь 2017 онд 8% байсан бол 2021 онд 29%-д хүрч өссөн. Харин цаашид дунд хугацаанд 21%-29%-ийн түвшинд тогтвортой байх төлөвтэй байна.

График 16. Жишиг компаниуд ба "Газар шим үйлдвэр" ХХК-ийн Өмчийн өгөөж(%)-ийн харьцуулалт



Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн аудитлагдсан санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөл

Хүснэгт 25. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн Орлого үр дүнгийн тайлангийн гүйцэтгэл ба прогноз

	Өнгөрсөн хугацааны санхүүгийн гүйцэтгэл						Прогнозын хугацааны санхүүгийн төсөөлөл					
	2017	2018	2019	2020	2021	2022/6	2022	2023	2024	2025	2026	2027
Борлуулалтын орлого (цэвэр)	8,241	11,886	14,856	21,514	29,186	15,506	33,579	42,144	55,275	71,807	89,472	108,479
Борлуулалтын өртөг	6,235	8,445	9,909	14,526	18,461	10,776	21,368	25,825	32,612	41,648	50,999	61,833
Нийт ашиг (алдагдал)	**2,006**	**3,441**	**4,947**	**6,988**	**10,725**	**4,730**	**12,211**	**16,319**	**22,663**	**30,159**	**38,473**	**46,646**
Хүүний орлого	-	16	6	41	62	6	-	-	-	-	-	-
Бусад орлого	27	11	0	193	361	33	-	-	-	-	-	-
Эрхийн шимтгэлийн зардал							104	110	115	121	127	133
Борлуулалт, маркетингийн зардал	463	655	987	1,185	2,153	1,074	2,351	2,950	3,869	5,026	6,263	7,594
Ерөнхий ба удирдлагын зардал	478	641	1,252	1,667	1,382	634	1,725	2,165	2,840	3,689	4,597	5,573
Элэгдэл, хорогдол	-	-	-	-	-	-	815	1,287	1,524	1,862	2,213	2,609
Санхүүгийн зардал	-	3	-	-	325	149	371	501	522	546	568	579
Бусад зардал	95	25	31	17	677	623	943	1,862	2,175	2,163	2,792	3,352
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(8)	(36)	27	61	(11)	(5)	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	2	(54)	(6)	(7)	-	-	-	-	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	986	2,107	2,712	4,361	6,592	2,276	5,902	7,444	11,618	16,752	21,912	26,806
Орлогын татварын зардал	(109)	(217)	(274)	(433)	(940)	(296)	(590)	(1,136)	(2,174)	(3,350)	(4,685)	(5,928)
Татварын дараахь ашиг (алдагдал)	**877**	**1,890**	**2,438**	**3,927**	**5,652**	**1,980**	**5,312**	**6,308**	**9,444**	**13,402**	**17,227**	**20,878**

Орлогын дэлгэрэнгүй тайлан /мянган төгрөгөөр/	Өнгөрсөн хугацааны санхүүгийн гүйцэтгэлийн бүтэц						Прогнозын хугацааны санхүүгийн төсөөллийн бүтэц					
	2017	2018	2019	2020	2021	2022/6	2022	2023	2024	2025	2026	2027
Борлуулалтын орлого (цэвэр)	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%
Борлуулалтын өртөг	75.7%	71.1%	66.7%	67.5%	63.3%	69.5%	63.6%	61.3%	59.0%	58.0%	57.0%	57.0%
Нийт ашиг (алдагдал)	**24.3%**	**28.9%**	**33.3%**	**32.5%**	**36.7%**	**30.5%**	**36.4%**	**38.7%**	**41.0%**	**42.0%**	**43.0%**	**43.0%**
Хүүний орлого	0.0%	0.1%	0.0%	0.2%	0.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Бусад орлого	0.3%	0.1%	0.0%	0.9%	1.2%	0.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Эрхийн шимтгэлийн зардал	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.3%	0.3%	0.2%	0.2%	0.1%	0.1%
Борлуулалт, маркетингийн зардал	5.6%	5.5%	6.6%	5.5%	7.4%	6.9%	7.0%	7.0%	7.0%	7.0%	7.0%	7.0%
Ерөнхий ба удирдлагын зардал	5.8%	5.4%	8.4%	7.8%	4.7%	4.1%	5.1%	5.1%	5.1%	5.1%	5.1%	5.1%
Элэгдэл, хорогдол	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	2.4%	3.1%	2.8%	2.6%	2.5%	2.4%
Санхүүгийн зардал	0.0%	0.0%	0.0%	0.0%	1.1%	1.0%	1.1%	1.2%	0.9%	0.8%	0.6%	0.5%
Бусад зардал	1.1%	0.2%	0.2%	0.1%	2.3%	4.0%	2.8%	4.4%	3.9%	3.0%	3.1%	3.1%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-0.1%	-0.3%	0.2%	0.3%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0%	0.0%	0.0%	-0.2%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Бусад ашиг (алдагдал)	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	**12.0%**	**17.7%**	**18.3%**	**20.3%**	**22.6%**	**14.7%**	**17.6%**	**17.7%**	**21.0%**	**23.3%**	**24.5%**	**24.7%**
Орлогын татварын зардал	-1.3%	-1.8%	-1.8%	-2.0%	-3.2%	-1.9%	-1.8%	-2.7%	-3.9%	-4.7%	-5.2%	-5.5%
Татварын дараахь ашиг (алдагдал)	**10.6%**	**15.9%**	**16.4%**	**18.3%**	**19.4%**	**12.8%**	**15.8%**	**15.0%**	**17.1%**	**18.7%**	**19.3%**	**19.2%**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК, БДО Монгол шинжилгээ

Хүснэгт 26. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн Ашигт ажиллагаа, өгөөж, өсөлт

	Өнгөрсөн хугацааны гүйцэтгэл						Ирээдүйн хугацааны төсөөлөл					
Ашигт ажиллагааны харьцаа	*2017*	*2018*	*2019*	*2020*	*2021*	*2022H1*	*2022*	*2023*	*2024*	*2025*	*2026*	*2027*
Нийт ашгийн маржин	24%	29%	33%	32%	37%	31%	36%	39%	41%	42%	43%	43%
EBITDA маржин	13%	19%	23%	25%	25%	18%	21%	24%	26%	27%	28%	28%
Үйл ажиллагааны ашгийн маржин	12%	18%	20%	21%	22%	15%	19%	19%	22%	24%	25%	25%
Цэвэр ашгийн маржин	10%	16%	16%	17%	18%	13%	16%	15%	17%	19%	19%	19%
Татварын дараах үйл ажиллагааны ашгийн маржин	10%	16%	19%	19%	19%	14%	17%	16%	18%	19%	20%	20%
Өгөөжийн харьцаа												
Жилийн дундаж өмчийн өгөөж	8%	17%	18%	22%	27%	9%	23%	20%	23%	27%	29%	29%
Жилийн дундаж капиталын өгөөж	8%	14%	13%	18%	22%	7%	20%	18%	25%	27%	29%	30%
Жилийн дундаж хөрөнгийн өгөөж	7%	13%	12%	17%	21%	7%	18%	16%	19%	23%	25%	25%
Жилийн эхэн дэх капиталын өгөөж	0.0%	20.0%	17.9%	23.0%	29.6%	9.6%	25.1%	30.7%	30.0%	35.8%	39.7%	40.5%
Жилийн эхэн дэх өмчийн өгөөж	0.0%	18.0%	19.3%	24.8%	29.3%	9.1%	24.6%	26.0%	24.5%	29.7%	32.2%	32.4%
Жилийн эхэн дэх хөрөнгийн өгөөж	0.0%	16.0%	13.1%	18.1%	23.2%	7.2%	19.5%	19.6%	20.0%	25.2%	27.3%	27.7%

	Өнгөрсөн хугацааны гүйцэтгэл						Ирээдүйн хугацааны төсөөлөл					
Өсөлтийн харьцаа	*2017*	*2018*	*2019*	*2020*	*2021*	*2022H1*	*2022*	*2023*	*2024*	*2025*	*2026*	*2027*
Борлуулалтын дундаж өсөлт		44%	25%	45%	36%	8%	15%	26%	31%	30%	25%	21%
Борлуулалтын жилийн нийлмэл өсөлт (ЖНӨ)		44%	34%	38%	37%	15%	32%	31%	31%	31%	30%	29%
Нийт ашгийн дундаж өсөлт		72%	44%	41%	53%	-16%	14%	34%	39%	33%	28%	21%
Нийт ашгийн ЖНӨ		72%	57%	52%	52%	21%	44%	42%	41%	40%	39%	37%
Үйл ажиллагааны ашгийн дундаж өсөлт		118%	44%	47%	45%	-26%	-4%	27%	53%	42%	30%	22%
Үйл ажиллагааны ашгийн ЖНӨ		118%	77%	67%	61%	22%	45%	42%	43%	43%	42%	40%
Цэвэр ашгийн жилийн дундаж өсөлт		121%	27%	53%	42%	-39%	1%	19%	50%	42%	29%	21%
Цэвэр ашгийн ЖНӨ		121%	67%	62%	57%	20%	44%	39%	41%	41%	40%	38%

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК, БДО Монгол

Хүснэгт 27. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн Дьюпонтын шинжилгээ

	Өнгөрсөн хугацааны гүйцэтгэл					Ирээдүйн хугацааны төсөөлөл					
Өсөлт	*2017*	*2018*	*2019*	*2020*	*2021*	*2022*	*2023*	*2024*	*2025*	*2026*	*2027*
Борлуулалт	53.8%	44.2%	25.0%	44.8%	35.7%	15.1%	25.5%	31.2%	29.9%	24.6%	21.2%
ХТЭХӨА	68.2%	102.6%	50.6%	55.9%	34.8%	-2.7%	40.1%	44.4%	35.3%	29.5%	21.4%
ХТӨА	68.4%	98.4%	43.4%	46.1%	44.5%	-3.4%	37.8%	48.3%	36.9%	30.6%	21.8%
Цэвэр ашиг	49.1%	115.6%	29.0%	61.1%	43.6%	-5.8%	31.9%	44.5%	34.8%	29.4%	21.1%
Margins											
ХТЭХӨА	13.6%	19.1%	23.3%	25.1%	25.0%	21.1%	23.6%	25.9%	27.0%	28.1%	28.1%
ХТӨА	12.9%	17.8%	20.7%	20.9%	22.2%	18.7%	20.5%	23.2%	24.4%	25.6%	25.7%
Цэвэр ашиг	10.6%	15.9%	16.4%	18.3%	19.3%	15.8%	16.6%	18.3%	19.0%	19.7%	19.7%
Ашигт ажиллагаа - ДьюПонтын шинжилгээ											
Хөрөнгийн эргэц	0.7x	0.8x	0.8x	1.0x	1.2x	1.1x	1.0x	1.1x	1.2x	1.3x	1.3x
x Ашигт ажиллагаа	10.6%	15.9%	16.4%	18.3%	19.4%	15.8%	16.6%	18.3%	19.0%	19.7%	19.7%
Хөрөнгийн өгөөж	**7.8%**	**12.5%**	**12.6%**	**18.3%**	**22.7%**	17.6%	17.4%	20.1%	23.4%	25.3%	25.5%
x Нийт хөрөнгө/Өмч харьцаа	1.1x	1.3x	1.4x	1.3x	1.3x	1.3	1.3	1.2	1.2	1.2	1.2
Өмчийн өгөөж	**8.3%**	**16.4%**	**17.8%**	**23.9%**	**28.7%**	22.9%	22.0%	24.2%	27.6%	29.7%	29.7%
Ашигт ажиллагаа – ROCE буюу оруулсан капиталын өгөөж											
Үндсэн хөрөнгө	2,359	4,780	8,175	7,431	7,672	7,688	16,817	16,282	15,408	14,182	12,562
Ажлын капитал	7,132	10,115	9,709	11,912	14,945	9,896	9,691	14,694	18,982	23,523	28,514
Мөнгө	1,072	2,157	1,607	2,646	2,410	7,444	12,946	15,333	21,094	29,568	40,313
Нийт капитал	**10,563**	**17,053**	**19,490**	**21,990**	**25,027**	**25,027**	**39,454**	**46,309**	**55,484**	**67,273**	**81,389**
ХТӨА	1,064	2,111	3,076	4,495	6,526	6,273	8,644	12,818	17,545	22,909	27,892
- Ттатвар	-109	-217	-274	-433	-940	-590	-1,136	-2,174	-3,350	-4,685	-5,928
Татварын дараах үйл ажиллагааны ашиг(NOPAT)	**955**	**1,894**	**2,802**	**4,061**	**5,586**	**5,683**	**7,508**	**10,644**	**14,195**	**18,224**	**21,964**
Капиталын өгөөж		**13.7%**	**15.3%**	**19.6%**	**23.8%**	22.7%	23.3%	24.8%	27.9%	29.7%	29.5%

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК, БДО Монгол шинжилгээ

5. Үнэлгээний шинжилгээ

5.1 Үнэлгээний хандлага, аргууд

- Бид "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолохдоо үнэлгээний тохиромжтой хандлага, аргуудыг шүүн тунгааж, хамгийн тохиромжтой гэж мэргэжлийн түвшинд авч үзсэн аргыг сонгосон.

- "Газар шим үйлдвэр" ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хүнсний үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагаа болно.

- Компанийн бизнесийг үнэлэхдээ бид дараах төсөөлөлд үндэслэн үнэлгээний орлогын хандлагын суурь арга болох байгууллагын хэмжээний чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргыг үндсэн арга болгон сонгон үнэ цэнийг тооцоолж дүгнэлт гаргасан ба Орлогын хандлагын Ногдол Ашиг Хорогдуулах (НАХ) загвар, Тохируулсан өнөөгийн үнэ цэнийн загвар болон Зах зээлийн хандлагын ЖКАЗ-г баталгаажуулах аргууд болгон ашигласан. Бид үнэлгээнд Зах зээлийн хандлага болон Орлогын хандлагыг дараах үндэслэлтэйгээр ашигласан:

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд **зах зээлийн хандлагыг** ихэвчлэн ашигладаг. Зах зээлийн хандлага нь бизнесийн хувьд хамгийн бодитой, ул үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Учир нь энэ аргын үед бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа, ижил буюу жиших боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэдэг.

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд **орлогын хандлагыг** тогтмол хэрэглэдэг. Мөн түүнчлэн, компани нь ойрын ирээдүй (прогнозын хугацаа)-д бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэж төсөөлөх боломжтой. Иймээс тасралтгүй хугацаанд үг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн Хорогдуулсан Мөнгөн Урсгал (ХМУ)-ын загварыг ашиглах боломжтой.

5.2 Зах зээлийн хандлага: Жишиг компанийн арга зүй (ЖКАЗ)

- Бизнес дэх өмчийн хувь оролцоог үнэлэхдээ зах зээлийн хандлага нь үнэлж буй бизнесийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, түүхэн ба хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэлийг: (1) ижил буюу төстэй бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, (2) эдийн засаг, байгаль орчны, улс төрийн ижил эрсдэлүүдэд өртдөг, (3) хөрөнгө оруулагчийн дараагийн сонголт байх боломжтой компаниудын зах зээлийн үнэлгээ болон бодит арилжааны мэдээлэлтэй харьцуулдаг.

- Зах зээлийн хандлагад түгээмэл хэрэглэгддэг хоёр арга байдаг нь:

  - Жишиг Компанийн Арга Зүй (ЖКАЗ): Энэ арга нь нээлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг, бизнесийн ижил салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны зах зээлийн үнээс тооцсон зах зээлийн үржүүлэгчийг ашигладаг. Үнэлж буй бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илтгэх хэмжүүрт тохирох үржүүлэгчийг сонгосноор арилжаалагдахуйц цөөнхийн сонирхлоор үнэ цэнэ тодорхой болдог. Хэрэв үнэлгээний зорилго нь бизнес дэх хяналтын багцын үнэ цэнийг тодорхойлох бол хяналттай хувь оролцооны урамшууллыг нэмж өгөх шаардлагатай.

  - Жишиг Арилжааны Арга Зүй (ЖААЗ): Энэ аргыг мөн "арилжааны арга" эсвэл "нэгдэл ба худалдан авалтын арга" гэж нэрлэдэг. Жишиг арилжаагаар зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ижил бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хяналтын эрхтэй буюу их дүнтэй арилжаанаас үүссэн үржүүлэгч ашигладаг. Энэ тохиолдолд ихэвчлэн арилжаалагдахуйц хяналтын эрхтэй сонирхлоор зах зээлийн үнэ цэнэ тодорхой болдог. Хэрэв хөрөнгийн биржээс гадуурх их дүнтэй арилжааны мэдээлэл ашиглах тохиолдолд, цөөнхийн хувь оролцоог үнэлэхийн тулд хөрвөх чадваргүйн хорогдуулалтыг хасаж өгөх тохиолдол байдаг.

- Бид өөрсдийн дотоодын мэдээллийн сан болон албан МХБ-ийн цахим хуудсанд тавигдсан нээлттэй мэдээллийн эх сурвалжид үндэслэн үнэлгээний шинжилгээнд ЖКАЗ-г авч үзсэн..

Жишиг компани сонгох шалгуур

- Бид жишиг компанийн арга зүйг ашиглахдаа МХБ-ийн ТОП20-д багтдаг хүнсний салбарын компаниудын Үнэ/Борлуулалт (P/S), Үнэ/Ашиг (P/E) болон БҮЦ/ХТӨА үржүүлэгчийг ашигласан.

- Бид эдгээр сонгосон жишиг компаниудын зах зээлийн Бета-г тооцож, орлогын хандлагад ашиглах хорогдуулах хувийн шинжилгээнд мөн ашигласан.

Хүснэгт 28. Сонгогдсон жишиг компаниуд

#	Жишиг компаниуд	Таних тэмдэг	Нийт Бор-лалт	Өмчийн өгөөж	ХТӨА	Цэвэр ашиг	Зах зээлийн үнэлгээ	Өр	БҮЦ	Өмчийн дансны үнэ	Үнэ Бор-лалт	Үнэ Ашиг	БҮЦ ХТӨА	Levered Beta	Татвар %	D/E	Unlevered Beta
1	Монос хүнс ХК	MCF	18,841	13.6%	2,914	2,030	43,117	7,579	50,696	15,615	2.3x	21.2x	17.4x	0.44	13%	0.49	0.31
2	Түмэншувуут ХК	TUM	35,913	23.1%	7,955	6,940	82,278	15,865	98,143	33,465	2.3x	11.9x	12.3x	0.72	13%	0.47	0.51
3	Талхчихэр ХК	TCK	75,804	8.9%	6,183	5,140	32,636	5,602	38,237	60,514	0.4x	6.4x	6.2x	0.48	11%	0.09	0.44
4	Сүү ХК	SUU	100,397	9.4%	13,804	9,401	178,601	43,435	222,037	32,981	1. 8x	19.0x	16.1x	0.60	0%	1.32	0.26
5	АПУ ХК	APU	678,164	22.7%	194,827	153,528	1,420,134	71,125	1,491,259	540,053	2.1x	9.3x	7.6x	0.69	21%	0.13	0.62
	1-р квартил		35,913	9.4%	6,183	5,140	43,117	7,579	50,696	32,981	1. 8x	9.3x	7.6x	0.48	11%	0.13	0.31
	Медиан		75,804	13.6%	7,955	6,940	82,278	15,865	98,143	33,465	2.1x	11.9x	12.3x	0.60	13%	0.47	0.44
	3-р квартил		100,397	22.7%	13,804	9,401	178,601	43,435	222,037	60,514	2.3x	19.0x	16.1x	0.69	13%	0.49	0.51

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Сонгогдсон компаниудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт VII-оос харна уу.
- Жишиг компаниудыг сонгохдоо дараах зарчим баримталсан:
  - Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг хүнсний салбарын үйлдвэрлэл эрхэлдэг компани байх;
  - Хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагддаг, хувьцааны идэвхтэй арилжаатай компани байх;
- Бид дээрх зарчмын дагуу МХБ-ийн ТОП20-д бүртгэлтэй хүнсний салбарын 6 компанийг сонгосон. Дараа нь мэдээллийн чанарт хийсэн шинжилгээнд суурилан Мах-Импекс ХК-ийг жишиг компаниас хассан.
- Сүү ХК-ийн хувьд 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг МХБ-ийн цахим сайтад нийтлээгүй учраас 2021 оны жилийн мэдээллийг ашигласан.
- Үнэлгээний үржүүлэгчийг 2021 оны санхүүгийн бүтэн жилийн мэдээлэлд суурилж тооцоолоод үнэлгээний өдөр ба 2021 оны 12 сарын 31-ний хоорондын хувьцааны үнийн өөрчлөлтийн нөлөөллийг арилгах тохируулга хийсэн.
- Эцэст нь жишиг компани түс бүрийн үржүүлэгч, өмчийн өгөөж, ашигт ажиллагааны хувь, ХТӨА-ийн маржин зэргийн хамаарлын шинжилгээгээр тохируулах замаар үнэлэгдэж буй компанид хамаарах үнэлгээний үржүүлэгчийг тооцоолсон.

5.3 Орлогын хандлага: Чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох арга

- Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн шинжилгээг нийтэд нь Хорогдуулсан Мөнгөн Урсгал (Discounted Cash Flow)-ын шинжилгээ гэж нэрлэдэг. Энэ арга нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнүүдийн нийлбэр нь бизнесийн үнэ цэнийг илтгэнэ гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Энэ арга зүйг ашиглахын тулд ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй дүнг тохиромжтой капиталын өртөг (хорогдуулах хувь)-өөр хорогдуулдаг.

- ХМУ-ын үндсэн хэд хэдэн хувилбар байдаг:

  - Бизнест хамаарах чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Firm) – нь бизнест хамаарах нийт чөлөөт мөнгөн урсгалыг ашиглан нийт бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог. Энэ аргын үед хорогдуулах хувийг КЖДӨ-өөр орлуулдаг. Бид энэ аргыг үнэлгээний үндсэн арга болгон сонгосон.
  - Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity) – нь өмчид хамаарах нийт чөлөөт мөнгөн урсгалыг ашиглан өмчийн үнэ цэнийг тодорхойлдог;
  - Ногдол Ашиг Хорогдуулах загвар (НАХ загвар буюу Dividend Discount Model) - нь санхүүгийн байгууллагын үнэ цэнийг тооцохдоо ирээдүйн ногдол ашгийг өмчийн өртгөөр хорогдуулж тооцдог. Энэ арга нь ойлгоход хялбар, түгээмэл хэрэглэгддэг боловч жил бүрийн ногдол ашгийн хэлбэлзэл өндөртэй, эсхүл ногдол ашиг тараадаггүй компанийг үнэлэхэд тохиромжгүй байдаг.

- Бизнест хамаарах чөлөөт мөнгөн урсгал болон Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгал нь үнэлгээнд түгээмэл хэрэглэгддэг арга учраас бид эдгээрийн хэрэглээнд зохих шинжилгээ хийсний үндсэн дээр ашигласан.

- НАХ загвар нь жил бүр тогтмол ногдол ашиг тарааж ирсэн, цаашид ч тараахаар төлөвлөж буй компаниудыг үнэлэхэд хамгийн тохиромжтой байдаг. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьд 2020 ба 2021 онуудад ногдол ашиг хуваарилсан ба 2022 оноос ногдол ашиг тараах төлөвлөгөөтэй байгаа учраас үнэлгээний үндсэн аргын үр дүнг баталгаажуулах зорилгоор ашигласан.

- Үндсэн арга буюу Бизнест хамаарах чөлөөт мөнгөн урсгал(БХЧМУ)-ыг хорогдуулан тооцох аргад орох суурь өгөгдөл болох БХЧМУ-ыг дараах байдлаар тодорхойлно:

$$\text{БХЧМУ} = \text{ХТӨА}(1 - \text{Татвар}) + \text{МБЗ} \pm \text{АКӨ} - \text{КЗ}$$

Энд:

БХМЧУ	=	*Байгууллагын хэмжээний чөлөөт мөнгөн урсгал;*
ХТӨА	=	*Хүү, татварын өмнөх ашиг;*
Татвар	=	*Татварын хувь.*
МБЗ	=	*Мөнгөн бус зардал.*
АКӨ	=	*Ажлын капиталын өөрчлөлт(өсөлт бол хасаж, бууралт бол нэмнэ).*
КЗ	=	*Капитал зарцуулалт.*

5.3.1 Хорогдуулах хувь

- Хэрэв ХМУ-ын аргад ашиглаж буй мөнгөн урсгал нь байгууллагын бизнест хамааралтай бол КЖДӨ-ийг, зөвхөн өмчид хамааралтай бол өмчийн өртөг (cost of equity)-ийг хорогдуулах хувь болгон ашиглах нь зохистой. КЖДӨ нь өмчийн өртөг, өмчийн капиталын нийт капиталд эзлэх хувь, өрийн өртөг, өрийн капиталын нийт капиталд эзлэх хувийн жинг ашиглан тооцсон жинлэсэн дундаж хувь байна.

- Өмчийн өртгийг тооцоолоход Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвар (КХҮЗ, Capital Asset Pricing Model, CAPM)-ыг ашиглах нь түгээмэл байдаг.

- Өмчийн өртгийг Өргөтгөсөн Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвар (extended-CAPM)-ийг ашиглан тооцсон:

$$K_e = R_f + \beta_l \cdot (R_m - R_f) + CSP$$

Энд:

K_e	=	*Өмчийн өртөг (cost of equity);*
R_f	=	*Эрсдэлгүй хүүний түвшин;*
β_l	=	*Өмчийн бета;*
R_m	=	*Өмчийн зах зээлийн өгөөж;*
$(R_m - R_f)$	=	*Өмчийн эрсдэлийн шагнал;*
CSP	=	*Компанийн тусгайлсан эрсдэлийн шагнал.*

Эрсдэлгүй хүүний түвшин (R_f)

- Эрсдэлгүй хүүний түвшин нь өмчийн өртгийн нэг чухал хэсэг юм.

- Аливаа улсын эрсдэлгүй хүүгийн түвшинг ихэнх тохиолдолд тухайн улсын Засгийн газрын үндэсний мөнгөн тэмдэгтээр гаргасан урт хугацаат бондын өгөөжөөр илэрхийлдэг. ХМУ-ын загварт эрсдэлгүй өгөөжийг 5 эсхүл 10 эсхүл 20 жилийн хугацаатай бондын өгөөжөөр илэрхийлэх нь түгээмэл байдаг хэдий ч одоогоор зах зээл дээр Монгол улсын Засгийн газрын төгрөгөөр гаргасан урт хугацаат бонд байхгүй байна.

- Тиймээс, бид олон улсын зах зээл дээр арилжаалагдаж буй Монгол улсын Засгийн газрын ам. долларын 10 жилийн хугацаатай ганц бондыг сонгон авч тооцоололдоо ашигласан бөгөөд Фишерийн тэгшитгэлийг ашиглан төгрөгийн эрсдэлгүй хүүг тооцоолсон:

$$R_f = i + P_M - P_{US}$$

Энд:

i	=	*"Century бонд" (2031)-ын хугацааны эцэс хүртэлх өгөөж;*
P_M	=	*Монгол улсын инфляцын дундаж хүлээлт;*
P_{US}	=	*АНУ-ын инфляцын дундаж хүлээлт.*

- Century бонд нь Монгол улсын Засгийн газраас олон улсын зах зээл дээр гаргасан, 2031 онд хугацаа нь дуусах бонд юм. 2022 оны 6-р сарын 30-ны байдлаар дуусгавар хугацаа хүртэлх хүлээгдэж буй жилийн дундаж өгөөж (yield-to-maturity) нь 8% байна.

- Инфляцын хүлээлтийн хувьд ОУВС-гийн 2022-2027 онуудын Монгол болон АНУ-ын дундаж инфляцын түвшний төсөөллөөс эцсийн жилийн төсөөлөл болох харгалзан 6.5% ба 2.0%-ийг сонгосон.

Хүснэгт 29. Эрсдэлгүй хүүний тооцоолол

Эрсдэлгүй хүүний тооцоолол	*%*	*Эх сурвалж*
Засгийн газрын 2031 онд дуусгавар болох гадаад бондын өгөөж (ам.доллар, 10 жил)	8.0%	Bloomberg
Монгол улсын инфляцын төсөөлөл	6.50%	ОУВС 2027 оны төсөөлөл
АНУ-ын инфляцын төсөөлөл	2.00%	ОУВС 2027 оны төсөөлөл
Төгрөгийн эрсдэлгүй хүүний түвшин	**12.5%**	*Энэ нь бодлогын хүү болон урт хугацаатай төгрөгийн хадгаламжийн хүүнээс бага байх нь зохистой.*

Эх сурвалж: Bloomberg, ОУВС, БДО Монгол шинжилгээ

- Бид дээрх тооцоог Монголын арилжааны банкнууд дах төгрөгийн урт хугацаат хадгаламжийн жинлэсэн дундаж хүүг ашиглан шалгасан. 20 сая төгрөгөөс доош үлдэгдэлтэй бүх хадгаламжийн дансыг Хадгаламжийн даатгалын корпорацаас даатгадаг тул дийлэнх хугацаатай хадгаламжийн данс бодит байдал дээр эрсдэлгүй гэж хэлж болно.

Хүснэгт 30. Арилжааны банкнуудын хадгаламжийн жинлэсэн дундаж хүү

	Огноо	*Жинлэсэн дундаж хүү*
36 сараас дээш хугацаатай шинэ хадгаламжийн данс	2022 оны 6 сард нээгдсэн	10.5%
36 сараас дээш хугацаатай шинэ хадгаламжийн данс	2022 оны 9-р сард нээгдсэн	11.1%

Эх сурвалж: МонголБанк

График 17. Монгол улсын B3 зээлжих зэрэглэлд суурилсан эрсдэлгүй хүүний түвшин



Эх сурвалж: Valutico

- Бид өөрсдийн эрсдэлгүй хүүгийн тооцооллыг баталгаажуулах зорилгоор Valutico-ийн улсын зээлжих зэрэглэлд суурилсан Монгол улсын 2022 оны 6 сарын 30-наарх судалгаагаар Монгол улсын эрсдэлгүй хүүний түвшин 11.6% байгааг шинжилсэн.

- ***График 17-д харуулсан 11.6%-ийн эрсдэлгүй хүүний түвшин болон Хүснэгт 30-д харуулсанчлан 2022 оны 6 дугаар сард нээгдсэн, 36 сараас дээш хугацаатай төгрөгийн шинэ хадгаламжийн дансны жилийн жинлэсэн дундаж хүү 11.1% байсан болон Монгол банкнаас 2022 оны 9 сарын 20-ны өдөр зарласан бодлогын хүүний түвшин 12% байгаа зэрэг нь Хүснэгт 29-ын тооцооллыг дэмжиж байна.***

Бета (β)

- Бета нь компанийн хувьцаанд агуулагдаж буй системийн шинжтэй эрсдэлийн хэмжүүр бөгөөд түүнийг тооцохдоо тухайн хувьцааны өгөөж болон хувьцааны индексээр хэмжсэн зах зээлийн өгөөжийн хамаарлыг ашиглан тооцдог.
- Хувьцаа нь бирж дээр арилжаалагддаг компанийн өмчийн (хөшүүрэгтэй) бета (levered beta)-г дараах томьёогоор тооцоолдог:

$$\beta_i = \frac{\sigma_{im}}{\sigma_m^2}$$

Энд:

β_i	=	*i компанийн хөшүүрэгтэй бета;*
σ_{im}	=	*i компанийн хувьцааны ханш болон зах зээлийн индексийн ковариац;*
σ_m^2	=	*Зах зээлийн индексийн дисперс.*

- Дээрх томьёог ашиглан тооцсон жишиг компаниудын бета нь тухайн компани түс бүрийн капиталын бүтэц (хөшүүрэг)-ийг агуулсан байгаа тул бид дараах томьёог ашиглан хөшүүргийн нөлөөг арилгасан.
- Хөрөнгийн (хөшүүрэггүй) бета (unlevered beta)-г тооцох томьёо:

$$\beta_u = \frac{\beta_l}{\left[1 + \left(\frac{Debt}{Equity}\right) \cdot (1 - Tax)\right]}$$

Энд:

β_u	=	*Хөшүүрэггүй бета (хөрөнгийн бета);*
β_l	=	*Хөшүүрэгтэй бета (өмчийн бета);*
$Debt/Equity$	=	*Өр /Өмч харьцаа (Debt/Equity ratio);*
Tax	=	*Татварын хувь (Effective tax rate).*

- Бид сонгосон компани түс бүрийн хөшүүргийн харьцаа болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээг ашиглан хөшүүрэггүй бета-г тооцоолсон. Сонголтоос бета-гүй эсхүл сөрөг бета-тай тохиолдлыг хассан. Дараа нь бид сонгосон зах зээлийн хөшүүрэггүй бета-ны медианаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хөшүүрэггүй бетаг тооцсон.
- Хүснэгт 28-д сонгосон ижил төстэй компаниудын жагсаалтыг холбогдох статистикийн хамт харуулсан. Бид компани бүрийн хөшүүрэггүй бета болон тэдгээрийн медианыг тооцоолсон бөгөөд үүнийг үйлчлүүлэгчийн хувьд хөшүүрэггүй бета болгон ашигласан:

Хүснэгт 31. Жишиг компаниудын хөшүүрэггүй бета

#	Жишиг компаниуд	Үр ашигт татварын хувь	Өр/өмч харьцаа	Бета (2 жил)	Хөшүүрэггүй бета
1	АПУ ХК(APU)	21.0%	0.10	0.686	0.6358
2	Махимпекс ХК(MMX)	11.0%	0.00	0.5537	0.5537
3	Монос хүнс ХК (MFC)	13.0%	0.23	0.4397	0.3665
4	Сүү ХК (SUU)	0.00%	1.08	0.5952	0.2861
5	Талхчихэр ХК (TCK)	11.0%	0.09	0.4757	0.4402
6	Түмэншувуут ХК(TUM)	13.0%	0.24	0.7247	0.5980
	Медиан буюу голч үтга				**0.4969**

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

- Хөрөнгийн бета нь тухайн хөрөнгө оруулалт бүхэлдээ хувьцаагаар санхүүжиж байгаа нөхцөлд шаардлагатай өгөөжийн хэмжээг тусгах зорилгоор капиталын бүтцээс өрийн нөлөөг хассан бета юм. Тиймээс бид сонгон авсан капиталын бүтцээр бета-г дахин өргөтгөж, хөшүүрэгдсэн буюу өмчийн бета-г тооцоолох шаардлагатай.
- Ингэж тооцоолсон бета нь үнэлгээ хийж буй компанийн санхүүгийн хөшүүргийн түвшинг тусгайлан тохируулсан зах зээлийн суурь бета болдог. Бета-г дахин өргөтгөх томьёо дараах байдалтай байна:

$$\beta_l = \beta_u \cdot \left[1 + \left(\frac{Debt}{Equity}\right) \cdot (1 - Tax)\right]$$

Энд:

β_l	=	*Дахин хөшүүрэгдсэн бета (өмчийн бета);*
β_u	=	*Хөшүүрэггүй бета (хөрөнгийн бета);*
$Debt/Equity$	=	*Өр/Өмч харьцаа;*
Tax	=	*Татварын үр ашигт хувь.*

- "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бета-н тооцооллыг доор харуулав:

Хүснэгт 32. Хөшүүрэгдсэн бета-н тооцоолол

Хөшүүрэгдсэн бета	Утга	Эх сурвалж
Хөшүүрэггүй бета	0.5	Хүснэгт 31
Өр/Өмч харьцаа	19.7%	Үнэлгээний өдрийн өгөгдөл
Татварын хувь	18.7%	2022-2027 оны санхүүгийн төсөөллийн дундаж
Хөшүүрэгдсэн бета	**0.58**	

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Өмчийн өртөг (K_e)

- Өмчийн өртгийг Капитал Хөрөнгийн Үнэлгээний өргөтгөсөн загварыг ашиглан тооцсон:

$$K_e = R_f + \beta_l \cdot (R_m - R_f) + CSP$$

Энд:

K_e	=	*Өмчийн өртөг;*
R_f	=	*Эрсдэлгүй хүүний түвшин;*
β_l	=	*Хөшүүрэгдсэн (өмчийн) бета;*
R_m	=	*Зах зээл дэх өмчийн өгөөж;*
$(R_m - R_f)$	=	*Өмчийн эрсдэлийн шагнал;*
CSP	=	*Компанийн тусгайлсан эрсдэлийн шагнал.*

- КХҮЗ загварыг ашиглан тооцоолсон өмчийн өртөг дараах байдалтай байна:

Хүснэгт 33. Өмчийн өртгийн тооцоолол

Өмчийн өртгийн тооцоолол		*Эх сурвалж*
Эрсдэлгүй хүүний түвшин	12.5%	Хүснэгт 29
Хөшүүрэгдсэн бета	0.58	Хүснэгт 32
Зах зээлийн эрсдэлийн шагнал	22.4%	
Эрсдэлгүй хүүний түвшин	-12.5%	
Өмчийн эрсдэлийн шагнал	9.9%	БДО Монгол шинжилгээ (2022/06/30)
Тусгайлсан эрсдэлийн шагнал	2.0%	БДО Монгол шинжилгээ
Өмчийн өртөг	**20.2%**	

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- Нэмэлт эрсдэлийн шагналыг компаниас ирүүлсэн мэдээлэл, хорогдуулах хувь болон үнэлгээний тооцооллын программ хангамжийн үйлчилгээ үзүүлдэг Valutico-ийн аргачлалыг ашиглан тооцоолсон.

- Дээрх тооцооллуудад үндэслэн дүгнэхэд, хувьцаанд хөрөнгө оруулагчид Үнэлгээний өдрийн байдлаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийхийн тулд хамгийн багадаа жилийн 20.2%-ийн өгөөж шаардана гэсэн үг юм.

Өрийн өртөг (K_d)

- Татварын өмнөх өрийн өртгийг арилжааны банкнуудаас олгож буй хөнгөлөлттэй зээлийг багтаасан хувийн секторын төгрөгийн зээлийн жинлэсэн дундаж хүүгийн түвшинд үндэслэсэн. Энэхүү өгөгдөл нь Монголбанкны статистикаар 2022 оны 6-р сарын байдлаар 14.3% байсан. Үүнийг компанийн үр ашигт татварын хувийг ашиглан татварын нөлөөллийг арилган тооцоолоход татварын дараах өрийн өртөг 11.6% байна.

- Өрийн өртгийн тооцоолол дараах байдалтай байна:

Хүснэгт 34. Өрийн өртгийн тооцоолол

Өрийн өртгийн тооцоолол		*Эх сурвалж*
Эрсдэлгүй хүүний түвшин	12.5%	Хүснэгт 29
Зах зээлийн хүүний сприд	1.8%	БДО Монгол шинжилгээ (2022/06/30)
Татварын өмнөх өрийн өртөг	14.3%	Монголбанк
Өсөн нэмэгдэх татварын хувь	18.8%	Газаршим бизнес төлөвлөгөө
Татварын дараах өрийн өртөг	**11.6%**	

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Капиталын жинлэсэн дундаж өртөг (КЖДӨ)

$$\text{КЖДӨ} = \left(\frac{E}{V} \times k_e\right) + \left(\frac{D}{V} \times k_d \times (1 - T)\right)$$

Энд:

КЖДӨ	=	*Капиталын жинлэсэн дундаж өртөг;*
E	=	*Компанийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ*
D	=	*Компанийн өрийн зах зээлийн үнэ цэнэ*
k_e	=	*Өмчийн өртөг;*
k_d	=	*Өрийн өртөг;*
T	=	*Татварын хувь;*

- Бидний тооцоолсон КЖДӨ дараах байдалтай байна:

Хүснэгт 35. Капиталын жинлэсэн дундаж өртгийн тооцоолол

КЖДӨ-ийн тооцоолол		*Эх сурвалж*
Өмчийн өртөг	20.2%	Хүснэгт 33
Өмчийн санхүүжилтийн хувь	80.8%	"Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан
Татварын дараах өрийн өртөг	11.6%	Хүснэгт 34
Өрийн санхүүжилтийн хувь	19.2%	БДО Монгол шинжилгээ
КЖДӨ	**18.6%**	

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

5.3.2 Хяналтгүй хувь оролцооны хямдруулалт

- Хяналтгүй хувь оролцоонд зориулсан хөнгөлөлт нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарна. Үүнд:
  - Бүсад хувьцаа эзэмшигчидтэй харьцуулахад эзэмшиж буй хувьцааны эзэмшлийн хэмжээ: Ерөнхийдөө жижиг хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны хэмжээ их байх тусам хөнгөлөлт бага байна.
  - Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаа: Компанийн дүрмээр жижиг хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангалттай олгодог тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь оролцоонд ногдох хөнгөлөлт бага буюу бараг тэгтэй ойролцоо байж болно.
  - Хувьцаа эзэмшигчдийн гэрээний заалтын нөлөө: Хэрэв хувьцаа эзэмшигчдийн гэрээнд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь оролцооны хөрвөх чадварыг хангах заалт(хувьцааг нь одоо байгаа хувьцаа эзэмшигчдэд худалдах эсхүл компанид буцаан өгөх сонголт гэх мэт) оруулсан бол хөнгөлөлт бага байж болно.
  - Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь оролцоог хамгаалсан заалтыг хуулиар эсхүл дүрмээр хамгаалсан заалтууд: Ийм хамгаалалт бүхий заалт нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрсдэлийг бууруулдаг үчраас хөнгөлөлтийг мөн бууруулна.
  - Компанийн бизнесийг удирдах удирдлагын багт жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг оруулдаг зохицуулалттай тохиолдолд хөнгөлөлтийг бууруулах практик түгээмэл байдаг.
  - Хувьцаа эзэмшлийн асуудлаарх шүүхийн зарга, маргаанд цөөнхийн хөнгөлөлт тооцохгүй. Учир нь ийм тохиолдолд тэгш шударга үнэ цэнийн суурь үйлчлэх үчраас бүх хувьцаа эзэмшигч адил, тэнцүү үнээр хувьцаагаа худалдан борлуулах эрх мэдэлтэй байна гэж үздэг.

- Эдгээр хүчин зүйлсийг харгалздаг ч гэсэн, хувьцааг худалдан авч буй этгээд компанийн хяналтын багцыг авах, эсвэл нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болохын түлд хувьцааны зах зээлийн үнээс дээгүүр үнэ төлөхөд бэлэн байгаа тохиолдолд бизнесийн үнэлгээний үр дүн дээр хяналттай хувь оролцооны шагналыг нэмж өгөхийг шаарддаг практик түгээмэл байдаг. Мөн үүний эсрэгээр, тооцоолсон үнэ цэнэ нь хяналттайн урамшууллыг агуулж байгаа боловч үнэлгээний ажил нь цөөнхийн оролцооны үнэ цэнийг тооцоолох зорилготой байгаа тохиолдолд жижиг хувьцаа эзэмшигчдийн хувь оролцооны хямдруулалтаар тохируулах шаардлагатай байдаг. Зах зээлийн нөхцөл байдал болон ашигласан өгөгдлөөс шалтгаалан хөгжсөн зах зээл дэх хяналтгүй хувь оролцооны хямдруулалт ойролцоогоор 10%-аас 40%-ийн хооронд байдаг байна.[5] Хэрэв борлуулагч тал нь борлуулах чин хүсэл эрмэлзэлтэй бол худалдан авагч тал нь илүү өндөр дүнгээр хөнгөлөлт эдлэхийн төлөө хэлэлцээр хийх магадлалтай. Харин худалдан авагч тал нь худалдан авах чин хүсэл эрмэлзэлтэй бол борлуулагч тал нь бага хөнгөлөлт үзүүлэхийн төлөө хэлэлцээр хийх магадлалтай. Мэдээж, компанид илүү их их хяналт тавих боломжтой хувь оролцоог олж эзэмшихийн түлд талуудын хооронд хэлцэл хийгдэнэ. Иймд хяналттай хувь оролцооны шагнал ба хяналтгүй хувь оролцооны хөнгөлөлт нь хоорондоо урвуу хамааралтай байна.

- Доорх зураг үнэлгээний хяналттай хувь оролцооны шагнал болон хяналтгүй хувь оролцооны хямдруулалтын өөр өөр түвшнүүдийг харуулж байна:



[5] https://fullerllp.com/blog/business-valuation-advice-8-factors-quantifying-minority-discounts/

- Бизнесийн хяналтыг багцыг худалдах, худалдан авах хэлцлийн үед ихэнхдээ хяналтын багцыг авах эрмэлзэл давамгайлдаг учраас хяналттайн нэмэгдлийн судалгаа олдоцтой байдаг. Иймд хяналттайн шагналын өгөгдлөөс хяналтгүйн хөнгөлөлтийг дараах томьёог ашиглан тооцно:

$$DLOC = 1 - (1/(1 + Control\ Premium)$$

- Бид "Газар шим үйлдвэр" ХХК-ийн олон нийтэд санал болгохоор төлөвлөж буй хяналтын эрх мэдэлгүй хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийн шинжилгээнд ашиглах зорилгоор Хяналттай хувь оролцооны нэмэгдлийн сүүлийн үеийн судалгаанд хайлт хийсэн. Бидний хайлтын хамгийн сүүлийн үеийн мэдээлэл нь BVR[6]-ийн 2021 оны нийтлэл байсныг бид энэхүү үнэлгээний шинжилгээнд ашигласан.



Exhibit 2. Differential Between the Two Types of Premiums Paid

	Strategic Buyer		Financial Buyer		Difference	
	Equity Acquisition Premium	Invested Capital Acquisition Premium	Equity Acquisition Premium	Invested Capital Acquisition Premium	Equity Acquisition Premium	Invested Capital Acquisition Premium
Number of Premiums Below 0%	1,836	1,686	437	399		
Number of Premiums Above 0%	9,540	8,965	2,355	2,186		
Number of Premiums at 0%	70	68	26	24		
Total Number of Transactions	11,446	10,719	2,818	2,609		
Low Premium	-99.9%	-99.8%	-99.8%	-99.7%		
High Premium	2846.4%	2846.4%	6900.0%	1775.0%		
Mean Premium	34.6%	24.4%	29.8%	17.7%	4.7%	6.8%
Median Premium	24.0%	16.4%	18.4%	12.1%	5.7%	4.2%

Source: Factset MergerStat/BVR Control Premium Study

Selected Control premium rate:	For Equity Value	For Enterprise Value
Minority	18.4%	12.10%
	15.5%	10.8%

- BVR-ийн судалгаанаас бид Invested Capital Acquisition Premium for Financial Buyer нь 12.1%, Equity Acquisition premium for for Financial Buyer нь 18.4% байгааг "Газар шим үйлдвэр" ХХК-ийн үнэлгээний шинжилгээнд ашиглахаар мэргэжлийн шүүн тунгаалтын үндсэн дээр сонгосон. Эндээс дээрх томьёог ашиглан Invested Capital Acquisition discount for Financial Minority Buyer-ийг тооцсон.

$$DLOC = 1 - \left(\frac{1}{1 + 12.1\%}\right) = 10.8\%$$

$$DLOC = 1 - \left(\frac{1}{1 + 18.4\%}\right) = 15.5\%$$

- Бид өөрсдийн бизнес үнэлгээний шинжилгээнд эхлээд "Газар шим үйлдвэр" ХХК-ийн Байгууллагын хэмжээний үнэ цэн(БУЦ)-ийг тодорхойлоод түүнээс дээрх томьёог ашиглан цөөнхийн буюу жижиг хувьцаа эзэмшигчдэд хамаарах хөнгөлөлтийг хассан.

[6] *Control Premiums: A deep dive into the new data on invested capital premiums.*

6. Өмчийн үнэлгээ

6.1 Орлогын хандлага: Чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох арга

6.1.1 Байгууллагын хэмжээний чөлөөт мөнгөн урсгалыг КЖДӨ-өөр хорогдуулах загвар

КЖДӨ-өөр хорогдуулсан ЧМУ-ын аргын үнэлгээний үр дүн

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь компанийн удирдлагаас бидэнд ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-д суурилсан.
- Бид хорогдуулах хувийг Үнэлгээний өдрөөр тооцоолсон КЖДӨ болох 18.6%-аар сонгосон.
- Бид прогнозын хугацааны жил бүрийн чөлөөт мөнгөн урсгалыг дараах байдлаар тооцсон.

Хүснэгт 36.ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргад ашиглагдсан санхүүгийн төсөөлөл

	2022H2	2023	2024	2025	2026	2027
Борлуулалт	**18,073**	**42,144**	**55,275**	**71,807**	**89,472**	**108,479**
ХТӨА	**3,848**	**8,644**	**12,818**	**17,545**	**22,909**	**27,892**
Орлогын албан татвар	(426)	(1,261)	(2,304)	(3,486)	(4,827)	(6,073)
Татварын дараах үйл ажиллагааны ашиг	**3,422**	**7,383**	**10,513**	**14,059**	**18,082**	**21,819**
+ Элэгдэл, хорогдол	427	957	1,194	1,532	1,883	2,279
- Капитал зарцуулалт	(3,607)	(10,087)	(658)	(658)	(658)	(658)
+/- Цэвэр ажлын капиталын өөрчлөлт	1,018	205	(5,003)	(4,288)	(4,541)	(4,991)
Чөлөөт мөнгөн урсгал	**1,260**	**(1,542)**	**6,046**	**10,644**	**14,767**	**18,449**

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон "Газар шим үйлдвэр" ХХК-ийн удирдлагаас ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-д суурилан тус компанийн дээрх ирээдүйн Чөлөөт мөнгөн урсгалыг тооцоолж, түүнийг КЖДӨ-өөр хорогдуулан тооцох замаар Байгууллагын үнэ цэнэ(БҮЦ)-ийг эхлээд тооцоолсон. Дараа нь түүнээс жижиг хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдэд хамаарах хяналтгүй хөнгөлөлтийг хасаж хяналтгүй хөнгөлөлтийн дараах БҮЦ-ийг тооцоолсон. Тооцоолсон БҮЦ-ээс цэвэр өрийг хасах замаар хяналт тавих эрх мэдэлгүй жижиг хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон.

- 2027 оноос хойших хугацааны хувьд, бизнесийн терминал үнэ цэнэ (terminal value) буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон. Ингэхдээ урт хугацааны өсөлтийг 5%-тай тэнцүү гэж авсан.

Хүснэгт 37. Терминал үнэ цэнийн тооцоолол

сая төгрөг	
Хорогдуулах хувь	18.6%
Урт хугацааны өсөлт	5%
2027 оны ЧМУ	18,449
Терминал үнэ цэнэ (2027 онд)	142,433

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- 2022-2027 оны ЧМУ болон терминал үнэ цэнүүдийн өнөөгийн үнэ цэнийг дараах байдлаар тооцсон:

Хүснэгт 38. Өнөөгийн үнэ цэнийн тооцоолол

	2022H2	2023	2024	2025	2026	2027
Чөлөөт мөнгөн урсгал	**1,260**	**(1,542)**	**6,046**	**10,644**	**14,767**	**18,449**
Терминал үнэ цэнэ						**142,433**
Хорогдуулах үе	0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75
Хорогдуулах фактор	0.958	0.742	0.626	0.527	0.445	0.375
Хорогдуулсан мөнгөн урсгал	**1,208**	**(1,144)**	**3,782**	**5,614**	**6,567**	**6,918**
Хорогдуулсан терминал үнэ цэнэ						**53,410**

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргын үр дүнгээс дүгнэхэд Үнэлгээний өдрөөр, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийт бизнесийн Байгууллагын зах зээлийн үнэ цэнэ **76,356 сая төгрөг** байна.
- Эндээс өмчийн үнэ цэнийг тооцоолсон тооцоолол дараах байдалтай байна:

Хүснэгт 39. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргаар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ

IPO-ийн дараах үнэлгээ	*Үнэлгээний дүгнэлт*	
Байгууллагын үнэ цэнэ/Enterprice Value	*Дээд хүрээ*	*Доод хүрээ*
ЧМУ-ын өнөөгийн үнэ цэнэ	22,946	22,946
Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ	53,410	53,410
Байгууллагын үнэ цэнэ	**76,356**	**76,356**
Цөөнхийн хөнгөлөлт	10.8%	15.5%
Цөөнхөд хамаарах Байгууллагын үнэ цэнэ	**68,114**	**64,960**
Өмчийн үнэ цэнэ/Equity Value		
Нийт өр	-4,534	-4,534
Нийт мөнгө	1,507	1,507
Цэвэр өр	-3,027	-3,027
Том хувьцаа эзэмшигчдэд хамаарах Өмчийн зах зээлийн үнэ цэнэ	**73,328**	**73,328**
ЖХЭ-д хамаарах хөнгөлөлт	8,242	11,396
ЖХЭ-д хамаарах Өмчийн зах зээлийн үнэ цэнэ	**65,087**	**61,933**

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Мэдрэмжийн шинжилгээ

- Инфляцын түвшин өндөр байгаа өнөөгийн эдийн засгийн орчин, Ковид-19 цар тахлыг тэглэх БНХАУ-ын бодлого болон Орос-Украйны дайнаас үүдэлтэй нийлүүлэлтийн саатлын улмаас үүссэн эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилж байгаа нөхцөлийг харгалзан бид үнэлгээний үр дүнг тодорхой интервалтайгаар санал болгох нь зүйтэй гэж үзсэн.

- Зэргэлдээ хүснэгт нь хорогдуулах хувийн болон урт хугацааны тогтмол өсөлтийн хувийн өөрчлөлтөд тооцоолсон үнэ цэнэ хэр мэдрэмжтэй байгааг харуулсан мэдрэмжийн шинжилгээ юм:

Хүснэгт 40. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргаар тооцсон өмчийн зах зээлийн дээд үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ

		Байнгын өсөлтийн хувь ('g')				
		3.0%	4.0%	5.0%	6.0%	7.0%
кждө	16.60%	70,573	75,203	80,632	87,085	94,883
	17.60%	63,926	67,764	72,210	77,423	83,620
	18.60%	58,187	61,401	65,087	69,358	74,365
	19.60%	53,188	55,904	58,992	62,534	66,638
	20.60%	48,802	51,116	53,726	56,694	60,099

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Хүснэгт 41. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргаар тооцсон өмчийн зах зээлийн доод үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ

		Байнгын өсөлтийн хувь ('g')				
		3.0%	4.0%	5.0%	6.0%	7.0%
кждө	16.60%	67,127	71,511	76,651	82,761	90,143
	17.60%	60,834	64,468	68,677	73,613	79,480
	18.60%	55,400	58,443	61,933	65,977	70,718
	19.60%	50,668	53,239	56,162	59,516	63,402
	20.60%	46,514	48,705	51,177	53,987	57,210

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргаар тооцсон "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нэгж хувьцаанд ногдох зах зээлийн тооцоолсон үнэ цэнэ **51.69 төгрөгөөс 54.32 төгрөгийн хооронд** байна.

Хүснэгт 42. ЧМУ-ыг хорогдуулан тооцох аргаар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н дараах)

сая төгрөг	Дээд	Доод
Нийт өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэн	65,087	61,933
Энгийн хувьцааны тоо	1,198,113,207	
Нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг мөнгө)	**54.32**	**51.69**
(Дүйцүүлсэн Үнэ/Ашиг харьцаа =12.3х ба 11.7х)		

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Дээд хязгаар

- Дээрх мэдрэмжийн шинжилгээний хүснэгтээс бид 18.6%-ийн хорогдуулах хувьтай, 5%-ийн урт хугацааны өсөлтийн хувьтай байх үеийн ЧМУ-ыг хорогдуулах аргаар тооцсон үнэлгээний үр дүнгээс байгууллагад хамаарах үнэ цэнэд 10.8%-ийн хяналтгүй хөнгөлөлт тооцсон үр дүнгээр үнэ цэнийн дээд хязгаарыг тогтоохоор шийдсэн. Хүнсний салбар нь өндөр өсөлт үзүүлдэг ч урт хугацааны өсөлт нь улсын эдийн засгийн өсөлтөөс илүүгүй байх үнэлгээний практикийг харгалзан урт хугацааны өсөлтийг хамгийн ихдээ 5%-тай тэнцүү тогтмол өсөлт үзүүлэх үндэслэлтэй гэж үзэж байна.

- Энэ хувилбарын дагуу, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн IPO-ийн дараах байдлаар ЧМУ-ыг хорогдуулах загварыг ашиглан тооцсон хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ **65,087 сая төгрөг**, харин нэгж хувьцааны үнэ цэнэ **54.32 төгрөг** байна.

IPO-ийн дараах нэгж хувьцааны дээд үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ

Хүснэгт 43. ЧМУ-ын аргаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (төгрөг)

Хорогдуулах хүү	Урт хугацааны өсөлт				
	3%	4%	5%	6%	7%
16.60%	58.90	62.77	67.30	72.69	79.19
17.60%	53.36	56.56	60.27	64.62	69.79
18.60%	48.57	51.25	54.32	57.89	62.07
19.60%	44.39	46.66	49.24	52.19	55.62
20.60%	40.73	42.66	44.84	47.32	50.16

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Доод хязгаар

- Бид энэ хувилбарын хүрээнд 18.6%-ийн хорогдуулах хувьтай, 5%-ийн урт хугацааны өсөлтийн хувьтай байх үеийн ЧМУ-ыг хорогдуулах аргаар тооцсон үнэлгээний үр дүнгээс өмчид хамаарах үнэ цэнэд 15.5%-ийн хяналтгүй хөнгөлөлт тооцсон үр дүнгээр үнэ цэнийн доод хязгаарыг тогтоохоор шийдсэн.

- Энэ хувилбарын дагуу, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн IPO-ийн дараах байдлаар ЧМУ-ыг хорогдуулах загварыг ашиглан тооцсон хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ **61,933 сая төгрөг**, харин нэгж хувьцааны үнэ цэнэ **51.69 төгрөг** байна.

IPO-ийн дараах нэгж хувьцааны доод үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ

Хүснэгт 44. ЧМУ-ын аргаар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (төгрөг)

Хорогдуулах хүү	Урт хугацааны өсөлт				
	3%	4%	5%	6%	7%
16.60%	56.03	59.69	63.98	69.08	75.24
17.60%	50.78	53.81	57.32	61.44	66.34
18.60%	46.24	48.78	51.69	55.07	59.02
19.60%	42.29	44.44	46.88	49.67	52.92
20.60%	38.82	40.65	42.71	45.06	47.75

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

6.1.2 Ногдол Ашиг Хорогдуулах загвар

- Компанийн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-д тусгаснаар, тус компани нь олон нийтийн компани болсноор жил бүр цэвэр ашгийн 30%-иас багагүй хувийг ногдол ашигт тараахаар төлөвлөжээ.

- Бид компаниас ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-ийг ашиглан НАХ загвараар компанийн хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнийг Үнэлгээний өдрийн байдлаар тооцоолсон.

- Компани 2020 болон 2021 онуудад ногдол ашиг тараасан ба түүнээс өмнөх жилүүдэд жил бүр тогтмол ногдол ашиг тараасан түүхгүй учраас бид НАХ загварыг үнэлгээний дүгнэлт гаргах арга болгож ашиглаагүй. Харин бид энэ арга болон ЖКАЗ-г ЧМУ-ын аргаар тооцоолж гаргасан үнэлгээний дүгнэлтийг шалгах, баталгаажуулахад ашигласан.

- Ингэхдээ өмчийн үнэ цэнийн доод хязгаарыг баталгаажуулахдаа терминал үнэ цэнийг Гордоны өсөлтийн загвараар тооцоолсон НАХ загварыг, дээд хязгаарыг баталгаажуулахдаа сүүлийн жилийн цэвэр ашгийг жишиг компаниудын Үнэ/Ашиг харьцааны медиан утгыг ашигласан Гарах үржүүлэгчийн аргаар тооцсон

Зах зээлийн үнэ цэнийн дээд хязгаар

- НАХ загвар ашиглан үнэ цэнийн дээд хязгаарыг тогтооход ашигласан аргачлалын томьёог доор харуулав:

$$Equity\ Value = \frac{D_{2022}}{(1+k_e)^{0.25}} + \cdots + \frac{D_{2027}}{(1+k_e)^{5.75}} + \text{ЦА}_{2027} \cdot ExitMultiple$$

Энд:

D_{2022} = *2022 оны сүүлийн хагас жилд өгөх ногдол ашгийн төсөөлөл;*

k_e = *Өмчийн өртөг;*

ЦА_{2027} = *2027 оны төсөөлсөн цэвэр ашиг;*

$Exit\ Multiple$ = *Жишиг компаниудын Үнэ/Ашиг харьцаа.*

- Бид 42-р хуудсанд сонгосон жишиг компаниудын медиан Үнэ/ашиг үржүүлэгчийг 2027 оны өмчийн үнэлгээнд ашигласан.

- Дараах хүснэгтэд Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-д тусгагдсан 2022 оноос 2027 он хүртэлх ногдол ашгийн төсөөллийг харуулав:

Хүснэгт 45. Ногдол ашгийн төсөөлөл

сая төгрөг	Төсөөллийн үе					
	2022	2023	2024	2025	2026	2027
Нийт ногдол ашиг	2,000	1,594	2,102	3,037	4,095	5,297
Терминал цэвэр ашиг						21,385
Жишиг компанийн үржүүлэгчийн медиан						11.86x

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК, БДО Монголын шинжилгээ

- Хорогдуулах хувь нь өмчийн өртөгтэй тэнцүү буюу 20.2% байна. Доорх хүснэгтэд ирээдүйн ногдол ашгуудын өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг харуулав:

Хүснэгт 46. Терминал үнэ цэнийн тооцоолол (НАХ загвар)

сая төгрөг	Үнэ цэнэ
2027 оны төсөвлөсөн цэвэр ашиг	21,385
Тогтмол өсөлтийн хувь	5%
Хорогдуулах хувь	20.2%
Жишиг компаниудын Үнэ/Ашиг үржүүлэгч	11.86x
Терминал үнэ цэнэ (2027): Гарах Үнэ/Ашиг үржүүлэгчээр	**253,627**
Терминал үнэ цэнэ (2027): Гордоны загвараар	**147,629**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК, БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 47. Ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ (Гарах үржүүлэгчийн арга)

сая төгрөг	2022H2	2023	2024	2025	2026	2027
Ногдол ашиг	2,000	1,594	2,102	3,037	4,095	5,297
Хорогдуулах үе	0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75
Хорогдуулах хүчин зүйл	0.955	0.725	0.603	0.501	0.417	0.347
Ногдол ашгийн ӨҮЦ	**1,910**	**1,155**	**1,267**	**1,523**	**1,708**	**1,838**
Терминал үнэ цэнийн ӨҮЦ						**88,011**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК, БДО Монголын шинжилгээ

- Үнэлгээний өдрийн байдлаар, НАХ загвараар тооцоолсон "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн дээд үнэ цэнэ нь **82,264 сая төгрөг** байна. Тооцооллын задаргааг хүснэгт эсс үзнэ үү.

Зах зээлийн үнэ цэнийн доод хязгаар

- НАХ загвар ашиглан үнэ цэнийн доод хязгаарыг тогтооход ашигласан аргачлалын томьёог доор харуулав:

$$Equity\ Value = \frac{D_{2022}}{(1+k_e)^{0.25}} + \cdots + \frac{D_{2027}}{(1+k_e)^{5.75}} + \text{ЦА}_{2027}(1+g)/(k_e - g)$$

Энд:

D_{2022} = *2022 оны сүүлийн хагас жилд өгөх ногдол ашгийн төсөөлөл;*

k_e = *Өмчийн өртөг;*

ЦА_{2027} = *2027 оны төсөөлсөн цэвэр ашиг;*

g = *Жишиг компаниудын Үнэ/Ашиг харьцаа.*

Хүснэгт 48. Ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ (Гордоны загвар)

сая төгрөг	*2022H2*	*2023*	*2024*	*2025*	*2026*	*2027*
Ногдол ашиг	2,000	1,594	2,102	3,037	4,095	5,297
Хорогдуулах үе	0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75
Хорогдуулах хүчин зүйл	0.955	0.725	0.603	0.501	0.417	0.347
Ногдол ашгийн ӨҮЦ	**1,910**	**1,155**	**1,267**	**1,523**	**1,708**	**1,838**
Терминал үнэ цэнийн ӨҮЦ						**51,229**

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 49. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг НАХ загвараар шалгасан үр дүнгийн нэгтгэл

сая төгрөг	*Гордоны загвар*	*Гарах Үнэ/Ашиг үржүүлэгчийн арга*
Хорогдуулсан ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ	9,401	9,401
Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ	51,229	88,011
Үнэлгээний өдрөөрх байгууллагын үнэ цэнэ	**60,629**	**97,412**
БҮЦ эсхүл Өмчийн ЗЗҮЦ-ээс хасаж тооцох жижиг хувьцаа эзэмшигчид хамаарах хөнгөлөлт	10.8%	15.5%
Хөнгөлөлтийн дараах байгууллагын үнэ цэнэ	**54,085**	**82,744**
Цэвэр өр(нийт өр ба мөнгөний зөрүү)	-3,027	-3,027
Хувьцаа эзэмшигчийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ	**50,058**	**79,717**
Нийт зарласан хувьцааны (тоо ширхэг)	1,198,113,207	
Нэгж хувьцаанд ногдох зах зээлийн үнэ цэнэ (төгрөг)	42.62	66.54
2022 оны хүлээгдэж буй ХТЭХӨА	7,088	7,088
Дүйцүүлсэн Үнэ/ХТЭХӨА харьцаа	7.2x	11.2x
2022 оны хүлээгдэж буй ашиг	5,312	5,312
Дүйцүүлсэн Үнэ/Ашиг харьцаа	9.6x	15.0x
2022 оны хүлээгдэж буй Борлуулалт	33,579	33,579
Дүйцүүлсэн Үнэ/Борлуулалт харьцаа	1.5x	2.4x
2022 оны 6 сарын 30-ны өмчийн дансны үнэ	23,559	23,559
Дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа	2.2x	3.4x

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

- ***Чөлөөт мөнгөн урсгалыг хорогдуулан тооцох аргын үр дүнг НАХ загвараар шалгахад, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигчийн өмчийн хяналтгүйн хөнгөлөлт хассан зах зээлийн үнэ цэнэ нь 51,058 сая төгрөгөөс 79,412 сая төгрөгийн хооронд байх үндэслэлтэй байна. Хураангуй үр дүнг Хүснэгт 49-д харуулсан.***

Хүүдас 54 | "Газар шим үйлдвэр" ХХК өмчийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан

Зах зээлийн үнэ цэнийн дээд хязгаарын мэдрэмжийн шинжилгээ

- НАХ загварын үр дүнг ялгаатай хорогдуулах хувь болон гарах үржүүлэгчийн аргаар тооцсон мэдрэмжийн шинжилгээг доор харуулав:

Хүснэгт 50. Гарах үржүүлэгч ашиглан НАХ загвараар тооцсон хувьцааны зах зээлийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н дараах)

Өмчийн өртөг	Гарах Үнэ/Ашиг үржүүлэгч				
	9.86x	10.86x	11.86x	12.86x	13.86x
18.21%	73,887	80,789	87,691	94,594	101,496
19.21%	70,440	77,016	83,592	90,168	96,744
20.21%	67,181	73,449	79,716	85,984	92,252
21.21%	64,098	70,074	76,050	82,026	88,002
22.21%	61,179	66,879	72,580	78,280	83,980

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 51. Гарах Үнэ/ашиг үржүүлэгч ашиглан НАХ загвараар тооцсон нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н дараах)

Өмчийн өртөг	Гарах үржүүлэгч				
	9.86x	10.86x	11.86x	12.86x	13.86x
18.21%	61.67	67.43	73.19	78.95	84.71
19.21%	58.79	64.28	69.77	75.26	80.75
20.21%	56.07	61.30	66.53	71.77	77.00
21.21%	53.50	58.49	63.47	68.46	73.45
22.21%	51.06	55.82	60.58	65.34	70.09

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Зах зээлийн үнэ цэнийн доод хязгаарын мэдрэмжийн шинжилгээ

- НАХ загварын үр дүнг ялгаатай хорогдуулах хувь болон урт хугацааны өсөлтөөр тооцсон мэдрэмжийн шинжилгээг доор харуулав:

Хүснэгт 52. Гордоны загвар ашиглан НАХ загвараар тооцсон хувьцааны зах зээлийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н дараах)

Өмчийн өртөг	Байнгын өсөлтийн хувь ('g')				
	3.0%	4.0%	5.0%	6.0%	7.0%
18.2%	55,199	59,186	63,777	69,120	75,416
19.2%	49,722	53,080	56,911	61,322	66,455
20.2%	44,978	47,830	51,058	54,739	58,979
21.2%	40,840	43,281	46,023	49,126	52,666
22.2%	37,209	39,312	41,660	44,297	47,281

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 53. НАХ загвараар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н дараах)

Өмчийн өртөг	Байнгын өсөлтийн хувь ('g')				
	3.0%	4.0%	5.0%	6.0%	7.0%
18.2%	46.07	49.40	53.23	57.69	62.95
19.2%	41.50	44.30	47.50	51.18	55.47
20.2%	37.54	39.92	42.61	45.69	49.23
21.2%	34.09	36.12	38.41	41.00	43.96
22.2%	31.06	32.81	34.77	36.97	39.46

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Зах зээлийн үнэ цэнийн доод ба дээд хязгаар

- НАХ загварыг ашиглан IPO-н дараах байдлаар тооцсон "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ **51,058 сая төгрөгөөс 79,716 сая төгрөгийн хооронд** байх бөгөөд нэгж хувьцаанд ногдох зах зээлийн үнэ цэнэ **42.61 төгрөгөөс 66.53 төгрөгийн хооронд** байна.

- ***Орлогын хандлагын НАХ загварын үр дүн нь бидний дүгнэлт гаргасан аргын үр дүнг дэмжиж байна.***

6.2 Зах зээлийн хандлага

6.2.1 Жишиг компанийн арга зүй

- ЖКАЗ-г 42-р хуудас болон Хавсралт VII-д тодорхойлсон жишиг компаниудын Үнэ/Борлуулалт, Үнэ/Ашиг, БҮЦ/ХТӨА харьцаанүүдын медиан утгуудыг ашиглан гүйцэтгэсэн. Дараах хүснэгтэд жишиг компаниудын үнэлгээний зарим үзүүлэлтүүдийг харуулав:

Хүснэгт 54. Жишиг компаниудын үзүүлэлтүүд

#	Жишиг компаниуд	Үнэ/Борлуулалт	Үнэ/ашиг	БҮЦ/ХТӨА
1	Монос хүнс ХК	2.3x	21.2x	17.4x
2	Түмэншувуут ХК	2.3x	11.9x	12.3x
3	Талхчихэр ХК	0.4x	6.3x	6.2x
4	Сүү ХК	1.8x	19.0x	16.1x
5	АПУ ХК	2.1x	9.3x	7.7x
	1-р квартил	1.8x	9.3x	7.7x
	Медиан	2.1x	11.9x	12.3x
	3-р квартил	2.3x	19.0x	16.1x

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

- IPO-н дараах байдлаар, жишиг компаниудын Үнэ/Борлуулалт үржүүлэгчийн медианыг ашиглан Үнэлгээний өдрөөр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолоход **59,735 сая төгрөгөөс 76,846 сая төгрөгийн хооронд, "Газар шим үйлдвэр"т тохируулсан үнэ цэнэ нь 68,049 сая төгрөг** байна.

- IPO-н дараах байдлаар, жишиг компаниудын Үнэ/Ашиг үржүүлэгчийн медианыг ашиглан Үнэлгээний өдрөөр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолоход **49,084 сая төгрөгөөс 101,001 сая төгрөгийн хооронд, "Газар шим үйлдвэр"т тохируулсан үнэ цэнэ нь 64,996 сая төгрөг** байна.

- IPO-н дараах байдлаар, жишиг компаниудын БҮЦ/ХТӨА үржүүлэгчийн медианыг ашиглан Үнэлгээний өдрөөр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн бизнест хамаарах байгууллагын үнэ цэнийг тооцоолоход **64,395 сая төгрөгөөс 100,179 сая төгрөгийн хооронд, "Газар шим үйлдвэр"т тохируулсан байгууллагын үнэ цэнэ нь 71,950 сая төгрөг** байна. Үүнээс цэвэр өрийг хасаж, өмчид хамаарах үнэ цэнийг тооцоолоход 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь 61,368 сая төгрөгөөс 97,152 сая төгрөгийн хооронд, "Газар шим үйлдвэр" ХХК-д зориулан тохируулсан 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь **68,922** сая төгрөг байна.

- **Бидний дүгнэлтээр, зах зээлийн хандлагын үнэлгээний үржүүлэгчид суурилсан шинжилгээний үр дүнгээр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 100%-ийн жижиг хувьцаа эзэмшигчдэд хамаарах зах зээлийн үнэ цэнэ нь 68,049 сая төгрөгөөс 73,296 сая төгрөгийн хооронд** байна.

Хүснэгт 55. Зах зээлийн үржүүлэгчид суурилан тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н дараах)

Үндсэн үзүүлэлт	2022ХБГ	Үрж-гч	Өмчийн үнэ цэнэ	Цэвэр өр	БҮЦ
	сая.төг	дахин	сая.төг	сая.төг	сая.төг
Борлуулалт	**33,579**	**2.0x**	**68,049**	**3,027**	**71,077**
ХТӨА	6,273	**11.0x**	68,922	3,027	71,950
Цэвэр Ашиг	5,312	**12.2x**	64,996	3,027	68,023
Үнэлгээний доод утга			**64,996**	**3,027**	**68,023**
Үнэлгээний дээд утга			**68,922**	**3,027**	**71,950**

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- ***IPO-н дараах байдлаар, жишиг компаниудын үржүүлэгч ашиглан Үнэлгээний өдрөөр "Газар шим үйлдвэр" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолоход 64,996 сая төгрөгөөс 68,922 сая төгрөгийн хооронд, үржүүлэгчүүдийн медианд суурилсан шинжилгээгээр 68,049 сая төгрөгийн зах зээлийн үнэ цэнэтэй байна.***

- ***Зах зээлийн хандлагын ЖКАЗ-н үр дүн нь бидний дүгнэлт гаргасан аргын үр дүнг дэмжиж байна.***

6.3 Өртгийн хандлага

6.3.1 Тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн арга

- Бизнесийн үнэ цэнийг өртгийн хандлагаар тодорхойлохын тулд бизнесийн бүх хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох шаардлагатай.

- Бид энэ хандлагын хүрээнд бизнес дэх Үнэлгээний өдрөөрх эргэлтийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нь зах зээлийн үнэ цэнээс материаллаг зөрүүгүй байна гэж үзэж, хараат бус аудитын байгууллагын баталгаажуулсан дансны үнийг зах зээлийн үнэтэй ойролцоо үнэ цэнэ байна гэж авч үзсэн.

- Харин бид бизнесийн өмчлөлийн эргэлтийн бус хөрөнгө болон урт хугацаат зээлийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний арга техник хэрэглэн тооцоолж, дансны үнийг зах зээлийн үнэ цэнэд шилжүүлэх тохируулга хийсэн.

- Зэргэлдээ хүснэгтэд бид өөрсдийн хийсэн үнэлгээний тохируулгыг харуулсан цэвэр өөрийн хөрөнгийн аргын үр дүнг хураангуйлан харуулсан.

- Үнэлгээний өдрөөр, "Газар шим үйлдвэр" ХХК-ийн биет хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн үнэ цэнийн тооцоололд суурилсан шинжилгээгээр одоогийн хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь гүүдвилийн үнэ цэнийг агуулаагүй байдлаар **40,882 сая төгрөгөөс 54,586** сая төгрөгийн зах зээлийн үнэ цэнэтэй байна. ***Тохируулга хийсэн цэвэр хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээний үр дүнгийн дээд утга нь бидний үнэлгээний дүгнэлтийн IPO-ийн өмнөх Өмчийн үнэ цэнийн дүгнэлтийг дэмжиж байна.***

- ***Энэхүү тооцоолол нь оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийгдсэн биет бус хөрөнгө нь компани бүрэн шилжиж ирнэ гэсэн төсөөлөлд суурилсан барааны тэмдгийн хамгийн минимум ба максимум эрхийн шимтгэлийн тооцоололд суурилан тодорхойлох боломжтой биет бус хөрөнгийн үнэлгээг авч үзсэн одоогийн эздийн өмчийн зах зээлийн үнэ цэнийн өртгийн хандлагад суурилсан тооцоолол болно. Энэ үнэ цэнэ дээр олон нийтэд санал болгож, татан төвлөрүүлэх хөрөнгийг нэмсний дараа бусад үнэлгээний аргатай зэрэгцүүлж, зах зээлд санал болгох үнэ цэнийг төлөвлөх боломжтойг анхаарна уу.***

Хүснэгт 56. Тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн аргын үр дүн(IPO-ийн өмнөх)

Балансын зүйл	2022 оны 6 сарын 30-ны байдлаар				
	Дансны үнэ	Үнэлгээний тохируулга	Зах зээлийн үнэ цэнэ		
			Доод	Сүүрь	Дээд
	сая.төг	сая.төг	сая.төг	сая.төг	сая.төг
Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	1,507		1,507	1,507	1,507
Дансны авлага	3,776		3,776	3,776	3,776
Татвар, НДШ – ийн авлага	115		115	115	115
Бусад авлага	3,595		3,595	3,595	3,595
Бараа материал	9,282		9,282	9,282	9,282
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,626		3,626	3,626	3,626
Нийт эргэлтийн хөрөнгө	**21,901**	**0**	**21,901**	**21,901**	**21,901**
Эргэлтийн бус хөрөнгө					
Үндсэн хөрөнгө	7,602	14,494	22,095	22,095	22,095
Биет бус хөрөнгө	8	5,873	5,881	11,754	19,584
Нийт эргэлтийн бус хөрөнгө	**7,610**	**20,367**	**27,976**	**33,849**	**41,680**
Нийт хөрөнгө	**29,511**	**20,367**	**49,878**	**55,751**	**63,581**
Хасах нь:					
Эргэлтийн өр төлбөр	1,418	3,300	4,718	4,718	4,718
Нийт оруулсан капитал	**28,093**	**17,067**	**45,160**	**51,033**	**58,863**
Хасах нь:					
Өрийн капитал	4,534	(257)	4,277	4,277	4,277
Тэнцэх нь:					
Одоогийн хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн капитал	**23,559**	**17,324**	**40,882**	**46,755**	**54,586**

Эх сурвалж: "Газар шим үйлдвэр" ХХК-ийн өгөгдөл, БДО Монгол шинжилгээ

6.4 Өмчийн үнэлгээний үр дүн

- Өмнөх хэсгүүдэд бид "Газар шим үйлдвэр" ХХК-ийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнийг хэд хэдэн үнэлгээний аргачлалыг ашиглан тооцоолсон. Эдгээрийн үр дүн нь IPO-аар босгох санхүүжилтийг багтаасан санхүүгийн төлөвлөгөөнд суурилсан болно.

6.4.1 IPO-н дараах байдлаарх үнэлгээний тооцооллын үр дүн

- Үнэлгээний аргачлалуудыг ашиглан тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнийг хураангуйлан доорх графикт харуулав:

График 18. IPO-н дараах байдлаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг)



Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- Эдгээр үр дүнгүүд нь IPO-н явцад "Газар шим үйлдвэр" ХХК-ийн татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг багтаасан үнэлгээний үр дүн болно. Өөрөөр хэлбэл, тус компани Дүнд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2022-2027)-дөө олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгө оруулалтыг багтаасан бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтыг авснаар үйлдвэрлэл, борлуулалтаа нэмэгдүүлнэ гэсэн төсөөлөлд суурилсан тооцоолол юм.

7. Хавсралт

Хавсралт I. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл 60
Хавсралт II. Мэдээллийн эх сурвалж 61
Хавсралт III. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл 62
Хавсралт IV. Үнэлгээний баг 63
Хавсралт V. Лиценз болон мэргэжлийн даатгал 65
Хавсралт VI. "Газар шим үйлдвэр" ХХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц ... 68
Хавсралт VII. Жишиг компаниудын мэдээлэл, гол үзүүлэлтүүд 69
Хавсралт VIII. Орлогын хандлагын Тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга (дэмжих арга) 70
Хавсралт IX. Зах зээлийн хандлага (дэмжих арга) 72
Хавсралт X. Үндсэн хөрөнгө 74
Хавсралт XI. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үр дүн 75
Хавсралт XII. "Газар шим үйлдвэр" ХХК-д шилжиж ирэх барааны тэмдгийн үнэ цэнэ . 76

Хавсралт I. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл

Энэхүү тайланд багтсан үнэ цэнийн дүгнэлттэй холбогдох хязгаарлах нөхцөлийг доор хураангуйлан орууллаа.

- Энэхүү үнэлгээний тайлан нь бусад үнэлгээ эсвэл судалгаатай хамт хэрэглэгдэхгүй. Үнэлгээний дүгнэлт, тайланд багтсан судалгаа, гүйцэтгэсэн горимууд нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд эдгээрийг тусад нь салгаж хэрэглэхгүй.

- Өртгийн хандлагын тохируулга хийсэн цэвэр өөрийн хөрөнгийн аргаар хийсэн үнэлгээний дүгнэлт нь аливаа биет бус хөрөнгийн үнэ цэнийг агуулаагүй бөгөөд компанийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг төлөөлөхгүй.

- Үнэлгээг зөвхөн тайланд заасан зорилго, зориулалтаар, зориулагдсан хэрэглэгчдэд зориулж бэлтгэсэн. БДО Монгол-оос бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд тайланг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хувилах, энд дурдсан мэдээлэл, тоо, дүнг өөр зорилгоор гуравдагч этгээд ашиглахыг хориглоно.

- БДО Монгол-оос өөр байгууллага, хувь хүн тайлангийн ямар нэг хэсэгт зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно. Ийм төрлийн өөрчлөлт орсон тохиолдолд БДО Монгол ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

- Гэрээт ажилтай холбоотой ажлын баримтыг бид хадгалж үлддэг бөгөөд үнэлгээний дүгнэлтэд тайлбар авах шаардлага гарсан тохиолдолд ажлын баримттай танилцаж болно. Гэхдээ энэ үйлчилгээ үнэлгээний гэрээт ажлын захидалд тусгайлан заагаагүй тохиолдолд нэмэлт төлбөртэй байна.

- Энэхүү тайланг БДО Монгол-оос бичгээр зөвшөөрөл авалгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зар сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд түгээх, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо эсвэл Засгийн Газрын бусад байгууллагад санал өгөхөөс бусад тохиолдолд хувийн болон олон нийтэд мэдээлэл өгөхдөө иш татах зэргээр нийтэд дэлгэх, түгээхийг хориглоно.

- Үнэлгээний өдрөөс хойш гарсан дүгнэлтэд нөлөөлж болох аливаа үйл явдал, нөхцөл байдалд бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.

- Энэхүү үнэлгээнд ашигласан зарим таамаглал эсвэл төсөөлөл нь хэрэгжихгүй байж болох ба урьдчилан төсөөлөөгүй үйл явдал үүсэж болзошгүй. Үүнд: эдийн засгийн томоохон өөрчлөлт; зах зээлийн томоохон өөрчлөлт; татвар ба бусад хууль зүйн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд багтана. Тиймээс прогнозын хугацааны бодит үр дүн нь удирдлагын шаардлагаас өөр байх магадлалтай. Энэхүү хэлбэлзэл нь материаллаг байж болох ба үнэлгээний тайланд багтсан үнийн дүнд нөлөөлж болзошгүй.

- Ирээдүйн үйл явдалтай холбоотой төсөв/урьдчилсан таамаглал/прогноз зэрэг нь төлөвлөсөн хугацаанд хүчинтэй хэвээр байна гэсэн төсөөлөлд суурилсан боловч энэ нь биелэхгүй байж болно. Ийм учраас төсөвлөсөн/урьдчилсан төсөөлөл нь бодит дүнтэй хэр ойрхон буух тал дээр бид ямар нэгэн дүгнэлт гаргаагүй болно.

- Удирдлагаас болон түүнээс эрх олгогдсон төлөөллөөс бидэнд өгсөн мэдээллийн үнэн зөв байдал эсвэл иж бүрэн байдалд бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.

- Энэхүү ажлыг хийхтэй холбоотой гэрээгээр урьдчилан тохироогүй эсвэл үйлчлүүлэгчийн зүгээс хүсэлт тавьж, нэмэлт төлбөр санал болгож, урьдчилсан тохиролцоо хийгээгүй л бол бид үнэлсэн суурь хувьцаатай холбоотой ямар нэгэн гэрчийн мэдүүлэг өгөх, шүүх хуралд оролцох, захиргааны үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээхгүй.

- Энэхүү тайланг зөвхөн тайланд дурдсан зориулалтаар хэрэглэх бөгөөд тайлан нь иж бүрнээрээ байхдаа хүчинтэй байна. Тайланд эцсийн байдлаар оруулсан тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ нь зөвхөн Үнэлгээний өдрөөр хүчинтэй байна.

- Үйлчлүүлэгчийн төлөөлөгчийн бидэнд өгсөн нягтлан бодох бүртгэлийн болон хууль эрх зүйн мэдээллийн үнэн зөв байдалтай холбоотой санал дүгнэлтийг БДО Монгол-оос гаргаагүй бөгөөд бид хөрөнгийн эзэмшлийн эрхэд ямар нэгэн дью дилижинсийн үйлчилгээ үзүүлээгүй болно.

- Зөвхөн тайланд багтсан төсөөлөл ба хязгаарлах нөхцөлүүдээр БДО Монгол-ын гүйцэтгэсэн шинжилгээ болон дүгнэлт хязгаарлагдана.

- Бид үйлчлүүлэгчийн өгсөн мэдээллийн иж бүрэн байдал ба үнэн зөв байдалтай холбоотой ямар нэгэн өр төлбөр эсвэл үүрэг хариуцлага хүлээхгүй

Хавсралт II. Мэдээллийн эх сурвалж

- Энэхүү тайланг бэлтгэхэд ашиглагдсан мэдээллийн үндсэн эх сурвалжид дараах зүйлс хамаарна:
  - 2017-2021 онуудын 12 сарын 31 болон 2022 оны 6 сарын 30-наарх СТОУС-ын дагуу бэлтгэгдсэн, аудитлагдсан түүхэн санхүүгийн тайлан, тэдгээртэй холбогдох тодруулгууд;
  - Компанийн үлсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм болон бусад холбогдох эрх зүйн баримт бичиг;
  - "Газар шим үйлдвэр" ХХК-ийн дунд хугацаа(2022-2027)-ны санхүүгийн төсөөлөл;
  - Үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрх газрын кадастрын зураглал, зээлийн гэрээ
  - Үйлчлүүлэгчээс бидэнд ирүүлсэн бусад мэдээлэл ба баримт бичиг.

- Бидний ашигласан бусад хөндлөнгийн мэдээллийн эх сурвалжид:
  - БДО Монгол-ын бэлтгэсэн хүнсний салбарын судалгааны тайлан;
  - Үндэсний Статистикийн Хорооны нийтлэл 2020-2022;
  - МХБ-ийн цахим хуудас;
  - БДО Монгол-ын IPO өгөгдлийн сан;
  - Bloomberg Market Data жишиг компанийн мэдээллийн сан;
  - S&P Capital IQ, PitchBook Data арилжааны өгөгдлийн сан, жишиг компаниудын үнэлгээний параметрүүд;
  - Pratt's Stats арилжааны өгөгдлийн сан, жишиг компанийн мэдээллийн сан;
  - Проф. Дамодараны веб хуудас: https://pages.stern.nyu.edu/~adamodar/;
  - АХБ, ОУВС, Монголбанк, СЗХ, ҮСГ-аас хэвлэн нийтэлдэг мэдээллүүд.

- Бидний судалсан бусад хууль эрх зүйн бичиг баримтууд:
  - Хөрөнгийн үнэлгээний тухай хууль;
  - Компанийн тухай хууль;
  - Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль;
  - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
  - Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол, журмууд.

- Үнэлгээ нь үнэлгээний өдрийн байдлаар хүчин төгөлдөр байгаа мэдээлэлд үндэслэн бэлтгэгдсэн. Бид хөндлөнгийн эх сурвалжаас авсан мэдээллээс бусад энэ тайланд багтсан эсвэл бидэнд ирүүлсэн аливаа мэдээлэл, мэдээллийн эх сурвалжид хариуцлага хүлээхгүй.

Хүүдас 61 | "Газар шим үйлдвэр" ХХК өмчийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан

Хавсралт III. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл

Бид дараах зүйлсийг баталж байна:

- Энэхүү тайланд багтсан мэдэгдлүүд нь үнэн зөв бөгөөд алдаагүй;
- БДО Аудит ХХК-д үйлчлүүлэгч, үйлчлүүлэгчийн хөрөнгө эсвэл холбоо хамааралтай этгээдүүдтэй холбоотой ямар нэгэн өнөөгийн эсвэл ирээдүйн хувь оролцоо, ялгаварлах үзэл байхгүй болно;
- Бидний шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа авч ашигласан суурь мэдээллүүд үнэн зөв ба алдаагүй болно. Энэхүү тайланд багтсан мэдээлэл, тооцоолол, дүгнэлт буюу үнэ цэнийн талаарх дүгнэлт нь үнэн зөв, алдаагүй бөгөөд найдвартай эх үүсвэрээс авсан мэдээлэлд суурилсан. Гэсэн хэдий ч эдгээр зүйлсийн үнэн зөв байдлын талаар өндөр түвшинд баталгаа гаргахгүй;
- Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, дэвшүүлсэн таамаглал, төсөөллүүд нь ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодитой тооцоолсон гэж үзэж байна;
- Тайлагнасан шинжилгээ, дүгнэлт нь тайлагнасан төсөөлөл ба хязгаарлах нөхцөлөөр л хязгаарлагдсан бөгөөд эдгээр нь бидний хувийн бөгөөд тусгайлан ялгаварлан авч үзээгүйгээр гаргасан мэргэжлийн шинжилгээ, шүүн тунгаалт, дүгнэлт болно;
- БДО Аудит ХХК болон бидний зүгээс үнэлэгдсэн өмчид ямар нэгэн алс хэтийн хувийн ашиг сонирхол, хувь оролцоо байхгүй бөгөөд оролцсон талуудтай ямар нэгэн хувийн ашиг сонирхол байхгүй болно;
- Үнэлгээний объект буюу үнэлэгдэж буй бизнес болон хөрөнгө нь энэ гэрээт ажилд оролцсон этгээдүүдтэй ямар нэгэн холбоогүй болно;
- Үнэлгээчид болон БДО Монгол нь "Газар шим үйлдвэр" ХХК, түүний хамаарал бүхий талуудтай ашиг сонирхлын холбоогүй;
- Энэ гэрээт ажилд оролцсон манай баг урьдчилан тодорхойлсон дүнг гаргах зорилгоор ажиллаагүй болохыг баталж байна;
- Энэ гэрээт ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой бидний ажлын хөлс нь урьдчилан тодорхойлсон дүнг боловсруулж тайлагнах эсвэл үйлчлүүлэгчийн хүслийг биелүүлэх, болзолт үр дүн гаргах зэргээс хамааралгүй болно;
- Бидний хийсэн шинжилгээ, мэргэжлийн шүүн тунгаалт, дүгнэлт нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол улсын хууль, Үнэлгээний олон улсын стандарт, Үнэлгээчдийн ёс зүйн дүрмийн шаардлагад нийцэж байгаа болно;
- Энэхүү баталгааг энд гарын үсэг зурсан Тусгай зөвшөөрөл эзэмшигч үнэлгээчид болон БДО Аудит ХХК-ийн эрх бүхий удирдлагууд гаргаж байгаа бөгөөд энэхүү ажилд оролцсон бусад мэргэжилтнүүдэд хамаарахгүй.

Үнэлгээний тайланг хариуцсан үнэлгээчид:

Г.Баянмөнх, Тэргүүлэх зэрэгтэй үнэлгээчин

Д.Алтансүх, Гүйцэтгэх захирал, CGMA

Д.Баярсайхан, Мэргэшсэн үнэлгээчин, CFA

Үнэлгээний тайланг нягтлан шалгасан:

Б.Одгэрэл, Мэргэшсэн үнэлгээчин



Г. Баянмөнх

Үнэлгээний партнер
БДО Монгол
Холбоо барих:
+976 9111 4040
+976 7740 4040
bayanmunkh@bdo.mn

Баянмөнх нь Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн татварын зөвлөх, мэргэшсэн үнэлгээчин бөгөөд БДО Монголын арилжааны үйлчилгээний нэгжийг удирддаг. Тэрээр бизнес өмчийн үнэлгээ, санхүүгийн дью дилижинс, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн 25 жилийн туршлагатай. Баянмөнх нь уул уурхай, хөдөө аж ахуй, эм үйлдвэрлэл, үл хөдлөх, төмөр зам, банк, барилга, хөнгөн болон хүнд үйлдвэр, даатгал, харилцаа холбоо зэрэг олон төрлийн салбарын үйлчлүүлэгчдэд зөвлөгөө өгч байсан. 2018 онд тэрээр Мандал Даатгал ХХК, Ард Даатгал ХХК-ийг багтаасан нийт таван IPO төсөл болон 2021 онд БогдБанкны IPO-д оролцсон бөгөөд олон тооны стратегийн хөрөнгө оруулагч татах төсөлд хараат бус үнэлгээчнээр ажилласан.



Д. Баярсайхан, CFA

Үнэлгээний захирал

БДО Монгол

Холбоо барих:

+976 8811 4483
+976 7740 4040
bayarsaikhan@bdo.mn

Баярсайхан нь Итгэмжлэгдсэн Санхүүгийн Шинжээч цолтой бөгөөд БДО Монголын үнэлгээний багийг ахлан ажилладаг. Тэрээр хөрөнгө оруулалтын зөвлөгөө, бизнес өмчийн үнэлгээ, санхүүгийн дью дилижинс зэргээр мэргэшсэн 13 жилийн туршлагатай. Баярсайхан нь Доиче Банк, Олон Улсын Санхүүгийн Корпораци зэрэг байгууллагуудад хөрөнгө оруулалтын чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Монгол болон гадаадын уул уурхай, хөргөн үйлдвэрлэлийн салбарын компаниудын үнэлгээн дээр оролцож ажилласан туршлагатай.



Б.Энх-Оргил

Ахлах шинжээч
БДО Монгол
Холбоо барих:
+976 8013 9559
+976 7740 4040
enkh-orgil@bdo.mn

Энх-Оргил нь 2017 онд БДО-д нэгдсэн бөгөөд одоогоор БДО Монголын арилжааны үйлчилгээний нэгжид шинжээчээр ажиллаж байна. Тэрээр АНУ-ын Колорода Их Сургуулиас санхүү-хөрөнгө оруулалтын чиглэлээр бакалаврын зэрэг болон эдийн засгийн минорын зэргийг авсан бөгөөд стратегийн хөрөнгө оруулалт татах зорилготой үнэлгээний үйлчилгээгээр мэргэшсэн. 2018 онд тэрээр Мандал Даатгал ХХК, Ард Даатгал ХХК-ийн IPO төсөл болон стратегийн хөрөнгө оруулагч татах хэд хэдэн төсөлд шинжээчээр ажилласан. Энх-Оргил нь CFA Level II цол горилогч юм.



Б.Одгэрэл

Мэргэшсэн үнэлгээчин
БДО Монгол
Холбоо барихт:
+976 8803 7830
+976 7740 4040
odgerel@bdo.mn

Одгэрэл нь 2021 онд БДО-д нэгдсэн бөгөөд Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч, мэргэшсэн татварын зөвлөх, мэргэшсэн үнэлгээчин. Одгэрэл нь Монгол Улсын Их Сургуулийг эдийн засагч-нягтлан бодогч мэргэжлээр төгссөн бөгөөд Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Тэрээр санхүүгийн салбарт ажилласан 20 жилийн туршлагатай. 2021 онд АПУ ХК-ийн захиалгаар брэндийн үнэлгээний ажилд үнэлгээчнээр, Богд Банк ХХК-ийн IPO төсөлд оролцсон туршлагатай.



Э.Золбоо
Шинжээч
БДО Монгол
Холбоо барих:
+976 8008 4131
+976 7740 4040
zolboo@bdo.mn

Золбоо нь 2021 онд БДО-д нэгдсэн бөгөөд Мандах бүртгэл дээд сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр төгсөж, бакалаврын зэрэг эзэмшсэн. Тэрээр Тайван улсын "National Chung Cheng University Taiwan" сургууульд олон улсын санхүү болон санхүүгийн менежментийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр 2021 онд АПУ ХК-ийн захиалгаар брэндийн үнэлгээний ажилд туслах үнэлгээчнээр ажилласан туршлагатай.



Ө.Шинэцэцэг
Туслах шинжээч
БДО Монгол
Холбоо барих:
+976 8032 2222
+976 7740 4040
shinetsetseg@bdo.mn

Ө.Шинэцэцэг нь 2022 онд БДО-д нэгдсэн бөгөөд Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодогч мэргэжлээр төгсөж, бакалаврын зэрэг эзэмшсэн. Тэрээр Ханбүргэдэй ХХК, Синчи Ойл ХХК-ийн санхүүгийн тайлангийн аудитын ажилд аудиторын туслахаар ажилласан туршлагатай.

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 13 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 07120001

Иргэний үрлийн овог: Мундгар

Иргэний овог нэр: Гомбо оюстон Баянмөнх

Иргэний үнэмлэхний дугаар: УБ0630617

Иргэний бүртгэлийн дугаар: РП57042814

Үнэлгээчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: УБ 1068695, Нийслэл, БЗД, 12-р хороо, Крастал маун 801-809 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2010/12/20-ны өдрийн 280 тоот тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон зөвөл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Ажахуйн үйлажиглагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд заасnаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно

САНГИЙН САЙД / С.БАЯРЦОГТ /

УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭЧИЙН ГОМБО БАЯНМӨНХ 1200001 2022

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2013. оны 286 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2013. оны 12..-р сарын 20..-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.УЛААН /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2017 оны 7 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2017 оны 1 -р сарын 11 -ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.ЧОЙЖИЛСҮРЭН /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 2019 оны 262 дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 2019 оны 12-р сарын 17..-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Ч.ХҮРЭЛБААТАР /

0000001

УЛААНБААТАР ХОТ ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХХК 1022000716 2577127 НД10583

БҮРТГЭВ 2023-01-19

СЗХ 2023.01.25 БҮРТГЭВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2021.10.25

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар :	чй******15
Нэр :	БАЯРСАЙХАН
Авсан огноо :	2021-09-28
Дуусах огноо :	2024-09-28
Хүчинтэй эсэх :	Хүчинтэй
Тушаалын огноо :	2021-09-28
Тушаалын дугаар :	№ 167
Тусгай зөвшөөрлийн нэр :	ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

/ Тусгай зөвшөөрлийн цахим системээс олгогдов. /

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байнгын шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгуурууд хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу

CFA Institute

The Board of Governors of CFA Institute confers the right to use the

Chartered Financial Analyst (CFA)

designation to

Bayarsaikhan Davaadorj

for fulfilling all the requirements prescribed for use of this designation subject to fulfilling the ongoing obligations of a CFA charterholder.
This charter is issued at Charlottesville, Virginia,
this fifth day of September, 2012.

Charter Number 135240

Alan M Meder
Chair

President

CFA Institute

САНГИЙН ЯАМ

Сангийн сайдын 2010 оны 19 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 17120006

Иргэний үргийн овог: Хасгууд

Иргэний овог,нэр: Бямбажав овогтой Одгэрэл

Иргэний үнэмлэхний дугаар:

Иргэний бүртгэлийн дугаар: ОЭ78033069

Үнэлгэчний гэрчилгээний дугаар:

Иргэний хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 17-р хороо, 4-р хорооллол 73-р байр 61 тоот

Зөвшөөрөл олгосон шийдвэр, огноо: Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 354 дугаар тушаал

Энэхүү зөвшөөрөл нь олгосон эсвэл сунгасан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу энэхүү тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

САНГИЙН САЙД ..... / Ч.ХҮРЭЛБААТАР /

УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙСЭЛЧЛЭН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН ГАЗАР

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20.21 оны 41 дүгээр тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..21оны 03.-р сарын 23ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / Б.ЖАВХЛАН /

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

0000300

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААНЫ СУНГАЛТ

Сангийн сайдын 20..... оны ..... дугаар тушаалаар энэхүү тусгай зөвшөөрлийг 20..... оны .....-р сарын .....-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар сунгав.

САНГИЙН САЙД / /

БҮРТГЭВ
№ 11
2023 .01. 23
он сар өдөр
СЗХ

БҮРТГЭСЭН-03
2023 -01- 19

Хавсралт VI. “Газар шим үйлдвэр” ХХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц

График 18. “Газар шим үйлдвэр” ХХК-ийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: “Газар шим үйлдвэр” ХХК

Хавсралт VII. Жишиг компаниудын мэдээлэл, гол үзүүлэлтүүд

Хүснэгт 57. Жишиг компаниудын мэдээлэл

#	Компани	Танилцуулга
1	АПУ ХК ((МХБ: APU)	АПУ ХК нь 1924 оны 4 сарын 15 нд үүсгэн байгуулагдсан бөгөөд 1992 оны 2 сарын 13 нд Монголын хөрөнгийн зах зээлд IPO гаргаж, олон нийтийн буюу хувьцаат компани болсон. Хувьцааны төрөл нь энгийн бөгөөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. 2016 онд улсад 121,3 тэрбум төгрөгийн татвар төлж үйлдвэрлэл үйл ажиллагаандаа 2000 гаруй, борлуулалтын сүлжээндээ 7000 гаруй хүнийг ажлын байраар ханган хувьцаа эзэмшигчдэдээ 5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тарааснаар 2015 оны топ 100 аж ахуй нэгжийн шилдэг 10-т шалгарсан. АПУ ХК нь АНУ, Канад, БНСУ, Хонг Конг, Япон, ОХУ, БНХАУ зэрэг дэлхийн улс орнуудад бараа бүтээгдэхүүнүүдээ экспортолж байна.
2	Моносхүнс ХК (МХБ:MFC)	Моносхүнс ХК нь 2012 оны 3 сарын 1 нд Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан бөгөөд дэлхийн шилдэг компаниудын хөгжлийн жишгээр 2019 онд монголын хөрөнгийн зах зээлд IPO гаргаж, олон нийтийн буюу хувьцаат компани болсон түүхтэй. Компанийн үндсэн үйл ажиллагаа нь жүүс, ундаа, чихэр, үрэл, цай, зөөлөн капсултай бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон гадаад худалдаа болно. Моносхүнс ХК-ийн бүтээгдэхүүн бүрийн орц найрлага дахь амин дэм, шимт чанар, ашигт байдлын үзүүлэлт нь Эм Судлалын Хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын судалгаа шинжилгээнд тулгуурлаж бүтээгддэг бөгөөд орчин үеийн шинжлэх ухааны шилдэг инновацыг шингээж өгснөөрөө онцлогтой байдаг.
3	Түмэншувуут ХК (МХБ:TUM)	Түмэншувуут ХК нь 2004 онд үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Монгол Улсын дотоодын өндөгний үйлдвэрлэлийн 30 гаруй хувийг бэлтгэн нийлүүлж байна. Шувууны аж ахуй нь хуучнаар Шувуун фабрикт байрлан нийт 18 га газар эзэмшин 13000м2 талбай бүхий үйлдвэрийн барилга байгууламжтай ба нийт 350 000 өндөглөгч тахиатай, нэг эзлэхдээ 80 000 толгой дэгдээхэй бойжуулах, 153 600 ширхэг өндөг дарах хүчин чадал бүхий инкубаторын цехтэй, өдөрт 200 000 ширхэг өндөг үйлдвэрлэн худалдан борлуулдаг. 2019 онд Нээлттэй хувьцаат компани болон зохион байгуулалт хийгдэж бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрийн тоо хэмжээг нэмэгдүүлэн хөдөө аж ахуйн цогц үйлдвэрлэлийг дэлхийн жишигт хүргэхээр зорин ажиллаж байна.
4	Талхчихэр ХК (МХБ:TCK)	Талхчихэр ХК нь 1984 оны 7 сарын 4 нд Талх чихрийн комбинат нэртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлж, 1999 онд 100% хувьчлагдаж, 3000 гаруй хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа Монголын топ 100 аж ахуй нэгжийн нэг бөгөөд АНУ, БНСУ, Итали, Чех, Франц, Герман, Голланд, Испани, Финланд гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа анх удаа нэвтрүүлэн, үйл ажиллагаагаа өргөжүүлсээр байна. 1999 оны 11 сарын 11 нд Монголын хөрөнгийн зах зээлд IPO гаргаж, олон нийтийн буюу хувьцаат компани болсон.
5	Сүү ХК (МХБ:SUU)	Сүү ХК нь 1958 оны 12 сарын 1 нд Сүүний үйлдвэр нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан бөгөөд 1985 онд барилга,, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, шинэ үйлдвэр ашиглалтад орсон. 1992 оны 8 сарын 31 нд Монголын хөрөнгийн зах зээлд IPO гаргаж, олон нийтийн буюу хувьцаат компани болсон. 2017 онд Сүү ХК-ийн хувьцаагаар баталгаажсан, нийт 6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий "Сүү Бонд"-ыг арилжаалж, үйлдвэрлэлийн шинэ төрлийн савлагааны шугам нэвтрүүлэх хөрөнгө оруулалтыг татсан төдийгүй Монголын хөрөнгийн биржийн түүхэнд хамгийн богино хугацаанд, хамгийн өндөр дүнтэй бондыг нээлттэй зах зээл дээрээс амжилттай босгож чадсан.

Эх сурвалж: МХБ

Хавсралт VIII. Орлогын хандлагын Тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга (дэмжих арга)

Хүснэгт 58. Орлогын хандлагын Тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргын тооцоолол

Тесөөлөл	
Хөшүүрэггүй өмчийн өртөг	17.92%
Байнгын өсөлтийн хувь ('g')	5.00%

	2022H1	2022H2	2023	2024	2025	2026	2027	ТҮ
Чөлөөт мөнгөн урсгал	**-1,811**	**1,260**	**-1,542**	**6,046**	**10,644**	**14,767**	**18,449**	**19,371**
Терминал үнэ цэнэ								**149,967**
Хорогдуулах үе		0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75	
Хорогдуулах фактор (16.99%)		0.9596	0.7494	0.6356	0.5390	0.4571	0.3876	
Хорогдуулсан чөлөөт мөнгөн урсгал		**1,210**	**(1,156)**	**3,843**	**5,737**	**6,750**	**7,152**	**58,135**

ХЧМУ-ын өнөөгийн үнэ цэнэ	23,527	52%
Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ	58,135	48%
Байгууллагын хөшүүрэггүй үнэ цэнэ	**81,670**	**100%**

	2022H1	2022H2	2023	2024	2025	2026	2027	ТҮ
Өр		**3,262**	**3,504**	**3,648**	**3,816**	**3,974**	**4,048**	**3,709**
Өр/ХТЭХӨА		0.45x	0.35x	0.25x	0.19x	0.16x	0.13x	0.13x
Жилийн дундаж зээлийн хүүний хувь		11.37%	35.47%	33.56%	21.25%	25.60%	27.07%	28.00%
Хүүний зардал		185	1,200	1,200	793	997	1,086	1,086
Татварын үр ашигт хувь		10.00%	12.91%	17.25%	19.63%	20.89%	21.64%	21.64%
Хүүнд хамаарах татварын хэмнэлт		**19**	**70**	**92**	**108**	**119**	**126**	**126**
Хорогдуулах үе		0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75	
Хорогдуулах фактор		0.9596	0.7494	0.6356	0.5390	0.4571	0.3876	
Хорогдуулсан хүүний татварын хэмнэлт		**17.8**	**52.4**	**58.6**	**58.0**	**54.5**	**48.7**	**377.1**

Хорогдуулсан хүүний татварын хэмнэлтийн өнөөгийн үнэ цэнэ	289.9	43%
Терминал хүүний татварын хэмнэлтийн өнөөгийн үнэ цэнэ	377.1	57%
Татварын хамгаалалтын хэмнэлтийн үнэ цэнэ	**667.0**	**100%**

Хүснэгт 59. Орлогын хандлагын Тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргын үр дүн

	6/30/2022
Байгууллагын хөшүүрэггүй үнэ цэнэ	81,670
Хүүний татварын хэмнэлтийн үнэ цэнэ	667
Байгууллагын үнэ цэнэ	**82,337**
Цөөнхийн хөнгөлөлт	**15.5%**
Цөөнхөд хамаарах Байгууллагын үнэ цэнэ	**70,012**
Цэвэр өр	-3,027
Өмчийн үнэ цэнэ	**66,985**
2022 оны форвард ХТЭХӨА	7,088
Дүйцүүлсэн БҮЦ/ХТЭХӨА буюу forward EV/EBITDA	9.9x
2022 оны форвард ашиг	5,312
Дүйцүүлсэн Үнэ/Ашиг	12.6x
2022 оны форвард Борлуулалт	33,579
Дүйцүүлсэн Үнэ/Борлуулалт	2.0x
2022 оны 6 сарын 30-ны Өмчийн дансны үнэ	23,559
Дүйцүүлсэн Үнэ/Данс	**2.8x**

Хүснэгт 60. Орлогын хандлагын Тохируулсан цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргын үр дүнгийн мэдрэмжийн шинжилгээ

Хорогдуулах хувь	Байгын өсөлтийн хувь ('g')				
	3.0%	4.0%	5.0%	6.0%	7.0%
15.92%	72,635	77,683	83,656	90,834	99,622
16.92%	65,592	69,742	74,588	80,322	87,212
17.92%	59,549	63,000	66,985	71,639	77,145
18.92%	54,315	57,214	60,529	64,357	68,828
19.92%	49,746	52,202	54,987	58,172	61,851

Хавсралт IX. Зах зээлийн хандлага (дэмжих арга)

Хүснэгт 61. Жишиг компаниудын Үнэ/Ашиг харьцааны түүхэн статистик

	2017	2018	2019	2020	2021	2022ХБГ
MFC		39.7x	37.7x	27.1x	22.8x	14.3x
TUM		15.3x	10.0x	8.4x	19.5x	11.0x
TCK	27.2x	10.0x	6.3x	5.5x	5.5x	5.7x
SUU	35.2x	16.9x	12.7x	10.0x	21.6x	
APU	30.2x	13.7x	8.9x	7.2x	12.5x	8.6x
MMX	30.8x	13.4x	12.2x	3.6x	2.6x	20.5x
Дундаж	**30.8x**	**18.2x**	**14.6x**	**10.3x**	**14.1x**	**12.0x**
Медиан	30.5x	14.5x	11.1x	7.8x	16.0x	11.0x
Доод квартил	29.4x	13.5x	9.2x	6.0x	7.2x	8.6x
Дээд квартил	31.9x	16.5x	12.6x	9.6x	21.1x	14.3x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 62. Үнэ/Ашиг үржүүлэгчид суурилсан Өмчийн үнэ цэнийн тооцоолол

	Үнэ/Ашиг	Цэвэр ашгийн маржин	Үнийн тохируулга	Тохируулсан Үнэ/Ашиг	Цэвэр ашгийн маржин
MFC	***22.8x***	10.8%	0.93	21.24x	10.8%
TUM	***19.5x***	19.3%	0.61	11.86x	18.5%
TCK	***6.3x***	6.8%	0.86	5.48x	6.6%
SUU	***21.6x***	9.4%	0.88	19.01x	8.0%
APU	***12.5x***	22.7%	0.74	9.24x	21.8%
GSHM				12.24x	15.8%

	Цэвэр ашиг 2022 оны ХБГ	Тохируулсан Үнэ/Ашиг	Өмчийн зах зээлийн үнэ цэнэ
"Газар шим үйлдвэр" ХХК-ийн өмчийн үнэ цэнэ	**5,312**	**12.24x**	**64,996**

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 63. Жишиг компаниудын Үнэ/Борлуулалт харьцааны түүхэн статистик

	2017	2018	2019	2020	2021	2022ХБГ
MFC	1.0x	4.3x	3.4x	2.5x	2.8x	1.8x
TUM	1.0x	2.6x	1.9x	1.5x	4.1x	2.3x
TCK	1.0x	0.5x	0.5x	0.4x	0.4x	0.4x
SUU	2.2x	1.3x	1.4x	1.3x	2.5x	
APU	3.5x	1.6x	1.5x	1.4x	2.9x	1.9x
MMX	1.1x	0.3x	0.2x	0.2x	0.2x	0.4x
Дундаж	**1.6x**	**1.7x**	**1.5x**	**1.2x**	**2.1x**	**1.4x**
Медиан	1.0x	1.4x	1.5x	1.3x	2.6x	1.8x
Доод квартил	1.0x	0.7x	0.7x	0.6x	0.9x	0.4x
Дээд квартил	1.9x	2.3x	1.8x	1.5x	2.9x	1.9x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 64. Үнэ/Борлуулалт үржүүлэгчид суурилсан Өмчийн үнэ цэнийн тооцоолол

	Үнэ/Ашиг	Эхний өмчийн өгөөж %	Үнийн тохируулга	Тохируулсан Үнэ/Бор-лалт	Цэвэр ашгийн маржин
MFC	***2.5x***	13.6%	0.93	***2.3x***	10.8%
TUM	***3.8x***	23.1%	0.61	***2.3x***	18.5%
TCK	***0.4x***	8.9%	0.86	***0.4x***	6.6%
SUU	***2.0x***	28.5%	0.88	***1.8x***	8.0%
APU	***2.8x***	30.4%	0.74	***2.1x***	21.8%
GSHM		26.2%		2.0x	26.2%

	Цэвэр бор-лт 2022 оны ХБГ	Тохируулсан Үнэ/Бор-лт	Өмчийн зах зээлийн үнэ цэнэ
"Газар шим үйлдвэр" ХХК-ийн өмчийн үнэ цэнэ	**33,579**	**2.0x**	**68,049**

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 65. Жишиг компаниудын БҮЦ/ХТӨА харьцааны түүхэн статистик

	2017	2018	2019	2020	2021	2022ХБГ
MFC	7.3x	35.4x	36.0x	22.1x	18.0x	12.1x
TUM	10.5x	-74.6x	10.3x	9.1x	18.4x	9.0x
TCK	20.2x	7.9x	7.7x	6.1x		5.2x
SUU	21.9x	11.4x	10.2x	7.9x	17.8x	
APU	22.9x	10.1x	7.1x	5.9x	10.1x	7.0x
MMX	27.6x	12.1x	12.1x	2.8x		18.4x
Дундаж	**18.4x**	**0.4x**	**13.9x**	**9.0x**	**16.1x**	**10.4x**
Медиан	21.1x	10.8x	10.3x	7.0x	17.9x	9.0x
Доод квартил	12.9x	8.4x	8.4x	5.9x	15.9x	7.0x
Дээд квартил	22.6x	11.9x	11.7x	8.8x	18.1x	12.1x

Эх сурвалж: МХБ-ийн өгөгдөл, БДО Монголын шинжилгээ

Хүснэгт 66. БҮЦ/ХТӨА үржүүлэгчид суурилсан Өмчийн үнэ цэнийн тооцоолол

	БҮЦ/ХТӨА	ХТӨА-ийн маржин %	Үнийн тохируулга	Тохируулсан БҮЦ/ХТӨА	ХТӨА-ийн маржин %
MFC	***18.0x***	15%	0.93	***16.8x***	15%
TUM	***18.4x***	22%	0.61	***11.2x***	22%
SUU	***17.8x***	14%	0.88	***15.7x***	14%
APU	***10.1x***	29%	0.74	***7.5x***	29%
GSHM		22%		11.5x	22%

	ХТӨА-ийн 2022 оны ХБГ	Тохируулсан Үнэ/Бор-лт	ААН-ийн үнэ цэнэ
"Газар шим үйлдвэр" ХХК-ийн өмчийн үнэ цэнэ	6,273	11.5x	71,950
Хасах нь: Цэвэр өр			-3,027
2022/6/30-наарх өмчийн үнэ цэнэ			**68,922**

Эх сурвалж: БДО Монголын шинжилгээ

Хуудас 73 | "Газар шим үйлдвэр" ХХК өмчийн болон хөрөнгийн үнэлгээний тайлан

Хавсралт Х. Үндсэн хөрөнгө

- Үнэлгээний өдрийн байдлаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн санхүүгийн байдлын тайланд 7,602 сая төгрөгийн дансны үнэтэй үндсэн болон ашиглах эрхтэй хөрөнгө бүртгэгдсэн байсан.

- Үл хөдлөх хөрөнгөөс бусад үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь бүртгээд дараа үед өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмждэг.

- Үндсэн хөрөнгийг элэгдүүлэх ашиглалтын хугацаа нь дараах байдалтай байна:
  - Барилга 25 жил
  - Үйлдвэрийн машин тоног төхөөрөмж 10 жил
  - Компьютер 2 жил
  - Тавилга 10 жил
  - Тээврийн хэрэгсэл 10 жил

- Үнэлгээний өдрийн байдлаар үндсэн хөрөнгийн дансны үнийн задаргаа дараах байдалтай байна:

Хүснэгт 67. Үндсэн хөрөнгө болон Ашиглах эрхтэй хөрөнгийн зах зээлийн тооцоолсон үнэ цэнэ (сая төгрөгөөр)

Үндсэн хөрөнгийн анги	6/30/2022 -ны дансны үнэ	Тохируулга	Тооцоолсон Зах зээлийн үнэ цэнэ	Ашигласан арга, хандлага
Газар эзэмших эрх	15	3,401	3,416	Зах зээлийн хандлага
Барилга, байгууламж	3,318	8,972	12,290	Зах зээлийн хандлага
Машин тоног төхөөрөмж	2,999	2,249	5,249	Зах зээлийн хандлага, Өртгийн хандлага
Тээврийн хэрэгсэл	893		893	Дансны үнэ
Лабораторийн тоног төхөөрөмж	19		19	Дансны үнэ
Компьютер дагалдах хэрэгсэл	6		6	Дансны үнэ
Оффисын тоног төхөөрөмж	116		116	Дансны үнэ
Программ хангамж	6		6	Дансны үнэ
Бусад үндсэн хөрөнгө	195		195	Дансны үнэ
Нийт дүн	**7,568**	**14,622**	**22,190**	

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

Үнэлэгдсэн газар ба үл хөдлөх хөрөнгө, машин тоног төхөөрөмжийн тодорхойлолт

- "Газар шим үйлдвэр" ХХК нь үйлдвэрлэлийн 140 ширхэг тоног төхөөрөмж эзэмшдэг бөгөөд үүнээс 77.85% нь БНХАУ, 7.85% нь ХБНГУ, 10% нь Нидерланд улс, 4.3%-ийг бусад улс орнуудаас худалдан авсан бөгөөд насжилтын хувьд харьцангуй шинэ хөрөнгүүд болно.

- Машин, тоног төхөөрөмжийн үнэлгээнд элэгдэл тооцсон нөхөн орлуулах өртгийн аргыг хэрэглэсэн.

Хавсралт XI. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үр дүн

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

- Үнэлгээний баг нь үнэлгээний өдрийн байдлаар "Газар шим үйлдвэр" ХХК-ийн эзэмшиж буй бүх үл хөдлөх хөрөнгийн талаарх мэдээллийг авч, шинжилсэн.
- Бид тус компанийн үл хөдлөх хөрөнгийн бүлэгт хийсэн дүн шинжилгээнд үндэслэн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн тодорхойлсон.

Зах зээлийн хандлага

- "Газар шим үйлдвэр" ХХК-ийн зах зээлийн үнэ цэнээр хэмжигдсэн үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 68."Газар шим үйлдвэр" ХХК-ийн зах зээлийн үнэ цэнээр үнэлэгдсэн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт (сая төгрөгөөр)

#	Үндсэн хөрөнгийн нэр	Байршил	Эзэмшигч	Зориулалт	Гэрчилгээний дугаар	Хэмжээ м2	Зах зээлийн үнэ цэн
	Үндсэн хөрөнгө – Барилга						
1	Барилга-Контор	БГД, 20-р хороо	"Газар шим үйлдвэр" ХХК	Контор	Y-2205071889	1,003.50	2,545.50
2	Барилга- Үйлдвэрлэл1	БГД,20-р хороо	"Газар шим үйлдвэр" ХХК	Үйлдвэрлэл	Y-2205068596	3,276.00	3,721.50
3	Барилга-Үйлдвэрлэл2	Дархан Уул аймаг, Орхон сум	"Газар шим үйлдвэр" ХХК	Үйлчилгээ	Y-2004000423	129	66.4
4	Барилга-дэлгүүр	БГД, 5-р хороо	"Газар шим үйлдвэр" ХХК	Үйлчилгээ	Y-2205017878	337	146.1
5	Барилга-Агуулах	БГД, 20-р хороо	"Газар шим үйлдвэр" ХХК	Агуулах	Y-2205071770	4,827.20	5,483.50
6	Барилга-гараж	БГД, 20-р хороо	Гэрчилгээгүй	Гараж	-	288	327.2
	Барилгажсан газар эзэмших эрх						
7	Газар-Сэлэнгэ Мандал	Сэлэнгэ аймаг, Мандал сум	"Газар шим үйлдвэр" ХХК	Гэр, орон сууцны хашаа	0000048165	5,738.00	7
8	Газар-Сэлэнгэ Мандал	Сэлэнгэ аймаг, Мандал сум	"Газар шим үйлдвэр" ХХК	Гэр, орон сууцны хашаа	0000111055	3,502.00	4.3
9	Газар-ДарханУул Орхон сум	Дархан Уул аймаг, Орхон сум	"Газар шим үйлдвэр" ХХК	Худалдаа, нийтийн үйлчилгээ	0000131145	1,163.00	311.5
10	Газар-БГД 20-р хороо	БГД,20-р хороо	Эйч Эс Зэт ХХК	Үйлдвэрлэл	000013035	11,782.00	2,212.50
11	Газар-БГД 4- хороо	БГД, 4-р хороо	"Газар шим үйлдвэр" ХХК	Үйлчилгээтэй орон сууц	000023648	714	880.3
	Нийт үл хөдлөх хөрөнгө						**15,705.70**

Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

- "Газар шим үйлдвэр" ХХК-ийн үл хөдлөх хөрөнгийн 4 нь хөдөө орон нутагт худалдаа, нийтийн үйлчилгээ, түүхий эд материал татах, Баянгол дүүрэгт байрлалтай 7 үл хөдлөх хөрөнгө нь үйлдвэрлэл үйлчилгээ, авто зогсоолын зориулалттай болно.

Үнэлгээчдийн дүгнэлт:

- Бид "Газар шим үйлдвэр" ХХК-ийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг ижил төстэй зориулалттай үл хөдлөх хөрөнгийн ойролцоо байршил дах зах зээлийн мэдээлэлд хийсэн шинжилгээгээр цуглуулсан үнийн мэдээлэлд суурилан үнэлгээний Үнэлгээний зах зээлийн хандлагаар тооцоолж, компанийн нягтлан бодох бүртгэлд тусгагдсан дансны үнэтэй харьцуулан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн дансны үнэд зохих тохируулга хийсэн.

Бид газар эзэмших эрх болон үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд ашиглагдсан зах зээлийн өгөгдөл, үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг энд хавсаргаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд бидний үнэлгээний ажлын баримттай танилцах замаар дэлгэрүүлж болно.

Хавсралт XII. “Газар шим үйлдвэр” ХХК-д шилжиж ирэх барааны тэмдгийн үнэ цэнэ

Барааны тэмдэг

- “Газар шим үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрлэн борлуулж буй бүх бараа нь 40-0003579 гэрчилгээний дугаартай, 3819 тоот мэдүүлгийн дугаартай, оюуны өмчийн 29,42 ангиллын “Газар шим” хэмээх барааны тэмдэгтэйгээр хэрэглэгчдэд танигдсан.
- Энэхүү барааны тэмдэгтийг эзэмших эрх нь үнэлгээний өдрийн байдлаар Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 6 дугаар хороолол, бага тойруу гудамж, 23-р байр, 23 тоот хаягт оршин суугч З.Байгалмаагийн нэр дээр бүртгэгдсэн байсан.
- Энэхүү барааны тэмдгийг иргэн З.Байгалмаагаас “Газар шим үйлдвэр” ХХК-д шилжүүлэх “Барааны тэмдэг эзэмших эрх шилжүүлэх гэрээ”-г талууд 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан.
- Эрх шилжүүлэх гэрээний дагуу ““Газар шим үйлдвэр”” ХХК нь эрх эзэмшигчид 3,300 сая төгрөгийг 2022 ба 2023 онд 2 удаагийн тэнцүү дүнгээр төлөх үүрэг хүлээсэн.
- Иймд 2022 оноос хойш хугацаанд компанийн үйлдвэрлэн борлуулах бүх бараа “Газар Шим” барааны тэмдэгтэйгээр хэрэглэгчдэд нийлүүлэгдэнэ.

Патент ашиглах Лицензийн гэрээ

- “Газар шим үйлдвэр” ХХК-ийн үйлдвэрлэн борлуулж буй Артишок ундаа нь 3960 дугаартай “Артишок (Cinara scolymus) агуулсан эрүүл мэндийн ундаа, түүнийг бэлтгэх арга”-ын патентаар эрх нь хамгаалагдсан.
- Энэхүү Патентыг эзэмших эрхийг үнэлгээний өдрийн байдлаар Монгол улсын иргэн Ц.Төгсөө эзэмшиж байсан.
- “Газар шим үйлдвэр” ХХК нь Патент эзэмшигчтэй энэхүү патентыг 2032 оныг дуустал ашиглах Лицензийн гэрээ байгуулсан.
- Лицензийн гэрээний дагуу “Газар шим үйлдвэр” ХХК нь 2032 он хүртэл жил бүр тухайн патенттай бүтээгдэхүүний борлуулалтын орлогын 10%-тай тэнцэх эрхийн шимтгэл төлөх үүрэг хүлээсэн.

Биет бус хөрөнгө ба эрхийн шимтгэлийн төлбөр

- “Газар шим үйлдвэр” ХХК нь 2022-2027 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөлд “Газар шим” Барааны тэмдгийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, 10 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлэхээр санхүүгийн төсөөллөө бэлтгэсэн.
- “Газар шим үйлдвэр” ХХК нь 2022-2027 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний санхүүгийн төсөөлөлд 3960 дугаартай “Артишок (Cinara scolymus) агуулсан эрүүл мэндийн ундаа, түүнийг бэлтгэх арга”-ын патентыг ашигласны төлөө патент эзэмшигчид төлөх патентлагдсан барааны борлуулалтын 10%-тай эрхийн шимтгэлийг үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрч мөнгөн урсгалаа төлөвлөсөн.

Зах зээлийн Эрхийн шимтгэлийн хувь

- Бид биет бус хөрөнгийн үнэлгээнд ашиглах зах зээлийн эрхийн шимтгэлийн хувийг оновчтой сонгохын тулд төлбөртэй эх сурвалжаас хайлт хийсэн.

Хүснэгт 69. Хүнсний салбарын эрхийн шимтгэлийн зах зээлийн хувь

Хүрээ	Эрхийн шимтгэлийн хувь
Максимум	70.00%
Дээд квартил	6.0%
Медиан	3.9%
Дундаж	5.6%
Доод квартил	2.3%
Минимум	0.3%

Эх сурвалж: IPSCIO Reports: Royalty Rate Industry Summary 2021 from the RoyaltySource database.

- Бид олон улсын хэмжээний хүнсний салбарын роялти хувийг цэвэр борлуулалтад суурилан Хүснэгт 69-д үзүүлсэнчлэн лицензийн гэрээгээр ашиглуулж байгааг IPSCIO Reports-оос төлбөртэйгээр худалдан авсан албан ёсны мэдээллийн эх сурвалжаас тодорхойлсон.
- Бид “Газар шим үйлдвэр” ХХК-ийн хамгаалагдсан оюуны өмчийн үнэлгээнд ашиглах Зах зээлийн Роялти хувийг зах зээлийн Роялти хувиас бууруулан сонгож, цэвэр

борлуулалтын дүнгээс гутранги төсөөлөлд 1.5%, суурь төсөөлөлд 3%, өөдрөг төсөөлөлд 5% байхаар сонгож ашиглахаар шийдсэн.

Оюуны өмчийг үнэлэхэд ашигласан үнэлгээний өдөр

- Бид тус компанийн хамгаалагдсан оюуны өмчид хийсэн дүн шинжилгээнд үндэслэн оюуны өмчийн зах зээлийн үнийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн тодорхойлсон.

Биет ба биет бус хөрөнгийн үнэлгээний арга хандлага

- Бид хамгаалагдсан оюуны өмчийн зах зээлийн бодит үнэ цэнийг тооцоолохдоо үнэлгээний тохиромжтой арга хандлагыг сонгон шинжилж, хамгийн тохиромжтой гэж мэргэжлийн түвшинд авч үзсэн аргыг сонгосон.
- Бид биет бус хөрөнгийн үнэлгээнд Орлогын хандлагын Рояалти буюу Эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргыг сонгож, гутранги, суурь, өөдрөг төсөөлөлд суурилан үнэлгээ хийсэн.

Орлогын хандлага: Эрхийн шимтгэлээс чөлөөлөх арга

- Биет бус хөрөнгийг гуравдагч талаас лицензээр авч ашиглахтай харьцуулан үзэхэд уг хөрөнгийг өмчилснөөр хэмнэгдэх болсон эрхийн шимтгэлийн таамагласан төлбөрүүдийн үнэ цэнийг баримжаа болгосноор эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргын дагуу биет бус хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлдог. Эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргыг хэрэглэх гол алхмууд нь:
    - Үнэлж буй биет бус хөрөнгөтэй холбоотой төсөвлөлтийг тэрхүү биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаагаар тооцож боловсруулах.
    - Үнэлж буй биет бус хөрөнгийн хувьд эрхийн шимтгэлийн хувийг тодорхойлох. Эрхийн шимтгэлийн таамагласан хувийг тооцон гаргахын тулд хоёр аргыг ашиглаж болно. Эхний арга нь жиших буюу төсөөтэй ажил гүйлгээний эрхийн шимтгэлийн зах зээлийн хувь хэмжээнд үндэслэдэг.
    - Энэ аргыг хэрэглэх урьдчилсан нөхцөл нь харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр ердийн нөхцөлд лицензээр ашиглуулж болох, жишилт хийх боломжтой биет бус хөрөнгө оршин байх явдал юм. Хоёр дахь арга нь зах зээлд бэлэн байгаа лиценз олгогч уг үнэлж буй биет бус хөрөнгийг ашиглах эрхээ мөн бэлэн байгаа лиценз хүлээн авагчид шилжүүлэх харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр төлөгдөнө гэж таамагласан ашгийн хуваалтад үндэслэдэг.
    - Тухайн биет бус хөрөнгийг өмчилснөөр төлөхгүй, зайлсхийх боломжтой болсон эрхийн шимтгэлийн төлбөрүүдийг тооцоолохын тулд тухайн сонгосон эрхийн шимтгэлийн хувийг уг санхүүгийн төсөөлөлд хэрэглэх.
    - Үнэлж буй хөрөнгийг лицензээр хүлээн авагч нь хариуцах аливаа нэмэлт зардлуудыг тооцоолох.
    - Үнэлж буй биет бус хөрөнгөнд хамаарах тохиромжтой хорогдуулах хувь ба өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох буюу тухайн биет бус хөрөнгийн өмчлөлтэй холбоотой хэмнэлтүүдийг капиталжуулах

"Газар шим үйлдвэр" ХХК-ийн брэндийн оюуны өмчийн хамгаалагдсан эрхийн үнэлгээ

- Газар шим брэндийн биет бус хөрөнгийн үнэ цэнэ нь эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмчийн зах зээлийн үнэ цэнийг төлөөлнө.
- Тодорхойлогдох биет бус хөрөнгө нь брэндийг патентаар хамгаалагдсан үйлдвэрлэх арга болон барааны тэмдгийн хамгаалалтаас бүрдэнэ.
- Бид тодорхойлогдох биет бус хөрөнгийн үнэлгээнд эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргыг ашигласан.
- Эрхийн шимтгэлийн суурь үзүүлэлтийг Цэвэр борлуулалт суурилан шинжилсэн.
- Тодорхойлогдох биет бус хөрөнгийн талаарх дараах төсөөллүүдийг хийсэн: Үүнд:
    - Цэвэр борлуулалт нь Эрхийн шимтгэл тооцох суурь үзүүлэлт байна.
    - Цэвэр борлуулалтад ногдох Зах зээлийн Роялти хувь (2.3%-6%-ийн хооронд байсан) зах зээлийн олонлогийн "Upper quartile" утгаас 1% доогуур буюу 5% байх үндэслэлтэй.
    - Хорогдуулах хувь нь "Газар шим үйлдвэр" ХХК-ийн 2022/06/30-ны өмчийн өртөгт суурилсан шинжилгээгээр 20.2% байх нь үндэслэлтэй гэж дүгнэсэн.
    - Прогнозын төсөөлсөн тодорхой хугацааг Патентын дуусгавар хугацаа (хамгаалалт хийгдсэн өдрөөс хойш 10 жил)-нд тооцоолох нь зохистой гэж дүгнэсэн.
    - Терминал хугацааны тогтмол өсөлтийн хувийг 5% байхаар төсөөлсөн.
- Эцсийн үр дүнг Барааны багц тэмдэгт Хүснэгт 64-д харуулсан судалгаанд суурилан хуваарилсан.

Хүснэгт 70. Эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргын тооцооллын үнэлгээний гутранги төсөөлөлд суурилсан шинжилгээ

Төсөөлөл	6/30/2022
Хорогдуулах хувь	20.2%
Урт хугацааны өсөлтийн хувь	5.0%
Эрхийн шимтгэлийн хувь	1.5%

	2022H1	2022H2	2023	2024	2025	2026	2027
Борлуулалт	14,985	17,551	41,049	54,125	70,600	88,204	107,148
Эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого		263	616	812	1,059	1,323	1,607
Татварын үр ашиг хувь		-10%	-13%	-17%	-20%	-21%	-22%
Хасах нь: татвар		(26)	(79)	(140)	(208)	(276)	(348)
Татварын дараах эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого		237	536	672	851	1,047	1,259
Терминал үнэ цэнэ							8,694
Хорогдуулах үе		0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75
Хорогдуулах фактор		0.9550	0.7246	0.6028	0.5014	0.4171	0.3470
Хорогдуулсан эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого: минимум		**226**	**389**	**405**	**427**	**437**	**437**
Теминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ							**3,017**

	Гордоны загвар	
Хорогдуулсан ЭШЧО-ын өнөөгийн үнэ цэнэ	2,320	43.5%
Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ	3,017	56.5%
Өмчийн үнэ цэнэ	**5,337**	**100.0%**
Татварын хорогдуулгын хэмнэлт	440	
Хамгаалагдсан оюуны өмч	**5,777**	

Хүснэгт 71. Эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргын тооцооллын үнэлгээний суурь төсөөлөлд суурилсан шинжилгээ

Төсөөлөл	6/30/2022
Хорогдуулах хувь	20.2%
Урт хугацааны өсөлтийн хувь	5.0%
Эрхийн шимтгэлийн хувь	3%

	2022H1	2022H2	2023	2024	2025	2026	2027
Борлуулалт	14,985	17,551	41,049	54,125	70,600	88,204	107,148
Эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого		527	1,231	1,624	2,118	2,646	3,214
Татварын үр ашиг хувь		-10%	-13%	-17%	-20%	-21%	-22%
Хасах нь: татвар		(53)	(159)	(280)	(416)	(553)	(696)
Татварын дараах эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого		474	1,072	1,344	1,702	2,093	2,519
Терминал үнэ цэнэ							**17,388**
Хорогдуулах үе		0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75
Хорогдуулах фактор		0.9550	0.7246	0.6028	0.5014	0.4171	0.3470
Хорогдуулсан эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого: минимум		**453**	**777**	**810**	**854**	**873**	**874**
Теминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ							**6,034**

	Гордоны загвар	
Хорогдуулсан ЭШЧО-ын өнөөгийн үнэ цэнэ	4,640	43.5%
Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ	6,034	56.5%
Өмчийн үнэ цэнэ	**10,674**	**100.0%**
Татварын хорогдуулгын хэмнэлт	880	
Хамгаалагдсан оюуны өмч	**11,554**	

Хүснэгт 72. Эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргын тооцооллын үнэлгээний өвдрөг төсөөлөлд суурилсан шинжилгээ

Төсөөлөл	6/30/2022
Хорогдуулах хувь	20.2%
Урт хугацааны өсөлтийн хувь	5.0%
Эрхийн шимтгэлийн хувь	5.0%

	2022H1	2022H2	2023	2024	2025	2026	2027
Борлуулалт	14,985	17,551	41,049	54,125	70,600	88,204	107,148
Эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого	0	878	2,052	2,706	3,530	4,410	5,357
Татварын үр ашиг хувь		-10%	-13%	-17%	-20%	-21%	-22%
Хасах нь: татвар		(88)	(265)	(467)	(693)	(921)	(1,159)
Татварын дараах эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого		790	1,787	2,239	2,837	3,489	4,198
Терминал үнэ цэнэ							28,980
Хорогдуулах үе		0.25	1.75	2.75	3.75	4.75	5.75
Хорогдуулах фактор		0.9550	0.7246	0.6028	0.5014	0.4171	0.3470
Хорогдуулсан эрхийн шимтгэлээс чөлөөлөгдсөн орлого: минимум		**754**	**1,295**	**1,350**	**1,423**	**1,455**	**1,457**
Теминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ							**10,056**

	Гордоны загвар	
Хорогдуулсан ЭШЧО-ын өнөөгийн үнэ цэнэ	7,734	43.5%
Терминал үнэ цэнийн өнөөгийн үнэ цэнэ	10,056	56.5%
Өмчийн үнэ цэнэ	**17,790**	**100.0%**
Татварын хорогдуулгын хэмнэлт	1,466	
Хамгаалагдсан оюуны өмч	**19,256**	

СЭХ
он сар елер
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БҮРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25
БҮРТГЭВ-03

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

СЗХ
2023.01.25
ирсэн өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25
БҮРТГЭВ-03

SNOW HILL
CONSULTANCY

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХХК-ИАС АНХ УДАА ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОН ҮНЭТ ЦААС НЭМЖ ГАРГАХАД ЗОРИУЛАВ.

ӨМГӨӨЛЛИЙН СНОУ ХИЛЛ КОНСАЛТАНСИ ХХН

2022.11.29

СЗХ
2023 оны 01 сар 25 өдөр
БҮРТГЭВ
Хуудас 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25
БҮРТГЭВ 03

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-Д

SNOW HILL
CONSULTANCY

2022 оны 11-р сарын 29 Улаанбаатар хот

Дүгнэлт гаргах нь:

"Сноу Хилл Консалтанси" ХХН нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 1-р сарын 27-ний өдрийн 24 тоот тогтоол болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх хэсэгт заасны дагуу үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэгдсэн үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувьд энэхүү дүгнэлтийг гаргах эрхтэй болно.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар "Газар Шим Үйлдвэр" ХХК ("**Компани**") нь үнэт цаасаа нийтэд санал болгон худалдах гэж байгаатай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хороо ("**СЗХ**")-ны 2021 оны 225 дугаар тогтоолын Хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 2018/01 тоот тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дах хэсгийг тус тус үндэслэн "Сноу Хилл Консалтанси" ХХН ("**Сноу Хилл**" эсвэл "**Хуульч**") нь 2022 оны 6-р сарын 29-ний өдрөөс Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж, энэхүү хууль зүйн дүгнэлт ("**Дүгнэлт**")-ийг гаргаж байна.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т *"...хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно."* 4 дүгээр зүйлийн 4.3-т *"Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон үнэт цаас гаргаж болно."* гэж заасны дагуу Компани нь нэмж гаргах энгийн хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдах эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна.

<u>Хариуцлага хязгаарлах тухай мэдэгдэл:</u>

Энэхүү Дүгнэлтийг 2022 оны 6-р сарын 29-ний өдрөөс 2022 оны 11-р сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд Компани болон эрх бүхий байгууллагаас хүлээн авсан мэдээлэл, баримт, материалд тулгуурлан гаргасан болно.

Энэхүү Дүгнэлтийн 5 дугаар бүлгийг Компаниас тодорхойлон ирүүлсэн сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэж тодорхойлсон хэлцэл, түүнтэй холбогдох гэрээг үндэслэж боловсруулсан ба бусад

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25
БҮРТГЭВ-03

СЗХ
2023 -01- 25
БҮРТГЭВ
№ -1

гэрээ хэлэлцээртэй холбоотой дүгнэлтийг сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн гэрээ, хэлцлээр хязгаарласан болно.

Энд дурдагдаж буй эрх бүхий байгууллагын тодорхойлолтод үндэслэн хийж буй дүгнэлтийн хамаарах хугацаа нь тухайн тодорхойлолтын огноогоор хязгаарлагдана. Тухайн тодорхойлолтын огнооноос хойших үйл явдалд Сноу Хилл хууль зүйн дүгнэлт хийгээгүй бөгөөд түүнд Хуульчийн зүгээс ямар нэгэн баталгаа гаргахгүй болно.

Сноу Хилл нь ийнхүү Дүгнэлтийг гаргахдаа (1) үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа дүгнэлт санхүүгийн мэдээлэл үнэн зөв, (2) Компанийн удирдлага, ажилтнуудаас бидэнд ирүүлсэн мэдээлэл нь үнэн зөв, (3) тэдгээр баримт бичигт зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг эх хувиар, бодит зөв, (4) бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлдсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлдэх, гарын үсэг зурах эрх бүхий гэж үзсэний үндсэн дээр Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль тогтоомжид нийцүүлэн энэхүү Дүгнэлтийг гаргав.

Компанийн талаар гаргасан энэхүү Дүгнэлтэд дараах мэдээллийг хамруулаагүй.

1) Компанийн үйлчлүүлэгчдийн талаарх мэдээлэл,
2) Санхүүгийн тайлан мэдээ,
3) Хүний нөөцийн талаарх мэдээлэл (ажил үүргийн хуваарь, цалин урамшуулал зэрэг),
4) Өмч хөрөнгийн тоо бүртгэл түүний удирдлага (элэгдэл хорогдол, үнэлгээ зэрэг),
5) Маркетингийн бодлого, стратеги,
6) Бизнесийн төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл,
7) Компанийн зүгээс явуулж буй бүтээгдэхүүн боловсруулах судалгаа, төлөвлөгөө,
8) Чанарын хяналтын талаарх үйл ажиллагаа.

Иймд бидний энэхүү Дүгнэлт нь Компанитай холбоотой бүхий л мэдээллийг хамарсан гэж үзэх боломжгүй.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Компани нь үнэт цаасаа нийтэд санал болгох замаар худалдах гэж байгаатай холбогдон мэдээлэл хүлээж авах эрх бүхий холбогдох байгууллагууд, хөрөнгө оруулагч нарт хүргүүлж байгаа бөгөөд бусад гуравдагч этгээдэд зориулаагүй, тараагаагүй.

Дор дурдсанаас бусад тохиолдолд Хуульчдын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү Дүгнэлтийг ашиглах, эшлэл авах, бусад баримт бичигт оруулан дурдах, бусдад хувилан хүргүүлэхийг хориглоно. Үүнд:

А) Компани үнэт цаасаа нийтэд санал болгох замаар худалдах гэж байгаатай холбоотой ажиллаж буй нягтлан бодогч, хуульч болон мэргэжлийн зөвлөхүүд;
Б) холбогдох хууль тогтоомжийн дагуу та бухний мэдээлэл, тайлан гаргаж хүргүүлэх ёстой төр захиргааны болон зохицуулагч байгууллага, агентлагууд;
В) холбогдох харьяаллын шүүх болон маргаан таслах байгууллагаас томилогдсон этгээд.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25

Компани үнэт цаасаа нийтэд санал болгон худалдах гэж байгаатай холбогдуулан гаргасан энэхүү Дүгнэлтийг зохих газар луу хүргүүлж, зөвшөөрлийг авсан өдрөөс хойш холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсон зэрэг бусад үйл ажиллагаатай холбогдуулан бид нэмэлт хууль зүйн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН:

"СНОУ ХИЛЛ КОНСАЛТАНСИ" ХХН-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /Б.НЯМЦЭРЭН/

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25
БҮРТГЭВ-03

ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ.....6
НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ ХУУЛИЙН ДАГУУ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДАЖ, БҮРТГЭГДСЭН ЭСЭХ, ҮНЭТ ЦААС ГАРГАХ ШИЙДВЭР ХУУЛЬД НИЙСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ..... 8
1.1.Үнэт цаас цаас гаргагч хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх талаарх дүгнэлт..... 8
1.1.1. Үүсгэн байгуулагдсан талаарх мэдээлэл;..... 8
1.1.2. Хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл;..... 8
1.1.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт;..... 9
1.1.4. Компанийн эрхлэх үйл ажиллагаа болон хугацааны мэдээлэл;.....10
1.1.5. Компанийн хаяг.....11
1.2.Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх талаарх дүгнэлт;.....11
1.3.Үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН ТӨСӨЛ нь хуульд нийцсэн эсэх талаарх дүгнэлт.....12
1.4.Хувьцаат Компанийн засаглалын журмуудын төсөл нь Монгол Улсын хууль тогтоомж, КЗК-т нийцэж буй эсэх талаар дүгнэлт.....14
ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОН ХОРООНООС БАТАЛСАН ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ 15
2.1.Эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн ерөнхий мэдээлэл;.....15
2.2.Эрх бүхий албан тушаалтнуудын удирдах чадвар, дадлага туршлагын байдал;.....15
2.3.Тохиромжтой этгээдийг тодорхойлсон журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх;.....20
ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДҮРЭМ, ДОТООД ЖУРМУУД НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ 24
3.1.Компанийн дүрэм нь КтХ-ийн шаардлагад нийцсэн эсэх талаар.....24
3.2.Компанийн үйл ажиллагааны баримт бичгүүд нь хуульд нийцэж буй эсэх талаар.....25
ДӨРӨВ. БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ХУДАЛДАХ БОЛОН ХУДАЛДАН АВАХ, БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ, ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БОЛОН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ ҮЗҮҮЛЭХ БУСАД ГЭРЭЭ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ.....38
4.1.Бусадтай байгуулсан Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий бусад гэрээ, хэлцлийн талаарх дүгнэлт.....38
4.2.Зээлийн болон барьцааны гэрээнүүд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаарх дүгнэлт;.....42
4.3.Компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээнүүд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаарх дүгнэлт;..... 44

SNOW HILL Consultancy LLP

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ

4.4. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт;.....60

ТАВ. СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ДОТОР ХИЙГДСЭН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ХИЙГДСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ.....62

5.1.Их хэмжээний хэлцэл хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх талаарх дүгнэлт;.....62

5.2.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх талаарх дүгнэлт;.....62

ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЛИЦЕНЗ, ЗОХИОГЧИЙН ЭРХ, ПАТЕНТ, БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДГИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ, ТЭДГЭЭРИЙН ХУГАЦАА ДУУСАХ ЦУЦЛАГДАХ, ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ЗЭРГЭЭР ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ БОДИТОЙ НӨЛӨӨЛЖ БОЛОХУЙЦ НӨХЦӨЛ БУЙ ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ.....65

ДОЛОО. ҮНЭТ ЦААС, ҮЛ ХӨДЛӨХ БОЛОН БУСАД ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ НЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ, АЛИВАА ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ЭСЭХ ТАЛААР 67

НАЙМ. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАГДСАН ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ НЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАРИМТААР НОТЛОГДОЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ 70

ЕС. КОМПАНИЙН ТОЛГОЙ, ОХИН, ХАРААТ, ЗЭРЭГЦЭЭ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛСОН ДҮГНЭЛТ; 71

9.1Хамаарал бүхий компаниудын мэдээлэл.....71

9.2.Эцсийн өмчлөгч.....73

АРАВ.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ИРГЭН, ЗАХИРГААНЫ ХЭРЭГТ ХАРИУЦАГЧААР ТАТАГДАЖ БАЙСАН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ.....75

АРВАН НЭГ. ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛ БОЛОН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ ӨР ТӨЛБӨРТЭЙ ЭСЭХ ТАЛААХ ДҮГНЭЛТ.....76

Хавсралт 1.....78

Хавсралт 2.....96

Хавсралт 3.....99

Хавсралт 4.....109

Хавсралт 5.....114

Хавсралт 6.....157

Хавсралт 7.....207

Монголын Сноу Хилл Консалтанси ХХК
SNOW HILL Consultancy LLP

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -01- 25

ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

Дор дурдсан мэдээлэл болон өөрсдийн шаардлагатай гэж үзсэн хяналт, шалгалтын материалд үндэслэн, энд тодорхойлсон хязгаарлалт болон нөхцөлийн хүрээнд Хуульч нь дараах дүгнэлтийг гаргаж байна:

1. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 1999 оны 07-р сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, 2007 оны 07-р сарын 20-ны өдөр Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн газар (“**ХЭУБ**”)-т бүртгүүлэн, 2577127 тоот регистрийн дугаартай үйл ажиллагаа явуулж байна.
2. Компани нь үйл ажиллагаа эрхлэх салбар, төлөөлөгчийн газаргүй.
3. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компани нь Цээпэлийн Ганбат (51%), Цээпэлийн Төгсөө (13%), Штэффэн Мэлцэр (15%), Занаширын Байгалмаа (11%), Дүгэржавын Сэргэлэн (5%), Ганбатын Түвшинзаяа (5%) гэсэн 6 хувьцаа эзэмшигчтэй байна.
4. Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т “*...хязгаарлагдмал хариуцлагатай компани дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно*” гэсэн зохицуулалтын хүрээнд байна.
5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтүүдийг тухай бүр бүртгэлийн эрх бүхий байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлсэн байх бөгөөд 2022 оны 11-р сарын 29-ний өдрийн байдлаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөг ба нэг бүр нь 0.11 (тэг зууны арван нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000,000,000(нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.
6. Компанийн Гүйцэтгэх захирлаар Цээпэлийн Ганбатыг томилсныг 2007 оны 07-р сарын 20-ны өдөр ХЭУБ-т бүртгүүлэн, Улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэсэн ба 2021 оны 12-р сарын 02-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хуралтай байгуулсан Контрактын гэрээний дагуу өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна.
7. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11-р сарын 08-ны өдрийн ээлжит бус хурлаар Компанийн дүрмийг шинэчлэн найруулсан байна. Дүрэм нь Компанийн тухай хууль (**“КтХ”**)-ийн 16 дугаар зүйлд заасан тусгагдвал зохих мэдээлэл бүрэн тусгагдсан байна.
8. Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журам, Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлтэй холбоотойгоор заавал мөрдөх заавар, стандартууд нь холбогдох хууль тогтоомж болон КтХ, СЗХ-ны 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан Компанийн Засаглалын Кодекс (**“КЗК”**)-т нийцсэн байна.
9. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд мөрдөгдөх хөдөлмөрийн дотоод журмын төсөл нь шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.
10. ХК-ийн Компанийн дүрмийн төсөл нь КтХ-д заасан заавал тусгах зүйлсийг бүрэн тусгасан, жижиг хувьцаа эзэмшигчийн эрх ашигт хамааралтай зохицуулалтыг агуулсан байгаа нь КтХ, КЗК-т нийцсэн байна.
11. Бусадтай байгуулсан Худалдах-худалдан авах, Бэлтгэн нийлүүлэх, Зээлийн гэрээ, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэрээнүүд нь Иргэний хуулийн гэрээнд тавигдах ерөнхий шаардлагуудыг хангасан байна.
12. Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5% ба түүнээс дээш үнийн дүн бүхий гэрээнүүдийн хэрэгжилт хэвийн байна.
13. Компанийн хөдөлмөрийн гэрээ нь шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдийг бүрэн тодорхойлсон байна.
14. Компани нь сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл байгуулаагүй боловч энэхүү Дүгнэлтийг гаргах

SNOW HILL Consultancy LLP
ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР ХК

өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй, 2019 оноос өмнө байгуулсан 1 (нэг) их хэмжээний хэлцэл байна. Компани нь сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй 5(тав) хэлцэл байгуулсан байна. Эдгээр хэлцлүүд нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан байна. Компани нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахаас өмнө Хувьцаа эзэмшигчдийн хурлаар КтХ-д заасан шаардлагын дагуу хэлэлцүүлж батлуулсан байгаа нь КтХ болон КЗК-ийн шаардлагад нийцсэн байна.

15. Оюуны Өмчийн Газрын 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн 3/403 тоот албан бичиг болон Оюуны Өмчийн Газрын мэдээллийн сангийн мэдээллээс үзэхэд Компанийн нэр дээр бүртгэлтэй барааны тэмдэг, патент, бүтээгдэхүүний загвар байхгүй байна. Гэхдээ компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа барааны тэмдэг, патентууд Компанийн Хувьцаа эзэмшигчдийн нэр дээр бүртгэлтэй бөгөөд Лицензийн гэрээ, Барааны тэмдгийн гэрээний хүрээнд ашиглахаар Оюуны Өмчийн Газарт холбогдох баримт бичгээ бүрдүүлэн хүргүүлсэн байна.
16. Компанийн үнэт цаас, Дүгнэлтийн хэсэгт зааснаас бусад үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр ба аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн нөхцөл үүсээгүй байна. Компанийн нэр дээр бүртгэлтэй Газар эзэмших эрхийн гэрчилгээтэй 4 газар, Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ байгуулагдсан, бүртгэлийн шатанд явж байгаа 2 газар байна.
17. Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн зээлийн мэдээллийн лавлагаагаар Компанийн зээлийн ангилал хэвийн түвшинд хамаарч байна.
18. Компанийн эсрэг аливаа төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, хувь хүнээс үүсгэсэн, үүсгэж болзошгүй ямар нэг захиргааны, шүүхийн, арбитрын хэрэг эсвэл хүлээгдэж буй шүүхийн шийдвэр, албадлагын арга хэмжээний мэдэгдэл байхгүй.
19. Татварын Ерөнхий Газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн татварын цахим системээс авсан Тодорхойлолт болон Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс[1] 2022 оны 07-р сарын 04-ний өдөр бидэнд ирүүлсэн 2086 тоот Тодорхойлолт зэргээс үзэхэд Компани нь Монгол Улсын татварын хууль тогтоомж зөрчөөгүй, тус компанийн эсрэг ямар нэг татварын нэхэмжлэл, маргаан үүсээгүй.
20. Гаалийн ерөнхий газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн Тодорхойлолтоор Компани нь Гаалийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн талаарх мэдээлэл гаалийн зөрчлийн санд бүртгэгдээгүй, 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн байдлаар гаалийн байгууллагад өргүй байна.
21. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн Тодорхойлолтоор Компани нь 2022 оны 10-р сард 43,351,755 (дөчин гурван сая гурван зуун тавин нэгэн мянга долоон зуун тавин тав) төгрөгийн өглөгтэй байна.
22. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн регистрийн дугаар, Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Компанийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ, өөрийн хөрөнгийн хэмжээ болон Компанийн холбоотой этгээдийн мэдээлэл нь Хуульчид Компанийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна.
23. Компанийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь Компанийн 51 хувийн хувьцааг эзэмшигч Монгол Улсын иргэн Ц.Ганбат байна.

---

[1] Монгол Улсын Захиргааны Ерөнхий Хуулийн дагуу татварын хэрэг маргааны шүүхийн харьяалал нь Захиргааны шүүхэд хамаарна.

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ НЬ ХУУЛИЙН ДАГУУ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДАЖ, БҮРТГЭГДСЭН ЭСЭХ, ҮНЭТ ЦААС ГАРГАХ ШИЙДВЭР ХУУЛЬД НИЙСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

1.1. Үнэт цаас цаас гаргагч хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх талаарх дүгнэлт

1.1.1. Үүсгэн байгуулагдсан талаарх мэдээлэл;

Компани нь анх "ГБТ Трейдинг" ХХК нэртэйгээр, 1999 оны 07-р сарын 23-ны өдрийн 01 тоот шийдвэрийн дагуу 9,984,000 (есөн сая есөн зуун наян дөрвөн мянга) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, 1 гишүүнтэйгээр үүсгэн байгуулагдаж, ХЭУБ-т зохих ёсоор бүртгүүлэн 1999 оны 07-р сарын 26-ны өдөр улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байгаа нь КтХ-д заасан шинээр үүсгэн байгуулахтай холбоотой хуулийн шаардлагуудыг[2] хангасан байна.

Компанийн нэрийг 2022 оны 08-р сарын 15-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдаанаар "Газар Шим Үйлдвэр" ХХК болгон өөрчилснийг ХЭУБ-т 2022 оны 08-р сарын 18-ны өдөр бүртгүүлсэн нь КтХ-д заасан компанийн нэрийг өөрчлөхтэй холбоотой хуулийн шаардлагыг[3] хангасан байна. (Компанийн регистрийн дугаар: 2577127)

1.1.2. Хөрөнгийн бүтэц, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл;

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11-р сарын 08-ны өдрийн 05 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан Компанийн дүрэм (**"Дүрэм"**)-ийн 5 дугаар зүйлийн 5.2-т зааснаар Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөг ба нэг бүр нь 0.11 (тэг зууны арван нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000,000,000(нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэхээр зохицуулсан байна. Энэхүү хувь нийлүүлсэн хөрөнгийг хэмжээг ХЭУБ-т бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэсэн байгаа нь КтХ-ийн холбогдох шаардлагыг[4] хангасан байна.

Дүрэмд зааснаар Компанийн хувьцааг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа нь КтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Компаниас гаргасан хувьцааг Монгол Улсын болон гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно" гэсэнтэй нийцэж байна.

Хүснэгт №1

---

[2] Компанийн тухай хууль 13 дугаар зүйл. Шинээр компани үүсгэн байгуулах.
13.1.Үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулна.
13.2.Компанийг нэг этгээд үүсгэн байгуулж байгаа тохиолдолд тухайн этгээд нь үүсгэн байгуулах шийдвэр гаргана.
Компанийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх.
15.1.Компани байгуулах тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.

[3] Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Компанийн оноосон нэр, оршин байгаа газар.
10.2.Компанийн оноосон нэр нь бусад компани, өөр хуулийн этгээдийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр түүнийг хэрэглэх онцгой эрхтэй болно.

[4] Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл. 16.2. Компанийн дүрэмд заавал тусгах зүйлс.
16.2.2.компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;

SNOW HILL Consultancy LLP

№	Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр	Гаргасан хувьцаа			Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		
			Нэг бүрийн	Бүгд	
1.	Цээпэлийн Ганбат	510 000 000	0.11	56 100 000	51
2.	Цээпэлийн Төгсөө	130 000 000	0.11	14 300 000	13
3.	Занаширын Байгалмаа	110 000 000	0.11	12 100 000	11
4	Штэффэн Мэлцэр	150 000 000	0.11	16 500 000	15
5	Дүгэржавын Сэргэлэн	50 000 000	0.11	5 500 000	5
6	Ганбатын Түвшинзаяа	50 000 000	0.11	5 500 000	5

1.1.3. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт;

Компани нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хувьцаа эзэмшлийн бүтцэд дараах өөрчлөлтүүдийг оруулж, тухай бүрд нь ХЭУБ-т бүртгүүлсэн байсан нь КтХ-ийн 17 дугаар зүйлийн 17.4[5] болон 17.9 дэх хэсэгт зааснаар тухайн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт нь хүчин төгөлдөрт тооцогдох үндэслэл болно.

- Компанийг үүсгэн байгуулах үед хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 9,984,000 (есөн сая есөн зуун наян дөрвөн мянга) төгрөг байсан;

- 2002 оны 09-р сарын 03-ны өдрийн "Монгол Германы хамтарсан Газар шим үйлдвэр ХХК байгуулах гэрээ"-ний дагуу Компанийг хамтарсан компани болгон өөрчлөн байгуулж, 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, Газар шим үйлдвэр ХХК (60%), Цээпэлийн Хүрэлбаатар (25%), Герман улсын "Штэффэн Мэлцэр Трейд" ХХК (15%) нар эзэмшихээр болж;

- Компанийн хувь нийлүүлэгчдийн 2008 оны 02-р сарын 18-ны өдрийн шийдвэрээр Компанийн хувь нийлүүлэгч Ц.Хүрэлбаатарын эзэмшиж байсан 25%-ийн эзэмшлээс 11,000,000 (арван нэгэн сая) төгрөг буюу Компанийн 10%-тай тэнцэх хувийг Ц.Төгсөөд шилжүүлсэн өөрчлөлтийг 2009 оны 08-р сарын 10-ны өдөр;

- Компанийн хувь нийлүүлэгчдийн 2016 оны 09-р сарын 12-ны өдрийн хурлаар 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр, Ц.Ганбат (67%), Ц.Төгсөө (18%), Штэффэн Мэлцэр Трейд ХХК (15%) нар байхаар шийдвэрлэсэн өөрчлөлтийг 2016 оны 09-р сарын 14-ний өдөр;

- Компанийн хувь нийлүүлэгчдийн 2019 оны 07-р сарын 22-ны өдрийн хурлаар Ц.Ганбат нь өөрийн эзэмшиж байсан 67%-с 3.Байгалмаад 16%-г шилжүүлсэн өөрчлөлтийг 2019 оны 07-р сарын 31-ний өдөр;

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 08-р сарын 15-ны өдрийн 01 тоот хурлын тогтоолоор Ц.Ганбат (51%), Ц.Төгсөө (13%), Гермон Штэффэн Мэлцэр

[5] Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйл. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах, бүртгэх

17.4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдрийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

17.9. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

ХЭУБ
2022 оны 01 сар 25 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

Трейд унд Сервис е.Кфм (15%), З.Байгалмаа (11%), Д.Сэргэлэн (5%), Г.Түвшинзаяа (5%) нар байхаар шийдвэрлэсэн өөрчлөлтийг ХЭУБ-т бүртгүүлсэн байна;

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 10-р сарын 21-ны өдрийн 04 тоот хурлын тогтоолоор Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд Сервис е.Кфм нь өөрийн эзэмшиж байсан 15%-г Штэффэн Мэлцэрт шилжүүлсэн өөрчлөлтийг 2022 оны 10-р сарын 25-ны өдөр тус тус ХЭУБ-т бүртгүүлсэн байна.

- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11-р сарын 08-ны өдрийн 05 тоот хурлын тогтоолоор компанийн хувьцааг 5,000 хувааж, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөг ба нэг бүр нь 0.11 (тэг зууны арван нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000,000,000(нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэхээр дүрэмд оруулсан өөрчлөлтийг 2022 оны 11 сарын 13-ны өдөр ХЭУБ-т бүртгүүлсэн байна.

1.1.4. Компанийн эрхлэх үйл ажиллагаа болон хугацааны мэдээлэл;

Компани нь үүсгэн байгуулагдахдаа 0119 кодтой Хүнсний ногоо консервлэх, 0131 кодтой Жимсний чанамал мармелад үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэхээр 1999 оны 07-р сарын 26-ны өдөр улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

Компани нь 0113 кодтой Хүнсний ногоо савлаж хадалдаалах, 0125 кодтой Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 2007 оны 07-р сарын 20-ны өдөр, 4630 кодтой Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа, 4610 кодтой Гадаад худалдаа, 0119 кодтой Хүнсний ногоо тариалах, худалдах, 0124 кодтой Жимс, жимсгэнэ тариалах, худалдаа, 1079 кодтой Ундаа, жүүс үйлдвэрлэл, 5610 кодтой цайны газар, 4690 кодтой Хүнсний дэлгүүр, 1010 кодтой Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 4774 кодтой Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ, 0150 кодтой Газар тариалан эрхлэх, 1073 кодтой Цайны үйлдвэрлэл, худалдаа, 0149 кодтой Фермерийн аж ахуй эрхлэх, 0130 кодтой Хүлэмжийн аж ахуй эрхлэх чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулахаар ХЭУБ-т 2016 оны 09-р сарын 14-ны өдөр бүртгүүлсэн байна. Иймхүү эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг зохих ёсоор бүртгүүлсэн нь Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Компанийн Дүрэм, ХЭУБ-ын 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн 22300002002861 дугаар лавлагаагаар тус тус тогтоогдож байна.

Эдгээр үйл ажиллагаа нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл олгогдсоны үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарахгүй байх бөгөөд Компанийн Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.5 дах хэсэгт Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхлэхээр тусгасан байна.

Компани нь 2020 оны 06-р сарын 16-ны өдөр Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3 дах хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрөл олгогдсоны үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд хамаарч байна.

Эрхэлж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт №2

Д/д	Код	Үйл ажиллагааны чиглэл	Үндсэн (одоо эрхэлж байгаа эсэх) үйл ажиллагаа эсэх
1	0113	Хүнсний ногоо савлаж худалдаалах	+
2	0125	Жимсний чанамал, мармелад үйлдвэрлэх	-
3	4630	Хүнсний бөөний болон жижиглэнгийн худалдаа	+
4	4610	Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	+
5	0119	Хүнсний ногоо тариалах, худалдах	+
6	0124	Жимс, жимсгэнэ тариалах, худалдаа	+
7	1079	Ундаа, жүүс үйлдвэрлэл	+
8	5610	Цайны газар	-
9	4690	Хүнсний дэлгүүр	+
10	1010	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	-
11	4774	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ	-
12	0150	Газар тариалан эрхлэх	+
13	1073	Цайны үйлдвэрлэл, худалдаа	-
14	0149	Фермерийн аж ахуй эрхлэх	-
15	0130	Хүлэмжийн аж ахуй эрхлэх	+

Компанийн химийн хорт болон аюултай бодисыг импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл нь 2 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. Тусгай зөвшөөрлийн талаар энэхүү Дүгнэлтийн 6 дугаар хэсгээс дэлгэрүүлж харна уу.

Компанийн Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.6-д зааснаар компани үйл ажиллагаагаа хугацаагүйгээр эрхлэхээр зохицуулсан байна.

1.1.5. Компанийн хаяг

Компани нь 2018 оны 12-р сарын 26-ны өдөр Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 115 газар шим төв хаягт бүртгэгдсэн байна. Үүнээс хойш ХЭУБ-т 2019 оны 01-р сарын 09-ний өдөр Компанийн албан ёсны хаягт өөрчлөлт оруулж Компанийн Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дах хэсэгт зааснаар Компанийн албан ёсны хаяг нь "Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, 66/1, 66/2 тоот" байна. Компани тус хаягийн мэдээллийг Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгүүлсэн байна.

Явцын дүгнэлт: *Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, Хуулийн этгээдийн улсын бүртгэл холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэл хийлгэсэн байна.*

1.2. Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх талаарх дүгнэлт;

1.2.1. Үнэт цаас гаргах асуудлыг хэлэлцэх Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай Гүйцэтгэх захирлын тушаал хуулийн дагуу гарсан эсэх;

ХЭЭБХ хуралдуулах тухай Гүйцэтгэх захирлын 2022 оны 11-р сарын 21-ний өдрийн тушаалд ХЭЭБХ хуралдуулах газар, өдөр, цаг, хурлын хэлэлцэх асуудал, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журмын мэдээллийг тусгасан

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ЗАХ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

байгаа нь КтХ-ийн 60 дугаар зүйлд нийцсэн байна. Мөн уг тушаал хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна.

1.2.2. Үнэт цаас нэмж гаргах асуудлыг хэлэлцсэн ХЭЭБХ хүчин төгөлдөр эсэх;

ХЭЭБХ-ын зарыг 2022 оны 11-р сарын 21-ний өдөр Хувьцаа эзэмшигч нарын цахим шуудангаар хүргүүлсэн нь КтХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1[6], 65.4[7] болон Дүрэмд заасан шаардлагыг хангасан байна.

ХЭЭБХ-ын тэмдэглэлд дурдсанаар хурлын ирц нь КтХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1-т[8] зааснаар саналын эрх бүхий хувьцааны 50%-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсон байх тул тухайн хурал хүчин төгөлдөр байна.

1.2.3. Үнэт цаас гаргах шийдвэр хүчин төгөлдөр эсэх;

ХЭЭБХ-ын тэмдэглэлд дурдсанаар Үнэт цаас нэмж гаргах, компанийн хэлбэр өөрчлөхтэй холбоотой асуудлыг хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар шийдвэрлэсэн нь КтХ-ийн 63 дугаар зүйлийн 63.7-д заасан шаардлагыг хувь хэмжээний хангасан байна. Иймд энэ шийдвэр хүчин төгөлдөр байна.

Явцын дүгнэлт: *Үнэт цаас нэмж гаргах тухай шийдвэр нь хуулийн дагуу гарсан байна.*

1.3. Үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН ТӨСӨЛ нь хуульд нийцсэн эсэх талаарх дүгнэлт:

Компани нь Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 11-р сарын 23-ны өдрийн "Компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болох, нэмж хувьцаа гаргах тухай" тогтоолын Хавсралт №1-ээр Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар үүсэх хувьцаат компанийн дүрмийн төслийг баталсан байна.

1.3.1. ХК-ийн дүрмийн төсөл нь КтХ-ийн шаардлагыг хангасан эсэх талаар;

Тус Компанийн дүрмийн төсөл нь дараах агуулга бүхий 16 бүлэгтэй байна.

1. Нийтлэг үндэслэл;
2. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг;
3. Компанийн үйл ажиллагааны чиглэл;
4. Компанийн эрх хэмжээ;
5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа
6. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг хариуцлага;
7. Компанийн үнэт цаас гаргах, худалдах, эргүүлэн авах;

---

[6] 65.4.Хувьцаа эзэмшигчдийн хурлын зард компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам зэрэг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээллийг тусгасан байна.

[7] 65.1.Энэ хуулийн 60.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал зарласан этгээд нь тухайн хурлын зарыг хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид мэдээлэх үүрэг хүлээнэ.

[8] Компанийн тухай хуулийн 69. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц /кворум/, хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох

69.1.Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

8. Хувьцаа эзэмшигчдийн хурал;
9. Төлөөлөн удирдах зөвлөл, түүний эрх хэмжээ;
10. Гүйцэтгэх удирдлага, түүний эрх хэмжээ;
11. Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний хүлээх хариуцлага;
12. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, ногдол ашиг хуваарилах;
13. Сонирхлын зөрчлийг зохицуулах;
14. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт тавих;
15. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай;
16. Бусад нөхцөлүүд.

Дүрмийн төслөөс үзвэл КтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2 дах хэсэгт заасан "Дүрэмд заавал тусгах зүйл" буюу (i) компанийн оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ, (ii) компанийн гаргасан хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, (iii) хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, (iv) төлөөлөн удирдах зөвлөл болон (v) компанийн үйл ажиллагааны чиглэл зэргийг бүрэн тусгасан байна. Мөн СЗХ-ны 2012 оны 03-р сарын 14-ний өдрийн Дугаар 74 тогтоолын Хавсралтаар батлсан "Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар"-т заасны дагуу хувьцаат компанийн дүрмийн төсөл нь дараах байдлаар хуулийн шаардлагыг хангаж байна гэж үзлээ. Үүнд:

1. Компанийн дүрмийн 2.1 хэсэгт Компанийн нэр Монгол хэлээр "Газар Шим Үйлдвэр" ХК, англи хэлээр "Gazar Shim Industry" Joint Stock Company болох талаар;

2. Компанийн дүрмийн 1.6 хэсэгт Компанийн оршин байгаа газрын хаяг нь Компанийн оршин байгаа газрын хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс 66/1, 66/2 өөрийн байранд байрлах талаар;

3. Дүрмийн 6 дугаар зүйлд Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлага, 8 дугаар зүйлд Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, 9 дүгээр зүйлд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн эрх хэмжээ, 15 дугаар зүйлд Компанийн Аудиторын хяналтын талаар;

4. Дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3 дах хэсэгт компанийн үйл ажиллагааны чиглэлийн талаар;

5. Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3 дах хэсэгт ТУЗ нь 9 гишүүнтэй байх, тэдгээрийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байх талаар тусгасан нь КтХ-ийн 75 дугаар зүйлийн 75.4[9] дэх хэсэгт заасантай нийцсэн байна.

1.3.2. ХК-ийн дүрмийн төсөл "Компанийн засаглалын кодекс"-т нийцэж буй эсэх талаар;

СЗХ-оос 2022 оны 03-р сарын 23-ны өдөр 145 дугаар тогтоолоор КЗК-ийг шинэчлэн батлсан бөгөөд засаглалын дараах 9 зарчмыг үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах, компанийн дүрэмд холбогдох асуудлыг тусгасан өөрчлөлт оруулахыг компаниудад үүрэг болгосон байна. Компанийн дүрмийн төсөл нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд хороод, тэдгээрийн чиг үүрэг;
3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал;
4. Аудит, хяналтын тогтолцоо;

[9] 75.4.Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

5. Эрсдэлийн удирдлага;
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал;
7. Оролцогч талуудын эрх ашиг;
8. Компанийн соёл;
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх.

Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэх, холбогдох мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх зэрэг КЗК-ийн зарчимд нийцүүлэн боловсруулсан нь хууль тогтоомжид нийцсэн байна.

Түүнчлэн "Газар Шим Үйлдвэр" ХК-ийн төсөлд компанийн эрх, үүрэг, компанийн хариуцлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, компанийн эрх бүхий албан тушаалтан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, санхүүгийн тайлан, ногдол ашиг хуваарилах, дотоод хяналт, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, өр төлбөрийг барагдуулах зэрэг асуудлыг тусгасан нь КтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2.7[10], 75 дугаар зүйлийн 75.4[11], 81 дүгээр зүйлийн 81.2[12] , 84 дүгээр зүйлийн 84.2[13] , 92 дугаар зүйлийн 92.8[14], 95 дугаар зүйлийн 95.3[15] дах хэсэгт заасан шаардлагад нийцэж байна гэж үзлээ.

Явцын дүгнэлт: *Хувьцаат компанийн дүрмийн төсөл нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.*

1.4. Хувьцаат Компанийн засаглалын журмуудын төсөл нь Монгол Улсын хууль тогтоомж, КЗК-т нийцэж буй эсэх талаар дүгнэлт

Хуульчид нь Хувьцаат компанийн дүрмийн төслөөс гадна компанийн засаглалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах журмын төслүүдийг боловсруулж, үйлчлүүлэгчид хүлээлгэн өгсөн. Үүнд:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;
2. Хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулах журам;
3. Ногдол ашгийн бодлого;
4. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам;
5. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх үйл ажиллагааны журам;
6. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын үйл ажиллагааны журам;
7. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын журам;
8. Залгамж халааны бодлого;
9. Компанийн эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаандаа мөрдөх "Ес зүйн дүрэм";
10. Хөндлөнгийн аудит томилох журам;
11. Мэдээллийн ил тод тайлагналын журам;
12. Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр;
13. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам.

---

[10] Компанийн тухай хуулийн 16.2.Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:
16.2.7.компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл.

[11] 75.4.Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

[12] 81.2.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

[13] 84.2.Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна.

[14] 92.8.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай энэ хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална.

[15] 95.3.Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацааг компанийн дүрмээр тогтооно.

ХОЁР ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОН ХОРООНООС БАТАЛСАН ТОХИРОМЖТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГАЖ БАЙГАА ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Дүрмээр Компанийн эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг КтХ-ийн 84 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлсон тул хуульд заасан агуулгын хүрээнд холбогдох албан тушаалтнуудаар СЗХ-оос батлан гаргасан Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг бөглүүлэх, түүнд дүн шинжилгээ хийх байдлаар дүгнэлээ.

2.1. Эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн ерөнхий мэдээлэл;

Компани нь КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1 болон Компанийн Дүрмийн 3.12 дах хэсэгт заасны дагуу дараах эрх бүхий албан тушаалтантай байна. Үүнд:

Хүснэгт №3

№	Эрх бүхий албан тушаалтан	Томилогдсон этгээд	Томилсон тогтоол, шийдвэр
1	Ерөнхий захирал	Ц.Ганбат	Хувь Нийлүүлэгчдийн Хурлын 2019.07.22-ны өдрийн тогтоол
2	Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий технологич	Ц.Төгсөө	Гүйцэтгэх захирлын 2015.08.01-ний өдрийн тушаал
3	Захиргаа, удирдлага хариуцсан захирал	З.Байгалмаа	Гүйцэтгэх захирлын 2021.11.01-ний өдрийн тушаал
4	Маркетинг, борлуулалт хариуцсан захирал	Д.Сэргэлэн	Гүйцэтгэх захирлын 2011.05.01-ний өдрийн тушаал
5	Ерөнхий нягтлан бодогч	Л.Бүрэнчимэг	Гүйцэтгэх захирлын 2022.10.17-ны өдрийн тушаал
6	Үйлдвэрийн дарга	Д.Жаргал	Гүйцэтгэх захирлын 2017.01.04-ний өдрийн тушаал
7	Ерөнхий инженер	М.Нямсанж	Гүйцэтгэх захирлын 2013.04.01-ний өдрийн тушаал
8	Чанар хяналтын албаны дарга	Ч.Оюунбилэг	Гүйцэтгэх захирлын 2017.02.01-ний өдрийн тушаал
9	Ахлах технологич	Ц.Батзаяа	Гүйцэтгэх захирлын 2017.02.01-ний өдрийн тушаал
10	Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер	Б.Энхбилэг	Гүйцэтгэх захирлын 2022.05.16-ны өдрийн тушаал
11	Лабораторийн эрхлэгч	Ю.Чулуунцэцэг	Гүйцэтгэх захирлын 2020.06.22-ны өдрийн тушаал

2.2. Эрх бүхий албан тушаалтнуудын удирдах чадвар, дадлага туршлагын байдал;

Цээпэл овогтой **Ганбат** нь 1982 онд Увс аймгийн Улаангом сумын 1-р ерөнхий боловсролын сургуульд суралцан төгссөн. 1984-1988 онд ХБНГУ-н Берлин хотод Эдийн засгийн дээд сургуулийг эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн байна. Ц.Ганбат нь 1996-2000 оны хооронд Глобал Инвест ХХК-ийн дэд захирал, 1992-1995 оны хооронд АЗ ББХК-ийн захирлаар тус тус ажиллаж байсан бөгөөд Компанийг 1999 онд үүсгэн байгуулсан хугацаанаас хойш одоог хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Монгол Япон төвөөс зохион байгуулсан "Жижиг дунд үйлдвэрийн газрын менежмент, үнэлгээ" сэдэвт бизнесийн практик сургалтад 2005 оны 3 дугаар сарын 25-ны өдөр, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллагын (JICA) Япон маягийн менежментийн сургалтад 2005 оны 8 дугаар сарын 15-ны өдөр, Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Бизнес төлөвлөгөө боловсруулах" сэдэвт бизнесийн практик сургалтад 2007 оны 12 дугаар сарын 18-с 21-ний өдрүүдэд, "Мэргэн Түшээ" сургалтын төвөөс зохион байгуулсан Төрийн албанд мэргэших 14 хоногийн сургалтуудад тус тус хамрагдаж гэрчилгээ авсан байна.

Цээпэл овогтой **Төгсөө** нь Увс аймаг Улаангом сумын 2-р ерөнхий боловсролын сургуульд 1978-1988 оны хооронд суралцан төгссөн. Бүгд Найрамдах Казахстан Улсын Удирдлагын Академид 1992-1996 оны хооронд Хүнсний бараа судлал мэргэжлээр бакалавр зэрэг эзэмшсэн. 2017 онд Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамны Органик хүнсний баталгаажуулалт сэдэвт сургалтад хамрагдан 63/ОХ/2017/ дугаар гэрчилгээ авсан байна. 1999 оноос одоог хүртэл Компанийн дэд захирал, ерөнхий технологичийн албан тушаал хашиж байна.

Занашир овогтой **Байгалмаа** нь 1982 онд Увс аймгийн Улаангом сумын 1-р ерөнхий боловсролын сургуульд суралцан төгссөн. 1982-1992 онд Эрхүү хотын Политехникийн их сургуулийг инженер, геологич мэргэжлээр бакалавр, магистр зэрэг, Улаанбаатар хотын Отгонтэнгэр их сургуулийг 1996-1999 оны хооронд эрх зүйч мэргэжлээр бакалавр зэрэг тус тус эзэмшжээ. Мөн МҮХАҮТанхим, БНСУлсын Хандонг Олон Улсын хууль зүйн сургуулийн хамтарсан "Оюун өмчийн арбитр" семинарт 2013 оны 6 дугаар сарын 4-ний өдөр, Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтэд "Байгууллагын мэдээлэл солилцооны арга технологи" сургалтад 2014 оны 5 дугаар сарын 5-9-ний өдрүүдэд, Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтэд "Төрийн байгууллагын бүтээмжийн удирдлага" сургалтад 2014 оны 5 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд, Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын харьяа Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтэд "Төрийн байгууллагын үйл ажиллагаанд сошиал медиа хэрэглээ" сургалтад 2014 оны 10 дугаар сарын 30-31-ны өдрүүдэд, Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Ялон маягийн менежмент" сэдэвт суурь мэдлэгийн сургалтад 2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр, ХХААХҮЯамны "Оролцооны баталгаажуулалтын сургалт"-д 2016 оны 10 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд, Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Жижиг дунд аж ахуй нэгжийн менежментийг сайжруулах бизнесийн үндсэн сургалт" сэдэвт удирдлагын менежментийн сургалтад 2022 оны 2 дугаар сарын 12-ны өдөр тус тус суралцжээ.

3.Байгалмаа нь 1988-1992 оны хооронд Эрэл геофизикийн цогцолбор экспедиз-д Инженер, геодези албан тушаал, 1992-1999 оны хооронд Патентын газарт Шинжээч, 1999-2008 оны хооронд Газар шим үйлдвэр ХХК-д Хөрөнгө оруулалтын менежер, 2009-2015 оны хооронд Оюуны өмчийн газарт Улсын хяналтын байцаагч, 2016 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Захиргаа удирдлага хариуцсан захирлаар ажиллаж байна.

Цэрэнчимэд овогтой **Батзаяа** нь 1998-2006 онд Увс аймаг, Завхан сумын 9н жилийн дунд сургуульд, 2006-2008 онд Ховд аймгийн ерөнхий боловсролын сургуульд суралцан төгссөн. 2008-2012 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Хүнсний био технологич мэргэжлээр бакалаврын зэрэг эзэмшсэн байна.

Ц.Батзаяа нь 2022 онд Обсерв Консалтинг ХХК-ийн Удирдлага тогтолцооны дотоод аудитор бэлтгэх /ISO19011:2018/ сургалтад хамрагдан OBC_QMSIA_814 дугаар сертификат, 2019 онд Эс Эф Си Эс ХХК-ийн Хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалт

(18-AG-55-SPP-DON-C-1) сэдэвт сургалтад хамрагдан FSC/SFCS/2019/M2/040 дугаар гэрчилгээ, 2018 онд онд Эс Эф Си Эс ХХК-ийн Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) стандарт хэрэгжүүлэх (Модуль-2) сургалтад хамрагдан ISO9001/M2/2018/006 дугаар гэрчилгээ, 2022 онд Обсерв консалтинг ХХК-ийн Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн онлайн багц сургалтад хамрагдан OBC_FS_079 дугаар сертификат, 2021 онд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн Үйлдвэрийн удирдлага сэдэвт ахисан түвшний сургалтад хамрагдан гэрчилгээ, 2013 онд Монгол-Япон хүний нөөцийн хөгжлийн төвийн Чанарын удирдлагын тогтолцоо сэдэвт сургалтад хамрагдан Гэрчилгээ тус тус авсан байна. 2013 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Ахлах технологичийн албан тушаалд ажиллаж байна.

Дорждагва овогтой **Жаргал** нь 1982-1990 онд Өвөрхангай аймгийн Бүрд сумын ерөнхий боловсролын сургуульд суралцан бүрэн дунд боловсрол, 1990-1993 онд Сэлэнгэ аймгийн Хөдөө Аж Ахуйн Техникумд Мал зүйч мэргэжлээр, 1996-2000 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Түүхий эд судлаач, бүтээгдэхүүний технологич мэргэжлээр бакалаврын зэрэг тус тус эзэмшсэн байна.

Д.Жаргал нь 2017 онд Аюулгүй байдал нэн тэргүүн ТББ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдан 17-14 дугаар сертификат, 2017 онд Эрүүл Мэндийн Яам, Нийгмийн эрүүл мэндийн төвийн хамтарсан Хүнсний бүтээгдэхүүний шошгололтыг олон улсын жишигт нийцүүлэхэд хүнс үйлдвэрлэгчдийн оролцоо дэмжлэг сэдэвт сургалтад хамрагдан 27/17 дугаар гэрчилгээ, 2018 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид мэргэшүүлэх 10 хоногийн сургалтад хамрагдан батламж, 2018 онд Монгол улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Стандарт Хэмжил Зүйн Газарын Хүнсний аюулгүй байдлын удирдлага – Хүнс үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 22000:2007 сэдэвт сургалтад хамрагдан СМЛСҮТ 381/18 дугаар гэрчилгээ, 2018 онд Эс Эф Си Эс ХХК-ийн Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага ISO 17025:2017 (MNS ISO 17025:2018) Стандартын танилцуулах (Модуль-1) сургалтад хамрагдан ISO17025/M1/2018/009 дугаар гэрчилгээ, 2021 онд Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан Үйлдвэрлэлийн удирдлага сэдэвт ахисан түвшний сургалтад хамрагдан гэрчилгээ, 2022 онд Обсерв Консалтинг ХХК-ийн Хүнсний аюулгүй байдал эрүүл ахуй онлайн багц сургалтад хамрагдан OBC_FS_080 дугаар гэрчилгээ, 2022 онд Обсерв Консалтинг ХХК-ийн Удирдлагын тогтолцооны дотоод аудитор бэлтгэх /ISO19011:2018/ сургалтуудад хамрагдан OBC_QMSIA_813 дугаар гэрчилгээ тус тус авсан байна. 1993-2001 оны хооронд Зоонез өвчин судлалын төвд Лаборант, технологич, 2001-2006 онд Монхангай группт Худалдагч, менежер, дэлгүүрийн дарга, 2006-2011 онд БатСарай ХХК-д Дэлгүүрийн зохион байгуулагч, нарийн бичиг, 2011 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Үйлдвэр эрхэлсэн орлогч даргаар ажиллаж байна.

Дүгэржав овогтой **Сэргэлэн** нь 1978-1988 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1989-1995 онд Казахстан улсын Алма-Ата хотын АЗВИ-д Малын эмч, 2012-2014 онд Улаанбаатар хотын Удирдлагын Академид Бизнесийн удирдлага мэргэжлээр бакалавр, тус сургуульд 2015-2016 онд Бизнесийн удирдлага мэргэжлээр магистрын зэрэг эзэмшсэн байна.

Д.Сэргэлэн нь 2017 онд Аюулгүй байдал нэн тэргүүн ТББ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдан 17-12 дугаар сертификат, 2018 онд Анрэйд ХХК-с зохион байгуулсан Сошил медиа, маркетинг, брендингийн сургалтад хамрагдан сертификат, 2018 онд Би Зи Пи ХХК-ийн Сошил медиа маркетинг бизнест үр дүнтэй ашиглах нь сэдэвт сургалтуудад хамрагдан батламж тус тус авсан байна. 2000-2011

онд Газар шим үйлдвэр ХХК-д Борлуулалтын менежер, 2011-2020 онд Маркетинг борлуулалтын албаны дарга, 2020 оноос одоог хүртэл Маркетинг борлуулалт хариуцсан захирлын албан тушаалд ажиллаж байна.

Лхагвасүрэн овогтой **Бүрэнчимэг** нь 1989-1998 онд Завхан аймгийн 1-р ерөнхий боловсролын сургуульд суралцан, 1998-2002 онд Хөдөө Аж Ахуйн Их Сургуульд Нягтлан бодогч мэргэжлээр бакалавр зэрэг эзэмшсэн байна. 2004-2015 онд Завхан аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн төсөвт байгууллагын нягтлан бодогч, 2015-2018 онд Завхайн аймгийн Засаг даргын тамгын газарт Санхүүгийн албаны дарга буюу ерөнхий нягтлан бодогч, 2018-2020 онд Алтан Жолоо ХХК-д Үндсэн хөрөнгө, зардлын нягтлан бодогч, 2020-2021 онд Газар Шим Үйлдвэр ХХК-ийн Цалин, НӨАТ хариуцсан нягтлан бодогч, 2022 онд Газар Шим Үйлдвэр ХХК-ийн ахлах нягтлан бодогч, 2022 оны 10-р сараас одоог хүртэл тус компанийн Ерөнхий нягтлан бодогчийн албан тушаалд ажиллаж байна.

Л.Бүрэнчимэг нь 2022 оны 03-р сарын 11-ний өдөр Удирдлагын тогтолцооны дотоод аудитор бэлтгэх /ISO19011:2018/ сургалтад хамрагдан OBC_QMSIA_826 дугаар сертификат авсан байна. Мөн Сангийн Сайдын 2022 оны 07-р сарын 07-ны өдрийн 148 тоот тушаалаар "Татварын мэргэшсэн зөвлөх" эрх авсан байна.

Мөнхнасан овогтой **Нямсанж** нь 1991-2001 онд Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуульд суралцан бүрэн дунд боловсрол эзэмшин 2003-2007 онд Дархан хотын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Цахилгааны инженер мэргэжил эзэмшсэн.

М.Нямсанж нь 2020 онд Жи То Жи сургалтын төвийн Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо – Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавих шаардлага ISO 22000:2018 (MNS ISO 22000:2019) стандартын дотоод аудитын (Модуль-2) сургалтад хамрагдан ISO22000/M2/2020/005 дугаар гэрчилгээ, 2020 онд Жи То Жи сургалтын Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо – Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавих шаардлага ISO 22000:2018 (MNS ISO 22000:2019) стандартын дотоод аудитын (Модуль-3) сургалтад хамрагдан ISO22000/M3/2020/005 дугаар гэрчилгээ, 2014 онд АНУ дахь Өу Эс Эч Академийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний багц сургалтад хамрагдан DB84102812 дугаар сертификат, 2015 онд Баянгол дүүргийн Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс болон Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн холбооны Үйлдвэрийн газрын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сэдэвт сургалтад хамрагдан HS-03-1034 дугаар гэрчилгээ, 2021 онд Монгол-Япон хүний нөөцийн хөгжлийн төвийн Үйлдвэрлэлийн удирдлага сэдэвт ахисан түвшний сургалтад хамрагдан гэрчилгээ,2022 онд Обсерв Консалтинг ХХК-ийн Удирдлагын тогтолцооны дотоод аудитор бэлтгэх /ISO19011:2018/ сургалтад хамрагдан OBC_QMSIA_806 дугаар сертификат, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн хамтран зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтны мэргэшүүлэх сургалтад хамрагдан 20220294 дугаар сертификат тус тус авсан байна. 2008-2011 онд АНУ Сервис, MFX Капитал ХХК-д Цахилгаанчин, 2011-2013 онд Катод Гал ХХК-д Цахилгааны инженер, 2011 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Ерөнхий инженерийн албан тушаалд ажиллаж байна.

Батболд овогтой **Энхбилэг** нь 2009-2011 онд Баянхонгор аймгийн 1-р ерөнхий боловсролын сургуульд суралцан бүрэн дунд боловсрол, 2011-2015 онд Удирдлагын Академид Удирдлагын менежмент мэргэжлээр суралцан төгссөн байна. 2016-2017 онд Мобиком ХХК-д Харилцагчийн үйлчилгээний менежер, 2017-2021 онд Хасбанк ХХК-д

Харилцагчийн үйлчилгээний менежер, 2021 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер албан тушаалд ажиллаж байна.

Б.Энхбилэг нь АНУ-ын соёлын солилцооны хөтөлбөрт 2016-2017 онд, Бүгд Найрамдах Солонгос улсын соёлын солилцооны хөтөлбөрт 2018-2019 онд хамрагдаж, TOPIK 6-р түвшин, 2022 онд Монгол-Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвөөс зохион байгуулсан "Үйлдвэрлэлийн удирдлага" сэдэвт ахисан түвшний сургалт, Компанийн засаглалын хөгжлийн төв, МҮХАҮТанхимын "Компанийн засаглалын гэрчилгээ" олгох сургалт, Компанийн засаглалын хөгжлийн төвийн "ТУЗ-ийн нарийн бичгийн дарга"-ын дипломын сургалтад тус тус хамрагджээ.

Чүлтэм овогтой **Оюунбилэг** нь 1973-1983 онд Улаанбаатар хотын Налайх дүүргийн 10 жилийн 1 дүгээр дунд сургуульд суралцан бүрэн дунд боловсрол эзэмшин 1983-1984 онд Улаанбаатар хотын Хүнсний үйлдвэрийн ТМС-д Тоног төхөөрөмжийн засварчин мэргэжил, 1988-1996 онд Москва хотын Москванийн Биотехнологийн академид Хүнсний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн механик инженер мэргэжлээр магистр зэрэг эзэмшсэн байна.

Ч.Оюунбилэг нь 2015 онд Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төвийн хамтран зохион байгуулсан Барилгын салбарын аж ахуйн ажил болон сургалт зохион байгуулах мэдлэг ур чадвар олгох, чадавхжуулах 14 өдрийн сургалтад хамрагдан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, сургагч багшийн ХАБЭАА-12-796 дугаар гэрчилгээ, 2015 онд Эс Эф Си Эс ХХК, Уул уурхай хүний нөөцийн хөгжил ТББ-ийн хамтран зохион байгуулсан Чанарын удирдлагын тогтолцоонд ISO 9001:2015 стандартын дагуу дотоод аудит хийх арга зүйн 3 өдрийн сургалтад хамрагдан 051 дугаар гэрчилгээ, 2015 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Монгол ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Барилгын талбайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах нь сэдэвт сургалтад хамрагдан 2015/W0010 дугаар гэрчилгээ, 2016 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн мэргэжилтний сургалтад хамрагдан Монгол улсын Хөдөлмөрийн Яамнаас олгосон 20-6/84,2015-06-18 дугаар Хүрэл сертификат, 2017 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтний сургалтад хамрагдан Монгол улсын Хөдөлмөрийн Яамнаас олгосон 20-6/84,2015-0618 дугаар Мөнгөн сертификат, 2018 онд Эс Эф Си Эс ХХК-ийн зохион байгуулсан Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 (MNS ISO 9001:2016) стандарт хэрэгжүүлэх (Модуль-2) сургалтад хамрагдан ISO9001/M2/2018/010 дугаар гэрчилгээ, 2018 онд Монгол улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Стандарт Хэмжил Зүйн Газар зохион байгуулсан Хүнсний аюулгүй байдлын удирдлага- хүнс үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавих шаардлага MNS ISO/IES 22000:2007 сургалтад хамрагдан СМЛСҮТ 382/18 дугаар гэрчилгээ, 2018 Байгаль орчин, аялал жуулчлалын яам зохион байгуулсан Бохирдуулах бодисын ялгарал, шилжилтийн үндэсний бүртгэлийн тогтолцоог нэвтрүүлэх сургалтад хамрагдан гэрчилгээ, 2018 онд Эс Эф Си Эс ХХК-ийн Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын тэргүүлэх аудитор/ аудиторын сургалтад хамрагдан ISO 9001-M4/2018/012 дугаар, 2019 онд Эс Эф Си Эс ХХК-ийн Хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалт (18-AG-55-SSP-DON-C-1) сэдэвт сургалтад хамрагдан FSC/SFCS/2019/M2/008 дугаар гэрчилгээ, 2022 онд Обсерв консалтинг ХХК-н Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуй онлайн багц сургалтад хамрагдан OBC_FS_084 дугаар сертификат тус тус авсан байна. 1984-1987 онд Архи пивоны үйлдвэрт Тоног төхөөрөмжийн засварчин, 2012-2018 онд Зун Шин Барилга угсралтын компанид ХАБЭА-н албаны дарга, 2018 оноос одоог хүртэл Газар шим үйлдвэр ХХК-д Чанар Хяналтын албаны дарга албан тушаалд ажиллаж байна.

Юра овогтой **Чулуунцэцэг** нь 1993-2001 онд Өмнөговь аймгийн Булган сумын 8-н жилийн сургууль, 2001-2003 онд Өмнөговь аймгийн 1-р арван жилийн сургуульд Бүрэн дунд

боловсрол, 2004-2009 онд Улаанбаатар хотын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуульд Хүнсний микробиологич мэргэжлээр бакалавр зэрэг эзэмшсэн байна.

Ю.Чулуунцэцэг нь 2016 онд Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлах лаборатори, Монголын микробиологийн нийгэмлэгийн хамтран зохион байгуулсан Микробиологийн шинжилгээний стандарт сэдэвт сургалтад хамрагдан 010 (196/ 2.0) дугаар сертификат, 2017 онд Монгол улсын Засгийн Газрын тохируулагч агентлаг Стандарт Хэмжил Зүйн Газарын Чанарын менежментийн тогтолцоо- MNS ISO 9001:2016, Дотоод аудит явуулах арга зүй сэдэвт сургалтад хамрагдан СМЛСҮТ 389/17 дугаар гэрчилгээ, 2018 онд Мэргэжлийн Хяналтын ерөнхий газар Хүнсний аюулгүй байдлын үндэсний лабораторийн Хяналтын итгэмжлэгдсэн лабораторийн нэгдсэн сүлжээний Эрхлэгч нарын сургалтад хамрагдан батламж, 2018 онд Счэлтек Лабораторийн Перкин Элмерийн аналитик тоног төхөөрөмжийн семинарт хамрагдан сертификат, 2019 онд Стандарт хэмжил зүйн газрын Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавигдах шаардлага MNS ISO/IEC 17025:2018 сэдэвт сургалтад хамрагдан СМЛСҮТ 1193/19 дугаар гэрчилгээ, 2020 онд Жи То Жи сургалтын төвийн Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо- Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавигдах шаардлага ISO 22000:2018 (MNS ISO 22000:2019) стандартын хэрэгжүүлэх арга зүй (Модуль-2) сургалтад хамрагдан ISO22000/M2/2020/012 дугаар гэрчилгээ, 2020 онд Жи То Жи сургалтын төвийн Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо- Хүнсний үйлдвэрлэлийн хэлхээн дэх аливаа байгууллагад тавигдах шаардлага ISO 22000:2018 (MNS ISO 22000:2019) стандартын хэрэгжүүлэх арга зүй (Модуль-3) сургалтад хамрагдан ISO22000/M3/2020/002 дугаар гэрчилгээ, 2022 онд Обсерв Консалтинг ХХК-ийн Удирдлагын тогтолцооны дотоод аудитор бэлтгэх /ISO19011:2018/ сургалтад хамрагдан OBC_QMSIA_818 дугаар сертификат тус тус авсан байна. 2010-2016 онд АПУ ХХК-д Оператор, 2016-2018 онд Монжүүс ХХК-д Микробиологич, 2018-2020 онд Дөрвөн Өлзий ХХК-д Чанарын менежер, 2020 оноос одоог хүртэл Газар Шим Үйлдвэр ХХК-д Лабораторийн эрхлэгчийн албан тушаалд ажиллаж байна.

2.3. Тохиромжтой этгээдийг тодорхойлсон журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх;

Хуулийн дүгнэлтийн Хүснэгт№3-оор тодорхойлсон Компанийн эрх бүхий албан тушаалтнуудаар Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор батлагдсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.2-т заасан шаардлагын хүрээнд тус журмын хавсралтаар баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулга”-ыг нэг бүрчлэн бөглүүлж, шалгуур үзүүлэлт тус бүрээр дүн шинжилгээ хийж үзлээ.

2.3.1. Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх;

Хүснэгт №4

№	Эрх бүхий албан тушаалтан	Томилогдсон этгээд	Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой	Хорооноос хүлээн зөвшөөрсөн сургалтад сууж, гэрчилгээ авсан
1.	Ерөнхий захирал	Ц.Ганбат	Тийм	Компанийн засаглалын үндэсний зөвлөл 2022.10.07 Дугаар:0731477
2.	Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий технологич	Ц.Төгсөө	Тийм	Компанийн засаглалын үндэсний зөвлөл 2022.10.07 Дугаар:0731483

3.	Захиргаа, удирдлага хариуцсан захирал	З.Байгалмаа	Тийм	Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн 2022.11.09 Дугаар: 0731494
4.	Маркетинг, борлуулалт хариуцсан захирал	Д.Сэргэлэн	Тийм	Компанийн засаглалын үндэсний зөвлөл 2022.10.07 Дугаар:0731475
5.	Ерөнхий нягтлан бодогч	Л.Бүрэнчимэг	Тийм	Компанийн засаглалын үндэсний зөвлөл 2022.10.07 Дугаар:0731474
6.	Үйлдвэрийн дарга	Д.Жаргал	Тийм	-
7.	Ерөнхий инженер	М.Нямсанж	Тийм	-
8.	Чанар хяналтын албаны дарга	Ч.Оюунбилэг	Тийм	-
9.	Ахлах технологич	Ц.Батзаяа	Тийм	-
10.	Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер	Б.Энхбилэг	Тийм	Компанийн засаглалын үндэсний зөвлөл 2022.10.07 Дугаар:0731478
11.	Лабораторийн эрхлэгч	Ю.Чулуунцэцэг	Тийм	-

2.3.2. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх шаардлагын хүрээнд;

Хүснэгт №5

№	Эрх бүхий албан тушаалтан	Томилогдсон этгээд	Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбоотойгоор эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээгээгүй байх[16]	Эрүүгийн хуульд заасан болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль, эдийн засгийн гэмт хэрэг, зөрчилтэй холбогдон шалгагдах болон шүүх хуралд шүүгдэгчээр, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд сэжиглэгдэж байгаа эсэх[17]
1.	Ерөнхий захирал	Ц.Ганбат	Тийм	Үгүй
2.	Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий технологич	Ц.Төгсөө	Тийм	Үгүй
3.	Захиргаа, удирдлага хариуцсан захирал	З.Байгалмаа	Тийм	Үгүй
4.	Маркетинг, борлуулалт	Д.Сэргэлэн	Тийм	Үгүй

[16] Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгад тусгасан мэдээлэл болон Мөн E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал сангаас "эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт зэргийг үндэслэв.

[17] Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгад тусгасан мэдээлэл болон Мөн E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн портал сангаас "эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт зэргийг үндэслэв.

	хариуцсан захирал			
5.	Ерөнхий нягтлан бодогч	Л.Бүрэнчимэг	Тийм	Үгүй
6.	Үйлдвэрийн дарга	Д.Жаргал	Тийм	Үгүй
7.	Ерөнхий инженер	М.Нямсанж	Тийм	Үгүй
8.	Чанар хяналтын албаны дарга	Ч.Оюунбилэг	Тийм	Үгүй
9.	Ахлах технологич	Ц.Батзаяа	Тийм	Үгүй
10.	Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер	Б.Энхбилэг	Тийм	Үгүй
11.	Лабораторийн эрхлэгч	Ю.Чулуунцэцэг	Тийм	Үгүй

2.3.3. Ёс зүйн нэр хүндтэй байх шаардлагын хүрээнд;

Хүснэгт №6

№	Эрх бүхий албан тушаалтан	Томилогдсон этгээд	сүүлийн 1 жилийн хугацаанд өөрийн бууцтай үйлдлээс, салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс үүдэн ажлаас халагдах арга хэмжээ авуулаагүй байх;	санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой үүссэн гомдлын гол бууцтан байсан эсэх;	сүүлийн 1 жилийн хугацаанд салбарын ёс зүйн хэм хэмжээг зөрчөөгүй байх;	Монгол Улс болон гадаад улсын нутаг дэвсгэрт хууль, журам, бизнесийн ёс зүй, дүрмийг зөрчсөн эсэх, бусдад энэхүү үйлдлийг хийхэд тусалсан хэрэгт холбогдоогүй байх;	Монгол Улсын болон гадаад улсын нутаг дэвсгэрт зохицуулалтын аливаа шаардлагыг хангахад, эсхүл мэргэжлийн болон ёс зүйн аливаа стандартыг дагаж мөрдөхөд бэлэн байх.
1.	Ерөнхий захирал	Ц.Ганбат	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
2.	Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий технологич	Ц.Төгсөө	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
3.	Захиргаа, удирдлага хариуцсан захирал	З.Байгалмаа	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
4.	Маркетинг, борлуулалт хариуцсан захирал	Д.Сэргэлэн	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
5.	Ерөнхий нягтлан бодогч	Л.Бүрэнчимэг	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
6.	Үйлдвэрийн дарга	Д.Жаргал	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм

7.	Ерөнхий инженер	М.Нямсанж	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
8.	Чанар хяналтын албаны дарга	Ч.Оюунбилэг	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
9.	Ахлах технологич	Ц.Батзаяа	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
10.	Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер	Б.Энхбилэг	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
11.	Лабораторийн эрхлэгч	Ю.Чулуунцэцэг	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм

2.3.4. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлагын хүрээнд;

Хүснэгт №7

№	Эрх бүхий албан тушаалтан	Томилогдсон этгээд	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 21, 22 дугаар зүйлд харшлаагүй байх;	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д заасан санхүүгийн үйлчилгээнд хамаарах үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль журамд харшлаагүй байх;
1.	Ерөнхий захирал	Ц.Ганбат	Тийм	Тийм
2.	Үйлдвэрлэл хариуцсан захирал бөгөөд Ерөнхий технологич	Ц.Төгсөө	Тийм	Тийм
3.	Захиргаа, удирдлага хариуцсан захирал	З.Байгалмаа	Тийм	Тийм
4.	Маркетинг, борлуулалт хариуцсан захирал	Д.Сэргэлэн	Тийм	Тийм
5.	Ерөнхий нягтлан бодогч	Л.Бүрэнчимэг	Тийм	Тийм
6.	Үйлдвэрийн дарга	Д.Жаргал	Тийм	Тийм
7.	Ерөнхий инженер	М.Нямсанж	Тийм	Тийм
8.	Чанар хяналтын албаны дарга	Ч.Оюунбилэг	Тийм	Тийм
9.	Ахлах технологич	Ц.Батзаяа	Тийм	Тийм
10.	Захиргаа, хүний нөөцийн ахлах менежер	Б.Энхбилэг	Тийм	Тийм
11.	Лабораторийн эрхлэгч	Ю.Чулуунцэцэг	Тийм	Тийм

Явцын дүгнэлт: *Эрх бүхий албан тушаалтнууд нь СЗХ-ооc батлагдсан Тохиромжтой этгээдийг тодорхойлсон журамд заасан шаардлагыг хангасан байна.*

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДҮРЭМ, ДОТООД ЖУРМУУД НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

3.1. Компанийн дүрэм нь КтХ-ийн шаардлагад нийцсэн эсэх талаар:

Компанийн энэхүү Дүгнэлт гарах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм (“**Дүрэм**”)-ийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 11-р сарын 08-ний өдрийн 05 тоот тогтоолоор баталж, 2022 оны 11-р сарын 13-ны өдөр ХЭУБ-т бүртгүүлсэн байна.

Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “*Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана*” гэж аливаа нэг Компанийн дүрэмд тавигдах шаардлагыг тавьсан байна. Үүнд:

- Компанийн бүрэн болон товчилсон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;
- Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- Компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;
- Хэрэв Төлөөлөн Удирдах зөвлөлтэй (ТУЗ) байхаар шийдвэрлэсэн бол ТУЗ гишүүдийн тоо;
- Компанийн үйл ажиллагааны чиглэл;
- Компанийн дүрэмд тусгахаар энэ зүйлд заасан бусад зүйл.

Хуулийн дээрх шаардлагын дагуу Компанийн Дүрэм нь дор дурдсан 12 зүйлтэй байхаар тогтоолоор баталсан байна. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл;
2. Компанийн эрх;
3. Компанийн үүрэг;
4. Компанийн хариуцлага;
5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө;
6. Компанийн удирдлага;
7. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх;
8. Гүйцэтгэх удирдлага;
9. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт;
10. Компанийг өөрчлөн байгуулах;
11. Компанийн татан буулгах;
12. Бусад зүйл гэсэн дараалаар холбогдох харилцааг зохицуулж байна.

Ийнхүү Дүрмийн 1-р зүйл Нийтлэг үндэслэлийн 1.1 дэх хэсэгт Компанийн оноосон нэр Монголоор “Газар шим Үйлдвэр” ХХК, англиар “Gazar Shim industry” LLC болох талаар, 1.2 дах хэсэгт Компанийн оршин байгаа газрын хаяг Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс 66/1, 66/2 тоотод байрлах талаар, 1.4 дэх хэсэгт компанийн үйл ажиллагааны чиглэлийг жагсаан тусгаж, үйл ажиллагааг эрхлэх талаар, 1.5 дахь хэсэгт тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрлийг бичгээр авах талаар, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөг ба нэг бүр нь 0.11 (тэг зууны арван нэг) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,000,000,000(нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байгаа талаар, 6 дугаар

зүйлд Компанийн эрх барих дээд байгууллага нь Компанийн ХЭХ-ын эрх хэмжээний талаар болон бусад асуудлыг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан батлсан нь хуулийн дээрх шаардлагад нийцсэн байна.

3.2. Компанийн үйл ажиллагааны баримт бичгүүд нь хуульд нийцэж буй эсэх талаар:

Энэ асуудлын хүрээнд (i) Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах журмын талаар, (ii) Компанийн дотоод үйл ажиллагаанд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад журмын талаар (iii) Компанийн дотоод үйл ажиллагаанд зайлшгүй мөрддөг стандарт, заавар, үйлдвэрлэлийн зохистой дадал, төлөвлөгөө нь хууль тогтоомж, стандартад нийцэж буй эсэх гэсэн 3 бүлэг болгон, дүн шинжилгээ хийлээ.

3.2.1. Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцтэй холбоотой журмууд нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх талаар;

3.2.1.1. Хөдөлмөрийн дотоод журам нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх:

Компани нь Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчлэн найруулсан/ 122 дугаар зүйлийн 122.1[18] дэх хэсэгт заасан шаардлагад нийцүүлэн Хөдөлмөрийн дотоод журам (**"Журам"**)-ын төслийг боловсруулсан байна.

Журмын төслөөр хөдөлмөрийн харилцааны зохион байгуулалт, орон тоо төлөвлөлт, хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, ажил, амралтын горим, хангамж, хөдөлмөрийн сахилга, хариуцлага, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох, цуцлах, ажил хүлээлцэх зэрэг асуудлыг тус тус зохицуулсан нь хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

Ажилтанд өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах, нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах, үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах, албан тушаал бууруулах, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн эрхлэлтийн харилцааг цуцлах хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн нэрлэн заасан боловч Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1[19] дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн сахилгын зөрчил нь зөвхөн дотоод журамд зааснаар хязгаарлахгүй бөгөөд сахилгын зөрчлийн шинж, үр дагаварт тохируулан дээр дурдсан сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэж болохыг зөвлөж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3[20] дахь заалт, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 05-р сарын 25-ны өдрийн А/110 дугаар тушаалын Хавсралтаар батлсан "Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар" -ын 1 дүгээр зүйлийн 1.1 [21]-т ажил олгогч ажилтны хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

---

[18] Хөдөлмөрийн тухай хуулийн 122. Хөдөлмөрийн дотоод журам
122.1. Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.

[19] Хөдөлмөрийн тухай хуулийн 123. Хөдөлмөрийн сахилгын шийтгэл
123.1. Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны бүруутай үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцно.

[20] Хөдөлмөрийн тухай хуулийн 43. Ажил олгогчийн үндсэн эрх, үүрэг
43.3. Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

[21] Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтны ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ

Тиймээс уг асуудлаар болон ажилтантай хөдөлмөр гэрээ байгуулах, үүнд: хөдөлмөрийн хугацаатай болон хугацаагүй гэрээний зохицуулалт, ажилтан ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзах эрх, ажил үүрэг гүйцэтгэхийг түдгэлзүүлэх, ажилтнаар хэд хэдэн ажил үүрэг зэрэг гүйцэтгэх, зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулах, сэлгэн ажиллуулах, өөр ажилд түр шилжүүлэх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн харилцаа өөрчлөгдөх, үргэлжлэх үе шат, хөдөлмөрийн гэрээний төрөл, ажилтны ажил үүргийн онцлогоос хамааран үл өрсөлдөх үүрэг, зарим бүлгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, ажил олгогчийн хүлээх хариуцлага тухайлбал цалин хөлсийг тогтоосон хугацаанд олгоогүй үед алданги тооцох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас ажилтанд учирсан хохирлыг нөхөн төлөх (төлбөрийн хэмжээ), хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцалсны тэтгэмж, хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулалтын талаар тус тус зохицуулаагүй байх тул энэ талаарх зохицуулалтыг журамд тусгаж, илүү сайжруулах шаардлагатай гэж үзлээ.

Явцын дүгнэлт: *Хөдөлмөрийн дотоод журам нь хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа боловч хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулагдах зарим харилцааг орхигдуулсан байх тул холбогдох зохицуулалтыг оруулахыг зөвлөж байна.*

3.2.1.2. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, хүний нөөцөд хамаарах бусад журмууд нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх;

Компани нь байгууллагын хөдөлмөрийн эрхлэлтийн харилцаанд Хөдөлмөрийн дотоод журмаас гадна дараах 7 журмыг батлан мөрдүүлж байна. Үүнд:

- Цалин хөлс, олговор тооцон олгох журам;
- Ажилтны мэргэжил ур чадварын түвшин тогтоох журам;
- Гүйцэтгэлийн үнэлгээний журам;
- Ажилтны сургалт хөгжлийн журам;
- Хүний нөөцийн үйл ажиллагааны бүрдүүлэлт, сонгон шалгаруулах журам;
- Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм;
- Ажлын байрны хүчирхийлэл, дарамт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсох, энэ талаар гомдол гаргах ба хүлээн авч шийдвэрлэх журам.

Холбогдох журмаас онцгойлон дурдвал шинэчлэн боловсруулсан "Цалин хөлс, олговор тооцон олгох журам"-ыг баталсан байх бөгөөд журмаар Компанийн бүтэц, орон тоотой уялдуулан ажил, албан тушаалыг зэрэглэх, тохирсон цалингийн суурийг тодорхойлох, хөдөлмөрийн гэрээ, хөлсөөр ажиллах болон бусад төрлийн гэрээний үндсэн ажиллаж байгаа ажилтны цалин хөлсийг олгох, нэмэгдүүлэх, өөрчлөх, тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахаар тусгасан нь Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Журам нь нийтлэг үндэслэл, цалин хөлс олгох зарчим, үндсэн цалин, ажил албан тушаалын түвшин, зэрэглэл тогтоох, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал тогтоох, олговор, тэтгэмжүүд, сул зогсолтын үеийн олговор, цагийн бүртгэл, тайлан, чөлөө авах, ээлжийн амралт, цалин хөлс тооцоолол, шимтгэл суутгал, оролцогчдын эрх, үүрэг, цалингийн нууцлал, бусад гэсэн 8 бүлэг, зүйлтэй бөгөөд холбогдох хууль, тогтоомжийг зөрчөөгүй байна.

Ерөнхий захирлын 2022 оны 09-р сарын 10-ны өдрийн А/29 тоот тушаалын хавсралтаар "Ажлын байрны хүчирхийлэл, дарамт, бэлгийн дарамтаас урьдчилан

сэргийлэх, таслан зогсоох, энэ талаар гомдол гаргах буюу хүлээн авч шийдвэрлэх журам"-ыг баталсан байна. Тус журмаар компанийн хэмжээнд дарамт, хүчирхийллээс ангид орчин бүрдүүлэх, эдгээрийг үл тэвчих хандлага төлөвшүүлэхэд ажил олгогч ба ажилтны оролцоо, хүлээх үүрэг, эдлэх эрх, гомдлыг зөвлөлөөр шийдвэрлэх, ажилтанд ногдуулах ёс зүйн ба сахилгын хариуцлага, гомдлыг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг асуудлыг тусгасан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 6, 7 дугаар зүйлд заасантай нийцэж байна.

Ерөнхий захирлын 2022 оны 06-р сарын 02-ны өдөр баталж хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Ажилтны мэргэжил ур чадварын түвшин тогтоох журам"-аар ажилчдын ур чадварын түвшин тогтоох, үнэлэх, үнэлэлт дүгнэлт өгөх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, мэдлэг, ур чадвар, гүйцэтгэлийн чанарт суурилсан албан тушаалын зэрэг, зэргийн шатлалыг ахиулах, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх, комиссын гүйцэтгэх үүрэг зэрэг харилцааг зохицуулсан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.2 дахь хэсэг[22]-т заасантай нийцсэн байна.

Шинэчлэн боловсруулсан "Гүйцэтгэлийн үнэлгээний журам" нь нийтлэг үндэслэл, ажлын гүйцэтгэлийг төлөвлөх үйл явц, гүйцэтгэлийн үнэлгээнд оролцогч талуудын эрх, үүрэг, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, үнэлэх, аргачлал, гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал олгох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн дээр суурилан авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцлага, мэдээллийн нууц гэсэн 8 бүлэгтэй байхаар зохицуулсан нь хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Ерөнхий захирлын 2019 оны 09-р сарын 25-ны өдрийн Б/231а тоот тушаалын Хавсралтаар "Ажилтны сургалт хөгжлийн журам"-ыг баталсан ба журмаар Компанийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн болон ерөнхий ур чадвартай, зөв хандлагатай ажилтнуудыг бэлтгэн сургаж, хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан нь хуульд нийцэхээс гадна, ажилтнуудын мэдлэг, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх давуу тал болсон байна.

Ерөнхий захирлын 2021 оны 12-р сарын 01-ний өдрийн А/26-b тоот тушаалын Хавсралтаар "Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм"-ийг баталсан нь Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 156 дугаар зүйлийн 156.1[23] дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 153-р тогтоолоор баталсан "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм"-д "*...20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж байгууллагад байгуулна"* гэж заасныг зөрчөөгүй, хуулийн шаардлагыг хангаж байна.

Журмаар зохицуулах харилцаа нь хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх чиг үүрэг бүхий хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг байгуулах, уг комиссоор хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохицуулах бөгөөд журмыг Засгийн газрын 2022 оны 153-р тогтоолоор баталсан "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын дүрэм"-д нийцүүлж, комиссыг нийт ажилчдын хурлаар сонгогдсон ажил олгогч, ажилтны төлөөллөөс бүрдсэн 4 ба түүнээс дээш тооны бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатайгаар байгуулахыг зөвлөж байна.

Явцын дүгнэлт: *Хөдөлмөрийн дотоод журмаар нарийвчлан зохицуулах боломжгүй бусад хөдөлмөр эрхлэлтийн харилцааг холбогдох журмуудаар зохицуулж байгаа нь сайн талтай байна.*

---

[22] Хөдөлмөрийн тухай хуулийн 80. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах
80.1.2.ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн хувьд гүйцэтгэж байгаа ажил үүрэгтээ тэнцэхгүй болох нь тогтоогдсон. Энэ тухай ажилтанд өмнө нь анхааруулж, мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлээ сайжруулах боломжит хугацаа олгосон байвал зохино;

[23] Хөдөлмөрийн тухай хуулийн 156. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс.
156.1. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус байнгын ажиллагаатай комиссыг 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад байгуулна.

СЗХ
он 2 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

БҮРТГЭВ-03

3.2.2. Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмууд нь хууль хуульд нийцэж буй эсэх:

3.2.2.1. Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж буй бусад журам:

Компани нь дотоод үйл ажиллагаандаа хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөөс гадна дор дурдсан журмуудыг мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Оффисын үйл ажиллагааны журам;
- Баримт бичгийг боловсруулах, батлах, хянан, мэдээлэх журам;
- Нууц мэдээ, материалтай харьцах, хадгалах, хамгаалах тухай журам;
- Ёс зүйн дүрэм;
- Архивын үйл ажиллагааны журам;
- Гомдол, санал шийдвэрлэх журам;
- Шалган нэвтрүүлэх журам;
- Дотоод хяналтын журам;
- Аюулгүй байдлын албаны ажиллах журам.

Эдгээр журмуудаас онцгойлон дурдвал Ерөнхий захирлын 2020 оны 08-р сарын 12-ны өдрийн 02/31 тоот тушаалын Хавсралтаар "Оффисын үйл ажиллагааны журам"-ыг баталсан байх журмаар зохицуулагдах харилцаа нь ажилчдыг тохилог, цэвэр, аюулгүй ажлын байраар хангах буюу галын аюулгүй байдал, тохижилт, ариун цэврийн болон орчны нөхцөлийг сайжруулах үүрэг хүлээх бөгөөд Компанийн нийт ажилтан албан тасалгаанд цэвэрч нямбай, дэг журамтай, ажил хэрэгч хамтран ажиллагсдаа хүндэтгэн ажиллах харилцааг өгсөн нь хууль зөрчөөгүй байна.

Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, нэр томьёо, тодорхойлолт, ажлын байранд баримтлах зарчим, ажлын байрны ашиглалт, талуудын эрх, оффисын ажилтнуудын эрх, үүрэг, хяналт шалгалт гэсэн 6 зүйлтэй бөгөөд ажлын байранд баримтлах зарчимд оффист нэвтрэх дэг, оффисоос гарах дэг, ажилтны албан харилцаа, утсан харилцаа, хувцаслалт, ажлын цаг ашиглалт, хурал, уулзалтын дэг, материал танилцуулах, Хүнсний аюулгүй байдал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах, ажилчдын хоолны зохион байгуулалт зэрэг асуудлыг тусгасан байх бөгөөд эдгээр асуудлыг Компанийн хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулах боломжтой гэж үзэж байна. Учир нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10[24] дах хэсэгт заасны дагуу байгууллагын дотоодод холбогдох журмыг баталж мөрдүүлэхийг хуулиар хориглоогүй боловч нэгдсэн 1-3 журмаар зохицуулах нь илүү давуу талтай бөгөөд ажилтан олон журмын зохицуулалтыг хольж будилах, төөрөгдөл үүсэх зэрэг сул талтайг цаашид үйл ажиллагаанд анхаарч ажиллахыг зөвлөж байна.

Ерөнхий захирлын 2021 оны 02-р сарын 03-ны өдөр баталсан "Гомдол, санал шийдвэрлэх журам"-аар байгууллагын үйл ажиллагаа болон лабораторийн шинжилгээний ажлын чанар болон бусад асуудлаар захиргаа, албан тушаалтанд хандаж байгаа бүхий л санал, гомдлыг хүлээн авах, авах арга хэмжээ, гомдол барагдуулах үйл явц зэргийг тусгасан нь хууль тогтоомжид нийцсэн байна.

[24] Хөдөлмөрийн тухай хуулийн 4. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
4.1.10."хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ" гэж хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо дагаж мөрдөхөөр холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн ажил олгогчоос бичгээр гаргасан баримт.

Ерөнхий захирлын 2019 оны 06-р сарын 01-ний өдрийн 02/57 тоот тушаалын Хавсралтаар "Баримт бичгийг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ыг батлан мөрдүүлж, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах баримт бичгийг боловсруулах, батлах, түгээх, хадгалах, хянах, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг зохицуулсан нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246-р тогтоолын Хавсралтаар баталсан "Албан хэрэг хөтлөлтийн журам"-ыг зөрчөөгүй, хуульд нийцсэн байна. Гэхдээ уг журмыг Ерөнхий захирлын тушаалын Хавсралтаар баталсан нь "Архивын үйл ажиллагааны журам"-тай нэгтгэж, нэг журмаар зохицуулах боломжтой гэж үзэж байна.

Ерөнхий захирлын 2020 оны 01-р сарын 01-ны өдрийн 02/01 тоот тушаалын Хавсралтаар "Архивын үйл ажиллагааны журам"-ыг баталж, Компанийн үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдөх баримт бичгийг эмхлэн цэгцлэх, тоо бүртгэл хөтлөх, лавлах, үйлдэх, хадгалж хамгаалах, ашиглуулах, байнгын хадгалалтад баримт шилжүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулсан нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийг зөрчөөгүй, хуульд нийцсэн байна.

Ерөнхий захирлын баталсан байгууллагын бүх албан тушаалтан, ажилчдын хэмжээнд дагаж мөрдөх "Ёс зүйн дүрэм"-ийг баталж, уг журмаар ёс зүйн хэм хэмжээ, компанийн ажилтан, албан тушаалтны мөрдөх ёс зүйн зарчим, хээл хахууль, авлига, албан тушаалтан, ажилтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах, бэлэг сэлт, шан харамж авах, хандив тусламж, ажилчдын биеэ авч явах зан үйл, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх зэрэг харилцааг зохицуулсан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой болжээ.

Ерөнхий захирлын 2018 оны 08-р сарын 31-ний өдрийн 02/27 тоот тушаалаар "Дотоод хяналтын журам"-ыг баталж, Компанийн дүрэм, журам, Ерөнхий захирлын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, санхүү, өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчилдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг илрүүлж арилгах замаар хууль тогтоомж, стандартыг нийтээрээ хэрэгжүүлдэг хэвшлийг тогтоосон нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй байна.

Шинэчлэн боловсруулсан хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд байгууллагын бүх албан тушаалтан, ажилтнууд дагаж мөрдөх "Нууц мэдээ материалтай харьцах, хадгалах, хамгаалах тухай" журам нь Хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2[25] дахь хэсэгт заасантай нийцсэн байна.

Журмаар байгууллагын нууц бичиг баримт материалыг хадгалах, хяналт тавих, байгууллагын нууц бичиг баримт материалтай танилцах ажилтны эрх, үүрэг, нууцын ангилал, төрөл, нууц баримт баримт бичигтэй танилцах албан тушаалтны хүрээ, нууц баримт бичиг, материал боловсруулах, олшруулах, нууц бичиг, материалыг хүлээн авах, бүртгэх, байгууллагын нууц задрах, нууц баримт материал үгүй болоход арга хэмжээ, хариуцлагын харилцааг тус тус зохицуулж, Хавсралтаар ажилтантай байгуулах "Нууц хадгалах гэрээ"-г баталсан нь хууль тогтоомжид нийцжээ.

Ерөнхий захирлын 2019 оны 07-р сарын 25-ны өдрийн 02/68 тоот тушаалаар "Аюулгүй байдлын албаны ажиллах журам"-ыг баталж, уг журмаар аюулгүй байдлын албаны албан хаагч харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байх үед объектуудын аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах, өмч хөрөнгийн хадгалалт бүрэн бүтэн байдалд хараа хяналт тавих, түүнийг үрэгдүүлэн шамшигдуулах, алдагдахаас сэргийлэх, гал түймэр болон байгалийн

[25] Хөдөлмөрийн тухай хуулийн 74. Ажилтны нууц хадгалах үүрэг
74.2. Аж ахуйн нэгж, байгууллагын нууц хадгалах, нууцтай харьцах журмыг ажил олгогч батлах болно.

гэнэтийн аюул, гаднын халдлагаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан нь хууль тогтоомжийг зөрчөөгүй байна.

Компанийн "Шалган нэвтрүүлэх журам"-аар байгууллагын оффис болон үйлдвэрийн объектод ажилтан, иргэд нэвтрэх үйл ажиллагаа, хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор уг журмыг баталж мөрдүүлсэн нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй байна.

3.2.2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах журам:

Компани нь дотоод үйл ажиллагаанд мөрдөж байгаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах нийт 8 журам, дүрмийг Хуульчдад ирүүлсэн байна. Үүнд:

1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам;
2. ХАБЭА-н хяналтын тухай журам;
3. Хими, нян судлалын лабораторид ажиллагсдын аюулгүй ажиллагааны журам;
4. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг олгох, ашиглах журам;
5. Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин судлах бүртгэх журам;
6. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын ажиллах журам;
7. ХАБЭА-н сургалт зааварчилгаа явуулах, шалгалт авах журам;
8. Хүнсний аюулгүй байдлын багийн дүрэм.
9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дүрэм.

Компани нь үйл ажиллагаандаа дээр дурдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд хамаарах журам, дүрмийг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудад нийцүүлэн Ерөнхий захирлын тушаалаар батлан мөрдүүлж байна.

Эдгээр журмаас дурдвал Ерөнхий захирлын 2021 оны 02-р сарын 03-ны өдөр баталсан "Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны журам"-ыг баталсан бөгөөд журмаар хамрах хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, үүрэг хариуцлага, үндсэн үйл ажиллагаа, аюулгүй ажиллагааны заавар, хор саармагжуулах бүтээгдэхүүн, лабораторийн осол гарсан тохиолдолд авах анхан шатны арга хэмжээ, галын аюулгүй ажиллагаа зэрэг харилцааг зохицуулсан нь Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1[26] , Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нийцсэн байна.

Ерөнхий захирлын 2017 оны 02-р сарын 13-ны өдрийн 07/18 тоот тушаалын Хавсралтаар компанийн ажилтнууд үндсэн үйл ажиллагаандаа дагаж мөрдөх "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтын журам"-ыг батлан мөрдүүлж ажиллаж байна. Тус журмаар ХАБАЭ-н хууль тогтоомж, техникийн норм норматив, заавар, шаардлагын болон ХАБАЭ-н талаарх ажил үүргийн биелэлт, ажлын байрны болон ажил гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангаж буй эсэхийг шалгахтай холбоотой харилцааг зохицуулсан нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг зөрчөөгүй, хуульд нийцсэн байна.

Ерөнхий захирлын 2022 оны 07-р сарын 01-ны А/21 тоот тушаалаар "Хүнсний аюулгүй байдлын багийн дүрэм"-ийг баталж мөрдүүлсэн байх ба дүрмээр хүнсний аюулгүй байдлын багийн бүтэц, зохион байгуулалт, гишүүдэд тавигдах шаардлага, багийн үйл ажиллагааны журам, чиг үүрэг, чанарын багийн гишүүдийн эрх, үүрэг, аюулыг хянах төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх үйл явц зэрэг харилцааг зохицуулсан нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй

[26] Хүнсний тухай хууль. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналт.
12.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4[27] , 16 дугаар зүйлийн 16.3[28] , Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлага MNS ISO 22000:2019 стандартад нийцэж байна.

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зааварчилгаа явуулах, шалгалт авах журам"-ыг шинэчлэн боловсруулсан байна. ХАБЭАтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3[29], 28 дугаар зүйлийн 28.1.8[30] дах хэсэгт заасны дагуу ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан, зөвлөлийн чиг үүрэг боловч заавал журам батлах шаардлагагүй тул "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хяналтын тухай журам"-д тусгах, эсхүл хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн багийн чиг үүрэгт энэ талаарх зохицуулалтыг оруулах боломжтой гэж үзэж байна.

Компани нь Ерөнхий захирлын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил үүргийн тухай журам", "Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг олгох, ашиглах журам", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажил үүргийн тухай журам", "Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин судлах бүртгэх журам, "Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссын ажиллах журам", "Хүнсний аюулгүй байдлын багийн дүрэм" зэрэг холбогдох журам, дүрмийг Ерөнхий захирлын тушаалаар баталж, мөрдүүлж байгаа нь хуульд нийцэж байгаа боловч хуульд тусгагдсан асуудлыг хэт олон, нүсэр журмаар зохицуулах нь ажилтанд хүндрэл үүсгэх, ойлголтын зөрүү үүсэх зэрэг сул талтай тул эдгээрийг нэгтгэж цөөн журмаар зохицуулж ажиллахыг зөвлөж байна.

3.2.2.3. Чанар, хяналтын үйл ажиллагаанд хамаарах журам:

Компани нь чанар, хяналтын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дараах журмыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Чанарын удирдлагын хорооны дүрэм;
2. Чанарын удирдлагын багийн үйл ажиллагааны журам;
3. Дотоод хяналтын лаборатори Үл тохирлыг хянах, залруулах, сэргийлэх үйл ажиллагааны журам;
4. Дотоод хяналтын лаборатори Эрсдэл ба боломжид тулгуурласан ажиллагааны заавар;
5. Дотоод хяналтын лаборатори Менежментийн тогтолцоонд тавих шаардлага;
6. Дотоод хяналтын лаборатори Үр дүнг тайлагнах заавар.

Эдгээр журмаас Ерөнхий захирлын 2021 оны 04-р сарын 08-ны өдрийн тушаалаар батлагдсан "Чанарын удирдлагын хорооны дүрэм" нь компанийн чанарын менежментийн тогтолцоо болон Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бүрдүүлэхэд Чанарын удирдлагын хороо, чанарын багийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зохион байгуулалт, үүрэг хариуцлагыг тодорхойлж зохицуулах, баримт бичиг боловсруулах, хэлэлцэх, дотоод хяналт шалгалт, аудитын дүгнэлтэд дүн шинжилгээ хийх, цаашид сайжруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Ийнхүү журмаар байгууллага чанарын менежментийн тогтолцооны

---

[27] 15.2.4.эрсдэлийн үнэлгээ хийх удирдамж баталж, эрсдэлийн үнэлгээг энэ хуулийн 16.1-д заасан эрсдэлийн үнэлгээний баг /цаашид "баг" гэх /-аар гүйцэтгүүлэх, багийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, үнэлгээний дүнг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх;

[28] 16.3.Баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

[29] 27.3.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;

[30] 28.1.8.аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байх;

хүрээнд зорьсон үр дүнд хүрэх зорилтоо хэрэгжүүлэх боломж, стратеги чиглэлд хамааралтай гадаад, дотоод асуудлыг тодорхойлж гаднын олон дотоод асуудлуудад хамаарах мэдээлэлд мониторинг, дүн шинжилгээ хийх, нэгдсэн төлөвлөгөө баталж, хяналт тавьж дүгнэж ажиллахаар тусгасан нь хууль тогтоомжид нийцсэн байна.

Ерөнхий захирлын 2021 оны 02-р сарын 03-ны өдрийн "Үл тохирлыг хянах, залруулах, сэргийлэх үйл ажиллагааны журам"-ыг баталсан бөгөөд журмаар лабораторийн сорилт шинжилгээний ажилд болон түүний чанарын тогтолцоонд гарч болзошгүй үл тохирлыг хянах, илрүүлэх, илэрсэн үл тохирлыг залруулах, дахин давтагдахаас сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, үүрэг хариуцлага, ажлын заавар зэрэг харилцааг зохицуулсан нь Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4[31], Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2[32], 12 дугаар зүйлийн 12.1[33] дэх хэсэгт заасантай нийцсэн байна гэж үзлээ.

3.2.2.4. Үйлдвэр, лабораторийн үйл ажиллагаанд хамаарах журам:

Компани нь өөрийн эрхлэх хүнсний чиглэлийн үйлдвэр, лабораторийн үйл ажиллагаанд хамаарах дараах журмыг баталсан байна. Үүнд:

1. Дотоод хяналтын лаборатори Үл тохирлыг хянах, залруулах, сэргийлэх үйл ажиллагааны журам;
2. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох журам;
3. Шилний хагарлын үеийн хяналтын журам;
4. Химийн бодис хадгалах, ашиглах, устгах журам;
5. Бүртгэлийг хянах журам;
6. Бүтээгдэхүүнийг зах зээлээс эргүүлэн татан авах журам;
7. Дотоод аудитын журам;
8. Лабораторийн нууцын тухай журам;
9. Түүхий эд хүлээж авах журам;
10. Дотоод хяналтын лаборатори хэмжлийн эргэлзээг үнэлэх журам;
11. Дотоод хяналтын лаборатори Үр дүнгийн үнэн бодит байдлыг хангах журам;
12. Дотоод хяналтын лаборатори Үр дүнг тайлагнах журам;

Эдгээр журмаас онцгойлон дурдвал, Компанийн Ерөнхий захирлын 2015 оны 06-р сарын 02-ны өдрийн 50 тоот тушаалын Хавсралтаар "Шил хагарлын үеийн хяналтын журам"-ыг баталсан байна. Журмаар Компанийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн явцад бүтээгдэхүүнд шил орохоос урьдчилан сэргийлэх, түүнтэй холбогдон гарах аюулгүй байдлыг хангах, ажлын байранд ажиллах зарчим, шил хагарлын үеэр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тус тус зохицуулсан нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2[34], 10.1.4, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан технологийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага болон стандартад нийцсэн байна.

Ерөнхий захирлын 2019 оны 12-р сарын 05-ны өдрийн УНТ-ҮТХБЗС-1 код бүхий тушаалаар баталсан "Үл тохирлын хяналтын бүртгэл, залруулах болон сэргийлэх үйл ажиллагааны журам" Компанийн бүх алба нэгжүүдийн, үйлдвэрлэл, борлуулалтын үйл явцад тогтоосон шаардлагад нийцэхгүй бүтээгдэхүүнийг санамсаргүй хэрэглэх,

[31] 7.4.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүсэх сөрөг үр дагавар, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах арга хэмжээг бүрэн хариуцна.
[32] 10.2.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд дараах хяналт, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж болно.
[33] 12.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
[34] 10.1.2.стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх;

нийлүүлэхээс урьдчилан сэргийлэх, илэрсэн үл тохирлыг шуурхай арилгах, залруулах, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг харилцааг зохицуулсан байна. Журмаар компанийн зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, шинж чанарыг байнга сайжруулах, чанарын гологдол гаргахгүй байх, үл тохирлын шийдвэр гаргах явцад маргаан, эргэлзээ зэрэг үүссэн тохиолдолд чанарын хяналтын албаны дарга үл тохиролд хамаарах бусад алба, нэгжийн удирдлага, албан тушаалтантай хамтран ярилцах, үл тохиролтой холбоотойгоор гүйцэтгэлийн онооноос хасах, учруулсан хохирлыг арилгах, ажилтанд захиргааны арга хэмжээ авах, цалингийн хэмжээ бууруулах, зэрэг бууруулах, ажлаас халах зэрэг асуудлыг шийдвэрлэхээр тусгасан нь онцлог болсон байна.

Тус журмыг Чанарын удирдлагын тогтолцоо-MNS ISO 9001:2015 шаардлага, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо MNS ISO 22000:2007 стандартын шаардлага, Компаниас баталсан Үл тохирлыг залруулах болон сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцүүлэн баталсан байна.

Ерөнхий захирлын 2021 оны 11-р сарын 20-ны өдрийн ЛЖ дугаар тушаалаар “Лабораторийн химийн бодис хадгалах, ашиглах, устгах журам”-ыг баталсан ба уг журмаар лабораторийн хэрэглэгдэх химийн бодисыг хадгалах, ашиглах, устгахтай үйл ажиллагааг зохицуулсан нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3[35] дахь болон Химийн хорт болон аюултай бодисын тухай болон Эрүүл ахуйн тухай хуульд нийцжээ.

Ерөнхий захирлын 2021 оны 02-р сарын 03-ны өдрийн тушаалаар “Бүртгэлийн хянах журам”-ыг баталсан бөгөөд журмаар лабораторийн үйл ажиллагаатай хэрэглэгдэх сар, жил, улирлын тайлангууд, үйл ажиллагаатай холбоотой өдөр тутмын мэдээлэл, хөтлөгдөж байгаа бүртгэл, сорилт шинжилгээний дүр дүнгийн хуудас, дүрэм журмыг индексжүүлэн бүртгэж, архивлан хадгалах үйл ажиллагааг зохицуулсан нь хууль тогтоомжтой зөрчилдөөгүй байна.

Ерөнхий захирлын 2015 оны 05-р сарын 04-ний өдрийн 33 тоот тушаалын Хавсралтаар “Бүтээгдэхүүн зах зээлээс эргүүлэн татан авах журам”-ыг баталж, мөрдүүлсэн ба журмаар зах зээлд нийлүүлэгдсэн бараа бүтээгдэхүүн чанар, стандартын шаардлага хангахгүй болж зах зээлээс эргүүлэн татах, буцаалт хийх нөхцөлд баримтлах үйл явцыг зохицуулсан нь хууль тогтоомж болон стандарт нийцсэн журам болжээ.

Ерөнхий захирлын 2021 оны 02-р сарын 03-ны өдрийн тушаалаар “Дотоод аудитын журам”-ыг баталж, журмаар лабораторийн сорилт шинжилгээний үнэн зөв байх нөхцөлийг бүрдүүлэн, лабораторийн чанарын удирдлагын тогтолцооны бүх баримт бичгүүдэд хөтөлбөрийн дагуу дотоод аудит явуулах харилцааг зохицуулжээ. Журмаар зохицуулагдах харилцаа нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй байна.

3.2.2.5. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хамаарах журам

Компани нь үйл ажиллагаандаа санхүүгийн дараах журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Үүнд:

1. Кассын үйл ажиллагааны журам;
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг;
3. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн журам.

[35] 10.3.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу баталсан жагсаалтад орсноос бусад пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд хэрэглэхийг хориглоно.

4. Санхүүгийн тайлан.

Эдгээрээс онцлон дурдвал Ерөнхий захирлын 2022 оны 06-р сарын 05-ны өдрийн А/18 тоот тушаалын Хавсралтаар "Үндсэн хөрөнгийн бүртгэлийн журам"-ыг баталж, журмаар үндсэн хөрөнгөнд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг олж авах, бүртгэх, данснаас хасах (актлах, худалдан борлуулах) шилжүүлэх болон холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг тооцох тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулсан нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй, хуульд нийцсэн байна.

Компани нь санхүүгийн үйл ажиллагаанд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдлөг болгон ажиллаж байгаа нь Компанийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчөөгүй, хуулийн шаардлагыг хангаж байна.

3.2.3. Компанийн дотоод үйл ажиллагаанд зайлшгүй мөрдөх стандарт, заавар, үйлдвэрлэлийн зохистой дадал, төлөвлөгөөний талаар;

Компани нь эрхлэх үндсэн үйл ажиллагаандаа дараах стандартын гэрчилгээнүүдийг авсан байна. Үүнд:

1. Нөөшилсөн жимс, хүнсний ногоо болон ундааны үйлдвэрлэл, худалдаа SFCS-FMSC (GMP)1.0-2018/2021-002 тоот гэрчилгээг 2021.12.11-ны өдрөөс 2024.12.10-ны хүртэл хугацаатай;
2. Нөөшилсөн жимс, хүнсний ногоо болон ундааны үйлдвэрлэл, худалдаа (Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог MNS ISO 22000:2019 стандарт) SFCS-ISO22000/2021-001 тоот гэрчилгээг 2021.12.11-2024.12.10-г хүртэл 3 жилийн хугацаатай;
3. Нөөшилсөн жимс, хүнсний ногоо болон ундааны үйлдвэрлэл, худалдаа (Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016 стандарт) SFCS-ISO22000/2021-0022 тоот гэрчилгээг 2021.12.11-2024.12.10-г хүртэл 3 жилийн хугацаатай;
4. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001: 2015 (MNS ISO 9001:2016), Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 22000:2018 (MNS ISO 22000:2020), Үйлдвэрлэлийн зохистой дадал GMP шаардлагыг хангасан тул баталгаажуулалтын гэрчилгээг 2022 оны 01-р сарын 06-ны өдрөөс 3 жилийн хугацаатайгаар тус тус олгосон байна.

Эдгээр стандартын гэрчилгээнүүд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон Тохирлын үнэлгээ-Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17021-1:2020 стандарт, Компанийн Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын журмыг зөрчөөгүй, хууль тогтоомжид нийцсэн байна.

А. Компани нь бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанар стандартыг сайжруулах, үйл ажиллагаагаа холбогдох хууль тогтоомж, чанар стандартад нийцүүлэн мөрдөж ажиллах хүрээнд Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (цаашид "ХАБМТ" гэх) MNS ISO 22000:2019 стандарт, Чанарын удирдлагын тогтолцоо ISO: 9001 стандартын шаардлагыг баримтлан ажиллахын зэрэгцээ энэхүү Дүгнэлтийн **3.2.4-т** заасны дагуу холбогдох стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

В. Компани нь үйлдвэрлэлийн зохистой дадлыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байгаа нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4[36], Хүнсний бүтээгдэхүүний

[36] 10.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нийтлэг шаардлага тавина:
10.1.4. үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлэх

аюулгүй байдлыг хангах тухай хуулийн (**"ХБАБХтХ"**) 7 дугаар зүйлийн 7.1, 7.1.2, 7.1.3[37], ХАБМТ MNS ISO 22000:2019 стандартад нийцсэн байна.

Явцын дүгнэлт: *Нэгтгэн дүгнэвэл Компанийн дотоод үйл ажиллагаанд хамаарах журмууд нь холбогдох хууль тогтоомж, стандартуудад нийцэж байна.*

3.2.4. Үнэт цаас гаргагчийн Салбарын хууль эрх зүйн орчин, зохицуулалт, стандартын талаар(*үүгээр хязгаарлагдахгүй*);

Хууль:

1. Хүнсний тухай хууль (2012 он);
2. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль (2012 он);
3. Эрүүл ахуйн тухай хууль (2016 он);
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008 он);
5. Баяжуулсан хүнсний тухай хууль (2018 он);
6. Органик хүнсний тухай хууль (2016 он);
7. Усны тухай хууль /шинэчилсэн найруулга/ (2012 он);
8. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль (2006 он);
9. Хог хаягдлын тухай хууль (2017 он);
10. Компанийн тухай хууль (1999 он);

Улсын Их Хурлын тогтоол:

1. Улсын Их Хурлаас батлагдсан ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоол (2020.05.13 №52);
2. Улсын Их Хурлаас батлагдсан "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол; (2022.06.17 №36);

Засгийн Газрын тогтоол:

1. Засгийн газраас батлагдсан "Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэх үлгэрчилсэн журам" (2014.05.17 №157);

Сайдын тушаал:

1. Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын батлагдсан "Баяжуулсан хүнс үйлдвэрлэл, хадгалах, тээвэрлэх журам" (2020.01.30 №А-26);
2. Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын батлагдсан "Баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам" (2020.01.30 №А-27);
3. Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын батлагдсан "Төмс, хүнсний ногоог богино, урт хугацаанд хадгалах үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлал" (2019.02.26 №А-43);
4. Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын батлагдсан "Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам" (2018.10.25 №А-180);
5. Хүнс, Хөдөө, Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын батлагдсан "Журам, аргачлал батлах тухай" (2018.01.15 №А-09);

[37] 7.1. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:
7.1.2. хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүү ахуйн зохистой дадал
7.1.3. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал

6. Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн Сайд, Эрүүл Мэндийн Сайдын хамтарсан тушаалаар батлагдсан "Журам батлах тухай" (2013.04.08 №А/46/115)

Агентлагийн тушаал:

1. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын Даргын тогтоолын хавсралтаар батлагдсан "Хүнсний үйлдвэрт мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм" (2017.11.01 №А/179);
2. Стандарт, Хэмжил Зүйн Газрын Даргын тогтоолын хавсралтаар батлагдсан "Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журам" (2021.11.04 №А/153);

Стандартууд:

1. Ногооны нөөш Техникийн ерөнхий шаардлага. MNS 5075:2001;
2. Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгололтонд тавигдах шаардлага. MNS 6648:2016;
3. Зохицуулах үйлчилгээтэй хүнс "Артишок бүтээгдэхүүн, Техникийн шаардлага". MNS 6368:2012;
4. Нөөшилсөн жимс, хүнсний ногооны эрүүл ахуйн дадлын дүрэм MNS CAC RCP 2:2014
5. Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим. MNS CAC RCP 1:2003;
6. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд эрхлэгчид тавигдах шаардлага. MNS ISO 22000:2019;
7. Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS ISO /IEC 17025:2018;
8. Микробиологи. 30°C-т ургасан бичил биетний колони тоолох ерөнхий арга MNS ISO 4833:1995;
9. Микробиологи. E.Coli тоог тодорхойлох ерөнхий арга MNS ISO 7251:1995;
10. Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч S.Aereus тоог тогтоох MNS ISO 6888-1:2011;
11. Микробиологи. Salmounella илрүүлэх, тоолох, серологийн шинжээр ялгах ерөнхий арга MNS ISO 6579:2020;
12. Колиформын тоог тогтоох, Коли тоолох арга MNS ISO 4831:1999;
13. Нян судлал. Эд зүйлсийн гадаргуугаас арчдас авч шинжилгээ хийх арга MNS 6410:2018;
14. Агаарын чанар: Нянгийн тоог тоолох, нян илрүүлэх шинжилгээний арга MNS 5484:2005;
15. Усны чанар: Гэдэсний бүлгийн бичил биетэн, халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн,бичил биетэн болон таамаглаж буй E.Coli-г илрүүлэх,тоолох MNS ISO 9308-1:1998;
16. Усны чанар: Амьдрах чадвартай бичил биетний тоог тогтоох, тэжээлт орчин дотор буюу гадаргад нь ургасан нянгийн бөөгнөрлийг тоолох MNS ISO 6222:1998;
17. Халдваргүйтгэлийн бодисын нянд үйлчлэх идэвхийг тодорхойлох нян судлалын арга MNS 6236:2011;
18. Хүн ба амьтны хоол тэжээлийн микробиологи Клостридиум перфрингенсийн тоог тогтоох арга,колони тоолох арга MNS ISO 7937:2000;
19. Хүнсний бүтээгдэхүүн. Мөөгөнцрийг таньж,тодорхойлох арга MNS 5132:2002;
20. Хүнсний бүтээгдэхүүнд энтерококк тодорхойлох арга MNS 5686:2006;
21. Нянг будах MNS 1049:1969;
22. Нөөшилсөн жимс, хүнсний ногооны эрүүл ахуйн дадлын дүрэм MNS CAC RCP 2:2014
23. Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 6308:2012;
24. Төрөл бүрийн ундаанд микробиологийн шинжилгээ хийх арга MNS 5322:2015;

25. Хүнсний микробиологи. Listeria monocytogenes ба. Listeria spp. илрүүлэх, тоолох ерөнхий арга. MNS ISO 11290-11-99;
26. Микробиологи Бацилус цереусын тоог тогтоох 300С-т колони тоолох арга. MNS ISO 7932:1999;
27. Хөрсний чанар. Хөрсөнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх арга MNS 6341:2012;
28. Гэдэсний бүлгийн савханцар болон байж болох E.Coli илрүүлэх арга MNS 5367:2004;
29. Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:1991;
30. Ногооны консерволсон бүтээгдэхүүнээс дээж авах бүтээгдэхүүн хэсгийн харьцааг тогтоох шинжилгээд бэлтгэх арга MNS 0358-0:1989;
31. Шинэ жимс ба ногоо- дээж авах MNS ISO 874:2000;
32. Консерволсон ногоонд хими-физик шинжилгээ хийх аргууд MNS 358.1:89;
33. Жимс ба ногооны бүтээгдэхүүнд pH-ын утга тодорхойлох MNS ISO 1842:2000;
34. Жимс ба ногоон бүтээгдэхүүн-титрлэгдэх хүчиллэгийг тодорхойлох MNS ISO 750-2000;
35. Түргэн хөлдөөсөн жимс, хүнсний шинжилгээний арга MNS CAC 4942:2000;
36. Ундны ус. Хлорын агуулгыг тодорхойлох арга MNS 4424:2005;
37. Ундны ус. Төмрийн агуулгыг тодорхойлох арга MNS 4430:2005;
38. Усны чанар-кальци ба магний нийт агуулгыг тодорхойлох-трилон Б-гээр титрлэх арга MNS ISO 6059:2005;
39. Усны чанар нитрат тодорхойлох арга MNS ISO 7890-3:2001;
40. Усны чанар нитрит агуулгыг тодорхойлох арга MNS 4431:2005;
41. Давсалсан өргөст хэмх MNS CAC 115:95;
42. Өргөст хэмх-хадгалалт ба хөргөлттэй тээвэрлэлт MNS ISO 7560:2003;
43. Жимс, хүнсний ногоо тэдгээрээс гаралтай бүтээгдэхүүн сорбины хүчлийн агууламжийг тодорхойлох арга MNS ISO 5519:2007;
44. Хүнсний ногоон дахь органик фосфат болон карбамат пестицидийн үлдэгдэлийн тодорхойлох биологийн хурдавчилсан арга MNS NV/T 488:2009;
45. Жимс, хүнсний ногоо тэдгээрээс гаралтай бензойны хүчил тодорхойлох арга MNS ISO 5518:2007;
46. Хүнсний ногоон дахь органик фосфат болон карбамат пестицидийн үлдэгдэлийн тодорхойлох биологийн хурдавчилсан арга MNS GB/T 5009.199:2009;
47. Нөөшилсөн жимс, хүнсний ногоонд хүнд металл, хортой болон химийн зарим элемент тодорхойлох MNS 5228:2002;
48. Ариутгал, халдваргүйтгэлийн бодист идэвхтэй хлорын агуулгыг тодорхойлох титрметрийн арга MNS 5574:2005;
49. Гэр, ахуйн, ундны усны физик-химийн шинжилгээний арга MNS 1097:1970;
50. Хүнсний бүтээгдэхүүнд хлорорганик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга MNS 4833:1999;
51. Хүнсний бүтээгдэхүүнд фосфорорганик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга MNS 4832:1999;
52. Ундны ус Хуурай үлдэгдлийг тодорхойлох арга MNS 4423:1997;
53. Төрөл бүрийн ундаа химийн шинжилгээ MNS 5321:2016;
54. Усны чанар. Шүлтлэгийг тодорхойлох. 1-р хэсэг: Нийт ба холимог шүлтлэгийг тодорхойлох MNS ISO 9963-1:2005;

Явцын дүгнэлт: *Үнэт цаас гаргагчийн салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа дээрх хууль, тогтоомж, эрх зүйн актуудаас Энэхүү хуулийн дүгнэлтийн агуулгын хүрээнд мөрдөх ёстой хууль, тогтоомж, эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.*

ДӨРӨВ. БУСАДТАЙ БАЙГУУЛСАН ХУДАЛДАХ БОЛОН ХУДАЛДАН АВАХ, БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ, ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БОЛОН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЧУХАЛ АЧ ХОЛБОГДОЛ ҮЗҮҮЛЭХ БУСАД ГЭРЭЭ НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

4.1. Бусадтай байгуулсан Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий бусад гэрээ, хэлцлийн талаарх дүгнэлт

Компанийн бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээнүүдийг сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2019 оны 07-р сарын 06-ны өдрөөс 2022 оны 06-р сарын 30-ны өдөр (цаашид "Гэрээг тасалбар болгосон өдөр" гэх)-өөр тасалбар болгон, хүчин төгөлдөр үйлчилж байгаа эдгээр гэрээнүүдийн хуулбарыг эх сурвалж болгож, тэдгээрийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжтой нийцэх нийцлийн талаар дүгнэсэн болно. Харин эдгээр гэрээ, хэлцлийн үүргийн гүйцэтгэлд дүгнэлт хийгээгүй болно.

Энэхүү бүлэгт сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулагдсан гэрээний тоон мэдээлэл, агуулгыг гэрээний төрөл тус бүрээр Хүснэгт № 4-өөс харж болно.

Хүснэгт №8

№	Гэрээний нэр төрөл	2019.07.06-2020.07.06	2020.07.06-2021.07.06	2021.07.06-2022.07.06	Нийт
1.	Худалдах, худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ	22	27	50	99
2.	Зээлийн гэрээ	1	0	0	1
3.	Үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий бусад төрлийн гэрээ	1	3	2	6

4.1.1. Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээнд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлт;

Энэхүү бүлэгт Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Компанийн бусадтай байгуулсан худалдах, худалдан авах болон бэлтгэн нийлүүлэх гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа талаар хуулийн нийцэл, дүгнэлтийг гаргахдаа тус гэрээнүүдийг нэг бүрчлэн судлан үзэж дүгнэлт өгсөн болно.

Компанийн 2019-2022 онд байгуулсан Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээний жагсаалтыг энэхүү Дүгнэлтийн **Хавсралт** №1-д харуулав.

Хуульч нь Компанийн зүгээс бусадтай байгуулсан Худалдах-худалдан авах гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

1. Худалдах-худалдан авах гэрээний зүйл буюу бэлтгэн хөрөнгийг[38] талууд харилцан тохиролцсон эсэх[39];
2. Гэрээгээр худалдах, худалдан авах хөрөнгийн тоо, хэмжээ, чанарыг талууд харилцан тохиролцсон эсэх[40];
3. Гэрээний үнийг талууд харилцан тохиролцсон эсэх[41];
4. Хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон /савлах, баглах гэх мэт/ зардлыг Худалдагч, бараг худалдагчийн байгаа газраас өөр газар хүргэх, зөөх, тээвэрлэх, хүлээн авахтай холбогдсон зардлыг Худалдан авагч хариуцах талаар талууд тохиролцсон эсэх[42];
5. Үл хөдлөх эд хөрөнгө худалдах- худалдан авахад гэрээ болон шаардагдах баримт бичгийг нотариатаар гэрчлүүлж, улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх[43];
6. Хариуцлага болон доголдолтой холбоотой эрхийг хязгаарласан заалт[44] гэрээнд тусгагдсан эсэх;
7. Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж[45], тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Компани нь өөрийн эрхэлж буй энэхүү Дүгнэлтийн 1.2 дах хэсэгт дурдсан үйл ажиллагаатай холбоотойгоор ихэвчлэн бүтээгдэхүүний сав баглаа боодол болох шилэн лонх, "Газар шим" бичигтэй картон хайрцаг болон хүнсний бүтээгдэхүүний орцтой холбоотойгоор хэрчиж хөлдөөсөн улаан чинжүү, хэрчиж хөлдөөсөн ногоон чинжүү, хөлдөөсөн мөөг, хөлдөөсөн броккли, хөлдөөсөн хулуу, хөлдөөсөн хаш, хөлдөөсөн чавга болон чангааз, өргөст хэмх, бөөрөнхий цагаан сонгино, лууван, сонгино, байцаа, чинжүү, манжин болон алим, хөлдөөсөн шар тоор болон хөлдөөсөн гүзээлзгэнэ, улаан лоолийн нухаш, өргөст хэмхийн амт оруулагч, саримсны үнэр оруулагч, ногоон гоньдын амт оруулагч, хар перец, гичийн үр, салатны амтлагч, митчамын гааны охь зэрэг бүтээгдэхүүнийг худалдан авахаар Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулсан бөгөөд эдгээр гэрээнүүд нь Худалдах-худалдан авах гэрээнд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэх талаар дор дурдсан дүгнэлтийг гаргаж байна.

Дүгнэлтийн Хавсралт №1 "Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх" гэрээний жагсаалтад дурдагдсан Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан нийт Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээнээс үзэхэд гэрээний дагуу Компанийн худалдан авч буй бүтээгдэхүүний тоо ширхэг, хэмжээ, бүтээгдэхүүний модель буюу загвар, гэрээний нийт үнийн дүнг талууд харилцан тохиролцсон нь Иргэний хуулийн 243 болон 244 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

Хуульчид ирүүлсэн Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан нийт Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээнээс үзэхэд Компани нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ байгуулаагүй байна.

---

[38] Иргэний хуулийн 84.1, 84.2 дах хэсэгт зааснаар аливаа этгээдийн эзэмшилд байгаа юмсыг эд хөрөнгө гэх бөгөөд эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө байна.

[39] Иргэний хуулийн 243.1 дэх хэсэг

[40] Иргэний хуулийн 251.1 дэх хэсэгт зааснаар гэрээгээр тогтоосон тоо, хэмжээ, чанар бүхий эд хөрөнгийг биет байдлын хувьд доголдолгүй гэж үзэх бөгөөд хэрэв гэрээнд эд хөрөнгийн чанарын талаар заагаагүй бол гэрээнд заасан зориулалтаар ашиглах боломжтой эд хөрөнгийг биет байдлын доголдолгүй гэж үзнэ.

[41] Иргэний хуулийн 244.1 дэх хэсэг

[42] 245.1.Гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон /жигнэх, савлах, баглах гэх мэт/ зардлыг худалдагч, бараг худалдагчийн байгаа газраас өөр газар хүргэх, зөөх, тээвэрлэх, хүлээн авахтай холбогдсон зардлыг худалдан авагч хариуцна.

[43] Иргэний хуулийн 109.2 болон 110.1 дэх хэсэг

[44] Иргэний хуулийн 257.1 дэх хэсэгт зааснаар ямар нэгэн доголдолтой эд хөрөнгийг худалдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх, эсхүл хүлээх хариуцлагыг хязгаарлахаар талууд тохиролцон гэрээнд зааж болох боловч худалдагч нь эд хөрөнгийн доголдлыг зориуд нуун дарагдуулсан бол гэрээ хүчин төгөлдөр бус байна.

[45] Иргэний хуулийн 42.2 болон 43.2.1 дэх хэсэг

Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан нийт Худалдах-худалдан авах гэрээ нь ямар нэгэн доголдолтой эд хөрөнгийг худалдсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй байх, эсхүл хүлээх хариуцлагыг хязгаарлах зохицуулалтыг тусгасан заалт агуулаагүй байна.

Хуульчид ирүүлсэн Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан нийт Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ нь бичгээр байгуулагдсан бөгөөд талуудыг төлөөх эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

Хуульчид ирүүлсэн Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан нийт Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээ нь талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй гэж заасны дагуу гэрээний чөлөөт байдлын зарчмыг[46] баримтлан Иргэний хуульд нийцүүлэн байгуулагдсан байна.

4.1.2. Худалдах-худалдан авах гэрээ болон бэлтгэн нийлүүлэх гэрээний онцлох зохицуулалт

Энэхүү хэсэгт Компанийн зүгээс Хуульчид ирүүлсэн Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх гэрээний онцлох зохицуулалтыг дүгнэж, цаашид гэрээ байгуулахад анхаарах зүйлсийн талаарх зөвлөмжийг оруулаа.

Хэрэглэх хууль

Олон улсын шинжтэй гэрээний харилцаанд дотоодын хууль тогтоомжоос гадна гадаад улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ хэрэглэгдэх боломжтой байдаг. Иймд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хэрэглэгдэх хуулийн талаар тусгайлсан зохицуулалтыг гэрээндээ тусгаж болдог. Хэрэв энэ талаар гэрээнд тусгайлан зохицуулаагүй тохиолдолд энэхүү олон улсын шинж бүхий гэрээний онцлог байдлаас шалтгаалан олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос давуу хүчинтэй үйлчилдэг.

Компанийн бусадтай байгуулсан худалдах-худалдан авах болон бэлтгэн нийлүүлэх нийт 12 гэрээнд худалдагчийн улсын буюу ОХУ болон БНЭУ-ын хууль тогтоомжийг хэрэглэхээр заасан нь Иргэний хуулийн 549 дүгээр зүйлийн 549.1 [47]-т "*...талууд харилцан тохиролцож тодорхойлсон улсын хуулиар зохицуулна*" гэж заасныг зөрчөөгүй, хуульд нийцсэн байна.

Худалдах-худалдан авах, бэлтгэн нийлүүлэх нийт 52 гэрээнд хэрэглэх хууль тогтоомжийг заагаагүй байгаа нь Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг[48] болон мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг[49] зааснаар Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

---

[46] Иргэний хуулийн 189.1 дэх хэсэг

[47] **61 дүгээр бүлэг**. Олон улсын иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид

549.1. Гэрээний дагуу эдлэх эрх, үүрэг, гэрээний агуулга, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, гэрээ дуусгавар болох буюу хүчин төгөлдөр бус болох, гэрээний үүргээ гүйцэтгэхгүй буюу зохих ёсоор гүйцэтгэхгүй байх зэрэг асуудлаас үүсэх үр дагаврыг гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож тодорхойлсон улсын хуулиар зохицуулна.

[48] "Иргэний хуулийн 2.2 дахь хэсэг. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө."

[49] "Иргэний хуулийн 3.2 дахь хэсэг.Тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомж гаргах шаардлагатай гэж олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд иргэний эрх зүйн харилцаанд Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ."

Монгол Улс нь 1980 оны Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай НҮБ-ын конвенцод нэгдэн орж, соёрхон баталсан ба Конвенцын 1 дүгээр зүйлийн 1(1)(а)-д заасны дагуу тус олон улсын гэрээгээр гэрээний талуудын эрх, үүргийг тодорхойлж, түүнээс үүсэх аливаа харилцааг зохицуулна.

Хуульч нь гадаад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй болно.

Шүүхийн харьяалал

Компани нь нийт 8 тооны гэрээнд маргаан гарсан тохиолдолд Монголын Үндэсний Худалдааны Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрт шийдвэрлүүлэхээр заасан бол 21 тооны гэрээнд хариуцагчийн буюу гэрээний зөрчил гаргасан талын харьяалах улсын арбитраар, мөн уг арбитрын дүрмийг баримталж маргаанаа шийдвэрлүүлэхээр заасан байна. Харин үлдсэн гэрээнүүдэд ОХУ болон БНХАУ-ын арбитрт маргааныг харьяалан шийдвэрлэхээр тохирсон байна.

Өмнө дурдсанчлан, олон улсын шинжтэй гэрээний харилцааг зохицуулахдаа гадаад улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээг хэрэглэх боломжтой байдаг. Шүүхийн харьяаллыг талууд урьдчилан тохиролцоогүй нөхцөлд олон улсын гэрээний давуу хүчин чадлыг харгалзан түүнийг тодорхойлно.

Компани нь 38 тооны гэрээнд маргаан шийдвэрлэх шүүхийн болон арбитрын харьяаллыг тохироогүй байна. Энэ тохиолдолд гэрээний талуудын нэгдэн орсон иргэний хэргийн шүүхийн харьяаллын талаарх зохицуулалт бүхий олон улсын гэрээ байхгүй тул Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр бүлэг[50], 189 дүгээр зүйлийн 189.2[51], 189.2.1 [52]дахь хэсэгт зааснаар шүүхийн харьяаллыг тодорхойлох боломжтой бөгөөд Монгол Улсын шүүхэд хандах боломжтой гэж үзэж байна.

Харин цаашид англи хэл дээр гэрээг байгуулахдаа хэрэв гэрээнээс үүдэлтэй маргаан гарах, маргасан тохиолдолд Монгол Улсын шүүх эсхүл Монгол Улсын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын журмаар шийдвэрлүүлэх эсэх талаар талууд харилцан тохиролцож, гэрээндээ тусгаж байхыг зөвлөж байна.

Гэрээний хэл

Компани нь худалдах-худалдан авах болон бэлтгэн нийлүүлэх гэрээг Англи, Орос болон Хятад хэл дээр байгуулсан байх ба Монгол хэлний тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу гадаад хэл дээр гэрээ хэлцэл байгуулахыг хориглосон зохицуулалт байхгүй тул хуульд нийцсэн байна.

Мөнгөн төлбөрийн үүрэг

Компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан худалдах-худалдах авах, бэлтгэн нийлүүлэх гэрээнд мөнгөн төлбөрийн үүргийг гадаадын мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн байна. Эдгээр бүх гэрээний нөгөө тал буюу худалдагч талууд нь гадаад улсын хуулийн этгээд бөгөөд гэрээний зүйл болох бараа, бүтээгдэхүүнийг гадаад улсын хуулийн этгээдээс

---

[50] 19 дүгээр бүлэг. Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

[51] 189.2. Монгол Улсын шүүхээр гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнтэй холбогдолтой иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна.

[52] 189.2.1. нэхэмжлэлийн хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг

худалдан авсны хариуд Компани нь холбогдох төлбөрийг хоёр талт олон улсын гэрээний дагуу гадаад улсын хуулийн этгээд рүү шилжүүлдэг. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үзүүлж буй үйлчилгээ болон борлуулж буй бараа, бүтээгдэхүүний үнийг зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэхийг зохицуулсан[53] тул Монгол Улсын нутаг дэвсгэрт бус гадаад улсаас импортоор оруулж ирж буй бараа, бүтээгдэхүүний үнийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэхэд саад болохгүй. Тиймээс гадаад валютаар илэрхийлсэн эдгээр гэрээнүүдийг уг хуульд нийцэж байна гэж дүгнэж байна.

Харин Компани нь ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнах үүрэгтэй[54] ба дээр дурдсан гадаад валютаар илэрхийлсэн гүйлгээг хийхдээ гүйлгээ хийх өдрийн Монгол Банкны албан ханшинд хөрвүүлэн тайлагнах үүргээ хуулийн дагуу биелүүлдэг болохоо Компанийн зүгээс Хуульчид ирүүлсэн 2022 оны 10-р сарын 28-ны өдрийн 02/177 тоот албан бичгээр тодорхойлж, баталгаажуулсан болно.

> ***Явцын дүгнэлт:*** *Бусадтай байгуулсан Худалдах-худалдан авах, Бэлтгэн нийлүүлэх гэрээнүүд нь Иргэний хуульд заасан тухайн төрлийн гэрээнд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн байна.*

4.2. Зээлийн болон барьцааны гэрээнүүд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаарх дүгнэлт;

4.2.1. Зээлийн гэрээ болон барьцааны гэрээнд тавигдах ерөнхий шалгуур үзүүлэлт

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан зээлийн гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

1. Зээлдэгчийн өмчлөлд шилжүүлэх мөнгөн хөрөнгийн болон хүүгийн хэмжээ, Зээлдэгчийн зүгээс уг мөнгөн хөрөнгийг хүүгийн хамт буцаан төлөх хугацааг талууд харилцан тохиролцсон эсэх[55];
2. Зээлийн гэрээг бичгээр байгуулсан эсэх[56];
3. Нэмэгдүүлсэн хүү төлөхөөр зээлийн гэрээнд заасан эсэх[57];
4. Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгосон зээлийн гэрээнд анзын зохицуулалт тусгасан эсэх[58];
5. Зээлийг эргүүлэн төлөх арга, хэлбэр (тухайлбал харилцах дансны мэдээлэл байгаа эсэх)-ийг тодорхой тусгасан эсэх;
6. Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

---

[53] Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйл
[54] Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйл
[55] Иргэний хуулийн 281.1, 282.1 болон 451.1 дэх хэсэг
[56] Иргэний хуулийн 282.3 болон 451.2 дах хэсэг
[57] Иргэний хуулийн 452.2 дах хэсэг
[58] Иргэний хуулийн 232.4 дэх хэсэгт зааснаар анз нь торгууль, алданги гэсэн төрөлтэй байна. Иргэний хуулийн 452.2 дах хэсэгт зааснаар банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй.

Компаниас ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээнээс үзвэл энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Голомт банктай байгуулсан 1 (нэг) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Голомт банктай 2018 оны 05-р сарын 29-ний өдөр байгуулсан ЗГ1605138846 дугаар зээлийн гэрээ (Хавсралт №4 "Гэрээний ерөнхий мэдээлэл")

Компани нь Сангийн Яам болон Голомт банкны хооронд 2016 оны 05р сарын 05-ны өдөр байгуулагдсан 76 тоот "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-ний үндсэн дээр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, хоршоодын нэмүү өртгийн сүлжээний хөрөнгө оруулалтыг дэмжихэд зориулан тогтоосон шалгуур үзүүлэлтийн дагуу Сангийн Яам болон Азийн хөгжлийн банкны холбогдох нэгжийн зөвшөөрөлтэйгөөр Голомт банкнаас олгож буй зээл авахаар ЗГ1605138846 дугаар зээлийн гэрээг 2018 оны 05р сарын 29-ний өдөр байгуулсан.

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн дүн: 4,600,000,000 (дөрвөн тэрбум зургаан зуун сая) төгрөг
- Зээлийн зориулалт: Энэхүү зээлийн гэрээний Хавсралт №3-т заасан дарсан ногоо, дулааны аргаар боловсруулсан ногооны салатны нэмүү өртгийн сүлжээг өргөтгөх төслийг хэрэгжүүлэх буюу санхүүжүүлэх
- Үндсэн нөхцөлийн зээлийн хүү: жилийн 24%
- Сангийн Яам болон Голомт банкны хооронд 2016 оны 05-р сарын 05-ны өдөр байгуулагдсан 76 тоот "Дамжуулан зээлдүүлэх гэрээ"-нд заасан энэхүү зээлийн гэрээний хугацаанд үйлчлэх хөнгөлөлттэй хүү: жилийн 8%
- Нэмэгдүүлсэн хүү: зээлийн үндсэн хүүгийн 20%
- Зээлийн хугацаа: 84 сар, 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн зээлийг төлж эхэлнэ.
- Хариуцлага: Компани нь зээлийн төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулаагүй бол зээл төлөгдөх хуваарьт өдрийн дараах өдрөөс эхлэн зээлийн үндсэн хүүг үргэлжлүүлэн төлөхөөс гадна нэмэгдүүлсэн хүүг энэхүү гэрээний үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдаж дуусах хүртэл төлнө. Компани нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээнд заасан хугацаа дууссан өдрөөс эхлэн барьцааны гэрээнд заасан эд хөрөнгийг худалдаж зээлийн төлбөрийг төлүүлнэ.

Энэхүү гэрээг талууд бичгээр байгуулан, эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 451.2 дах хэсэгт заасан "*зээлийн гэрээг бичгээр байгуулах*" шаардлагыг хангасан байна.

Зээлийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1.3 дах хэсэгт зээлдэгч нь зээлийн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд зээлийн хүүгийн хорин хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдүүлсэн хүүг төлөх үүрэгтэй байхаар тусгасан байна. Иймхүү нэмэгдүүлсэн хүү төлөхөөр заасан нь Иргэний хуулийн 452 дугаар зүйлд "*Зээлдэгч гэрээнд заасан хугацаанд авсан зээлээ эргүүлэн төлөөгүй бол гэрээнд заасны дагуу зээлдүүлэгчийн үндсэн хүүгийн хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлөхөөр гэрээнд зааж болно*" гэж заасантай нийцэж байна.

Зээлийн гэрээнд анзын зохицуулалтыг тусгаагүй байгаа нь Иргэний хуулийн 452.2 дах хэсэгт "*Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс олгох зээлд анзыг хэрэглэхгүй*" байх шаардлагыг хангасан байна.

Монгол банкны Зээлийн мэдээллийн сангийн 2022 оны 07-р сарын 27-ны өдрийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзэхэд Компани нь Монгол банкны Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэгч банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс авсан нийт 2 зээлийн мэдээлэл бүртгэлтэй байгаа бөгөөд энэхүү Дүгнэлт гаргах өдрийн байдлаар энэхүү зээлийн гэрээгээр авсан зээлийн төлөлт нь хэвийн байна.

Голомт банкны 2022 оны 07-р сарын 27-ны өдрийн 10/579-1 дугаар лавлагаагаар Компани нь тус банканд зээлийн хүүгийн өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан зээлийн гэрээ нь Дүгнэлтийн 4.2.1 дэх хэсэгт дурдсан ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангасан, холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна.*

4.3. Компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээнүүд хууль тогтоомжид нийцсэн эсэх талаарх дүгнэлт;

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 10-р сарын 28-ны өдрийн 02/177 тоот албан бичгээр тодорхойлсны дагуу Компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий гэрээний жагсаалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт №9

№	Гэрээний нэр төрөл	2019.07.06-2020.07.06	2020.07.06-2021.07.06	2021.07.06-2022.07.06	Нийт
1	Хөдөлмөрийн гэрээний загвар				2
2	Ажил гүйцэтгэх гэрээ		6	4	10
3	Түрээсийн гэрээ		5	7	13
4	Барьцааны гэрээ		1		1
5	Хамтран ажиллах гэрээ		3	1	4
6	Ус ашиглах гэрээ		1		1
7	Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээ		1	1	2
8	Даатгалын гэрээ	1	1		2

Эдгээр Компанийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээний дэлгэрэнгүй мэдээлэлтэй Дүгнэлтийн **Хавсралт** №1 "Гэрээний ерөнхий мэдээлэл" хүснэгтээс танилцана уу.

Дээрх Компанийн үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээнүүд Дүгнэлтийн 4-р бүлэгт дүгнэсэн тул 4.1, 4.2 дах хэсгээс харна уу.

4.3.1. Хөдөлмөрийн гэрээ

Хуульч нь Компаниас ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг, ажил үүрэг гүйцэтгэх байршил, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл гэсэн гэрээний гол нөхцөлийг талууд харилцан тохиролцож, хөдөлмөрийн гэрээнд тусгасан эсэх.[59]
- Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажлын бүтэн бус цагийн ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд дээр дурдсан хөдөлмөрийн гэрээний гол нөхцөлөөс гадна өдөрт, эсхүл долоо хоногт, эсхүл сард ажиллах нийт цаг, ажил эхлэх, дуусах цагийг[60] тусгайлан талууд харилцан тохиролцсон эсэх.

Хөдөлмөрийн гэрээнд хийсэн дүгнэлт

Компанийн зүгээс Хуульчид Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын хавсралтаар батлагдсан хөдөлмөрийн гэрээний батлагдсан загвар болон ажлын бүтэн бус цагаар ажиллуулах гэрээний загварыг ирүүлсэн.

Компанийн ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдийг бүрэн тодорхойлсон байна. Хөдөлмөрийн гэрээнээс үзэхэд ажилтны ажил үүрэг гүйцэтгэх байршил, үндсэн цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, ажиллах ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажлын байрны тодорхойлолтыг тус гэрээний хавсралтаар тодорхойлохоор заасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.1[61], 49.1.2[62] болон 49.1.4[63] дэх хэсэгт заасан шаардлагад тус тус нийцэж байна. Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдэнэ[64]. Хөдөлмөрийн гэрээний 1 дүгээр зүйлийн 1.9 дэх хэсэгт ажилтны үндсэн цалингийн хэмжээг тусгахаар заасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.3 дах хэсэгт заасны дагуу цалин хөлсний хэмжээ буюу үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдсэн цалин хөлсний хэмжээг хөдөлмөрийн гэрээнд тусгах шаардлагад нийцэхгүй байгаа тул цаашид хөдөлмөрийн гэрээний заалтад өөрчлөлт оруулж, цалин хөлсний хэмжээг цалин хөлсний бүрдэл тус бүрийн хэмжээгээр тогтоон зааж, харилцан тохиролцохыг зөвлөж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.3 дах хэсэгт зааснаар туршилтаар ажиллах ажилтны үндсэн цалинг тухайн ажлын байрны үндсэн цалингаас багагүй байхаар тогтоох бөгөөд түүнд нэмэгдэл, нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, олговрыг энэ хуульд заасны дагуу олгоно.

Ажилтны ур чадварын, ажилласан жилийн, мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласны болон бусад нэмэгдлийг хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно. Иймд хөдөлмөрийн гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан "туршилтын хугацаанд ур

---

[59] Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1 дэх хэсэг
[60] Хөдөлмөрийн тухай хуулийн 66.2 дах хэсэг
[61] Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана:
49.1.1.ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг;
[62] 49.1.2.ажил үүрэг гүйцэтгэх байршил;
[63] 49.1.4.хөдөлмөрийн нөхцөл.
[64] Хөдөлмөрийн тухай хуулийн 101.1 дэх хэсэг

чадварын нэмэгдэл олгогдохгүй" гэж заасан заалтыг дээрх Хөдөлмөрийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн өөрчлөхийг зөвлөж байна.

Хөдөлмөрийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.6 дах хэсэгт "ажилтны ажлаас хоцорсон минут тутмыг 100 төгрөгөөр тооцож цалингаас суутгана" гэж заасан нь Хөдөлмөрийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэгт[65] заасан цалин хөлснөөс суутгал хийх үндэслэлд хамаарахгүй буюу холбогдох хуулийн зүйл заалттай нийцэхгүй байна. Иймд энэхүү хөдөлмөрийн гэрээний хэсэгт хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулахыг зөвлөж байна.

Талууд Хөдөлмөрийн гэрээний 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсэгт "ноцтой зөрчил"-д тооцох үндэслэлийг харилцан тохиролцож, зөрчлийг нэрлэн зааж, дурдсан нь Хөдөлмөрийн тухай хуулийг зөрчөөгүй, хуульд нийцсэн байна.

Компанийн зүгээс Хуульчид ирүүлсэн ажлын бүтэн бус цагаар ажиллуулах гэрээний загварын үндсэн нөхцөл хэсэгт талууд ажил үүрэг гүйцэтгэх байршил, гүйцэтгэх ажил үүрэг, ажлын хөлсийг харилцан тохиролцохоор тусгасан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.1, 49.1.2, 49.1.4 дэх хэсэгт тус тус нийцэж байна.

Гэвч талууд ажлын байрны нэр, хөдөлмөрийн нөхцөл хэсгийг энэхүү ажлын бүтэн бус цагийн ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд тусгахаар заагаагүй байна. Түүнчлэн гэрээний үндсэн нөхцөл хэсэгт заасан "ажлын хөлс" хэсэгт цалин хөлсний хэмжээ буюу үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллын хэмжээнээс бүрдсэн нэгдсэн дүнг талууд харилцан тохиролцож гэрээнд тусгах шаардлагатайг анхаарна уу.

---

[65] Хөдөлмөрийн тухай хуулийн 119. 19.1.Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно:
119.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан;
119.1.2.шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон;
119.1.3.ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан;
119.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.

Талууд гэрээний үндсэн нөхцөл хэсэгт ажил гүйцэтгэх хугацааг харилцан тохиролцож тусгахаар заасан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 66.2[66] дах хэсэгт заасан шаардлагад нийцэж байна. Харин талууд гэрээний энэхүү хэсэгт ажил эхлэх, дуусах цагийг нэмж тусгайлан тохирох нь зүйтэй байна.

Явцын дүгнэлт: *Компанийн зүгээс Хуульчид ирүүлсэн хөдөлмөрийн гэрээ нь хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөл болох ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг, ажил үүрэг гүйцэтгэх байршил, хөдөлмөрийн нөхцөлийг талууд харилцан тохиролцож гэрээнд тусгахаар заасан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.1, 49.1.2, 49.1.4 дэх хэсэгт заасан шаардлагад нийцэж байна. Хөдөлмөрийн гэрээний 1.9 дэх хэсэгт заасан "үндсэн цалин" хэсгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.3 дах хэсэгт заасантай нийцүүлж цалин хөлсний хэмжээ буюу үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, ээлжийн амралтын цалин, шагнал урамшууллаас бүрдсэн цалин хөлсний хэмжээг гэрээнд тусгах нь зүйтэй байна.*

Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд талууд ажил үүрэг гүйцэтгэх байршил, гүйцэтгэх ажил үүрэг, ажлын хөлсийг харилцан тохиролцохоор тусгасан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.1, 49.1.2, 49.1.4 дэх хэсэгт тус тус нийцэж байна. Түүнчлэн ажил гүйцэтгэх хугацааг харилцан тохиролцож тусгахаар заасан байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 66.2 дах хэсэгт заасан шаардлагад нийцэж байна. Талууд Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1.1, 66.2 дах хэсэгт тус тус нийцүүлэн ажлын байрны нэр, ажил эхлэх, дуусах цагийг нэмж гэрээгээр харилцан тохиролцох нь зүйтэй байна.

4.3.2. Ажил гүйцэтгэх гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Талууд гэрээгээр хийж гүйцэтгэх ажил, үүргийг тусгайлан тодорхойлж, харилцан тохиролцсон эсэх[67];
- Талууд гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга,журам, хугацааг гэрээнд тодорхойлон заасан эсэх[68];
- Энэхүү Дүгнэлтийн 1.2 дах хэсэгт дурдсанчлан хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Компани нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтныг эрүүл ахуй, ариун цэврийн сургалтад

[66] 66.2.Ажлын бүтэн бус цагийн ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан нөхцөлөөс гадна өдөрт, эсхүл долоо хоногт, эсхүл сард ажиллах нийт цаг, ажил эхлэх, дуусах цагийг тусгайлан тохирно.

[67] Иргэний хуулийн 343.1 дэх хэсэг

[68] Иргэний хуулийн 344.1, 346.1 дэх хэсэг

хамруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах үүргээ биелүүлэн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах гэрээ байгуулсан эсэх[69];

- Компани нь төсөл хэрэгжүүлэгч болохын хувьд хууль тогтоомжид заасан байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн эсэх буюу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан эсэх[70];
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэхээр гэрээ байгуулсан хуулийн этгээд нь эрх авсан дотоодын аж ахуйн нэгж байгууллага мөн эсэх[71]
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Ажил гүйцэтгэх гэрээнд хийсэн дүгнэлт

Компани нь "Асралт мед" эмнэлэгтэй эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, багц шинжилгээ хийх гэрээ байгуулсан ба энэхүү гэрээгээр эмнэлэг нь Компанийн хүсэлтээр түүний ажилтнуудад гэрээнд заасан урьдчилан сэргийлэх багц, шинжилгээ, нарийн мэргэжлийн эмчийн оношилгоо, ерөнхий эмчийн дүгнэлт, зөвлөгөө, шаардлагатай нэмэлт үзлэг, шинжилгээг талуудын харилцан тохиролцсон хугацаанд түргэн шуурхай хийж, Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж, үнэн зөв бодитой дүгнэлт хариуг Компанид гаргаж өгөх, Компани нь гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээгээр Компанийн нийт 149 ажилтныг нийт 15,864,900 (арван таван сая найман зуун жаран дөрвөн мянга есөн зуун) төгрөгийн шинжилгээнд хамруулахаар талууд харилцан тохиролцсон байна.

Энэхүү гэрээгээр хийж гүйцэтгэх ажил, үүргийг тодорхойлж, гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээг харилцан тохиролцсон нь Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх гэрээнд тавигдах шаардлагад нийцсэн байна.

Компани нь хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч болохын хувьд хууль тогтоомжид заасан үүргээ биелүүлж, Компанийн ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж байгаа нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн гэрээ байна.

Компани нь "Жимс, хүнсний ногооны нөөш, ундааны Газар Шим үйлдвэр" төслийг хэрэгжүүлэх гэж байгаатай холбогдуулан 2021 оны 04-р сарын 27-ний өдөр "Цагаан Уулын Оргил" ХХК-тай ЦУО-21/05 дугаар байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын гэрээ байгуулсан.

Энэхүү гэрээгээр

1. Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Компанийн "Жимс, хүнсний ногооны нөөш, ундааны Газар Шим үйлдвэр" төсөлд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, судалгааг хийх, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргуулах
2. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж, хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэхэд төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран оролцох
3. Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамны Мэргэжлийн зөвлөлийн хурлаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцүүлэх, 5

[69] Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10.1.7 дах хэсэг
[70] Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.1, 3.1.6 дах хэсэг
[71] Мөн хуулийн 8.2 дах хэсэг

жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ажлыг гэрээ батлагдсан өдрөөс хойш 2-3 сарын хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээний 1.2 дах хэсэгт зааж, талууд харилцан тохиролцсон байна.

Гэрээний үнэ буюу гэрээгээр хийж гүйцэтгэх ажлын нийт үнэ 12,000,000 /НӨАТ багтсан/ байхаар талууд харилцан тохиролцсон бөгөөд

- Гэрээ хүчин төгөлдөр болж, нэхэмжлэхийг Компанид хүргүүлсэн өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор гэрээний үнийн дүнгийн 60% буюу 7,200,000 төгрөгийг
- Үлдэгдэл 40% буюу 4,800,000 төгрөгийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамаар батлуулсны дараа Гүйцэтгэгч "Цаст Уулын Оргил" ХХК-н Худалдаа Хөгжлийн Банкны дансанд шилжүүлж төлөхөөр талууд гэрээний 1.2 дах хэсэгт харилцан тохиролцсон байна.

Ийнхүү хийж гүйцэтгэх ажил, үүрэг, гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ болон хөлс төлөх арга,журам, хугацааг гэрээнд тодорхойлон заасан Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх гэрээнд тавигдах шаардлагад нийцсэн байна.

Компани нь төсөл буюу шинээр байгуулах болон ажиллаж байгаа үйлдвэр, үйлчилгээ, уул уурхай, барилга байгууламж, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх зэрэг аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэж байгаатай холбогдуулан төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохоор байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэхээр энэхүү гэрээг байгуулсан нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтад нийцэж байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.2 дах хэсэгт зааснаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.6 дах хэсэгт заасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч "Цаст Уулын Оргил" ХХК нь 2012 оны 04-р сарын 20-ны өдөр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд тусгай зөвшөөрөл нь 2023 оны 03-р сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.[72] Ийнхүү тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэсэн нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8.2 дах хэсэгт заасантай нийцэж байна.

Энэхүү гэрээний дагуу "Цаст Уулын Оргил" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 2021/E68[73] дугаар тайлан 2022 оны 02-р сарын 17-ны өдөр Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамаар батлагдсан болох нь тус яамны байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллээр тогтоогдож байна.

Компанийн хэрэгжүүлэх гэж буй төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний 13/4584 дугаар[74] тайлан 2021 оны 09-р сарын 30-ны өдөр батлагдсан байна.

[72] https://eic.mn/eia/orgpermission.php - Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага
[73] https://eic.mn/eia/eiareport.php?menuitem=1&count=10&page=1&proponent_name=%D0%93%D0%91%D0%A2%20%D0%A2%D1%80%D0%B5%D0%B9%D0%B4%D0%B8%D0%BD%D0%B3&action=more&eiareport_id=7682
[74] https://eic.mn/eia/upload/2022/02/taeiareport/1/01_20220217_4294.pdf

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын гэрээ нь Иргэний хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасан шаардлагыг хангасан, хуульд нийцсэн гэрээ байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар бусадтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнүүд нь Дүгнэлтийн 4.3.2 дах хэсэгт заасан ажил гүйцэтгэх гэрээнд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн байна.*

4.3.3. Түрээсийн гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан түрээсийн гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх тодорхой хөрөнгийг гэрээнд заасан эсэх[75];
- Түрээсийн төлбөрийг гэрээнд заасан эсэх[76];
- Түрээсийн гэрээг бичгээр байгуулсан эсэх[77]
- Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээг эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн эсэх[78]
- Түрээсийн хугацааг талууд харилцан тохиролцож гэрээнд заасан эсэх[79]
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Түрээсийн гэрээнд хийсэн дүгнэлт

Компани нь бараа бүтээгдэхүүн худалдан борлуулахаар бусадтай лангуу, тавиур түрээслэх түрээсийн гэрээнүүд байгуулсан байна.

Эдгээр түрээсийн гэрээнд түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад лангуу тавиур шилжүүлэх, түрээслэгч тал нь сарын түрээсийн төлбөрийг төлөхөөр талууд харилцан тохиролцсон байна. Талууд гэрээг бичгээр байгуулж, талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

Талууд түрээсийн гэрээнд гэрээний хугацааг зааж өгсөн байна. Компани нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээ байгуулаагүй байна. Иймд Компанийн бусадтай байгуулсан түрээсийн гэрээ нь Иргэний хуульд заасан холбогдох шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн байна.

[75] Иргэний хуулийн 318.1 дэх хэсэг
[76] Мөн эх сурвалж
[77] Иргэний хуулийн 318.3 дах хэсэг
[78] Мөн эх сурвалж
[79] Иргэний хуулийн 318.2, 320.1 дэх хэсэг

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар бусадтай байгуулсан түрээсийн гэрээнүүд нь Дүгнэлтийн 4.3.3 дах хэсэгт заасан түрээсийн гэрээнд тавигдах ерөнхий шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн байна.*

4.3.4. Барьцааны гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан барьцааны гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Барьцааны гэрээг бичгээр байгуулсан эсэх[80];
- Талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг барьцааны гэрээнд заасан эсэх[81]
- Барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх[82];
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Барьцааны гэрээнд хийсэн дүгнэлт

*Голомт банктай 2020 оны 02-р сарын 06-ны өдөр байгуулсан ЗБ1605138846-4 дугаар барьцааны гэрээ (**Хавсралт** №1 "Гэрээний ерөнхий мэдээлэл")*

Зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон Компани нь өөрийн дараах хөрөнгийг барьцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан ипотекийн ЗБ1605138846-4 дугаар гэрээг байгуулсан байна.

Гэрээний мэдээлэл:

- Талуудын нэр, оршин суугаа газар: Улаанбаатар-15160, Д.Сүхбаатарын талбай 5, Голомт банкны төв байр хаягт байрлах Голомт банк ("Барьцаалагч") болон Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, үйлдвэрийн бүс, 66/1, 66/2 тоот хаягт оршин суух ГБТ трейдинг ХХК ("Барьцаалуулагч")
- Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ: Зээлийн гэрээгээр тодорхойлогдох бөгөөд талуудын хооронд байгуулагдсан ЗГ1605138846 тоот гэрээний дагуу төлөх үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, Барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр болон зээлдүүлэгчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.
- Үүргийг хангах хугацаа: Зээлийн гэрээнд тодорхойлсон зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу /хэсэгчлэн/ гүйцэтгэнэ.
- Барьцааны зүйл, түүний байгаа газар, үнэ

Хүснэгт №10

[80] Иргэний хуулийн 156.1 дэх хэсэг
[81] Иргэний хуулийн 156.2 дах хэсэг
[82] Мөн эх сурвалж

№	Барьцаа хөрөнгийн нэр, зориулалт	Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар	Байршил	Барьцаа хөрөнгийн талаар харилцан тохиролцсон үнэлгээ
1.	Агуулахын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө	Y-2205071770 ГД-000746686	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16102/ гудамж, 66/3 тоот	2,443,922,167.50 төгрөг
2.	Конторын зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө	Y-2205071889 ГД-000747932	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16102/ гудамж, 66/1 тоот	508,074,558.75 төгрөг
3.	Үйлдвэрлэлийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө	Y-2205068596 ГД-000747931	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс /16102/ гудамж, 66/2 тоот	1,658,646,990.00 төгрөг

Энэхүү барьцааны гэрээг талууд бичгээр байгуулан талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан бөгөөд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд Y-2205071770 дугаарт 2020 оны 03-р сарын 02-ны өдөр бүртгүүлсэн байгаа нь Иргэний хуулийн 156.1 дэх хэсэгт "*барьцааны гэрээг бичгээр байгуулах*", 156.2 дах хэсэгт "*үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх*" шаардлагыг тус тус хангасан байна.

Гэрээний талуудын нэр, оршин байгаа газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг тодорхойлон зааж тусгасан байгаа нь Иргэний хуулийн 156.2 дах хэсэгт "*гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана*" гэж заасан шаардлагыг хангасан байна.

Д.Санжмятавтай 2021 оны 06-р сарын 29-ний өдөр байгуулсан 13/04 дугаар барьцааны гэрээ ***(Хавсралт №1 "Гэрээний ерөнхий мэдээлэл")***

Талуудын хооронд байгуулагдсан 2021 оны 06-р сарын 29-ний өдөр байгуулсан 13/03 дугаар бараа бүтээгдэхүүн худалдан, борлуулах гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгон барьцаалуулагч Монгол Улсын иргэн Д.Санжмятав нь энэхүү гэрээнд заасаг үл хөдлөх хөрөнгийг барьцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан барьцааны 13/04 дугаар гэрээг байгуулсан байна.

Гэрээний мэдээлэл:

- Талуудын нэр, оршин суугаа газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, үйлдвэрийн бүс, 66/1, 66/2 тоот хаягт оршин суух Газар шим үйлдвэр ХХК ("Барьцаалагч") болон Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Эсба 48-ийн 11 тоот хаягт оршин суух Дорлигжав овогтой Санжмятав ("Барьцаалуулагч")

- Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ: Бараа бүтээгдэхүүн худалдан, борлуулах гэрээгээр тодорхойлогдох бөгөөд барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх шүүхийн зардал, барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар, хураамж, төлбөр болон барьцаалагчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.
- Үүргийг хангах хугацаа: Бараа бүтээгдэхүүн худалдан, борлуулах гэрээгээр тодорхойлогдоно.
- Барьцааны зүйл, түүний байгаа газар, үнэ

Хүснэгт №11

№	Барьцаа хөрөнгийн нэр, зориулалт	Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар	Байршил	Барьцаа хөрөнгийн талаар харилцан тохиролцсон үнэлгээ
4.	Орон сууц	1617000169 ГД-0054935	Ховд аймаг, Жаргалант сум, Магсаржав баг 2-24, 16 тоот	60,000,000 төгрөг

Энэхүү барьцааны гэрээг талууд бичгээр байгуулан талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байгаа нь Иргэний хуулийн 156.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

Гэрээний талуудын нэр, оршин байгаа газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг тодорхойлон зааж тусгасан байгаа нь Иргэний хуулийн 156.2 дах хэсэгт "*гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана*" гэж заасан шаардлагыг хангасан байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар Голомт банктай байгуулсан ЗБ1605138846-4 дугаар барьцааны гэрээ нь Дүгнэлтийн 4.3.3 дах хэсэгт заасан заасан барьцааны гэрээнд тавигдах шаардлагыг хангасан, хууль тогтоомжид нийцсэн гэрээ байна. Харин Д.Санжмятавтай байгуулсан 13/04 дугаар барьцааны гэрээ нь Иргэний хуулийн 156.2 дах хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэх шаардлагыг хангаагүй хүчин төгөлдөр бус гэрээ байна.*

4.3.5. Хамтран ажиллах гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Хамтран ажиллах гэрээг бичгээр буюу амаар байгуулсан эсэх[83]
- Гэрээний үндсэн шинж, хэлбэрийг илэрхийлсэн өвөрмөц агуулга бүхий нэрлэгдээгүй гэрээнд хамаарах эсэх[84]
- Талуудын нэр, хаяг, хамтын үйл ажиллагааны төрөл, зорилго, талуудын эрх, үүрэг, удирдлагын бүтэц, эрх, үүрэг, ашиг, алдагдлыг хуваарилах журам, гэрээнээс гарах журам, гэрээний хугацаа, гэрээг дуусгавар болгох үндэслэл, дундын эд хөрөнгийг хуваарилах журмыг гэрээнд тусгасан эсэх буюу хамтран ажиллах гэрээний шинжийг агуулсан эсэх[85]
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Хамтран ажиллах гэрээнд хийсэн дүгнэлт

Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан хамтран ажиллах гэрээнүүд ***(Хавсралт №1 "Гэрээний ерөнхий мэдээлэл")*** нь Иргэний хуулийн 476 дугаар зүйлд заасан хамтран ажиллах гэрээний шинжийг агуулаагүй байна. Харин Иргэний хуулийн 189.5 дах хэсэгт заасан нэрлэгдээгүй гэрээнүүд байна.

Дээрх гэрээнүүд нь Иргэний хуульд заасан Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй байх гэрээний чөлөөт байдлын зарчим дээр үндэслэн байгуулагдсан байх бөгөөд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар бусадтай байгуулсан хамтран ажиллах нэртэй нэрлэгдээгүй гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан хүчин төгөлдөр гэрээ байна.*

4.3.6. Ус ашиглах гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан ус ашиглах гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Ус ашиглах гэрээнд дараах зүйлийг тусгасан эсэх:
  1. Ус ашиглуулах тухай шийдвэр
  2. Ус ашиглах зориулалт, хоногт ашиглах усны хэмжээ, чанар, найрлага
  3. Усны эх үүсвэрийн байршил, барилга байгууламжийн зураг, төсөл
  4. Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага, хаях цэг, байршил зэргийг заасан хаягдал ус зайлуулах зөвшөөрөл
  5. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ
  6. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ
  7. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ
  8. Гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг

[83] Иргэний хуулийн 476.2 дах хэсэг
[84] Иргэний хуулийн 189.5 дах хэсэг
[85] Иргэний хуулийн 476.3 дах хэсэг

9. Шаардлагатай бусад зүйлийг талууд гэрээгээр харилцан тохиролцсон эсэх[86];
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Ус ашиглах гэрээнд хийсэн дүгнэлт

Компани нь Туул Голын Сав Газрын Захиргаатай 2021 оны 07-р сарын 01-ний өдөр УНТ 21/34 дугаар ус ашиглах гэрээг байгуулсан байна.

Гэрээний мэдээлэл:

- Ус ашиглуулах тухай шийдвэр: Энэхүү гэрээг ус ашиглуулагчаас Компанид "Усны газар"-ын 2021 оны 06-р сарын 22-ны өдрийн 05/526 дугаартай албан бичгээр ирүүлсэн 106 дугаар "Ус ашиглуулах дүгнэлт" болон ус ашиглуулагч Туул голын сав газрын захиргааны даргын 2021 оны 07-р сарын 01-ны өдрийн А/41 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн байгуулсан байна.
- Ус ашиглах зориулалт, хоногт ашиглах усны хэмжээ, чанар, найрлага: Компанийн Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хорооны нутаг дэвсгэр, Үйлдвэрийн баруун бүс жимс, хүнсний ногоо боловсруулах зориулалтаар ус ашиглана. Нийт ашиглах усны хэмжээ нь 48,863.0 м^3. Худгийн уснаас улирал тутам дээж авч усны чанарын шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлэхээр талууд гэрээнд тусгасан байна.
- Усны эх үүсвэрийн байршил, барилга байгууламжийн зураг, төсөл:
  - Унд, ахуй, технологийн хэрэгцээнд ашиглах 1ш гүний худагтай. Худгийн байршил: 47°53'58.58", 106°47'42.01", LXSG загварын усны тоолууртай.
  - Барилга байгууламж: Үйлдвэрт цэвэр ус дамжуулах 63мм голчтой 130м урт шугам хоолойтой. Цэвэр ус нөөцлөх 36 тн багтаамжтай 1ш сав, 18тн багтаамжтай 2ш савтай.
- Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага, хаях цэг, байршил зэргийг заасан хаягдал ус зайлуулах зөвшөөрөл: "Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартын шаардлагыг хангасан хаягдал усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлнэ.
- Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:
  - Хүнсний үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах 47,364.5 м^3 усны нөөц ашигласны төлбөрт 2,682,723 төгрөгийг Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 60 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар улиралд төлнө.
  - Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан "Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам"-д заасны дагуу төлбөр тооцно.
- Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ: хаягдал усан дах бохирдуулах бодисын хэмжээг хаягдал усны шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид улирал тутам хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсарган Туул голын сав газрын захиргаанд ирүүлэхээр талууд гэрээнд харилцан тохиролцсон байна.
- Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:
- Гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэг: гэрээний гуравдугаар зүйлд талуудын эрх үүргийг талууд харилцан тохиролцож, тусгасан байна.

[86] Усны тухай хуулийн 29.2 дах хэсэг

- Шаардлагатай бусад зүйл: Гэрээний дөрөвдүгээр зүйлд бусад зүйлийг талууд харилцан тохиролцож, тусгасан байна.

Энэхүү ус ашиглах гэрээг талууд бичгээр байгуулж, талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна. Компанийн байгуулсан ус ашиглах гэрээ нь Дүгнэлтийн 4.3.6 дах хэсэгт тусгагдсан нийт зохицуулалтын найман шаардлагыг гэрээнд тусгасан, хууль тогтоомжид нийцсэн гэрээ байна. Харин энэхүү ус ашиглах гэрээнд талууд усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг харилцан тохиролцож, тусгаагүй байна. Иймд энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцсоноор бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болохоор гэрээний 4.3 дах хэсэгт заасан байх тул гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой байна. Гэрээний 4.5 дах хэсэгт зааснаар тайлант оны 12-р сарын 20-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлдэг ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг үйлдэж, ус ашиглагч гэрээнд заасан төлбөрийг төлсөн тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй байхаар тусгагдсан байна. Гэрээний 4.2 дах хэсэгт заасны дагуу жил бүрийн эхний улиралд багтаан ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрлийг гаргуулж, ус ашиглах гэрээг байгуулна. Иймд гэрээг шинэчлэн байгуулахдаа талууд Усны тухай хуульд заасан Дүгнэлтийн 4.3.6 дах хэсэгт заасан гэрээнд тусгах нөхцөлийг бүрэн тусгаж, гэрээг хуульд бүрэн нийцүүлэн байгуулахыг зөвлөж байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар Туул голын сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглах гэрээ нь Дүгнэлтийн 4.3.6 дах хэсэгт заасан нийт есөн шаардлагын найман шаардлагыг хангасан гэрээ байна. Ус ашиглах гэрээнд усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг харилцан тохиролцож, тусгаагүй байна. Иймд талууд гэрээнд бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл гэрээг дахин шинэчлэн байгуулах замаар ус ашиглах гэрээнд тусгах шаардлагатай бүх гол нөхцөлүүдийг хуульд нийцүүлэн, харилцан тохиролцож, тусгахыг зөвлөж байна.*

4.3.7. Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшүүлэх гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй гэрээ байгуулсан эсэх[87]
- Тоон гарын үсэг хэрэглэснээр цаасан хэлбэрт байгаа баримт бичигт зурсан гарын үсэгтэй адил эрх зүйн үр дагавар үүсэх тухай гэрээнд тайлбарлаж, тусгасан эсэх[88]
- Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших, ашиглах техникийн болон бусад нөхцөлийн тухай гэрээнд тайлбарлаж, тусгасан эсэх[89]
- Хувийн түлхүүрийн нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай[90]

[87] Цахим гарын үсгийн тухай хуулийн 16.6 дах хэсэг
[88] Цахим гарын үсгийн тухай хуулийн 16.4.1 дэх хэсэг
[89] Цахим гарын үсгийн тухай хуулийн 16.4.2 дах хэсэг
[90] Цахим гарын үсгийн тухай хуулийн 16.4.3 дах хэсэг

- Гэрчилгээ эзэмшигчийн буруутай үйл ажиллагаанаас хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задруулснаас үүсэх хариуцлагыг өөрөө хүлээх тухай[91]
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээнд хийсэн дүгнэлт

Компани нь гэрчилгээ олгох байгууллага болох "МонПасс СА" ХХК-тай 2021 оны 01-р сарын 21-ний өдөр 1611197737336855, 2021 оны 08-р сарын 04-ний өдөр 1628054630905484 дугаар тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших гэрээг тус тус байгуулсан байна.

Цахим гарын үсгийн тухай хуулийн 16.6 дах хэсэгт заасны дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч тоон гарын үсгийн гэрчилгээ олгохдоо гэрчилгээ эзэмшигчтэй харилцан тохиролцож гэрээ байгуулна.

Гэрчилгээ олгох байгууллага "МонПасс СА" ХХК нь харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу тоон гарын үсгийн гэрчилгээ олгож байгаа байгууллага мөн[92] байна.

Тоон гарын үсгийг хэрэглэснээр ердийн гарын үсгийг хэрэглэсэнтэй адил эрх зүйн үр дагавартай байна. Байгууллагын тамга дарж баталгаажуулах эрх бүхий этгээд тоон гарын үсэг хэрэглэснээр тамга дарсанд тооцох болохыг гэрээний 1.3, 1.4 дэх хэсэгт зааж, тайлбарласан байгаа нь тоон гарын үсэг хэрэглэснээр цаасан хэлбэрт байгаа баримт бичигт зурсан гарын үсэгтэй адил эрх зүйн үр дагавар үүсэх тухай гэрээнд тайлбарлаж, тусгах шаардлагыг хангасан байна.

Тоон гарын үсгийн гэрчилгээ захиалах болон хүлээн авах журмыг гэрээний 3 дугаар зүйл, тоон гарын үсгийн гэрчилгээг шинэчлэн авах журмыг гэрээний 4 дүгээр зүйл, хос түлхүүр, тээгч төхөөрөмж /e-token/ төхөөрөмжийн талаар гэрээний 5 дугаар зүйлд тус тус заасан нь тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмших, ашиглах техникийн болон бусад нөхцөлийн тухай гэрээнд зааж тусгах шаардлагыг хангасан байна.

Гэрчилгээ олгож буй e-token төхөөрөмжийн гэрчилгээнд хандах нууц үгийг 15 удаа буруу оруулсан тохиолдолд уг төхөөрөмжийн криптограф модуль түгжигдэх ба энэ тохиолдолд гэрчилгээ олгох байгууллагын аль нэг салбар нэгжид хандаж, түгжээг тайлуулах бөгөөд түгжээг тайлсны дараа шинэ нууц үг олгох талаар болон төхөөрөмжийн аюулгүй байдлын талаар гэрээний 6, 11 дүгээр зүйлд тус тус тусгасан байгаа нь хувийн түлхүүрийн нууцлал, аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай гэрээнд тусгах шаардлагад нийцсэн байна.

Гэрчилгээ эзэмшигчийн буруутай үйл ажиллагаанаас хувийн түлхүүрийг алдсан, хувийн түлхүүрийн нууцыг задруулснаас үүсэх хариуцлагыг өөрөө хүлээх тухай гэрээний 8 дугаар зүйлд тусгаж өгсөн байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар Гэрчилгээ олгох байгууллага "МонПасс СА" ХХК-тай байгуулсан хоёр тоон гарын үсгийн гэрчилгээ*

[91] Цахим гарын үсгийн тухай хуулийн 16.4.4 дэх хэсэг

[92] https://mddc.gov.mn/mn/%d1%82%d0%be%d0%be%d0%bd-%d0%b3%d0%b0%d1%80%d1%8b%d0%bd-%d2%af%d1%81%d0%b3%d0%b8%d0%b9%d0%bd-%d0%b3%d1%8d%d1%80%d1%87%d0%b8%d0%bb%d0%b3%d1%8d%d1%8d/ - Тоон гарын үсгийн гэрчилгээ олгож буй байгууллагуудын мэдээлэл

эзэмших гэрээ нь Дүгнэлтийн 4.3.7 дах хэсэгт заасан бүх шаардлагад нийцсэн, талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан гэрээ байна.

4.3.8. Даатгалын гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан даатгалын гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Даатгалын зүйл;
- Даатгалын эрсдэлийн төрөл;
- Даатгалын үнэлгээний хэмжээ;
- Даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
- Даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
- Даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
- Гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл[93]
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Даатгалын гэрээнд хийсэн дүгнэлт

Компани нь агуулахын, үйлдвэрийн болон конторын зориулалттай үл хөдлөх хөрөнгүүд, тоног төхөөрөмж, газраа даатгуулан хураамж төлж, гэрээнд заасан эрсдэл учирсан тохиолдолд нөхөн төлбөр авах тухай харилцааг зохицуулсан эд хөрөнгийн даатгалын гэрээг 2020 оны 03-р сарын 03-ны өдөр "Практикал даатгал" ХХК-тай байгуулсан байна.

Гэрээний 4 дүгээр зүйлд зааснаар даатгалын зүйл нь Компанийн энэхүү гэрээний хавсралт №1-т заасан эд хөрөнгө байна. Гэрээний 5 дугаар зүйлд зааснаар даатгалын эрсдэл нь галын, байгалийн, цахилгааны, сан техникийн, ус чийгийн, гуравдагч этгээдээс хохирол учруулах төрөлтэй байна. Гэрээний 6 дугаар зүйлд даатгалын үнэлгээний хэмжээг тусгаж, талууд харилцан тохиролцсон байна. Даатгалын нийт үнэлгээ нь 7,362,652,527.75 (долоон тэрбум гурван зуун жаран хоёр сая зургаан зуун тавин хоёр мянга таван зуун хорин долоон төгрөг далан таван мөнгө) төгрөг байна.

Даатгалын хугацаа нь 2020 оны 03-р сарын 03-ны өдрөөс 2021 оны 03-р сарын 02-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байхаар талууд гэрээний 3 дугаар зүйлд харилцан тохиролцсон байна. Гэрээний 3.3 дах хэсэгт зааснаар гэрээ дуусгавар болсон тохиолдолд гэрээг дүгнэж, гэрээг сунгах эсэхийг шийдвэрлэхээр талууд харилцан тохиролцсон байна.

Гэрээний 6 дугаар зүйлд даатгалын хураамжийн хэмжээг тусгаж, талууд харилцан тохиролцсон байна. Даатгалын нийт хураамжийн хэмжээ нь 13,692,442.69 (арван гурван сая зургаан зуун ерэн хоёр мянга дөрвөн зуун дөчин хоёр төгрөг жаран есөн мөнгө) төгрөг байна. Гэрээний 6.2 дах хэсэгт зааснаар даатгалын хураамжийн даатгалын гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 3 хоногт багтаан төлөхөөр талууд харилцан тохиролцсон байна. Даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлагыг гэрээний 11 болон 12 дугаар зүйлд тус тус тусгасан байна. Гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл тус

[93] Иргэний хуулийн 431.4 дэх хэсэг

даатгалын гэрээний 3 болон 13 дугаар зүйлд тус тус тусгаж, талууд харилцан тохиролцсон байна.

Явцын дүгнэлт: *Компанийн "Практикал даатгал" ХХК-тай байгуулсан даатгалын гэрээ нь холбогдох хууль тогтоомжид заасан гэрээнд тусгах шаардлагатай нөхцөлийг бүгдийг тусгасан, гэрээг бичгээр байгуулж, талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан, хууль тогтоомжид нийцсэн гэрээ байна.*

4.3.9. Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ

Хуульч нь Компанийн зүгээс ирүүлсэн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанаас хамааруулан дараах ерөнхий шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

- Гэрээний үндсэн шинжийг агуулсан эсэх[94]
- Талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

Inner Mongolia Weilesi International Freight Agency Co., Ltd-тай байгуулсан тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ

Компани нь үйлдвэрлэлийн түүхий эд худалдан авах зорилгоор БНХАУ-ын Inner Mongolia Weilesi International Freight Agency Co., Ltd" компанитай Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар ачаа, бараа (лонхны таг, шилэн лонх) тээвэрлэхтэй холбоотой талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох тухай нийт 3 гэрээ байгуулсан байна.

"Ландбридж" ХХК-тай байгуулсан тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ

Компани нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар зуучлагч нь үйлчлүүлэгчийг төлөөлөн улс хоорондын болон орон нутгийн ачаа тээврийг зохион байгуулах, үйлчлүүлэгч нь гэрээнд заасны дагуу зохих төлбөрийг төлөх тухай харилцааг зохицуулсан тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх 1 гэрээ байгуулсан байна. Зуучлагч нь тухайн тээвэрлэлтийн явцад гарах тээвэрлэлттэй холбоотой төлбөр тооцоо, хил боомтын болон сэлгэн ачилтын зардлыг Компанийн өмнөөс төлнө. Зуучлагч нь ачааг тээврийн хэрэгсэлд ачих үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж байгаа тохиолдолд үйлчлүүлэгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн үйлчлүүлэгчийн өгсөн зураг тооцооны дагуу ачааны бэхэлгээ болон ачилтын техникийн нөхцөл боловсруулах, ачаа хилийн өртөө боомтуудаар дамжсан хөдөлгөөний тухай замын мэдээллээр Компанийг хангахаар гэрээнд заасан байна. Ачаа тус бүрийн тээврийн хөлс болон нэмэлт зардлыг төлбөрийн нэхэмжлэхийн дагуу тухай бүр төлөхөөр талууд харилцан тохиролцсон байна. Энэхүү гэрээ нь талуудын хүсэлтээр гэрээ цуцлагдах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

Түүнчлэн энэхүү тээвэрлэлтийн гэрээний хавсралтаар зуучлагч болох "Ландбридж" ХХК-р дамжуулан тээвэрлэгдэж байгаа ачаа, бараанд учирч болох эрсдэлийг хамгаалах зорилгоор даатгалын нөхцөлийг баталсан байх бөгөөд даатгагч нь "Хаан даатгал" ХХК

[94] Иргэний хуулийн 189.5 дах хэсэг

байна. Энэхүү даатгалын нөхцөл нь 2020.11.01-ний 00:00 цагаас 2021.10.31-ний 23:59 цагийг хүртэлх хугацаанд ачигдсан ачаанд хамаарна. Нэг удаагийн тээвэрлэлтийн буюу нэг удаагийн тохиолдлоор нөхөн төлбөр олгох дээд хэмжээ 1.000.000.000 төгрөг байхаар даатгалын нөхцөлийн буюу гэрээний хавсралтын 7 дугаар зүйлд тусгагдсан байна.

Тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээнд хийсэн дүгнэлт

Компанийн Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар бусадтай байгуулсан тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээнүүд ***(Хавсралт №1 "Гэрээний ерөнхий мэдээлэл")*** нь Иргэний хуулийн 189.5 дах хэсэгт заасан шууд нэрлэгдээгүй боловч гэрээний үндсэн шинж, хэлбэрийг илэрхийлсэн өвөрмөц агуулга бүхий нэрлэгдээгүй гэрээнүүд байна.

Энэхүү гэрээнүүд нь бичгээр байгуулагдаж, талуудын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан, холбогдох хууль тогтоомжид заасан зохицуулалтад харшлаагүй, Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд заасны дагуу гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй гэрээний чөлөөт байдлын зарчим дээр үндэслэн байгуулагдсан байна.

Явцын дүгнэлт: *Компанийн Гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар бусадтай байгуулсан тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх нэртэй нэрлэгдээгүй гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн, талуудын эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан хүчин төгөлдөр гэрээ байна.*

4.4. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт;

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа[95] компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.2 дах хэсэгт зааснаар Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 110,000,000 (нэг зуун арван сая) төгрөг байна.

Компани нь Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 114 гэрээний мэдээллийг Хуульчид ирүүлсэн. Эдгээр гэрээний мэдээлэлтэй Дүгнэлтийн **Хавсралт** №3 "Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний мэдээлэл" хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Компанийн зүгээс Хуульчид ирүүлсэн гэрээ хэлцлүүдийн гадаад валютаар тогтоогдсон (эдгээр гэрээ хэлцлүүд нь тухайн харилцагч улсын хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа) үнийн дүн бүхий хэлцлийг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг рүү хөрвүүлэхдээ Компани нь нэмж гаргах энгийн хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хувьцаат компани болж өөрчлөн байгуулагдах гэж байгаатай холбогдуулан Компанийн олон нийтэд санал болгож, нэмж гаргасан энгийн хувьцааг авах сонирхолтой хөрөнгө оруулагч нарын эрх, ашиг сонирхолд нийцүүлэн Иргэний хуулийн 218 дугаар зүйлийн 218.1 дэх хэсэгт "***төлбөр гүйцэтгэх хугацаа болохоос өмнө мөнгөний ханш өссөн, буурсан бол үүрэг үүсэх үеийн ханшаар*** *тооцож төлбөрийг төлнө*" гэж заасан

[95] Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн тогтоолоор шинэчлэн батлагдсан Компанийн дүрэм

хуулийн зохицуулалтыг төсөөтэй хэрэглэж, энэхүү Дүгнэлт гарах өдрийн Монгол банкны албан ханш[96]аар тооцон хөрвүүллээ.

Компанийн бусад этгээдтэй байгуулсан Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл нь Дүгнэлтийн **Хавсралт** №1 "Гэрээний ерөнхий мэдээлэл"-д заасан гэрээ, хэлцэлтэй давхцаж байгаа тул эдгээр гэрээний дүгнэлтийг энэхүү Дүгнэлтийн дөрөвдүгээр бүлгээс үзэж танилцана уу.

Харин эдгээр гэрээний хэрэгжилтийн хувьд: Энэхүү Дүгнэлт гаргахтай холбоотойгоор төрийн байгууллагаас авсан дараах лавлагаа тодорхойлолтын агуулгаас харахад Гэрээний Хавсралт №1-р тодорхойлогдсон гэрээ, хэлцлүүд, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн өр төлбөр, бусад үүргийн зөрчилтэй холбоотой ямар нэгэн шаардах эрх үүсээгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлээгүй шүүхэд болон арбитрт нэхэмжлэл, шаардлага гараагүй, иргэний хэрэг үүсээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа эхлээгүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны 11-р сарын 28-ны өдрийн 0003192 дугаар тодорхойлолт *"...шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй тухай ...."*
2. Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн тусгай архивын 2022 оны 07-р сарын 04-ний өдрийн 1/1827 дугаар албан бичиг *"...сүүлийн 3 жилийн байдлаар Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй тухай..."*
3. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2022 оны 07-р сарын 04-ний өдрийн 2086 дугаар албан бичиг *"...Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилд оролцож байгаагүй тухай..."*
4. Цагдаагийн Ерөнхий Газрын 2022 оны 07-р сарын 01-ний өдрийн *"...Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй, хүлээгээгүй тухай..."*

Явцын дүгнэлт: *Хувь нийлүүлсэн хөрөнгийн тав ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцлүүдийн хэрэгжилт хэвийн байна.*

[96] "Монгол Улсын Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль", "Төрийн мэдээлэл" эмхэтгэл, 2009 оны №28, 3 дугаар зүйлийн 3.1.3 дах хэсэгт "Монгол банкны албан ханш" гэж банк хооронд болон банкнаас байгууллага, иргэнтэй хийсэн гадаад валютын бэлэн бус арилжааны дүн, ханшид үндэслэн тооцоолж Монгол банкнаас зарласан ханшийг ойлгоно гэж заасан.

ТАВ. СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ДОТОР ХИЙГДСЭН ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ХИЙГДСЭН ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

5.1. Их хэмжээний хэлцэл хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх талаарх дүгнэлт;

Хуульчдад ирүүлсэн Компанийн сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд бусадтай байгуулсан гэрээ, хэлцлүүдийн үнийн дүнг Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тодорхойлсноор хэлцэл хийхийн өмнөх Компанийн сүүлийн балансын активын нийт дүн[97]гийн 25 хувьтай харьцуулж үзэхэд их хэмжээний хэлцэл илэрсэнгүй.

Гэхдээ энэхүү Дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Хүснэгт №13-т заасан дараах их хэмжээний гэрээ, хэлцэл байгуулагдсан байгаа нь хуульд заасан шаардлагыг хангаж[98] байгуулагдсан гэж дүгнэж байна.

Хүснэгт №13

№	Гэрээний нэршил	Гэрээний нөгөө тал	Гэрээний үнэ	Гэрээ байгуулсан огноо	Уг гэрээ хэлцлийг баталсан Хувьцаа эзэмшигчийн шийдвэр
1.	ЗГ1605138846 тоот Зээлийн гэрээ	Голомт банк	4,600,000,000.00 төгрөг	2018.05.29	ГБТ трейдинг ХХК-ийн 2018 оны 4-р сарын 9-ний өдрийн хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоол

5.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх талаарх дүгнэлт;

Компанийн тухай хуулийн 89[99] дүгээр зүйлд зааснаар тодорхойлоход Үнэт цаас гаргагч компани нь сүүлийн гурван жилийн хугацаанд 5 (таван) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг байгуулсан байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг байгуулах, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцсэн ХЭХ-ийн хурлын тэмдэглэлүүдэд дурдсанаар сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг батлах ХЭХ-ийн хурлын ирц нь КтХ-ийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасан хэмжээнд хүрсэн байх тул тухайн хурал хүчин төгөлдөр байна.

ХЭХ-ийн хурлын тэмдэглэлд дурдсанаар сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах, зөвшөөрөл олгох асуудлыг ХЭХ-ийн хуралд оролцсон гишүүдийн тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэсэн нь КтХ-ийн 92 дугаар

---

[97] Компанийн Санхүүгээс гаргаж, баталгаажуулж өгсөн дүнгээс тооцов. Хавсралт

[98] Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг.

[99] 89.1.Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

89.1.1.хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

89.1.2.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.3.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

89.1.4.хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

зүйлийн 92.1[100] дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Иймд энэ сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан шийдвэр хүчин төгөлдөр байна.

Хүснэгт №14

№	Гэрээний талууд	Гэрээний хугацаа, гэрээний нэр	Хоорондоо ямар хамааралтай талаар \зэрэгцээ, охин\	Уг гэрээ хэлцлийг баталсан Хувьцаа эзэмшигчийн шийдвэр
1.	"Эйч Эс Зэт" ХХК	"Эйч Эс Зэт" ХХК нь өөрийн эзэмшдэг Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороонд байрлах 11773 м2 газрын газар эзэмших эрхийг Компанид шилжүүлэх, Компани нь тохирсон төлбөрийг гэрээний төлбөрт төлөх тухай	Ц.Төгсөө нь "Эйч Эс Зэт" ХХК нь Компанийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2021 оны 10-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №2 шийдвэр
2.	Ц.Төгсөө	Ц.Төгсөө нь өөрийн эзэмшдэг Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороонд байрлах 1681910232 тоот нэгж талбарын дугаартай 1203 м.кв газар эзэмших эрхийг Компанид шилжүүлэх тухай	Компанийн 13 хувийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №5 шийдвэр
3.	Ц.Төгсөө	Лицензийн гэрээ "Артишок (Cynara scolymus) агуулсан эрүүл мэндийн ундаа, түүнийг бэлтгэх арга" патентыг Компанид ашиглуулах тухай	Компанийн 13%-ийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №1 шийдвэр
4.	Д.Сэргэлэн	Д.Сэргэлэн нь өөрийн эзэмшдэг Дархан-Уул аймаг, Орхон сум, Залуучууд-1, 122 хаягт байрлах 4503005838 тоот нэгж талбарын дугаартай 1163 м.кв газар эзэмших эрхийг Компанид шилжүүлэх тухай	Компанийн 5%-ийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн "Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай" №3 шийдвэр

[100] 92.1.Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана.

5.	З.Байгалмаа	Барааны тэмдэг эзэмших эрх шилжүүлэх гэрээ “40-0003579 улсын бүртгэлийн дугаар бүхий “ГАЗАР ШИМ” барааны тэмдгийн эзэмших эрхийг Компанид шилжүүлэх”	Компанийн 11%-ийн хувьцаа эзэмшигч	Компанийн хувьцаа эзэмшигч болох Гермон Штэффэн Мэлцэр Трейд унд сервис е.Кфм-ийн 2022 оны 8-р сарын 15-ны өдрийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрлийг нөхөн баталгаажуулах тухай” №4 шийдвэр

Явцын дүгнэлт: *Энэхүү хуулийн дүн шинжилгээ хийхээс өмнөх сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн Үнэт цаас гаргагч Компанийн Их хэмжээний болон Сонирхлын зөрчилтэй хэлцлүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна.*

ЗУРГАА. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЛИЦЕНЗ, ЗОХИОГЧИЙН ЭРХ, ПАТЕНТ, БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭМДГИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР ЭСЭХ, ТЭДГЭЭРИЙН ХУГАЦАА ДУУСАХ ЦУЦЛАГДАХ, ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ЗЭРГЭЭР ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД НЬ БОДИТОЙ НӨЛӨӨЛЖ БОЛОХУЙЦ НӨХЦӨЛ БУЙ ЭСЭХ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

6.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухайд;

